



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ



БАГШ

БАГШИЙН ХӨГЖЛИЙН ОРДОН

"ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ"

ОНОЛ, ПРАКТИКИЙН VI БАГА ХУРАЛ

Улаанбаатар хот
2018 он



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ



“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ”

ОНОЛ, ПРАКТИКИЙН VI БАГА ХУРАЛ

*Боловсролын чанар нь хичээлийн чанараас,
хичээлийн чанар нь хичээлийн судалгаанаас*

Улаанбаатар, 2018

ННА 94
ДАА 080
Х-855

**“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ
АРГА ЗҮЙ” СЭДЭВТ ОНОЛ, ПРАКТИКИЙН VI
БАГА ХУРАЛ**

2018 оны 11 сарын 16-17

Зохион байгуулагч:

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ
МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ
ЖАЙКА ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН ТӨСӨЛ

2018 он

ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ:

Ажлын хэсгийн ахлагч: О.Оюунтунгалаг (БМДИ-ийн дэд захирал)

Гишүүд:

- Д.Даваасүрэн (Математик, мэдээлэл зүйн багшийн хөгжил хариуцсан арга зүйч)
- Э.Даваахүү (Биологийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч)
- С.Ариунгэрэл (Сургалтын арга зүй, технологийн хөгжил хариуцсан арга зүйч)
- Ц.Нарантуяа (Бага боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч)
- Т.Гэрэлтуяа (Дүрслэх урлаг технологийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч)
- Н.Сайнбаяр (Физикийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч)
- Н.Мөнхбаяр (Суралцагчийн хөгжлийн албаны дарга)
- П.Одсүрэн (Багш судлал, багшийн хөгжил хариуцсан арга зүйч)
- Н.Оюунцэцэг (Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн гүйцэтгэх захирал)
- Ж.Норжмаа (Жайка, Тусгай хэрэгцээт боловсролын төслийн ажилтан)

ИЛТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

Ганбаатар Т.	МУБИС-ийн Математикийн тэнхимийн багш
Ганбат М.	МУИС, ШУС, БУС-ийн физикийн тэнхимийн багш
Д.Энхтуяа	МХСН-ийн гишүүн
Норжмаа Г.	Тусгай хэрэгцээт боловсрол төслийн ажилтан
Нямгэрэл Ч.	МУИС, ШУС-ийн Химийн тэнхимийн багш
Оюунцэцэг Н.	МУИС, ШУС-ийн зөвлөх проф., МХСН-ийн гүйцэтгэх захирал
Үүрийнтуяа Д.	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн мэргэжилтэн
Хишигбаяр Б.	Жайка, "PROCESS" төслийн ажилтан
Чойсүрэн Э.	МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
Чулуунцэцэг О.	МУБИС-ийн зөвлөх багш
Юмчмаа Г.	МУИС, ГТС-ийн багш
Мөнхбаяр Н.	БМДИ, Суралцагчийн хөгжлийн албаны дарга
Оюунцэцэг Ш.	БМДИ, Сургалтын албаны дарга
Ариунгэрэл С.	БМДИ, Сургалтын арга зүй, технологийн хөгжил хариуцсан арга зүйч
Гажидулам Ч.	БМДИ, ТНУ-ны багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Гэрэлтуяа Т.	БМДИ, Дүрслэх урлаг, технологийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Даваасүрэн Д.	БМДИ, Математик, мэдээллийн технологийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Даваахүү Э.	БМДИ, Биологийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Жавзансэлмаа О.	БМДИ, Урлаг, гоозүйн боловсрол хариуцсан арга зүйч
Жаргал Ч.	БМДИ, Тэгш хамруулан сургах боловсрол хариуцсан арга зүйч
Ирээдүй А.	БМДИ, Гадаад хэлний багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Нарантуяа Д.	БМДИ, Хүүхэд судлал, хүүхдийн хөгжил хариуцсан арга зүйч
Нацагдорж Б.	БМДИ, Багш судлал, багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Одсүрэн П.	БМДИ, Багш судлал, багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Оюунчимэг М.	БМДИ, Сургалтын хөтөлбөр, үнэлгээ хариуцсан арга зүйч
Цасанчимэг Б.	БМДИ, МХУЗ-ын багшийн хөгжил хариуцсан арга зүйч
Энхтулга Д.	БМДИ, Хүүхдийн хөгжилд оролцогч талуудын хамтан ажиллагаа хариуцсан арга зүйч

ТЕХНИКИЙН РЕДАКТОР:

Д.Даваасүрэн	БМДИ, арга зүйч
Н.Оюунцэцэг	МХСН-ийн гүйцэтгэх захирал
Н.Сайнбаяр	БМДИ, арга зүйч
С.Ариунгэрэл	БМДИ, арга зүйч

Гарчиг

ӨМНӨХ ҮГ	7
НЭГ. МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮНДСЭН ИЛТГЭЛ	10
Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг 5 жилд.....	10
Хичээлийн судалгааг гурвал онолоор шинжихүй.....	17
Сургуулийн өмнөх боловсролын сургалтын онол, арга зүйн үндэс.....	18
Хичээлийн судалгааны чанарын өөрчлөлтийг судалсан зарим үр дүн.....	18
Сургуулийн зорилго ба сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо.....	21
ХОЁР. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА.....	27
Алхам алхмаар сурагчдыг бүтээлч үйлд хөтлөх нь	27
Эко-клубын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь	32
Үгийн сүлжээгээр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх боломж.....	37
Үнэлгээний хуудсаар хүүхдийг хөгжүүлэх нь	43
Туршилтат хичээлийг ээлжит хичээл бүрээр зохион байгуулж, сурагчдаар мэдлэг бүтээлгэх нь..	54
“ Хавчаараар наадъя “ арга зүй	59
Мэдээллийн технологийн хичээлээр ухаалаг хэрэглээг дэмжих аргазүй, шийдэл	68
ГУРАВ. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА	77
Монгол хэлний сургуулийн хөтөлбөр.....	77
Хичээлийн Төлөвлөлтөд Асуултыг Оновчтой Тусгах Арга Зүй	89
Ухаалаг Дэвтрийн Үйл Ажиллагааг Дэмжих Замаар Сургалтын Чанарыг Сайжруулах нь	5
Хичээлийн судалгааны тэмдэглэлд тулгуурлан сурагчдын сурах арга барилыг оношлох боломж..	22
Хүүхэд Нэг Бүрийн Оролцоог Хангасан Бүтээлч Хичээлийг Зохион Байгуулах Замаар Сургуульд Суурилсан Хичээлийн Судалгааг Зохион Байгуулах нь	48
Сургуульд суурилсан хичээлийн судалгаа нь багш нарын тулгамдсан асуудлуудыг шийдэх боломж	52
ДӨРӨВ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ	58
Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн харааны хүртэхүйг хөгжүүлэх арга зүй	58
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дугуйлан секцээр хөгжүүлэх нь.....	65
ТАВ. СУДЛАГДАХУУНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА.....	70
БАГА БОЛОВСРОЛЫН САЛБАР.....	70
Хүн ба байгалийн хичээлд бодит ба дүрслэлт үзүүлэнг ашиглах нь	70
V ангид “Хөшүүрэг, хялбар механизм” сэдвийн хүрээнд шинэ хэрэглэгдэхүүн зохион бүтээсэн нь	77
Музейг сургалтад ашиглан сурагчдын ажиглах, тэмдэглэх чадварыг нэмэгдүүлэх нь.....	82

Хүүхдийн сонирхолд түшиглэн хөгжүүлэх боломж.....	89
Математикийн хичээлд хөтлөн чиглүүлэх аргыг хэрэглэсэн үр дүн	97
Хүүхэд нэг бүрийг өгүүлбэртэй бодлого бодуулж сургах нь	103
Процент сэдвийг заах арга зүй.....	110
БАЙГАЛИЙН УХААН САЛБАР	119
“Гурвалжны талбай олцгооё” ээлжит хичээлийн арга зүйн туршлага.....	119
Квадрат функцийн график, тоон интервал ашиглан квадрат тэнцэтгэл биш бодож сургах	126
Суралцахуйн алдаанаас хэрэглэгдэхүүнийг сайжруулсан үр дүн	136
“Бодит хөдөлгөөний ажиглалтаас хөдөлгөөнийг загварчлах” арга зүй.....	143
Туршилт ажлын дэвтэр ашиглан суралцагчдад шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэх нь.....	152
“Дуу авианы өнгө” ээлжит хичээлийн арга зүйг сайжруулсан туршлага.....	164
“Диффузийн хурдад гадаргуугын талбай нөлөөлөх нь” ээлжит хичээлийн арга зүйн туршлага..	173
Химийн бодлого бодоход гарч буй хүндрэлийг ажиглалт болон рубрик арга ашиглан судласан туршлагаас	178
“Кейс-судалгаа”-нд суурилсан асуудал шийдвэрлэх арга зүйгээр шинжлэх ухаанч арга барилыг хөгжүүлэх нь.....	187
“Молекул кинетикийн онол” ээлжит хичээлийн арга зүйн туршлага.....	195
Сурагчдын бүтээлч сэтгэлгээг нэмэгдүүлэх нь	201
Газарзүйн зургийг ашиглаж сурахад суралцагчдад тулгарсан зарим бэрхшээл	211
Бие даалтын бүтээлээр дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь	220
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	231
Өөрийн үнэлгээгээр оюутны ахиц хөгжлийг дэмжих арга зүй, боломж	231
“Чухлыг сонгон тайлбарлах” аргаар сурагчдын бүтээлээр унших, бичих, ярих чадварыг хөгжүүлэх нь.....	237
“Хичээл төлөвлөлт хүүхдийн хөгжилд үйлийн судалгаа нөлөөлөх нь	252
Тулгуур дохионы аргаар суралцагчдын англиар ярих чадварыг нэмэгдүүлэх нь	259
Сурагчдад үр дүнтэй бичих арга техникийг эзэмшүүлэх нь.....	266
“Айзамт 5 хором”-оор сурагчдын уншаад тогтоох чадварыг ахиулах нь.....	278
Уран зохиолын хичээлээр суралцагчдын мэдээлэл боловсруулах чадварыг хөгжүүлэх нь	290
“Анхааралтай сонсох арга”-аар сонсох, ярих, бичих чадварыг хөгжүүлэх нь	296
Зүү ороож оёх хялбар аргачлал.....	302

ӨМНӨХ ҮГ



Зуу гаруй жилийн тэртээ Япон улсын бага сургуулийн багш нарын санаачилж, үүсгэсэн хичээлийн судалгааны арга зүй өнөөдөр дэлхийн олон улсад түгэн дэлгэрээд байна. Энэ арга зүйг Монгол улсад таниулах, туршин хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх төслийн ажил Жайка байгууллагын дэмжлэгийн дор зургаан жилийн хугацаанд 2006-2009, 2009-2012 гэсэн хоёр үе шаттай амжилттай хэрэгжсэн билээ.

“Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг” гэдэг нэгэн айл энэ төслийг үргэлжлүүлж, хичээлийн судалгааг Монгол улсын ерөнхий боловсролын сургуульд нутагшуулахаар өрхөө татаж, үүдээ сөхсөн өдрөөс хойш таван хаврыг угтаж, таван намрыг үджээ. Хүний насаар тоолбол тархины хөгжлийн оргил үе гэж хэлж болно. Байгууллагын хувьд ч хийж бүтээхээр зорьсныхоо суурийг болсгож, хөгжүүлэх чигээ тогтоосон цаг үе байсан болов уу.

Хичээлийн судалгаа гэдэг бол багш мэргэжил эзэмшин хойч ирээдүйгээ сургаж байгаа хэн бүхний мэргэжлийн багаж байх ёстой цаг үед бид ажиллаж, амьдарч байна. Алс холын од эрхэсийг дурангүйгээр судлах боломжгүй одон оронч шиг, амтат сайхан хоолыг хутга, галгүйгээр хийх боломжгүй тогооч шиг, аль нэг очих газарт минь унаагүйгээр хүргэх боломжгүй жолооч шиг хичээлийн судалгаа бол багш хүний сурагчдынхаа сэтгэлд юуг бүтээж өгснөө хэмжиж, шалгах багаж байх ёстой цаг үед бид ажиллаж байна. Зааж байгаа хичээл маань сурагчдын хэрэгцээг хангаж байгаа эсэх, үр дүнд хүрч байгаа эсэх, өмнөхөөсөө ахиж дэвшиж байгаа эсэхээ хэмжих багаж бол хичээлийн судалгаа юм. Магад заримдаа хэн нэг багшийн хичээлд ажиглалт хийж, хэлэлцэх, дүгнэж ярилцах нь цаг авч байгаа мэт санагдах үе байдаг ч өвдсөн хүүхдийн тань халуун хэд хүрч байгаа, ямар эмчилгээ шаардлагатай байгааг хэлж өгдөг “халууны шил”-ийн үүргийг хичээлийн судалгаа бидний ажилд гүйцэтгэж байдаг билээ.

Зөвхөн тухайн багшийн хичээлээ заах чадварыг өсгөөд зогсохгүй багш нарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, багш багшаасаа сурсан хамтын ажиллагааны чадвараа сурагчдадаа өвлүүлэхийн суурийг тавьж өгөх зорилгоор Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг хамтран “Боловсролын чанар хичээлийн чанараас, хичээлийн чанар хичээлийн судалгаанаас” гэсэн уриан дор “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” онол практикийн бага хурлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн билээ.

Эдгээр хурлаар багш, удирдах ажилтан, судлаачдын хичээлийн судалгаагаар бүтээсэн шилдэг арга туршлага, технологи, үр дүнг хэлэлцэж, хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг боловсронгуй болгон хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох, ажлын байрандаа хамтдаа тасралтгүй хөгжих хэрэгцээ, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжсээр ирлээ.

Энэ удаагийн VI бага хурал Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн 5 жилийн ойтой давхцаж байгаа, ЛСА олон улсын байгууллагаас Монгол улсад хэрэгжүүлж буй Тусгай хэрэгцээт боловсролын START төсөл хамтран дэмжиж ажиллаж байгаа зэрэг онцлогтой байна. Түүнчлэн жилээс жилд энэхүү онол, практикийн бага хурлын хамрах хүрээ өргөжин тэлж, сургуулийн өмнөх боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн багш нар, эрдэмтэн судлаачид хамтран оролцож, хичээлийн судалгаагаар бүтээсэн үр дүнтэй арга зүй, туршлага, технологи хуваалцаж байна. Цаашдаа ч илүү өргөжин хөгжинө гэдэгт итгэж байна.

Та бүхний сурган хүмүүжүүлэх, судалгааны ажилд амжилт хүсье.

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ

Захирал Д.Сүрэнчимэг Ph.D



Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэг үүсэн байгуулагдсаны 5 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол практикийн VI бага хурлаар дахин уулзаж байгаадаа баяртай байна.

2013 оны 8 дугаар сарын 15-16-нд БМДИ ба төслийн баг хамтран зохион байгуулсан “Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал” дээр ашгийн бус ТББ “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (Mongolian Association of Lesson Study)”-ийг байгуулах тухай анх зарласан. Мөн оны 9 дүгээр сарын 03-нд үүсгэн байгуулагчдын анхдугаар хурал хуралдаж тус нийгэмлэгийг ТББ хэлбэрээр байгуулах хүсэлт гарган шийдвэрлүүлэхээр болсон бөгөөд энэ өдрийг МХСН байгуулагдсан өдөр гэж албан ёсоор үздэг юм. БСШУЯ

ба ОУХА-ы нийгэмлэг Жайка байгууллагын хамтарсан “Суралцагчдын суралцах арга зүйг дэмжих багшлах арга зүй”, “Багшлах арга зүйг хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” гэсэн хоёр шаттай төсөл 2006-2013 онд хэрэгжүүлсэн билээ. Хичээлийн судалгааны арга зүйд эхлэн суралцаж байсан тэр цагаас эдүгээр хүртэл 12 жил өнгөрсөн ч төслийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж байна. Төсөл нь хүүхдийг хөгжүүлэх сургалтын шинэ арга зүйг бүтээх, тэдний бие даан суралцах чадварыг нээн хөгжүүлэх үндсэн арга зам болох хичээлийн судалгааны арга зүйг судлан хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсээр дамжуулан багш нарын мэргэжил дээшлүүлэх, тэднийг ажлын байран дээр нь хөгжүүлэх ажлын суурь эхлэлийг байсан билээ. Энэхүү XXI зууны багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн арга замыг цаашид хөгжүүлэх төдийгүй дотоод гадаад сурталчлах үйлсэд БМДИ ба МХСН үр дүнтэй хамтран ажиллаж байна.

Хичээлийн судалгаа нь манай ЕБС-иудад суралцагчдын хөгжлийг хангах, сургалтын чанарыг улам бүр сайжруулах, багшлах арга зүйг тасралтгүй хөгжүүлэх анхны зорилгынхоо дагуу амжилттай түгэн дэлгэрч байна. “ТХЗ 4-Боловсрол-2030-д боловсролын шинэ алсын хараанд чиглүүлэн “Сургалтын технологит хичээлийн судалгааг нэвтрүүлэх” гэсэн сургуулийн түвшинд хэрэгжүүлэх стратегүүдийн харилцан уялдаа, нэгдмэл шинж чанарын онол, арга зүйн үндэслэлийг тодорхойлсон нь цаашид хичээлийн судалгааны арга зүйн судалгааг судлан хөгжүүлэх замаар боловсролоо хувирган өөрчлөх шинэ шатны зорилт дэвшиж байна.

Хурлыг зохион байгуулах нөр их ажлыг санаачлагатай, сэтгэл зүтгэлээрээ амжилттай биелүүлж байдаг БМДИ, МХСН-ийн удирдлага, хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд болон мэргэжлийн багийн эксперт, зөвлөхүүддээ талархал илэрхийлье. Мөн монголд хичээлийн судалгааг анх эхлүүлэн хөгжүүлсэн, цаашид тогтвортой авч явахад оролцож буй, шинэ арга зүй бүтээж бусадтайгаа хуваалцсан, түгээн дэлгэрүүлсэн бүх хүмүүстээ МХСН-ийн үүсэн байгуулагдсаны 5 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

Онол практикийн VI бага хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.
Та бүгдийн бүтээсэн шинэ санаа, арга зүй түгэн дэлгэрэх болтугай

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ

Гүйцэтгэх захирал

Н.ОЮУНЦЭЦЭГ



Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг хамтран 6 дахь жилдээ “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол, практикийн бага хурлыг зохион байгуулж байгаад талархлаа илэрхийлье.

Энэ жилийн хурал “Сургуульд суурилсан хичээлийн судалгаа”, “Судлагдахуунд суурилсан хичээлийн судлагаа”, “Хүүхдийн хөгжлийн судалгаа”, “Тусгай хэрэгцээт боловсролын судалгаа” гэсэн 4 чиглэлээр 135 илтгэлийг хүлээн авлаа. Мөн хамрах хүрээгээ тэлж, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдлага, орон нутгийн БСГ-ын мэргэжилтнүүд, их дээд

сургуулийн багш, судлаач, оюутан нар оролцох боломж нээлттэй болсоор байна. 2006 оноос ЖАЙКА “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил төсөл” хэрэгжүүлэн, Монгол улсад Хичээлийн судалгааны арга зүйг танилцуулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Боловсролын хүрээлэн, БМДИ, МУИС, МУБИС, аймгийн БСГ, нийслэлийн болон орон нутгийн туршилтын сургуулиудын багш нарын хамтын оролцоо, хүчээр үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн билээ.

ЖАЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллага нь Монгол улсаас гадна бусад олон улс орнуудад “Хичээлийн судалгаа”-ны арга зүйг танилцуулж, түгээн дэлгэрүүлж ирсэн боловч төсөл дуусахын хамтаар “Хичээлийн судалгаа” ч бас дууссан орны жишээ байсаар байна. Харин Монгол орны хувьд үндэсний хэмжээнд сургуулиуд дээр үргэлжлүүлэн Хичээлийн судалгааг хийж, “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг”-ийг үүсгэн байгуулснаар үйл ажиллагаагаа нь тогтвортой явж байгаа нь үнэхээр сайшаалтай байна. Мөн БМДИ-ийн үндсэн сургалтаар “Хичээлийн судалгаа”-г танилцуулж байгаа нь энэ арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр болж байна.

Монгол улс Хичээлийн судалгаагаар дамжуулан багшийн мэргэжил, арга зүйгээ улам сайжруулан, хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн чанартай боловсролын үйлчилгээ хүртэнэ гэдэгт итгэлтэй байна. Та бүхэнд МХСН-ийн үүсэн байгуулагсаны 5 жилийн ойн баярыг хүргэе.

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ
Гишүүн Иший Тэцужа

НЭГ. МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮНДСЭН ИЛТГЭЛ

Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг 5 жилд

Ноокоо Оюунцэцэг
МХСН-ийн гүйцэтгэх захирал
99231521, nookooyun@yahoo.com

Зорилго

МХСН-ийн үүсэн байгуулагдсаны 5 жилийн ойг тохиолдуулан өнгөрсөн 5 жилийн ажлаа нэгтгэн дүгнэж тайлагнах, тохиолдож буй бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замуудыг хэлэлцүүлэхэд чиглэгдэж байна.

Түлхүүр үг

Хичээлийн судалгаа, судалгаат хичээл, суралцахуйг дэмжсэн арга зүй,

Удиртгал

БСШУЯ ба ОУХА-ы нийгэмлэг Жайка байгууллагын хамтарсан “Суралцагчдын суралцах арга зүйг дэмжих багшлах арга зүй”, “Багшлах арга зүйг хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” гэсэн хоёр шаттай төсөл 2006-2013 онд хэрэгжүүлсэн билээ. Энэ төсөл хэрэгжиж хичээлийн судалгааны арга зүйд эхлэн суралцаж байсан тэр цагаас эдүгээр хүртэл 12 жил өнгөрчээ. Энэхүү төсөл нь хүүхдийг хөгжүүлэх сургалтын шинэ арга зүйг бүтээх, тэдний бие даан суралцах чадварыг нээн хөгжүүлэх үндсэн арга зам болох хичээлийн судалгааны арга зүйг судлан хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсээр дамжуулан багш нарын мэргэжил дээшлүүлэх, тэднийг ажлын байран дээр нь хөгжүүлэх ажлын суурь эхлэлийг байсан билээ.

2013 онд төслийн хоёрдугаар шат дуусахад төслийн үндсэн үйл ажиллагааг тогтвортой байдлыг цаашид хангах, багшлахуй ба суралцахуйн чанарыг ахиулах үндсэн арга хэрэгсэл болох хичээлийн судалгааг цаашид хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарсан билээ. Энэхүү эрэлт хэрэгцээг хангах, үйл ажиллагааг нь авч явах нэр хүнтэй, хариуцлагатай үүргийг төрийн байгууллага БМДИ ба ТБ байгууллага МХСН хүлээн авч өнөөдөр хүртэл амжилттай хамтран ажиллаж байна.

2013 оны 8 дугаар сарын 15-16-нд БМДИ ба төслийн баг хамтран зохион байгуулсан “Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал” дээр ашгийн бус ТББ “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (Mongolian Association of Lesson Study)”-ийг байгуулах тухай анх зарласан. Мөн оны 9 дүгээр сарын 03-нд үүсгэн байгуулагчдын анхдугаар хурал хуралдаж тус нийгэмлэгийг ТББ хэлбэрээр байгуулах хүсэлт гарган шийдвэрлүүлэхээр болсон бөгөөд энэ өдрийг МХСН байгуулагдсан өдөр гэж албан ёсоор үздэг юм.

2013 оны 9 дугаар сарын 27-нд болсон МХСН-ийн удирдах зөвлөлийн анхдугаар хурлаар байгууллагын эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл, дүрмийн бүтцийг баталсан байна. Тус хурлаас “Судалгаанд суурилсан хичээл- Суралцахуйг дэмжсэн арга зүйн хөгжил” гэсэн эрхэм зорилго, “Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх замаар суралцахуйн чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулахад оршино” гэж байгууллагын зорилгыг томьёолон баталжээ.

МХСН боловсролын судалгаа, суралцахуйн судалгаа, багш бэлтгэдэг их дээд сургууль болон ЕБС-ийн багш нар, судлаачдын хамтын ажиллагаа, ажлын байран дээр багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа, сургалт, судалгаа, мониторинг, зөвлөгөө, туршлага солилцоо, гадаад харилцаа зэрэг үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирлээ.

Тус байгууллага нь удирдах болон үүсгэн байгуулагчдын зөвлөлийн удирдлага дор сургалт хамтын ажиллагааны, судалгаа арга зүйн, гадаад харилцаа, хамтын ажиллагааны, хэвлэл мэдээллийн хороо гэсэн бүтэцтэйгээр гүйцэтгэх захирал, нягтлан бодох, сайтын админ гэсэн албан ёсны орон тоо, орон тооны бус сайн дурын идэвхтэн, гишүүдтэйгээр ажиллаж байна. Төслийн дараа орон нутагт БГ-ын

дэргэд 20-21 хүнтэй баг, БМДИ дээр төсөлд хамрагдаагүй бусад судлагдахууны багууд зохион байгуулагдсан болно.

“Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүй”, “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” 2 үе шаттай хэрэгжүүлсэн төслийн загвар аймгаар ажиллаж, багшлах арга зүйн баялаг туршлага хуримтлуулсан Сэлэнгэ аймаг Хичээлийн судалгааны нийгэмлэгийн анхны салбар зөвлөлийг 2018 оны 01 дүгээр сарын 24-нд байгуулан ажиллаж байна. Одоо Завхан, Дорнод, Говь-Алтай зэрэг хэд хэдэн аймаг салбар зөвлөл байгуулах хүсэлт ирүүлээд байна.

Багшлахуйн хөгжлийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар ажлын байран дээрээ багшлах арга зүйг хөгжүүлэх үйлсэд дэмжлэг үзүүлэх зорилгоор mals.mn сайтыг 2015 оны 10 дугаар сард нээж, түүгээр дамжуулан МХСН-ийн үйл ажиллагаа, сургууль, багш нарын туршлагыг түгээн дэлгэрүүлж байна.

Үндсэн агуулга: МХСН-ийн 5 жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Хичээлийн судалгаа нь манай ЕБС-иудад суралцагчдын хөгжлийг хангах, сургалтын чанарыг улам бүр сайжруулах, багшлах арга зүйг тасралтгүй хөгжүүлэх анхны зорилгынхоо дагуу амжилттай хэрэгжиж, түгээн дэлгэрч байна. “ТХЗ 4-Боловсрол-2030 үйлийн хүрээ”-нд тодорхойлсон боловсролын шинэ алсын хараанд чиглүүлэн “*Сургалтын технологит хичээлийн судалгааг нэвтрүүлэх*” гэсэн сургуулийн түвшинд хэрэгжүүлэх стратегүүдийн харилцан уялдаа, нэгдмэл шинж чанарын онол, арга зүйн үндэслэлийг тодорхойлсон нь цаашид хичээлийн судалгааны арга зүйн судалгааг судлан хөгжүүлэх замаар боловсролоо хувирган өөрчлөх үйл явцын нэг хөшүүрэг болгох шинэ зорилт дэвшиж байна (Ч.Нямгэрэл, Н.Нэргүй, 2018).

Судалгаа.

Хичээлийн чанарыг дээшлүүлэх үндсэн арга зам болох хичээлийн судалгааны арга зүйг хэрэгжүүлэх замаар сурагчдын суралцахуйг дэмжих багшлах арга зүйг судлаачид, багш нар, оюутан багш нарын хамтын ажиллагаагаар бүтээх, түгээн дэлгэрүүлэх үндсэн зорилгоор судалгааны ажил хийгдэж байна. БСШУЯ ба Жайка байгууллагын төсөлд ажилласан судлаачид, багш нар, бэлтгэгдсэн хичээлийн судалгааны мэргэжилтэн (эксперт, үндэсний зөвлөх, сургагч багш) болон сургууль багш нар хамтран сургуульд суурилсан болон судлагдахуунд суурилсан судалгааны чиглэлийг боломжийн түвшинд хөгжүүлж байна. Тэдгээр судалгааны ажлыг МУИС, МУБИС болон зарим багш бэлтгэдэг дээд сургуулийн судлаачид хичээлийн судалгаа судлан хөгжүүлэх эрдэм шинжилгээний ажил хийх, багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлээр голлон гүйцэтгэж үр дүнг илтгэл, өгүүлэл, магистрын дипломын ажил, докторын диссертаци зэрэг эрдэм шинжилгээний бүтээл хэлбэрээр хэлбэршүүлдэг. Тухайлбал, МУБИС дээр 1 доктор, 5 магистрын дипломын ажил (Г.Баярмаа, 2018), МУИС дээр хими, физик боловсролын чиглэлээр 7 бакалавр төгсөж, 3 магистр, 1 доктор суралцаж байна.

БМДИ-ийн арга зүйчид багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, хичээлийн судалгааг хөгжүүлэх, мониторинг хийх үйл ажиллагааг явуулах зэргээр багшлахуйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд бодит хувь нэмрээ оруулан ажиллаж ирлээ. БМДИ, МХСН дээрх үйл ажиллагааг чиглүүлэх, үр дүнг дүгээн дэлгэрүүлэх, нэгтгэн дүгнэхэд голлон анхаарч байна.

БМДИ, МХСН хамтран жил бүр зохион байгуулдаг “Хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах аргазүй” сэдэвт онол практикийн бага хурлаар судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж чиглүүлэхийн зэрэгцээ ЕБС-ийн болон их, дээд сургуулийн судлаачид, боловсролын салбарын удирдах ажилтнуудын туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх сайхан талбар болж ирлээ.

“Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол практикийн бага хурал 2013 оноос эхлэн “Боловсролын чанар нь хичээлийн чанараас, хичээлийн чанар нь хичээлийн судалгаанаас” уриан дор тогтмол явагдаж ирлээ.

“Хүүхдийн хөгжил хичээлийн судалгаа” сэдэвт үндэсний ЭШ-ий анхдугаар бага хурлыг “Багшлах арга зүйн хөгжлийн тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд санаачлан 2013 онд зохион байгуулсан. Энэ хуралд төсөл хэрэгжүүлсэн загвар аймгуудын сургуульд суурилсан 2, судлагдахуунд суурилсан 10

илтгэл, мэргэжлийн багийн 12, нийт 24 илтгэл хэлэлцсэн байна. 2014 оноос БМДИ, МХСН-ийн хамтран “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвтэй үндэсний онол практикийн бага хурлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирлээ.

Хүснэгт 1. Үндэсний онол практикийн бага хурлын илтгэлийн тоон товчоо.

№	Хуралдсан он, сар, өдөр	Ирсэн илтгэл	Хэлэлцүүлсэн аман илтгэл					Үүнээс ханын	Нийт
			Үндсэн	Сур.д С	Суд.д С	Хүүхдийн хөгжил	ТХБ		
II	2014.12.17-18	174	8	3	17		-	10	38
III	2015.12.17-18	177					-	13	45+13
IV	2016.11.22-23		7	6	48	?	-	4	65
V	2018.01.11-12	138	4	3	37	4	6	?	54

Онол практикийн дөрөвдүгээр бага хуралд “Хүүхдийн хөгжлийн судалгаа”, тавдугаар бага хуралд “Тусгай хэрэгцээт боловсрол”-ын чиглэлээр шинээр нэмэгдсэн байна.

Хичээлийн судалгаа, хүүхдийн хөгжлийн чиглэлээр судалгааны үр дүнгээ дэлхийн тавцанд хүргэх нэг арга зам бол WALS болж байна. Хичээлийн судалгааны дэлхийн нийгэмлэг (The World Association of Lesson Studies-WALS) нь багшлахуй, суралцахуйн чанарыг дээшлүүлэх зорилт бүхий хичээлийн судалгааны практик үйл ажиллагаа болон шинжилгээ судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2000 оны эхэн үед байгуулагджээ. Энэ үеэс улс орнуудын боловсролын судлаачид, сургуулийн захирал, сургалтын менежер, багш нар хичээлийн судалгааны арга зүйн талаар харилцан туршлага солилцох, бэрхшээлээ хамтдаа туулан хөгжихөөс гадна хөгжлийн хэтийн чиг хандлагын талаар олон улсын түвшинд хэлэлцдэг болсон юм.

Манай судлаачид 2012 оноос эхлэн WALS-ийн хуралд тогтмол оролцож монгол дахь хичээлийн судалгааны түүх, хөгжил, бэрхшээлүүдээ хуваалцахаас гадна олон улсын судлаачдаас судалгааны арга зүй, практик туршлагуудыг сурч өөрийн орны боловсролын хөгжилд зохих хувь нэмэр оруулж байна.

Хүснэгт 2. WALS-ийн хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн товчоо

Он	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	Хаана
WALS-2012	Some results if implementing the lesson Study by chemistry teacher’s Bayangol district	Ч.Нямгэрэл (МУИС) Ж.Энэбиш	
WALS-2013	Has the lesson study changed the teacher’s of Mongolia?	Тэцүя Н.Оюунцэцэг, Сузуки	Иший, Саяака Швед
WALS 2014	Improving mathematics learning tools through lesson study	Т.Ганбаатар	Индонез, Бандуг
WALS-2015	Condition of lesson study in Mongolia	Т.Ганбаатар, Н.Оюунцэцэг, Б.Хишигбаяр, О.Оюунтунгалаг	Тайланд, Бандунг
WALS-2015	Assessing opportunities of lesson on classroom practices in an undergraduate science education course in Mongolia	Ц.Пагамсүрэн	Тайланд,
WALS-2016	Results of the research Mongolian Classroom Discourse In Historical And International Context: Through Lesson Analysis Of Mathematics Lessons	Н.Дуламжав (МУБИС) Т.Ганбаатар (МУБИС) О.Алтангоо (МУБИС)	Англи (United Kingdom)

WALS-2017	A Methodology to Measure Lesson Quality through Students' Engagement Using Transcript Based Lesson Analysis	Т.Ганбаатар (МУБИС)	Япон, Нагоя
	Result of Abstract submission No.: 20411	Ш.Сайнбилэг, Н.Оюунцэцэг	Япон, Нагоя
	Situation of Lesson Study at Graduate School of Mongolia	Г.Баярмаа, Н.Дуламжав Отани Такаши	Япон, Нагоя
	Curriculum Improvement Through The Competence Based Assessment in Mongolia	Д.Нямжав (МУБИС) Ц.Оюунбат (МУБИС) Н.Дуламжав (МУБИС) Д.Пүрэвсүрэн (Гурван-Эрдэнэ)	Япон, Нагоя

2018 оны 11 дүгээр сарын 24-27-нд Бээжин хотод болох WALS-2018 хуралд манай төлөөлөгчид илтгэлээ хэлэлцүүлэхээр олон хүнтэй баг явах гэж байгаа. Энэ багийн бүрэлдэхүүнд Өвөрхангай аймгийн 1-р сургуулийн А.Батцэцэг ахлагчтай багш нарын оролцож илтгэл тавих болсоныг дуулгахад таатай байна.

Ийнхүү хичээлийн судалгааны арга зүй нь их дээд сургуулийн судлаачдын судалгааны нэгэн шинэ сэдэв болж өргөжин хүрээгээ тэлж өсөн дэвжиж байгаа боловч улсын хэмжээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжилт олж технологийн түвшинд үндэсний онцлогтойгоор загварчлан гаргах, боловсролын бүх түвшинг жигд хамруулж чадахгүй байгаа (СӨБ, дээд), аймаг орон, дүүргийн оролцоо жигд бус байгаа, ялангуяа судлаачдын хамтын ажиллагаа дутмаг зэрэг бэрхшээл тулгамдсан асуудал байгааг тэмдэглэж байна. Энэ тулгамдсан бэрхшээлүүд нь бидний цаашид хөгжих хөгжлийн шинэ эрэлт хэрэгцээ болж байна.

Сургалт

МХСН-ийн нэг томоохон үйл ажиллагаа бол дотоодын болон гадаадын сургалт зохион байгуулах зорилт юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дотоодод захиалгат сургалт, зочны хэлэлцүүлэгт сургалт, төрөлжсөн сургалт, мониторинг зөвөлгөө өгөх, Mals.mn сайтаар дамжуулан мэдээлэл түгээх, харилцан туршлага солилцох зэрэг хэлбэрээр үйл ажиллагааг явуулж ирлээ. Японд жил бүр “Хичээлийн судалгааны арга зүй” сургалтыг зохион байгуулж байна.

Захиалгат сургалт. Захиалгат сургалтыг бэлтгэсэн хичээлийн судалгааны эксперт, үндэсний зөвлөхүүдийн оролцоотойгоор зохион байгуулж ирлээ. Тухайлбал,

- УБ, Эрдмийн Өргөө цогцолбор сургууль дээр 21 аймаг 9 дүүргийн оролцогч 225 хүний 5 өдрийн сургалт зохион байгуулсан (2013.10 сард)
- Нийслэлийн сургуулиудын захирлуудын сургалт (2014 он, МУИС-ийн 320)
- Өвөрхангай Хар хорины сургуулиуд (2014 оны хавар)
- Орхон аймгийн Орхон цогцолбор сургууль, “Судалгаат хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг”, “Сургуульд суурилсан хичээлийн судалгаа”, 2015.01.21
- “Хичээлийн судалгаа - Судалгаат хичээл” сургалт МУБИС-ийн харьяа лицей бага сургууль (2017 он)
- Жайка, Тусгай Хэрэгцээт Боловсролын төслийн захиалгат “Хичээлийн судалгааны арга зүй” сэдэвт сургалт (2018.02.24, МУБИС)
- Сэлэнгэ аймгийн бүсийн сургуулиудын “Хичээлийн судалгаа - Судалгаат хичээл” сургалт, (2018.04.28, Мандал сумын 1 дүгээр сургууль дээр)
- Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар сургууль, “Бүсийн сургалт – хичээлийн судалгаа (2018.04.21- 22, Чойбалсан)
- Хөвсгөл аймаг “Дэлгэрмөрөн цогцолбор” сургуулийн Хичээлийн судалгааны өдөрлөг, (2017.11 сар; Монголд анх удаа, Мөрөн)
- Хөвсгөл аймаг “Дэлгэрмөрөн цогцолбор” сургуулийн Хичээлийн судалгааны өдөрлөг, 2018 оны 10 сарын 03-04, Мөрөн

- Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар сургууль, “Бүсийн сургалт – хичээлийн судалгаа, сэдэвт сургалт, (2018.10.26- 27 (Чойбалсан)

Хичээлийн судалгааны захиалгат сургалтыг зохион байгуулахад идэвх зүтгэлтэй ажилладаг хичээлийн судалгааны эксперт Т.Ганбаатар, Н.Оюунцэцэг, Д.Энхтуяа, М.Ганбат, Г.Норжмаа болон бусад сургагч багш нартаа баярласнаа илэрхийлье.

Хэлэлцүүлэгт сургалт. Хичээлийн судалгааны өлгий нутаг Японы профессор багш нар, сайн дурын ажилтнууд цуврал лекц, хэлэлцүүлэгт сургалтыг явуулж ирлээ. Тухайлбал, 2014-2016 онд математик, байгалийн ухааны багш нарт зориулсан Иижима, Камата, Хаяаши, Мацүра (Гакугейн их сургууль), 2016-2017 онд Takashi Otani, Yoshiaki Shibata (Нагоя Их сургууль) багш нартай хичээлийн судалгаа, хичээл ажиглалтын талаар санал солилцох хэлэлцүүлэгт сургалтыг явуулсан байна. Мөн Монголд ажиллаж буй Жайкагийн сайн дурын багш Аүака Комүра математик, Касэ байгалийн ухааны сургалтыг нийгэмлэгийн гишүүд, багш нарт зориулсан цуврал сургалт, хэлэлцүүлэг явуулсан байна.

Япон дахь сургалт. Төслийн нэг үндсэн үйл ажиллагаа байсан “Хичээлийн судалгааны арга зүй” сэдэвт Японд дахь сургалтыг МХСН уламжлан авч 2014 оноос эхлэн жил бүр зохион байгуулж ирлээ. Япон сургууль дахь хичээлийн судалгааны арга зүйн хөгжил, бодит судалгаат хичээлд оролцох замаар хичээлийн судалгааны арга зүйг ухааран ойлгох зорилготой уг сургалтаар Японы боловсролын систем, сургуулийн үйл ажиллагаа, багш нарын багшлах арга зүйн туршлага судлах, хичээлийн судалгааны өдөрлөгт оролцох, багш нар арга зүйгээ хэрхэн дээшлүүлж байгаатай танилцахаас гадна тухайн багт орсон багш, мэргэжилтний мэргэжлийн онцлогтой сэдвийг оруулж өгдөг. Жишээлбэл, СӨБ-ийн мэргэжилтэн, багш байвал тусгайлан СӨБ-ийн үйл ажиллагаа, хичээлтэй танилцана.

2014-2018 онд явагдсан 6 удаагийн сургалтад боловсролын салбарын удирдлага, захирал, сургалтын менежер, багш нар нийт 85 хүн хамрагдсан байна.

Хүснэгт 3. Япон дахь сургалтын товчоо (оролцоогоор)

Он	Хамрагдсан хүний тоо	Бүрэлдэхүүн	Хаана
2014	12	БСГ-ын дарга-2, ЕБС-ийн захирал 2, ЕБС-ийн багш 8	Токио
2015	15	БМДИ- ийн арга зүйч 5, МУИС-2, ЕБС-ийн сургалтын менежер -2, багш -6	Токио
2016	15	ЕБС-ийн захирал 1, сургалтын менежер-1, багш -13	Токио
2017	11	БҮТ-3, ЕБС-ийн захирал 1, МУБИС-ийн багш 2, багш 4	Нагоя ИС,
2017	15	Дүүргийн мэргэжилтэн-1, ЕБС-ийн захирал -3, МУИС багш -2, ЕБС-ийн багш- 9	Токио
2018	14	Сургалтын менежер -4, МУИС-ийн багш -1, ЕБС-ийн багш-9	Токио
Нийт	85		

Сургалтад хамрагдсан багш нарын сэтгэгдлээс харахад энэхүү сургалт үр нөлөөтэй сураглт болох нь харагдаж байна.

- Асар их тэвчээр хүчин зүтгэлийн үр дүн энэ өндөр боловсролын системийг бий болгосныг ойлгосон
- Хэт өндөр түвшинд хичээлээ шахааж, мэдээлэл дамжуулах үүднээс зааж байгаа маань алдаа юм. Цаашид хичээлийг хүүхдэд зориулж, удаан ч гэсэн эрдэм болгож үлдээж заах хэрэгтэй юм байна
- Багшийг шалгах дүгнэх биш, багш сурагчдын төлөө үргэлж дэмжиж, тусалж ажилладаг
- Хүүхдүүдийг сэргэлэн цовоо, хэлэх гэсэн зүйлээ шууд хэлдэг болгодог
- Бодлого гаргаад багишдаа даатгаад хаядаг биш яамнаасаа багш хүртэл бүгд холбоотой нэг чиглэлээр ажиллаж, ижил нэгж, ээлжит хөтөлбөрөөр зааж байгаа нь хүүхдэд ялгавартай биш жигд хөгжих боломж олгодог
- БУ-ы хичээл дээр хүүхдүүд хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэлтэй харьцаж байгаа, ажигласан зүйлээ тэмдэглэн бичиж байгаа, хичээлд мэдэхийн төлөө оролцож, эргэлзээтэй зүйлийг өөрөө явж бусдаас мэдэж авч байгаа зэрэг үйлүүд нь бүр хэвшил болохоос гадна "би хийх ёстой" гэсэн сэтгэлтэй байгаа нь таалагдсан

- Хичээлийн дараах хэлэлцүүлэгт бидний саналыг сонсож хуваалцаж бас асуултанд хариулж байгаа нь энгийн бөгөөд сэтгэл шингэсэн
- "Дүүргийн боловсролын хэлтэс"-ээс мэргэжилтнүүд жилд нэг сургууль ээр 10 удаа зөвлөн тусалдаг
- Хүүхдийг багаас нь эмх цэгцтэй байдалд сургаж чаддаг, сургуулийн гадна, дотор орчинг энгийн зүйлээр шийдсэн
- Хичээл сураглтын хөтөлбөрөөс зорилгоо тодорхойлно, стандарттай тохирсон үнэлгээтэй, шалгуураа төлөвлөдөг
- Залуу багш, ахмад багш, зөвлөх, судлаачид үр дүнтэй хамтран ажилладаг. Хамтран төлөвлөх, хичээл ажиглалт хийх, хичээл зааж үзүүлэх, хичээлийн бэлтгэл судалгаа хийх, ямар даалгавар өгөх гэж байгаа, ямар асуулт асуух гэж байгаа, хүүхэд юу гэж хариулах бол гэх мэт зүйлсийг зөвлөдөг.
- Японы сургуулийн эрхэм зорилго нь "Сайхан сэтгэл, эрдэм мэдлэг, эрүүл биеийг төлөвшүүлдэг сургууль", "Аливааг даван туулах чадвартай хүүхэд болгон төлөвшүүлэх" гэх мэтчлэн хүүхдийн төлөө байдаг.
- Японы хүүхдүүд бусаддаа туслах гэсэн сэтгэлээр, хандлагаар хичээлдээ оролцдог болохыг бодитоор харсан. Хүүхэд өөрөө мэдэх, сурах нь чухал биш багийнхаа найзад, асуудалтай байгаа ангийнхаа найзад туслая, түүнийг сурсая гэсэн сэтгэлээр хичээлдээ оролцож байсан. (Математикийн 4-р ангийн хичээл)
- 5-р ангийн физикийн "Хүнд, хөнгөн" туршилтат хичээлийг үзэхэд хүүхдийг чөлөөтэй туршуулж, бүх боломжийг туршиж үзэх боломж олгож байгаа нь хүүхдийг хэдэн удаа турш, тэг ингэ гэж хайрцаглахгүй байгаа нь миний хувьд суралцах нэг том арга зүй байсан. Учир нь би туршилтат хичээл дээр хүүхдүүдээр хурдан туршуулаад, үр дүнг гаргах гэж яардаг байснаа ойлгосон.
- Япон багш нар үйл ажиллагаандаа судалгаатай ханддаг. Түүнийгээ шийдэж чаддаг хүмүүс юм Уйгагүй хөдөлмөрлөж судалж, үр дүнг нь хардаг юм байна. Хүүхдийг багаас нь эмх цэгцтэй байдалд сургаж чадаж байгаа нь зөвхөн нэг цагийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг эмхэлж цэгцэлж байгаа байдлаас харагдлаа. Хичээлийг хүүхэд өөрөө хийсээр байгаад шинэ мэдлэгээ бүтээж түүнийгээ тайлбарладаг талаар олон шинэ санаа авсан. Бид тэднээс сурах зүйл их байлаа гэх мэт маш олон сэтгэгдэл ирүүлдэг (mals.mn сайтаас).

Төрөлжсөн сургалт. БСШУЯ ба олон улсын Жайка байгууллагын хамтарсан төслийн багт оролцож хичээлийн судалгааны арга зүйд суралцан туршлага хуримтлуулсан хичээлийн судалгааны үндэсний эксперт 22, үндэсний зөвлөх 24, үндэсний сургагч багш 11, Бүсийн сургагч багш 49 бэлтгэгдсэн байдаг. МХСН уг үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрх олгох төрөлжсөн сургалтыг хөтөлбөрийг боловсруулан холбогдох байгууллагаар батлуулан 2016 оноос эхлүүлсэн.

Эрх олгох төрөлжсөн сургалтын зорилго "Шинэ зууны хамгийн өгөөжтэй багийн мэргэжил дээшлүүлэх арга болсон ажлын байран дээр багшлах арга зүйгээ хамтран хөгжүүлэх замаар хичээлийн судалгааг удирдах, зөвлөх, хөгжүүлэх чанартай мэргэжилтэн бэлтгэх" явдал юм. Энэхүү хөтөлбөрийн онцлог нь өөрийн идэвхтэй, практик үйлээр суралцаж хөтөлбөрийн мэдлэг, чадвараа эзэмшиж, тодорхой шалгууруудыг хангасан нөхцөлд эрхээ авдаг юм (mals.mn сайтаас шалгууруудыг үзнэ).

МХСН 2017 онд Монгол улсад багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд өөрийн бодит үйл ажиллагаагаар оролцож, зохих шалгуурыг хангасан дараах багш нарт хичээлийн судалгааны "Үндэсний шинжээч", "Бүсийн сургагч багш"-ийн эрх олгосон байна.

Хүснэгт 4. төрөлжсөн сургалтад хамрагдан 2017 онд хичээлийн судалгааны эрх авсан багш нар

Эрх	Хэнд	Үндсэн ажил	Гэрчилгээний дугаар
Үндэсний эксперт	Гончигжавын Юмчмаа	МУИС, ШУС-ийн газар зүйн багш, доктор	№0001
Үндэсний эксперт	Бямбаагийн Лхамноржмоо	БГД-ийн "Эхлэл" сургуулийн сургалтын менежер	№0002
Бүсийн сургагч багш	Баасанжавын Гантулга	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолбор сургуулийн Математикийн багш	№0004
Бүсийн сургагч багш	Баярсайханы Тунгалагцэцэг	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолбор	№0005

		сургуулийн Математик-физикийн багш	
Бүсийн сургагч багш	Рэгээдмаагийн Цэрэн-Очир	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Далайван ЕБСургуулийн биологийн багш	№0003

Ийнхүү бэлтгэгдсэн хичээлийн судалгааны эксперт, зөвлөх, сургагч багш нар цаашид хичээлийн судалгааны арга зүйг зохих ёсоор хөгжүүлж, зөвлөх, түгээн дэлгүүлэх мэргэжилтэн болдог.

Хичээлийн судалгааны мониторинг. Мониторинг бол багшлах болон суралцах үйл явцыг тодорхой үзүүлэлт хэрэглэн мөрдөн ажиглаж, цуглуулсан баримтадаа үндэслэн хичээлийн судалгааны үйл явцыг сайжруулах, зөвлөн туслах үйл ажиллагаа юм. МХСН БМДИ-тэй хамтран 2014 оны 3-р сард Хэнтий аймгийн Хан-Хэнтий, Тэмүүжин, Хэрлэн-4 сургуулийн судалгаат хичээл (Г.Норжмаа, Хаяши Широо), 2014 оны 12-р сард Дорноговь аймгийн 1,3,5-р сургуулийн хичээлийн судалгаат хичээл (М.Ганбат, Ц.Нарантуяа, Ж.Энэбиш, Г.Норжмаа), 2015 оны 03 сар мөн 2017 оны 11-р сар, 2018 оны 10-р сард Хөвсгөл аймаг “Дэлгэрмөрөн цогцолбор” сургуулийн Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа (Т.Ганбаатар, Ж.Энэбиш, Г.Норжмаа) зэрэг хэд хэдэн аймаг, дүүрэг, сургуулийн захиалгат мониторинг хийж зөвлөн тусалсан.

Хичээлийн судалгааны өдөрлөг. Хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх үе шатны нэг ажил нь хичээлийн судалгааны өдөрлөгийг сургууль, дүүрэг, бүс нутгийн хэмжээнд зохион байгуулж туршлагаа харуулах, түгээн дэлгэрүүлэх билээ. Манайд энэ ажил дөнгөж эхлэн хэрэгжиж байна. Монгол улсад анх удаа Хөвсгөл аймгийн “Дэлгэрмөрөн цогцолбор” сургууль Хичээлийн судалгааны өдөрлөгийг 2017 оны 11 сарын 29 зохион байгуулж анхдагчийн гэрчилгээ авсан байдаг. Мөн нийслэлийн лаборатори 28-р сургуулийн бага ангийн багш нар 2018 оны 03-р сард “Хичээлийн судалгаа-багшийн хөгжил” сэдэвт өдөрлөг зохион байгуулж заах арга ур чадвараараа харилцан туршлага солилцуулсан нь үр дүнтэй болсон байна.

Тулгарч буй бэрхшээл

Монгол улсад хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх ажилд бас бэрхшээл байна. Үүнд:

- Хичээлийн судалгааны арга зүй, багшлах арга зүйн хөгжлийн талаарх хууль эрх зүйн орчин дутмаг
- Хичээлийн судалгааны талаарх зөрүүтэй, нэгдсэн ойлголт, мэдээлэл дутмаг
- Боловсролын салбарын бодлого 4 жилээр өөрчлөгддөг, улс төрийн нөлөөлөлтэй
- Зөвлөх, экспертний хүрэлцээ муу, тоо цөөхөн
- Хичээлийн судалгааны илтгэл, тайлан бичих, судалгаа хийх чадвар дутмаг
- Гарын авлага, материал дутмаг
- Хичээлийн судалгаа явуулах сургуулийн менежмент, сургуулийн бие даасан байдал сул
- Багш нарын болон их дээд сургуулийн багш нартын хамтын ажиллагаа сул
- Их сургууль, ЕБС-ийн хамтын ажиллагаа сул

Бэрхшээлийг даван туулах арга зам

- Хичээлийг судалгааг эзэмшин хэрэгжүүлэх нь тийм ч амархан ажил биш, урт хугацаа шаардана гэдгийг ойлгох
- Сургууль дээр тогтмол хэрэгжүүлэх, багш нар судлаачидтай хамтран ажиллах
- Бусдыгаа хошуучлах хүнийг олох, хамтран ажиллах
- Хичээлийн судалгааны нөлөөт үр дүн (impact)-г тодорхойлох, суралцагчдын ямар хөгжилд дэмжлэг үзүүлэхийг оновчтой тогтоох
- Судалгааны үр дүнг зөвхөн суралцагчдад гарч буй ахиц амжилтаар бус харин тулгамдаж буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, цаашид хөгжлийг дэмжих боломжтой арга зүйн хувилбарыг боловсронгуй болгоход чиглүүлэх
- ХС-ны үр дүнг тайлагнах сурталчлах ажлыг чухалчлан үзэж, туршлагатай, мэргэшсэн хүмүүсийг оролцуулах

- Багшийн хөгжлийн тасралтгүй хангах арга бол ХС гэдгийг ойлгох
- Түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эхнээсээ ХС-ны чанар, хөгжил (бага хурал, форум зэрэг)-ийг бодох
- Хичээлийн судалгааны арга зүйн сонин, сэтгүүл зэрэг тогтсол хэвлэлтэй болох

Талархал

Энэхүү илтгэлийг бэлтгэхэд мэдээлэл цуглуулах, боловсруулахад туслалцаа үзүүлсэн хичээлийн судалгааны эксперт Т.Ганбаатар, Ж.Энэбиш, Г.Юмчмаа нарт болон МХСН-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцог гишүүд дэмжигчдэдээ гүн талархал илэрхийлье.

Ном зүй

Баярмаа Г., Дуламжав Н., Такаши Отани. (2018). *Хичээлийн судалгаа: Эрдэм шинжилгээний бүтээл*. БСШУЯ, Жайка. (2013). “Хүүхдийн хөгжил хичээлийн судалгаа” сэдэвт үндэсний ЭШ-ий анхдугаар бага хурлын илтгэлийн эмхэтгэлийн дэлгэрэнгүй. УБ., БМДИ, МХСН., (2014). “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвтэй үндэсний онол практикийн II бага хурлын илтгэлийн эмхэтгэлийн дэлгэрэнгүй. УБ., БМДИ, МХСН., (2015). “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвтэй үндэсний онол практикийн III бага хурлын илтгэлийн эмхэтгэлийн дэлгэрэнгүй. УБ., БМДИ, МХСН., (2016). “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвтэй үндэсний онол практикийн IV бага хурлын илтгэлийн эмхэтгэлийн дэлгэрэнгүй. УБ., БМДИ, МХСН., (2018). “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвтэй үндэсний онол практикийн IV бага хурлын илтгэлийн эмхэтгэлийн дэлгэрэнгүй. УБ., МХСН-ийн жилийн ажлын тайлан. (2016,2017). МХСН-ийн *mals.mn* сайт, 2015-2018 Нямгэрэл Ч., Нэргүй Н.. (2018). *Хичээлийн судалгаа ба Тогтвортой хөгжлийн боловсрол. V бага хурлын илтгэлийн эмхэтгэл, хууд 18. УБ*

Хичээлийн судалгааг гурвал онолоор шинжихүй

Бадрахын ЖАДАМБА
Төмөрбаатарын Ганбаатар
Очирбатын Алтангоо

Хичээлийн судалгааг улс орон бүр янз бүрээр ойлгож, өөрийн онцлогтой хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Японы Jugo Kenkyu буюу Хичээлийн судалгаа нь англи хэлнээ орчуулагдахдаа үндсэн утга нь алдагдсан гэж үзэх хүмүүс ч байдаг.

Иймд хичээлийн судалгааг гурвал онолын үүднээс авч үзэж, Монголын онцлогийг шингээсэн хичээлийн судалгааны нэгэн шинэ төрлийг гаргахыг энэхүү судалгааны зорилго болголоо.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд хичээл судлалын талаар судлаачдын тодорхойлсон тодорхойлолт болон гол ойлголтуудыг харьцуулан судалсан.

Эдгээр ойлголтуудыг дорнын гүн ухаанаас үүдэлтэй хос эхлэл, хоёрын дундаас гуравт дэвших сэтгэлгээ, гурвал онол зэрэг онолуудын үүднээс тайлбарлан авч үзэхийг арга зүйгээ болгосон.

Ертөнцийн эхийг түүний арга тал ч биш, билиг тал ч биш, харин тэдгээрийн нэгсэл нэгэн хэмээн үзэж, түүнийг “нэгэн – арга – билиг” буюу “амь – ахуй – ухамсар” гэсэн бүтэц бүхий гурвал гэж төсөөлж, аливаад ханддаг үзлийг амь ухаан \Б.Жадамба, 2017\ буюу гурвал онол \Н.Нагаанбуу, 1990\ гэдэг.

Гурвал онол бол алив бүхний эсрэг тэсрэг талын тэмцэлд нь бус түүний дундаас учрыг салгаж үздэг гурамсан сэтгэлгээнд суурилан түүний нийтийн мүс чанарыг хайдаг ухаан. Энэ онолын үүднээс хичээлийн гурвалуудыг ялган, тайлбарласан. Эдгээр тайлбаруудад үндэслэн хичээлийн гадаад болон дотоод талуудыг тодруулж, хичээл судлалын гурвал онолыг боловсруулсан. Энэхүү өгүүллийн хүрээнд хичээл судлалын гурвалуудыг товч тайлбарлан гурвал тус бүрийг үндэс болговол хичээлийн судалгаа хэрхэн өрнөх боломжтой талаар санаа дэвшүүлэн хэлэлцүүлж байна.

Хичээл судлалыг ийнхүү гурвалуудаар илэрхийлснээр гурвал тус бүр нь цаашдын судалгааны эхлэл болох онол болон практикийн ач холбогдолтой юм.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын онол, арга зүйн үндэс

Н.Норжхорлоо

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын зөвлөх багш
nnorjoo@yahoo.com

Түлхүүр үгс: Сургуулийн өмнөх боловсрол, социал конструктив онол, ко-конструктив суралцахуй, үнэлгээ, ажиглалт, баримтжуулалт

Товч агуулга: Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ) нь сургуулиас тавих шаардлага буюу хүүхдийн гаргаж буй амжилтад уу, эсвэл сургууль болон цаашдаа нийгмийн амьдралаас тавигдах шаардлагуудыг даван туулахад чадваржуулж, “хүн болж төлөвших”-д нь илүү төвлөрч байна уу гэдгээс тухайн улс орны СӨБ-ын шийдвэрүүд гардаг ажээ. Хэрэв эдгээрийн 2 дахь чиглэлийг нь барьж байвал хүүхдийн эзэмших үндсэн чадамжууд (competence)-ийг чухалчилдаг бөгөөд, тэр чадамжуудыг хүүхэд социал-конструктив (social-constructivist) үйл явцад идэвхтэй оролцсоноор, өөрөөр хэлбэл хүмүүний хоорондын идэвхтэй харилцан үйлчлэлийн нөлөөнд эзэмшинэ гэж үздэг.

Монгол улс сүүлийн жилүүдэд СӨБ-ын бодлогоо 2 дахь чиглэлээр нь тодорхойлон хөгжүүлж байна. Иймд сургалтын агуулга нь чадамжид, арга зүй нь багш/эцэг эх, хүүхэд хоорондын идэвхтэй харилцан үйлчлэлд, үнэлгээ нь хүүхдийн чадамжийг үнэлэхэд чиглэх шаардлагатай.

Хүүхэд бүрийн чадамжийг үнэлэхэд багш хүүхдийн мэдлэг, чадвараас гадна хүүхдийн зан чанар, хандлага, сонирхол, сэтгэл хөдлөл (affective), хүүхдийн амжилт гаргахтай холбогдох чадвар, сэдэл, танин мэдэхүйн талуудыг хамран өргөн хүрээтэй үнэлэх нь чухал. Үүнтэй холбогдуулан зарим улс орон (Сингапур, БНСУ, ХБНГУ, Швейцари, АНУ, ОХУ)-ы бага насны хүүхдийн хөгжлийн үнэлгээний зорилго, арга хэлбэрийг өөрийн орныхтой харьцуулан судалж үзлээ.

Дүгнэлт:

1. Сургалтын үндэсний стандарт, хөтөлбөрийн шинэчлэлд **боловсруулах, хэрэгжүүлэх** гэсэн 2 үндсэн ажил байдаг. Үүнээс “хэрэгжүүлэх” нь илүү нэгдмэл ойлголт, шинжлэх ухааны үндэслэлтэй зөв чиглүүлэг, хүч, хөрөнгө, анхаарал, байгууллага, хүмүүсийн хамтын ажиллагаа шаардсан ажил гэдгийг манай улсын СӨБ-ын 20 жилийн түүх харуулж байна. Чиглэсэн онол, үзэл санаанаасаа хазайх, эргэж буцах тохиолдол гарсаар ирэв.

2. Өнөөгийн СӨБ-ын сургалтын бодлогыг тууштай хэрэгжүүлж, сургалтыг **“социал-конструктив”** онол, үзэл санаанаас хазайхгүйгээр явуулснаар өнөөгийн хүүхэд багачуудыг ирээдүйд тулгарах эрсдлийг даван туулахад чадваржуулахын зэрэгцээ “зөв хүн” болж төлөвших баттай суурийг тавих болно.

3. Улс орнуудын СӨНХ-ийн хөгжлийн ахицын үнэгээний зорилго, арга хэлбэрийг өөрийн орныхтой харьцуулан үзэхэд манай улсын сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн ахицын **үнэлгээ дэлхий нийтийн түвшинд** хийгдэж байна гэж үзэх үндэстэй. Харин багш нарт системтэй сургалт явуулж, тэднийг улам чадваржуулах, ойлголтын зөрүүг арилгах, шаардлагатай ном, гарын авлагаар хангах шаардлагатай.

Хичээлийн судалгааны чанарын өөрчлөлтийг судалсан зарим үр дүн

Ш.Сайнбилэг

МУИС, ШУС sainbilegnum@gmail.com

Key words: Lesson study, Lesson study management, Changes in lesson quality, Changes in teaching method, Changes in lesson study.

Танилцуулга:

Монгол улс нь 2005 оноос цогц чадамжид суурилсан боловсролын стандарттай болсон. Улмаар хичээлийн агуулга арга зүйд парадигмын шинжтэй өөрчлөлт хийх, хэрэгжүүлэх хэрэгцээ үүссэн. Гэвч энэ тийм хялбар биш байсан болно. Иймд Монгол Улсын БСШУЯ нь Японы ЖАЙКА байгууллагатай хамтран 2006–2009 онд “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” сэдэвт төслийг хэрэгжүүлсэн. Төслийн зорилго нь суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүй

бүхий хичээл бүтээхэд оршиж байсан болно. Энэ зорилгын хүрээнд боловсролын судлаачдаар удирдуулсан хичээлийн судалгааг загвар болгон сонгосон ерөнхий боловсролын сургуулиудад анх удаа туршиж хэрэгжүүлсэн юм.

Бид 2006-2009 онд хичээлийн судалгаа нь суралцагчдын суралцахуйг дэмжиж байгаа эсэхийг болон багшийн багшлах арга зүйд хэрхэн нөлөөлж буйг судалсан. Ингэхдээ 3 жил дараалан ялгаатай менежмент ашиглан суурь боловсролын химийн хичээлийн хүрээнд хичээлийн судалгааг зохион байгуулсан. Судалгаанд 3 жил дараалан УБ хотын загвар сургууль (45, 46, 97)-ийг хамруулсан. Мөн орон нутгийн сургуулийнхтай харьцуулах зорилгоор Дорнод аймгийн загвар сургууль (5, Хан-Уул цогцолбор, Матад)-ийг хамруулсан. Судалгааны анхдагч мэдээлэлд Descriptive болон Inferential Statistics хийсэн. Судалгаагаар дараах үр дүн гарсан.

Хичээл заасан багшийн өөрийн үнэлгээ 2009 онд 2007 онтой харьцуулахад өссөн ($p=0.003$) байна. Харин хичээлд ажиглалт хийсэн багш нарын хөндлөнгийн үнэлгээний өөрчлөлт 2009 онд 2007 онтой харьцуулахад өссөн ($p=0.000$) байна. Түүнчлэн сурагчдын өөрийн үнэлгээний өөрчлөлт жилийн дунджаар авч үзэхэд жил бүр $p=0.007$, $p=0.000$, $p=0.001$ гэсэн үзүүлэлттэй гарсан.

Бид гүйцэтгэсэн судалгааны үр дүндээ үндэслэн “хичээлийн судалгаа” хийсний үр дүнд багшлах арга зүйг хөгжүүлэх, суралцах үйлийг дэмжих, сургалтын хэрэглэгдэхүүн боловруулах боломжтой бөгөөд хичээлийн судалгааны менежмент нь энэхүү технологийг оновчтой хэрэгжүүлэхэд зайлшгүй тооцох шаардлагатай асуудлыг илрүүлж, судлах боломжийг олгодог гэсэн дүгнэлтийг хийсэн.

Цаашид 2010-2013 онд Монгол Улсын БСШУЯ ба Японы ЖАЙКА байгууллага хамтран “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” сэдэвт төслийг хэрэгжүүлсэн. Төслийн зорилго нь багшийн арга зүйн хөгжлийг суралцагчдын суралцахуйг дэмжсэн чиглэлээр хөгжүүлэх менежментийг бий болгох, туршихад оршиж байсан болно. Энэ зорилгын хүрээнд боловсролын судлаачдаар мониторинг хийлгэх замаар загвар болгон сонгосон ерөнхий боловсролын сургуулиудаар хичээлийн судалгааг анх удаа туршуулж хэрэгжүүлсэн.

Улмаар 2014 оноос Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт (ITPD) хариуцан хичээлийн судалгааг үндэсний хэмжээнд бүх сургуульд хэрэгжүүлж эхэлсэн.

Бид 2006-2009 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүн дүгнэлтдээ үндэслэн 2010-2013 он, 2014-2017 он гэсэн үечлэлтэйгээр сургууль, багшийн бие даасан үйл ажиллагаанд тулгуурласан хичээлийн судалгаа нь суралцагчдын суралцахуйг дэмжсэн багшлах арга зүйг хөгжүүлэх боломжтой эсэхийг судласан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, ЗАН-н ахлагч, багш нарын хичээлийн судалгааны талаарх ойлголт, хэрэгжүүлж буй менежмент, тулгарч буй бэрхшээлийн талаар судалсан. Ийнхүү 2 үе шаттайгаар 6 жил үргэлжилсэн туршилт судалгааны үр дүнгээ танилцуулахаар бэлтгэсэн болно.

Арга зүй: Бид хичээлийн чанарын өөрчлөлт, хичээлийн судалгааны чанарын өөрчлөлтийг судлах замаар багшлах арга зүйн хөгжлийн өөрчлөлтийг идрүүлэх судалгаа хийсэн. Судалгаанд 2010-2013 онд 3 жил дараалан Завхан аймгийн зургаан сургууль (Улиастай-Чандмань-Эрдэнэ, Шилүүстэй, Завхан-Мандал, Баян-Тэс, Тосонцэнгэл, Сонгино)-ийг хамруулсан болно.

Судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн химийн 6 багш хичээл зааж оролцсон ба 14 багш хичээлд ажиглалт хийсэн. 130 орчим сурагч оролцсон. Харин 2014-2017 онд Завхан аймгийн гурван сургууль (Улиастай-Чандмань-Эрдэнэ, Дэвшил, Жавхлант)-ийг хамруулсан болно. Судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн 4 багш хичээл заасан ба 8 багш хичээлд ажиглалт хийсэн, 90 орчим сурагч оролцсон. Мөн хичээлийн судалгаа хийсэн үр дүнд үндэслэн шалгарсан химийн “Сайн хичээл”-үүдэд судалгаа хийсэн болно. Судалгаанд ажиглалт, асуулга ярилцлага, баримт бичгийн аргыг ашигласан болно.

Бид ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, ЗАН-н ахлагч, багш нарын хичээлийн судалгааны талаарх ойлголт, хэрэгжүүлж буй менежмент, тулгарч буй бэрхшээлийг судлахдаа дараах сургуулиудыг хамруулсан. Үүнд: Завхан аймгийн таван сургууль (Улиастай-Чандмань-Эрдэнэ, Шилүүстэй, Завхан-Мандал, Тосонцэнгэл, Сонгино)- Судалгаанд 50 орчим ажилтан хамрагдсан. Судалгаанд ажиглалт, асуулга ярилцлага, баримт бичгийн аргыг ашигласан болно.

Үр дүн: 2010-2013, 2014-2017 онд гүйцэтгэсэн судалгаагаар хичээлийн чанарт гарч буй өөрчлөлт, хичээлийн судалгааны чанарт гарч буй өөрчлөлтийг судалсан. Судалгаагаар цуглуулсан анхдагч мэдээлэлд чанарын анализ хийсэн.

Багш нарын зааж буй хичээл 2010-2011 онд багшийн үйл ажиллагаа голлосон, 2011-2012 онд суралцагчдын оролцоонд суурилсан боловч хичээлийн зорилго, хүрэх үр дүн тодорхойгүй, 2012-2013 онд суралцагчдаар мэдлэг бүтээлгэх үйл ажиллагаа голлож байсан боловч шинжлэх ухааны хувьд буруу ойлголт төсөөлөл үүсгэх хандлагатай байсан.

Харин 2014-2017 онд хичээл зохион байгуулах арга, хичээлийн цаг төлөвлөлт илүү сайжирсан үр дүн гарсан. Мөн хичээл суралцагчдын оролцоонд суурилсан боловч хичээлийн зорилго, хүрэх үр дүн тодорхойгүй, хичээлийн агуулга шинжлэх ухааны хувьд алдаатай байх хандлага давамгайлсан үр дүн гарсан.

Хичээлийн судалгааны чанарын өөрчлөлтийн судалгаагаар дараах үр дүн гарсан. Үүнд:

Хичээл төлөвлөх үе шат: 2010-2011 онд сурагчийн гүйцэтгэх үйлийн алхмууд тодорхойгүй, багшийн өмнөх туршлагад үндэслэгдсэн заах арга зүйн судалгаа голлон хийгдэж байна. Хичээлийн агуулга, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, сурагчийн мэдлэг эзэмшилт, гаргах алдааны судалгаа дутмаг байна гэсэн үр дүн гарсан. 2012-2013 онд хичээлд сурагчдыг сэдэлжүүлсэн үйл ажиллагаа, сонирхолтой арга хэрэглэх тал дээр ахиц гарсан. 2013-2014 онд хичээлд сурагчийн гүйцэтгэх үйлийн алхмуудыг илүү оновчтой бөгөөд тодорхой төлөвлөж эхэлсэн.

Хичээлд ажиглалт хийх үе шат: 2010-2011 онд хичээл заасан багшийн үйл ажиллагаанд төвлөрч ажиглалт хийж байна гэсэн үр дүн давамгайлж байсан. 2011-2012 онд хичээлийг тодорхой чиглэлийн хүрээнд ажиглаж, тэмдэглэл хөтлөх байдал давамгайлж байсан. Харин 2012-2013 онд хичээлд ажиглалт хийх чадвар илүү дээшилсэн үр дүн гарсан.

Хичээлийн хэлэлцүүлэг хийх үе шат: 2010-2011 онд хичээл заасан багшийг шүүмжлэх эсвэл ажиглалтын үр дүн үндэслэл нь тодорхойгүй боловч зорилгоо хангасан сайн хичээл болсон гэсэн үр дүн давамгайлж байсан. 2011-2012 онд багшийг шүүмжлэх эсвэл хичээлд ажиглалт хийсэн үр дүн оновчтой биш, хичээл сайжруулах ерөнхий санал их, тодорхой санал бага байх байдал давамгайлж байсан. Харин 2012-2013 онд багшийг үл шүүмжлэх байдал эрс багассан. Хичээлд ажиглалт хийсэн үр дүн, шалтгаан оновчтой болж ирсэн. Мөн хичээл сайжруулах ерөнхий саналаас гадна тодорхой саналуудыг хэлэлцэх болсон. Гэвч хичээлийг хэрхэн сайжруулах арга зам тодорхой биш байна гэсэн үр дүн гарсан.

Хичээл дахин төлөвлөх үе шат эхний 2 жил хийгдээгүй, харин 3 дахь жилээс хийж эхэлсэн үр дүн гарсан.

2014-2017 онд дээрхтэй төстэй зүй тогтол бүхий үр дүн гарсан. Гэхдээ хичээлээ сайжруулж дахин төлөвлөх үе шатыг илүү сайн хийдэг болсон байна.

Дүгнэлт: Бид багшлах арга зүйн хөгжлийн өөрчлөлтийг судласан үр дүндээ үндэслэн дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

Судалгааны үр дүнд үндэслэн “хичээлийн судалгаа”-аар суралцагчдын суралцахуйг дэмжсэн багшлах арга зүйг хөгжүүлэх буюу багш ажлын байран дээрээ мэргэжил дээшлүүлэх боломжтой. Гэвч хичээлийн судалгаанд оролцогч талуудын хамтын үйл ажиллагааны оновчтой загварт тулгуурлах нь зүйтэй.

Мөн мэргэшсэн судлаачидтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэсэн.

Бид ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, ЗАН-н ахлагч, багш нарын хичээлийн судалгааны талаарх ойлголт, хэрэгжүүлж буй менежмент, тулгарч буй бэрхшээлийг судласан үр дүндээ үндэслэн дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургууль нь хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй зорилго, хүрэх үр дүнгээ тодорхойлох
2. Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх менежментийн загвараа шинжлэх, хөгжүүлэх
3. Сургууль төвтэйгээр хичээлийн судалгаа хийх менежментийг орон нутаг, сургуулийн онцлогт тохируулан хийх
4. Ерөнхий боловсролын сургууль нь хэрэгжүүлж буй хичээлийн судалгаандаа мониторинг хийж эргэх холбоотой ажиллах

5. Өөрийн орны уламжлалт нээлттэй хичээл ба хичээлийн судалгааны зорилго, агуулга, арга зүй, менежментийн ялгаатай талыг илүү сайн ойлгох шаардлагатай байна.

Сургуулийн зорилго ба сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо

С.Ариунгэрэл

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт

Сургалтын байгууллагын менежментийн албаны арга зүйч

Удиртгал

Байгууллагын менежмент нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд асуудал уу, эсвэл шинж тэмдэг үү гэдгийг ялгаж зорилгыг оновчтой тодорхойлох нь хамгийн чухал. Гэтэл олонх сургуулиуд зорилгоо тодорхойлоход алдаа гаргадаг байна. Зорилго бол бидний ирээдүйд хүрэх түвшин. Харин стратеги бол зорилгыг биелүүлэх бодлого юм.

Жишээ нь: Сүрьеэгээр өвчилсөн хүн ханиалгана, сульдана, халуурна, хоолонд дургүй болно. Энэ бол сүрьеэ өвчний шинж тэмдгүүд. Түүнээс биш суурь өвчин биш юм. Сүрьеэгийн өвчлөл бактериар үүсгэгддэг. Тиймээс сүрьеэгийн бактерийг антибиотик ууж л эдгээнэ. Түүнээс биш ханиалга намдаах эм ууснаар сүрьеэг эмчилж чадахгүй. Антибиотیکیг бүтэн 3 сарын турш уух нь маш чухал алхам. Мөн хоол ба амралтын маш нарийн дэглэмийг баримтлах нь түүнтэй эн зэрэгцэх чухал алхам юм.

Яг үүнтэй адил байгууллага хөгжихөд өдөр тутам олон бэрхшээл, асуудал тулгардаг. Иймээс нөхцөл байдлаа зөв үнэлж, зорилгодоо хүрэх бодлогоо тодорхойлох, бодлого бүрийн цаана хийгдэх алхмуудыг нарийвчлан төлөвлөх, үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох нь чухал.

Сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллага. Сургалтын үйл ажиллагааны үр дүнг тодорхойлогч баримт бол сургалтын хөтөлбөр юм. Өөрөөр хэлбэл, сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулснаас сургуулийн хөгжил тодорхой хэмжээгээр хамаарна гэж үзэж байна. Үүний тулд хичээл тус бүрийн сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа хүрэх үр дүн буюу зорилтоо үнэлэгдэхүйц хэмжигдэхүйц байдлаар томъёолохыг чухалчилдаг. Сургуулийн хөгжил, ялангуяа сургуулийн хэтийн болон эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын хөтөлбөрийн зорилтоо дэвшүүлэх, улмаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх нь чухал. Энэхүү дэвшүүлсэн зорилтод хэр хэмжээнд хүрэх гэдгийг гарц үр дүнгийн шинжилгээгээр дүгнэх бөгөөд гарсан үр дүнг дараагийн жилийн хөтөлбөрийн зорилтод тусгах чиглэлээр сургуулийн үйл ажиллагааг болон багшийн хөгжлийг тодорхойлох үндэс болно.

Сэдэв сонгосон үндэслэл: Сургуулийн менежмент, сургалтын хөтөлбөрийн талаар эрдэмтэд олон бүтээл гаргасан байдаг. Сүүлийн жилүүдэд сургуулиуд сургуулийн зорилгоо тодорхойлох чиглэлээр нэлээд өөрчлөлтийг хийж байгаа боловч сургалтын үйл ажиллагаатай хэрхэн холбож байгаа талаар харилцан адилгүй байна. Энэхүү судалгаанд зөвхөн сургуулиудын зорилго зорилт, үйл ажиллагааны чиглэлийг нэгж болон ээлжит хичээлийн арга зүйгээр дамжуулан хэрэгжүүлж болох уялдаа холбоог судлахыг зорилоо.

Хамрах хүрээ: Монгол улсын боловсролын салбарт өөрчлөлт, шинэчлэл эрчимтэй явагдаж, боловсролыг нийгмийн эн тэргүүний салбар болгох, хэрэглэгчдийн зүгээс ч өндөр шаардлагыг тавьж буй өнөө үед боловсролын чанар, хүртээмж, үр өгөөжтэй байх нь багшийн хөгжлөөс шууд хамааралтай байдаг. Энэхүү судалгаанд сэдвийг сургуулийн зорилго, сургалтын хөтөлбөр гэж 2 ангилан судаллаа. Энэ 2 ангиллыг дараах байдлаар нарийвчлан задаллаа. Үүнд сургуулийн тулгамдсан асуудал, сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, багшийн арга зүйн төлөвлөлт гэж ангилсан болно.

Дээрх зорилгын хүрээнд энэхүү сургуулийн хөгжлийн бодлого, багшийн нэгж хичээлийн хөтөлбөр гэсэн 2 чиглэлээр анализ хийж судлахдаа нийслэлийн 2, аймгийн төвийн 1 сургуулийн хөтөлбөрийг сонгон авлаа. Судалгаанд ашигласан өгөгдлийн цаг хугацааны хамрах хүрээг 2017-2018 он, 2018-2019 оны хичээлийн жилээр авч судаллаа. Үүний үр дүнд 3 сургуулийн хөтөлбөр, 30 нэгж хичээлийн хөтөлбөр цуглуулан анализ хийлээ.

Судалгааны үр дүн:

Сургуулийн хөтөлбөрт хийсэн анализын үр дүнг Хүснэгт 1-т харуулав. 3 сургуулийн хөтөлбөрийг сонгон авч үзэхэд сургуулийн зорилго тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг бүх сургууль хийсэн


буюу 100%, харин тулгамдсан асуудлаа тодорхойлсон 1 сургууль (33%), тэргүүлэх зорилтоо тодорхойлсон 3 сургууль (66%), зорилгод хүрснээ үнэлэх үнэлгээний шалгуураа гаргасан 1 сургууль (33%) байна.

Хүснэгт 1. Сургуулийн хөтөлбөрт хийсэн анализ

	Эрдмийн өргөө цогцолбор сургууль	45-р сургууль	Увс 1-р сургууль
Тулгамдсан асуудлаа тодорхойлох	-	+	-
Зорилго тодорхойлох	+	+	+
Тэргүүлэх зорилтоо тодорхойлох	+	+	-
Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	+	+	+
Үнэлгээний шалгуур	-	+	-


Судалгаанаас харахад Сургуулийн хөтөлбөрт зайлшгүй авч тусгах чиглэлийг 45-р сургууль 100%, Эрдмийн өргөө цогцолбор сургууль 60%, Увс аймгийн 1-р сургууль 40%-тай төлөвлөжээ. Хөтөлбөрийн чиглэл бүрийг зураг 1-аар дэлгэрэнгүй харуулав.

Зураг 1
Сургуулийн тулгамдсан асуудлын чиглэл



Тулгамдсан асуудлаа тодорхойлсон байдлыг авч үзвэл, Боловсролын үнэлгээний төвөөс жил бүр авдаг чанарын үнэлгээний шалгалт болон элсэлтийн ерөнхий шалгалтын улсын дунджаас доогуур үнэлэгдэж байна, мөн дүүрэг, нийслэлийн хөндлөнгийн шалгалтын үнэлгээ, багшийн өөрийн үнэлгээний зөрүү их байгаа нь сургуулийн тулгамдсан асуудал болж байна гэж үзжээ.


Зураг 2
Сургуулийн зорилго тодорхойлсон байдал



Сургуулийн хичээлийн жилийн зорилгоо тодорхойлохдоо судлагдахууны хичээлийн чанарыг сайжруулахаар 1 сургууль (33%), ээлжит хичээлийг үр дүнтэй зохион байгуулахаар 2 сургууль (66%), эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхээр 1 сургууль (33%), сургалтын орчноо сайжруулахаар 1 сургууль (33%), сургалтын чанарыг дээшлүүлэхээр 1 сургууль (33%) дэвшүүлжээ. Харин дээрх зорилгын хүрээнд хүүхдийн дүр төрхийг тодорхойлсон сургууль байхгүй байна.

Зураг 3


Тэргүүлэх зорилтоо дэвшүүлсэн байдал



Сургуулийн зорилгод хүрэхийн тулд сургууль бүр тэргүүлэх зорилтоо тодорхойлсон байдлыг харахад Увс аймгийн 1-р сургууль тодорхойлоогүй байна. Тодорхойлсон сургуулиудыг авч үзэхэд багшийн үйл ажиллагаатай холбоотой 4 зорилт (57.1%), шалгалттай холбоотой 1 зорилт (14%), сургалтын үйл ажиллагаатай холбоотой 1 зорилт (14%), зохион байгуулалт, хариуцлагатай холбоотой 1 зорилт (14%) дэвшүүлжээ.


Зураг 4

Үйл ажиллагааны чиглэл тодорхойлсон байдал



Тэргүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэл тодорхойлсон байдлыг эрэмбэлэн харвал, даалгаврын сан бүрдүүлэх, эцэг эхтэй хамтран ажиллах үйл ажиллагааг 3 сургууль (100%), ээлжит хичээлийн бэлтгэл хангах, хөндлөнгийн шалгалтын мөрөөр ажиллах, агуулгын залгамж холбоог сайжруулах үйл ажиллагааг 2 сургууль (66%), солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, ном унших цагтай болох, багш хөгжлийн төв ажиллуулах, секц дугуйлан ажиллуулах, цөм хөтөлбөр хэрэгжүүлэх, хүн бүр зорилгоо тодорхойлох, ажлын төлөвлөгөө гарган ажиллах зэрэг үйл ажиллагааг тодорхойлжээ.

Зураг 5. Үнэлгээний шалгуур



Сургуулийн зорилгод хүрсэн үнэлгээний шалгуур тодорхойлсон байдлыг харахад Эрдмийн өргөө цогцолбор сургууль, Увс аймгийн 1-р сургууль төлөвлөөгүй, 45-р сургууль 5 чиглэлээр төлөвлөжээ. Агуулгын хувьд шалгалтуудын үр дүнгээр сургуулийн зорилгын хүрсэн үр дүнг тодорхойлохоор төлөвлөсөн байна.

Зураг 6. Нэгж хичээлийн хөтөлбөрийн арга зүйн боловсруулалт



Багш нарын боловсруулсан 30 нэгж хичээлийн хөтөлбөрийн арга зүйн боловсруулалтад шинжилгээ хийж үзэхэд асуулт асууна, үнэлгээ хийнэ, РРТ үзүүлнэ гэж ерөнхий байдлаар төлөвлөсөн 30 (100%), багш сурагчийн үйл ажиллагааг тус бүрчлэн хувааж төлөвлөсөн ч багш хийлгэнэ, сурагч хийнэ, мөн сурах бичгийг хуулах байдлаар төлөвлөсөн 29 (96.6%), сурагчдад мэдлэг чадвар эзэмшүүлнэ гэж тодорхойлж бичсэн 24 (80%), багшийн цаг төлөвлөлт, сурагчдаар хийлгэх үйл ажиллагааны харьцаа оновчгүй өөрөөр хэлбэл мэдээлэл боловсруулах үйл ажиллагааг 3 мин төлөвлөсөн 21 (71%), хичээлийн үе шат, цөм хөтөлбөрт байгаа сурах арга барилын үе шатыг хольсон 19 (63.3%), арга зүй огт төлөвлөөгүй зөвхөн заах агуулгыг төлөвлөсөн 18 (60%), цөм хөтөлбөрийн арга зүйг шууд хуулж бичсэн 14 (46.6%), нэгж болон ээлжит хичээлийн зорилго тодорхойлоогүй 8 (26%) багш байна.

Хэрэгжүүлсэн байдал

Дээрх судалгааны үр дүнд үндэслэн судалгаанд хамрагдсан Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн багш, удирдах ажилтантай хамтарч сургуулийн зорилгыг багшийн хөтөлбөр төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга зүйг боловсруулахаар төлөвлөж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар сургуулийн зорилго ба сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоог сургуулийн бодлого, багшийн нэгж хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд судалж үзлээ. Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Сургуулиуд хичээлийн жилийн зорилго, зохион байгуулах үйл ажиллагааг жил бүр төлөвлөдөг болох нь судалгаанд хамрагдсан сургуулийн баримт бичгээс харагдаж байна. Гэвч тулгамдсан асуудлаа тодорхойлсны үндсэн дээр сургуулийн зорилгыг тодорхойлох, сургууль бүр суралцагчаа дэвшүүлж буй зорилгынхоо төвд авч үзэн, зорилгод хүрэх тэргүүлэх зорилгоо оновчтой тодорхойлж, үр дүнтэй үйл ажиллагааг төлөвлөхөд анхаарах шаардлага байгааг дээрх судалгаанууд харуулж байна.

Учир нь дээрх судалгааны явцад зорилго, зорилт, үйл ажиллагаа холилдсон, хүрэх үр дүн тодорхойгүй зэрэг нь дээрх бүхнийг уялдаа холбоотой төлөвлөдөггүйтэй шууд хамааралтай гэж дүгнэж байна. Багш нар нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж байгаа ч хүүхдээ харж сургуулийн зорилгоо тодорхойлоогүйн улмаас багш төвтэй сургалт явагдсаар байна.

Энэ нь хүүхэд төвтэй сургалтын арга зүйг төлөвлөж хичээлийг зохион байгуулахад асуудал дагуулсан хэвээр байна. Иймээс сургуулийн зорилгыг тодорхойлохдоо дээрх бүхий л зүйлүүдийг тал бүрээс нь авч үзэх шаардлага тулгарсаар байна.

Ном зүй

1. Багш боловсролын ирээдүй төсөл, УБ., 2005
2. www.bolovsrolsudlal.mn
3. google.com
4. Сургалтын цөм хөтөлбөр Бага, суурь, Бүрэн дунд-Монгол хэл
5. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй Онол практикийн 2-5-р бага хурлын эмхтгэл
6. 45-р сургуулийн хөгжлийн хөтөлбөр
7. Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн стратеги төлөвлөгөө

8. *Увс аймгийн 1-р сургуулийн стратеги төлөвлөгөө*
9. *2018 оны үндсэн сургалтад оролцогч захирлуудын сургуулийн бодлого, хөтөлбөр*

ХОЁР. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

Алхам алхмаар сурагчдыг бүтээлч үйлд хөтлөх нь


*Донров Оюунмаа, Машлай Хараа, Доржсүрэн Бат-Эрдэнэ
Дорнод аймаг, Хэрлэн сум, 12 дугаар сургууль*

Судалгааны ажлын зорилго

6 настай хүүхдийн онцлогийг оношлон, тэдний нас сэтгэхүйн онцлогт тохирсон ээлжит хичээлийн агуулгыг алхам алхмаар хөтлөн ойлгуулж хөгжлийн ахицыг илрүүлэхийг зорьсон.

Судалгааны загвар / аргазүй/ хандлага

Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон хэрэглэгдэхүүнийг боловсруулан бэлтгэж, цэгцтэй мэдлэгийг алхам алхмаар бүтээлч үйлд хөтлөх замаар “Цаг хугацаа”-ны тухай ойлголтыг хичээлийн судалгаагаар туршин илрүүлсэн аргазүй, технологийн үр дүн



Судалгааны үр дүн

Алхам алхам аргазүйгээр ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан хичээлийн судалгааг зохион байгуулж судалгаат хичээл зааснаар өдөр тутмын цаг тооллын асуудлыг тооцоолох чадварт суралцсан.

Практик ач холбогдол

Цаг хугацааны баримжаатай болох нь чухал ба ханын болон бугуйн цагийг баримжаалан унших чадвар нь өдөр тутмын амьдралын шаардлагаар шаардагддаг тул цаг хугацааны холбогдолтой амьдрал ахуйн хэрэглээний бодлогуудыг цээжээр бодох чадварыг хөгжүүлэх ач холбогдолтой.

Хичээлийн шинэлэг санаа:

1-р ангийн математикийн хичээлийн “Цаг хугацаа” нэгж сэдвийг заахдаа сурагчдад сонирхолтой үзүүлэн тараах материал ашиглан, алхам алхмаар хичээлийг хөтлөн мэдлэгийг олгосноор хүүхэд бүрийн анхаарлын тогтворжилтыг нэмэгдүүлэх боломжтой.

6 настай суралцагчдыг ярьж сургах, өөрийн хийснээ бусаддаа тайлбарлах, өөрийгөө үнэлэх, бусдаас суралцах, эргэцүүлэн бодох, ярилцах зэрэг үйл хийх явцад мэдлэгийг бүтээлгэх чадварт сургах юм. Мөн минут, цаг, хоног, долоо хоног, улирал, сар, жил гэсэн хугацааны нэгжүүд хоорондоо холбоотой болохыг дүгнэлт хичээлээр ойлгуулахыг зорьсон.

Түлхүүр үг: , цаг , хоног , сар , улирал , жил , ээлжит хичээл , анхаарлын тогтворжилт

Товч агуулга:

6 настай 1-р ангид анх удаа судалгаат хичээлийг туршин зохион байгууллаа.

“Цаг хугацаа” сэдвээр судалгаат хичээлийг зохион байгуулахдаа 6 настай суралцагчдын сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгааг 5-н чиглэлээр авч сурагчдын танин мэдэхүйн чадварыг оношилсон. 40 сурагчдаас авсан хөгжлийн судалгааг графикаар харуулвал танин мэдэхүйн хөгжил нь бусдаасаа давуу байгаа нь судалгаанаас харагдаж судалгаат хичээлийг зохион байгуулах боломжтой байна гэж үзсэн. \ Д.Оюунмаа багштай 1а ангийн судалгааг харуулав.\



Энэхүү судалгаат хичээлээ 1-р ангийн 4 бүлэгт мөн 2-р ангийн 2 бүлэгт 6 удаа хичээлийн төлөвлөлтийг засан сайжруулж заалаа.



1-р ангид өглөө, үд, орой, өдөр, сар улирал, жил гэсэн ерөнхий ойлголтуудтай танилцдаг.

Сурагчдын амьдралын туршлага дээр нэг жил 4 улиралтай, улирал бүр 3 сартай, сар бүрд ямар ямар баяр болдог ба 12 сар нь 1 жил болж, хоногт 24 цаг байдгийг цахим слайдаар сурагчдад сонирхолтойгоор хичээлийг зохион байгуулсан.

Сэдвийг сонгосон үндэслэл:


Боловсролын чанарын шинэчлэлийн үр дүнд бид ямар ч орчин нөхцөлд өөрт тулгамдсан асуудлын гарцыг соргоогоор олж харж, шийдвэрлэж чаддаг бүтээлч сэтгэлгээтэй хүүхдийг хөгжүүлэх явдал билээ.

Багш бидэнд хичээл бүрийн сурах бичиг, багшийн ном, зөвлөмж байгаа хэдий ч зарим хичээлийн тухайн сэдвийг заахад хүндрэл бэрхшээл тулгардаг.

Ялангуяа 6 настай 1-р ангийн сурагчдын анхаарлын тогтворжилт 7-10 минут үргэлжилдэг тул тухайн багш хичээлээ ганцаар бэлтгэн заахад бэрхшээлтэй ба анги бүрт заахад хүндрэлтэй багш нарын гаргасан сэдвийн жагсаалтаас сонгон өнгөрсөн хичээлийн жил математик судлагдахууны баг “Цаг хугацаа” сэдвээр 1-р ангид хичээлийн судалгаа хийлээ.

Хичээлийн бэлтгэл судалгаа...

Нэг. Хүүхдийн хөгжлийн судалгааг сургуульд бэлтгэгдсэн 5 чиглэлээр зохион байгуулж хичээлийн судалгааг зохион байгуулахад хүүхэд бүрийн чадварын түвшинг оношилж тогтоосон



Хоёр.

Хичээлийн бэлтгэл-хөтөлбөрийн судалгааг багш нар ээлжит хичээлийг чанартай заах зорилгодоо хүрэхийн тулд хийдэг. Иймээс дээрх хөгжлийн судалгааны үр дүнд үндэслэн хичээлийн бэлтгэл судалгааг дараах байдлаар зохион байгуулсан.

1. Заах хичээл болон сэдвээ багш нарын саналын дагуу тогтоосон. |2018 оны 03 сарын 6 ны 1 ээлжийн 2-р цаг дээр 1а ангид Д. Оюунмаа багш заана.
2. Хичээлийг судлагдахууны багаараа бэлтгэсэн / Хүүхдэд сонирхолтой хэрэглэгдэхүүн хийх, хичээлийн алхмуудыг төлөвлөх, асуултыг оновчтой тавих, самбар төлөвлөлт, хүүхдийн онцлог хандлага зэргийг тусгах /
3. Математикийн багшийн ном, сурах бичиг, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, холбогдох бусад ном, сэтгүүл зэрэгт энэхүү сэдвийн агуулгыг судалсан.
4. Хичээлийнхээ хөтөлбөрийг бичсэн. / Хөтөлбөрийг хавсралтаар оруулав. /
Нэгж хичээлийг судлан хөтөлбөртөө 1-р ангийн хүүхдийн онцлог, чадвар нэгж хичээлийн агуулга, боловсруулах заах арга зүйг төсөл хэлбэрээр бичин тусгаж 1а ангийн 41 сурагчдад эхний хичээлээ заасан. Хичээлд нийт 18 багш сууж тэмдэглэл хөтөлсөн.
5. Хичээлийн хөтөлбөрийн тухай хэлэлцсэн.

Хичээлийн явцыг ажиглан багш сурагчдад илэрсэн өөрчлөлтийг хэлэлцүүлгийн явцаас протоколд тэмдэглэн цаашид сайжруулах аргыг судлагдахууны багийнхан бичиж тэмдэглэн дараагийнхаа хичээлд тусган судалгаат хичээлийг 4 удаа засан сайжруулж заасан.

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл: / мэдлэг бүтээлгэх /

Эхлэл хэсэг:-5 мин

Хичээлийн дэг , зорилго танилцуулна.

Зургийг ажиглан ямар үйл явдал хэзээ болж байгааг ярилцана. \ТҮ слайд-1 харуулах \



- ✚ Та нар 7 хоногийн хэдэн өдөр хичээлдээ явдаг вэ? 7 хоногийн гарагуудыг хэн нэрлэх вэ? гэж асуулт тавьж нэрлүүлнэ.

Хичээлийн өрнөл хэсэг: 20 мин

Алхам- 1 1жил= ... улирал

- ✚ Ажиглаад юу төсөөлөгдсөнөө ярилцана .Юу гэж бодож \ТҮ-ээр слайд -2 харуулах\
- ✚ 4-н улирлын тухай ярилцаад самбарт байрлуулан улирлын нэрлүүлэн уншуулна.



байна?
нэрийг

- ✚ **ТҮ –ээр слайд-3 харуулах** → **1жил=4 улирал **
Хичээлийн сэдэв гарна.....

Алхам-2 1 жил=... сар

Өнөөдрийн хичээлтэй холбоотой 12 юу байдаг вэ?

- ✚ Сурагчдад 12 сарын онцлох үйл явдлыг илэрхийлсэн зураг харуулна. Эдгээр баярт үйл явдлууд хэзээ хэдэн сард болдогийн болоо? ажиглаад ярилцаарай.
- ✚ Та нар анх хэдэн сард сургуульд орсон бэ? Сая хэдэн сард цагаан сарын баяр болсон бэ? Мал хэдэн сард төллөж эхэлдэг вэ? гэх мэт дөхүүлэх асуулт тавина.

С: Зургийг ярилцан хэдэн сард ямар үйл явдал болдог зургийг асуултанд хариулсан сурагчид гарч ирж самбарт өлгөнө.

Зун Эд ТҮ-ээр Слэ...уулах \ хуваалт... слайд \
 Хавар – 3,4,5 Зун – 6,7,8 намар – 9,10,11 өвөл- 12,1,2 уншуулах \ 1 жил=12 сар \

Алхам-3 1 хоног= ... цаг

- ✚ ТҮ-ээр слайд-5 харуулах
Одоо юутай адилхан харагдаж байна. цаг \ Цаг болоход юу дутуу байна? Цаг хэдэн зүүтэй байдаг вэ? \ 3 | \ цагийн зүү нь богино минутын зүү урт \



Хамтран дагуулж уншина. \1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12,13,14,15,16,17,18,19,20,21,22,23,24 \

- ✚ Слайд 4 харуулах \ 1 хоногт=24 цаг \




Алхам-4 1 цаг = ... минут

- ✚ Слайд -5 харуулах
- ✚ Энэ зүй тогтлыг олоорой.
- ✚ \ 5,10,15,.....,,, ... , 55,60 \ минутыг уншуулах нь 12 дээр заасан байна. \ 1 цаг =60 минут \

Богино зүү нь цагийг заана. Урт зүү

Бататгал-8 мин

Ажлын хуудас- 1 Цаг хэд болж байгааг тэмдэглэнэ. Өөрсдийн өдрийн тэмдэглэлийн цагаа бичиж ярина.



Дүгнэлт - 2 мин

4:00, 10:00, 7:00 цагийн зүүг тохируулан харуулах хүүхэд бүр.

Бамбарууш хаана буух вэ? Өнөөдрийн сурсан мэдлэгээ үнэлээд бамбаруушийн газрыг байрлуулаарай.

Хүүхдүүд гэрлэн дохиогоор өөрийгөө үнэлнэ.

Өнөөдрийн хичээлийн гайхалтай нь юу байсан бэ? Юу мэдэж ойлгож авсан бэ?

Судалгаат хичээлийн үр дүн

Сайн хичээлийн сайн хөтөлбөр нь багш нарын хамтын үйл ажиллагааны үр дүнд бий болдог ба үр дүнд сурагчид маань хөгжиж, бие дааж сурах арга барил эзэмших, бүтээлч сэтгэлгээтэй асуудлаа шийдэх чадвартай, өөртэй итгэлтэй болдог.

- ✓ Хичээлийн судалгааны эцсийн үр дүнд энэ л хамгийн сайн боллоо гэсэн хөтөлбөртэй буюу өөрсдийн "Кюзай"-гаа нээн олж илрүүлээ.
- ✓ Нас сэтгэхүйн онцлогт тохирсон хэрэглэгдэхүүнийг ээлжит хичээл бүрд тохируулан хэрэглэсний үр дүнд хичээлийн чанарт сайнаар нөлөөлсөн.
- ✓ Хамтын ажиллагааны үр дүнд аргагүйгээ сайжруулж өөрийн сайн тал, сул талыг мэдэрч бусдад зөвлөгөө өгөх, бусдаас суралцах арга барилд суралцлаа.
- ✓ Багш сурагчдаа оношлох, асуулт тавих аргаар суралцсан.
- ✓ Минут, цаг, хоног, долоо хоног, сар жил гэсэн хугацааны нэгжүүдийг та мэдэж цаг хараад хэд болж бүхэл цагт ойролцооноор хэлж сурсан.
- ✓ 6 настай 1 дүгээр ангийн сурагчдыг сонгон судалгаат хичээлийг явуулсан хүүхдийн хөгжлийн судалгааг аль ч ангид олж харж болохыг энэхүү хичээл харуулж чадсан.

Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа

6 настай суралцагчдыг ярьж сургах, өөрийн хийснээ бусадтай тааруулах, бусдаас суралцах, эргэцүүлэн бодох, ярилцах зэрэг үйл хийх явцад мэдлэгийг бүтээлгэх чадварт сургах юм. Мөн цаг, хоног, улирал, сар, жил гэсэн хугацааны нэгжүүд хоорондоо холбоотой болохыг ойлгуулахыг зорьсон.

Яагаад сайн хичээл болсон бэ?

- ✓ Хүүхдүүдийн чадварт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн, даалгавар боловсруулсан.
- ✓ Алхам алхмаар самбар төлөвлөлтөө хийж, мэдлэгийг цэгцтэй ойлгуулж чадсан.
- ✓ Хэлэлцүүлгийн явцад багш нарын шинэ санаануудыг хичээлдээ тусгасан.
- ✓ Хүүхэд бүрийн оролцоог хангасан, сэдэл тэмүүллийг өрнүүлсэн.
- ✓ Даалгавар болон агуулгын залгамж, уялдаа холбоо сайн байсан.
- ✓ Бүлэг бүрт сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгааг танин мэдэхүйн хөгжлөөр нь судлан оношилж, 6 настай сурагчдыг сонгон судалгаат хичээлийг зохион байгуулсан нь сурагчдын танин мэдэхүйн хөгжил нь давуу байсныг илрүүлсэн.

Бусдад хүргэх туршлага

Багш бүрт өөрийн гэсэн заах арга байдаг бөгөөд түүнийгээ "тордож сайжруулаад" олны хүртээл болгох нь боловсролын шинэчлэлд оруулж буй бидний чухал хувь нэмэр юм. 6 настай сурагчдыг хичээл үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулж сургах нь тэдний насны онцлогийг харгалзан хэрэглэгдэхүүнийг амилуулан ашиглах аргаар шийдвэрлэж багшлах аргагүйгээ хөгжүүлэхийг хүсье. Энэ бол бидний алхам алхмаар сурагчдыг бүтээлч үйлд хөтлөх бусдад түгээх "Кюзай" юм.

Ном зүй:

- БШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар: Колорфул.
- БСШУЯ., 6 настай хүүхэдтэй ажиллах аргагүй., Уб., 2008., хуудас 19
- Б. Балдулмаа, Ц. н. (2008). Бага боловсролын математикийн онол дидактик. Улаанбаатар БСУГ.
- (2016). Шилдэг илтгэл-сайн туршлага. Чойбалсан: ДИС-ийн хэвлэх үйлдвэр
- Батболд Г, Б. Б. (2008). Бага боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль
- Гантуул А. Батболд Г нар (2014). Багшийн ном. Математик-1. Улаанбаатар.
- Батболд Г. Түвшинжаргал Д нар. (2014). Багшийн ном. Математик-1. Улаанбаатар.
- "Хүүхдийн хөгжил-хичээлийн судалгаа" сэдэвт үндэсний эрдэм шинжилгээний IV бага хурал



буух

Эко-клубын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь

Р.Цэрэн-Очир

Хөвсгөл аймгийн “Далайван” сургуулийн биологийн
багш, rtserenochir@gmail.com

Удиртгал Нэг мод таривал нэг насны буян

Хоёр мод таривал хойд насны буян

Монголчууд эрт дээр үеэс нүүдэллэх үедээ буйраа цэвэрлэх, булгийн эхээс мод авах, цус, сүү дусаах зэргийг цээрлэж, овоо тахих, лус савдгаа аргадан амьдрахыг захин сургаж ирсэн нь зүгээр ч нэг хэлсэн үг биш бөгөөд байгаль дэлхийгээ тахин шүтэх үзэл санаа тасралтгүй байсаар ирсэн нь тогтвортой хөгжлийн үндэс суурь болж байна. Энэхүү байгаль хамгаалах уламжлалт ёс заншил алдагдсанаар сүүлийн жилүүдэд байгаль орчны доройтол асар ихээр нүүрлэсээр байна.¹

Ургамал бол амьтай бүхний амьдралыг тэтгэгч эх булаг гэдэгтэй хэн ч үл маргах буй за.

Иймд хүүхэд багачуудаа байгалиа хайрлан хамгаалах ухаалаг тогтвортой хэрэглээтэй болгон төлөвшүүлэх шаардлага урган гарсаар байна.

Хөрсөнд мод

Зүрхэнд нь хайр бий болгон мод тарих, арчлан ургуулах ажлын хүнд хэцүү, бахдам сайхан, үнэ цэнийг өөрийн биеэр мэдэрснээр ухаалаг хэрэглээтэй иргэн болгон төлөвшүүлэх зорилготойгоор туршилтын талбайд мод, бут тариулах, голын усны шинжилгээ хийх зэрэг судалгаат хичээлүүдээр шинжлэх ухаанч арга барилд сургахад хичээлд сонгосон хэрэглэгдэхүүн нь хүүхэд нэг бүрийн шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэхэд дэмжлэг болж буй эсэх болон багшийн чиглүүлэг арга зүйн судалгаа хийж засан сайжруулахыг зорилоо.²

Нэгдүгээр бүлэг. Онол аргагүйн үндэс, судалгааны загвар

Сэдвийг сонгосон үндэслэл: Биологийн олон янз байдал сэдвийн агуулга өргөн, шаардлагатай хэрэглэгдэхүүн /ургамлын хатаадас, шавжны цуглуулга, бодит чихмэл/ дутмаг зураг, видео бичлэг ашиглан амьд биеийн морфологи шинжийг ялган таньж тодорхойлох, түлхүүр бичиг зохиох шинжлэх ухаанч арга барилыг төлөвшүүлэхэд дэмжлэг болж чаддаггүй.

Хичээлийн санаа: Биологийн олон янз байдал ба ангилал сэдвийн хүрээнд 8-10-р ангийн Ангилал зүйн бага, том нэгж \аймаг, хүрээ, анги, баг, овог, төрөл, зүйл\-ийн онцлог шинжийг ашиглан зарим амьд биеийг ялган таних, тодорхойлох түлхүүр бичиг зохиох, ашиглах хичээлд “Ургамал, усны индикатор макро сээр нуруугүйтэн амьтдыг тодорхойлох түлхүүрийг зохион ашиглаж, орон нутгийн гол мөрний усны чанарыг үнэлэх” бодит хэрэглэгдэхүүн дутмаг байна. Иймд эко-клубын үйл ажиллагаагаа, туршилтын талбайг бий болгон хичээллэх боломжийг судлаж, түүнийг судалгаат хичээлдээ ашиглан шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэх арга зүйг судлаж үзэх зорилго дэвшүүлэн судалгаат хичээлийн арга зүйг боловсруулав.³

Хичээлийн бэлтгэл судалгаа: “Үүргэвчтэй аялал-сургалт”-д хэрэглэгдэх голын усны шинжилгээний хайрцаг/цаг, тор, гарын авлага, ажиглалтын хуудас, жижиг бөмбөг, метр, хямсаа, тэвш, томруулдаг шил/ аялалын маршрут, туршилтын талбайд тарих мод, бутны тарьц зэрэг шаардлагатай хэрэглэгдэхүүн бэлтгэсэн. Үүргэвчтэй аялал- сургалтаар голын усны шинжилгээ хийхдээ голын усны урсгалын хурд, макро сээр нуруугүйтнийг тодорхойлох, индикатор амьтдаар усны чанарыг тодорхойлж, орон нутгийн орчинд үнэлгээ хийнэ. Туршилтын талбайн дахь сургалтаар модны

¹ Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030он

² Монголчуудын байгалиа хамгаалах уламжлалт соёл Ш. Чоймаа 2013 он

³ Цөм хөтөлбөр 2014

морфологи шинж, ургах орчин бүтцийг онцлогыг тодорхойлох, тарих, арчлах, тэмдэглэл хөтлөх үйл ажиллагаанд багш асуултаар удирдан чиглүүлэх аргыг төлөвлөсөн.

Судалгаат хичээл: 2016-2017 онд Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн эко-клубын сурагчид, 9а,б ангийн сурагчд, 2017 оноос Далайван ерөнхий боловсролын сургуулийн 9а, 12а ангид заан туршиж хичээлийн хөтөлбөр, ажлын хуудас, ажиглалтын хуудсаа хэд хэдэн удаа дахин засаж сайжруулсан бөгөөд хичээлийн судалгааны явцдаа “Үүргэвчтэй аялал-сургалт” танхимын бус сургалтын явцад “Асуултаар чиглүүлэх арга зүй”-гээ сайжруулан хөгжүүлэхийг зорьсон.⁴



Судалгаат хичээлд зөвлөхөөр “Дэлгэрмөрөн” цогцолбор сургуулийн сургалтын менежер Б.Гантулга, биологийн багш Д.Ойдовжунай, газарзүйн багш Д.Энхтүвшин, Далайван сургуулийн газарзүйн багш Дэнсмаа, аймгийн байгаль орчны газрын мэргэжилтэн нар оролцсон болно.

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл /мэдлэг бүтээлгэх/

Орчны бохирдолтын судалгаа баримт нотолгоо цуглуулах түүнд дүн шинжилгээ хийх, төсөл бичих илтгэл тавих, мод бут тарих, арчлах Үүргэвчтэй аялал-сургалт зохион байгуулах зэрэгт багшийн чиглүүлэг сурагчийн үйл ажиллагааг тодорхой дэс дараатай алхмуудаар гүйцэтгэхээр төлөвлөн суралцагчдын бүтээлч, идэвхтэй үйлийг хөгжүүлсэн, мөн сурагч төвтэй арга зүйн төлөвлөлтийн загвар гаргасан.⁵

1.3 Аргазүй, шийдэл

Багшийн асуулт чиглүүлэг	Тухайн хэсгийн шийдэл, гол санаа
Хичээлийн “эхлэл” хэсэг	
Хорхойтой усыг ууж болох уу? -Голын усны бохирдол, түүний эх үүсвэрийг тогтоох, индикатор амьтны тухай таамаглал дэвшүүлэв.	Хорхойны тухай мэдлэгээ сэргээн санах, сэдэл төрүүлэх Хорхойг ашиглан усны цэвэр, бохирыг тогтоож болох болов уу? гэсэн таамаглал дэвшүүлэх
Ургамал байхгүй бол амьдрал оршин тогтнох уу? тайлбарлаарай.	Ургамлын тухай мэдлэгээ сэргээн санах, сэдэл төрүүлэх Ургамал хэрхэн ургадаг, ямар арчилгаа шаардагдах талаар таамаглал дэвшүүлэх
Хичээлийн “өрнөл” хэсэг	
Голын усны макро сээр нуруугүйны судалгаа хийх ажлын дараалалтай танилцах Урсгалын хурд тодорхойлох Дээж авах Суур нуруугүйтэн амьтны морфологи шинжийг тодорхойлох	Урсгалын хурдыг тодорхойлох, дээж авах, сээр нуруугүйтэн амьтдын морфологи шинжийг ажиглах, хэмжих, тэмдэглэл хөтлөх, харьцуулах, хялбар түлхүүр бичиг зохих зэрэг чадваруудыг хөгжүүлэх, шинжлэх ухаанч арга барил эзэмшихийг дэмжинэ.
Туршилтын талбайд тарих ургамлаа сонгох Тарих, арчлах талаар мэдээлэл цуглуулах, тарьц авах Ургамлынхаа морфологи шинж, ургах орчин, онцлогийг тодорхойлох/ажиглах, хэмжих, тэмдэглэл хөтлөх, харьцуулах/	Ургамлын ургах орчин, морфологийн онцлогыг тодорхойлох Ажиглах, хэмжих, тэмдэглэл хөтлөх, харьцуулах/ Хөрс бэлтгэх, нүх ухах, тариалалт хийх

⁴ Хичээлийн судалгааны илтгэл бичих зөвлөмж МУИС, ШУС, химийн тэнхмийн доктор, профессор Н.Оюунцэцэг нар 2016.02.06

⁵ Хичээлд мониторинг хийх арга зүйн зөвлөмж /МУЛсын БСШУЯ, Япон Улсын Жайка хамтран гаргасан зөвлөмж/

Хөрс бэлтгэх, нүх ухах Тариалалт хийх	Мэдээлэл цуглуулах чадваруудыг хөгжүүлэх, шинжлэх ухаанч арга барил эзэмшихийг дэмжинэ.
Хичээлийн “төгсгөл” хэсэг	
Гарын авлага ашиглан сээр нуруугүйтэн болон усны чанар, бохирдлын шалтгааныг тогтоох Орчны үнэлгээ хийх	Орчны төлөв байдалд үнэлгээ өгөх Судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэн дүгнэлт гаргах чадварт суралцах
Ургамал ургахад шаардлагатай хүчин зүйлүүдийг тодорхойлох Ажиглалтын хуудас хөтлөх, ургамлаа арчлах	Ургамлын талаарх мэдлэгтээ тулгуурлан учир шалтгааныг олж, логик сэтгэхүйн аргаар дүгнэж таамаглалаа батлах Жнь: навч яагаад шарласан, яагаад ургаагүй вэ? гэх мэт

Шинэ санаа арга зүйн туршлага:


- ✓ Байгалийн юмс үзэгдлийн учир шалтгаан зүй тогтлыг олох, ургамлын ургах орчин, морфологийн онцлогыг тодорхойлох, ажиглах, хэмжих, тэмдэглэл хөтлөх, харьцуулах, хөрс бэлтгэх, нүх ухах, тариалалт хийх, мэдээлэл цуглуулах чадваруудыг хөгжүүлэх барилыг эзэмшүүлэх сургалтын бодит орчин бий болгосон.
- ✓ Үүргэвчтэй аялал-сургалт зохион байгуулснаар сурагчдын биологийн хичээлийг сонгон суралцах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлж энгийн түлхүүр бичиг зохиох, голын усны чанар, бохирдол зэргийг хялбар аргаар тодорхойлох орчны үнэлгээ хийх чадварыг дэмжсэн.

Судалгааны үр дүн:

Голын усны шинжилгээний үед хэрэглэх ажлын хуудас, туршилтын талбайд мод, бут тарих үед ашиглах ажиглалтын хуудасны төлөвлөлтөд орчны үнэлгээний хэсгийг оруулж бохирдуулж буй хүчин зүйлийг тодорхойлж бохирдлыг бууруулах арга зам, түүнд сурагчдын оролцоог төлөвлөх чадварыг хөгжүүлэх зорилт дэвшүүлэн оруулсан.


- Үүргэвчтэй аялал-сургалт, туршилтын талбайн сургалтаар хэмжих, тэмдэглэл хөтлөх, ажиглах, харьцуулах, мэдээлэл цуглуулах, туршин хэрэгжүүлэх, чадваруудыг хөгжүүлснээр Ангилал зүйн бага, том нэгж \аймаг, хүрээ, анги, баг, овог, төрөл, зүйл\-ийн онцлог шинжийг ашиглан зарим амьд биеийг ялган таних, тодорхойлох түлхүүр бичиг зохиох, ашиглах, шинжлэх ухаанч арга барилыг хөгжүүлж чадсан.
- 2010 оноос өдгөөг хүртэл сургуулийн нийт талбайд 650 гаруй гоёл чимэглэлийн мод, 28ш чацарганы бут, 20ш үхрийн нүдний бут тарьж ургуулан нарийн ногооны хүлэмж бүхий туршилтын талбай, “Мини-цэцэрлэгт хүрээлэн байгуулах суурийг бий болгоод байна. Үүгээр дамжуулан байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлүүдийг бууруулах арга, бүтээлч үйлээр нь дамжуулан шинжлэх ухаанч аргад сургах танхимын бус сургалтын орчин бий болгосон.
- Биологийн хичээл нь бодит үзүүлэн, ТӨМ, гарын авлага зэрэг олон хэрэглэгдэхүүнийг шаардсан байдаг бөгөөд энэ бол туршилтын талбай байгуулан хичээлүүлснээр жимс, жимсгэний болон гоёл чимэглэл мод бут, хэрэглэгдэхүүн ашиглан сургалтын чанар сайжруулах боломж байна.

Сурагчдын мэдлэг чадварын ахиц амжилт: Үнэлгээний шалгуур хавсралт-4 /Ажиглалтын хуудсан дахь гүйцэтгэл, жишиг даалгаврын /хавсралт-5/ гүйцэтгэлээр үнэлэв./



Дүгнэлт: Эко-клубын сурагчдын хэмжих, тэмдэглэл хөтлөх, ажиглах, харьцуулах, мэдээлэл цуглуулах, туршин хэрэгжүүлэх чадварыг үнэлэх гарааны үнэлгээнд 53-77% байсан бол арга зүйд суурилсан хичээлийн судалгаа явуулсны үр дүнд сурагчдын шинжлэх ухаанч арга барилд дахин үнэлгээ хийх дараах дүн гарсан байна. Үүнд 86,8-93,3% болж 33,8-23,3%-иар өссөн нь шинжлэх ухаанч арга барил төлөвшиж байгаа нь харагдаж байна.

Сурагчдын шинжлэн судлах арга барилын ахиц амжилт: /Ажиглалтын хуудсан дахь гүйцэтгэлээр үнэлэв./ Үнэлгээний шалгуур хавсралт-4



Дүгнэлт: Үүргэвчтэй аялал-сургалтаар голын усны үнэлгээ хийх чадварыг үнэлэх гарааны үнэлгээнд 49,4-64% байсан бол ажлын хуудасны төлөвлөлт, багшийн асуултаар чиглүүлэх арга зүйд суурилсан хичээлийн судалгаа явуулсны үр дүнд⁶ сурагчдын голын усны шинжилгээ хийх чадварт дахин үнэлгээ хийх дараах дүн гарсан байна. Үүнд 89-93,6% болж 39,6-29,6%-иар өссөн нь шинжлэн судлах арга барилыг төлөвшүүлж болохуйц сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон нь батлагдаж байна гэж үзлээ.⁷

Бусдад хүргэх туршлага:

Голын усны шинжилгээний хээрийн судалгааны хуудас /хавсралт-2/

Судлаач сурагч ажиглалтын хуудас /хавсралт-3/

Арга зүйн төлөвлөлт: Технологийн үндсэн үе шат, арга аргачлал

⁶ Сургалтын технологи, хичээлийн технологи-сурган хүмүүжүүлэх техник МХСН-ийн тэргүүн Н.Оюунцэцэг багшийн лекц /Хөвсгөл аймаг мөрөн сум 2014он

⁷ Голын усны шинжилгээний Макро сээр нуруугүйтний лавлах

№	Үе шат	Алхам	Аргачлал
1	I- Төсөлт уралдаануудад оролцох	Алхам-1	“Экологийн ул мөрийг бууруулах нь”
		Алхам-2	Дэлхийн зөнгийн сургалт
		Алхам-3	БОГ-ын сургалт
2	II- Туршилтын талбай	Алхам-1	Нэг сурагч нэг мод тарих, ажиглалтын хуудас хөтлөх
		Алхам-2	Мини-цэцэрлэгт хүрээлэн
3	III-Сургалтын орчин бүрдүүлэх	Алхам-1	Мод бут, хүлэмжийн ногоо тарих аргын тухай мэдээлэл цуглуулах
		Алхам-2	Хүлэмж, туршилтын талбай байгуулах
4	IV-Үүргэвчтэй аялал сургалт	Алхам-1	Байгалийн ухааны хичээлийн нэгдсэн агуулга, үзэсгэлэнт газрыг судлах, маршрут зохиох
		Алхам-2	Байгаль орчны үнэлгээ “Голын усны хяналт шинжилгээ”- хяналт үнэлгээ
5	V- Үр дүнгээ тайлагнах	Алхам-1	Бүтээлийн үзэсгэлэн
		Алхам-2	Үр дүнгийн тайлан

Цаашид хөгжүүлэх санал:

Туршилтын талбайг өргөжүүлэн байгалийн ухааны хичээлийг цогцоор хичээллүүлэх боломжтой болгох. Тухайлбал:

- ✓ Хөрсний үе давхаргыг харуулсан хөрсний хөндлөл огтлол хийх.
- ✓ Газрын гадарга, экосистемийн бүс, бүслүүр түүний онцлог ургамал амьтны аймгийг судлуулах
- ✓ Ус, хөрсний хими, физик шинж чанарыг тодорхойлох боломжийг бүрдүүлэх

Багшлах арга зүйд гарсан өөрчлөлт:

1. Сурагчдын шинжлэх ухаанч арга барил эзэмшилт, чадварын ахиц өөрчлөлтийг тооцох арга зүйгээ хөгжүүлсэн
2. Сургалтад ашиглах бүрэн боломжтой бодитой, шаардлага хангахуйц багц /Макро сээр нуруугүйтний цуглуулга / хэрэглэгдэхүүн, туршилтын талбайтай болсон.

Б. Суралцагчдын сурах арга барилын хөгжил:

1. Хэмжих, тэмдэглэл хөтлөх, ажиглах, харьцуулах, мэдээлэл цуглуулах, туршин хэрэгжүүлэх шинжлэх ухаанч арга барил хөгжүүлэн, байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэлгээг өрнүүлж, тогтвортой хэрэглээтэй, зөв дадал хэвшилтэй иргэн болгон төлөвшихөд суралцаж эхэлсэн.
2. Өөрсдийн цуглуулсан мэдээллийг ашиглан илтгэл бичих, илтгэл тавих арга зүйд суралцаж “Экологийн ул мөрийн бууруулах нь” төслийн уралдаанд тэргүүн байр эзэлж Мини-цэцэрлэгт хүрээлэн байгуулах төслийн санхүүжилт авсан.

Дүгнэлт: Арга зүйд суурилсан хичээлийн судалгаа буюу судалгаат хичээл нь багш ажлын байран дээрээ хөгжих, багш нар хамтран арга зүйгээ өөрчлөх өргөн боломжийг бидэнд нээж өгч байна. Эко-клубын үйл ажиллагаа, Үүргэвчтэй аялал-сургалт, туршилтын талбайд судалгаат хичээлийг зохион байгуулан ажилласнаар дараах дүгнэлтэд хүрлээ.

- ❖ Сурагчдын сурч боловсрох, багш ажиллагсдын ажиллах таатай орчин бүрдүүлж чадсанаараа байгаль орчноо хайрлан хамгаалах дадал хэвшилтэй болгон төлөвшүүлж байна.
- ❖ Биологийн хичээлийн танхимын бус сургалт зохион байгуулж сурагчдын амьдрах ухаанд суралцах байгаль орчноо хайрлан хамгаалах сэтгэлгээтэй иргэн төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Ном зүй

- ✓ Монгол улсын тотвортой хөгжлийн үзэл баримтлал 2030он
- ✓ Цөм хөтөлбөр 2014 он
- ✓ Монголчуудын байгалиа хамгаалах уламжлалт соёл Ш. Чоймаа2013 он
- ✓ Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй-І,ІІ,ІІІ /МУлсын БСШУЯ, Япон Улсын Жайка хамтран гаргасан зөвлөмж/
- ✓ Хичээлд мониторинг хийх арга зүйн зөвлөмж / МУлсын БСШУЯ, Япон Улсын Жайка хамтран гаргасан зөвлөмж/
- ✓ Сургалтын технологи, хичээлийн технологи-сурган хүмүүжүүлэх техник МХСН-ийн тэргүүн Н.Оюунцэцэг багшийн лекц/Хөвсгөл аймаг мөрөн сум 2014он/
- ✓ Сорил тооцоогоор мэдлэг бүтээх арга зүй-І,ІІ,ІІІ / МУлсын БСШУЯ, Япон Улсын Жайка хамтран гаргасан зөвлөмж/
- ✓ Голын усны шинжилгээний Макро сээр нуруугүйтний лавлах
- ✓ Голын усны чанарын хяналт шинжилгээ

Үгийн сүлжээгээр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх боломж

Д.Энхсайхан

Завхан аймаг Эрдэнэхайрхан сум ЕБС-ийн багш

Хамтран боловсруулсан :М.Нийвэндагва

Удиртгал

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь сурагч нэг бүрийн сурах арга барил амьдрах ухаан шинжлэх ухааны суурь мэдлэг чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл түүх соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан хүмүүнлэг үзэлтэй иргэн болгон төлөвших боломж олгоход оршино. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд нэгж ба ээлжит хичээлийн чанар үр дүн дээшлүүлж үнэлгээг бодитой болгох хэрэгцээ шаардлага тулгарсан. Өнөөдөр хичээл хэрхэн явагдаж байна вэ? Хичээлийг сурагчдад сонирхолтой тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр дүнтэй явуулахын тулд яах вэ? Сурагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх, мэдлэгээ бататгах хэрэглэх ямар арга замууд байна вэ? гэсэн асуудлыг шийдвэрлэхэд багахан ч болов тус болох арга замыг эрэлхийллээ.

Онол арга зүйн үндэс

Өнөөдөр багш бидэнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа. Бага боловсролоос суурь боловсролд шилжиж ороход олон төрлийн хичээл орж олон агуулга үзэж байгаагаас хүүхдүүдэд мэдлэгээ багцлах, хувиргах, уялдаа холбоог нь ойлгоход хүндрэл тулгарч байна. Дээрх асуудлуудыг шийдэхэд хүүхдэд ойлгомжтой, хялбар сонирхолтой цогц шийдэл юу байж болох вэ? Сурагчид олон төрлийн хичээлийн даалгаврыг уншиж хийхээс залхуурч зайлсхийж байна. Тэгвэл хүүхдийг хэрхэн уншихад сонирхолтой болгох, их даалгаврыг төвөгшөөлгүйгээр аав ээжтэйгээ хамтран хийх ямар боломж байна вэ? Эдгээрт хариу болгож болох зүйл нь үгийн сүлжээ байж болно гэж үзээд энэ сэдвийг сонголоо. **Сэтгэх нь унших, бичих, ярих сонсохын нэгэн адил юм. Өдөр тутмын амьдрал сургалтын агуулгыг салангид авч үзвэл хэзээ ч бүтээлч сэтгэлгээнд сургаж чадахгүй.**⁸

Сонгосон судлагдахуун: Байгалийн ухааны хичээлүүд

Хамрах хүрээ: 6-9 ангийн нийт 65

Хамрагдсан багш: Физик- Газар зүй, Хими-Биологи 2 багш

Туршин хэрэгжүүлсэн хугацаа: 2017-2018 оны хичээлийн жил

⁸ Браун(1989 он)

Хугацаа

2017-2018 хичээлийн жил

Илтгэлийн зорилго

Хичээлийг сурагчдад сонирхолтой тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үр дүнтэй явуулах, мэдлэгээ хувирган хэрэглэх, бататагах, бүтээлчээр бие даан өөрийгөө хөгжүүлэхийн тулд үгийн сүлжээг өргөнөөр ашиглан туршиж судлахад оршино.

Сурагчдаар мэдлэг бүтээлгэх чиг хандлага

Мэдлэг нь ШУ-аар нотлогдсон мэдээлэл юм. Иймд сурагчдаар мэдлэг бүтээлгэнэ гэдгийг ШУ-ны нээлт гаргалгаа хийлээ гэж ойлгож болохгүй. Харин мэдлэгийг хүүхэд бие даан хэрхэн өөрөө нээж өөрийнхөөрөө ойлгох вэ? Өөрийн болгож авах вэ? Цаашид түүнийг өөрөө хэрхэн хэрэглээ болгох вэ? гэсэн ойлголт юм. Тэгвэл ангидаа сурсан зүйлээ бататгах, хэрэглээ болгох үйл явц нь гэрийн даалгавар юм. Гэрийн даалгавар нь сонирхолтой бүтээлч, хүүхдийн хөгжлийг дэмжсэн байх ёстой. Гэвч зарим тохиолдолд гэрийн даалгавар дааж давшгүй ачаа их захгүй хуулан бичиг залхаалт болоод байна. Гэрийн даалгаврыг сонирхолтой болгох хэлбэрүүд шүлэг зохиох, оюуны зураглал хийх, үгийн сүлжээ хийх, бүтээл хийх, туршилт хийх, зураг зурах, зохиол бичих зэрэг байж болно. Энэ хэлбэрүүдээр гэрийн даалгавар хийхэд мэдлэг чадвараа бататгахаас гадна хүүхдийн бүтээлч сэтгэхүй хөгжих, сууж сурах, мэдээлэлтэй ажиллах, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах арга барилд суралцах сайн талуудтай. (Г.Цэрэнбалбар, 2011) (БСШУЯ, Суралцахуйг дэмжсэн хичээл үйл ажиллагаа, 2016)

Үгийн сүлжээний тухай Бид бүхний чөлөөт цагаараа бөглөдөг үгийн сүлжээг анх хэн зохиосон гэж бодно. Хэдийгээр уг асуудал судлаачдын дунд нэлээд маргаантай байдаг ч Өмнөд Африкийн бүгд найрамдах улсын иргэн Виктор Орвилл шоронд хоригдож байхдаа дөрвөлжин хээ бүхий шалнаас үүдэн анх зохиосон гэсэн баримт бий. Мөн зарим нэг хүний үзэж буйгаар Ливерпулийн иргэн, сэтгүүлч мэргэжилтэй Артур Уинн Нью-Йоркт цагаачилж гарсан хойноо үгийн сүлжээг зохиосон гэдэг.

Эдүгээ хэн зохиосон нь тун тодорхой биш ч гэсэн анх үгийн сүлжээ 1913 оны 12 дугаар сарын 21-нд “Нью-Йорк уорлд” сонинд хэвлэгдсэн нь тогтоогджээ.


Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх орчныг бүрдүүлэх (БСШУЯ, Суралцахуйг дэмжсэн хичээл үйл ажиллагаа, 2016)

Бүтээлчээр сэтгэж сургах нь зөвхөн ангид хичээл заах төдийгөөр бүтэх хялбар ойлголт биш. Бүтээлч сэтгэлгээнд сургах тогтсон жор байхгүй. Гэвч бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх тодорхой сургалтын нөхцөлүүд суралцагчдын идэвхтэй үйл ажиллагаа гэж бий. Бүтээлч сэтгэлгээг дэмжихийн тулд багш нар дараах зүйлийг анхаарвал зохино.

1. Суралцагчдын бүтээлчээр сэтгэж сурахад хангалттай хугацаа боломж олгох
2. Суралцагчдыг эргэцүүлэн бодох боломжоор хангах
3. Олон ургалч үзэл бодол, санал санаачилгыг хүлээн зөвшөөрөх
4. Суралцах үйл ажиллагаанд суралцагчдыг идэвхтэй оролцуулах
5. Суралцагч бүрийн шүүмжлэлт шийдэл гаргах чадварыг нээж илрүүлэх, түүнд итгэл үзүүлэх
6. Суралцагчдыг чөлөөтэй туршиж, бодол саналаа илэрхийлэх орчинг найдвартай бүрдүүлэх
7. Бүтээлч сэтгэлгээг үнэлэх

Үр ашигтай, бүтээлчээр сэтгэж сурах үйл ажиллагаанд оролцохын тулд суралцагчид дараах зүйлийг мэдвэл зохино. Үүнд:

1. Өөрийн итгэл үнэмшлийг төлөвшүүлж, үзэл бодлын үнэ цэнийг ойлгож мэдэх



2. Сурах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
3. Олон ургалч үзэл бодлыг хүндэтгэн сонсож сурах
4. Ухаалаг дүгнэлт өгч, үнэн зөвөөр ойлгуулах чадвартай байх

Харвардын их сургуулийн профессор Ховард Гарднерын хүүхэд бүрийн сэтгэхүйн онцлог ялгаан дээр тулгуурлан гаргасан судалгаанаас харахад 8 төрлийн оюун ухаан байдаг ажээ. Энэхүү сэтгэхүйн онцлогт тулгуурлан хүүхдийнхээ ирээдүйн мэргэжлийг сонгон түүнийх нь дагуу авьяас чадварыг хөгжүүлэх нь чухал гэж профессор үзжээ.

1. Үг ярианы буюу хэлний ухаан:
2. Логикийн буюу тооны ухаан:
3. Харааны болон орон зайн ухаан:
4. Биеийн эвслийн болон кинестетикийн ухаан:
5. Хөгжмийн болон хэмнэлийн оюун ухаан:
6. Харилцааны болон олон нийтийн ухаан:
7. Дотоод ухаан:
8. Байгалийн ухаан:

Таны хүүхдэд дээрх чадваруудын аль илүү байгааг ажиглаж, сонирхлыг нь хөхүүлэн дэмжвэл ирээдүйд хүүхэд тань суут хүн ч болж мэдэх юм гэжээ. Эндээс харахад . Үг ярианы буюу хэлний ухаанд хүүхдийг чадваржуулах хэрэгтэй . Энд үгийн сүлжээ бөглөснөөр үгийн баялаг сайтай, үлгэр түүх онигоо ярих, ном унших, үгийн сүлжээ бөглөх, зохиох ,оньсого таах, үгэн тоглоом тоглох дуртай болдог.

Суурь боловсролын хичээлүүдээр эзэмших сурах арга барил эзэмших чадварууд (БСШУЯ, 2015)

Хичээл	Сурах арга барил	Эзэмшүүлэх чадварууд
Монгол хэл бичиг Гадаад хэл	Мэдээлэлтэй ажиллах харилцах судлан шинжлэх	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл хүлээн авах унших сонсох ярих бичих\ • Мэдээлэл боловсруулах \унших сонсох ярих бичих\ • Илэрхийлэх \унших сонсох ярих бичих\
Математик	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> • Асуудлыг олж харах томъёолох • Асуудлыг математик загварт оруулах төлөвлөгөө боловсруулах • Төлөвлөгөөг хэрэгжүүлэх • Дүгнэлт гаргах үр дүнг тайлбарлах
Мэдээллийн технологи	Мэдээлэл харилцаа холбооны технологи хэрэглэн асуудал шийдвэрдэх	<ul style="list-style-type: none"> • МХХТ мэдээллийг таньж мэдэх хэрэгцээт мэдээллээ тодорхойлох • Мэдээлэл боловсруулах ажлыг төлөвлөх арга аргачлал гаргах • Технологи сонгон мэдээлэл боловсруулах • Мэдээлэл МХХТ-г хэрэглэх үнэлэх түгээх хамтран эзэмших
Байгалийн ухаан	Шинжлэх ухаанч арга барил	<ul style="list-style-type: none"> • Асуудал таамаглал дэвшүүлэх • Шинжлэн судлах ажлыг төлөвлөх • Баримт нотолгоо гаргах тайлагнах • Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах үнэлэх
Түүх нийгмийн ухаан	Шинжлэн судлах арга барил	<ul style="list-style-type: none"> • Асуулт тавих асуудал таамаглал дэвшүүлэх • Үйлийг төлөвлөх мэдээлэл цуглуулах • Мэдээлэл боловсруулах • Үр дүнг хэлэлцэх шинэ санаа гаргах
Дизайн технологи	Бүтээлч эрэлхийллийн арга барил	<ul style="list-style-type: none"> • Асуудал хэрэгцээг илрүүлэх • Мэдээлэл цуглуулах дүн шинжилгээ хийх • Дизайны шинэ санаа шийдэл гаргах • Бүтээх хөгжүүлэх • Үнэлэх үр дүнгээ танилцуулах

Хичээлээс гадуурхи үйл ажиллагаа	Асуудал шийдвэрлэх арга барил	<ul style="list-style-type: none"> • Өөрийгөө удирдан хөгжүүлэх чадвар • Манлайлах чадвар • Харилцааны чадвар • Оролцооны чадвар
----------------------------------	-------------------------------	--

Хэрэгжүүлсэн байдал

Унших материал ихтэй цээжлэх тогтоох нэр томьёо олонтой нэгж хичээлээр шалгалт авахад хүүхдүүд тааруу дүн үзүүлж байв. Үүний учир шалтгаан юу байв гэдгийг судлан хүүхдүүдтэй ярилцахад их материал унших олон нэр томьёог цээжлэн тогтоох хоорондох холбоо хамаарал уялдааг олоход их төвөгтэй анхаарал төвлөрөхгүй нойр хүргэсэн байсан учраас гэж хариулж байсан нь энэ асуудлыг ямар аргаар илүү сонирхолтой хэлбэрээр шийдэж болохыг эрэлхийлэх аянд гаргахад хүргэсэн билээ. Үүнийг шийдвэрлэхэд тохирох арга нь юу болох талаар удаан бодсоны эцэст үгийн сүлжээ байж болох юм гэсэн санаа олсон билээ. Ингээд нөгөө тааруу дүн авсан нэгжээ дахин судлуулахын тулд үгийн сүлжээг энгийнээс хүндэрсэн шатлалаар 5 хувилбар бүхий зохиож сурагчдаар ажиллуулж үзлээ.

Дээрхи байдлаас ажиглалт хийж үзэхэд хүүхдүүдийн сонирхол нэмэгдэн урьд нь залхуураад уншихгүй байсан зүйлээ маш амархан уншиж гол хэрэгтэй зүйлээ тэмдэглэн авч чадаж байлаа, мөн үгийн сүлжээнд хэрэглэгдэж байсан нэр томьёог амархан тогтоож байсан. Мөн өөрсдөө сонирхон олон загварын үгийн сүлжээ зохиож хоорондоо солилцон ажиллаж өрсөлдөж байсан нь хялбар сонирхолтой аргаар асуудлаа шийдвэрлэж байсан нь харагдсан.

Үгийн сүлжээгээр дамжуулан хөгжүүлж болох чадварууд ба судлагдахуунуудаар олгох чадваруудын холбоо хамаарал


Үгийн сүлжээгээр дамжуулан хөгжүүлж болох чадварууд	Судлагдахуунуудаар олгох чадварууд	Судлагдахуун
Холбогдолтой мэдээлэл цуглуулах унших	Мэдээлэл хүлээн авах \унших\	монгол хэл гадаад хэл
	Асуудлыг олж харах томьёолох \гол ойлголтоо тодруулах\	Математик
	Үйлийг төлөвлөх мэдээлэл цуглуулах	Түүх
	Асуудлыг олох тодорхойлох төлөвлөх мэдээлэл цуглуулах	АЧСҮА
	Өөрийгөө удирдан хөгжүүлэх чадвар \зорилгодоо хүрэх алхамуудыг төлөвлөх тодорхойлох\	ХГҮА
Асуултаа боловсруулах	Мэдээлэл боловсруулах \асуултыг найруулга \	Монгол хэл
	Асуудал таамаглал дэвшүүлэх	Байгалийн ухаан
	Асуулт тавих	Түүх нийгмийн ухаан
Үгийн сүлжээгээр зурах	Дизайны шинэ санаа шийдэл гаргах	Дизайн технологи
	Технологи сонгон мэдээллээ боловсруулах	Мэдээллийн технологи
Үгийн сүлжээ бөглөх	Мэдээлэл боловсруулах илэрхийлэх	Монгол хэл Гадаад хэл
	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Математик
	Баримт нотолгоо гаргах тайлагнах	Байгалийн ухаан
	Мэдээлэл боловсруулах үр дүнг гаргах	Түүх нийгмийн ухаан

Үгийн сүлжээгээр хүүхдийн хөгжилд хийсэн судалгааны гараа

Хүүхдүүдээр үгийн сүлжээ зохиолгоход дараах чадварууд дутмаг байгаа нь харагдсан.

Үгийн сүлжээний чадварууд	Илэрсэн чадварууд
Мэдээлэл боловсруулах төлөвлөх томьёолох	Уншаад гол зүйлээ салгаж задлан шинжилж чадахгүй
	Залхуурал их байсан ном уншдаггүй
	Хэрэгцээт мэдээллээ хайж олж чадахгүй эх сурвалжаа олж чадахгүй байсан
Асуултаа боловсруулах	Үгийн сонголт буруу холбоо хамаарал муутай
	Асуулт нь тодорхойгүй салаа утгатай
	Бүх асуултууд асуух хэлбэртэй байсан.
	Сэдвээс хальсан хүнд ойлгомжгүй асуулт тавих
	Асуултаа боловсруулахад цаг их шаардсан.
Үгийн сүлжээ зохиох	Сүлжээний зохиомж ойлгомжгүй эмх цэгцгүй
	Тоо үсэг хольж бичсэн
	Дизайн муу бохир муруй балласан
	Хэт их урт үг авах
	Хэд хэдэн үгнээс бүтсэн байх
	Хэтэрхий урт эсвэл маш богино тодорхойгүй
Үгийн сүлжээ бөглөх	Үгээ буруу алдаатай бичих
	Мэдээлэл уншихаас зайлсхийж худлаа таах
	Гадаад нэр томьёо товчилсон үгэнд төөрөх


Дээрх алдааг багасгахын тулд хэзээ хэрэглэх вэ? ямар арга замаар хийх вэ? гэсэн асуудал тулгарсаныг дараах байдлаар шийдэхээр оролдсон.




Судалгааны үр дүн

Энэ бүх үйл ажиллагааны дараа дараах үр дүн гарлаа.

Үгийн сүлжээг бататгал хичээл гэрийн даалгавар явцын болон нэгжийн үнэлгээнд хэрэглэхэд дараах үр дүн гарч байгаа нь ажиглагдлаа. Гэрийн даалгаварт үгийн сүлжээ өгснөөр гэрийн даалгавар хийх хувь өссөн үр дүн гарсан тэр дундаа 8-р ангийн биологийн хичээлийн гэрийн даалгавар хийлт хамгийн их өсөлттэй байлаа.



Дээрх бүх үйл ажиллагааг зохион байгуулж явуулсны дараа хийсэн үгийн сүлжээнүүдэд дүгнэлт хийж үзэхэд өмнө нь дутмаг байсан чадваруудад дараах байдлаар ахиц гарлаа.



Дүгнэлт

Үгийн сүлжээгээр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх боломжийг судлан бичсэн илтгэлээс дараах дүгнэлтийг хийж байна.

1. Олон хэлбэрийн үгийн сүлжээ нь бүтээлч сэтгэлгээг хөгжүүлдэг. Сурагчид маань энгийн, зурган, гол ойлголтоо тодотгосон, төрөл бүрийн дүрс хэлбэртэй, тоон, үгийн гинж, бодлого бодох, хариултаас асуулт зохиох гэх мэт хэлбэрээр үгийн сүлжээ зохиож бөглөж сурсан.
2. Үгийн сүлжээ зохиож бөглөж сурсанаар үгийн баялаг болон зөв бичих чадвар сайжирч, анхаарлаа төвлөрүүлэн уншиж гол ойлголтоо тэмдэглэж сурсан.
3. Сурагчдын бүтээлчээр сэтгэн бодох үйл ажиллагаанд хангалттай хугацаа зарцуулах боломж олгож байгаа учраас хүүхэд сууж сурдаг.
4. Гэртээ хийж байгаа учраас ээж аавтайгаа хамт хийх улмаар эцэг эхчүүд давхар суралцах харилцаа хандлага сайжрах боломжийг бүрдүүлсэн.
5. Цөм хөтөлбөрийн судлагдахуунаадаар сурах арга барил, эзэмших чадварыг цогцоор хөгжүүлэхэд ашиглаж болох сонирхолтой шийдэл

6. Сурагчдын аливаа зүйлд хандах хандлага, хувийн зохион байгуулалт сайжирч байгаа нь харагддаг.
7. Сурагчдын эргэцүүлэн бодох боломжоор хангах зэрэг олон ач холбогдолтой нь харагдаж байна.
8. Түүх, нийгмийн ухаан, биологи зэрэг хичээлийн онцлог нь лекцийн аргаар явуулах болон унших, бичих, тэмдэглэх агуулга ихтэй байдаг учраас сурагчдын идэвх, сонирхол, анхаарал буурдаг тул энэ аргаар сурагчдын идэвх сонирхлыг өрнүүлж сургалтыг зохион байгуулвал үр дүнд хүрэх юм.

Дэвшүүлсэн санаа

1. Олон даалгавар саланги даалгавар өгч сурагчдыг залхааж байснаас хичээлүүдээ бүлэглэн нэгдмэл байдлаар агуулгаа нэгтгэн үгийн сүлжээ хэлбэрээр даалгавар өгч болох юм.
2. Үгийн сүлжээ сонирхогчдын дугуйлан клуб ажиллуулан хүүхдүүдийг сонирхлоор нэгтгэн хөгжүүлж болох юм.
3. Суурь боловсролын хичээлүүдээс ялангуяа хэлний хичээлүүд дээр үг цээжлүүлэх зөв бичих сонирхолтой арга болгон хэрэглэж хэвших мөн судалгаа хийж болох юм.
4. Үгийн сүлжээ ашиглан үнэлгээний даалгаварын сантай болж болох
5. Үгийн сүлжээг гол төлөв гэрийн даалгавар, бие даалт, бүтээлийн сан, бүлэг сэдвийн бататгал дүгнэлт зэрэгт ашиглах нь тохиромжтой юм.
6. Үгийн сүлжээг бататгах хичээл болон жишиг даалгавар болгон ашиглахад сурагчдын сурах идэвх сонирхлыг ихээр төрүүлж байна.

Ном зүй

1. *Суурь боловсролын цөм хөтөлбөр БСШУЯ 2015 он*
2. *Суралцахуйг дэмжсэн хичээл үйл ажиллагааны төлөвлөлт БСШУЯ 2016 он*
3. *Та хүүхдээ өөрчилч хөгжүүлье гэвэл Г. Цэрэнбалбар 2011 он*

Үнэлгээний хуудсаар хүүхдийг хөгжүүлэх нь

*Түдэвжамц Пагмасүрэн, Аюушийн Отгонбаяр
Завхан аймаг Яруу сумын ерөнхий боловсролын сургууль*

Оршил хэсэг

Үнэлгээ гэдэг нь сурган хүмүүжүүлэх үйл явц болон суралцах үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж ямар үр дүнд хүрснийг мэдэж авахын тулд тодорхой зорилго бүхий үйл ажиллагаа зохион байгуулж мэдээлэл цуглуулах үйл явц юм. Үнэлгээ нь сургах болон суралцах үйл явцын стратеги, багш нарын гүйцэтгэх үүрэг хариуцлагад нөлөөлдөг учраас сургалтын үйл явцад маш чухал үүрэгтэй. Үнэлгээг зохистой ашиглах нь суралцагчдыг суралцах үйл ажиллагаандаа хариуцлагатай хандахад уриалан дууддаг

Сэдэв сонгосон үндэслэл: Монголын мянга мянган багш нар болон боловсролын байгууллагын ажилтнууд хичээлийн үр өгөөж, хүртээмжийг хэрхэн дээшлүүлэх вэ, суралцагчдад бие даасан, бүтээлч хандлагыг хэрхэн төлөвшүүлэх вэ, үнэлгээг хэрхэн бодитой хийх вэ гэх мэт олон асуудалтай тулгарч тэдгээрийг нааштай шийдэх арга замыг дор бүрнээ эрэлхийлж, нэгийг бодож хоёрыг тунгааж байгаа нь дамжиггүй.

Бид сургалтыг сайжруулах, эцэг эхчүүд болон суралцагчдын оролцоо идэвхийг нэмэгдүүлэх асуудалд дусал нэмэх үүднээс Үнэлгээ гэж юу вэ?, Үнэлгээг ямар зорилгоор хийдэг вэ?, Үнэлгээний объект нь юу юу байж болох вэ?, Үнэлгээг юунд ямар зорилгоор ашиглах боломжтой вэ? гэсэн асуултыг өөртөө тавьж тэдгээрт хариулт хайж хэдэн жилийн өмнөөс судалж эхэлсэн бөгөөд зарим нэг туршилтыг сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлээд байна. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд үнэлгээний аргыг суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан хэрэглэж байгаа туршлага, аргууд багш нарт зайлшгүй хэрэгцээт зүйлсийн нэг байдаг.

Сонгосон судлагдахуун : Анли хэл

Хамрах хүрээ: 6-9-р ангийн суралцагчид, эцэг эхчүүд, багш нар

Түлхүүр үг: Нэгж ээлжит хичээлийн чадвар, үнэлгээ, ажиглах мэдлэг чадвар тэмдэглэлийн арга, үнэлгээ ил тод шударга

Зорилго: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэн идэвх оролцоог нэмэгдүүлэн бие даан сурах арга барилд сургах үнэлгээний аргыг сургалтанд оновчтой хэрэглэх арга зүйг туршин багш хөгжихөд оршино.

Зорилт:

- Үнэлгээний тухай ойлголтуудыг тодруулан авч үзэх
- Багш эцэг эх сурагчдаас судалгаа авч үнэлэлт дүгнэлт хийх
- Өөрийн туршлага болох үнэлгээний хуудас дээр анализ хийх
- Хүүхэд бүрийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон үнэлгээний аргыг дэлгэрүүлэн нэгтгэн дүгнэх

Эерэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа: 3 жил

1. Онолын хэсэг

Үнэлгээ юунд хэрэгтэй вэ? АНУ-ын Мичиганы Их Сургуулийн үнэлгээний төвийн захирал Л.Стуффльбийм ”

Үнэлгээ өгөх гол шалтгаан нь:

1. Чадах бүхнээ хийж байгаа эсэхийг мэдсэнээр суралцагч бүрт сурахад нь туслах
2. Бүлгийн сургалт явуулах хамгийн үр дүнтэй арга барил нээж олох
3. Сурагч болон эцэг эхэд сурах үйл ажиллагаандаа дүгнэлт хийж, сайжруулах хэрэгсэл болох
4. Сурлагын түвшинг тодорхойлох зэрэг болно “ гэсэн байна.

Үнэлгээний дидактик үндэс:

Үнэлгээний дидактик үндэс нь суралцагчдын мэдлэг, чадвар эзэмшилтийн явц, үр дүнг тодорхойлж, сургалтын явцад хүүхдийн хөгжилд гарч буй ахицыг өмнөхтэй жишиж, харьцуулах түүнчлэн эзэмшвэл зохих агуулгыг ямар түвшинд эзэмшсэнийг тодорхойлоход оршино. Тэгвэл сурган хүмүүжүүлэх ухаанд үнэлгээг өргөн утгаар авч үзвэл суралцагчийн боловсролын үр дүнг шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэх тогтолцоо, явцуу утгаар авч үзвэл суралцагчийн мэдлэг чадвар төлөвшлийг хэмжих процесс юм гэж тодорхойлсон байдаг

2. Судалгааны хэсэг

Судалгааны объект : Суралцагч, багш, эцэг эх

Судалгааны арга: Ажиглалт, Ярилцлага. Асуулга, Анализ, ситуаци, ганцаарчилсан арга,

Судалгааны зорилго: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд үнэлгээний үр дүн бодит байдлыг судлахад оршино.

Судалгааны зорилт:


- Үнэлгээний талаарх тулгамдаж байгаа асуудлыг судлах
- Үнэлгээний ил тод байдал, үнэлгээндээ суралцагчдын сэтгэл ханамжтай байдалд дүгнэлт хийх
- Эцэг эхчүүдийн хүүхдийнхээ сурлагын үнэлгээний талаарх мэдээлэлд дүгнэлт хийх
- Багш нарын хичээл үйл ажиллагаандаа хэрэглэдэг үнэлгээний аргад үнэлэлт дүгнэлт хийх
- Хичээл үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцоо хэр байгаад үнэлэлт дүгнэлт хийх

Судалгааны ач холбогдол Багш, эцэг эх, суралцагчдаас үнэлгээний талаар тулгамдаж буй асуудлыг тодруулах


Судалгаа -1 Суралцагчдын судалгаа

Асуулт-1


Багш нарын гаргасан улирлын дүнд хэр сэтгэл хангалуун байдаг вэ?




Асуулт- 2 Чамд улирлын төгсгөлд ямар хичээл дээр хэдэн хувь үнэлгээтэй гарах урьдчилсан дүнгийн мэдээлэл байдаг уу?



Асуулт-3 Улирлын дүнгээ ахиулах боломж багш нар тань чамд олгодог уу?




Асуулт- 4 Багш нарын гаргаж байгаа үнэлгээ хэр бодитой байдаг вэ?



Суралцагчдаас авсан судалгааны дүгнэлт: Дээрх судалгаануудаас харахад суралцагчид улирлын үнэлгээндээ сэтгэл хангалуун байдал дунд зэрэг буюу хангалуун биш гэж нийт суралцагчдын 40% нь хариулсан. Улирлын төгсгөлд ямар хичээл дээр хэдэн хувь үнэлгээтэй гарах урьдчилсан дүнгийн мэдээлэл байдаг эсэх асуулганд суралцагчдын байдаггүй буюу заримдаа гэж 85% нь хариулсан байна. Багш нар суралцагч нарынхаа дүнг ахиулах боломж олгодог эсэх асуултанд олгодоггүй буюу заримдаа гэж 80% хариулсан. Багш нарын гаргаж байгаа үнэлгээ хэр бодитой байдаг гэж үзэж байгааг асуухад бодитой биш буюу заримдаа гэж 47% нь хариулсан байгаа нь үнэлгээний тал дээр багш нар анхаарч ажиллах хэрэгтэй байна. Дээрх судалгаанд үндэслэн үнэлгээг маш бодитой, суралцагчдад ойлгомжтой болгох, харилцан хүлээн зөвшөөрсөн үнэлгээ хийх хэрэгтэй байгааг харуулж байна.


Судлагаа 1.2 Багш нарын судалгаа

1. Та заадаг хичээлийнхээ улирлын дүнг гаргахаасаа өмнө суралцагсдад өөрийн дүнгээ урьдчилан мэдэх боломж олгодог уу?



2. Та хичээл заахдаа үнэлгээний ямар хэлбэрийг түлхүү хэрэглэдэг вэ?
 - Явцын тэмдэглэл хөтөлсөн үнэлгээг улирлын дүн гаргахдаа ашигладаг
 - Аман үнэлгээ- 6
 - Даалгаврын гүйцэтгэл дүгнэх хуудас
 - Гэрлэн дохио
 - Туслах багш
 - Дасгал даалгавар
 - Бүтээлээр -2
 - Урамшуулах
 - Эрхий хурууны арга- 4

- Тамган үнэлгээ- 2
 - Үнэлгээний хуудас
 - 2 од 1 хүсэл
3. Таны хэрэглэдэг үнэлгээний ямар арга суралцагчдын сонирхолыг төрүүлж илүү идэвхжүүлдэг вэ?
- Идэвхжүүлж
 - Явцын үнэлгээний сонирхолтой арга
 - Аман үнэлгээ - 4
 - Таван хошуу тавьж үнэлдэг
 - Туслах багш
 - Нэгж хичээлийн болон аман үнэлгээ
 - Тамган үнэлгээ- 2
 - Магтах
 - Бүтээл хийх шинэ санаа
4. Таны гаргасан суралцагсдын улирлын үнэлгээний дүнд та хэр сэтгэл хангалуун байдаг вэ?



Дүгнэлт: Дээрх судалгаанаас харахад улирлын дүнг гаргахаасаа өмнө суралцагсдад өөрийн дүнгээ урьдчилан мэдэх боломж заримдаа олгодог гэж 54% нь хариулсан. Багш нарын хэрэглэдэг үнэлгээний аргуудаас аман ба эрхий хурууны аргыг ихэнх нь хэрэглэдэг нь тодорхой харагдаж байна. Мөн дадал хэвшил болсон шинэлэг үнэлгээ хэрэглэсэн байдал бага байна.

Судалгаа.1.3 Эцэг эхийн судалгаа

1. Та хүүхдийнхээ хичээлүүдийн улирлын дүнгийн талаар хэр мэдээлэлтэй байдаг
 - Бага
 - Мэдээлэл сайтай байдаг
 - Багш нь хэлж өгвөл мэднэ уг нь байнга мэдэж байвал зүгээр
 - Мэдэхгүй -3
 - Улирал бүрийн дүнг үзүүлдэг таниулдаг
 - Жилийн эцсийн үнэлгээг нэг л хардаг
 - Эцэг эхийн хурлаар хардаг
2. Та хүүхдийнхээ хичээлийн дүн хичээлийн идэвхи оролцооны талаар мэдээллийг өдөр бүр мэдэх боломж байдаг уу
 - Мэдээлэл байхгүй- 4
 - Байдаг
 - Англи хэл дээр мэддэг
 - Багш нар хүүхдийг ялгарладаг

Дүнэлт: Дээрх судалгаанаас харахад эцэг эхчүүдийнх ихэнх мэдээлэл бага, хүүхдийн хичээлийн дүн идэвхи оролцооны талаар мэдээлэл байхгүй гэж ихэнх нь хариулсан байна. Суралцагчдын мдлэг чадварын түвшин, ахицын талаарх мэдээлэл дутмаг байна. Хүүхэд нэг бүрийн хөгжүүлэхэд эцэг оролцоог нэмэгдүүлэх боломжийг судлах хэрэгтэй.

Дээрх судалгааны мөрөөр дараах ажлыг хийж хэрэгжүүлэн үр дүнг тооцсон:

Бүтээлч үйл ажиллагааг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан үнэлгээний хуудас хэрэглэсэн байдал

Загвар№1

Үнэлгээний хуудас

2014-2016 он

Суралцагчын нэр

Сар өдөр	унших	бичих	ярих	сонсох	Даалгавар1	Даалгавар2	Даалгавар3	Багаар ажиллах

Давуу тал:

- ✓ Цэвэр гаргацтай бичдэг болж бичгийн хэв сайжирсан
- ✓ Дэвтэр ашиглалт эмх цэгцтэй болсон
- ✓ Гэрийн даалгавраа тогтмол хийдэг болсон
- ✓ Өөрийгөө үнэлдэг болсон
- ✓ Хичээлийн цагийг илүү бүтээлч үр дүнтэй өнгөрүүлдэг болсон
- ✓ Үгийн дуудлага зөв унших чадвар нэмэгдэж байна
- ✓ Өөртөө санаа тавьдаг болсон
- ✓ Багаар ажиллаж сурч байна

Сул тал:

- Зөвхөн ээлжит хичээлд хэрэглэгддэг
- Мэдлэг зарим чадвар хэрэглээ болоход нөлөөлөхгүй байна

Загвар№2

Суралцагчийн үнэлгээний хуудас

2017он

Суралцагчийн нэр.....

Санамж:Хичээл тасалсан, чөлөөтэй,өвчтэй шалтгаанаар байхгүй байсан суралцагч тухайн шалгуураа заавал нөхөж шалгуулан үнэлгээгээ тавиулна.

Шалгуур	Үнэлгээ
---------	---------

	нийлбэр												
80 асуулт, хариулт													
14 хэлц үг													
7 орчуулга													
Шинэ үг 160 \ 7хоногт 20үг													
Тест-4													
7 сэдэв унших \ орчуулсан сэдэв\													
Сургуулийнхаа тухай бичиж ярих- үгийн тоо 100 дээш													
Нийт үнэлгээ													

Сайжруулсан байдал:

- Улирлын үнэлгээний явцын үнэлгээнд хэрэглэсэн
- Үнэлгээний шалгуурыг оруулж өгсөн
- Бие даан суралцах арга барилыг дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн
- Хүүхэд бүрийн мэдлэг чадварын ахицыг үнэлсэн
- Урьдчилсан байдлаар явцын үнэлгээгээ хүүхэд өөрөө гаргаад хянаад явах боломж бүрдсэн
- Улирлын үнэлгээгээ ахиулах боломж хүүхдэд бий болсон

Шалгуур	Үнэлгээ												
50 асуулт, хариулт	4	5	10	4	3	9	4						
14 хэлц үг	3	4	8	1	1	4							
7 орчуулга	1	1	1	1	1	1							
Шинэ үг 160 \ 7хоногт 20үг\	0	5	5	10	15	10	10	9	10	20			
Тест-4	1	1	1	1	1	1							
Унших \ 7 сэдэв\	1	1	1	1	1	1							
Өөрийнхөө тухай бичиж ярих- үгийн тоо 100 дээш	1	1	1	1	1	1							
Нийт үнэлгээ													90-100

Загвар№3

Суралцагчийн үнэлгээний хуудас

2017-2018

Суралцагчийн нэр.....


анги-6

1-р улирал

Санамж:Хичээл тасалсан, чөлөөтэй,өвчтэй шалтгаанаар байхгүй байсан суралцагч тухайн шалгуураа заавал нөхөж шалгуулан үнэлгээгээ тавиулна.

Шалгуур	Үнэлгээ нийлбэр
---------	-----------------


- 3) Үнэлгээ хийж дүн гаргасны дараа суралцагч бүртэй **ганцаарчилсан ярилцлага** хийх замаар суралцагчийн өөрийн үнэлгээг сонсох, багшийн хийсэн үнэлгээг танилцуулах гэх мэтээр харилцан хүлээн зөвшөөрсөн үнэлгээ хийгддэг.
- 4) Цөм хөтөлбөрийн эзэмших чадвар нь тодорхой байдаг
- 5) Эцэг эхчүүдийн оролцоо нэмэгдсэн
- 6) Массын сургалтын сайжирсан




7)

Суралцагчдын сурлагын ахиц амжилтанд нөлөөлж байгаа байдлыг Графикаар харуулбал

Багшийн өөрийн үнэлгээ




Хөндлөнгийн үнэлгээ



Багшийн өөрийн үнэлгээ хөндлөнгийн үнэлгээ хоёрын зөрүү бага гарч байгаа нь Хүүхэд нэг бүрийн ахицыг харилцан хүлээн зөвшөөрсөн үнэлгээг хийн суралцагч бүр мэдлэг чадварын ахицаа эцэг

эх,багш,суралцагч хамтран тодорхой шалгуурын дагуу бодитой хийгдэж байгаагийн үр дүн гэж үзэж байна

Сүүлийн 3 жилийн 6-р ангийн суралцагчдын мэдлэг чадварын ахиц амжилтын үзүүлэлт




Үнэлгээний хуудастай ажиллахад суралцагч бүрт тулгарч буй бэрхшээл

- Суралцагч өөрийн үнэлгээ хийхдээ өөрийн ахиц дэвшилийг бодитоор үнэлж чадахгүй өөртөө итгэлгүй байдал, өөртөө шүүмжлэлтэй байх хандлагууд илэрч байсан.
- Үнэлгээний хуудасны үр дүн ач холбогдолыг ойлгон хэвшүүлэхэд хугацаа шаардагдаж байсан

Үйл ажиллагааны дараах судалгаа \ Суралцагсад\

Асуулт-1 Үнэлгээний хуудас таныг хэр бодитой үнэлдэг вэ?



Асуулт-2 Үнэлгээний хуудсаны давуу тал юу вэ?

- ✓ Хийх даалгавар тодорхой
- ✓ Үнэлгээгээ өөрөө хянах боломжтой
- ✓ Ялгаварлах байдал байхгүй
- ✓ Зөндөө их зүйл мэдэж авдаг
- ✓ Үнэлгээгээ ахиулах боломж олгодог
- ✓ Зорилго тодорхой

- ✓ Бусдадаа тусладаг
- ✓ Өдөр бүр сурсан зүйлээ үнэлүүлдэг
- ✓ Өөртөө хариуцлага хүлээдэг

Эцэг эхээс авсан үйл ажиллагааны дараах судалгаа

1. Англи хэлний хичээлийн үнэлгээний хуудас хэр үр дүнтэй байна гэж та бодож байна вэ?

- Үнэлгээний хуудасаар дамжуулан хүүхдийнхээ дүн хичээлийн оролцоог мэдэж авдаг
- Маш бодитой үнэлгээ болж чаддаг хүүхэд идэвхитэй байдаг
- Бүх хичээлд хэрэглэвэл зүгээр
- Үр дүнтэй хүүхэд өөрийгөө үнэлдэг- 3
- Хэр суралцаж байгааг хянадаг
- Үнэлгээний хуудас хэрэглэж байгаа хичээл үр дүнтэй ил тод байдаг

Үнэлгээний хуудасны дүгнэлт: Суралцагч юуг яаж хийхээ мэддэг болсон, хичээлийн явцад өөрт дутагдаж байгаа зүйлийг ойлгож тэдгээрийг засаж сайжруулахад анхаарч суралцах боломжтой болсон гэсэн эерэг хандлага 80-аас дээш хувь илэрсэн. Мөн ярилцлагаар суралцагчидын 85 орчим хувь нь сурах зорилгоо хэр зэрэг биелүүлж байгаагаа үнэлж дүгнэх, эргэцүүлэх, дараагийн улиралд юу хийх вэ, яаж сурах ёстой вэ гэдгээ ойлголоо хэмээн дүгнэж байлаа. Түүгээрч зогсохгүй тулгамдсан асуудлыг олж харах, сургалт хэр зэрэг үр дүнтэй явагдаж байгааг мэдэрч илүү сайн сургалтын үйл ажиллаа зохион байгуулахад анхаарч ажиллахад эцэг эхийн оролцоо нь үнэлгээнд ихээхэн ач холбогдолтой.

6-р ангийн улирлын дүнгийн ахиц амжилт

2017-2018 оны хичээлийн жилийн Англи хэл хичээлийн 6-р ангийн суралцагчдын 1-р улирлын дүн

№	Суралцагчдын нэр	Оогс	Үрж	Биек	Нягт	Тусгай	Эцэглэсэн болон	Үнэлгээ	Шалтгаан	Үнэлгээ
1	Амаржаргал	200	100	100	100	100	100	100	100	100
2	Баянжаргал	200	100	100	100	100	100	100	100	100
3	Нямбат	200	100	100	100	100	100	100	100	100
4	Ганзориг	200	100	100	100	100	100	100	100	100
5	Очира	200	100	100	100	100	100	100	100	100
6	Доржсүрэн	200	100	100	100	100	100	100	100	100
7	Ланъян-Очира	200	100	100	100	100	100	100	100	100
8	Баянжаргал	200	100	100	100	100	100	100	100	100
9	Мянган-Очира	200	100	100	100	100	100	100	100	100
10	Утсан	200	100	100	100	100	100	100	100	100
11	Өндөржаргал	200	100	100	100	100	100	100	100	100
12	Тувшигжаргал	200	100	100	100	100	100	100	100	100
13	Цэцэглэсэн	200	100	100	100	100	100	100	100	100
14	Цэцэглэсэн	200	100	100	100	100	100	100	100	100

Балын дүн: A-0 B-1 C-3 D-2 E-8

AB% - 0,7%
 ABCD% - 48,8%

Суралцагчдад зөвхөн үнэлгээний давуу талыг мэдэж авдаггүй, үнэлгээний давуу талыг мэдэж авдаггүй, үнэлгээний давуу талыг мэдэж авдаггүй...



2017-2018 оны хичээлийн жилийн Англи хэл хичээлийн 6-р ангийн суралцагчдын 2-р улирлын дүн

№	Суралцагчдын нэр	Оогс	Үрж	Биек	Нягт	Тусгай	Эцэглэсэн болон	Үнэлгээ	Шалтгаан	Үнэлгээ
1	Амаржаргал	200	100	100	100	100	100	100	100	100
2	Баянжаргал	200	100	100	100	100	100	100	100	100
3	Нямбат	200	100	100	100	100	100	100	100	100
4	Ганзориг	200	100	100	100	100	100	100	100	100
5	Очира	200	100	100	100	100	100	100	100	100
6	Доржсүрэн	200	100	100	100	100	100	100	100	100
7	Ланъян-Очира	200	100	100	100	100	100	100	100	100
8	Баянжаргал	200	100	100	100	100	100	100	100	100
9	Мянган-Очира	200	100	100	100	100	100	100	100	100
10	Утсан	200	100	100	100	100	100	100	100	100
11	Өндөржаргал	200	100	100	100	100	100	100	100	100
12	Тувшигжаргал	200	100	100	100	100	100	100	100	100
13	Цэцэглэсэн	200	100	100	100	100	100	100	100	100
14	Цэцэглэсэн	200	100	100	100	100	100	100	100	100

Балын дүн: A-0 B-3 C-1 D-2 E-8

AB% - 95,7%
 ABCD% - 5,7%

2-р улирлын давуу талыг мэдэж авдаг, үнэлгээний давуу талыг мэдэж авдаг, үнэлгээний давуу талыг мэдэж авдаг...



Дүгнэлт

Энэхүү туршилт судалгааны үр дүнд үнэлгээг суралцагчдыг үнэлж, дүгнэхэд ашиглаад зогсохгүй сургалтын ололттой хийгээд дутагдалтай талыг нээн илрүүлж, дутагдлыг арилгах арга замыг эрэлхийлэх байдлаар сургалтыг сайжруулахад ч ашиглах боломжтой гэж үзэж байна. Үнэлгээ хийснээр сургалт явагдаж дууслаа гэсэн үг биш бөгөөд сургалтын явцад хийгээд үнэлгээ хийх явцад олж мэдсэн зүйлийг сургалтыг улам сайжруулахын тулд бүтээлчээр ашиглах хэрэгтэй.

- **Багшид гарсан өөрчлөлт** :Үнэлгээ нь сурагч бүрийн сурах үйл ажиллагаа,ахиц амжилтыг дэмжин,хөгжих боломжийг ханган багш сурах бичгийн мэдлэг чадвараар үнэлгээний хуудас боловсруулан арга зүй туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэн судалгаа оношилгоо шинжилгээ хийж өөрийгөө хөгжүүлж байна.
- **Суралцагчдад гарсан өөрчлөлт**:Суралцагч бүр өөрийн мэдлэг чадварын ахицаа хянаж өөртөө зорилготой,хариуцлагатай байж бие даан сурах арга барилд суралцаж багшаар үнэлүүлэх.Багш суралцагчдын харилцаанд эерэг хандлага бий болох.Мэдлэг чадвар ахицынхаа үнэлгээнд сэтгэл хангалуун байх.Өөрийн мэдлэгийн түвшингөө бодитой үнэлэн ахиулуулах арга замыг эрэлхийлэх
- **Эцэг эхчүүдэд гарсан өөрчлөлт**:Хүүхдийнхээ мэдлэг чадварын ахицыг дэмжин туслах.Хичээл заагч багштай байнга холбоотой байж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэх зэрэг эерэг хандалгууд ажиглагдаж байна.

Ийм учраас Боловсролын шинэчлэлийг гардан зохион байгуулагч багш бид хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүйд эрэл хайгуул хийж судалгаа шинжилгээг тогтмол авч дүн шинжилгээ хийн “Нарт ертөнцөд байхгүй нандин сайхан алба”-г нэр төртэй хашиж ирээдүй хойч үеийнхээ сайн сайхны төлөө цаг наргүй хөдөлмөрлөж байх нь багш бидний эрхэм үүрэг гэдгийг ойлгох явдал хамгаас чухал юм.

Цаашид санал болгох зүйл:

1. Нийт багш нарт хүүхэд нэг бүрийг үнэлгээний хуудасны давуу талыг сурталчилж, багш нарын үнэлгээний хандлагад өөрчлөлт оруулж үр дүнтэй бусдад нөлөөлөхүйцээр зохион байгуулах хэрэгтэй.
2. Сурагчдын мэдлэг чадварын түвшинд тохирсон үнэлгээг цөм хөтөлбөрийн чадвараар боловсруулж, сурах сонирхлыг нь сайжруулж, цаашид өөрөө бүтээлчээр эрэл хайгуул хийх, багш эцэг эх, суралцагсдын залгамж холбоог сайжруулах
3. Мөн дээрхи судалгаанд тулгуурлаад дараахи саналыг дэвшүүлж байна. Багш, суралцагчийн харилцан хүлээн зөвшөөрсөн үнэлгээг хийх. Ингэхдээ үнэлгээ хийсний дараа “Ганцаарчилсан зөвлөгөө”-г өгөх байдлаар төлөвлөгөөнд тусгах

Ном зүй

1. Боловсрол судлалын судалгааны арга зүй Н. Оюунцэцэг
2. Үнэлгээний цахим сайтнууд
3. Багшийн хөгжил
4. Амжилттай суралцах арга зам 2012 Б. Батхуяг
5. www.google.com

Туршилтат хичээлийг ээлжит хичээл бүрээр зохион байгуулж, сурагчдаар мэдлэг бүтээлгэх нь

Т.Базаргүр¹

Ж. Алтангэрэл, Б. Мэндсайхан, Н. Дархүү Ж. Алтанхуяг

¹Хөвсгөл аймгийн “Далайван” сургуулийн бага ангийн багш

²Бага ангийн багш, МУГБ

Удиртгал

Хүүхэд бүрийг хөгжүүлнэ л гээд л багш бүр ярьдаг. Тэгвэл залуу багш бид яаж хөгжүүлэх вэ? гэдгээ ээлжит хичээл бүрийн бэлтгэлээр л хангана. “Сонссон хүн мартдаг, харсан хүн санадаг, хийсэн хүн хөгждөг ” гэсэн зарчмын дагуу “ Туршилт хичээл”-ийг зохион байгуулахад туршилтын үйл явцад хүүхэд өөрөө хийж, өөрөө мэдэрч, өөрөө бүтээж байж гэмээн хүүхдийн чадварт ахиц гарна, ур ухаан сууна, хөгжинө. Байгалийн ухааны сургалтын өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэн хэлэхэд дээрх үзэл баримтлал, зарчмыг өнгөц илээд өнгөрөхтэй адил бодит үр дүн харагдахгүй байгаа нь нууц биш. Байгалийн ухааны хичээл бүрээр суралцагчдад **насан туршийн хэрэглээ болох чадваруудыг** эзэмшүүлэх бодит боломжийг судалж, хэрэгжүүлэхэд санаачлагатай, бүтээлч хандлагаар ажиллах шаардлагатай байгааг энэхүү ээлжит хичээлийн арга зүй, туршлагаас харж болно. харж болно.

Нэгдүгээр бүлэг. Онол арга зүйн үндэс, судалгааны загвар
Сэдвийг сонгосон үндэслэл:

- Туршилт /дадлага/ хичээлийн материалыг байнга авчирч мэдлэг чадвар, суралцахуйгаа дэмжих хэрэглэгдэхүүн болгон ашиглаж чадаж байна уу?
- Туршилт хичээлийн материаллаг хэрэглэгдэхүүн, сургууль багшид байна уу? Лаборатори бий юу? Яаж шийдвэрлэх вэ?
- Багшийн төлөвлөлтөд материаллаг хэрэглээг шийдэх талаар хэрхэн тусгагддаг бэ? Асуудлыг шийдэх, сурагчийг хөгжүүлж төлөвшүүлэх бүтээлч арга зүйг хэрэгжүүлж чадаж байна уу? гэдэг нь анхаарал татсан юм.

Байгалийн ухааны хичээлийн үр дүн нь сурагчдын хийж бүтээх үйлээр дамжуулан эзэмшсэн мэдлэг чадварын түвшингээр үнэлэгдэх боловч, хэрхэн үр дүнтэй эзэмших нь хүүхдийн өөрийн хичээл зүтгэл, багшийн дэмжлэгээс гадна гартаа барих материал, хэрэглэгдэхүүнээс ихээхэн шалтгаална. Сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан туршилт хийж мэдлэг бүтээдэг **хүүхдийг** хөгжүүлэхийг зорьж сэдвийг сонгосон болно.



Хичээлийн санаа: Байгалийн ухааны хичээлд шинжлэх ухаанч арга барилын таван алхамчлалыг сорил туршилтаар мэдлэг бүтээх арга зүйтэй уялдуулан төлөвлөж, сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан **орлуулах хэрэглэгдэхүүнийг** сонгон авчтуршсан.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Хичээлийн бэлтгэл-хөтөлбөрийн судалгаа бол зорилгодоо хүрэхийн тулд хийдэг үйл ажиллагаа юм. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ямар үйл хийвэл зохих вэ? гэдгийг багш нар үргэлж бодож, хичээлийн бэлтгэлээ хийхдээ тооцож үздэг байх нь чухал. Ямар хэрэглэгдэхүүн ашиглах, ямар асуултууд асуувал түүндээ хүрэх вэ? Суралцагчид хичээл дээр тухайн ухагдахууныг таниулахын тулд мэдээлэл харилцааны технологийг яаж ашиглах вэ? гэх мэт хичээлийн зорилгод хүрэх, зорилгоо биелүүлэхийн тулд хийдэг багш нарт тулгардаг асуудлуудыг шийдвэрлэх дидактик шийдэлд хүрэх заах арга зүй шийдлүүд нь хичээлийн бэлтгэл судалгааны салшгүй элемент болдог. Иймээс хэрэглэгдэхүүний судалгаанд гол анхаарлаа хандуулж нарыг-чийдэнгээр, салхийг-үсний сэнсээр орлуулах, ариун цэврийн цаас, хямсаа, ажлын хуудас, аюулгүй ажиллагааны дүрэм, багшийн асуулт, чиглүүлэг зэргийг сорил туршилтаар мэдлэг бүтээх арга зүйтэй уялдуулан бэлтгэсэн.

Судалгаат хичээл:

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл:

Хичээлийн үе шат	Багшийн асуулт чиглүүлэг	Сурагчийн үйл ажиллагаа
Таамаглах	Захидал унших	Тэмүүлэнд болсон явдлын тухай кэйсийг анхааралтай сонсох Яаж тэмүүлэнгийн цамцыг хурдан хатаах вэ? Таамаглал дэшүүлэх

<p>Ажиглалт туршилтын алхмуудыг зөв төлөвлөх</p>	<p>Хэрэглэгдэхүүн сонгон авч туршилтын төлөвлөлт боловсруулах алхам хийлгэх</p>	<p>Туршилт хийх төлөвлөгөө</p> <p>Туршилт 1:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нойтон цаасаа ширээн дээр дэлгэнэ. 2. Үсний сэнсээ тогонд залгана. 3. Сэнсээ асаана. Нойтон цаасаа сэнсээр хатаана. 4. Ажиглаад тэмдэглэнэ. 5. Дүгнэлт гаргана. <p>Туршилт 2:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ширээний гэрлээ тогонд залгана. 2. Ширээний гэрлээ асаана. 3. Нойтон цаасаа гэрэл ойртуулан барина. 4. Ажиглаад тэмдэглэнэ. 5. Дүгнэлт гаргана гэх мэт гаргана 																
<p>Туршилтыг зөв гүйцэтгэх, үр дүнгээ тэмдэглэх, мэдээлэл боловсруулах</p>	<p>Төлөвлөгөөний дагуу туршилтаа хийе? / задлан шинжлэх /</p>	<p>Турших үе шат: Багаараа хамтран туршилтаа хийнэ.</p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">   </div> <p>Мэдээлэл боловсруулж, хүүхэд бүр ажлын хуудсан дээр ажигласанаа бичнэ.</p>																
	<p>. Мэдээлэл боловсруулах</p> <p>Ажлын хуудсанд хүүхэд бүр тэмдэглэгээ хийх зааврыг багш өгнө.</p> <p>Багш туршилт хийх явцыг ажиглана. Зөвлөгөө өгнө.</p>	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="824 1041 1092 1224">Нөхцөл</th> <th data-bbox="1092 1041 1187 1224">Эхэлсэн цаг</th> <th data-bbox="1187 1041 1281 1224">Дууссан цаг</th> <th data-bbox="1281 1041 1446 1224">Ус ууршихад зарцуулагдсан хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="824 1224 1092 1341">Цаасан алчуур ямар нөлөөгүй байх нөхцөлд</td> <td data-bbox="1092 1224 1187 1341"></td> <td data-bbox="1187 1224 1281 1341"></td> <td data-bbox="1281 1224 1446 1341"></td> </tr> <tr> <td data-bbox="824 1341 1092 1430">Үсний сэнс ашигласан нөхцөлд</td> <td data-bbox="1092 1341 1187 1430"></td> <td data-bbox="1187 1341 1281 1430"></td> <td data-bbox="1281 1341 1446 1430"></td> </tr> <tr> <td data-bbox="824 1430 1092 1520">Ширээний чийдэн ашигласан нөхцөлд</td> <td data-bbox="1092 1430 1187 1520"></td> <td data-bbox="1187 1430 1281 1520"></td> <td data-bbox="1281 1430 1446 1520"></td> </tr> </tbody> </table>	Нөхцөл	Эхэлсэн цаг	Дууссан цаг	Ус ууршихад зарцуулагдсан хугацаа	Цаасан алчуур ямар нөлөөгүй байх нөхцөлд				Үсний сэнс ашигласан нөхцөлд				Ширээний чийдэн ашигласан нөхцөлд			
Нөхцөл	Эхэлсэн цаг	Дууссан цаг	Ус ууршихад зарцуулагдсан хугацаа															
Цаасан алчуур ямар нөлөөгүй байх нөхцөлд																		
Үсний сэнс ашигласан нөхцөлд																		
Ширээний чийдэн ашигласан нөхцөлд																		
<p>Дүгнэлт</p>	<p>Багаараа ярилцаад дараах асуултанд хариулаарай.</p> <p>Гурав: Бататган нэгтгэн дүгнэх 8 мин</p> <p>Дүгнэлт: / Нэгтгэн дүгнэх/</p> <p>Үсний сэнсээр цаг агаарын ямар нөхцөлийг орлуулсан бэ?.</p>	<p>Дүгнэлт:</p> <p>Үсний сэнсээр цаг агаарын ямар нөхцөлийг орлуулсан бэ?</p> <p>Үсний сэнсээр салхийг орлуулан туршилт хийлээ.</p> <p>Ширээний чийдэнг ямар юутай зүйрлүүлэн ашигласан бэ?.</p>																

<p>Туршилтын үр дүн хувирлын талаар дүгнэлт гаргах, батлах, тайлбарлах</p>	<p>Ширээний чийдэнг ямар юутай зүйрлүүлэн ашигласан бэ? Ууршихад үзэгдэлд цаг агаарын ямар нөхцөлүүд нөлөөлж байна вэ?. Яаж мэдсэн бэ? Нар болон салхи хоёулаа байвал хувцас хэдий хугацаанд хатах вэ?. Та нар Тэмүүлэн найздаа юу гэж зөвлөх вэ?. Хосдоо хэлж өгөөрэй. Хувцас хатахад ус ямар төлвөөс ямар төлөвт шилжиж байгаа вэ?</p>	<p>Нарны гэрэлтэй зүйрлүүлэн ашигласан. Ууршихад үзэгдэлд цаг агаарын ямар нөхцөлүүд нөлөөлж байна вэ?. Яаж мэдсэн бэ? Гэрлийн нөлөөгөөр ус ууршиж хийн төлөвт шилжинэ. Нар болон салхи хоёулаа байвал хувцас хэдий хугацаанд хатах вэ? Нар салхины нөлөөгөөр хувцас хурдан хатна. Та нар Тэмүүлэн найздаа юу гэж зөвлөх вэ?. Нар салхинд хувцас хурдан хатна.</p> <p>Хажуу найздаа хэлж өгнө.</p> <p>Шингэн төлвөөс хийн төлөвт шилжиж байна. Дүгнэлт: Уурших үзэгдэлд нар,салхи нөлөөлдөг.</p>
---	---	--


Шинэ санаа арга зүйн туршлага:

- ✓ Байгалийн ухааны хичээлээр сорил туршилтаар мэдлэг бүтээх арга зүйд суурилан хүүхэд нэг бүрийг шинжлэн судлах арга барилд сургах арга зүйг туршин хэрэгжүүлсэн.
- ✓ Орлуулах хэрэглэгдэхүүн /үсний сэнс, хямсаа, чийдэн гэх мэт/-ийг сурагчдын нас сэтгэхүйн онцлог, аюулгүй ажиллагаанд тохируулан оновчтой сонгосон.
- ✓ Ажлын хуудас ээлжилт хичээлийн хөтөлбөрийн боловсруулан олон дахин туршин сайжруулсан.

Судалгааны үр дүн: **Судалгаа 1.** Дээрх арга зүйгээр хэрэгжүүлсэн багшлахуйн үр дүн

Хичээл 1	Хичээл 2	Хичээл 3
Дунд 68,8%	Хангалттай 78%	Сайн хичээл 85%
5 багшийн дундаж үнэлгээ	6 багшийн дундаж үнэлгээ	4 багшийн дундаж үнэлгээ

Судалгаа 2 Суралцахуйн ойлголтын үр дүн



Багшид:

Давуу тал \Багшид\	Цаашид анхаарах чиглэл: \Багшид\
--------------------	----------------------------------

<ul style="list-style-type: none"> • Хичээлийн бэлтгэл төлөвлөлтийг сайн хийдэг боллоо. • Бүх зүйлийг урьдчилан тооцож бэлтгэн төлөвлөсөн байх учир хичээлийн зорилгыг чанартай хэрэгжүүлнэ • Ангид туршилт зохион байгуулахад хэрэгцээт хэрэглэгдүүний сантай болсон. • Сайн хөтөлбөртэй болсон. • Сайн хичээлийн сантэй болсон. 	<ul style="list-style-type: none"> • Багшид цаг хугацаа их зарцуулагдах учраас чин сэтгэлээсээ хандсан, тэвчээртэй үйл ажиллагаа шаардлагатай. • Баг хамт олноороо хамтарч сургуулийн захиргаанд төсөл бичиж хэрэгжүүлэх • Хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэхэд багш эцэг эхийн дэмжлэг авч байх
--	---

Үр дүн: Сурагчид:

Давуу тал \Сурагчид\	Цаашид анхаарах чиглэл: \Сурагчид\
<ul style="list-style-type: none"> • Туршилтаас мэдлэг бүтээх хүсэл, эрмэлзлэлд нь хандлагын өөрчлөлт гарч байна • Сурагчдын хичээлд оролцох идэвх оролцоо сайжирч тэдний хичээлд хандах сэтгэл ханамж эерэг үзүүлэлтэй байна. • Сурагч өөрийнхөө хүсэл сонирхлыг илэрхийлэх боломжтой болсон • Сурагч хийж сурах чин хүсэлтэй байгаа зүйлээ илүү дуртай хийж, чадваржиж байна. • Эцэг, эхдээ өөрийн юу мэддэг болсон, юу хийж чаддаг болсон гэдгээ тайлагнаж өөрийн чадвараар бахархах болно 	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд бүр өөрийн амьдралд хэрэг болох зүйл сурч байна гэдгээ ойлгож ухамсарлах • Бүх зүйлийг өөрөө гардан хийж байж чадвар, ур ухаанд суралцаж хөгжинө гэдэгт сэтгэл зүрхнээсээ хандах • Өөрийн сурсан мэдсэн зүйлийг бусадтай хуваалцсанаар нь өөрөө илүү хөгжинө гэдгээ ойлгох

Судалгаа ба дүгнэлт / мэдээлэл цуглуулах арга, асуулга, ажиглалтын арга, туршилтын арга ашигласан болно /

Асуулга №1. “ *Туршилт хичээлийн ажлын материаллаг хэрэглэгдэхүүнийг хэрхэн шийддэг вэ?* / баримт материалаас... /

- Бага ангийн кабинетэд туршилт хийх багаж төхөөрөмж байдаггүй
- Багш нар ихэвчлэн өөрсдөө бэлддэг.
- Зарим үед эцэг эхээр бэлдүүлдэг ... гэсэн хариулт өгч байсан.

Судалгаанаас: Эндээс харахад ЕБ-ын улсын сургуулиудын хувьд хуулиндаа үнэ төлбөргүй боловсрол эзэмшүүлнэ гэж заасан хэдий ч хөгжилтэй орнуудын адил хичээл сургалтын бүх хэрэглэгдэхүүнийг улсын төсвөөс хангаж өгч чадахгүй учраас байгалийн ухааны туршилт хичээлийн дадлага ажлын материалыг багш нар бие даан бүтээлчээр оновчтой шийдэх арга зүйг судлан хэрэгжүүлэх нь гарцаагүй юм. Харин үүнийг яаж хэрэгжүүлэх вэ гэсэн асуулт урган гарна.

Судалгааны нэгдсэн дүгнэлт:

Дээрх судалгааг дүгнэвэл бага ангийн багш нар байгалийн ухааны хичээлийн дадлага ажлын материаллаг хэрэглэгдэхүүнийг шийдэх талаар:

1. Судалгаатай алсаас төлөвлөж, туршилт хийх хэрэглэгдэхүүнийг бэлтгэх нь ховор.
2. Ээлжит хичээлийн төлөвлөлтөд ч материалыг хаанаас яаж шийдэх, хүүхдээр юу хийлгэх вэ гэдгийг төлөвлөдөггүй. г.м ...

Иймээс дээрх нөхцөл байдлыг арилгахын тулд багш миний хувьд, туршилт хичээлийн хэрэглэгдэхүүнийг сайн бэлтгэж, сайн бэлтгэлтэй хичээл зааж байж гэмээ нь туршилт хичээлийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж, шавь нараа “ **Туршилтаас мэдлэг бүтээлгэх арга барил**”-д сургах чухал байлаа.

Судалгааны ач холбогдол: Энэхүү судалгааны бичвэр нь байгалийн ухааны хичээлийн туршилт хийх хэрэглэгдэхүүний бэлдэц хамгийн ихээр тулгамдсан асуудал болох дадлага хичээл, туршилт хичээлийн хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр шийдэх боломж нөхцөлийг илрүүлж, хичээл сургалтын үр дүнг сайжруулан ахиц гаргаж, хүүхэд нэг бүрийг бүтээлчээр хөгжүүлэх арга зүйг эзэмших явдал байлаа.

Төлөвлөлт, туршилт :

Судалгаанд үндэслэн сургалтандаа дараах арга зүйг боловсруулан, алхамчлан туршсан болно. Үүнд:

1. Залуу багш миний хувьд 4-р ангийн байгалийн ухааны “Хувцасыг яаж хурдан хатаах вэ?” ээлжит хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, сургууль бүсийн хэмжээнд 3 удаа зааж сайжруулсан хөтөлбөрөө “**Сайн хөтөлбөр**”, заасан хичээлээрээ “**Сайн хичээл**”-ийн сан бүрдүүлэх зорилготой.
/Хөтөлбөр -Хавсралт-1 /

Дүгнэлт: Багш хүүхдийг шинжлэн судлах арга барилд сурган, асуулт асуух, таамаглал дэвшүүлэх, үйл ажиллагаагаа төлөвлөх, төлөвлөсний дагуу хийж гүйцэтгэх, мэдээлэл боловсруулах, дүгнэлт гаргах чадварыг олгосноор сэргээн санах, хэрэглэх,ойлгох, задлан шинжлэх, үнэлэх түмшний асуултыг зохиож чаддаг болохоос гадна, таамаглалаа батлан, туршилтын алхмуудыг төлөвлөн,туршилт хийхэд шаардлагатай багаж хэрэгслүүдийг зөв сонгож, ажиглалт туршилт, хэмжилтүүдийн үр дүнг ажлын хуудсанд тэмдэглэн боловсруулалт хийн, туршилтын үр дүндээ дүгнэлт гаргах тусгай чадваруудыг эзэмшүүлэх нь “**ТУРШИЛТААС МЭДЛЭГ БҮТЭЭХ**” арга зүйг хэрэгжүүлэх нь оновтой алхам юм.

Ном зүй

1. Бага боловсролын сургалтын хөтөлбөр
2. Байгалийн ухааны 4-р ангийн сурах бичиг
3. Багшийн ном

“ Хавчаараар наадъя “ арга зүй

Х. Кунзила, kunzila2888@gmail.com

Ц. Долгормаа dogo_0831@yahoo.com

Б. Наранхүү borisnarankhuu_0527@yahoo.com

Орхон, Баян-Өндөр, 4 дүгээр цэцэрлэг

Удиртгал

Цэцэрлэгийн орчинд хүүхдийн сурах сонирхолыг татаж, идэвхжүүлэхийн тулд сургалтын идэвхтэй аргатай хослуулан сургалтын хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгон хэрэглэх нь зүйтэй .

Бага насны хүүхэд бол төрөлхийн сониуч зантай байдаг. Тэд эд зүйлийг юу гэж нэрлэдэг, хэрхэн яаж ажилладаг, яагаад ийм зүйл тохиолдов, яагаад өөрчлөгдөв гэх мэтчилэн байнгын орчноо сонирхон ажиглаж бодож байдаг. Асууж сонирхох, судлаж турших нь тэдний суралцах үйлийн гол зэвсэг нь болдог.Насанд хүрэгчид нь тодорхой агуулга, ухагдахууныг хүүхдэд ойлгуулахын тулд боломж бүрийг идэвхтэй хайж, тэдний суралцах үеийг ухаалгаар удирдан чиглүүлж чадвал хүүхдийн насан туршдаа идэвхтэй суралцагч байх чадварыг хөгжүүлж чадна.

Зөв дадал нь зөв үйлд хүргэдэг . Ийнхүү бага насны хүүхдийн сургалт нь хүүхэд өөрөө талбар байх олон удаагийн дадал хэвшил давтамжын явцад хүүхэд суралцдаг.

Хавчаар нь :

- Ашиглахад хялбар
- Олдоц сайтай
- Хүүхэд өөрөө өөртөө үйлчилдэг
- Хүүхэд үйлийн эзэн байж ,
- Гарын жижиг булчин хөгжих, бүтээлч сэтгэлээ хөгжих боломж бүрдэнэ.
- Хамтач , нийтэч,
- Бүтээлч

- Цогц чадвар олгоно.

Сэдэв сонгосон үндэслэл

2015 –онд Усаар наадъя хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж байх явцад хүүхэд хавчаарыг атгаж шагай , шүр хавчиж чадахгүй байсан үүнээс үүдэн хавчаараар хүүхэд хөгжүүлж болох юм гэсэн санаа төрсөн.

Арга зүйг хэрэгжүүлэх үе шат

Төлөвлөх бэлтгэл үе :

- Багш хүүхдийн хэргэцээ шаардлагад тулгуурлан зорилгоо дэвшүүлэх , боловсруулах
- Төрөл бүрийн хэлбэр хэмжээтэй хавчаар цуглуулах
- Туслах материалууд бэлтгэх
- Хавчаарийг сургалтанд ашиглаж аргачлалыг суралцахуйн чиглэл, бүлэг бүрд тохируулан боловсруулах

Ажиглалт ярилцлага :

- Хүүхдийн бүтээлч үйл хэрэглэгдэхүүнтэй харьцаж буй байдлыг ажиглах , дүгнэх
- Хавчаарын өнгө хэлбэр хэмжээ, зориулалтын талаар ярилцах
- Хавчаараар юу бүтээж болох талаар өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх

Бүтээх үйл явц :

- Хавчаар ашиглан боловсруулсан аргачлалын дагуу болон , хүүхэд өөрийн санаачлагаараа
- Бүтээх, чимэглэх, урлах
- Сургалтыг дэмжсэн үйл ажиллагаанд оруулах, хэрэглэх, тоглох

Үр дүн, дүгнэлт :

- Хүүхэд үйлийн эзэн байж, бүтээлчээр сэтгэх чадвар нь хөгжин, бие даах чадвар нь сайжирна .

Хавчаарын онцлог

- Хүүхдийн оролцоог дэмжсэн , хэрэглэгдэхүүнийг хялбар аргаар боловсруулан хөгжүүлэх үйл ажиллагаандаа тасралтгүй ашиглах боломжтой
- Хүүхэд хавчаарыг гараараа барьж элдэв үйл хийхэд гарын жижиг булчин хөгжинө
- Хүүхдийн тоолох , сэтгэн бодох , анхаарх чадвар сайжирна
- Хүүхэд юмсыг багцалж сурна
- Өөрөө өөртөө үйлчлэх энгийн чадвар сууна
- Хүүхдийг амьдрах арга барилд сургаж, биеийн болон гар хурууны хөдөлгөөний чадвар , дадал эзэмшиж байна
- Хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэн оюуныг задлан хөгжүүлнэ
- Хүүхэд мэдлэг бүтээж , бүтээлч чадварыг хөгжүүлнэ

Агуулгын хүрээ

Суралцахуйн чиглэл	Агуулга
Хөдөлгөөн эрүүл мэнд	Гар хурууны хөдөлгөөнийг сайжруулах бие дааж аливааг хийхийг эрхэмлэх
Зан харилцаа	Хамтарч тоглох, бусадтай харилцах , бусдыг хүндлэх, ээлж дарааллаа хүлээх
Математик	Тоолох , өрөх эвлүүлэх , харьцуулах, бүтээх, өнгө хэлбэр хэмжээгээр ялгах, сэтгэн бодох, анхаарах чадвар сайжруулах
Бнот	Орчноо ажиглах Орчин тойрныхоо эд зүйлсийг бүтээх
Хэл яриа	Өөрийн санаа бодлоо илэрхийлэх хүүхэд мэдлэг бүтээж , бүтээлчээр сэтгэх
Хөгжим	Дуу чимээ , авиаг ялгах , хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийх
Дүрслэх урлаг	Олон аргаар төрлөөр зурж барьж зохион бүтээх эвлүүлэх

Хавчаарыг үйл ажиллагаанд ашигласанаар гарсан ахиц дэвшил

Багшид	Хүүхдэд	Эцэг эхэд
➤ Багш үйл ажиллагаандаа оруулж өгсөн	<ul style="list-style-type: none"> ➤ Хүүхдийн сонголтыг дэмжсэн ➤ Өөрийн дуртай чөлөөтэй орчинд ажиллах ➤ Өнгөний сонголт хэрэглээнд ахиц гарсан 	➤ Хавчаарийг цуглуулж өгсөн

<ul style="list-style-type: none"> ➤ Хүүхдээ илүү таньж мэдэх судлах ➤ Хүүхдээ олон талаас нь судлах боломж бүрдсэн ➤ Эрэл хайлт хисэн ➤ Арга зүйгээ тодорхойлсон ➤ Арга зүйгээ боловсронгуй болгох аргачлал боловсруулах ➤ Хүүхдүүдтэй бүтээлчээр эрэл хайгуул хийсэн 	<ul style="list-style-type: none"> ➤ Өөртөө итгэлтэй болсон ➤ Хүүхэд олон хувилбараар орчны юмсыг бүтээсэн ➤ Хүүхэд хүүхдээсээ суралцсан ➤ Хүүхдийн сэтгэх чадварын хурд нэмэгдэж , гарын жижиг булчингийн хөгжлийг дэмжсэн ➤ Багаар ажиллах ➤ Өөрийнхөө санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж сурсан ➤ Бүтээлчээр болон хийсвэрээр сэтгэж дүрсэлж эхэлсэн ➤ Тоолох чадвар сайжирсан 	<ul style="list-style-type: none"> ➤ Багшийн үйл ажиллагааг дэмжихийг эрмэлздэг болсон ➤ Хүүхдийнхээ ахицад сэтгэл хангалуун байгаа
--	--	---

Түгээн дэлгэрүүлсэн байдал

№	Хэзээ	Сэдэв	Сур\ чиглэл	Хаана хэнд
1.	2016. 04.14	“ Усаар наадъя “ Шүр,бөглөө , шагай , хавчаар ашигласан	Хөдөлгөөн эрүүл мэнд	Цэцэрлэгтээ Дунд бүлэгт - 34 хүүхэд -12 багш
2.	2016. 04.20	Усаар наадъя Шүр,бөглөө , шагай ,цайны шүүлтүүр хавчаар ашигласан	Байгаль нийгмийн орчин	Аймаг Дунд бүлэгт 34 хүүхэд
3.	2016 10.26	“ Би чадна “ Шүр,бөглөө , шагай ,цайны шүүлтүүр, хавчаар	Математик	Багш солилцоогоор 22-р цэцэрлэгт Ахлах бүлэгт -25 хүүхэд -8 багш
4.	2017 01.27	“ Хавчаараар наадъя” Шүр хавчаар ашиглаж дүрстэй танилцуулах	Математик	УБ хотын төмөр замын багш нарт Ахлах бүлэгт 34 - Хүүхэд -10 багш
5.	2017 04-05	Хавчаар арга зүй	Бүх чиглэлээр Үзэсгэлэн	Архангай , Хөвсгөлийн багш нарт Давхардсан тоогоор 20
6.	2017 09-15	Хавчаар арга зүйг танилцуулж сурталчлав	Үзэсгэлэн бүх чиглэлээр	Булган аймгийн багш нарт 13 багшид
7.	2017, 11.20	Хавчаарыг ухаалаг хэрэглээ болгон ашигласан нь	Илтгэл бичсэн	Мэргэжил нэгт багш нартаа Цэцэрлэгийнхээ-14 22-р цэцэрлэгийн 6-багш
8.	2017 12-с	Хавчаар арга зүйгээрээ Мониторинг хийлгэсэн зөвлөгөө авсан	БМДИ-ийн зөвлөх “ бүүвэй бага нас “ ТББ-ын гүйцэтгэх захирал Н. Норжхорлоо БАГШ \ phd\ БСШУСЯ-ны дэргэдэх боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн З. Мөнхтуул багш	
9.	2018 11- с	Хавчаар арга зүйн технологи	Багшийн хөгжил сайтад тавьсан	
10.	2018 4- с	Шилдэг арга зүй шалгаруулах аймгийн уралдаанд тэргүүлсэн	Сайн арга зүйн илтгэлээр шалгарсан	
11.	2018 4- с	Хавчаараар наадъя арга зүйн илтгэл	Бүүвэй .mn сайтад тавьж түгээн дэлгэрүүлсэн	

Хавчаарыг сургалтын чиглэл бүрээр ашиглах нь

Хэл яриа:

Сургалтын агуулга нь

- Хийж бүтээж буй зүйлээ тайлбарлан ярих, тоочиж нэрлэх,
- Өөрийнхөө санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх
- Хийсэн зүйлээрээ бахархах сэтгэл хөдлөлөө илэрхийлэх
- Бусадтай харилцах

Хэрэглээ болгосон нь:

- Хэл ярианы чадварт ахиц гарсан, дуу шүлгийг амархан цээжилдэг
- Харилцан яриа хөгжиж найзынхаа үгийг сонсох, өөрийгөө илэрхийлэх , бусадтай санаа бодлоо солилцдог боллоо
- Хийсэн эд зүйлээрээ жүжиглэх чадвар сайжирсан



Математик

Сургалтын агуулга нь

- Тоолох , бодох, төсөөлөн сэтгэх чадвар
- Харьцуулах
- Орон зайн байрлал
- Өнгө хэлбэр хэмжээг ялгах

Хэрэглэгдэхүүн:

- Тараах материал, олон хувилбараар төрөл бүрийн хавчаар

Хэрэглээ болгосон нь:

- Математикийн энгийн чадвар дадлуудыг маш сонирхолтой олж авч чадаж байсан
- Цифрээ нүдлэх, тохирох тоотой холбох, харьцуулах
- Энгийн бодлого бодох хариуг хавчаараар хавчих
- Тоолох чадвар сайжирсан
- Багцалж сурсан



Дүрслэх урлаг

Сургалтын агуулга нь

- Хавчаараар дуртай зүйлээ бүтээх
- Үзэж харсанаа бүтээлээрээ илэрхийлэх

Хэрэглэгдэхүүн нь

- Хавчаар цавуу өнгийн цаас , усан будаг
- Баримал, гуашь

Хэрэглээ болгосон нь

- Орчины бодит байдлыг харж ашиглаж сурсан
- Өнгөний мэдрэмж хөгжисөн



- Гоо сайхны мэдрэмж сайжирсан
 - Өөрийн хийсэн зүйлийг эргүүлж ашиглах
 - Зохиомжлон зурах , дүрслэх чадвар сайжирсан
 - Дардас болгон ашигласан
 - Ширээний үзүүлэнгээ өөрсдөө бүтээж чаддаг болсон
 - Хавчаарыг чөлөөтэй будаж хувиргаж тоглодог болсон
 - Өөрийн дуртай зүйлийг урлаж бүтээдэг болсон
- Үүнд: онгоц, машин, цэцэг, цасан өвгөн, эрвээхэй, анааш, тэмээ, хүүхэд



Хөдөлгөөн эрүүл мэнд

Сургалтын агуулга нь

- Гарын жижиг булчин хөгжих
- Өөрөө өөртөө үйлчлэх
- Дадал хэвшил эзэмших

Хэрэглэгдэхүүн:

- Хавчаар , өдөр тутмын үйл ажиллагаа

Хэрэглээ болгосон нь:

- Хавчаарыг чөлөөтэй хавчиж сурсан
- Төмөр хавчаарт уясан олсыг ашиглаж гурваар жигд сүлжиж сурсан
- Идэх боов, печень, боорцог зэргийг хавчиж авч өгөх , тавганд тавих
- Өөрөө сонгож хэрэглэж сурлаа



Байгаль нийгмийн орчин

Хүүхдийн сонирхол , сонголт хийх хэрэгцээнд дээр тулгуурлан хавчаарын төрлийг олруулж ирлээ. Одоогоор хавчаар нь олон янзын өнгөтэй , том жижиг, модон, төмөр, певорь, бичгийн, буузны , үсний гэх мэт төрөл , тоо ширхэгийг олон болгож саванд хийснээр хүүхэд өөрөө хүссэн үедээ авч хэрэглэж хэвшлээ.

Хүүхдийн сонголтыг эрхэмлэсэнээр үйл ажиллагааны явцад бие даан суралцах үйл хөгжиж, сэтгэж бодох , бүтээлчээр сэтгэх, найз нөхөдтэйгөө уралдах, зөвлөн туслах, дагуулж хийх чадвар сайжирч ахиц гарлаа

Судалгаа № 1

Хэрэглээ ашиглалтын судалгаа

2015--2018 оны хичээлийн жилд

Судалгааны зорилго:

- Хавчаарын олон төрлийг сургалт үйл ажиллагаанд ашиглаж чадаж байгаа байдлыг судлах

Судалгааны объект:

4-р цэцэрлэгийн бага бүлгийн 34 хүүхэд

Судалгааны арга :


- Ажиглалт
- Туршилт

Бага бүлэг



Дунд бүлэг

Ахлах бэлтгэл бүлэг



Судалгааны дүгнэлт :

Судалгаанаас харахад модон хавчаар нь бага , дунд бүлэгт хүндрэлтэй буюу хатуу, ам нь ангайдаггүй , атгаж хавчиж чаддаггүй юм байна . Харин ахлах, бэлтгэлийн хүүхдүүдийн гарын жижиг булчин нь бага бүлгээ бодвол илүү хөгжсөн , хавчаарыг нээж ангайлгаж атгаж чаддаг болсон байдаг учраас баяжуулан бүтээлчээр хэрэглэхэд дөхөмтэй байна.

Үүнээс үүдэн том хавчаар нь

- Бага бүлэгт--- певерь хавчаар , том буузны хавчаар
- Дунд бүлэгт --- певерь хавчаар , том буузны хавчаар

- Ахлах, бэлтгэл бүлэгт --- бүх төрлийн хавчаарыг ашиглахад тохиромжтой байна.

Цацраг дунд бүлгийн хүүхдүүдээс авсан “Хавчаараар наадъя” байдлыг ажиглан тогтоох судалгаа

Судалгааны зорилго :

Хүүхэд хавчаараар тоглож бүтээл хийх, дур сонирхол, бүтээлдээ хандах хандлага , анхаарлаа төвлөрүүлэх ,хавчаарыг, хавчих чадварыг ажиглан дүгнэх

- Хавчаарыг зохиомжлон хэлхэж эд зүйлс бүтээх

Судалгааны арга:

- Ажиглалт
- Харьцуулалтын арга

Судалгааны объект:


- 4-р цэцэрлэг 8-р дунд бүлгийн 34 хүүхэд .

Судалгаа № 1

2015-10сард



Дунд бүлэг эхэнд Хүүхдүүд хавчаарыг маш их сонирхож оролдож үзэж байсан боловч анхаарал нь амархан саринаж овоо юм хийж байснаа өөр зүйлрүү орхиод явж байсан. Мөн хавчих гэж их хичээж байсан боловч эвээ олохгүй хоёр гараараа барьж хавчих , хүч нь хүрэхгүй байх, бусдыг даган дуурайж хийх , хийсэн зүйлээ тайлбарлахдаа бусдыг дуурайж хэлэх, хавчаарыг өмчилж хумиж булаацалдах гэж оролдож байгаа нь ажиглагдаж байв.



Дунд бүлэг 2016 оны 4 сар

Ахисан байдлыг тогтоох судалгаа

Дүгнэлт :

Хүүхдүүд хавчаараар тоглож маш их сонирхдог болж анхаарал нь төвлөрч аливаа зүйлийг зохиомжлон хийх , элдэв зүйлийг төвөггүй хавчиж зөөж сурсан нь харагдаж байлаа Өөрсдөө хавчаараар тоглох

явцдаа хамтарч тоглох саанаа бодлоо илэрхийлэх , бие биетэйгээ зөвшилцөх, туслах ,өөрийн хийч бүтээсэн зүйлийг багшдаа болон найз нөхөддөө үзүүлэхийг эрмэлздэг боллоо

Мөн тоглох явцадаа

- Малгайн чимэг хийх
- Титэм зүүх
- Хамтаараа том цагираг хийх
- Элдэв дүрс бүтээх
- Үлгэрийн баатрууд болох спайдермэн шагай хавчиж тоолж хийх гэх мэт олон санааг гаргаж байв.



Судалгаа №2

Бүтээлч үйлийн судалгаа

2014-2015 оны хичээлийн жил

Судалгааны зорилго :


- Өгөгдсөн зураг хараад дуурайлган хийж чадаж байгаа байдлыг судлах

Судалгааны объект :

- 4-р цэцэрлэгийн бага бүлгийн 30 хүүхэд

Судалгааны арга :

- Ажиглалтын арга
- Туршилтын арга
- Биечлэн үзүүлэх арга



Дүгнэлт:

Бага бүлгийн хүүхдүүд даалгавар гүйцэтгэхдээ эв ээ олохгүй , цаасаа онож хавчихгүй , өөр зүйл хавчих , хаяж явах тохиолдол гарч байв. Олон дахин давтаж хийсний үр дүнд хавчаарыг чөлөөтэй хавчиж сурсан . Өнгийн дагуу хавчдаг болсон.

Бүтээлч үйлийн судалгаа

2015 - 2016 оны хичээлийн жил

Судалгааны зорилго :


- Зургийн дутуу хэсгийг гүйцээж хавчаараар хавчих

Судалгааны объект :

- 4-р цэцэрлэгийн дунд бүлгийн 34 хүүхэд

Судалгааны арга :

- Ажиглалтын арга
- Туршилтын арга
- Биечлэн үзүүлэх арга



Дүгнэлт:

Бага бүлэгт олж авсан чадвар дээр тулгуурлан дүрс, зургийг баяжуулан бүтээх даалгавар өгөхөд эхлээд хавчих, даалгавар ойлгохгүй байх нь ажиглагдаж байв. Жилийн эцэст дээрхи даалгаварыг дахин өгөхөд гурвалжин дүрсийг гацуур, дугуй дүрсийг нар, хүн амьтадын хөл, чих, сүүд, гар гэх мэт нэмэлт зүйлүүдийг хийж сурлаа.

Бүтээлч үйлийн судалгаа

2016 - 2017 оны хичээлийн жил

Судалгааны зорилго :

- Хавчаараар өөртөө хувцас гоёл чимэглэл зохион бүтээх

Судалгааны объект :


- 4-р цэцэрлэгийн ахлах бүлгийн 40 хүүхэд

Судалгааны арга :

- Ажиглалтын арга
- Туршилтын арга

Дүгнэлт:

Хүүхдүүд эхэндээ бие биенээ дуурайж 1-2 бүтээлийг урлаж байсан бол, жилийн эцсийн судалгаанд хийж байгаа бүтээлдээ тохируулж хавчаарыг сонгож, өөр эд зүйлстэй зохицуулан цогц хэлбэрээр бүтээлчээр урлаж байлаа.



Бүтээлч үйлийн судалгаа

2017 - 2018 оны хичээлийн жил

Судалгааны зорилго :

- Сэдвийн хүрээнд хавчаар ашиглан бүтээл хийх

Судалгааны объект :


- 4-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхэд

Судалгааны арга :

- Ажиглалтын арга
- Туршилтын арга

Дүгнэлт:

Бэлтгэл бүлэгт хавчаартай хослуулан тодорхой сэдвийн хүрээнд урлан бүтээх олон төрлийг ашиглан, бүтээл хийлгэхэд хавчаарыг будаж машины эд анги, сагс, барималаар онгоц орчинтой бүтээл хийж байгаа нь харагдлаа.



Ерөнхий дүгнэлт

Мэдлэг мэдээллийн эрин зуунд хүүхдийг сонирхлоор нь чаддаг зүйлээр нь хөгжүүлсэнээр хүүхэд сургууль цэцэрлэгтээ дуртай болно. Хүүхэд бүр адилхан биш. Өссөн орчин, сонирхож байгаа зүйл нь ялгаатай байдаг үүнээс үүдээд манай боловсролын салбар хүүхэд бүрээ хөгжүүлж гэсэн зорилго тавьсан. Хүүхэд бүрийг хөгжүүлдэг арга технологи багш нарт байх ёстой. 2014–2018 оны хичээлийн жилд

“Хавчаараар наадацгаая” арга зүйг боловсруулан туршиж хэрэгжүүлсэнээр :

- Хүүхэд нэг бүрийн идэвхи нэмэгдсэн
- Даалгавар хийх сонирхлыг дээшлүүлж байсан
- Үзэг харандаагаа барихад ядрахгүй бичих дадал эзэмшсэн
- Цэвэр нямбай будах, урлан бүтээх, баяжуулан зурах сэтгэн бодох, бүтээлч үйл хөгжиж бие хүн төлөвших хамтарч наадаж сурсан, эелдэг харилцааны суурь тавигдсан
- Би чадна, би мэднэ, би хийнэ гэсэн хүсэл эрмэлзлэлтэй болсоноор цаашид хөгжих үндэс нь бий болсон

Дэвшүүлэх санаа

- Хүүхэд нэг бүрийг судалж оношилдог байх
- Төрөлх чадвар дээр нь тулгуурлан хөгжүүлж сул талыг нь аажим аажимаар багасгах
- Хүүхэд нэг бүрийнхээ чадварт нь тулгуурлан хэрэглэгдэхүүнээ бэлтгэх
- Хэрэглэгдэхүүн хийх боломж байгаа учраас хүүхэд, багш, эцэг эх, олон нийтийн оролцоог дээшлүүлэх
- Хүүхэд бүрд би сурч чадна гэсэн итгэлийг өгөх
- “Хавчаараар наадацгаая” арга зүйгээ түгээн дэлгэрүүлэх, бусад багш нартайгаа хамтран ажиллах

Ном зүй

- [1] Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил-үйл ажиллагааны онцлог УБ 2012 он
- [2] Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт УБ.,2010
- [3] Бага насны хүүхдийг гэр бүлд хөгжүүлэх нь УБ.2002
- [4] Сургуулийн өмнөх боловсрол – эцэг эх олон нийтийн оролцоо УБ.,2008
- [5] “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй -2014” УБ.,2015
- [6] Хүүхэд бүрийн хөгжил туршлага амжилт” үр дүн БСШУЯ 2016 УБ
- [7] Н.Ариунцэцэг “Яагаад” Хүүхэд-1 УБ 2009
<http://www.assa.mn>
News.gogo.mn
www.davlagaa.mn

Мэдээллийн технологийн хичээлээр ухаалаг хэрэглээг дэмжих аргазүй, шийдэл

Э. Оюунболор

Хэнтий аймгийн Биндэр сумын ЕБС-ийн Мэдээллийн технологийн багш, Ombo0314@gmail.com

Удиртгал

“Нийгмийг хүн өөрчилдөг-Хүнийг боловсрол өөрчилдөг”. Иймээс эрдэс баялгийн хязгаарлагдмал нөөцөд тулгуурласан хөгжлийн загвараасаа хүний оюуны хязгааргүй нөөцөд түшиглэн дэвших нь шинэ зууны зөв зам гэж үзэж болох юм. Тиймдээ ч Юнескогоос 2007 онд дэвшүүлсэн “XXI зууны боловсролын эрхэм зорилго нь хүний хөгжилд чиглэсэн байх явдал юм” хэмээн үзэж, хүний хөгжлийн үндсэн үзүүлэлт болох эрүүл энх байж урт удаан наслах, ажил хийх, хангалуун сайхан амьдрах, хүрээлэн байгаа орчин, нийгэмдээ зохицон амьдрах зэргийг томъёолсон байдаг.[2] Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулан 2015-2016 оны хичээлийн жилээс орон даяар мөрдөж байна. Сурагч бүрийг сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн болгон төлөвшүүлэх боломж олгоход чиглэсэн суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байна.

Хүүхэд амьдралын туршлага болон сургалтын явцад олж авсан мэдлэг, чадвараа тулгарч буй асуудалд ухаалгаар хэрэглэн шийдвэрлэж чадаж байвал дээрх шалгуурт нийцсэн амьдрах ухаантай иргэн бэлтгэгдэж буй явдал юм.



Зураг 1. Боловсролын салбарын шинэчлэлийн онцлог

Түлхүүр үг: Хэрэгцээ, амьдрах ухаан, сурагч, сургалт, бүтээлч, бодит байдал

Судалгааны арга зүй

Суралцагчдын ухаалаг хэрэглээнд хандах үзлийг тодорхойлох зорилгоор нээлттэй асуулгын аргаар судалгаа авч дүн шинжилгээ хийн, үр дүнд тулгуурлан ухаалаг хэрэглээг бий болгох арга зүйг эрэлхийлсэн шийдэл бүхий зорилтот үйл ажиллагааг судалгаанд хамрагдсан суралцагчдын дунд өрнүүлж туршин ахиц өөрчлөлтийг Лайкертын шкалаар хэмжээсжүүлэн дүгнэлт хийв.

Сэдвийг сонгосон үндэслэл:

Даяаршил, шинжлэх ухаан, технологийн дэвшлийн эрин үе нь нээлттэй, өрсөлдөөнтэй, мэдээлэлжсэн орчинд амьдрах чадварыг хүн бүрээс шаардаж байгаагаас дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинэ зуунд хүн төрөлхтний нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оролцох мэдлэг чадвартай, бүтээлч, хариуцлагатай, насан туршдаа суралцах арга барилтай иргэн төлөвшүүлэхэд чиглүүлж байна. Хүүхдэд хөгжиж төлөвших боломж олгох, уламжлал, шинэчлэл хосолсон, хүүхэд төвтэй соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийгмийн бүхий л бүлэгт зориулан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өдгөө өсвөр насны сурагчид цахим орчинг шүтэх, цахим орчинд хэт автах хандлага ихсэж, тэдний ухаалаг хэрэглээний талаарх ойлголт, үзэл бодол харилцан адилгүй байна. Иймд сурагчдад ухаалаг хэрэглээ, зөв хандлага, үйл ажиллагааг хэвшүүлэх арга зүйг судлах шаардлагатай гэж үзлээ.

Сонгосон судлагдахуун: Мэдээллийн технологи

Судалгааны зорилго

Суралцагчдын ухаалаг хэрэглээний талаарх ойлголтыг илрүүлж, ухаалаг хэрэглээг бий болгох арга зүйг төлөвлөн туршиж, үр дүнд шинжилгээ хийн, дүгнэлт гаргана.

Судалгааны зорилт

- Ухаалаг хэрэглээнд хандах хандлагын талаар судалж, бодит байдлыг тодорхойлох;
- Бодит байдалд анализ хийн шийдвэрлэх ёстой арга замыг эрэлхийлэх;
- Судалгаанд тулгуурлан зөв хандлагаар өөрчилж болох зүйлсийн талаар зөвлөгөө, хэлэлцүүлгийг зохион байгуулах;
- Хүүхдийг ухаалаг хэрэглээтэй, амьдрах ухаантай иргэн болж төлөвших хандлагад хөтлөх ямар боломж байгааг судлан дүгнэлт хийх;
- Тодорхой арга зүй боловсруулж, турших;
- Үр дүнд тулгуурлан, дүгнэлт гаргах, цаашдын санааг дэвшүүлэх.

Дэвшүүлж буй асуудал

- Мэдээллийн технологи нь сургалтыг дэмжих хэрэгсэл болохоос ухаалаг хэрэглээг бий болгож буй зүйл биш.
- Сургалтаар олж авсан мэдлэг, чадвараараа өөрийн хэрэгцээг ханган, амьдрал ахуйдаа зөв хэрэглэж насан туршийн ухаалаг хэрэглээ болгох.
- Ухаалаг хэрэглээг бий болгоход нээлттэй эрэл хайлт хийн амьдрал, бодит байдалд суурилсан сургалтын арга зүйг хичээлд хэрэглэх шаардлагатай байна.

Таамаглал

Өсвөр насныханд ухаалаг хэрэглээний талаарх ойлголт цахим орчиноор хязгаарлагдаж байна.

Ухаалаг хэрэглээний ач холбогдлыг ухуулан таниулж чадвал суралцагчдад төдийгүй сургуулийн орчинд эерэг өөрчлөлт гарна.

Хамрах хүрээ

- Хэнтий аймгийн Биндэр сумын сургуулийн 9-12-р ангийн 50 сурагч
 - Улаанбаатар хотын Улсын тэргүүний 84-р сургуулийн 9-12-р ангийн 50 сурагч
 - Хэнтий аймгийн Чингис хотын ЕБСургуулийн 9-12-р ангийн 50 сурагч
- Нийт 150 сурагчдыг хамрууллаа.

Хугацаа: 2017.04.10-2018.09.25

Онолын хэсэг

Хэрэгцээний талаар ойлголт:

Хэрэгцээ гэж юу вэ?: Хүн, физиологи болон сэтгэл зүйн хувьд ямар нэгэн зүйлээр дутагдаж гачигдаж байдаг. Үүнийг хэрэгцээ гэнэ. Хэрэгцээ хүнийг тодорхой зорилготой үйлдэл хийхэд хүргэдэг. Үр дүнд нь хүн өөрийн болон бусдын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангана. 5 түвшин бүхий А.Маслоугийн пирамидад хэрэгцээний түвшинг:

1. Физиологийн хэрэгцээ
2. Аюулгүй байдлын хэрэгцээ
3. Нийгмийн хэрэгцээ
4. Өөрийгөө хүндлэх хэрэгцээ
5. Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ гэж авч үзсэн байдаг [15].

Эхний түвшний хэрэгцээ болох физиологийн хэрэгцээ бүх хүнд нэгэн адил төрөнгүүт бий болно. Энэ хэрэгцээний 85-аас багагүй хувийг хангаж байж аюулгүй байдлын хэрэгцээ үүснэ. Харин аюулгүй байдлын түвшинд хэрэгцээнийх нь 70% нь хангагдаж байж нийгмийн хэрэгцээ бий болно. Нийгмийн хэрэгцээ нь өөрийгөө хүндлэх хэрэгцээ үүссэн хүний 70%-ийг хангаж байх ёстой. Өөрийгөө хүндлэх хэрэгцээгээ хангасан бие хүний 60% нь өөрийгөө илэрхийлэх хэрэгцээгээ тэмүүлж эхэлнэ. Соёлын буюу дээд түвшиний хэрэгцээг хангахад нэлээд хэцүү. Энэ түвшиний хэрэгцээ 40%-д хүрвэл хүн өөрийнхөө аз жаргалтайг мэдэрдэг. Хамгийн сонирхолтой нь, дэлхийн хүн амын ердөө 1-4% л энэ түвшинд хүрдэг.

1. Хэрэглээний талаар ойлголт

Ухаалаг гэдэг үгийг монгол хэлний тайлбар толь бичгээс үзвэл ухаан сайтай, сэргэлэн, авьяастай, авхаалж самбаатай хэмээн тайлбар хийсэн байна.

Хэрэглээ гэдэг үгийг монгол хэлний тайлбар толь бичгээс үзвэл хүний өдөр тутмын амжиргааны зүйл хэмээн тайлбар хийсэн байна.

- Хүнд олон төрлийн эрэлт, хэрэгцээ, сонирхол бий.
- Эдгээр хэрэгцээ, сонирхлыг хангахын тулд хүн өөртөө тодорхой зорилго тавина.
- Зорилгоо ухамсартайгаар биелүүлэхийн төлөө хичээл зүтгэл гаргана. Хичээл зүтгэлийг хүний идэвхт чанар гэнэ.
- “Эрэлт, хэрэгцээ” – “зорилго” – “идэвхт чанар” гурвыг нэгтгэвэл хүний үйл ажиллагаа болно. Үйл ажиллагаа нь зорилго чиглэлтэй, үр дүнд нь тодорхой байхад оршино.
- Хэрэгцээгээ ханган эерэг үр дүнд хүрэхийн тулд үйл ажиллагаагаа ухаалгаар төлөвлөн ашиглахыг **УХААЛАГ ХЭРЭГЛЭЭ** гэж үзэж байна.

Ухаалаг хэрэглээг олон чиглэлээр бий болгож болно. Жишээ нь:

1. Өөрийгөө болон гэр бүл, найз нөхдөө хайрлан, хамгаалах
2. Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах
3. Бага зардлаар өндөр ашиг шимийг олох
4. Бага хугацаанд илүү ихийг хийж бүтээх
5. Мэдээлэл Харилцаа Холбооны хөгжил, технологийг ашиглах
6. Тогтвортой хөгжлийг дэмжих
7. Анхдагч болон соёлын хэрэгцээгээ хангах гэх мэт.

Хүүхдүүд бодох сэтгэх маш дуртай. Тэд эргэн тойрноо ажиглаж, асуулт тавьж, хариулт олохын тулд бяцхан туршилт хийж, өөртөө нээлт хийж байдаг. Мөн өөрийн хүссэн сорил туршилтыг томчуудын заавраар амжилттай хийж чаддаг. Бүхнийг мэдэх хүүхдийн төрөлхийн хүсэл тэмүүлэл бол шинжлэх ухаанд сургах түлхүүр, хөрс юм,[3]. Ийнхүү эрэл хайгуул хийн олж мэдсэн зүйлс бүхэн тэдэнд туршлага болон үлддэг.

2. удлан шинжлэх арга /Онолын судалгаа/



Зураг 3. Эдгар Дэйлийн үр дүнтэй сургах арга зүйн конусын загвар

(Эх сурвалж: http://www.etsu.ude/uged/etsu1000/document/Dales_Cone_Of_Experience.pdf)

Эдгар Дэйлийн конус загварын хэсэг бүр нь сургалтын ялгаатай байдалд харгалзах мэдээлэл хадгалах хурдыг илэрхийлдэг. Конус дээрээс доош чиглэсэн шилжилт бүр нь илүү их мэдлэгийг өгөхийн зэрэгцээ тэр хэмжээний мэдээлэл суралцагчдад хадгалагдан үлдэнэ гэжээ. Сургалтын агуулгыг зөвхөн үгээр илэрхийлэх, түүнийг сонсох хэлбэрээр хүлээн авах нь хамгийн бага үр дүнтэй идэвхгүй үйл. Зураг, схемээр илэрхийлснийг харах, дүрс бичлэг, үзүүлэн загвар үзэх зэрэг нь мөн л сэтгэхүйн доод түвшний үйл болох ойлгох, хэрэглэх идэвхгүй үйл байна. Харин конусын суурь хэсэгт байрлах тодорхой зорилгод чиглэсэн практик дадлага, бодит амьдралд ойр туршилт, биеэр гардан хийх зэрэг үйл нь анализ хийх, үнэлэх, бүтээх гэсэн дээд түвшний сэтгэн бодох үйлүүдийг багтаажээ, [4].


Ингэснээр суралцагчдыг бүтээлч үйл ажиллагаанд суралцуулж, зохион бүтээх, шинэлэг байдлыг эрэлхийлсэн, аливааг өөр өнцгөөс харах чадвар зэрэг маргаашийг өнөөдрөөс илүү сайн сайхан болгоход чиглэсэн зорилт бүхий мэдлэг, чадвартай иргэн бэлтгэхэд илүү үр дүнтэй хэлбэр юм.

Судалгааны хэсэг

3. Тандалтын судалгаа


Зорилго: Суралцагчдын ухаалаг хэрэглээний талаарх ойлголтыг тодорхойлох.

Асуулгын хэлбэр: Нээлттэй асуулгын аргыг ашиглан хамгийн олон гарсан хариултуудыг багцлан илэрхийлэв.



Тандалт судалгааны дүгнэлт :

- Нийт судалгаанд хамрагдсан 150 сурагчийн 75%-85% хувь нь ухаалаг хэрэглээг зөвхөн ухаалаг гар утас, сургалтын LED дэлгэц, интернэт холбоо зэргээр зүйрлэж байна. Энэ нь ухаалаг хэрэглээ гэх тодорхойлолтоос өөр зүйл юм. Төхөөрөмж, хэрэглээ гэсэн хоёр өөр ойлголтыг бодит жишээ, дадлага, туршилт зэргээр тайлбарлан таниулах нь нэн тэргүүнд тавигдах асуудал мөн.
- Сурагчдад нээлттэй олон хувилбарт асуултыг тавих нь илүү үр дүнтэй болох нь анзаарагдаж байна.
- Сурагч бодит жишээнд тулгуурлан арга аргачлалыг сонирхолтой хэлбэрээр тайлбарлан, туршилтад тулгуурласан сургалтын хэлбэрийг хүсэмжилж буй нь анзаарагдаж байна.



Туршилтын хэсэг

Иймд багш, сурагчдаа эерэг хандлагаар, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах сэтгэлээр, бага хугацаанд илүү ихийг хийж бүтээх хүсэл эрмэлзэлтэй, шинжлэх ухаанч эрэл хайлт бүхий ухаалаг алхам хийхэд бэлэн болгох зорилгоор дараах ажлуудыг Эдгар Дэйлийн конусан загварын суурь хэсэг буюу 7-11 дүгээр сургалтын хэлбэрээр хичээлийг зохион байгууллаа.

Хүүхдийг ухаалаг хэрэглээнд хөтлөх боломжийг судлах үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Оролцогч	Үр дүн
1	Даалгавар-1,2,3,4	Сурагч	Гэр бүл, найз нөхөд, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах сэтгэлтэй, бүтээлч үйлийн аргад суралцах хүсэл тэмүүлэлтэй болохоос гадна сурагчдын ухаалаг хэрэглээний талаарх ойлголт, хандлага өөрчлөгдөж байна.
2	Хэлэлцүүлэг	Багш	Эдгар Дэйлийн үр дүнтэй сургах арга зүйн конусан загварын 7-11 дүгээр агуулгаар хичээлийг зохион байгуулахад багшийн төлөвлөгөөтэй асуух АСУУЛТ гол чиглүүлэгч нь хэмээн багш нар үзэж, хичээл сургалт бүртээ асуултаа төлөвлөж орох хандлага нэмэгдсэн.

Арга зүй

Уг илтгэлийн гол арга зүй нь Эдгар Дэйлийн “Үр дүнтэй сургах арга зүйн конусын загвар”-т суурилан суралцагчдыг бүтээлч үйлийн төсөлт ажлаар чиглүүлэх, зөвлөх явдал юм. Төлөвлөгөөний дагуу 4 даалгавар (төсөлт ажил) –ыг мэдээллийн технологийн сургалтын явцад гүйцэтгэсэн ба дараах үр дүн гарсан.

Даалгавар-1: “УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖИЙГ БУС УХААЛАГ ХЭРЭГЛЭЭГ ЭРХЭМЛЭЭ” сэдвийн хүрээнд яриа таниулга хийснээр сурагчдын хандлага өөрчлөгдөж, байгаль орчноо хайрлан хамгаалсан, бага хугацаанд илүү ихийг хийж бүтээх хүсэл эрмэлзэлтэй болж сургалтын явцад зөв зүйтэй ашиглах хэрэгтэйг ойлгож авсан.



Даалгавар-2:
“МУЛЬТИМЕДИА БҮТЭЭЛИЙН УРАЛДААН”

Мэдээллийн технологийн хичээлээр дамжуулан сурагчдын байгаль дэлхий, эх орон, гэр бүл, найз нөхдөө хайрлан хамгаалах үзлийг нэмэгдүүлэх зорилгоор “Сургамжит теле зохиомж”-ийн уралдааныг ахлах ангийн хүрээнд зохион байгуулсан. Сурагчдыг сэдэлжүүлэх зорилгоор “ЦАНГАСАН ДЭЛХИЙ” уран сайхны киног үзүүлж, дэлхийн усны хомсдол, бохирдлын талаар мэдээллүүдийг танилцуулсан. Ингэснээр сурагчид байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах хэрэгтэйг бусдадаа уриалах зорилгоор амьдралын туршлага болон Газарзүй, Технологи, Дүрслэх урлаг, Түүх, Монгол хэл зэрэг хичээлээс олж авсан мэдлэгд тулгуурлан богино хэмжээний сургамжит видео эвлүүлэгийг амжилттай хийсэн.



Даалгавар-3: “ТОГОРУУНЫ ТАНИЛЦУУЛГА”

2017 оны 06-р сарын 13нд Хэнтий аймгийн Биндэр суманд болсон “Тогорууны баяр”-т бүтээл хийх зорилгоор сурагчидтайгаа Цагаан нуураар аялж нутаг усны гайхамшиг, домог түүхийн талаар ярилцан Цэн тогоруу, Өвөг тогоруу, Хар тогоруу гэх зэрэг олон төрлийн тогорууны талаар мэдээлэл, танилцуулгыг бэлтгэн ведио эвлүүлэг хийсэн.



Даалгавар-4: “БҮТЭЭЛЧ

СЭТГЭЛГЭЭ МОНГОЛ ӨВ УЛАМЖЛАЛ”

Мэдээллийн технологийн хичээлийн “Загвар ба загварчлал” сэдвийг ухаалаг хэрэглэгдэхүүнд суурилан амжилттай зохион байгууллаа. Биет байдлаар харж, өөрсдөө хичээлийн явцад угсарч, сэтгэл шингээж хийсэн учир гэр, байшин, урц зэргийг барих аргыг хэзээ ч мартахааргүй боллоо хэмээн сурагчид урамшиж байсан.



Хэлэлцүүлэг: “ШИНЖЛЭХ УХААНЧ ЭРЭЛ ХАЙЛТЫГ СУРГАЛТЫН ЯВЦАД АШИГЛАХ НЬ” сэдэвт хэлэлцүүлгийг тус сургуулийн 39 багшийн дунд амжилттай зохион байгуулсан бөгөөд багш нар Эдгар Дэйлийн үр дүнтэй сургах арга зүйн конусан загварын 7-11 дүгээр агуулгаар хичээлийг зохион байгуулахад багшийн асуух АСУУЛТ гол чиглүүлэгч нь хэмээн үзсэн юм.

Асуулт-1: Эрэл хайлтаар олж авсан мэдээллийг сурагчдад хүргэх гол гүүр нь юу вэ? гэсэн асуулгад багш нарын 87% нь АСУУЛТ ТАВИХ гэж хариулсан.

Асуулт-2: Асуултыг оновчтой тавихын үр дүн нь юу вэ?

- Асуулт нь гол зүйлд төвлөрүүлж өгдөг.
- Асуудлыг ялгаж тодруулдаг.
- Асуулт асуухад төдийлөн тусгай материаллаг бэлтгэл шаардлагагүй.
- Судалгааг асуултаас эхэлж болно гэсэн хариултуудыг өгсөн. Хэлэлцүүлгийн төгсгөлд доорх дүгнэлтэд хүрэв.

Асуултын чанараас хичээлийн эхлэл, цаашдын өрнөл, үр дүн хамаардаг. Иймд асуултыг маш сайн бодож, төлөвлөж, бэлтгэх шаардлагатай байдаг.

- Бид яах гэж асуулт тавьдаг юм бэ?
- Асуулт зорилготой байх ёстой.
- Юу мэддэгийг нь илрүүлэх гэж асуув уу?
- Юу мэдэхгүйг нь илрүүлэхийг зорив уу?
- Асуудлын мөн чанарыг гаргахыг хичээв үү? гэх зэргээс сургалтын явцын төлөвлөлт, өрнөл, дүгнэлт зэрэг шалтгаалах болно.

Иймд багшийн үгийн сонголт, асууж байгаа асуулт нь сургалтын явцад сонгож буй ухаалаг хэрэглээ болоод зогсохгүй тулгарсан гол асуудлыг шийдвэрлэх гүүр цаашид амдрах ахуйдаа мэдлэг, чадварыг хэрэглэх чиглэл болж өгдөг.

Туршилтын дараах судалгаа

“УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖИЙГ БУС УХААЛАГ ХЭРЭГЛЭЭГ ЭРХЭМЛЭЭ” сэдвээр яриа таниулга, хичээл, сургалт зохион байгуулсаны дараа сурагчдын ухаалаг хэрэглээнд хандах хандлагын илрэлийг Лайкерттын шкалаар хэмжээсжүүлэн үр дүнд шинжилгээ хийв.

Асуулт-1	Өмнө					Дараа				
	Огт үгүй	Бараг үгүй	Заримдаа	Үе үе	Үргэлж	Огт үгүй	Бараг үгүй	Заримдаа	Үе үе	Үргэлж
Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ эх орон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ёстой	1.8%	30.2%	53.7%	12.1%	2.2%	0.0%	7.1%	25.7%	30.1%	37.2%
Асуулт-2	Огт буруу	Буруу	Ялгаагүй	Зөв	Маш зөв	Огт буруу	Буруу	Ялгаагүй	Зөв	Маш зөв
Сургалтыг сурган хүмүүжүүлэх арга болон ухаалаг төхөөрөмжтэй хосолсон хэлбэрээр явуулах зүйтэй	2.0%	3.3%	58.7%	25.7%	10.3%	0.0%	13.3%	9.7%	48.7%	28.3%
Асуулт-3	Огт буруу	Буруу	Ялгаагүй	Зөв	Маш зөв	Огт буруу	Буруу	Ялгаагүй	Зөв	Маш зөв
Ухаалаг төхөөрөмжийн сайнаар бус ухаалаг хэрэглээг зөв сонгосноор сургалтын үр дүн эерэг гарна	42.4%	24.1%	21.6%	9.8%	2.1%	0.0%	5.3%	7.1%	34.5%	53.1%
Асуулт-4	Огт үгүй	Бараг үгүй	Заримдаа	Үе үе	Үргэлж	Огт үгүй	Бараг үгүй	Заримдаа	Үе үе	Үргэлж
Та өөрийн анхдагч болон соёлын хэрэгцээгээ хангахын тулд ухаалаг хэрэглээг сонгодог уу?	6.7%	48.2%	28.3%	13.6%	3.2%	0.0%	8.8%	28.3%	33.6%	29.2%
Асуулт-5	Огт үгүй	Үгүй	Эргэлзээтэй	Зөвшөөрч байна	Бүрэн зөвшөөрч байна	Огт үгүй	Үгүй	Эргэлзээтэй	Зөвшөөрч байна	Бүрэн зөвшөөрч байна
Та ухаалаг сонголт хийж, шинийг эрэлхийлж, бусадтай эерэг харилцаж чаддаг уу?	9.0%	23.7%	42.7%	20.2%	4.4%	0.0%	2.7%	32.7%	36.3%	28.3%


Дүгнэлт	Өмнө					Дараа				
	Огт буруу	Буруу	Ялгаагүй	Зөв	Маш зөв	Огт буруу	Буруу	Ялгаагүй	Зөв	Маш зөв
	12.4%	25.9%	41%	16.3%	4.2%	0.3%	7.4%	20.3%	39.1%	32.9%

Судалгааны үр дүн

Үр дүнд хүрэхэд чиглэсэн ерөнхий зорилго, түүндээ зохицсон аргууд, үйл ажиллагаа бүхий төсөлт ажлыг зохион байгуулснаар сурыгчдын ухаалаг хэрэглээнд хандах хандлагад эрс өөрчлөлт ажилгадаж байна.

Ерөнхий дүгнэлт

- Нийт судалгаанд хамрагдсан 150 сурагчийн 75%-85% хувь нь ухаалаг хэрэглээг зөвхөн ухаалаг гар утас, сургалтын LED дэлгэц, интернэт холбоо зэргээр ойлгож байсан бөгөөд тэдний энэ хандлагыг өөрчлөх шаардлагатай гэж үзсэн.
- Туршилтын дараа Сурагч Б: Ухаалаг төхөөрөмж гэдэг бол зөвхөн цаг хугацааг л хэмнэх зорилготой харин ухаалаг хэрэглээг өөртөө хэвшүүлж чадвал насан туршдаа цаг хугацааг байлдан дагуулж чадах юм байна. Сурагч Х: Манай сургууль ухаалаг олон самбартай байхаас илүү ухаалаг сургалтын аргыг л хэрэгжүүлэх нь зүйтэй юм байна гэх зэрэг эргэцүүллийг хийсэн бөгөөд бүтээлч үйл ажиллагаагаар тэдний хандлагад багахан ч гэсэн өөрчлөлт гарсан хэмээн үзэж байна.
- Эдгар Дэйлийн “Үр дүнтэй сургах арга зүйн конус” загварыг төсөлт ажилтай уялдуулан арга зүйгээ боловсруулж, хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь үр дүнтэй болох нь харагдлаа.
- ЕБС нь сурагчдад суурь мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэх зорилготой бөгөөд тэд эзэмшсэн мэдлэг, чадвараа тулгарч буй асуудалд зөв ашиглаж, эерэг үр дүнд хүрч чадвал энэ нь ухаалаг хэрэглээ болно гэж дүгнэж байна.
- Иргэн бүр ухаалаг хэрэглээг өөртөө бий болгосноор насан туршийн амьдрах ухаантай хүн болон төлөвшинэ хэмээн үзэж байна. Үүнд судлаач миний заасан хичээл тодорхой дэмжлэг үзүүлсэн гэж дүгнэж байна.



Ном зүй, ашигласан материал:

1. Түмэнцэцэг, Б. (2016) Бага ангийн сургалтын цахим хэрэглэгдэхүүн бүтээх арга зүй боловсруулж туршсан үр дүн. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
2. UNICEF, 2007, х.31-33
3. Ганбат.М, Норжмаа.Г, Энэбиш.Ж, (2015) Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй-2014, Шинжлэх ухаанч эрэл хайлтыг хичээлд хэрэглэх тухай зөвлөмж. Улаанбаатар: Очирпресс
4. Түмэнцэцэг, Б. (2016) Бага ангийн сургалтын цахим хэрэглэгдэхүүн бүтээх арга зүй боловсруулж туршсан үр дүн. Улаанбаатар: Соёмбо Принтинг

5. “Боловсрол судлал” (2016). сэтгүүл. №08.[126]
6. Жон Максвелл (2009). “Хандлагын хүч”
7. Доржжав,Д. (2005)в “Сэтгэл зүйд өөрөө суралцах нь”
8. Ичинхорлоо,Ш. (2008) .“Судалгааны ажлын үндэс”
9. Ичинхорлоо,Ш. (2017) .“Сургалтын технологи”
10. Байгалмаа,Ч. (2015) .“Боловсролын судалгааны арга зүй”
11. Түмэнцэцэг, Б. (2016) “Бага ангийн сургалтын цахим хэрэглэгдэхүүн бүтээх арга зүй боловсруулж туршсан үр дүн”
12. “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй-2014” ЭШХ 2-р эмхэтгэл
13. “Ухаан бодрол” сэтгүүл 2014. №03.[03]
14. Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр / гарын авлага / 2015
Ашигласан вэб сайт
15. <http://naranpsychology.blogspot.com/2015/08/blog-post.html>)
16. http://www.etsu.ude/uged/etsu1000/document/Dales_Cone_Of_Experience.pdf)

ГУРАВ. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

Монгол хэлний сургуулийн хөтөлбөр

Б.Алимаа

Өмнөговь, Цогтцэций сумын 6-р сургууль

Хураангуй:

Зорилго: Сургуульд суурилсан судалгаагаар сургуулийн зорилго, зорилтод нийцүүлж, сургалтын шинэлэг арга зүйг боловсронгуй болгон сургалтын чанарыг сайжруулахын тулд дүн шинжилгээтэй ажиллаж багшийг тасралтгүй хөгжүүлэхэд оршино.

Судалгааны арга зүй: Сургалтын хөтөлбөрийн тохирц, сургах үйл ажиллагааны арга хэлбэр хэрхэн нийцэж байгааг багшийн өдөр тутмын ажиглалтын тэмдэглэл, улирал бүрийн хөндлөнгийн судалгаа, секцийн ажлын хэлэлцүүлгээр илрүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Бага боловсролын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичиг, багшийн номд баримжаалан бага боловсролын Монгол хэл, Хүн ба орчин хичээлийн сургуулийн хөтөлбөртэй болсон. Үүнд сургуулийн хөтөлбөрийн зорилго, цогц чадамжид суурилсан эзэмших чадвар, бүлэг сэдэв нэгж хичээлийн хөтөлбөр үнэлгээний аргачлал, багшид өгөх зөвлөмж, чиглүүлэг, жишиг даалгавар багтсан болно.

Практик ач холбогдол: Сургуулийн хөтөлбөртэй болсоноор дараах практик ач холбогдолтой байна. Үүнд:

1. Хүүхэд нэг бүрийн сурах арга барилыг судлах, оношлох, чадварын түвшинг тогтооход багшийн ажлыг чиглүүлж өгч байна.
2. Энэхүү хөтөлбөрийг боловсруулснаар жил бүр дахин сайжруулж хэрэглэхээс багшийн долоо хоногийн ажлын ачааллыг 3-5 цагаар хөнгөвчилж ээлжит хичээлд чанартай бэлтгэхэд чухал ач холбогдолтой.
3. Сурагчдаа судлах оношлох бүрэн боломж олгосон сургуулийн баримт бичиг болж чадсан.

Шинэлэг санаа: Хүүхдийн хөгжлийг бие, сэтгэл, оюуны хөгжлөөр тодорхойлж сургуулийн хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тухайн судлагдахууны сурах үйл ажиллагаа, арга зүй, үнэлгээгээр дамжуулан хэрэгжүүлж сурагч нэг бүрийн хандлага төлөвшил, суурь чадвар, когнитив чадвар, сурах арга барилыг ажиглан судлах замаар хүүхдийн бие, сэтгэл, оюуныг цогцоор нь хөгжүүлэх хөтөлбөр юм.

Товч агуулга: Бага боловсролын цөм хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2014-2015 оны хичээлийн жилээс өөрийн сургуулийн алсын хараа, зорилго зорилт, сургалтын баримталж буй онол, үнэлгээний системийг цогцоор нь хэрэгжүүлэхүйц монгол хэлний хичээлийн сургуулийн хөтөлбөр боловсруулахыг зорин бага ангийн тэнхимийн багш нар зориг шулуудан ажиллаж эхэлсэн юм.

Таван ангийн 108 бүлэг сэдвээр төлөвлөгдсөн энэхүү хөтөлбөрийн ээлжит хичээлийн цагийн хуваарилалт, сурах үйл ажиллагааг хэрхэн хүүхдийн сонирхолд нийцүүлэн бэлтгэх үйл ажиллагааг багшийн мэдэлд үлдээсэн болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хүүхэд нэг бүрийн хандлага төлөвшил, суурь чадвар, тусгай чадварыг тогтмол дэмжин хөгжүүлж, жилдээ 3-4 удаа үнэлэн, сурах арга барил эзэмшиж буй үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцоо, тухайн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлж буй багшийн ээлжит хичээлийн үйл явцыг ажиглан судалж хэлэлцүүлэг өрнүүлэн сайжруулсан юм.

Тус хөтөлбөрийг энэ жил 5 дахь удаагаа туршин хэрэгжүүлж засан сайжруулах явцад багш сурагчдад дараах эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Үүнд:

- Суралцагчдын хандлага төлөвшил, суурь чадвар жилээс жилд 2-10 хувийн ахиц, тусгай чадварын гүйцэтгэлд 3-7 хувийн ахиц гарч байна.
- Сурагчдын харилцах, хамтран ажиллах, унших, бичих, сонсох үйл ажиллагаанд оролцох оролцоо 5-38 хувиар нэмэгдэж унших, бичих, ярих, сонсох арга барил зөв төлөвшиж байна.
- Унших, бичих, сонсох, ярих, харилцах хамтран ажиллах арга барилд суралцаж байгаа гүйцэтгэлийг ажиглан судлах арга барилд багш суралцаж байна.


- Багшийн бүлэг болон нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах цаг хэмнэгдсэнээр ээлжит хичээлд чанартай бэлтгэх боломж бүрдэж байна.

**Дэлгэрэнгүй:
УДИРТГАЛ**

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь: “Бага боловсролыг эх хэлний суурь чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн, бүтээлч, сурах арга барилтай Монгол хүүхэд төлөвших үе хэмээн хөгжүүлнэ” ¹ гэсэн байдаг.

Монгол хэлний хөтөлбөр нь” Бага боловсролын монгол хэлний цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэж, хүүхэд бүрийг эх хэл, соёл уламжлалаа дээдэлдэг, унших, бичих, ярих, сонсох бүтээлч сурах арга барилтай болгож танин мэдэхүй, хэл нийгэм, амьдрах ухааны чадамжийг хөгжүүлж тэдгээр харгалзах ерөнхий болон тусгай чадварыг эзэмшүүлнэ” ² гэжээ.


Манай сургуулийн бага боловсролын хөтөлбөрийн зорилго нь “хүүхэд нэг бүрийг өөртөө итгэлтэй, өөрийгөө илэрхийлэх чадвартай, хувийн зохион байгуулалт сайтай, суурь, тусгай чадварыг бүрэн эзэмшсэн, ерөнхий чадвар, сурах арга барилтай, зөв дадалтай монгол хүүхэд төлөвшүүлнэ” гэж тодорхойлж хүрэх үр дүнг дараах байдлаар томъёолон судалж байна.



Иймд шинэ таксономийн хоёр хэмжээтэй тогтолцоо юм. Нэг хэмжээс нь мэдлэгийн 3 айг, нөгөө нь оюуны үйлийн 6 түвшинг тус тус илэрхийлдэг.

Шинэ таксономийн гол санаанд энэхүү хөтөлбөрийн арга зүйн онол тулгуурлаж байгаа бөгөөд нэг талаар суралцахуй, багшлахуй, үнэлгээ гурав хоорондоо тохирч байх, нөгөө талаар хүний тархины үйл ажиллагааны механизмыг шинжлэх ухааны үндэстэй зөв тооцож чадвал сургалт чанартай, үр ашигтай явагдана гэсэн зарчмыг баримталж байгаа юм.. Үүнийг бид сургалтын хөтөлбөр болон өдөр тутмын үйл ажиллагаандаа маш сайн тусгаж чадсан.

Суралцахуйн үндсэн зарчмуудын талаар товчхон



Бид хүүхдийн хөгжлийг бие, сэтгэл, оюун ухааны хөгжлийн цогц гэж үздэг учраас суралцахуйг нэг талаар дээрх зураг дээр харуулсан шиг когнитив үйл явц, нөгөө талаар хувь хүний хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн идэвхитэй харилцаа гэж үзлээ. Учир нь хүний хөгжил бол биологийн өсөлт хөгжил ч мөн, соёлын үнэт зүйлийг эзэмших үйл явц ч мөн юм. Өөрөөр хэлбэл суралцахуй дахь байгаль ба нийгэм, соёлын нөлөөллийг бид арга билгийн шүтэн барилдлагын үүднээс авч үздэг гэсэн үг. Иймд багшлах арга зүйн тал дээр бид дараах зарчмуудыг хослуулан хэрэглэнэ. Үүнд:

Тархины үйлийн системүүд	Бихевиорист суралцахуйн зарчмууд	Хүмүүнлэг суралцахуйн зарчмууд	Когнитив суралцахуйн зарчмууд	Тайлбар
	Сэдэл ба урамшуулал	Суралцагчийн сэтгэл санааны эрэлтэд нийцүүлэх	Мэдлэг дамждаггүй, харин бүтээгддэг	

Селф систем	Амжилттай суралцахад сэдэл хэрэгтэй	Албадлагагүй суралцахуй хамгийн үр дүнтэй		Тархины БХС дахь мэдээллийн агуулга богино хугацаанд хадгалагдах бөгөөд шинэ мэдээлэлд амархан зайгаа тавьж өгдөг.
	Суралцахуйг бөөндөж бус алхам алхмаар өрнүүлдэг	Суралцагч сурах зүйлээ өөрөө сонгох эрхтэй		Багшийн ярианы хурд, хэмнэл зэрэг нь суралцагчдад хүргэмжтэй байхаас гадна агуулгын багтаамж түүнийг эзэмшүүлэх хугацаатай харилцан тохирч байх ёстой.
	Бататгалыг тухай бүрт нь хийж явах	Суралцагч сурах үйлдээ хариуцлага үүрэх ёстой		Зөвхөн байнга сэргээн дуудагддаг, хэрэглэгддэг мэдээллийг л тархи урт хугацааны санамжинд (УХС) хадгалдаг.
	Дадал хэвшил болгох үүднээс тогтмол давтуулах			
Метакогнитив систем		Суралцагчийн өөрийн үнэлгээ багшийнхаас эрхэм		Суралцагч зорилгоо тодорхойлох, гарсан үр дүндээ үнэлгээ шинжилгээ хийх чадвартай байж гэмээн суралцахуй үр ашигтай өрнөдөг.
		Нийгэмших явцдаа суралцах		
Когнитив систем			Мэдээлэл дамжих явцдаа заавал гажиж, өөрчлөгддөг (алдааг илрүүлж, залруулж зөв болгох шаардлагатай)	Үйлийн хэлбэр олон байх тусмаа суралцагчдын анхаарлын төвлөрөл тогтвортой байж, шинэ мэдлэгийг ойлгох үйл явц чанартай болдог.
			Шинэ мэдлэг өмнөх төсөөлөл дээр суурилж бүтдэг (мэдлэг бүтээгддэг)	УХС дахь хур мэдлэг буюу өмнөх төсөөллийг сайжруулж өөрчлөх замаар шинэ мэдлэгийг эзэмшүүлбэл сургалт үр дүнтэй болдог.

Суралцахуйн ШУ-ы дээрх дурдагдсан онолын үзэл баримтлалд тулгуурлан бид сурагч нэг бүрийн бие сэтгэл оюуны хөгжлийг хослуулан хандлага төлөвшил, суурь чадвар, когнитив чадварыг судлан оношлохыг зорилоо.

СЭДВИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ:

Бидний 6-р сургууль 2012-2013 оны хичээлийн жилд шинээр үүсгэн байгуулагдсан бөгөөд тухайн үед бидний бүх зүйл шинэ байлаа. Багш- шинэ төгсөгчид, ангиуд шинээр үүссэн, сургууль шинэ, бодлого төлөвлөлт бас шинэ. 2012-2014 онуудын багш нарын хичээл хөгжлийн үзүүлэлт 49-55 хувьтай, бага ангийн монгол хэлний чадварын гүйцэтгэл 55-69 хувьтай байв. Багш нарын арга зүй дорвитой сайжрахгүй, ажлын ачаалал ихтэй, жил бүр бүлэг сэдэв, нэгж хичээлийн төлөвлөлт хийсэн ч дараа жилдээ шаардлагад нийцдэггүй, үүнийгээ дагаад сурлагын амжилт ч сайнгүй байсан тул сургуулийн хөтөлбөрийг нэгдсэн зохион байгуулалтаар боловсруулан туршиж, сургах үйл ажиллагааг чиглүүлэх, сургуулийн үнэлгээний нэгдсэн арга зүйг хэрэгжүүлэх зорилго тавин ажиллаж эхэлсэн бөгөөд энэ нь өдгөө 5 дахь жилдээ туршин хэрэгжүүлж буй монгол хэлний хөтөлбөр юм.

Энэхүү илтгэлээрээ бага боловсролын монгол хэлний сургуулийн хөтөлбөрийг хэрхэн боловсруулж туршсан, энэ хугацаанд тохиолдсон саад бэрхшээлийг даван туулсан, болон сурагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжилд гарсан өөрчлөлтийг танилцуулахыг зорилоо.

ХАМРАХ ХҮРЭЭ: Хөтөлбөр боловсруулах туршилт судалгаанд 2014-2018 оны хичээлийн жилд тус сургуулийн 1-5 дугаар ангид суралцаж байсан 1678 суралцагч 52 багш (*давхардсан тоогоор*) хамрагдсан болно.

ХУГАЦАА: Хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаа дараах үе шаттай явагдаж байгаа бөгөөд туршилтын хугацааны 3 дахь жилээс үр дүн мэдэгдэж эхэлсэн юм. **2018-2019**



ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Хөтөлбөр боловсруулах менежмент: Хөтөлбөр боловсруулах турших энэхүү туршилтын таван жилийн хугацаанд манай сургууль 10-18 хүртэлх бүлгийн багш секцийн зохион байгуулалтаар, сургалтын менежер Алимаа миний удирдлага дор ажилласан бөгөөд бидний зохион байгуулалт ажил үүргийн хуваарь дараах загвартай байлаа.



Бид ажил үүргээ дараах байдлаар хуваарилан ажилласан юм.

Ажлын чиглэл	Боловсруулах	Турших	Хэлэлцэх Дүгнэлт гаргах	Дахин сайжруулах
Цөм хөтөлбөрөө судлах, сургуулийн онолын үзэл баримтлалд буулгах	Сургалтын менежер	Багш нар	Сургалтын менежер Багш нар	Сургалтын менежер
Хандлага төлөвшил, суурь чадварын үнэлгээний аргачлал боловсруулах	Сургалтын менежер	Багш нар	Сургалтын менежер Багш нар	Сургалтын менежер
Бүлэг сэдвийн хүрэх үр дүн, зорилго зорилт, агуулгын залгамж холбоог тодорхойлох	Багш нар	Багш нар	Сургалтын менежер	Багш нар сургалтын менежер
Жишиг даалгавар боловсруулах	Багш нар	Багш нар	Багш нар, сургалтын менежер	Сургалтын менежер
Тусгай чадварыг үнэлэх рубрик	Сургалтын менежер	Багш нар	Сургалтын менежер багш нар	Багш нар


Багшийн ажиглалтын тэмдэглэл	Сургалтын менежер	Багш нар	Багш нар, сургалтын менежер	Багш нар
Суралцахуй зорилт сурах үйл ажиллагааг төлөвлөх	Багш нар, сургалтын менежер	Багш нар	Багш нар	Багш нар
Багшид өгөх зөвлөгөө, багшийн чиглүүлэг дэмжлэг анхаарах зүйл	Багш нар	Багш нар	Сургалтын менежер багш нар	Багш, сургалтын менежер
Бүлэг сэдвийн үнэлгээг шинэ үнэлгээнд шилжүүлэх	Багш нар	Багш нар	Сургалтын менежер	Багш нар

Сурагчдын хөгжилд гарч буй өөрчлөлт:


Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хүүхдийн хөгжил төлөвшилд ямар өөрчлөлт гарч байгааг бид дараах судалгаагаар илрүүлж байсан юм. Үүнд:

1. Бүлэг сэдвийн үнэлгээ
2. Улирал бүр сургалтын албанаас авдаг хөндлөнгийн судалгаа
3. Жилд 2 удаа суурь чадварын судалгаа
4. Хандлага төлөвшлийн багшийн ажиглалтын тэмдэглэл
5. Тусгай чадвар эзэмжих явцад сурах арга барил хэрхэн төлөвшиж байгааг ажиглах хуудас

Дээрх ажиглалт судалгаагаар зөвхөн 1 сурагчийн сурлага төлөвшлийн үнэлгээнд судалгаа хийж ахицыг харахыг зорьё. Бидний сонгосон сурагч бол 2017-2018 оны хичээлийн жилд 56 ангид суралцаж төгссөн Б. Азбаяр юм. Азбаярын 3-р ангиас эхлэн хөтөлбөрийн дагуу хэрхэн үнэлэгдэж байсныг харуулъя.



Энэ сурагчийн хувьд тусгай чадварын түвшин жил тутам 3-7%, унших болон бичих чадвар 4-22% ахицтай суралцжээ. Хөтөлбөрийн 4-р ангид 8 бүлэг сэдэв, 5-р ангид 9 бүлэг сэдвийн бичих арга барилд суралцах үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгааг ажиглан судалсан юм. Жишээ нь Г. Баярцэцэг багш дээрх ангийг 4 ба 5-р ангид бичих санаагаа олох төлөвлөх, бичсэнээ хянан сайжруулах үйл ажиллагааг ажигласан тэмдэглэлийг харуулж байна.



Багш өөрийн ажиглалтын судалгааг үндэслэж сурагч Анхбаярын бичих санаагаа олох төлөвлөх чадварыг дараах байдлаар дүгнэжээ.

Бичиж сурах арга барил	4-р анги	5-р анги
Бичих санаагаа өөрөө олох	Санаагаа өөрөө олдоггүй бусдын хэлсэн санааг авч бичдэг	4 удаагийн бичих үйл ажиллагаанаас 2 удаа бичих санаагаа өөрөө олсон.
Бичих санаагаа төлөвлөх	Төлөвлөгөө гаргадаггүй шууд бичдэг байснаа сүүлийн 2 бичилтэд төлөвлөгөө гаргах оролдлого хийсэн	Годорхой хэмжээнд бичих санаагаа төлөвлөдөг болсон.

Бичсэнээ хянан сайжруулах	Сайжруулах санаагаа өөрөө гаргадаггүй бусдаар хэлүүлдэг байсан.	Бусдын бичсэнийг сонсоод өөрийн сайжруулах санаагаа олдог болж байна.
Дахин сийрүүлж бичих	Алдаагаа бараг засдаггүй дахин хуулж бичдэг байсан бол алдаагаа засах оролдлого хийдэг болсон	Өөрийн алдааг маш сайн илрүүлдэг, засдаг болсон ч 1-3 алдаа гаргадаг.

Энэхүү судалгаагаар бичих санаагаа олох төлөвлөх чадвар 4-р ангид 37% байсан 5-р ангид 78% болж 41%, бичсэнээ хянан сайжруулах чадвар 4-р ангид 34% байсан бол 80% болж 46 %-ийн ахиц гарсан нь харагдаж байна.




Бичих арга барилд суралцах үйл ажиллагаанд оролцох оролцоог чадвар тус бүрээр харьцуулан харахад 28%-59% хүртэл өссөн харагдаж байна.



Сонсох арга барилд суралцах үйл ажиллагааг 5-р ангийн “Илтгэх чадварт суралцъя” бүлэг сэдвээр ажиглан судалсан бөгөөд үйл ажиллагаанд оролцох оролцоо 40% байсан бол 70% болж оролцоо 30%-иар ахиж байлаа.



Суралцах арга барилд сургахын тулд үйл ажиллагааг зөв чиглүүлэх нь ямар чухал болохыг эдгээр оролцооны судалгаанууд харуулсан бөгөөд сонсох арга барилын оролцоо 16%-61% ахиж байв. Бид хөтөлбөрөө үнэлэхдээ анги тус бүрийн тусгай чадварын түвшин ямар байгааг судалгаа бүрийн дараа бүртгэж алдаа дутагдлаа хэлэлцдэг бөгөөд энэхүү судалгааг сүүлийн 2 жилд хийсэн болно.




Тусгай чадвар эзэмшилтийн судалгаагаар 2016-2017 оны хичээлийн жилд дундаж гүйцэтгэл 65.1% байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 75.1% болж 6% ахиц гарсан.

Дээрх судалгааны ажлыг хийх явцад хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд дараах эерэг сайн талууд байгааг хэлэлцэж дүгнэлээ. . Үүнд:

- Тусгай чадвар эзэмшиж буй байдлыг хүүхэд нэг бүрээр ажиглан судлах боломж бүрдсэн байна.
- Унших, бичих, ярих, сонсох арга барилд сургах үйл ажиллагаа төлөвлөгдөж чадсан бөгөөд эдгээрийг хүүхэд нэг бүр дээр ажиглах, ахиц амжилтыг тооцох үйлийн орчин бүрдсэн.
- Хөтөлбөрийн дагуу багш ажлаа төлөвлөхөд ачаалал үүсэхгүйгээс гадна ахиц өөрчлөлтийг илрүүлэхэд хялбар байлаа.
- Анги тус бүрийн тусгай чадварыг жилдээ 1-5 удаа үнэлж, сурах арга барилыг 4-7 удаа ажиглаж байгаа тул сураг нэг бүрийн ахиц амжилтыг илрүүлэх бүрэн боломжтой.
- Багш хүүхэд нэг бүрийн сурах үйл ажиллагааны бүрэн мэдээлэлтэй болсноор эцэг эхтэй хамран ажиллахад дөхөмтэй байна.

Багшийн арга зүйд гарсан өөрчлөлт: 2012-2014 онуудад багш нарын маань хамтын ажиллагаа төдийлөн сайн биш секцийн хамт олон 7-14 хоногт 1-2 удаа хамтарч ажилладаг, цугласан үедээ хийх ажлаа зөвхөн аман хэлбэрээр төлөвлөдөг байв. Хөтөлбөрийг боловсруулж эхэлсэн жилээс багш нар секцийн зохион байгуулалтад орж багаар хамтран ажилласнаар дараах эерэг үзүүлэлтүүд ажиглагдлаа. Таван жил тасралтгүй ажилласан багш нарын заах арга барил хичээл хөгжлийн сургалтын менежерийн болон өөрийн үнэлгээний дунджийг нэгтгэж үзлээ.



Дээрх графикаас дүгнэвэл:

- 2012-2014 онуудад багшийн ээлжит хичээл зохион байгуулах гүйцэтгэл дунджаар 40% байсан бол хөтөлбөр боловсронгуй болж эхэлсэн 2015 оноос хичээлийн чанарт 10%-28% ийн ахиц харагдаж эхэлсэн байна.
- 2016 оноос хойш ээлжит хичээлийн чанар 64%-иас дээш гүйцэтгэлтэй болж ирсэн нь хөтөлбөрт суралцахуйн зорилт сурах үйл ажиллагааг оруулж багшийн үйл ажиллагааг нэлээд сайн чиглүүлж өгсөнтэй холбон тайлбарлаж байна.

Даваацэрэн багшийн хичээл хөгжлийн үнэлгээг ээлжит хичээлд тавигдах сургуулийн шаардлагын дагуу судалсан судалгааг графикаар харууль.



Энэ багшийн хичээлийн чанарын өөрчлөлтөөс харахад:

- Хичээлийн зорилго тодорхойлох, тухайн агуулгыг элементарчлах, хэрэглэгдэхүүнийг агуулга, үйл ажиллагаатай тохируулан оновчтой сонгох, тухайн хичээлийг тохирсон арга зүйгээр зохион байгуулах гэсэн үзүүлэлтүүд 20%-50% ахисан байгаа нь сургуулийн хөтөлбөр эдгээр үйл ажиллагаанд багшийг нэлээд сайн чиглүүлж өгч байна гэсэн дүгнэлтийг хүргэж байна.
- Ээлжит хичээлийн арга зүйн эдгээр элементүүд доод тал нь 8% түүнээс дээш 50% хүртэлх өсөлттэй байгаа нь багшийн арга зүйн сайжирч байгааг харуулж байна.
- Ээлжит хичээл дээр явцын болон чанарын үнэлгээний гүйцэтгэл 40%ийн ахицтай байгаа нь бүлэг сэдэв бүрийн багшийн ажиглан судлах үнэлэх ажиллагааг графикт оруулж төлөвлөсний үр дүн гарч байна гэж дүгнэлээ.

Багш нараас “Хөтөлбөр боловсруулах, турших, сайжруулах хэлэлцэх явцад багш таны хөгжилд ямар өөрчлөлт орсон бэ?” гэсэн асуултад дараах хариултыг өгч байна.


- Багаар хамтарч ажиллаж сурч байна.
- Хичээлийн бэлтгэл болон хэлэлцүүлэгт бусдыгаа нэлээд хүлээлгэх, цаг баримтлахгүй байх бэрхшээл маш их байсан бол одоо энэ байдал эрс сайжирсан.
- Багийн зохион байгуулалтаар хэн ч ажил үүргийн хуваарь гаргаагүй байхад ажлаа хамтарч хийдэг, амжуулдаг болсон.
- Жишиг даалгаврыг таксонимийн түвшинд боловсруулах чадвар сайжирсан.
- Суралцахуйн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дагуу ээлжит хичээлд бэлтгэхэд нэлээд сайн чадваржиж байна.
- Сурагчдаа судалж ажиглалтын тэмдэглэлийг сайн хөтөлдөг болсон.
- Ажиглалтын тэмдэглэлдээ дүгнэлт хийж эцэг эхэд сурах арга барил эзэмшиж буй явцын талаар мэдээлэл хийж чаддаг болж байна.
- Бүлэг сэдэв бүрийн дараах секцийн хэлэлцүүлэгт эхний үед ярих хэлэх зүйл олддоггүй байсан бол санаа бодлоо хуваалцдаг болсон.

Судалгааны үр дүн:

Бид багшийн ажлын ачааллыг багасгах замаар ээлжит хичээлийн чанарыг сайжруулж хүүхэд нэг бүрийн хөгжилд ахиц гарган сургалтын чанарыг сайжруулах зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулж ирсэн билээ.

2018 оны 9-р сард бага ангийн 18 багшаас авсан судалгаагаар монгол хэлний хичээлийн бүлэг сэдэв, нэгж хичээлийн төлөвлөлт хийх 7 хоногийн 2-4 цаг ээлжит хичээлийг чанартай бэлтгэхэд зориулагдаж байна гэсэн бол энэхүү хөтөлбөр багшийн хөгжил арга зүй сайжрахад маш сайн чиглүүлэг дэмжлэг болж байна гэж 100% үзсэн байна.

Сургуулийн бага боловсролын монгол хэлний тусгай чадвар эзэмшиж буй байдлыг сүүлийн 5 жилээр харуулбал 18 %-ийн ахицтай байна.



Бага ангийн багш нарын хичээл хөгжлийн үнэлгээний дунджийг мөн сүүлийн 5 жилд 41% ахиц гарсан.



Эдгээр судалгааг шинжилж үзэхэд энэхүү хөтөлбөр нь сургалтын чанар болон багшийн арга зүйд дараах ахиц, амжилтыг гаргаж байгааг учир сайн хөтөлбөр гэж дүгнэж байна. Үүнд:

- Суралцагчдын хандлага төлөвшил, суурь чадвар жилээс жилд 2-10 хувийн ахиц, тусгай чадварын гүйцэтгэлд 4-18 хувийн ахиц гарч байна.
- Сурагчдын харилцах, хамран ажиллах, унших, бичих, сонсох үйл ажиллагаанд оролцох оролцоо 5-38 хувиар нэмэгдэж унших, бичих, ярих, сонсох арга барил зөв төлөвшиж байна.
- Унших, бичих, сонсох, ярих, харилцах хамтран ажиллах арга барилд суралцаж байгаа гүйцэтгэлийг ажиглан судлах арга барилд багш суралцаж, эцэг эхэд хүүхдийнх нь сурах арга

барил төлөвшиж байгаа үйл явц, оролцооны талаар бүрэн мэдээлэл хийж хамтарч ажиллах боломж бүрдэж байна.

- Багшийн бүлэг болон нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах цаг хэмнэгдсэнээр ээлжит хичээлд чанартай бэлтгэх боломж бүрдэж ээлжит хичээлд 2-19 хувийн чанарын ахиц гарлаа.
- Энэхүү хөтөлбөр нь шинэ төгсөгч болон туршлага багатай багш нарын сургах үйл ажиллагааг зөв чиглүүлэх, багшлах зөв дадалтай болоход нэлээд ач холбогдолтой байгааг багш нараас авсан судалгаа илрүүлсэн болно.

Бид сургуулийн монгол хэлний хөтөлбөрөөс гадна 1-3 дугаар ангийн хүн ба орчин хичээлийн хөтөлбөр боловсруулсан бөгөөд мөн энэхүү хөтөлбөрийн хэмжээнд хүрсэн. Мөн математикийн хөтөлбөр боловсруулан туршиж сайжруулаад 2 дахь жилдээ ажиллаж байна.

Сургууль бүр өөрийн сургуулийн онцлогт тохирсон сургуулийн хөтөлбөрийг судлагдахуун тус бүрээр боловсруулж багшийг ажлын байран дээр нь хөгжүүлэхээс гадна багшийн ажлыг хөнгөвчлөх замаар сургалтын чанарт ахиц гаргах боломж байгааг энэхүү илтгэлээрээ туршага болгон түгээж байна.

Энэ хичээлийн жилд бид суралцагчдын шинэ үнэлгээний журманд нийцүүлэн бүлэг сэдвийн үнэлгээг сайжруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

НОМ ЗҮЙ:

1. Монгол улсын бага боловсролын цөм хөтөлбөр
2. Монгол улсын суурь боловсролын цөм хөтөлбөр
3. Бага боловсролын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмжүүд
4. Ш. Оюунцэцэг, Ө Хадаа ... нарын Монгол хэл-I Багшийн ном
5. Ш. Оюунцэцэг, Ө Хадаа ... нарын Монгол хэл-I сурах бичиг
6. Г. Бямбасүрэн, В. Хажидмаа ... нарын Монгол хэл-II Багшийн ном
7. Г. Бямбасүрэн, В. Хажидмаа ... нарын Монгол хэл-II сурах бичиг
8. Монгол хэл-III Багшийн ном
9. Монгол хэл-III сурах бичиг
10. П. Одсүрэн, Б. Гэрэлсайхан ... нарын Монгол хэл-IV Багшийн ном
11. П. Одсүрэн, Б. Гэрэлсайхан... нарын Монгол хэл-IV сурах бичиг
12. Л. Олзвой, Б. Оюунцэцэг ... нарын Монгол хэл-V Багшийн ном
13. Л. Олзвой, Б. Оюунцэцэг ... нарын Монгол хэл-V сурах бичиг
14. Ц. Өнөрбаян, Л. Жумдаан ... нарын Монгол хэл-VI Багшийн ном
15. Ц. Өнөрбаян, Л. Жумдаан ... нарын Монгол хэл-VI сурах бичиг
16. Д.Батболд,Д. Боловсролын зорилгын таксономын хөгжил, Боловсрол судлал сэтгүүл. Дугаар 2013/07
17. М.Ганбат, Б.Бурмаа, Д.Батболд, Физик сургалтын технологийн шинэчлэл, ЕБС-ийн багш нарын гарын авлага, УБ. 1998 он.
18. Батцэцэг.С, Батболд.Д, Суралцагчдын сурлага, хүмүүжлийн явцад үнэлгээ хийж буй нэгэн загварт шинжилгээ хийсэн нь, Боловсрол судлал сэтгүүл, 2014/09 (07)
19. Д.Батболд, Б.Алимаа, Г.Уугантуяа, Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн тулд багшлах арга зүй ямар байх ёстой вэ?, Боловсрол судлал сэтгүүл, 2014/02 (100), х.31-41.
20. Батболд.Д, Золбоо.Э, ЕБС-ийн суралцагчдын сурахуйн хэв шинжийг судалсан нь, “Шинэ зууны багшийн чадамж “ сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, МУБИС, УБ., 2014.05.08-09.
21. Батболд.Д, Багшлахуйд учир бий, УБ, 2017

Хичээлийн Төлөвлөлтөд Асуултыг Оновчтой Тусгах Арга Зүй

А.Батцэцэг, О.Бунданцэцэг, Л.Амгалан
Өвөрхангай аймгийн ЕБ-ын I сургууль

Хураангуй:

Түлхүүр үг: Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ, багшийн асуулт, хүүхдийн хариулт, нээлттэй ба хаалттай асуулт, хичээлийн төлөвлөлт, хичээлийн чанар

Зорилго: Багшийн асуулт ба хүүхдийн хариултын харилцан хамаарал нь хичээлийн чанарт хэрхэн нөлөөлөхийг судлахад оршино Орчин үед сургуулиудын бие даасан байдал, багш нарын ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэлтийг чухалчилж байна. Түүнчлэн багш нар харилцан хичээлд сууж, ажиглалт хийх, хэлэлцэх, хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр түлхүү ажиллах болсон.

Практик ач холбогдол: Энэхүү үйл ажиллагааны цаад зорилго нь хичээлийн чанарыг сайжруулахад оршиж байна. Хичээл амжилттай, үр өгөөжтэй болох нь багшаас олон төрлийн чадвартай байхыг шаарддаг. Тэр дундаа багшийн асуулт оновчтой байх нь хамгийн чухал юм. Манай ЕБ-ын сургуулиудын багш нар хичээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа хичээлийн төлөвлөлтөд тусгагдсан багшийн асуултыг төдийлөн нарийвчлан хэлэлцдэггүй. Энэ асуудал манай сургуульд ч байсан учраас бидэнд энэхүү бэрхшээлийг даван туулах зайлшгүй хэрэгцээ шаардлага гарсан.

Шинэ санаа: Иймд манай сургууль 2017 оны 3-р сараас хичээлийн судалгааны баг байгуулж ажиллаж эхэлсэн. Энэ хичээлийн жилд 4-р ангийн Байгалийн Ухааны 21 цагийн хичээлийг зааж хэлэлцүүлгийг “Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ” арга зүйгээр зохион байгуулсан. Энэхүү арга зүй нь товчоор хэлбэл хичээлийн үйл явцыг тэмдэглэл хэлбэрт оруулж түүн дээрээ хэлэлцэн хичээлийг сайжруулдаг. Хичээлийн тэмдэглэлээс харахад нэг ээлжит хичээл дээр багшийн тавьсан асуултын 45% нээлттэй, 55% хаалттай асуулт байна. Нээлттэй асуултанд сурагчид 4-5 үгээр буюу бүтэн өгүүлбэрээр, хаалттай асуултанд 1-2 үгээр товч хариулж байна. Хаалттай асуулт нь сурагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхгүй байгаа учраас энэ төрлийн асуулт нь асуултын дийлэнх хувийг хамарч болохгүйг харуулж байна.

Арга зүй: Бидний судалгаагаар хичээлийн тэмдэглэлд анализ хийх арга зүй нь асуултын зорилгыг тодорхойлж, нээлттэй, хаалттай асуултыг нэг бүрчлэн задалж авч үзэх, хувилбаргүй хаалттай асуултыг хэрхэн оновчтойгоор асуух, багшийн асуултанд хүүхэд хэрхэн хариулж байгааг хичээлийн тэмдэглэлээс харах, багшийн асуулт, хүүхдийн хариултын харилцан хамаарлыг судлах боломж олгож байна. Тиймээс бодит нотолгоон дээр суурилсан “Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ” арга зүйг багш бүр эзэмшснээр хичээлийн судалгааг асуултаас эхэлж, асуулт асуух чадвараа хөгжүүлээд зогсохгүй улмаар хүүхдийн хариултаас хичээлээ сайжруулах боломжтой болохыг энэхүү илтгэлээр танилцуулж байна.

Товч агуулга: Орчин үед сургуулиудын бие даасан байдал, багш нарын ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэлтийг чухалчилж байна. Түүнчлэн багш нар харилцан хичээлд сууж, ажиглалт хийх, хэлэлцэх, хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр түлхүү ажиллах болсон. Бид хичээлийн чанарыг сайжруулахдаа “Судалгаат хичээл – Хичээлийн судалгаа,” арга зүйг ихэвчлэн хэрэглэдэг. Хэдийгээр хичээлийн судалгаа нь хичээлийн агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, цаг төлөвлөлт гэх мэт олон зүйлийг судлах давуу талтай боловч багшийн асуулт, сурагчийн хариултын харилцан хамаарал, багш хичээлийн төлөвлөлтөнд асуултыг хэрхэн төлөвлөсөн эсэхийг нарийвчлан судлах боломж бага байгаа нь харагдсан.

Оршил

Орчин үед сургуулиудын бие даасан байдал, багш нарын ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэлтийг чухалчилж байна. Түүнчлэн багш нар харилцан хичээлд сууж, ажиглалт хийх, хэлэлцэх, хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр түлхүү ажиллах болсон. Энэхүү үйл ажиллагааны цаад зорилго нь хичээлийн чанарыг сайжруулахад оршиж байна. [1]

Бид хичээлийн чанарыг сайжруулахдаа “Судалгаат хичээл – Хичээлийн судалгаа,” арга зүйг ихэвчлэн хэрэглэдэг. Хэдийгээр хичээлийн судалгаа нь хичээлийн агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, цаг төлөвлөлт гэх мэт олон зүйлийг судлах давуу талтай боловч багшийн асуулт, сурагчийн хариултын харилцан хамаарал, багш хичээлийн төлөвлөлтөнд асуултыг хэрхэн төлөвлөсөн эсэхийг нарийвчлан судлах боломж бага байгаа нь харагдсан. [1]

Зорилго: Багшийн асуулт ба хүүхдийн хариултын харилцан хамаарал нь хичээлийн чанарт хэрхэн нөлөөлөхийг судлахад оршино

Зорилт:

- Ээлжит хичээлийн видео бичлэг хийх;
- Видео бичлэгийг үгэн тэмдэглэлд хөрвүүлэх;
- Хичээлийн тэмдэглэлийг уншиж, багшийн асуултад анализ хийх;
- Хэлэлцүүлэг хийх, хичээлийн төлөвлөлтийг сайжруулах;

Судалгааны арга зүй:

- Хичээлийн тэмдэглэлд анализ хийх арга замаар багшийн асуулт ба хүүхдийн хариултын харилцан хамаарлыг судална.

Судалгааны объект:

- Багшийн асуулт
- Сурагчдын хариулт
- Хичээлийн чанар

1. Үндсэн хэсэг

1.1. Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ гэж юу вэ?

- What is **Lesson Analysis**?
- a way for sharing values of the lesson (Hiroyuki KUNO, PhD Aichi University of Education, Japan)
 - Lesson analysis is **method** for analysis and reflection of the lesson based on the transcription (Matoba, Masami. Nagoya University)
 - Lesson Transcript:
Lesson Transcript is recorded lesson document in which all of comments by teacher and students are put in and sharable these values to others who was not observed that.

Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ хийх нэгэн аргачлал нь дараах алхмуудтай байна.

- Ээлжит хичээлийн видео бичлэг хийх;
- Видео бичлэгийг үгэн тэмдэглэлд хөрвүүлэх (WORD doc);
- Хичээлийн тэмдэглэлийг уншиж, хичээлийн үе шатуудыг тодорхойлох;
- Хичээлийн тэмдэглэлээс хичээлийн онцлог, мөн чанарыг харах, анализ хийх;
- Хэлэлцэх, төлөвлөлтийг сайжруулах;


Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализын давуу талуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

- Хичээлийн тэмдэглэлийг дахин дахин унших замаар хичээлийн гүнрүү орох, утгыг ойлгох боломжтой
- Хичээлийн зарим чухал хэсэг, үе шатыг сонгон төвлөрч судлах боломжтой;
- Хичээлийн тухай санамжаа удаан хугацааны турш хадгалах боломжтой;
- Хичээлд ажиглалт хийгээгүй хүмүүс тэмдэглэл ашиглан анализ хийх боломжтой;
- Бүхэл хичээлийг нэг өнцгөөр онцлон харах, анализ хийх боломжтой [2]

1.2. Туршилт, судалгааны хэсэг

Бид 2017-2018 оны хичээлийн жилийн II, III улирлын 4-р ангийн “Хүн ба байгаль” хичээлийн “Зай ашиглан чийдэн асаая”, “Юу цахилгаан дамжуулдаг юм бол?” “Цахилгаан дамжуулдаг ба дамжуулдаггүй бие” хичээлүүдийг багш “Б” зааж, хичээлийн видеог хийсэн. Хичээлийн видеог тэмдэглэлд хөрвүүлж, хичээлийн тэмдэглэлээс багшийн асуултанд анализ хийж, хичээлийг сайжруулан заасан.

Эхний хичээлүүдэд багшийн асуулт оновчгүй, хаалттай асуултын тоо олон байсан бол хичээлийн тэмдэглэлд анализ хийснээр, багшийн хичээлийн төлөвлөлтөөс харахад асуулт оновчтой, нээлттэй болж байна. Ийнхүү багшийн асуулт оновчтой болсноор сурагчдын хариулт олон үгээр, бүтэн өгүүлбэрээр болж байгаа нь хичээлийн чанар сайжирч байгааг харуулж байна.



Нээлттэй ба хаалттай асуултын тоог хичээл тус бүрээр үзүүлбэл:

Хичээлийн тэмдэглэлд анализ хийж

багшийн хаалттай асуултыг нээлттэй асуултаар сольж хичээлийн хөтөлбөрт тусгаж байна. Тухайлбал:

Хичээлийн тэмдэглэл дэх багшийн асуулт	Сайжруулсан асуулт
Асуултыг сайжруулсан байдал	
Тэгвэл чийдэн маань юуны тусламжтайгаар асдаг юм бол?	Утсаар юу юу дамжиж чийдэн асаж байна вэ?
Цахилгаан дамжсаны улмаас чийдэн маань яаж байгаа юм?	Цахилгаан дамжсаны улмаас юу ажиглагдаж байна вэ?
Энэ дотор юу юу байна вэ?	Хайрцагт юу юу байна гэж бодож байна вэ?
Хэрвээ чийдэн асахгүй бол яаж байна гэсэн үг үү?	Чийдэн ассангүй. Яагаад?
Бидний сонгосон материал цахилгааныг дамжуулдаг юм болов уу? Дамжуулдаггүй юм болов уу?	Хоорондоо материалаа солиод дахин туршаарай.

Багшийн асуултанд сурагчид хэрхэн хариулж байгааг дэлгэрэнгүйгээр үзүүлбэл:

“Хүн байгаль” хичээлийн “Зай ашиглан чийдэн асаая” хичээлийн тэмдэглэлийн асуултанд хийсэн анализ

Тус хичээлийн явцад багш сурагчдаас 19 асуулт асууснаас 8 нээлттэй асуулт, 11 хаалттай асуултыг асуусан байна. Сурагчид эдгээр асуултанд 1-4 үгээр, өгүүлбэрээр хариулсан байна. Үүнд:

1 үгээр – 8, 2 үгээр – 1, 3 үгээр – 0, 4 үгээр 3, Өгүүлбэрээр – 6, Огт хариулаагүй - 1

Д.д	Асуулт	Асуултын хэлбэр	1 үгээр	2 үгээр	3 үгээр	4 үгээр	Өгүүлбэрээр
1	За юу ажиглагдав?	Хаалттай		+			
2	Анги танхимыг гэрэлтүүлж байгаа гэрэл цацруулж байгаа энэ зүйлийг юу гэж нэрлэдэг юм бол?	Хаалттай	+				
3	Энэ юуны зураг вэ?	Хаалттай	+				
4	Энэ юу юм бол?	Хаалттай	+				
5	Хэрвээ хагалсан тохиолдолд ямар аюултай вэ?	Нээлттэй				+	
6	Энэ чидэн маань өдөр тутмын амьдралд хэрэгцээтэй байдаг юм бол?	Нээлттэй					+
7	Яагаад 2 өнгийн утас байгаа юм бол?	Нээлттэй				+	
8	Зургаа хараад тайлбарлаарай. Яагаад асаагүй вэ? Хэн тайлбарлах вэ?	Нээлттэй					+
9	2-р туршилт ассан уу?	Хаалттай	+				
10	Яагаад? Хэн тайлбарлах вэ? 2-р зураг аль холболтон дээр байх вэ?	Нээлттэй					+
11	3-р туршилт ассан уу?	Хаалттай	+				
12	Яагаад? Хэн тайлбарлах вэ?	Нээлттэй					+
13	За ассан уу? Хэн тайлбарлах вэ?	Хаалттай	+				
14	Өө зүйтэй. Тэгвэл аль холболтон дээр байрлах вэ?	Нээлттэй				+	
15	За бусад нь асахгүй байхад энэ яагаад асав?	Хаалттай					
16	За сайн байна. Тэгвэл энэ холболт хаана байрлах вэ?	Нээлттэй					+
17	Ассан уу?	Хаалттай	+				
18	Яагаад?	Хаалттай	+				
20	За өнөөдрийн хичээлээр юу мэдэж авав?	Нээлттэй					+
Бүгд	19 асуулт	9 нээлттэй 10 хаалттай	8	1	0	3	6

Судалгааны үр дүн:

Бидний судалгаагаар “Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ” арга зүй нь багшийн асуултын зорилгыг тодорхойлж, нээлттэй, хаалттай асуултыг нэг бүрчлэн задалж авч үзэх, хувилбаргүй хаалттай асуултыг хэрхэн оновчтой, нээлттэйгээр асуух, багшийн асуултанд хүүхэд хэрхэн хариулж байгааг хичээлийн тэмдэглэлээс харж, багшийн асуулт, хүүхдийн хариултын харилцан хамаарлыг судлах боломж олгож байна.

Дүгнэлт:

Бодит нотолгоон дээр суурилсан энэхүү арга зүйг багш бүр эзэмшснээр хичээлийн судалгааг асуултаас эхэлж, ээлжит хичээлийн төлөвлөлтөнд асуултыг оновчтой тусгаж, улмаар хүүхдийн хариултаас хичээлээ сайжруулах боломж бүрдэнэ гэж дүгнэж байна.

Ном зүй:

1. “Хүүхдийн хөгжил-Хичээлийн судалгаа” эрдэм шинжилгээний хурлын өгүүлүүд, 2014 он
2. Физик дидактик-2. 2016 он. Б.Бурмаа, М.Ганбат ба бусад
3. Бага боловсролын цөм хөтөлбөр, 2014 он
4. “Тэмдэглэлд суурилсан хичээлийн анализ” илтгэл 2015 он. Т.Ганбаатар МУБИС, МБУС Ж.Дэнсмаа, Боловсролын хүрээлэн, СБСОСС
5. Бага ангийн багшийн гарын авлага I, II, III, 2015 он
6. Хүн ба байгаль-4 сурах бичиг, 2014 он
7. Хүн ба байгаль-4 сурах бичиг багшийн ном, 2014 он
8. Жайка III зөвлөмж, Хүн ба орчин, Математик, 2009 он
9. Жайка III зөвлөмж, Физик, 2009 он
10. www.mnie.mn

ХАВСРАЛТ-1. Хичээлийн тэмдэглэл

4-р ангийн Хүн ба байгаль хичээлийн “Зай ашиглан чийдэн асаая” сэдвээр заасан хичээлийн тэмдэглэл

2018-01-27

Үе шаг	Цаг	№	Нэрс	Хичээлийн үйл ажиллагааны тэмдэглэл	
Хичээлийн эхлэл хэсэг		1	Б	Сайн байцгаана уу? Сайхан амарцгаасан уу?	
		2	С	Сайн сайхан амарсан.	
		3	Б	За суушгаа.	
		4	Б	Өнөөдөр бүгдээрээ хамтран Хүн байгаль хичээлийг явуулна.Хичээлдээ идэвхтэй сайн оролцоорой.	
		5	Б	За тэр хамгийн цаана сууж байгаа охин унтраалгаа нэг дараадахдаа.	
		6		За юу ажиглагдав?	
		7	С	Гэрэл ассан.	
		8	Б	За гэрэл ассан.Анги маань гэрэл гэгээтэй болсон байна.Анги танхимыг гэрэлтүүлж байгаа, гэрэл цацруулж байгаа энэ зүйлийг юу гэж нэрлэдэг юм бол?	
		9	С	Чийдэн	
Хичээлийн орнол хэсэг		10	Б	За өнөөдрийн хичээлийн сэдэв маань Зай ашиглан чийдэн асаая\Багш самбарт сар. Өдөр сэдвээ бичлээ.\	
		11	С	Сурагчид хичээлийн сэдвээ уншив.	
		12	Б	Хичээлийнхээ зорилготой танилцъя.Зорилгоо самбарт байрлуулав.	
		13	С	Зорилгоо уншив.	
		14	Б	За бүгдээрээ үүнийг хамтдаа нэрлэе.Энэ юуны зураг вэ?	
		15	С	Чийдэн	
		16	Б	За чийдэн байх нь.За энэ ?	
		17	С	Зай	
		18	Б	Зай буюу батерей. За энэ?	
		19	С	Чийдэнгийн суурь	
		20	Б	За зайгаа энэ суурин дээр байрлуулж чийдэнгээ асаана тиймүү? Энэ юу юм бол?	
		21	С	Холбогч утас	
		22	Б	Өө зүйтэй бид нар энэ чийдэнг асаахын тулд заавал холбогч утас хэрэг болно. Үзүүлсэн зурагнуудаа самбарт байрлууллаа.Багш нь баг бүрт зай, чийдэн, холбогч утас өгсөн байгаа.За эдгээртэй зөв харьцахын тулд юуг анхаарах вэ гэвэл анхааруулгаа уншаарай.Самбарт байрлуулв.	
		23	С	Сурагчид анхааруулга уншив.	
		24	Б	За чийдэнг унагаж хагалахаас болгоомжилно. Хэрвээ унагаж хагалахын бол гар хүрэлгүй багшдаа хэлэх нь байна.хэрвээ хагалсан тохиолдолд яах аюултай билээ?	
		25	С	Гар хуруугаа зүсэх аюултай.	
		26	Б	Өө гар хуруугаа зүсэх аюултай учраас болгоомжтой харьцах нь байна.Энэ чийдэн маань өдөр тутмын амьдралд ямар хэрэгцээтэй байдаг юм бол?	
		27	С	Гэрэл асаана.харанхуйг гэрэлтүүлж өгнө.	
		28	Б	Өө зүйтэй.Өөр? за ерөөсөө л харанхуйг гэрэлтүүлж гэрэл гэгээтэй болгож өгдөг өдөр тутмын хэрэгцээ юм.За тэгвэл багш нь багуудад хэрэглэгдэхүүн өгсөн байгаа.Ямар холболт хийж чийдэнг асаах вэ? Утсан дээр тайлбар хийе.яагаад 2 өнгийн утас байгаан бол?	
		29	С	Нэг нь нэмэх, нөгөө нь хасах	
		30	Б	2 утсаа чийдэн зайгаа ашиглаад ямар холболт хийвэл чийдэн асах уу? Бодоод багахан туршилт хийгээрэй багаараа хамтраад. За багаараа хамтраад хийгээрэй. Багт 6 хүүхэд байгаа учраас 3,3-аараа туршилтаа хийж болно.	
		31	С	Сурагчид 3,3 аараа туршилтаа хийж байна.	
		32	Б	За эднийх эхний чийдэнгээ асаасан сайн байна.Холболтоо ажиглаад сууж байгаарай. Бусад нь туршилтаа үргэлжлүүлээрэй.	
	8 мин		33	С	1-р баг холболтоо амжилттай хийж чийдэнгээ асаасан.Туршилт үргэлжилсээр...
			34	Б	За эднийх асаасан. Холболтоо ажиглаарай.Маш мундаг. Янз бүрээр туршилтаа хийж үзээрэй.Яаж холбовол асах боломжтойг.Асаасан багууд холболтоо ажиглаад сууж байгаарай.Багш багуудад очиж тайлбарлалт хийж байна.
			35	С	Хоорондоо ярилцаад туршилтаа хийж байна.Багууд туршилтаа хийж дууссан.


	36	Б	За бүгдээрээ анхааръя.3-р баг хараахан асааж амжсангүй.бүгд амжилттай асаасан сайн байна.Багууд эхнээсээ багийнхаа гишүүдийг дугаарлаарай.
	37	С	Эхнээсээ тоолж гишүүдээ дугаарласан.
	38	Б	За баг болгоноос 2,2 хүүхэд гарч ирээд сая хийсэн туршилтаа бусаддаа тайлбарлаж өгье.Хэрхэн яаж асааснаа холболтоо тайлбарлаад өгөөрэй.За эдний баг хэрхэн яаж холбосныг ажиглаарай.
	39	С	Сурагчид холболтоо амжилттай хийж үзүүлж байна.
	40	Б	Сайн байна баяр хүргэе.Сүүлийн баг арай өөр холбосон байна. Үүн дээр тайлбар хийв\ За наашаа анхаараарай.Зайн дээр тайлбар хийв.Нэмэх шон буюу нэмэх туйл дээрээ нэмэх утсаа, хасах шон буюу хасах туйл дээр хасах утсаа холбоно.Тиймүү?
	41	Б	Асааж амжаагүй баг дараагийн үйл ажиллагаанаас хэрхэн яаж асаах талаар сурч авна.За баг бүрт ажлын хуудастарааж өгсөн байгаа.6 зураг байгаа.Энэ зургийнхаа дагуу туршилт хийнэ.2,2-оороо туршилтыг хийнэ.Туршилт хийж байгаа 2 сурагчаа бусад нь сайн ажиглана.Хэрвээ асаж байх юм бол зөв тэмдэглэгээ хийнэ асахгүй тохиолдолд х тэмдэглэгээ хийнэ. За багийн 1,2-р гишүүн туршина.Бусад нь ажиглаж тэмдэглэгээ хийнэ.
	42	С	Туршилтаа хийж байна.Туршилтаа хийж дууссан.
	43	Б	Ассан холболт Асаагүй холболт гэж самбарт байрлуулсан.1-р туршилтаа самбарт байрлуулсан.Яагаад асаагүй вэ?Хэн тайлбарлахуу?
	44	Х	Яагаад гэвэл нэг утсаар залгасан хасах цэнэгтэй утас байхгүй. Х гэсэн тэмдэглэгээгээ ажлын хуудсан дээр тэмдэглэв.
	45	Б	Зурган дээр нэмэлт тайлбар хийв.2-р туршилтыг багийн 3,4-р гишүүн хийгээрэй.Бусад нь ажиглаарай.
	46	С	Туршилтыг хийж дууссан.
	47	Б	2-р туршилт ассан уу?
	48	С	Асаагүй
	49	Б	Яагаад? Хэн тайлбарлах уу? 2-р зураг аль холболтон дээр байх уу?
	50	Х	Асаагүй холболтон дээр.Яагаад гэвэл хасах цэнэгтэй утас нь зайныхаа эх биен дээр наалдсан учраас асаагүй.Х тэмдэглэгээг хийв.
	51	Б	2-р зурган дээр тайлбар хийв. За 3-р туршилтыг багийн 5,6 гишүүн хийгээрэй.Бусад нь ажиглаад тэмдэглэгээг хийгээрэй.
	52	С	5,6 гишүүн туршилтаа хийж байна.Бусад нь ажиглаад тэмдэглэгээг хийж байна.
	53	Б	За наашаа анхаар.3-р туршилт ассан уу?
	54	С	Асаагүй
	55	Б	Яагаад? Хэн тайлбарлах уу?
	56	Х	Нэмэх цэнэгтэй утас байхгүй учраас асаагүй.
	57	Б	3-р зурган дээр нэмэлт тайлбар хийв.Аль холболтонд хамаарагдах уу?
	58	С	Асаагүй холболт Х тэмдэглэгээг хийв.
	59	Б	За дараагийн холболт буюу 4- р туршилтыг багийн 1,6 гишүүн туршаарай.Бусад нь ажиглаарай.
	60	С	Ажлын хуудасныхаа зургийг ажиглаад холболтоо хийж байна.
	61	Б	Багуудад тайлбар хийж байна.
	62	С	Туршилтаа хийж дууссан.
	63	Б	За ассануу? Хэн тайлбарлах уу?
	64	С	Асаагүй
	65	Х	Зайныхаа эх биен дээр нь 2 утас маань байсан учраас асаагүй.
	66	Б	Өө зүйтэй.Тэгвэл аль холболтон дээр байрлах уу?
	67	С	Асаагүй холболтон дээр байна.
	68	Б	За 5-р туршилтыг багийн 2,5-р гишүүн хийгээрэй.Бусад нь ажиглаад тэмдэглэгээг хийгээрэй.
	69	С	Туршилтаа хийж байна.Асаж байна.4-р баг асахгүй байна.
	70	Б	4-р баг арай л буруу холбоод байна даа.Зургаа сайн хараарай.
	71	Б	За бусад нь асахгүй байхад энэ яагаад асав?
	72	С	Зөв холбосоон учраас.Нэмэх хасах утсаа зөв холбосон учраас ассан.
	73	Б	За сайн байна. Тэгвэл энэ холболт хаана байрлах уу?
	74	С	Ассан холболтон дээр. Зөв тэмдэглэгээг хийнэ.
	75	Б	За хамгийн сүүлийн туршилт буюу 6-р туршилтыг багийн 2,5 гишүүн гүйцэтгээрэй.
	76	С	Туршилтаа хийж байна.
	77	Б	Энэ баг маш сайн туршиж байна.

	78	С	Туршилтаа хийж дууссан.	
	79	Б	За тэгвэл наашаа анхааръя.Ассан уу?	
	80	С	Асаагүй.	
	81	Б	Яагаад?	
32мин	82	С	Яагаад гэвэл 2 утсаа хоёуланг нь нэмэх туйлаас авсан байна.	
	83	Б	За тэгвэл тэмдэглэгээгээ хийгээрэй.За энэ 6 туршилтаас хэд нь асаад хэд нь ассангүй вэ?	
	84	С	1 нь асаад 5 нь асаагүй.	
	85	Б	Ассан холболтын зургийг самбарт байрлуулав.Ажиглаарай хүүхдүүдээ.Яг энэ холболтоор ассан уу?	
	86	С	Мөн байна.Энэ холболтоор ассан.	
	87	С	Буруу.	
	88	Б	Яагаад?	
	89	С	Улаан нь хасах дээрээ байна.	
	90	Б	За энэ бол монголчууд ерөнхийдөө Улаан утсыг нэмэх хар утсыг хасах гэсэн ойлголттой байдаг.2 өөр өнгийн утас л байвал болно.	
	91	Б	За багш нь нэг юм тайлбарлая.Энэ баг ийм холболт хийгээд асаагүй.2 утсаа хоёуланг нь чийдэнгийнхээ доод туйл дээр хүргэсэн учраас асаагүй.Хасах утсаа доод туйлд нь,нэмэх утсаа чийдэнгийнхээ хажуу резвотой хэсэг дээр нь хүргэж байж чийдэн асна.Ингэж холболтоо зөв хийнэ шүү.	
Хичээлийн төгсгөл хэсэг		92	Б	Ажлын хуудсаа дэвтэртээ сар өдрөө бичээд дэвтэртээ наагаарай.
	36мин	93	С	Дэвтэртээ нааж байна.
		94	Б	За наачихсан уу?
		95	С	Наасан.
		96	Б	Сурах бичгээ нээгээрэй.Хуудас 34 самбарын зургийг ажиглаарай.Ассан үеийн холболтыг ажиглаарай.
		97	С	Бүгд ассан байна.Ийш тийшээ харсан байна.
		98	Б	Өө зүйтэй.Чийдэнгийн байрлал хамаарахгүйгээр яг энэ холболтоор зөв холбосон бол асах ёстой.Ассан үеийн холболтоо сайн ажиглаарай.
		99	Б	Асаагүй холболт буюу аюултай ямар ямар холболт байдгийг хэлж өгье.
		100	Б	1.Шалбарсан хэсгийг хооронд нь наалдуулж болохгүй. 2.Зайныхаа 2 туйлыг нэг утсаар холбож боолохгүй.Үүнийг богино холболт гэж нэрлэдэг. 3.2 утсаа нийлүүлээд чийдэнгийн доод туйлд хүргэж болохгүй. Эдгээрийг аюултай холболт гээд байгаа юм.
		101	С	Утас нь халаад шатах аюултай.
		102	Б	Зүйтэй сайн байна.Ийм холболт хийж болохгүй.
		103	Б	За өнөөдрийн хичээлээр юу мэдэж авав?
	104	С	Чийдэн асааж сурлаа.Зөв холболт хийж сурлаа.Бас аюултай холболтыг мэдэж, туршиж үзлээ.	
40мин 23сек	105	Б	За хичээлд идэвхтэй оролцсон сурагчдадаа баярлалаа.	

ХАВСРАЛТ-2. Хичээлийн хэлэлцүүлэг

Хичээлийн тэмдэглэлд анализ хэлэлцүүлэг хийхэд багш нар “Зай ашиглан чийдэн асаая” хичээл дээр багшийн асуултыг нээлттэй, хаалттайгаар нь ангилж ярилцсан ба ерөнхий зүйлсийг хэлэлцэж байсан.


Харин дараагийн “Юу цахилгаан дамжуулдаг юм бол?” Хичээлийн тэмдэглэлд анализ хийж, хэлэлцүүлэг хийх үед багш нар хаалттай асуултыг хэрхэн нээлттэй асуултаар солих талаар хэлэлцэж асуултыг өөрчилж хичээлийн хөтөлбөрөө сайжруулж, хэрэглэгдэхүүнийг сайжруулах санал гарч, хичээлийн үе шатыг хэлэлцэж, ажлын хуудсыг сайжруулах олон санаа гарч хэлэлцүүлэг нэлээд хичээл рүү орж ярилцаж байгаа ахиц гарч байна.



Хичээлийн хэлэлцүүлгийн бичлэгийг хийж, багш нэг бүрээр хэлэлцүүлэгт хэлсэн зүйлсийн тэмдэглэл хийж байна.

Хичээлийн тэмдэглэлд анализ хийж багшийн асуултыг нээлттэй асуултаар сольж хичээлийн хөтөлбөрт тусгаж байна. Тухайлбал:

Хичээлийн тэмдэглэл дэхь багшийн асуулт	Сайжруулсан асуулт
Асуултыг сайжруулсан байдал	
Тэгвэл чийдэн маань юуны тусламжтайгаар асдаг юм бол?	Утсаар юу юу дамжиж чийдэн асаж байна вэ?
Цахилгаан дамжсаны улмаас чийдэн маань яаж байгаа юм?	Цахилгаан дамжсаны улмаас юу ажиглагдаж байна вэ?
Энэ дотор юу юу байна вэ?	Хайрцагт юу юу байна гэж бодож байна вэ?
Хэрвээ чийдэн асахгүй бол яаж байна гэсэн үг үү?	Чийдэн ассангүй. Яагаад?
Бидний сонгосон материал цахилгааныг дамжуулдаг юм болов уу? Дамжуулдаггүй юм болов уу?	Хоорондоо материалаа солиод дахин туршаарай.



ХАВСРАЛТ-3 Тэмдэглэлд суурилсан судалгаат хичээлийн “Зай ашиглан чийдэн асаая” сэдвээр хийсэн хичээлийн анализ

Хэлэлцсэн асуудалууд:

Код	Хичээлийн явцад	Сайжруулах санаа
5Б	Оновчтой асуулт	Хичээлээ маш сайн сэдэлжүүлсэн.
8Б	оновчтой асуулт	Асуулт оновчтой байсан учраас сурагчид маш ойлгомжтой хариулт өгсөн
16Б	хаалттай асуулт	Багш бүтэн өгүүлбэрээр асуултаа асуух
18Б	Хаалттай асуулт	Багш бүтэн өгүүлбэрээр асуултаа асуух
22Б	Хүүхдүүдээ их ойр оновчтой асуулт байсан	Асуулт маш оновчтой байсан
28Б	Асуултанд сул үг орсон	Багш асуултандаа сул үг хэрэглэхгүй байх
29С	Хүүхдүүдээ зөв чиглүүлсэн	Багшийн асуулт оновчтой байсан учраас хүүхдүүд асуултанд сайн хариулсан.
34Б	Аман үнэлгээгээ сайн өгсөн	Сурагчдыг маш сайн урамшуулсан.
40Б	Үнэлгээгээ оновчтой өгсөн	Багш хичээлээ зөв чиглүүлсэн.
43Б	Яагаад ? нээлттэй асуулт	Асуулт оновчтой байсан.
50Х	Зөв оновчтой хариулж байсан	Сурагч бүтэн өгүүлбэрээр, шинжлэх ухааны үндэслэлтэй маш оновчтой хариулсан.
71Б	асуулт буруу	Бусад холболт асахгүй байхад энэ холболт яагаад ассан бэ?
72С	Бүтэн өгүүлбэрээр хариулж байсан	Сурагчид бүтэн өгүүлбэрээр маш сайн хариулж байсан.
77Б	Хүүхдүүдийг сайн чиглүүлсэн	Багшийн заах арга барил чиглүүлэх үйл ажиллагаа сайн байсан.
90Б	Сайн зөвлөгөө өгсөн	Энэхүү холболтыг хийхэд 2 өөр өнгийн утас байхад болно гэдгийг сайн ойлгуулж байсан.
98Б	Тайлбараа зөв үед өгсөн	Чийдэн асааж чадсан багуудад зөвлөлгөө тайлбарыг сайн өгч байсан.
103С	Дүгнэлт зөв хийгдсэн	Хичээлээ хэрхэн ойлгосоноо сурагчид бүтэн өгүүлбэрээр оновчтой дүгнэсэн.

Ухаалаг Дэвтрийн Үйл Ажиллагааг Дэмжих Замаар Сургалтын Чанарыг Сайжруулах нь

Б.Урантогос, Г.Энхжаргал
Дундговь аймаг “Мандал” сургууль

Оршил

Сурагч хүнийг тодорхойлдог хамгийн гол зүйл бол түүний хичээлийн дэвтэр байдаг билээ. Дэвтрээ цэвэр гамтай хэрэглэхээс эхлээд хэрхэн харьцаж байгаагаар нь тухайн сурагчийн хүмүүжил төлөвшил, хичээл сурлагын байдал тодорхой харагддаг. Иймээс тухайн хичээлийн дэвтэр нь гадна хавтас, дотоод бүтцээс эхлээд сурагчдын мэдлэг, мэдээлэл хийгээд сурахуйд нь дэмжлэг үзүүлсэн байх шаардлага тулгараад байна. Тухайлбал хичээлийн дэвтрийн нүүр болох хавтсан дээр зүй бусаар хувцасласан хүмүүсийн зураг, элдэв рок хэв маяг бүхий гавлын яс дүрслэгдсэн байх, эсвэл ахлах ангийн сурагчдын хэрэглэж байгаа дэвтэр нь хүүхэддэй киноны зураг, цэцэг навч, элдэв дүрс, хичээлтэй холбоотой бус утга нь ойлгомжгүй элдэв үг тэмдэглэгдсэн байх нь сурагчдын хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлөхөөс гадна монгол сурагчдад харь орны ханзаар бичсэн нүүр бүхий дэвтэр байх нь зохимжгүй гэж үзэж байна.

Сурагч бүрийн хэрэглээ, юманд хандах хандлага өөр өөр байдаг бөгөөд дэвтрийн голоос ураг, ард урд нь элдэв үг бичих, зай ашиглахгүй үлдээх зэрэг замбараагүй хэрэглээ их байгаа учраас дэвтрийн зохистой хэрэглээ буюу ухаалаг хэрэглээг маш чухлаар авч үзэх шаардлага байна. Түүнчлэн сурагчид нэг хичээлийн жилд нэг хичээл дээр 1-3 дэвтэр хэрэглэдэг бөгөөд ахлах дунд ангийн сурагчдын хувьд 10 гаруй хичээл дээр дэвтэр хэрэглэдэг. Дэвтрийн үнэ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа өнөө үед дэвтрээ зохисгүй хэрэглэж, үрэлгэн хандах нь өрх гэрийн эдийн засгийн хувьд ч хохиролтой зүйл юм. Мөн сурагчдын байнгын хэрэглээ болсон дэвтэр, номын гол түүхий эд болсон цаасыг модоор хийдэг бөгөөд цаасыг үр бүтээлгүйгээр үрэлгэн хандаж ихээр ашиглах нь тогтвортой хөгжлийн нэг гол үзүүлэлт болох байгаль экологийн хувьд ч хохиролтой үзэгдэл болоод байна.

Иймээс сурагч бүрийг хичээлийнхээ дэвтрийг үр бүтээлтэй ашиглах, хайрлаж гамнах, дэвтрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор “Ухаалаг дэвтэр”-ийг хичээл сургалтандаа ашиглах нь тал бүрийн ач холбогдолтой хэмээн энэхүү илтгэлээ бичлээ.

Судалгааны ажлын зорилго:

Сурагчдын өнөөгийн хэрэглэж байгаа дэвтэр, “ухаалаг дэвтэр” хоёрын хоорондох ялгааг харьцуулж, ухаалаг дэвтэр нь хичээл сургалтын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж буйг баримтаар нотолно.

Судалгааны ажлын зорилт:

- Сурагчдын хичээлийн дэвтрийн бүтэц дизайн болон дэвтэр ашиглалтанд ажиглалт хийж анализ хийх
- Сурагчдын хэрэгцээнд тулгуурласан “Ухаалаг дэвтэр”-ийг боловсруулж, турших
- Бидний өнөөгийн хэрэглэж байгаа дэвтэр болон ухаалаг дэвтрийн ялгаа болон ач холбогдлыг харьцуулах
- Дээрх судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж үр дүнг хэлэлцүүлэн “Ухаалаг дэвтэр”-ийг хэрэглэх нь сургалтын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж буйг баримтаар нотлох

Судалгааны ажлын таамаглал:

Судалгаанд дараах таамаглалыг дэвшүүлсэн. Үүнд:

- Сурагчдын одоогийн дэвтэр нь хавтаснаасаа эхлэн сурагчдын нас сэтгэхүйн онцлог, сурахуйд нь дэмжлэг болохуйц хэрэгцээтэй мэдээлэл байхгүй бөгөөд харин ч сурагчдын хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлөх утга агуулга бүхий элдэв зураг, бичиг үсэг нийтлэг байна. Түүнээс гадна сурагчид дэвтрийн хавтас болон арын хуудсанд өөрт хэрэгтэй зүйлсийг тэмдэглэх, зурах, тоглох, хичээлийн хуваарь тэмдэглэх, нэг дэвтэр дээр хоёр хичээл тэмдэглэх гэх мэтээр ашигласан байна. Иймээс сурагчдын мэдлэг, сурахуйд дэмжлэг үзүүлэхүйц дэвтрийг хичээл сургалтанд ашиглах хэрэгцээ хүүхэд бүрт байгаа нь хүүхдүүдийн дэвтрийг ашигласан доорх зургуудаас харж болохоор байна. Ийм зайлшгүй хэрэгцээ байгаа учраас сурагчдын сурах үйл болон сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц “ухаалаг дэвтэр” бүтээх шаардлага байна гэж үзлээ.

Сэдэв сонгосон үндэслэл:

Өнөөгийн хэрэглэж байгаа хичээлийн дэвтрүүд нь сурагчдын нас сэтгэхүйн онцлог болон хичээл сургалтын үйл ажиллагаанд тохиромжгүй, хүмүүжил төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц, зай

ашиглалт хангалтгүй, хаягдал ихтэй, эдийн засгийн хувьд үр ашиг муутай төдийгүй байгаль экологийн хувьд ч хохиролтой юм.

Иймд дээрх сөрөг үр дагавруудыг арилгаж сургалтын чанарыг сайжруулах үүднээс “Ухаалаг дэвтэр”-ийг бий болгож, сургалтандаа ашиглах зайлшгүй шаардлага тулгарч байгаа учраас энэхүү сэдвийг сонголоо.

Шинэлэг тал:

1980 оноос хойшхи дэвтрүүдийг харьцуулан судлахад дэвтрийн гадна хавтас, дизайн өөрчлөгдсөнөөс дотоод бүтцийн хувьд өөрчлөлт гараагүй байна. Харин “Ухаалаг дэвтэр”-ийг дэмжсэнээр сурагч, эцэг эх, багш, менежерүүдийн уялдаа холбоо сайжрах төдийгүй, сурагчдын хичээл сургалтын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөхүйц дэвтэр санаачилж, туршин үр дүн, ач холбогдлыг тодорхойлсон.

Арга зүй:

Энэхүү судлагааны мэдээллийг цуглуулахдаа агуулгын дотроос нь ажиглах, түүхчлэн судлах, харьцуулах, баримт бичиг судлах зэрэг судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн ба практикт өргөнөөр хэрэглэгддэг мэдээлэл боловсруулдаг программуудыг ашигласан. Мөн сонгож авсан сэдэвтэй холбогдох гарын авлага, ном зохиол.судалгааны материал, илтгэл зэргүүдийг ашигласан.

Түлхүүр үг:

- Ухаалаг хэрэглээ – Өдөр тутмын хэрэглээгээ зөв зохистой хэрэглэх
- Сургалтын үйл ажиллагаа- Сурах үйлийн оновчтой эрэмбэ дараалал
- Хичээлийн дэвтэр- Тухайн өдрийн хичээлээр олж авсан мэдлэгийн дагуу хийсэн үйл ажиллагааг тэмдэглэх талбар

I. Дэвтрийн түүхэн замнал

1.1 Цаасны үүсэл хөгжил ба бичгийн хэрэгслийн үүсэл

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа санаа бодлоо бие биедээ хэлээр илэрхийлж байсан боловч нүүр тулан харилцах боломжгүй үед бие биенээ ойлгох шаардлагын улмаас бичиг үүсчээ. Тухайлбал МЭӨ 25-20 мянган жилийн тэртээх хүмүүсийн агуйн хана, чулуун дээр зурж үлдээсэн элдэв амьтны сүг зургууд нь урлаг судлалын хувьд сонирхолтой баримт төдийгүй бие биедээ мэдээлэл үлдээж байсны хувьд, бичиг үсгийн түүхийн хувьд ч чухал зүйл юм.

Цаасыг анх МЭ-ний 105 онд Хятадад гар аргаар хийж эхэлсэн бөгөөд археологийн олдворын мэдээнээс үзэхэд, цаасыг хэдийнэ Хан-Династын үед (МЭӨ 206 -240) ахуй хэрэгцээнд хэрэглэж байсан нь нотлогдож, торгоны замын дагууд тархсан уламжлалт цаас үйлдвэрлэх арга техник Хятадын хилээс халин гарч... Ү зууны эхэн үеэс Төв Азид (Самарканд гэх мэт), ҮШ зууны эхээр Солонгос, Японд, ҮШ зууны үед Түвд болон Түвэдийн ойролцоох улсуудад харин XI зууны үеэс Арабын ихэнх оронд болон XII-XIII зуунд хойд Африкаар дамжин Испани, Итали улсуудад болон Европын төв, хойд, зүүн бүсийн орнуудад хөгжиж эхэлсэн байна



Дэлхийн түүхэнд Феодалын нийгмийн үед бичгийн анхны хэрэгсэл үүсч үнсэн самбар, муутуу цаас гэсэн хэлбэртэй байсан.



Үнсэн самбар: Тогооны хөөг тостой хольж жижиг банзан хавтсанд наалдуулан дээр нь үнс түрхэн мод, хулсан үзгээр бичдэг бичгийн хэрэглэл

Муутуу цаас: Олсоор хийсэн цаасыг хэлнэ.


Монголд өрнийн соёл дэлгэрснээр **зургийн дэвтэр** (зураг зурах, дүрслэх үдмэл цаас), **нотны дэвтэр** (нот тэмдэглэх үдмэл цаас), **өврийн дэвтэр** (а. Биедээ авч явах авсаархан жижиг дэвтэр; б. Тэмдэглэлийн дэвтэр), **санал гомдлын дэвтэр** (үйлчилгээтэй холбоотой сайн, саар зүйлийн талаар хувийн саналаа бичих дэвтэр), **сурлагын дэвтэр** (авсан дүнг нь бичиж эцэг эхтэй харилцах дэвтэр), **тэмдэглэлийн дэвтэр** (тэмдэглэл хөглөх зориулалттай бичиг цаас), **хадгаламжийн дэвтэр** (иргэдийн банканд мөнгөө хадгалуулсан тухай албан ёсны баталгаатай дэвтэр), **хичээлийн дэвтэр** гэсэн дэвтрийн олон төрөл нэмэгдсэн байна. Ардын хувьсгал ялж бага сургууль үүссэн цагаас эхлэн сурагчид хичээлийн дэвтрийг ашиглаж эхэлжээ. Тэр үед сурагчдын дэвтэр ОХУ-аас нийлүүлэгддэг байсан бөгөөд цулгай хавтастай, ихэвчлэн 12 хуудастай дэвтрийг ашигладаг байжээ.

1.2 Хичээлийн дэвтрийн түүхэн хөгжил

Хичээлийн дэвтрийг 1980-аад оноос хойш судлан үзвэл:



/Зураг 3/




/Зураг 4/




2000 оноос хойш дэвтрий хамтлаг дуучид, цэцэг навч, сонирхолын дагуу хавтсаа шинэчилсэн байна. Харин үнийн хувьд жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.


х дуртай кино сонсох дуртай



Гэв



гамнаас



зоогүйг

2.1 Өнөөгийн хэрэглэж буй дэвтрийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал



Сурагчдын өнөөгийн хэрэглэж буй дэвтрийн дизайн, бүтэц болон сурагчдын хэрэглээнд хийсэн ажиглалт:

Гадна талын хавтас дизайны хувьд: 1980 оноос хойшх дэвтүүдийг харьцуулан үзвэл

жилээс жилд өнгө үзэмжийн хувьд сурагчдын сонирхолыг татахуйц жишээлбэл: сонсдог хамтлаг дуучин, үзэх дуртай кино, чамин өнгө үзэмжийг хариулсан байна. Гэвч Эдгээр нь хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна.


Тухайлбал: **Жишээ 1.** Энэ бол 116 ангийн сурагч Г. Даваадоржийн Газарзүйн хичээлийн дэвтэр байна. Уг дэвтрийн нүүрийг ажиглавал газарзүйн хичээлтэй холбоотой нэг ч мэдээлэл байхгүй, хүүхэд үүнээс



ямар нэг зүйлийг бодож тунгаах, эрэгцүүлэх боломжгүй, нас сэтгэхүй онцлогт тохироогүй байна.



Жишээ 2. Дээрх дэвтрүүд нь 11а ангийн сурагч Ц.Буяннэмэх, 12б ангийн сурагч Х.Мөнхмагнай нарын дэвтрүүд байна. Эдгээр дэвтрийн зургууд нь сурагчдад буруу үлгэр дууриалал үзүүлэхүйц, хэт ил задгай байдлыг сурталчилсан байна. Үүнийг үзвэл сурагчдын хувцаслалт, биеэ авч явах байдал, охиод хөвгүүдийн харилцаанд

сөргөөр нөлөөлөх боломжийг



бүрдүүлсэн байна.

Жишээ 3. Дээрх дэвтрүүд нь 8б ангийн сурагч С.Цэрэнчунт, ба ангийн сурагч Дарханбат нарын дэвтэр байна. Утга агуулга тодорхой бус гадаад хэл бүхий бичээстэй дэвтэр хэрэглэх нь тэдний үндэсний хэл, түүх соёлыг үнэлэх үнэлэмжид сөргөөр нөлөөлж байна. Үүнээс үзвэл хичээлийн дэвтрийн гадна хавтасны өнгө үзэмж улам баяжиж өөрчлөгдсөөр байгаа ч сурагчдад тухайн хичээлтэй холбоотой сэдэл өгөхөөргүй, нас сэтгэхүйн онцлогт тохироогүй үндэсний хэл, түүх соёлоороо бахархах үзэлд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна, хувцаслалт, биеэ авч явах байдалд буруу үлгэр дууриал болсон агуулга бүхий байна гэж үзэж байна.





Харин дэвтрийн дотоод бүтцийн хувьд: Илүү дутуу тэмдэглэгээгүй, тууш, дөрвөлжин шугам бүхий дэвтэр дээр бичдэг байсан бол улаан талбай татаж багшид дүн бичих хэсэгтэй болгосноос өөр өөрчлөлт ороогүй байна. Сурагчдын хийх үйл ажиллагаа тодорхой бус учраас сурагчид дэвтрийн зайг ашигладаггүй, хичээл дээр хийх ажил, эзэмших чадвараа ойлгоогүйгээс юу ч хийхгүй он сар бичиж үлдээх гэх мэтээр зохисгүй хэрэглэсэн алдаа нийтэг байна.

2.1. Ухаалаг дэвтрийг бий болгох замаар сургалтын үйл ажиллагааг сайжруулах нь

Харьцуулсан хүснэгт

<u>Одоогийн хэрэглэж байгаа дэвтэр</u>	<u>Ухаалаг дэвтэр</u>
<i>Гадна талын хавтас, дизайны хувьд</i>	
	<p data-bbox="943 1255 1438 1367">Сурагчдад тухайн судлагдахуунаар үзэх хичээлийн сэдэл бүхий хичээлтэй холбогдсон зурагтай байна.</p>
Дотоод бүтэц, ашиглалтын хувьд	



Илүү дутуу тэмдэглэгээгүй, тууш, дөрвөлжин шугам бүхий дэвтэр дээр бичдэг байсан бол улаан талбай татаж багшид дүн бичих хэсэгтэй болгосноос өөр өөрчлөлт ороогүй байна. Иймээс сурагчдын дэвтрийн зай ашиглалт хангалтгүй байгаа нь дээр зургаас харгдаж байна. Мөн энэхүү дэвтрийн улаан талбай бүхий хэсэг нь тухайн нүүрийн зургааны нэгийг эзэлж байна. Тодруулбал багш хуудас бүр дээр тэмдэглэгээ хийдэггүй учраас нэг нүүрний зургааны нэг нь мөн ашиглагддаггүй бөгөөд хаягдал болон үлдэж байна.

Энэхүү дэвтэр нь зай ашиглалт маш сайн бөгөөд хуудсыг бүрэн ашиглах зорилгоор тухайн нүүрэнд бүрэн тэмдэглэгээ хийгдсэн байгаагаараа давуу талтай. Мөн өмнөх дэвтрийн ард, урдах хоёр хавтсыг ашигладаггүй бол “Ухаалаг дэвтэр” маань нүүрнийхээ хоосон зайд сурагчийн танилцуулгыг багтааж бүх боломжоороо ашиглаж нэг ч хаягдал гаргахгүй байлгах тал дээр анхаарч байгаагаараа давуу талтай.


Эдийн засгийн хэмнэлтийн хувьд

10-р ангид заавал судлах болон сонгон гүнзгийрүүлэх нийт 14 хичээлийн 18 ширхэг дэвтрийг ашигласан. Өмнөх жилийн дэвтрийн зах зээлийн үнийн дүнгээр нийт 18 ширхэг дэвтэр буюу нийт 780-н хуудастай дэвтрийг 11,300 төгрөгөөр худалдаж авсан. Үүнээс хичээлийн жил дуусахад ашиглагдаагүй үлдсэн дэвтрүүдийг хуудсыг тооцвол 156,5 хуудас бүхий 2266,12 төгрөгийн дэвтэр хаягдаж байна. Мөн дэвтрийн хуудас бүрт байх багшийн тэмдэглэл бүхий улаан шугамтай талбай нь тухайн хуудасны 1/6-ийг эзэлдэг бөгөөд энэ нь хичээлийн жилийн турш ашиглагдаж буй нийт дэвтрийн 130-н хуудас бүхий 1882,4 төгрөгийн дэвтэр ашиглагдахгүй хаягдаж байгааг харуулж байна. Дээрх дүгнэлтээс харахад хичээлийн жилийн эхэнд худалдаж авсан 780- хуудастай дэвтрийн 286,5-н хуудас үр ашиггүй хэрэглээг илтгэх бөгөөд 4148,52 төгрөгийн үнэ бүхий дэвтрийг ашиглахгүй хаяж байгаа нь харагдаж байна.


4-5 хичээлийн агуулга, сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх бусад мэдээллийг багтаасан “Ухаалаг дэвтэр”-ийг үйлдвэрлэхэд 4000 төгрөг ба тооноос хамааран үүнээс бага өртөгөөр хэвлэгдэх бүрэн боломжтой.

10-р ангийн нэг сурагчийн хувьд дэвтрийн ашиглаагүй зай талбайг мөнгөн дүнгээр тооцож үзвэл жилд дунджаар 4148,52 төгрөг болсон бөгөөд үүнээс үзвэл бидний санаачилсан 4-5 хичээлийн бүтэн жил ашиглах цогц дэвтрийг үр ашиггүй хаяж байна гэсэн үг юм. Иймд энэхүү үр ашиггүй хэрэглээг “Ухаалаг дэвтэр”-ийн хэрэглээгээр солих нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй нь харагдаж байна.

Байгаль экологийн хувьд




Сурагчид хичээлийн дэвтэр дээр яаж ажиллах заавар зөвлөлгөө байхгүйн улмаас дэвтрийг дутуу ашиглах, бага агуулгатай хичээл дээр зузаан хуудастай дэвтэр ашиглан түүнийг дуусгахгүйгээр дараагийн ангидаа орох, шинэ ангид орохдоо шинэ дэвтэр ашигладаг сул тал байдаг. Дэвтрийг цаасыг модоор хийдэг бөгөөд ингэж дутуу ашилах нь эргээд байгаль экологид сөрөг нөлөө авч ирдэг.



Энэ “Ухаалаг

дэвтэр” нь зай талбайг хэмнэсэн цаасны ухаалаг, гамтай хэрэглээг эрхэмлэн нэг ч хуудас, жаахан зай талбайг ашиглах зорилго бүхий бөгөөд хуучин дэвтрийн ашигладаггүй байсан хавцасны нүүрэн дээр сурагчийн хамгийн чухал мэдээлэл болох танилцуулгыг гаргаж өгснөөрөө давуу талтай.

Хичээл сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөх нь



бий болгодог

Уг дэвтэрт дөрвөлжин нүд, улаан шугамнаас өөр тэмдэглэл, чиглүүлэг байхгүй байгаа нь сурагдыг дэвтрээ мартах, шалгалтанд зориулж голоос нь урах, элдэв зураг зурах, зөвхөн он сар гарчиг тавьж өөр зүйл бичихгүй орхих, дэвтрээ алга болгох, хичээл бүр дээр дэвтэртэй учраас дэвтэр мартдаг зэрэг сул талуудыг

Уг дэвтрийн сургалтад нөлөөлж буй зэрэг шинжүүд:

Төрөл	Тоо
1. Хичээлийн материал	4
2. Хичээлийн материал	8
3. Хичээлийн материал	12
4. Хичээлийн материал	16
5. Хичээлийн материал	20
6. Хичээлийн материал	24
7. Хичээлийн материал	28
8. Хичээлийн материал	32
9. Хичээлийн материал	36
10. Хичээлийн материал	40
11. Хичээлийн материал	44
12. Хичээлийн материал	48
13. Хичээлийн материал	52
14. Хичээлийн материал	56
15. Хичээлийн материал	60
16. Хичээлийн материал	64
17. Хичээлийн материал	68
18. Хичээлийн материал	72
19. Хичээлийн материал	76
20. Хичээлийн материал	80

Хичээлийн материал	Тоо
1. Хичээлийн материал	4
2. Хичээлийн материал	8
3. Хичээлийн материал	12
4. Хичээлийн материал	16
5. Хичээлийн материал	20
6. Хичээлийн материал	24
7. Хичээлийн материал	28
8. Хичээлийн материал	32
9. Хичээлийн материал	36
10. Хичээлийн материал	40
11. Хичээлийн материал	44
12. Хичээлийн материал	48
13. Хичээлийн материал	52
14. Хичээлийн материал	56
15. Хичээлийн материал	60
16. Хичээлийн материал	64
17. Хичээлийн материал	68
18. Хичээлийн материал	72
19. Хичээлийн материал	76
20. Хичээлийн материал	80

1. Зай талбайн ашиглалт сайтай, хуудас бүр дугаартай учраас хуудас урах байдал арилна.
2. Аль хуудсанд ямар ухагдахуун байгааг товъёг дээрээс харах
3. Хичээлийн жилийн бүтцийн хуанлитай/сурагчид он сар харахаар заавал гар утас ашиглах шаардлагагүй хичээлийн дэвтрээсээ үзэх, мөн хичээл хэзээ амрах, орохоо дэвтэр дээрээсээ харахад болно/
4. Өөр зүйл зурах, сараачих, урах боломжгүй/хуудас бүр тоотой, хийх үйл ажиллагааг нь заасан байдаг жишээлбэл: шалгалт авах тусгай хэсэгтэй учраас шалгалтанд зориулж дэвтрийн голоос урах шаардлагагүй/
5. Хувийн мэдээлэлтэй учраас дэвтрээ хаяхгүй
6. Нэг дэвтэр дээр олон хичээл байдаг учраас дэвтэр мартагч тохиолдол гарахгүй.
7. Хичээл тус бүрийн чадварууд болон цагчилсан төлөвлөгөө байдаг учраас сурагчид багшийн хичээлд дүгнэлт хийх, дараагийн үзэх хичээлийнхээ сэдвийг мэдэж байгаа учраас уншиж судлах, аль хичээл орсон, ороогүйг хянах./сурагчид багшийг хянахаас гадна сургалтын менежер сурагчийн дэтрээр дамжуулан багшийг төлөвлөсөн цагаараа хичээл орсон үгүйг хянах, мөн эцэг эхчүүд хичээлд хяналт тавих давуу талтай /
8. Тухайн нэгжээр үзсэн хичээлийг яаж дүгнэх үнэлгээний шалгуурыг хавсаргасан ба сурагчид түүнд нийцүүлэн үнэлгээг хийлгэх өөртөө дүгнэлт хийх
9. Явцын үнэлгээ болон улирлын үнэлгээг дэвтэр дээр тэмдэглэн сурлагын дэвтэр шиг гарын үсгээр баталгаажуулна./Сурагч болон эцэг эхчүүд улирлын дүн болон жилийн эцсийн үнэлгээг хянах боломжтой, анги удирдсан багш 4-5 багшаас дүн авахын оронд ганц дэвтрээс 4-5 дүн авах боломжтой, АУБ нар сурагчдынхаа явцын үнэлгээнд хяналт тавьж чиглүүлэх гэх мэт/
10. Тухайн судалгдахууны хичээл бүрээр нэр томъёоны тайлбар, дүрэм, тодорхойлтыг ард нь хавсаргасан ба сурагчид түүнийг хичээл дээр ашиглах боломжтой.
11. Сурагчдад хэрэгтэй мэдээллээ тэмдэглэх боломж олгох /Жишээлбэл: Сурагчид хэрэгтэй утасны дугаар хүний нэр зэргээ дэвтрийнхээ аль нэг газар тэмдэглэхэд бол “Ухаалаг дэвтэр”-нд тусгай тэмдэглэлийн зайтай /
12. Сурагчдын хичээл сургалтандаа ашиглах хэрэгтэй веб сайтууд, мэдээ мэдээллүүдийг багтаасан

Дүгнэлт

Энэхүү илтгэлийг дүгнэн үзвэл: Монгол улсад бага сургууль үүссэн цагаас эхлэн сурагчид дэвтрийг ашиглах болсон бөгөөд дэвтэр нь гадна хавтас, дотоод бүтцээс эхлээд сурагчдын мэдлэг, мэдээлэл хийгээд сурахууд нь дэмжлэг үзүүлсэн байх шаардлагатай. Тухайлбал хичээлийн дэвтрийн нүүр болох хавтсан дээр зүй бусаар хувцасласан хүмүүсийн зураг, элдэв рок хэв маяг бүхий гавлын яс дүрслэгдсэн байх эсвэл 11,12 ангийн сурагчдын хэрэглэж байгаа дэвтэр нь хүүхэлдэйн киноны зураг, цэцэг навч, элдэв дүрс байхаас гадна утга нь ойлгогдохгүй, хичээлтэй холбоотой бус элдэв үг тэмдэглэгдсэн байх нь сурагчдын хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлөхөөс гадна өсвөр насны монгол сурагчдад харь орны ханзаар бичсэн нүүр бүхий дэвтэр байх нь зохимжгүй гэж үзэж байна.

Эдийн засгийн хувьд: Хичээлийн дэвтрний нэг нүүр 7,2 төгрөгөөр бүтдэг. Сурагч дэвтрээ дуустал нь ашиглалаа гэж бодоход хоёр хавтасны хоёр бүүр буюу 14,4 төгрөгийг дэвтэр тус бүр дээр хаяж байна. Мөн хичээлийн дэвтрийн нэг нүүрний улаан шугам татсан хэсгийг сурагчид ашигладаггүй бөгөөд энэ нь нийт дэвтрийн зургааны нэгийг ашиглахгүй хаяж байна гэсэн үг юм. Дээрхээс дүгнэвэл: өнөөгийн хэрэглэж байгаа дэвтэр нь хавтаснаас гадна зай ашиглалт байхгүй бөгөөд 10-р ангийн нэг сурагчийн дэвтрт хийсэн судалгаагаар ашиглаагүй зай талбайг мөнгөн дүнгээр тооцож үзвэл сурагч жилд дунджаар 4148, 52 төгрөг буюу бидний санаачилсан 4-5 хичээлийн бүтэн жил ашиглах цогц дэвтрийг үр ашиггүй хаяж байна гэсэн үг юм.

Байгаль экологийн хувьд: Цаасанд үрэлгэн хандах нь модны нөөцөд нөлөөлөх, экологийн тэнцвэрт байдал алдагдахад нөлөөлж байгаа учраас бид цаасны хэрэглээг улам боловсронгуй үр ашигтай болгож ажиллах нь чухал байна. “Ухаалаг дэвтэр”-ийн хувьд зай ашиглалт сайн, сурагчдын хувийн бүх тэмдэглэл байгаа учраас үрж хаяхгүй, гамтай хэрэглэх ба дэвтрийн үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгон аригч хямгач хандах зан чанарыг сурагчдад төлөвшүүлнэ.

Сургалтын үйл ажиллагааны хувьд: Энэхүү дэвтэр багшийн хувьд ажлыг хөнгөвчилсөн, сурагчдын ахиц амжилтанд анализ хийх боломжийг олгосон, эцэг эх, багш сурагчийн гурвалсан холбоог сайжруулах зэрэг давуу талуудтай. Жишээлбэл: гадна хавтаснаас эхлээд дэвтрийн хуудас нэг бүр нь сурагчдын сурах үйлийг хөтөлж чиглүүлсэн, ээлжит хичээл бүрийн оролцоог дэмжсэн, өөрийн ажлын төлөвлөгөөг гаргах, хичээлийн жилийн бүтэц болон хэзээ амрах, хэзээ шалгалт өгөхөө мэддэг болох, багшийн заасан хичээлээр ямар чадвар эзэмших, багш тухайн чадварыг олгоход чиглүүлж чадаж буй эсэхэд хяналт тавих, мөн хичээлд байнга ашиглагддаг нэр томъёо, дүрэм, тодорхойлтуудыг ашиглах, сурагчдад үйлийн алхамуудыг хийх хэсгүүдийг хувааж өгсөн нь аливаа мэдлэг мэдээллийг хураангуйлах чадварт сургах зэргээс үзэхэд “Ухаалаг дэвтэр”-ийг

цаашид хичээл сургалтанд ашиглахад сургалтын үйл ажиллагааны чанарыг сайжруулахад томоохон хөшүүрэг болно.

Иймээс ухаалаг дэвтрийн үйл ажиллагааг дэмжих замаар сургалтын чанарыг сайжруулах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Туршиж хэрэгжүүлсэн байдал:

Энэхүү дэвтрийг Дундговь аймгийн Сайнцагаан сумын “Мандал” Ерөнхий боловсролын сургуулийн илтгэлийн хамтарсан баг уг “Ухаалаг дэвтр”-ийг хамтран бүтээж Э.Сүрэнчулуун багштай 10 ангийн 26 сурагчдад 2017-2018 оны хичээлийн жилийн 1-р улиралд нийгмийн ухааны дээр туршиж хэрэгжүүллээ.

Арга зүй	Арга зүйн зөвлөмж	Хүрсэн үр дүн
-Ухаалаг дэвтр болон одоогийн дэвтрийн ялгааг таниулах	Хүүхдүүдэд дэвтрийг дахин ашиглах сэдэл өгөх. - Ухаалаг дэвтрийн хувьд сурагчийн олон мэдээллийг агуулсан учраас тухайн дэвтрийг хаях, дахин дахин солих шаардлагагүй бөгөөд өөрт чухал утасны дугааруудаа тэмдэглэх, тухайн хичээлтэй холбоотой тодорхойлт, нэр томъёонуудыг ашиглах зэрэг олон давуу тал байгааг тайлбарлах - Нэг дэвтр дээр олон хичээл тэмдэглэхийн давуу талыг эдийн засгаар харьцуулан үзүүлэх /36 хуудастай 1 дэвтр 650 төгрөг байдаг нийт.. хичээл ордог гэж үзвэл,, дахин дэвтр авбал... гэх мэтээр тооцоо хийж үзүүлэх / -Дэвтр буюу цаасны зохисгүй хэрэглээ нь экологийн тогтворгүй байдалд хүртэл чухал нөлөөтэй гэдгийг тайлбарлах нь зүйтэй	-Тухайн нэр томъёо, тодорхойлтыг мэдэхгүйн улмаас хичээлд идэвх муутай оролцох, хичээлээс хоцрох явдал багасна. -Тухайн хичээлээр эзэмших чадварыг багшийн тусламжгүйгээр мэддэг болно -Хувийн дэглэм, төлөвлөгөөг хийж сурах ба цаг төлөвлөлт сайжирч өөрийн хийсэн ажилдаа анализ хийх боломжийг хүүхдэд олгоно
Сурагчдад дэвтрийг ашиглах заавар зөвлөмжийг танилцуулах	-Дэвтрийн бүтэц ашиглалтыг хүүхдүүдэд тайлбарлах /тодруулбал: хичээлийн жилийн бүтэц амралт хэзээ эхэлж, хэзээ дуусах, ээлжит хичээлийн тэмдэглэгээг яаж хийх талаар нарийн тайлбар чиглүүлэг өгөх/ -Дэвтрийг хэр үр дүнтэй хэрэглэж байгаад хяналт тавих, чиглүүлэг өгөх	- Сурагчид дэвтрээ зориулалтын дагуу, зорилго чиглэлтэйгээр ашиглаж сурна -Дэвтрийн үнэ цэнийг ойлгох, хайрлах түүгээрээ өөрийн гэрийн өрхийн төсөвтөө хувь нэмрээ оруулна.

Санал зөвлөмж:

Сургалтын менежрийн хувьд:

1. Сурагчийн дэвтрийн үйл ажиллагаагаар багш сурагчийн үйл ажиллагааг хянах
2. Хичээлийн дэвтрээс тухайн хичээлийн агуулга, эзэмших чадваруудыг мэдэх
3. Ээлжит хичээлийн явцыг ажиглах зэрэг давуу талтай

Анги удирдсан багшийн хувьд:

1. Ангийнхаа хүүхдүүдийг бусад хичээл дээр хэр сурч байгаад дүгнэлт хийх
2. Эцэг эхүүдэд нь хүүхдүүдийнх нь талаар зөвлөмж өгөхөд тустай
3. Олон хичээлийн дүнг нэг дэвтрээс авах боломжтой

Эцэг эхийн хувьд:

1. Хүүхдүүдийнхээ хичээлд хяналт тавьж зөвлөмж өгөх
2. Багшийн үйл ажиллагааг хянах
3. Хүүхдийнхээ дүнд анализ хийх боломж олгох
4. Эдийн засгийн хувьд хэмнэлттэй

Сурагчийн хувьд:

1. Өөрийнх нь хувийн мэдээлэл байгаа учраас хаяж гээхгүй
2. Олон хичээл байгаа учраас дэвтрээ мартаг асуудал гарахгүй
3. Хичээлийнхээ хуваарийг тэмдэглэнэ

4. Өөрийн ажилдаа төлөвлөгөө гаргаж сурна
5. Багшийн үйл ажиллагааг хянаж болно
6. Өөрийнхөө явц, улирал, жилийн дүнд анализ хийх боломж олгох
7. Олон хичээлийг нэг дэвтэрт багтаасан учраас олон дэвтэр авч явах шаардлагагүй
8. Эзэмших чадвар, шалгуулах шалгуураа мэддэг болох
9. Эдийн засгийн хувьд хэмнэлттэй
10. Арвич, хямгач, цэвэр нямбай зан чанар төлөвшинө.
11. Өөрт хэрэгтэй мэдээллүүдээ дэвтрээсээ авах боломжтой

Ном зүй:


1. “Сургалтын арга”, Ц.Баасандорж 2002
2. “Монгол хэлний сурагчийн толь”, А.Янжиндолгор
3. “Нийгмийн ухаан I”, Л.Алтанзаяа, Ч.Алтангэрэл, Р.Дарьхүү, Д.Долгорсүрэн, Ч.Гажиддулам
4. “Нийгмийн ухаан II”, Л.Алтанзаяа, Ч.Алтангэрэл, Р.Дарьхүү, Д.Долгорсүрэн, Ч.Гажиддулам
5. “Багилахуйн менежмент”, Ч.Пүрэвдорж
6. “Өсвөр үеийнхний өөрийн хүмүүжил”, Заанхүү
7. “Нийгмийн тухай мэдлэг”, Д.Буян

Хавсралт: “Ухаалагдэвтэр”-ийн загвар

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН “МАНДАЛ” ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ**

Хичээлийн судлагдахуун: Нийгэм судлал

Ургийн овог: _____
Эцэг/эх/-ийн нэр, утас: _____
Сурагчийн нэр: _____
Гэрийн хаяг: _____
Facebook хаяг: _____
Утасны дугаар: _____
Дотны 3 найзын нэр, утас: _____



20.....-20.... оны хичээлийн жил

Товьёг

№	Бүтэц	Хуудасны дугаар
1	Хичээлийн хуваарь	3
2	Сурагчийн хувийн төлөвлөгөө	4
3	“Нийгмийн ухаан” хичээлийн цагчилсан төлөвлөгөө	5
4	Нийгмийн ухааны хичээлээр эзэмших чадварууд	6
5	Нийгмийн ухаан	7 -77
6	Үнэлгээний шалгуур	78
7	Түүхийн хичээлээр эзэмших чадварууд	79 – 80
8	Түүх	81 – 151
9	Үнэлгээний шалгуур	152
10	Монгол хэлний хичээлээр эзэмших чадварууд	153 – 154
11	Монгол хэл	155 – 225
12	Үнэлгээний шалгуур	226
13	Англи хэлний хичээлээр эзэмших чадварууд	227 – 228
14	Англи хэл	229 – 319
15	Үнэлгээний шалгуур	320
16	Үнэлгээний хэсэг /явц болон жилийн эцэс /	321 – 322
17	Нэр томъёоны тайлбар	323 – 327
18	Утасны жагсаалт	328
19	Цахим хуудас	329
20	Сурагчийн тэмдэглэл	330

Хичээлийн жилийн бүтэц

2017																											
Январь							Февраль							Март							Апрель						
Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд
					1		6	7	8	9	10	11	12	6	7	8	9	10	11	12	3	4	5	6	7	8	9
2	3	4	5	6	7	8	13	14	15	16	17	18	19	13	14	15	16	17	18	19	10	11	12	13	14	15	16
9	10	11	12	13	14	15	20	21	22	23	24	25	26	20	21	22	23	24	25	26	17	18	19	20	21	22	23
16	17	18	19	20	21	22	27	28						27	28	29	30	31			24	25	26	27	28	29	30
23	24	25	26	27	28	29																					
30	31																										
Май							Июнь							Июль							Август						
Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд
					6	7	1	2	3	4			1	2						1	2	3	4	5	6		
8	9	10	11	12	13	14	5	6	7	8	9	10	11	3	4	5	6	7	8	9	7	8	9	10	11	12	13
15	16	17	18	19	20	21	12	13	14	15	16	17	18	10	11	12	13	14	15	16	14	15	16	17	18	19	20
22	23	24	25	26	27	28	19	20	21	22	23	24	25	17	18	19	20	21	22	23	21	22	23	24	25	26	27
29	30	31					26	27	28	29	30			24	25	26	27	28	29	30	28	29	30	31			
Сентябрь							Октябрь							Ноябрь							Декабрь						
Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд	Пн	Вт	Ср	Чт	Пт	Сб	Нд
					2	3	1						1	2	3	4	5			1	2	3					
4	5	6	7	8	9	10	2	3	4	5	6	7	8	6	7	8	9	10	11	12	4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17	9	10	11	12	13	14	15	13	14	15	16	17	18	19	11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24	16	17	18	19	20	21	22	20	21	22	23	24	25	26	18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30		23	24	25	26	27	28	29	27	28	29	30			25	26	27	28	29	30	31	
							30	31																			

Хичээлийн хуваарь

1 дүгээр улирал					
Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1					
2					
3					
4					
5					
6					
7					

2 дугаар улирал					
Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1					
2					
3					
4					
5					
6					
7					

3 дугаар улирал					
Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1					
2					
3					
4					
5					
6					
7					

4 дүгээр улирал					
Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1					
2					
3					
4					
5					
6					
7					

Сурагчийн хувийн төлөвлөгөө

9 ДҮГЭЭР САР

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	

10-р ангий “Нийгмийн ухаан”-ы хичээлээр эзэмших чадварууд

№	Бүлэг сэдэв	Эзэмших чадварууд
1	<i>Нийгэм, нийгмийн харилцаа</i>	<ul style="list-style-type: none"> • Тоон болон чанарын өгөгдлүүдийг тайлбарлах аргачлал эзэмших • Тухайн цаг үед тохиож буй нийгмийн үзэгдэл, үйл явдлын шалтгаан, үр дагаврыг тодорхойлох • Нийгмийн бүрдэл хэсэг, тэдгээрийн уялдаа холбоог тулгуур ойлголтуудас ашиглан тайлбарлаж чаддаг болох • Гажуудлын эерэг хийгээд мөн чанарыг тодорхойлон, гэмт хэрэг, болзошгүй сөрөг үр дагавраас өөрийгөө хамгаалах
2	<i>Соёл</i>	<ul style="list-style-type: none"> • Соёл нь угсаа гарлыг нэгтгэдэг хүчин зүйл болохг эх сурвалжуудад үндэслэн нотлон тайлбарлах • Монголын угсаатны бүлгүүдийн сочлын талаар өгүүлсэн тоон болон чанарлаг баримтуудыг ашиглан тайлбарлах, дүгнэл хийх • Хувь хүн, бүлэг байгууллага, улс үндэстний сочлын оролцоо, хэрэглээ, чиг үүргийн хүрээнд асуудал дэвшүүлэн шийдвэрлэх
3	<i>Эрх зүй</i>	<ul style="list-style-type: none"> • Хүний эрхэм чанарын тухай ойлголт, онцлог шинжийг судлан тайлбарлах • Үндсэн хуулийн мөн чанар, ач хобогдол, суурь зарчмуудыг тодорхойлох • Захиргааны байгууллагын үйл ажиллагааны хэлбэр, ангиалал, практик хэрэглээний талаар судлан мэдэх, хувийн амьдралд хэрхэн нөлөөлдгийг ойлгох
4	<i>Эдийн засаг</i>	<ul style="list-style-type: none"> • Үндэсний эдийн засгийн нэмэлт үзүүлэлтүүд, тэдгээрийн мөн чанар, онцлог ялгаа, хоорондын холбоо хамаарлын талаар мэдэх • Эдийн засгийн нэмэлт үзүүлэлтүүдийг тооцоолох аргачлал эзэмших, хэрэглэх • Макро эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн үүрэг оролцоог таньж мэдэх, хэрэгжилтэнд үнэлэлт өгөх • Эдийн засгийн хүрээний хууль, ёс зүйг даган мөрдөж эрсдэлээс өөрийгөө сэргийлэх • Санхүүгийн харилцаанд ухаалгаар оролцох чадвар эзэмших

5	Улс төр	<ul style="list-style-type: none"> • Ардчиллын тулгуур үнэт зүйлсийг Монгол Улсын Үндсэн хуулин дахь иргэний эрх үүрэг, хариуцлагын тухай үзэл баримтлалтай холбон тодорхойлох • Ардчиллын үнэт зүйлсийг хэрэгжүүлэх эрмэлзлээ илэрхийлэх
6	Олон улсын харилцаа	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага олон улсын харилцааны оролцогч болохыг тайлбарлах • Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоо, түүний хэлбэр, чиглэлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг томъёолох

10-р ангийн “Нийгмийн ухаан” хичээлийн цагчилсан төлөвлөгөө

Улирал	Бүлэг сэдэв	Ээлжит хичээлийн сэдэв	Цаг
I улирал	Нийгэм, нийгмийн харилцаа	Нийгмийг тайлбарлах онол хандлагууд	2
		Нийгмийг хэрхэн судлах вэ?	2
		Судалгааны арга гэж юу вэ? / Бататгал явц /	2
		Нийгмийн бүтэц	2
		Нийгэмшилтийн тухай ойлголт	2
		Нийгмийн гажуудал / Бататгал явц /	2
	Соёл	Соёлын тухай ойлголт	2
		Соёлын чиг үүрэг	2
	Бүлэг сэдвийн шалгалт /30оноо/		
II улирал	Соёл	Монголын угсаатны бүлгүүд	2
		Соёлын өв / соёлын хэрэглээ /	2
		Соёлыг хэрхэн ангилах вэ? / бататгал явц /	2
		Соёлын оролцоо, хэрэглээ	2
		Соёлын хөгжилд хувь хүний үзүүлэх нөлөө / бататгал явц /	2
	Эрх зүй	Хүний эрхэм чанар	2
		Хүний эрхийн үзэл баримтлал	2
	Бүлэг сэдвийн шалгалт / 30 оноо /		
III улирал	Эрх зүй	Үндсэн хуулийн мөн чанар	2
		Эрх зүйд захирагдах нь / бататгал явц /	2
		Эрх зүйн харилцаа гэж юу вэ?	2
		Иргэн ба төрийн харилцаа	2
	Эдийн засаг	Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтүүд	2
		Эдийн засгийн нэгдмэл үзүүлэлт / бататгал явц /	2
		Эдийн засгийн өсөлт	2
		Ажилгүйдэл, инфляци түүний үр дагавар	2
	Бүлэг сэдвийн шалгалт / 30 оноо /		
IV улирал	Улс төр	Ардчилал, ардчиллын үнэт зүйлс	2
		Төрийн эрх мэдлийн хуваарилалт	2
		Засгийн газрын үйл ажиллагаа, хэрэгжилт / бататгал явц /	2
		Төр ба иргэн	2
	Олон улсын харилцаа	Олон улсын харилцаа гэж юу вэ?	2
		Олон улс дахь Монгол улсын оролцоо	2
		Монгол улсын олон улс дахь оролцооны хэлбэрүүд / бататгал явц/	2
		Монгол улсын гадаад харилцааны хэлбэрүүд	2

	<i>Бүлэг сэдвийн шалгалт / 30 оноо /</i>	2
<i>Нийт 70 цаг</i>		

Хичээлийн сэдэв: **Огноо:.....**

<i>Зорилго:</i>		
<i>Түлхүүр үг:</i>		
	<i>Үйл ажиллагаа</i>	<i>Нэмэлт тайлбар</i>
<i>Эхлэл хэсэг:</i>		
<i>Мэдээлэлтэй ажиллах:</i>		
<i>Мэдээлэл боловсруулах:</i>		
<i>Дүгнэлт, бататгал:</i>		
<i>Гэрийн даалгавар:</i>	<i>Багийн үнэлгээ:</i>	<i>Өөрийн үнэлгээ:</i>

Нэмэлт мэдээлэл / тэмдэглэл

10-р ангийн “Нийгмийн ухаан”-ы хичээлийн үнэлгээний шалгуур:

Бүлэг сэдэв	Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
Нийгэм, нийгмийн харилцаа	Нийгмийн судалгаа, нийгмийн бүтэц, нийгэмшилт, гажуудалд холбогдох ойлголтуудыг ашиглан бичих, илтгэх, уялдаа холбоонд нь авч үзэх	<ul style="list-style-type: none"> - Судлах агуулгаас асуулт, асуудлыг олж харах, таамаглалыг дэвшүүлэх - Судалсан агуулгаас үнэн зөв тодорхойлох - Хэд хэдэн хувилбарыг харьцуулж, үндэслэл сайтай хувилбарыг сонгож хамгаалах - Судалсан ойлголтуудаа ашиглан хэлэлцэх, бичих, илтгэх
Соёл	Соёлын амьдралтай холбогдох мэдээлэлтэй ажиллах, уялдаа холбоонд нь авч үзэх	<ul style="list-style-type: none"> - Соёлын хөгжилд хувь хүний оролцоо чухал болохыг илтгэн харуулсан мэдээлэл цуглуулах, мэдээлэлтэй ажиллах, боловсруулах, дүн шинжилгээ хийх - Мэдээллээ уншиж ойлгох, бүлэглэж төлөвлөх - Дүн шинжилгээний үр дүн, мэдээлэл баримтын утгыг тайлбарлах, дэвшүүлэх
Эрх зүй	Хүний эрх ба Үндсэн хууль, иргэд хоорондын харилцаа, иргэн ба төрөн харилцаанд холбогдох ойлголтуудыг ашиглан бичих, илтгэх, уялдаа холбоонд нь авч үзэх	<ul style="list-style-type: none"> - Хүний эрхэм чанар болон эрх зүйд захирагдах ёсны талаар өөрийн үзэл бодлоо бусадтай хуваалцах үнэлэт өгөх - Эрх эрх чөлөөг хуулиар хэрхэн хамгаалдаг талаар нотолгоо дэвшүүлэх - Өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлгээ дүгнэлтийг гаргах
Эдийн засаг	Судалсан агуулгын дагуу сэтгэх, эргэцүүлэх, эдийн засгийн хэлээр бичих, илтгэх	<ul style="list-style-type: none"> - Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтүүдийг нэрлэж, тэдгээрийн онцлог, ялгаа, логик холбоог тайлбарлах - Эдийн засгийн хүрээний хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх нь хувь хүн ба нийгэмд ямар үр дагаварт хүргэж болохыг эргэцүүлэх
Улс төр	Улс төрийн асуудалд холбогдох ойлголтуудыг ашиглан бичих, илтгэх, уялдаа холбоонд нь авч үзэх	<ul style="list-style-type: none"> - Төрөөс гаргаж буй шийдвэр, тэдгээрийн төрөл, ангилал, иргэдэд үзүүлж буй нөлөөллийн талаар судалж схем, зураглалаар илэрхийлэх - Төр засгаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар судалж, тодорхой шинжээр нь ангилж, ялган таних - Төрөөс гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаанд оролцох эрмэлзлэлтэй болох

“Нийгмийн ухаан” хичээлийн үнэлгээний хэсэг

10	Улирал	Үзүүлэлтүүд	Нэгж хичээлийн сэдэв / үйл ажиллагаа/	Үнэлэгдсэн байдал 1	Үнэлэгдсэн байдал 2	Багшийн тэмдэглэл /анхаарах зүйлс/
Нийгмийн ухаан	I улирал	Ирц 10%	Хичээлийн ирц			
		Явц 60%	Нийгмийн тухай ойлголт сэдвийн шалгалт			
			Хувь хүн ба нийгэм сэдвийн шалгалт			
			Бие даалт			
	Шалгалт 30%	Бүлэг сэдвийн шалгалт				
	I улирлын дүн					
	II улирал	Ирц 10%	Хичээлийн ирц			
		Явц 60%	Соёл, түүний ангилал сэдвийн шалгалт			
			Хувь хүн ба соёл сэдвийн шалгалт			
			Бие даалт			
	Шалгалт 30%	Бүлэг сэдвийн шалгалт				
	II улирлын дүн					
	III улирал	Ирц 10%	Хичээлийн ирц			
		Явц 60%	Хүний эрх ба эрх зүй сэдвийн шалгалт			
			Эдийн засгийн харилцааны нэгдмэл үзүүлэлтүүд сэдвийн шалгалт			
			Бие даалт			
	Шалгалт 30%	Бүлэг сэдвийн шалгалт				
	III улирлын дүн					
	IV улирал	Ирц 10%	Хичээлийн ирц			
		Явц 60%	Төр ба иргэн сэдвийн шалгалт			
			Олон улсын харилцаа сэдвийн шалгалт			
			Бие даалт			
	Шалгалт 30%	Бүлэг сэдвийн шалгалт				
	Жилийн эсийн үнэлгээ					

Танилцсан:

Анги удирдсан багш: /

Мэргэжлийн багш:..... /

Эцэг эх:..... /

Хичээлийн судалгааны тэмдэглэлд тулгуурлан сурагчдын сурах арга барилыг оношлох боломж

Д.Байгалмаа, А.Саранчимэг, Г.Бадамханд
Дорнод аймаг

УДИРТГАЛ

Сурагчдын сурах арга барилыг оношлох боломжуудыг судлах үндэслэл нь нэг талаас, дэлхий нийтийн боловсролын “Хүүхдийг суралцахад нь яаж сургах вэ?” гэсэн чиг хандлагаас урган гарсан шаардлага, нөгөө талаас хүүхэд бүрийг оношлох, хүүхдийн хөгжлийг тодорхойлох ажлыг багш бүр дорвитой хийж, хүүхдэд сурах арга барил эзэмшиж, хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх, сургах хэрэгцээгээр тодорхойлогдож байна. Тухайлбал: НҮБ-ын Боловсрол Соёл Шинжлэх ухааны байгууллагын Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтын хүрээнд 2030 он хүртэл дэлхийн боловсролын алсын харааг “Нэгдсэн зорилго хүсэл эрмэлзэлтэй, хүн бүрт хүрсэн боловсролын хөтөлбөрийг боловсруулна” [Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр БСШУЯ. 2015] хэмээн тодорхойлсон тул суурь, бүрэн дунд боловсролын түвшинд сурагчдын сурах арга барилыг оношлох тухай асуудал нь тулгамдсан асуудал болоод байна. Үүнд:

- Багш нарт сурагчдын сурах арга барилыг ганцаараа судалж тогтоох боломж нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал, судалгааны ажил хийх мэдлэг, чадвар дутмаг байна.
- Сурах арга барилыг тогтоох, үнэлэх нь баг хамт олноор сургуулийн түвшинд хийх ажил юм.

Сурган хүмүүжүүлэх ухаанд сурагчдад сурах арга барил эзэмшүүлэх асуудал зөвхөн өнөөдөр гарч ирээгүй юм. 17-р зууны сонгодог СХУ-ны үндэслэгчдийн нэг Я.А. Коменский сурган хүмүүжүүлэх өвийг судлахад “хүн харагдаж үзэгдэх юмыг хараагаар, сонсогдохуйц юмыг сонсогоор, үнэртэй юмыг үнэрлэх эрхтэнээр, амттай юмыг амтлах эрхтэнээрээ л мэдэрнэ гээд харин яаж ажиглах, хэрхэн сонсох арга ухааныг багш зүгшрүүлж өгөх нь чухал” гэж үзсэн байдаг. Судлаач Е.Н.Кабанова-Меллерийн тодорхойлсноор “Аливаа мэдлэгийг эзэмших үед бодитой илэрч байгаа хэд хэдэн үйлдэл хөдөлгөөнийг сурах арга гэнэ.” [Ш.Ичинхорлоо Сурах арга 2011] гэж үзсэн байна. Сурах арга барилыг хэрхэн эзэмшүүлэх талаар эрдэмтэн А.Загдаа нь “Оюун ухааны үйл ажиллагааны арга барил эзэмшүүлэх арга зүйг боловсруулан дор дурдсан үе шаттай байвал үр дүнтэй” гэж үзжээ. Үүнд:

- Сурагчдад тайлбарлах шинэ материалын агуулгын онол практикийн талыг гүнзгий олгох
- Материалын агуулгад анализ хийж түүнд харгалзах оюуны үйл ажиллагааны арга барилыг тодорхойлох
- Арга барилыг хэрэглэж сурах сурагчийн үйл ажиллагааг бичнэ.
- Сурах явцаар арга барилаа хэрэгжүүлнэ.
- Хичээлээр арга барил эзэмшүүлсэн зарим зүйлийг дараа нь тэмдэглэнэ.
- Уул сэдвийг эзэмшүүлсэн байдалд сурах үйл ажиллагааны логикийн үүднээс анализ дүгнэлт хийнэ. [ЗагдааА,Сургах арга зүй 1981] гэж үзсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулиуд нь хичээлийн судалгаа, судалгаат хичээлийн явцад багшлах арга зүйгээ сайжруулж улмаар сурагчдад сурах арга барилыг эзэмшүүлсэн арга туршлагаараа судалгааны ажил боловсруулж, илтгэл хэлэлцүүлэн [БСШУСЯ, БМДИ, МХСН Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй илтгэлүүд 2013-2018] судалсаар байна.

Гэвч дээрх судалгаануудад нэг ангид хичээлийн судалгааг тасралтгүй явуулж хичээлийн судалгааны тэмдэглэлд тулгуурласан судалгаа хийгээгүй байна. Иймээс бид хичээлийн судалгааны тэмдэглэлд тулгуурлан сурагчдын сурах арга барилыг оношлох боломжуудыг судалсан үр дүнгээсээ танилцуулахыг зорилоо.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар Сэдвийг сонгосон үндэслэл

Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй 11-12 насны хүүхдэд бие физиологийн талаас “Шилжилтийн нас”, суралцах орчин нөхцөлийн талаас “Олон багш хичээл заах” гэсэн өөрчлөлтөөс болж сурлагаар хоцрогдох, хичээлдээ сонирхолгүй болох хандлагууд гардаг. Үүнийг “Олон хичээлийг олон багш орсноос боллоо” гэж үздэг ч бага ангид хүүхэд нь багшийн зааварчилгаар

хийх, даган дуурайх чадварт л ихэвчлэн суралцсан байдгаас дунд ангид ойлгох, ухаарах, бодох, сэтгэх гээд танин мэдэхүйн болон сэтгэхүйн олон үйлийг бие даан хийхээр эдгээр чадварт суралцаагүй хүүхдэд ойлгоогүй, чадахгүй бүхэн нь бэрхшээл саад болж байна.

Иймд хүүхэд хэрхэн суралцаж байгааг тодорхойлох, тэднийг оношлох, түүнд нь тохирсон хичээлийг зохион байгуулах замаар хүүхдийг аливаад дур сонирхолтой, хүсэл тэмүүлэлтэй, бие даах чадвартай болгоход “Багш нарын хамтын үйл ажиллагаа чухал” хэмээн үзэж сургуулийн хэмжээнд хичээлийн судалгааг 4 жилийн турш тасралтгүй явуулснаар хичээлийн судалгааны баримт бичиг, нотолгоонуудыг бүрдүүлж чадсан. Энэхүү баримт бичиг, нотолгоо нь бидний судалгааны ажлын гол тулгуур болох юмаа.

Судлаачид сурах аргын олон төрлийг судалж сурагчдад эзэмшүүлэхийг үндэслэсэн байдаг. Сурах аргын төрөл зүйлийг А.Загдаа: “Унших, сонсох, ажиглах, харьцуулах, гол шинжийг олох, ангилах, тогтоох, төлөвлөгөө хийх, номтой ажиллах” [Ш.Ичинхорлоо Сурах арга 2011] гэжээ.

“Судлагдахуун бүрийн онцлогтой холбоотойгоор мэдээлэлтэй ажиллах, харилцах, судлан шинжлэх, асуудал шийдвэрлэх, шинжлэх ухаанч арга барил, шинжлэн суралцах арга барил, бүтээлч эрэлхийллийн арга барил, бие бялдраа хөгжүүлэх арга барил, эрүүл мэндээ хамгаалах арга барил эзэмшүүлнэ” [БСШУЯ. Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр 2015] гэж заажээ.

Сурагчдын сурах арга барилын эзэмшилтийг

- Анхаарлаа төвлөрүүлэн сонирхож, хүлээн авч буй байдал
- Мэдээлэл хүлээн авч, хариу үйлдэл хийж буй байдал
- Мэдээлэл боловсруулан мэдлэг бүтээж буй байдал
- Тэмдэглэл хөтлөх, дасгал даалгавар ажиллаж буй байдал
- Бусдын яриаг анхааралтай, хүлээцтэй сонсож, ойлгож буй байдал

зэргийг индикатор үзүүлэлтүүдээр тодруулах үүднээс сурагчийг ажиглах хуудас, хичээл заасан багшийн өөрийн үнэлгээ, дүгнэлтийн тэмдэглэл, хичээлийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, ээлжит хичээлийн төлөвлөлтөд анализ хийв.

Сонгосон судлагдахуун

Монгол хэл, орос хэл, англи хэл, иргэншил, математик, физик, биологи, газарзүй, физик-газарзүй, физик-хими, хими-биологи, биологи-газарзүй, технологи, мэдээллийн технологи-хөгжим

Хамрах хүрээ

Дорнод аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2013-2014 оны хичээлийн жилийн 7а ангийн 33 сурагч, 2014-2015 оны хичээлийн жилийн 8а ангийн 30 сурагч, 2015-2016 оны хичээлийн жилийн 9а ангийн 38 сурагчдын сурах арга барилд анализ, дүгнэлт хийв.

Эерэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа

Судалгаат хичээл явуулсан хугацаа нь 2013-2017 оны хичээлийн жил буюу 4 жил

Хугацаа

2013-2017 оны хичээлийн жил буюу 4 жил

Судалгаат хичээлийг явуулсан байдал:

2013-2014 оны хичээлийн жилд 7а ангид 8 судлагдахууны 7 хоногт судлах цагийг 2 дахин нэмж заах замаар явуулсан 40 цагийн судалгаат хичээлийн 381 нүүр ажиглалтын тэмдэглэлээс нэгтгэв. Уг судалгаат хичээлд давхардсан тоогоор 430 хүн оролцсон. 2014-2015 оны хичээлийн жилд 8а ангид байгалийн ухааны хичээлийг интеграцчилан Хэрлэн сумын 6 дугаар сургууль, Хан-Уул цогцолбор сургуулийн багш нартай хамтран явуулсан 11 цагийн судалгаат хичээлийн 38 нүүр ажиглалтын тэмдэглэлээс нэгтгэв. Уг судалгаат хичээлд давхардсан тоогоор 94 хүн оролцсон. Ажиглалтад аймгийн БСГ-ын байгалийн ухааны Япон мэргэжилтэн Ноакаг урьж оролцуулан санал зөвлөгөөг авсан. 2015-2016 оны хичээлийн жилд 9а ангид явуулсан 7 цагийн судалгаат хичээлийн 90 нүүр ажиглалтын тэмдэглэлээс нэгтгэв. Хичээлийн ажиглалтад давхардсан тоогоор 54 хүн оролцсон. 2016-2017 оны хичээлийн жилд 10а ангид явуулсан 3 цагийн судалгаат хичээлийн ажиглалтад давхардсан тоогоор 27 хүн оролцсон. Хүүхэд бүрт ажиглалт хийгээгүй.

Судалгаат хичээлийн явцад хийсэн ажил, түүний үр дүн:

1. Багш нар хүүхдийг ажиглаж тэмдэглэл хөтөлсөн. /Баримт 509 нүүр/

2. Хичээл заасан багшийн өөрийн үнэлгээ, дүгнэлтийн тэмдэглэл хөтөлсөн. /Баримт 62 нүүр/
3. Хичээл бүрт хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтөлсөн. /Баримт 62 нүүр/
4. Ээлжит хичээлийн төлөвлөлтийг хэлэлцүүлгийн дараа сайжруулж байсан.
5. 2013-2014 оны хичээлийн жилд сурагчдын анхаарлын хуваарилалт, тогтворжилтыг 2 удаа судалсан. 2 судалгааг харьцуулахад ангийн сурагчдын анхаарлын хуваарилалт, тогтворжилт 9 хувиар ахисан. /Баримт эх материал/
6. 2013-2015 оны хичээлийн жилд эцэг, эх, асран хамгаалагчдад тайлант уулзалтыг 4 удаа зохион байгуулж санал асуулга авсан. Эцэг, эхчүүд 84.8-93.9 хувьтай оролцсон. Санал асуулгаар өөрийнх нь хүүхэд “Биеэ дайчлан суралцах нь нэмэгдсэн”, “Ухаарч ойлгон унших нь сайжирсан” гэсэн чадваруудыг 60-71,4 хувьтай үнэлжээ. /Баримт эх материал/
7. 2015-2016 оны хичээлийн жилд эцэг, эх, асран хамгаалагчдад үнэлгээ дүгнэлтийн хичээлийг 1 удаа зохион байгуулсан. Эцэг, эхчүүд 78.7 хувьтай оролцсон. Санал асуулгаар 29.1 хувь нь маш сайн, 43.1 хувь нь сайн, 22.0 хувь нь дутмаг, 5.5 хувь нь дэмжлэг шаардлагатай гэж үнэлсэн. /Баримт эх материал/
Гол үйл ажиллагаа: 2009 оны 9 сараас 2018 оны 9 сарыг хүртэлх хугацаанд сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулсан явц үр дүнг дүгнээд үзэхэд “Хүүхэд нэг бүрийн оролцоог хангасан бүтээлч хичээлийг зохион байгуулах” зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан болно.

1. Багш бүр өөрсдөө анги бүлэг, хичээлээ сонгон хичээлийн судалгааг нэгдлээрээ хамтран хийсэн
2. “МОНИТОРИНГ” багийн ахлагч багш бүрээр анги, бүлэг, хичээлийг сугалуулан судалгаат хичээлийг заалгасан. Судалгаат хичээлийг зохион байгуулах гол шалгуур нь хүүхэд бүрийг оролцоог хангахад оршино.
3. Хичээл ажиглалтын хуудсыг шинэчлэн суралцагчдын оролцоог чухалчлан чанарын болон тоон үнэлгээг түлхүү тавьж өгсөн.

Хичээлийн судалгааг 3 үе шаттайгаар 9 дэх жилдээ зохион байгуулах

Хичээлийн судалгааг хийхдээ багш нар сонирхлын баг, ажилласан жилийн баг, судалгаа арга зүйн нэгдлээрээ, мэргэжлийн багаар хамтран зохион байгуулж хичээлийн жил бүрт нэгэн зорилго дэвшүүлж түүнд хүрэх арга замаа тодорхойлон ажилласаар ирсэн.

дд	Хичээлийн жил	Зорилго	Зохион байгуулсан хэлбэр	Хүрсэн үр дүн
1	2009-2010	Хичээлийг төлөвлөх, заах хэлэлцүүлэг хийх аргад суралцах	Судалгаа арга зүйн нэгдлээрээ хамтран	Хичээлийн судалгааг хийж, хэлэлцүүлэг хийж хэвшсэн.
2	2010-2011	Бүтээлээр сурагчдыг үнэлж дүгнэх	Сонирхлын багаар	Ээлжит хичээлийн бүтээлээр үзэсгэлэн гаргасан
3	2011-2012	Нээлттэй болон хаалттай асуултаар сурагчдыг хөгжүүлэх	Судалгаа арга зүйн нэгдлээрээ хамтран	Асуултыг боловсруулж сурагчдаас хариултыг бүрэн дүүрэн авдаг болсон
4	2012-2013	Сурагчдын багаар ажиллах чадварыг дээшлүүлэх	Ажилласан жилээр	Сурагчдын багаар ажиллах чадвар нэмэгдсэн
5	2013-2014	Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх	Судалгаа арга зүйн нэгдлээрээ хамтран	Бүтээлч даалгаврыг боловсруулж гүйцэтгүүлдэг болсон.
6	2014-2015	Сурагчдын хосоор ажиллах чадварыг нэмэгдүүлэх	Судалгаа арга зүйн нэгдлээрээ хамтран	Сурагчдыг хосоор ажиллуулах аргыг боловсруулж ажиллуулж хэвшүүлсэн.

7	2015-2016	Анги нийтийн массын амжилтыг ахиулах	Багш бүр ганцаарчилсан	Сүүлийн 5 жилийн дунджаар сурлагын ахиц амжилт нэмэгдсэн
8	2016-2017	Хүүхэд нэг бүрийн оролцоог хангасан бүтээлч хичээлийг зохион байгуулах	Мэргэжлийн багш бүр ганцаарчлан заасан	Хүүхэд нэг бүрийн хичээлд оролцох идэвх нэмэгдсэн.
9	2017-2018	Ангийн ахиц амжилтыг нэмэгдүүлэх \ээлжит хичээлийн чанартай зохион байгуулах	САЗН, ганцаарчилсан	40 минутын хичээлийг үр дүнтэй зохион байгуулснаар ангийн ахиц амжилт нэмэгдсэн.

Сургууль дээрх хичээлийн судалгааны баг нь дараах 5 зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж хэвшсэн.

Сурагчдын дэвтрийн үйл ажиллагааг сайжруулах

1. Хичээл бүрийн онцлогийг харуулсан дэвтрийн хавтастай болсон \бүх анги, бүх хичээл\
2. Дэвтрийн үзлэгийг улиралд 2 удаа явуулж хэвшсэн
3. Дэвтрийн үйл ажиллагааны үзэсгэлэнг “Эцэг эхийн нээлттэй өдөрлөг”-ийн үеэр буюу жилд 2 удаа гаргаж бусад сурагчдад сурталчилдаг болсон.
4. Ажлын хуудсыг дэвтэрт хавсарган бүтээлч дэвтрийн шаардлагыг хангах болсон

Багшийн самбар хөтлөлтийг боловсронгуй болгох

1. Багш бүр ээлжит хичээлийн төлөвлөлтийн ард самбар ашиглалтын схемийг оруулж хэвшсэн.
2. “Багшийн самбар-Сурагчийн толь” арга хэмжээг зохион байгуулж шилдэг самбар хөтөлдөг багшийг шалгаруулдаг болсон.
3. Бүтээлч самбар ашиглалтын аргачлалыг залуу багш нарт зааж сургадаг болсон.

Сайн хичээл-үйл ажиллагаа уралдааныг 4 дэх жилдээ зохион байгуулах

1. Сайн хичээл-үйл ажиллагаа уралдааныг сургууль дээрээ 4дэх жилдээ амжилттай зохион байгуулж сургуулиас шалгарсан хичээлийг бүсийн арга хэмжээнд оролцуулж тогтмол 1-р байр эзэлж цаашлаад аймгийн тэмцээнд тэргүүлж улсын уралдаанд оролцож батламж гардсан зэрэг амжилтыг үзүүлээд байна.
2. “Сайн хичээл-үйл ажиллагаа III” бүсийн багш нарын уралдааныг сургууль дээрээ зохион байгуулж бүсийн 5 сургуулийн нийт 23 багш оролцож сургуулийн хичээлийн судалгааны туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж үзэсгэлэн гаргаж танилцуулсан.
3. “Сайн хичээл- үйл ажиллагаан”-д амжилттай оролцсон математик, хими, байгалийн ухааны хичээлийг CD бичлэгт буулган БМДИ-ийн сайн хичээлийн санд тавьж олны хүртээл болгосон.

Танхимаас гадуурх хичээлийг зохион байгуулах

1. Хичээлийг орчинд нь заах арга хэмжээг зохион байгуулж судалгаа арга зүйн нэгдлээрээ хамтран хичээлийг бэлтгэж “Улаан-овоо” нүүрсний уурхай, “Намуун” кафе, “Төрийн банк”, “Цаг уурын станц” “Ахмадын хороо” ЗДТГ-ын “Иргэний танхим” “Зэлтэр гол” зэрэг газруудад нэг цагийн хичээлийг зохион байгуулж хэлэлцүүлэг хийж сайжруулсан.
2. “Танхимаас гадуурх хичээлийг зохион байгуулах нь”сэдвээр эрдэм шинжилгээний хуралд оролцож аймагтаа тэргүүлж улсын уралдаанд оролцож 21 аймаг, 9-н дүүргийн багш нарт түгээн дэлгэрүүлсэн.

“Сурагчдын хүмүүжил-төлөвшил”-ийн талаар судалгаа арга зүйн нэгдлүүд нэг цагийн ээлжит хичээлийг зохион байгуулах

1. НУСАЗН-ийн хамт олон “Хүнээр хүн хийх Монгол ухаан” сэдвээр дунд ангийн сурагчдад
2. БУСАЗН-ийн хамт олон “Монголчуудын хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлалт арга” сэдвээр ахлах ангийн сурагчдад
3. БАСАЗН-ийн хамт олон “эрхээ эдэлж үүргээ хүлээж, хариуцлагаа ухамсарлах нь” сэдвээр бага ангийн сурагчдад 1 цагийн хичээлийг зохион байгуулсан

Судалгааны үр дүн

Зорилгодоо хүрсэн байдал: Нэг мэргэжлийн багш ганц байдаг, анги бүлэг ганц ганц байдаг хөдөөгийн цөөн хүүхэдтэй сургуулийн хувьд сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийх замаар арга зүйгээ хамтран хөгжүүлэхэд илүү тохиромжтой гэдгийг бодит байдал харуулж байна. Сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулахад хүүхэд нэг бүрийн оролцоог хангах нь судалгааны багийн ахлагчийн нол зорилго байсан.

Судалгааны багийн ахлагчийн үүрэг

Оношлох		Хичээл төлөвлөж, зохион байгуулах		Зөвлөгөө, тусламж үзүүлэх		ХШҮ хийх	
Сурагчдын оролцоог оношлох	-Багш бүр хичээл заах анги бүлгийн сурагчдын оролцооны бодит байдлыг гаргасан. \оролцоо хангалттай, дунд зэрэг, хангалтгүй\ -Ээлжит хичээлийг явуулсны дараа өмнөх оролцооны түвшинтэй харьцуулж ахицыг гаргасан.	Хичээл бэлтгэх, заах, ажиглах	-Ээлжит хичээлийн төлөвлөлтийг нэгдлээрээ, болон ижил мэргэжлийн багш нартай хамтран боловсруулалт хийлгэдэг -Хичээлд тоон болон чанарын үнэлгээ хийж хэвшсэн -Хичээлд ажиглалт хийх багш бүр хичээлд орохын өмнө хичээлийн аль үйл явцыг ажиглах вэ? гэдгийг сугалж ордог	Сайжруулах	-Судалгаат хичээлийн хэлэлцүүлэгийг ХС-ы багийн ахлагч чиглүүлж хөтөлдөг -Ололтой арга зүйг багш нар өөртөө тусган авч, арга зүйгээ сайжруулж талархаж сурсан, дутагдалтай арга зүйг дараагийн сайжруулсан хичээлээр засаж сайжруулж сурсан.	Мониторинг хийх	-Жил бүрийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл бичиж сургуульд суурилсан хичээлийн судалгааны ололт, үр дүн, ач холбогдлыг тооцох цаашид хэрхэн хөгжүүлж болох саналыг авч хэвшсэн. -Залуу багш нар луу түлхүү хандсан судалгаат хичээлийг зохион байгуулахаар болсон. -Багш нарын хичээлд тогтмол ажиглалт хийж зөвлөгөө өгдөг.

Хүүхэд бүрийн оролцоог хангах олон аргаас туршиж үзэж хамгийн сайн болсон аргыг дахин дахин туршиж үзэн дараагийн анги, хичээлд ашиглах болсон. Энэ нь хичээлд оролцдоггүй, идэвхигүй, цаг нөхцөөдөг, өөрийгөө бусдаас тусгаарладаг сурагчдыг хүртэл хичээлд татан оролцуулах болсноор хичээлийн үйл явц хүртэл амжилттай болж ангийн сурлагын ахиц амжилт дээшилж байсан. Хичээлд оролцдоггүй нэг сурагчийг ч болов оролцуулж дугаргаж байна гэдэг нь энэ хичээлийн том ололт гэж үзэн багш бүр арга зүйгээ боловсруулж хичээлийг зааж байсан.

Яагаад сайн болсон бэ?

1. Ээлжит хичээлийг үр дүнтэй зохион байгуулахын тулд хүүхэд нэг бүрийн оролцоог хангасан бүтээлч хичээлийг зохион байгуулах хэрэгтэй ингэснээр сурлагын ахиц амжилтын хувь өснө, массын сургалтын чанар сайжирсан

Бага ангийн жилийн эцсийн стандарт биелэлт сүүлийн 5-н жилээр

Хичээлийн жил	Амжилт	Чанар	Зөрүү
2013-2014	100%	59.9%	Дундажаас дээгүүр
2014-2015	100%	63.0%	4%-аар өссөн
2015-2016	100%	56.6%	6.3%-аар буурсан
2016-2017	100%	68.3%	11.7%-аар өссөн
2017-2018	100%	74.5%	5.8%-аар өссөн

Дунд, ахлах ангийн жилийн эцсийн стандарт биелэлт сүүлийн 5-н жилээр

Хичээлийн жил	Амжилт	Чанар	Зөрүү
2013-2014	100%	36.6%	
2014-2015	100%	45.0%	8.4%-аар өссөн
2015-2016	100%	53.4%	7.6%-аар өссөн

2016-2017	100%	58.0%	4.6%-аар өссөн
2017-2018	100%	60.9%	2.9%-аар өссөн

- 2.Багш нарын хувьд бүс, аймаг, улсын ур чадварын уралдаанд тогтмол оролцож амжилт гаргасан.
- 3.Багш нарын сайжруулсан 3 хичээлийн бичлэгийг олон нийтэд түгээж сайтуудад байршуулсан.
- 4.Сурагчдын хувьд сүүлийн 3 жилд монгол хэл, бичиг, түүх нийгмийн ухаан, математик, IQ-ийн хичээлийн олимпиадад аймагтаа тэргүүлж улсын олимпиадад амжилттай ороцсоор ирсэн.
- 5.ЭЕШ-нд сурагчид тогтмол өндөр оноо авч улсын их дээд сургуульд суралцах болсон.2016 онд монгол хэлний хичээлээр 800 оноо авсан
- 6.Хичээлийн судалгааны туршлагаа Сэлэнгэ аймгийн 35 сургууль, Монгол улсын 21 аймаг 9 дүүргийн багш нарт түгээн дэлгэрүүлсэн.
- 7.Хичээлийн судалгааны нийгэмлэгийн захиалгат сургалтанд багш нараа бүрэн хамруулж, гишүүнээр элссэн.

Бусдад хүргэх туршлага

- 1.Хүүхэд нэг бүрийг оролцоог хангасан бүтээлч хичээлийг зохион байгуулснаар сурагчдын оролцоо нэмэгдэж, цаашдаа сурлагын амжилт, чанарт ахиц гарсан.
- 2.Багшийн самбар ашиглалт, сурагчдын дэвтэрийн үйл ажиллагаа сайжирсан.

Цаашид хөгжүүлэх санал

1. Монголын хичээлийн судалгаа нийгэмлэгээс зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаанд тогтмол оролцох
2. Хичээлийн судалгааны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж бүсийн 5 сургуулийг урьж үйл ажиллагаагаа сурталчлах
3. “ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ” ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛД тогтмол оролцох
4. Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн захиалгат сургалтыг авах

Ном зүй

1. Жадамбаа.Б., Танхим дахь мэдлэг бүтээх үйл явц, УБ, 2003
2. Санжаабадам.С., Боловсролын чанарын үнэлгээ, УБ, 2006
3. Мэдлэгийн зуун-дээд боловсролын чанар, ЭШ-ний бага хурлын материал, УБ., 2009
4. Багшийн хөгжил түүнийг үнэлэх, дэмжих асуудлууд.Боловсролын хүрээлэн. УБ., 2007
5. Стандартад суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах нь .БХАН. УБ., 2007

Сургуульд суурилсан хичээлийн судалгаа нь багш нарын тулгамдсан асуудлуудыг шийдэх боломж

*А. Цэндулам, Д.Дүгэрмаа, Т.Бүрэнжаргал
Орхон 5-р сургууль*

Хураангуй:

Зорилго: Суурь боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад мэргэжлийн багш нар багаар хамтран ажиллаж, сурагч нэг бүрийг хөгжүүлэн, хичээлийн судалгааг явуулахдаа сургалтын үед тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг хамтран шийдэх зорилго тавин ажилласнаар багш ажлын байран дээрээ хэрхэн хамтран хөгжих боломж бүрдэж байгааг судлах. Мөн сургуулийн зүгээс багш нарт тулгамдаж буй асуудлыг олж харснаар хичээлийн судалгааг оновчтой зохион байгуулахад ямар эерэг өөрчлөлт, үр дүн гарч болохыг бусдад таниулахад оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Суурь боловсролын цөм хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан багш нарын хичээл зохион байгуулах арга, арга зүйд өөрчлөлт хийх хэрэгцээ шаардлага гарсан. Ийм учраас хичээлийн судалгаа хийх явцдаа багш нарт тулгамдаад байгаа олон асуудлуудыг хамтран шийдэж болох боломжит арга зам хувилбаруудыг судалж туршин хэрэгжүүлэх.

Судалгааны үр дүн: Судалгаанаас мэргэжлийн багш нар ЗАН-ээрээ хамтарч хичээлийн судалгааг өөрсдийн тулгамдсан асуудлуудыг хамтран шийдэх зорилго тавин явуулснаар суралцагсдын хөгжил,

төлөвшилд болон багш нарын хамтын ажиллагаанд олон талын ач холбогдолтой болох нь харагдсан болно.

Хичээлийн судалгааг хамтран хийснээр багш нар харилцан бие биенээсээ суралцах, бие биенээ хүндлэх, өөрсдийн арга зүй технологигоо боловсруулах арга зүйд суралцсан. Мэргэжлийн багш нарт тулгамдаад буй сургалтын арга зүй, хичээлийн цагийн төлөвлөлт, хичээлийн хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгон хийх, хэрэглэх, онолын хувьд хүнд сэдвүүдийг сурагчдад ойлгуулах зэрэг гарц шийдлийг эрж хайх үйл явц нь багшийн хөгжил, сургуулийн үйл ажиллагаанд ихээхэн ач холбогдол үзүүлж байна.

Сургалтын менежерүүд хичээлийн бэлтгэл судалгаанаас эхлээд сайжруулсан хичээлийн хэлэлцүүлгийг дуустал хамтран ажилласнаар хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, багш нарын мэргэжил, ур чадварыг ажлын байран дээр нь дээшлүүлж, арга зүйн зөвлөгөөгөөр тасралтгүй хангахын зэрэгцээ өөрсдөө хамтран хөгжих давуу талтай.

Практик ач холбогдол: Сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулахдаа мэргэжлийн багш нарт тулгамдаж буй асуудлуудыг хамтран ярилцаж, судалгаа явуулах анги хичээлийн сэдвээ сонгон, үр дүн гарахуйц шийдэл гаргаснаар заахад хүндрэлтэй байдаг сэдвүүдийг сонгон авч оновчтой аргыг хэрэглэн, хэрэглэгдэхүүнээ зөв сонгон хичээл зохион байгуулснаар ээлжит хичээлийн чанар үр өгөөж дээшлэхийн зэрэгцээ багш нар ажлын байран дээрээ хамтран хөгжиж байна.

Сайжруулсан хичээлийн хөтөлбөрөөр тухайн сэдвийг хичээл заагдаагүй бусад ангиудад боловсруулан зааснаар ээлжит хичээлийн чанар сайжирсан.

Сургуульд суурилсан хичээлийн судалгааг тодорхой зорилготой явуулах нь багшид ажлын байран дээрээ хөгжих, мэргэжлээ дээшлүүлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ багш нарын хамтын ажиллагаа нь сайжирч, харилцан бие биенээсээ суралцах, туршлага солилцох боломжоор хангаж байна.

Шинэлэг тал/ санаа: Сургуульд суурилсан хичээлийн судалгааг мэргэжлийн багш нар өөрсдийн хичээл заах явцад гарч буй тулгамдсан асуудлуудыг хамтран шийдвэрлэх зорилгыг тавин ажиллах нь багшид ажлын байран дээрээ хөгжих боломжийг нээж өгч байна.

Сургалтын менежерүүд сургуульд суурилсан хичээлийн судалгааг зөв чиглүүлэн ажилласнаар багш нарын заах арга зүй, ур чадварыг дээшлүүлэн, ээлжит хичээлийн чанар үр өгөөжийг дээшлүүлэх боломжтой.

Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, багшийн хөгжил, хамтын ажиллагаа

Товч агуулга

Удиртгал:

Орхон аймгийн V сургуулийн багш нар 2012 оноос эхлэн судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа хийж эхэлсэн. 2015 онд Хичээлийн судалгааны нийгэмлэгээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд “Хамтын хичээл нь сургуульд суурилсан хичээлийн судалгааны нэг хэлбэр мөн” илтгэлийг хэлэлцүүлсэн болно. 2016-2017 оны хичээлийн жилээс хичээлийн судалгааг явуулахдаа суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багш нарт тулгамдаж буй асуудлуудыг хамтран шийдэх арга замыг эрэлхийлэх зорилго тавин ажиллалаа. Энэ хугацаанд өөрийн хариуцан ажилладаг монгол хэл, түүх нийгмийн ухаан, гадаад хэл, дизайн технологийн мэргэжлийн багш нарын саналд тулгуурлан улирал бүр судалгаат хичээл нэгийг зохион байгуулж, ээлжит хичээлийн чанарыг дээшлүүлэх сурагч нэг бүрийн оролцоог нэмэгдүүлэхийг зорин ажилласнаар тодорхой үр дүн, ахиц гарсан болно.

Сэдэв сонгосон үндэслэл: Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх явцад багш нарт олон асуудал тулгамдаж байсан бөгөөд тэрхүү асуудлуудыг ганцаараа биш, мэргэжлийн багш нартайгаа хамтран шийдэх нь багшийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж байсан.

Сонгосон судлагдахуун: Монгол хэл, гадаад хэл, түүх, нийгмийн ухаан, дизайн технологи

Хамрах хүрээ: Орхон аймгийн V сургуулийн дунд ангийн 28 багш нар болон 6-12-р ангийн сурагчид

Хугацаа: Туршилтыг 2016-2017 оны хичээлийн жилд хийж эхлэн 3 дахь жилдээ үргэлжлүүлж байна.

Хэрэгжүүлсэн байдал: Суурь боловсролын цөм хөтөлбөр хэрэгжиж эхлэхэд багш нарын хувьд хичээл заах арга зүйгээ өөрчлөх, хичээлийн хэрэглэгдэхүүнийг оновчтой зөв сонгож хэрэглэх, хичээлийн

цагийг зөв төлөвлөх гэх мэтийн олон асуудлууд тулгарсан. Цөм хөтөлбөрийн агуулга үзэл санаанд сургалтыг уялдуулан өөрчлөх шаардлага залуу багш нар төдийгүй туршлагатай багш нарт ч тулгарсан.

Судлагдахуун бүрээр мэргэжлийн багш нарт тулгамдаж байсан асуудал:

№	Судлагдахуун	Тулгамдаж байсан асуудлууд
1.	Монгол хэл	Онолын хувьд хүнд сэдвүүдийг заах, цагийн төлөвлөлтийг сайжруулах, сурагчдын сонсох чадварыг хөгжүүлэх хэрэглэгдэхүүн сонгох, хүүхэд нэг бүрийн оролцоог хангах
2.	Нийгмийн ухаан	Суурь чадвар болох ярих бичих чадварыг зэрэг хөгжүүлэх, ажлын хуудсыг бэлтгэх, самбарын бичиглэлийг төлөвлөх, үнэлгээний шалгуур боловсруулах
3.	Гадаад хэл	Багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, ухаалаг ангийн техник хэрэгсэл дээр ажиллаж сурах, тоглоомын шинэ аргуудыг туршиж үзэх, хэрэглэж сурах, үнэлгээний шалгуурыг боловсруулах
4.	Дизайн технологи	Хичээлийн хэрэглэгдэхүүнийг гарын доорхи материалаар орлуулан хийх, төслийн аргаар хичээл заах арга зүйд суралцах, хичээлийн цагийн төлөвлөлтийг хийх

Судалгаат хичээлийн тоо, хамрагдсан багш, удирдах ажилтныг хүснэгтээр үзүүлбэл:

№	2016-2017 оны судалгаат хичээлийн зорилго			2017-2018 оны судалгаат хичээлийн зорилго		
	Арга зүй, цаг ашиглалтыг сайжруулах			Ухаалаг ангийн тоног төхөөрөмжийг ашиглах		
	Судлагдахуун	Заасан хичээлийн тоо	Хамрагдсан багш, удирдах ажилтан/давхардсан тоогоор/	Судлагдахуун	Заасан хичээлийн тоо	Хамрагдсан багш, удирдах ажилтан
1.	Монгол хэл	4	27	Монгол хэл	3	6
2.	Гадаад хэл	5	38	Гадаад хэл	6	46
3.	Түүх, нийгмийн ухаан	4	20	Түүх, нийгмийн ухаан	3	13
4.	Дизайн технологи	4	21	Дизайн технологи	3	15

Энэхүү асуудлуудыг мэргэжлийн багш нар хамтран шийдэх ямар боломж байгаа талаар хэлэлцэн тулгамдсан асуудлуудыг хичээлийн судалгааны явцад шийдэх арга зам, боломжит хувилбарыг эрж хайн хичээлийг зохион байгуулсан.

Хичээлийн судалгааг зохион байгуулах арга зүй:

№	Үе шат	Зохион байгуулалт
1.	Хичээлийн судалгааны хуваарийг гаргах	• Хичээл заах багш, анги сонгоно.
2.	Хичээлийн бэлтгэл судалгаа хийх	• Мэргэжлийн багш нар сурах бичгийн агуулгад судалгаа хийж сэдвээ тодорхойлно.
3.	Сэдвийн дагуу хичээлээ зохион байгуулах талаар хэлэлцэнэ	• Хичээлд ашиглах хэрэглэгдэхүүн сонгож, цагаа төлөвлөж ээлжит хичээлийн хөтөлбөрөө бэлтгэнэ.
4.	Хичээлийг зохион байгуулна.	• Мэргэжлийн багш нар хичээлийн явцад ажиглалт хийж тэмдэглэл хөтлөнө.

5.	Хэлэлцүүлэг хийх	• Мэргэжлийн багш нар өөр өөрсдийн ажиглалтыг танилцуулж санал бодлоо солилцоно.
6.	Ээлжит хичээлийн хөтөлбөрөө сайжруулах	• Хэлэлцүүлгийн дагуу хичээлийн хэрэглэгдэхүүн, хөтөлбөр, цагийн төлөвлөлтөө сайжруулна.
7.	Сайжруулсан хөтөлбөрийн дагуу хичээлээ зохион байгуулна.	• Мэргэжлийн багш нар хичээлийн явцад ажиглалт хийж тэмдэглэл хөтлөнө.
8.	Хэлэлцүүлэг хийх	• Мэргэжлийн багш нар санал бодлоо солилцож ээлжит хичээлийн хөтөлбөрт үнэлэлт дүгнэлт өгнө.

“Ухаалаг анги” төслийн хүрээнд багш нарын заах арга, ур чадварыг нэмэгдүүлж, мэдээлэл харилцааны технологийг сургалтанд нэвтрүүлсэн байдал:

2016-2017 оны хичээлийн жилд 5-р сургууль нь БНСУ-ын Гэнгиду мужийн хөрөнгө оруулалтаар “Ухаалаг анги” төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Тус ангийн Ухаалаг тоног төхөөрөмжийг ашиглан хичээл зохион байгуулах чадварыг багш нарт эзэмшүүлэх шаардлага гарсан бөгөөд сургуулийн захиргааны зүгээс сургалтуудыг явуулсан боловч тодорхой ахиц ажиглагдаагүй. Иймээс 2016-2017 хичээлийн жилд гадаад хэлний багш нарыг ухаалаг тоног төхөөрөмж дээр ажиллуулж сургах зорилго тавин тус судлагдахууны хичээлийн судалгааг “Ухаалаг анги”-д зохион байгуулсан. Ингэснээр гадаад хэлний багш нарын 50-аас дээш хувь нь ухаалаг ангийн тоног төхөөрөмжийг ашиглаж сурсан.


2017-2018 оны хичээлийн жилд бусад мэргэжлийн багш нарын судалгаат хичээлийг “Ухаалаг анги”-д зохион байгуулснаар монгол хэл, түүх нийгэм, дизайн технологийн багш нарын 40-өөс дээш хувь нь ухаалаг ангид хичээл зохион байгуулах чадварыг эзэмшсэн. Энэхүү туршилтаас харахад хичээлийн судалгааны явцад сургууль, багш нарын өмнө тулгамдаад байгаа асуудлуудыг хамтран шийдэх боломж нээгдсэн.

Хичээлийн судалгааны бэлтгэл судалгаанаас эхлээд хичээл зохион байгуулах, хэлэлцүүлэг хийх, сайжруулах, сайжруулсан хичээл заах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагаанд мэргэжлийн багш нар хамтран оролцож, санал бодлоо солилцож багш нарын арга зүй сайжирч, бие биенээсээ суралцах, хамтран ажиллах чадвар нэмэгдсэн.

Судалгааны үр дүн:

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагаанд багш бүрийг татан оролцуулах, дунд ангийн багш нарын хамтын үйл ажиллагааг сайжруулж, сургуульд суурилсан хичээлийн судалгааг хийх нь багш нарын хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа талаар 2017 оны 9-р сар, 2018 оны 5-р саруудад багш нараас судалгаа авч харьцуулан дүгнэж үзэхэд:

1. “Хичээлийн судалгааны үед та өөртөө тулгамдаж байсан асуудлуудыг шийдэж чадсан уу?” гэсэн асуултанд дараах байдлаар хариулсан байна.




Энэхүү графикаас харахад багш нарын хичээлийн судалгааны үед зарим асуудлуудыг шийдэж чадсан байна.

2. Хичээлийн судалгааны үед та ямар асуудлуудаа шийдэж чадсан бэ? гэсэн асуултанд:

- Хичээлийн цагийн төлөвлөлтийг хийж сурсан
- Заахад хэцүү сэдвүүдээ хамтран бэлдэж хичээлээ амжилттай заасан
- Бусдын туршлагаас суралцсан
- Шинэ аргуудаас туршиж өөрийн хичээлд хэрэглэдэг болсон
- Цахим хэрэглэгдэхүүн хийх аргуудаас суралцсан
- Ухаалаг ангийн тоног төхөөрөмж дээр ажиллаж сурсан
- Сурагчдын сонсох чадварыг хөгжүүлэх хэрэглэгдэхүүнийг олж авах шинэ сайтуудыг мэдэж авсан
- Хүүхэд нэг бүрийн оролцоог хичээлийн үед ханган ажиллах арга туршлагатай болсон
- Хичээлийн хэрэглэгдэхүүнийг гарын доорхи материал ашиглан хийх аргаас суралцсан
- Ажлын хуудас боловсруулж сурсан
- Үнэлгээний аргуудаас туршин үзэж, өөрийн хичээлд хэрэглэж байна

3. Багш нарын “Ухаалаг анги”-ийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадвар 2 жилийн хугацаанд хэрхэн нэмэгдэж байгааг харьцуулж үзэхэд:



Багш нараас авсан судалгааны дүнг нэгтгэж үзвэл хичээлийн судалгааг хамтран хийх нь багшийн хөгжилд дараах эерэг нөлөөг үзүүлсэн байна.

- Хамтарч хичээлийн судалгаа хийснээр багш нар бусдаас суралцан өөрийн заах арга, ур чадвараа дээшлүүлж байна
- Багш нарын багаар ажиллах чадвар сайжирсан, багийн үйл ажиллагааны сайн талыг ойлгосон
- Багш нарын харилцаанд эерэг өөрчлөлтүүд гарч, хамт олны уур амьсгал сайжирсан
- Багш нар өөрийн үйл ажиллагааг сайжруулахын тулд бусдаас суралцдаг болсон
- Тулгамдаж байгаа асуудлыг бусдын оролцоо, дэмжлэгтэйгээр шийдэх боломжтой
- Багш нарын Ухаалаг ангид хичээл заах ур чадвар нэмэгдэж байна.
- Багш өөрөө хөгжье, хүүхэд нэг бүрийг бусад багш нартай хамтраад хөгжүүлэе гэсэн эрмэлзэлтэй болж байна.

Судалгаанаас харахад багш нар хамтарч хичээлийн судалгаа явуулснаар, тулгамдаж байгаа асуудлаа хамтран ярилцаж, гарах арга замаа эрэлхийлэх явцдаа өөрийн заах арга, арга зүй, технологийг хөгжүүлж байна.

Бусдад хүргэх санал: Хичээлийн судалгаа нь ээлжит хичээлийн чанар, үр дүнг сайжруулах чухал арга учраас сургалтын менежерүүд хичээлийн судалгааг зөв чиглүүлэн, хичээлийн хуваарийг уян хатан /бусад мэргэжлийн бүх багш нар оролцох боломжийг бүрдүүлэх/ байдлаар зохион байгуулбал эерэг сайн үр дүнд хүрэх боломж байна. Багш нарын хамтын үйл ажиллагааг дэмжин сургуульд суурилсан

хичээлийн судалгааг тодорхой зорилготойгоор явуулах нь сургалтын явцад тулгарч буй асуудлуудыг шийдэх гарц байж болох юм.

Цаашид хөгжүүлэх санал:

Өмнөх туршлага дээрээ тулгуурлан жил бүр сургуульд суурилсан хичээлийн судалгааг сургалтын менежерүүд тодорхой нэг зорилгод чиглүүлэн явуулах нь үр дүнтэй байгаа нь харагдлаа. Дэлхий нийтийн боловсролын чиг хандлага нь тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч байна. Манай улсын боловсролын салбарт энэ чиглэлээр олон ажил хийгдэж эхлээд байна. Иймээс энэ хичээлийн жилд сургуульд суурилсан хичээлийн судалгааг тогтвортой хөгжлийн зорилгуудыг судлагдахуун бүрийн онцлог, агуулгатай уялдуулан интеграцчилахад чиглүүлэн зохион байгуулна.

Ерөнхий дүгнэлт

Сурагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаанаас 90% нь судалгаат хичээл сонирхолтой ойлгомжтой, богино хугацаанд их зүйлийг хийж чадсан гэж хариулсан. Судлагдахуун бүрээр мэргэжлийн багш нарт тулгамдаж буй асуудлуудыг олж илрүүлэн, судалгаат хичээлийг зохион байгуулснаар хичээлийн үр дүн сайжирсан төдийгүй сурагч, багш, эцэг эхийн хувьд дараах эерэг үр дүн, ахиц гарсан болно.

Үр дүн

Сурагчийн хувьд:

- Хамтач, бүтээлч, нээлттэй, чөлөөтэй сэтгэх хандлага төлөвшсөн.
- Олж авсан мэдлэг ойлголтоо хэрэглээ болгосон.
- Бие даасан бүтээлч үйл ажиллагаа сайжирсан.
- Өөрийгөө удирдан үйл ажиллагаагаа төлөвлөж сурсан.
- Хамтын үйл ажиллагаанд суралцсан.
- Өөрийн болон бусдын сул талыг ажиглан мэдэрч бусдадаа нөлөөлөх болсон.
- Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар нь сайжирсан.

Багш нарын хувьд:

- Мэргэжлийн багш нар хамтран ажилласнаар суурь боловсролын цөм хөтөлбөрийн аргагүйг хамтран эзэмшин сургалтыг амжилттай зохион байгуулж байна.
- Судалгаат хичээлийг зохион байгуулснаар ажлын байран дээрээ өөрсдийгөө хөгжүүлсэн.
- Зарим багш нар өөрийн технологи, арга зүйтэй болсон.
- Олон төрлийн хичээлийн хэрэглэгдэхүүн хийж, сургалтандаа ашигладаг болсон.
- Аймаг, улсын “Сайн хичээл, үйл ажиллагаа”-нд амжилттай оролцдог болсон.

Сургалтын менежерийн хувьд:

- Багшийг ажлын байран дээр хөгжүүлэхийн зэрэгцээ өөрөө хамтран хөгжиж байна.
- Сурагчдын сонирхол, хэрэгцээнд нийцсэн хичээлийн тоог нэмэгдүүлж байна.
- Ухаалаг тоног төхөөрөмж дээр ажиллах чадвартай багш нарын тоог нэмэгдүүлж “Ухаалаг анги” төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Ном зүй

[1] Эрдэм боловсролтой монгол хүн хөтөлбөр.УБ.,2013

[2] “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн модулиуд УБ.,2013

[3] Э.Шинэбаяр (хамтын бүтээл, 2013) Судалгааны арга зүй,УБ хот

[4]А.Хишигням,Судалгааны арга зүй,УБ.,2013

[5] Ч.Нямгэрэл (хамтын бүтээл,2007) Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй –зөвлөмж 1,УБ хот

[6] Б.Бурмаа (хамтын бүтээл,2009) Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй –зөвлөмж 2,УБ хот

[7] Б.Бурмаа(хамтын бүтээл,2009) Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй –зөвлөмж 3,УБ хот

[8] Боловсрол судлал сэтгүүл.УБ.,2009/11,Х38

[9] Боловсрол судлал сэтгүүл.УБ.,2010/05,Х48

[10] Интернет – www.slideshare.net, spe.num.edu.mn/bagsh/files/monitoring.

ДӨРӨВ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн харааны хүртэхүйг хөгжүүлэх арга зүй

Б.Одонтунгалаг, Ж.Бямбасүрэн, Ц.Саран
Булган, Хишиг-Өндөр сум

Илтгэлийн хураангуй:

2010 оны хичээлийн жилд 1-р ангийн 30 сурагчдыг хүлээн авахад О (эрэгтэй), М (эмэгтэй) гэдэг хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хоёр сурагч хуваарилагдлаа. Хичээлийн эхний өдрөөс л бидний хооронд үл ойлголцол үүсч, харилцахад бэрхшээлтэй байв. Долоо хоног хичээллэсний дараа сурагч О, М нарын эцэг эхтэй уулзан гарч буй бэрхшээлийн тухай ярилцаж, Улаанбаатар хотын тусгай сургуульд өгч суралцуулах санал тавьсан боловч

- Эцэг эхчүүд нь тусгай сургуульд явуулах боломжгүй
- Улаанбаатар хотод ах дүү хамаатан садан байхгүй
- Хүүхдүүд нь өөрсдөө биеэ даах чадвар муутай
- Тусгай сургуульд орсон бол төгстлөө л тэндээ байхыг шаарддаг

Эцэг эх нь дэргэдээ харж хандаж байх нь дээр гэх мэт шалтгааны улмаас тусгай сургуульд явуулах боломжгүй байгаагаа тайлбарлав. Иймд тухайн 2 сурагчаа судлан, тэдний авьяасыг нээх, хөгжүүлэх, энгийн сурагчидтай хамт сургаж төлөвшүүлэх нь чухал болсон тул сурагчдаа олон талаас нь судалж тасралтгүй 5 жил ажилласан. 2015 оны хичээлийн жил Дааврын булчирхайн эмгэг гэсэн оноштой хэл яриа, сонсголын бэрхшээлтэй сурагч Х.М (эмэгтэй), мөн бөөрний дутагдал оноштой О.С (байнгын хэвтрийн дэглэм сахих шаардлагатай) 2 сурагч элсэн орж ирсэн. Энэ сурагчтай гэрээр нь очиж даалгавар өгч ажиллаж байна. Эдгээр сурагчидтай 3 дахь жилдээ ажиллаж байна. Ердийн сургалттай ЕБС-д сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй сурагчидтай ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн арга зүй, туршлагаа танилцуулж арга туршлагаа туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломжтой гэж үзлээ

Зорилго: Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй сурагчдын харааны хүртэхүйг ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд хөгжүүлж төлөвшүүлэх

Судалгааны арга: Сурагчдын ерөнхий хөгжил төлөвшлийг нээн илрүүлэхийн тулд ихэвчлэн ажиглалтын арга хэрэглэж, эцэг эх, ангийн найз нөхдөөс нь асуулгын аргаар судалгааг хийлээ. Мөн бодит байдлын судалгааг хийж хүүхдийн хувийн онцлог, чадвар, хүүхдийн үйл ажиллагааг нь төлөвлөв.

Судалгааны шинэлэг тал: Энгийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хөгжүүлж төлөвшүүлж үр дүнд хүрч болох арга замыг эрэлхийлснээрээ шинэлэг юм.

Товч агуулга: Энэхүү арга замаар ажиллахад хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй сурагчдыг энгийн сургуульд сургаж, хөгжүүлж, төлөвшүүлж болдог гэдгийг харуулж байна. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд ганцаараа аливаа зүйлийг хийх, ганцаардмал хандлагатай байдаг. Тиймээс ийм хүүхдийг сургахдаа аль болох бусад хүүхдүүдтэй хамтран хийж гүйцэтгэх үйл ажиллагааг зохион байгуулбал сайн. Мөн хүүхдүүд бие биедээ зааж сургах нь их зөв арга шиг санагддаг. Энэ нь энгийн хүүхдүүд давамгайлах хандлагаар оролцох биш харин зааж сургаж байвал бэрхшээлтэй сурагчдад илүү сайхан харилцаа бүрддэг. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй сурагчдыг хөгжүүлэхийн тулд харааны хүртэхүйг сайтар хөгжүүлж, нүдлэн тогтоох арга ихээхэн үр нөлөөтэй. Ингэж ажиллаж чадвал сурагчид маань илүү сайн хөгжиж, сурч, төлөвшиж чаддаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид тохиолдож болох хүндрэл бэрхшээлүүдийг хэрхэн даван туулах арга замыг оновчтой сонгох арга замд суралцах хэрэгтэй.

Зорилго: Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй сурагчдын харааны хүртэхүйг ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд хөгжүүлж төлөвшүүлэх

Зорилт: Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн хөгжих боломжийг судлах
Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэхэд анги хамт олон, эцэг эх, сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багшийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг бий болгох

Сэдвийг сонгосон үндэслэл:

2010 оны хичээлийн жилд 1-р ангийн 30 сурагчийг хүлээн авахад сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй 2 сурагч хувиарлагдсан байв. \У.Мичидмаа, Г.Очбаяр\ хичээлийн эхний өдрөөс л багш сурагчдын дунд үл ойлголцол үүсч, хичээл зохион байгуулахад хүндрэл гарч эхэлсэн. Иймд сурагчдыг сайтар судлан, тэдний авьяасыг нээх, хөгжүүлэх, энгийн сурагчидтай хамт сургаж төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгаран гарч ирсэн. Дээрх сурагчдыг хөгжүүлж төлөвшүүлэхэд анхааран тасралтгүй 5 жилийн турш судалгаатай ажиллаж ирсэн. Мөн 2015 оны хичээлийн жилд дахин 1-р анги хүлээн авахад мөн хэл ярианы бэрхшээлтэй 1 сурагч, \Х.Маралгоо- дааврын булчирхайн эмгэг\, бөөрний архаг дутагдалтай гэсэн онош бүхий 1 сурагч \О.Саранзүг байнгын хэвтрийн дэглэм сахих шаардлагатай\ элсэн орж ирсэн. Эдгээр сурагчидтай 4 дэх жилдээ ажиллаж байна.

Ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй сурагчидтай ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн тул туршлагаа танилцуулж бусдад түгээн дэлгэрүүлэх боломжтой гэж үзлээ. \Сурагч У.Мичидмааг сонгон авлаа.\

Түлхүүр үг

Хэл яриа, сонсголын бэрхшээл, харааны хүртэхүй

Судалгааны арга: Сурагчдын ерөнхий хөгжил төлөвшлийг нээн илрүүлэхийн тулд ихэвчлэн ажиглалтын арга хэрэглэж, эцэг эх, ангийн найз нөхдөөс нь асуулгын аргаар судалгааг хийлээ. Мөн бодит байдлын судалгааг хийж хүүхдийн хувийн онцлог, чадвар, хүүхдийн үйл ажиллагааг нь төлөвлөв.

Судалгааны шинэлэг тал

Энгийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хөгжүүлж төлөвшүүлж үр дүнд хүрч болох арга замыг эрэлхийлснээрээ шинэлэг юм.

Онолын асуудал

Монгол улсын боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн болон тусгай сургалттай сургуульд сурах эрхтэй гэж заасан байдаг.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд” гэж төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, осол гэмтлийн улмаас бие эрхтэн, оюун ухаан, сэтгэц, тулах хөдлөх эрхтэн, мэдрэхүйн чадавх, амьдрах, хөдөлмөрлөх боломж хязгаарлагдсан нь тогтоогдсон хүүхдийг хэлнэ. \Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн хамгааллын тухай хууль. 2005.12.08\

Олон улсын өвчний ангиалал: \ICD -10\

- Харааны бэрхшээлтэй
- Сонсголын бэрхшээлтэй
- Хэл ярианы бэрхшээлтэй
- Тулах эрхтний бэрхшээлтэй
- Оюуны хомсдолтой
- Зан төлөвийн эмгэг өөрчлөлттэй гэж ангилдаг.

Манай сурагчдын хувьд сонсголын, хэл ярианы хосолмол бэрхшээлтэй сурагчид юм.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургалттай ЕБС-д хөгжүүлж төлөвшүүлэхэд, эрхээ бүрэн эдлэх боломжуудыг бий болгоход нийгмийн ажилтан, анги удирдсан багш нар маш сайн анхаарах хэрэгтэйг 5 жилийн ажлын үр дүнд мэдэрсэн. Ийм хүүхдүүдийн тухайд хайр халамж, дэмжлэг, урам зориг зэрэг нь хүчтэй нөлөөлж зан үйлийг нь зохицуулж байдгийг ажигласан.

Судалгаа

Судалгааны эхний шатанд: \Сурагч У.Мичидмаа \

- **Бие бялдрын хувьд:** Эрүүл чийрэг
- **Сэтгэхүйн хувьд:** Юмыг шууд ойлгон хүлээн авах чадваргүй боловч гар утасны тоглоом, компьютерийн тоглоом тоглож чаддаг.
- **Сонсголын хувьд:** Огт сонсголгүй

- **Хэл ярианы хувьд:** Огт ярихгүй, эвгүй дуу авиа гаргаж чанга дуугардаг
- **Хүмүүжлийн хувьд:** Өөрийн зүйлийг бусдаас харамлаж бусдыг цохих, муухай харах зэрэг ааш гаргадаг. Бусадтай харилцдаггүй. Их уурладаг
- **Тооны хичээл:** Тоо тоолох чадваргүй, цифр мэдэхгүй, бодит юмс тоолохгүй, дэвтрийн шугам ашиглаж мэдэхгүй, зурж бичих чадвар муу, өнгө ялгахгүй.
- **Монгол хэл:** Дэвтрийн шугам мэдэхгүй, дэвтэр ашиглаж чадахгүй, үсэг мэдэхгүй. Зурлага бичих чадвар муу

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн харааны хүртэхүйг хөгжүүлж ажилласан арга зүй

ЕБС-иудад тэгш хамруулах боловсрол олгогдож байгаа боловч олон шалтгааны улмаас сурагчид хоцорч тусгай сургууль руу шилжиж явдаг. Гэвч манай хоёр сурагчдын хувьд эцэг эхчүүд нь:

- Тусгай сургуульд явуулах боломжгүй
- Улаанбаатар хотод ах дүү хамаатан садан байхгүй
- Хүүхдүүд нь өөрсдөө биеэ даах чадвар муутай
- Тусгай сургуульд орсон бол төгслөө л тэндээ байхыг шаарддаг

Эцэг эх нь дэргэдээ харж хандаж байх нь дээр гэх мэт шалтгааны улмаас шилжин явах боломжгүй байсан. Иймээс тэднийг сурч хөгжих, төлөвших эрхийг хангахын тулд дараах арга барилаар ажиллалаа. Үүнд:

1. Ангийн сурагчид болон мэргэжлийн багш нарын сэтгэлгээг өөрчлөх:
2. 6 настай бяцхан суралцагч нарын хувьд тухайн сурагчыг гайхах, шоолох, шоглох, хоорондоо ойлголцохгүй байгаа үзэгдлүүд гарч байв. Багшийн зүгээс ангийн хүүхдүүдтэйгээ хөгжлийн бэрхшээлтэй байсан ч тэрхүү бэрхшээлийг даван туулахад хэн нэгэнд хэрхэн туслах талаар харилцан ярилцах, найзыгаа өрөвдөн хайрлаж, эелдэг харилцаа үүсгэн, тусалж дэмжих, найзлан нөхөрлөж байхыг зөвлөн, мөн энэ сэдэвтэй холбоотой бичлэг үзүүлж, кэйс уншуулж ярилцлага зохион байгуулж байв. Өөрийн ангид хичээл ордог мэргэжлийн багш нартай сурагч Мичидмаагийн бэрхшээлийг ойлгуулж, тэдэнд туслан тусгай дасгал даалгавар бэлтгэхэд анхаарсан.
3. Эцэг эхтэй нь хамтран ажиллах: Эцэг эхтэй нь уулзан хүүхдийн ахицыг нь хэлж, гэрт нь тав тухтай байлгах, багшаас өгсөн даалгаврыг хамтран хийх, чадаж байна гэсэн итгэл урам өгөхийг зөвлөдөг.
4. Сурагчидтай ганцаарчлан ажиллах: 7 хоногт 2-3 удаа 1-2 цагаар ганцаарчлан ажиллаж зураг зуруулах, өнгө ялгуулах, юмсын нэрсийг бичиж өгөн тогтоолгох зэрэг үйл ажиллагааг тогтмол хийх, багш өөртөө аль болох ойр суулгаж зурах, будах, хуулах, зургаар сурах дуурайн хийх даалгавар өгч ажиллууллаа.
5. Бусадтай хамтран ажиллах: Ижил хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг бие биед нь туслуулах замаар хамтран суралцуулсан. Мөн ангийн сурагчдаар туслуулан дэмжлэг үзүүлж ажилласны үр дүнд хүрсэн.

Сургалтын явцад бичүүлж сургахын тулд:

- Шугам, дэвтэр, ном гэдэг ойлголтыг биет зүйлүүд дээр тайлбарлах, дэвтрийн шугам гэдэг ойлголтыг дэвтэр дээр зааж өгөх, бусад хүүхдийн бичсэнийг харуулах, өөрөө бичиж үзүүлэх зэргээр ойлгуулах.
- Харандаагаар бичээд түүнийгээ давхардуулан бичүүлэх
- Гарыг нь барьж дагуулан бичүүлэх
- Хэв ашиглан дуурайлган бичүүлэх
- Бичих чадварыг хөгжүүлэх, сайжруулахын тулд хичээнгүй бичгийн дасгал ажлын дэвтэр ашиглах
- Бичмэлээр бичиж сурсны дараа дармалаас хуулах

- Самбараас хуулж бичих гэх мэт үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэх
- Тоолуулж сургахын тулд:
- Биет зүйлүүд ашиглах
- Гарын хурууг ашиглан тоолуулах, цифр таниулах
- Сонирхлыг нь татсан зураг ашиглах
- Шагай, савх, өнгийн харандаа ашиглаж цифрээ таниулж чадлаа.
- Мөнгийг хооронд нь ялган, их багыг мэддэг болсон.
- Тооны үйлдэл гүйцэтгэхдээ энгийн тооны машин болон гар утасны тооны машин ашиглуулж сургах

Хөгжүүлж төлөвшүүлэхийн тулд:

- Илүү цагаар зураг зуруулж, будуулах
- Өнгө ялгах чадварт нь голлон анхаарах
- Сурагчдыг бусдаас нь суралцуулах, даган дуурайлгах

Үг, нэрсийг нүдлүүлж тогтоолгохын тулд:

- Тусгай дэвтэр нээн өдөр бүр 3-5 шинэ үг бичин тогтоолгох. Шинэ үгээ бичих явцдаа тухайн бичиж буй эд зүйлээ заах, харуулах
- Өдөр бүр давтаж, нэрсийг заалгах
- Нэрс, эд зүйлийг заалгах явцдаа дэс дарааллыг байнга өөрчилж байх
- Эд зүйлээ зааж байгаад сурагчаар нэрийг нь бичүүлэх
- Журналын нэрсийг харуулж байгаад хүүхдийг заалгах
- Зөв заасан тохиолдол бүрт нь магтан, толгойг нь илэх, сайн байна гэсэн илэрхийллийг үзүүлэх гэх мэт олон янзын арга хэрэглэх.

Гарсан үр дүн

Сурагч У.Мичидмаа нь 5-р ангиа төгсөхдөө:

- 180 гаруй эд зүйлсийн нэрийг хараад зааж тухайн зүйлийг заадаг
- 5 жилийн турш дээрх арга зүйгээр ажилласны үр дүнд бичгийн хэв сайжирч, ангийн сайхан бичдэг сурагчдын нэг болсон.
- Ангийн багшийн нэр болон утасны дугаарыг бичиж чаддаг болсон
- Ангийн журнал дээрх сурагчдын нэрсийг хараад тухайн хүүхдийг заадаг болсон
- Гэр бүлийн гишүүдийн нэрсийг хараад зааж чаддаг чадвартай болсон.
- Зурах, будах, цаасаар бүтээл хийх сонирхолтой болсон.
- Хамт олондоо өөрийгөө ойлгуулж, ангийн сурагчид нь юу гэж байгааг нь дохио зангаагаар сайн ойлгож тусалж дэмжиж чаддаг. Анги хамт олонтойгоо 4 төрлийн бүжиг “Бий биелгээ”, “Сугсраан донж”, “Задгай цагаан”, “Хүмүүн төрөлхтөн” бүжгүүдийг 90 – 96%-ийн гүйцэтгэлтэй хийж сурахаас гадна 2-р цагийн хөгжимт дасгал “Gummy bear”, үдийн цайны дэг, завсарлагааны дэг гэх мэт бусад дэгүүдэд сургасан.
- Тооны машин, гар утас ашиглаж сурсан. Энэ нь өнөө үед маш чухал ач холбогдолтой. Өөрөө бие даан худалдан авалт хийхдээ тооны машин ашиглах, гар утас ашиглан өөрийн хэрэгтэй мэдээллийг олж авахад нь тустай юм.
- Хамт олонтойгоо эвсэг найрсаг харьцдаг
- Бусдад тусархуу
- Бүтээлийн хавтастай болж 40 гаруй бүтээлтэй болсон. Бүтээлээр нь “Зураг зурах сайхан” нэртэй ном бүтээлээ.

Баруун гар талд: У.Мичидмаагийн багшдаа өгсөн сэтгэл ханамж






Сурагч У.Мичидмаа бичвэр дуурайлган бичиж байгаа нь . 2010 он



Мичидмаагийн ээждээ бичиж өгсөн бэлэг 5-р анги /2015 он/



Сурагч У.Мичидмаагийн зурсан зураг



Сурагч У.Мичидмаагийн наасан наамлууд



Үдийн цайны цаг: зүүн талаас У.Мичидмаа



2-р цагийн хөгжимт дасгал
Эхний эгнээнд Зүүн гар талаас У.Мичидмаа \5-р анги\

Сурагч У.Мичидмаад хичээл зааж байсан багш

Сурагч У. Мичидмаад 2013 оноос 2015 оны хооронд технологийн хичээлийг заан явуулж байсан. Хичээлийн явцад түүнтэй харилцахдаа сурах арга барил нь хэл сонсголын бэрхшээлтэй байсан тул түүнтэй дохио зангаа зарим нэг үгийн бичвэрээр харилцдаг байсан. Тэр харсан үг өгүүлбэрийг дармалаас бичмэл болгон сайн бичдэг төдийгүй энгийн жишээ гэрэл, утас, цаас шугам, харандаа гэх мэт олон тооны үгийг ойлгодог нь хичээл заах явцад харагдсан төдийгүй дэс дарааллыг нь сайн ойлгуулсан нөхцөлд маш сайн хийж чаддаг байсан. Энэ чадварыг суулгахад бага ангийн багш нь нэлээдгүй сайн ажилласан байна гэж бид дүгнэдэг.

Сэтгэгдэл бичсэн технологийн багш *Хангалт* Г.Ганчимэг
2017.09.20.

Сэтгэл.

Сурагч Ч.Миндмаа нь нэгдүгээр ангид олон суралцаж бусдаас айм, шигт ганцаардсан, нийгмийн харилцаанд түгшээрчигдсэн байдалтай байсан.

Төхөөр байдал нь бусад хүүхдүүдийн зүгээс суралцахаар сурагч Миндмаа болон анги удирдсан багшийг аль алинд нь хүнд хөжүү байв.

Бөгөөд бэлтгэсэн Суралцагчид нь өөрийн гэсэн арга барилд өмнө, жилээр амжилтаснаар үг сурагч нь хэвд эрхлүүр и болгохос өрдийн хүүхдийн адил бөгөөд, бүрмөсдөг, үндэс (хөдөлгөөнөөр) бусадтай найзлагдсан хоёрлогдог байж гэдсэн.

Сургуулийн нийгмийн амжилт

СИА Сургууль

Б.Урагчаа

Сурагч Ч.Миндмаа 2016 оны нийгмийн

жилд 2017 оны 1-р үеийн хуртд анги удирдсан багшаар нь даан авч амжилсан.

Ч.Миндмаа нь сонсох нэг зунаар бэрхшээлтэй бэлдэ өмнө хэлт ажилтайгоо эвч, өөрийн санаа бодлоо айлгуулах гэдэгт, сургуули, олон нийгмийн амилуу үзвэртэй суралцаж, нийгмийн үзвэ сайтай. Бүрмөсдөг болон зургах авчдас нь хөжөөсөн. Тар бэлдэ төлөгдөө сайн. Хөвдөр нөхдөр шааршигаар 100 метрийн хүртэлх амжилттай суралцаж байсан. Өвчтөний бүрмөсдөг эвч үзвэ сайтай. Салбар болон зургах бүрмөсдөг нөгөөтүүд бүрмөсдөг нөгөөтүүд үзвэ сайтай. Эдгээр хөжөөг даа өмнө анги удирдсан бэлтгэсэн нь төрлийн бусад хүүхдээс түгшээрчигддөггүй бүрмөсдөг авчдас гэдгээр нөгөөтүүд бэлдээс нөгөөтүүд хөжөөг гэдгээр бэлтгэсэн.

Тодорхойлолт бүрмөсдөг: 5Б-ангийн АУБ. О.Оюунтүвш

Эхлээд бид суралцахаар ман хөжүү байсан бөгөөд дараа нь ман сайн харилцаанд бас амилуу ~~байсан~~ эхлэсэн. Миндмаа нөгөөтүүд нөгөөтүүд бусад дуртайн хийдэг болсон. Энэ нь бидэнд ман сайнаар нөгөөтүүд. Шүүдэг ч зөгсөжүг бусад, бусадтай ман ойлгож эхлэсэн. Миндмаа бусдад харгал, харилцаан эрхт байдалд ойлгож хийдэг. Ман авчдас, авчдас хүүхд юм. 5Б-ангийн сурагч Д.Төмөрчигдэн

Эхлээд бид Миндмаатай харилцаахад ман хөжүү байсан Харин бид Миндмаатай ^{бүрмөсдөг} үзвэ ман сайн ойлгож харилцаж сурсан. Өөрийн харилцаанд байсан бэлтгэсэн Миндмааг хөжөөг зөгсөн харилцаанд бас Миндмаа. ман үзвэнтэй хүүхд харин Миндмаа хөгжлийн бэрхшээлтэй байсан бэлтгэсэн ман үзвэнтэй хүүхд байх байсан юм бас суралцаж цовоо хүүхд байх байсан

5Б-ангийн сурагч Х.Миндмаа

Анх эрхлэхэд ман хөжүү байсан ажлаагаар тасалж эхлэсэн төлөгдөг суралцаж, суралцаж нөгөөтүүд бэлтгэсэн Миндмаа сайн суралцаж сэтгэлтэй ман өгөөг хүүхд байсан бас сэрлэн сэрлэн өмнө хөгжлийн өвчдөг бас авчдас хөгжлийн амилттай өмнө

Анх Миндмаатай ойлгохад ман хөжүү байсан Дараа нь дохиогоор ойлгож эхлэсэн Миндмаа нөгөөтүүд нөгөөтүүд. Найзүүдтайгаа Энэ хийрсэн гэдгээр. Бид Миндмааг өмнөтүүд бэрхшээлтэй байлаагүй бид бас нөгөөтүүд хүүхд байа байсан гэж эрхт, эрхт, эрхлэдэг. бөгөөд авчдас хүүхд юм.

5Б-ангийн 5Б-ангийн А.Криуновска

5Б-ангийн сурагч Б.Болоржигдэн

Дүгнэлт: Энэхүү арга замаар ажиллахад хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй сурагчдыг энгийн сургуульд сургаж, хөгжүүлж, төлөвшүүлж болдог гэдгийг харуулж байна. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд ганцаараа аливаа зүйлийг хийх, ганцаардмал хандлагатай байдаг. Тиймээс ийм хүүхдийг сургахдаа аль болох бусад хүүхдүүдтэй хамтран хийж гүйцэтгэх үйл

ажиллагааг зохион байгуулбал сайн. Мөн хүүхдүүд бие биедээ зааж сургах нь их зөв арга шиг санагддаг. Энэ нь энгийн хүүхдүүд давамгайлах хандлагаар оролцох биш харин зааж сургаж байвал бэрхшээлтэй сурагчдад илүү сайхан харилцаа бүрддэг. Нэгэнт сонсгол хэл яриагүй сурагчдыг хөгжүүлэхийн тулд харааны хүртэхүйг сайтар хөгжүүлж, нүдлэн тогтоох арга ихээхэн үр нөлөөтэй. Ингэж ажиллаж чадвал сурагчид маань илүү сайн хөгжиж, сурч, төлөвшиж чаддаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид тохиолдож болох хүндрэл бэрхшээлүүдийг хэрхэн даван туулах арга замыг оновчтой сонгох арга замд суралцах хэрэгтэй.

Ном зүй

1. *Хөгжлийн бэрхшээлтэй иргэлийн холбогдолтой хууль тогтоомжийн эмхтгэл УБ 2007 он*
2. *Анги удиодах урлаг DC Исмайл Боз 2000*
3. *Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй онол практикийн бага хурлын илтгэлийн дэлгэрэнгүй 2018 он*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дугуйлан секцээр хөгжүүлэх нь

Илтгэгч: ¹Р.Өлзийхишиг, ²Э.Өлзийдэлгэр

¹34-дүгээр сургуулийн захирал, ²3 дүгээр сургуулийн багш

Сэдэв сонгосон үндэслэл: Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөвхөн тусгай сургуулиар сургаж байсан бөгөөд тэдгээр сургуулиудад ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн маш бага хувь нь хамрагдаж байв. Хөдөө орон нутагт ажиллаж байсан тусгай сургуулиуд нь зах зээлийн нөхцөлд оршин тогтнох боломжгүй болж хаагдсаны улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ихэнх нь боловсролд хамрагдах боломж нь хязгаарлагдаж, нийгмийн эмзэг бүлгийн нэг хэсэг хэвээр үлдсээр байна. Ердийн сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч болох наад захын орчин бүрдээгүй, анги дүүргэлтийн тоо их, хүүхэд бүртэй тулж ажиллах боломж хомс, нийгмийн зүгээс ялгаварлан гадуурхах хандлага их, ядуугаасаа болоод суралцах боломжгүй, түүнчлэн сургууль нь хол оршдог, сургалтын хэрэгсэл дутмаг зэрэг нийгмийн талын материаллаг бэрхшээл саад болсон хэвээр байна. Сүүлийн хэдэн жилийн дотор Монгол улсын боловсролын тогтолцоонд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бөгөөд боловсролд тэгш хамруулах асуудлаар бодлого боловсруулах болон үндэсний хэмжээний бүтэц бүрдүүлэх талаар гарсан хамгийн сүүлийн үеийн томоохон ололтын нэг нь 2003 онд батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр" бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд ердийн сургууль, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт мэдэгдэхүйц нэмэгдсэн нь сэдвийг сонгох үндэслэл болсон.

Гол агуулга: Манай сургуульд 2013-2014 оны хичээлийн жилд “ХОС ЧАВХДАС” морин хуурын дугуйлан хичээллэж эхэлсэн. Сурагч Б-г аав ээж нь гар, хурууны үйл ажиллагааг нь сайжруулах, нот сурахаар юмыг амархан тогтоодог, оюун ухаан, сэтгэн бодох чадварыг нь хөгжүүлэх зорилгоор дугуйлангийн мэргэжлийн багшид сонголыг шалгуулж тэнцсэн. Дараа өдрөөс нь хүүхэддээ өөрт нь зориулан хуур худалдан авч сургалт 10 сарын 1-нээс эхэлсэн. 12-р сараас эхлэн гарын хөдөлгөөн сайжирч, нот хурдан тогтоогоод өөрийн болгож тоглож сурсан. 6 сарын дараа сургуулийнхаа “Бид авьяаслаг амжилтын эзэд” тайлан тоглолтод оролцож “Шилдэг сурагч” –аар шалгарсан.

- Жилийн дараа богино аяыг тоглодог болж сургууль болон дүүргийн олон уралдаан тэмцээнд орж эхэлсэн. 2дахь жилээс урт ая тоглож сурсан. “Ая эгшгийн 6 жигүүр” 2 жилд 1 удаа болдог улсын уралдаанд 2 удаа амжилттай оролцсон.
- Судалгааны 3 дахь жилээс хүссэн аяыг тоглох чавдартай болсон
- Судалгааны 4 дэх жил тухайн суралцагч өөрөө эрэл хайгуул хийж бие даах чадвар сайжирч хөөмийлж сурсан.
- 2017-2018 оны хичээлийн жилд “Бид авьяаслаг амжилтын эзэд” тайлан тоглолтын морин хуурын тоглолтыг удирдан оролцсон.
- Судалгааны 5 дахь жил: 2018-2019 оны хичээлийн жилд Завхан аймагт зохион байгуулагдсан 3000 морин хуурчийн тоглолтонд амжилттай оролцсон

- Морин хуурыг сайн судлахын зэрэгцээ бяцхан дүү нар, үе тэнгийн найзууд, ах эгч нартаа зааж сургаж, зөвлөн, удирдан чиглүүлж сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд амжилттай хамрагдан суралцаж байна.

Дүгнэлт: Дугуйланд хамрагдаж байгаа 10 сурагчаас судалгаа авахад тууштай байж цаг баримталдаг болж чадсан, хөгжмийн болон гоо зүйн мэдрэмжтэй, авьяасаа нээн хөгжүүлж найз, нөхөд, хамт олны дунд нэр хүндтэй болсон нь харагдаж байна. Тухайн хүүхэд өөрийгөө таних, би хэн бэ? гэдгийг нээж илрүүлж өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж өгсөн. Цаашид өөрийн мэргэжлийн чиг баримжааг олж авсан. Олон уралдаан тэмцээнд амжилттай оролцсон. Урилгаар хуур тоглодог. Найз нөхдийн хүрээлэл тэлсэн. Сургуулийн бүхий л үйл ажиллагаанд оролцдог болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхэд сургуулийн ХГҮА–ны цаг буюу дугуйлан, секц чухал ач холбогдолтой учир тэдгээр хүүхдүүдээ тэгш хамруулан сургах шаардлагатай.

Нэг. Удиртгал

1989 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассемблейгаар Хүүхдийн эрх, эрх чөлөөний тухай "Хүүхдийн эрхийн конвенц"-ийг баталсан ба түүнээс хойш гарсан олон улсын баримт бичиг, тунхаглалуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад боловсрол олгох, тэдний эрхийг хамгаалах, нийгэм хамт олон дунд нь нийгэмшүүлэх талаар онцлон заасан билээ. Энэ конвенцийн 23 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бүрэн дүүрэн аз жаргалтай амьдрахын тулд дэмжлэг тусламж, халамж хэрэгтэйгээс гадна сурч боловсрох эрх эдлэх, дээд зэргээр өөртөө итгэх, улмаар нийгмийн интеграцчилалд тэгш эрхээр бүрэн ханган оролцуулах буюу оролцох эрхтэй гэж заасан байдаг.

Боловсролын талаар 1994 онд гаргасан ЮНЕСКО-гийн "Нээлттэй удирдамж"-ийн гол санаа нь "Сургуулиуд бүхий л хүүхдэд үйлчилдэг байх ёстой" гэсэн боловсролд тэгш хамруулах зарчмын энгийн боловч чухал үзэл баримтлалд тулгуурладаг. Өөрөөр хэлбэл боловсролд тэгш хамруулах гэдэг нь хувь хүний хэв шинж, сул тал болон бэрхшээлээс үл хамааран бүхий л сурагчдад нээлттэй сургуулиудыг бий болгоно гэсэн үг. Ийм сургууль нь сурагчдын харилцан адилгүй байдлыг бэрхшээлтэй асуудал хэмээн үзэх бус харин ч урамшуулан сайшаадаг.

Хоёр. Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

2.1 Сэдвийг сонгосон үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь Монголд хэд хэдэн шалтгааны улмаас нэн чухал ач холбогдолтой юм. Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөвхөн тусгай сургуулиар сургаж байсан бөгөөд тэдгээр сургуулиудад ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн маш бага хувь нь хамрагдаж байв. Хөдөө орон нутагт ажиллаж байсан тусгай сургуулиуд нь зах зээлийн нөхцөлд оршин тогтнох боломжгүй болж хаагдсаны улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ихэнх нь боловсролд хамрагдах боломж нь хязгаарлагдаж, нийгмийн эмзэг бүлгийн нэг хэсэг хэвээр үлдсээр байна. Ердийн сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч болох наад захын орчин бүрдээгүй, анги дүүргэлтийн тоо их, хүүхэд бүртэй тулж ажиллах боломж хомс, нийгмийн зүгээс ялгаварлан гадуурхах хандлага их, ядуугаасаа болоод суралцах боломжгүй, түүнчлэн сургууль нь хол оршдог, сургалтын хэрэгсэл дутмаг зэрэг нийгмийн талын материаллаг бэрхшээл саад болсон хэвээр байна. Сүүлийн хэдэн жилийн дотор Монгол улсын боловсролын тогтолцоонд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бөгөөд боловсролд тэгш хамруулах асуудлаар бодлого боловсруулах болон үндэсний хэмжээний бүтэц бүрдүүлэх талаар гарсан хамгийн сүүлийн үеийн томоохон ололтын нэг нь 2003 онд батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр" бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд ердийн сургууль, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт мэдэгдэхүйц нэмэгдсэн нь сэдвийг сонгох үндэслэл болсон.

2.2 Судалгааны орчин, нөхцөл:

Хан –Уул дүүргийн 34-р сургууль нь 1091 сурагчидтай. Тэдгээрээс ХБХ-ийн тоог доорх хүснэгтэд харуулав.

Түвшин	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Бага	3	1					2	1	1			
Дунд	2			1						1	2	
Ахлах	1	1								1		

2.3 Хамрах хүрээ: морин хуурын дугуйланд 4-12 –р ангийн 15 сурагчид хамрагдаж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэх зорилгоор дугуйлан, секцэд тогтмол хамруулан ажиллаж байна.

2.4 Эерэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа

2013-2014 оны хичээлийн жилийн 10 сараас морин хуурын дугуйлан хичээллэж эхэлсэн. Эхний 2 сараас эхлэн гарын хөдөлгөөн сайжирч, нотоо түргэн тогтоож, шууд хараад тоглодог болсон.

Гурав. Хугацаа

2013-2014 хичээлийн жилээс 2018-2019 оны хичээлийн жил хүртэлх 5 жилийн хугацаанд судалсан.

Дөрөв. Хэрэгжүүлсэн байдал

4.1 Гол үйл ажиллагаа

Манай сургуульд 2013-2014 оны хичээлийн жилд “ХОС ЧАВХДАС” морин хуурын дугуйлан хичээллэж эхэлсэн. Сурагч Б-г аав ээж нь гар, хурууны үйл ажиллагааг нь сайжруулах, нот сурахаар юмыг амархан тогтоодог, оюун ухаан, сэтгэн бодох чадварыг нь хөгжүүлэх зорилгоор дугуйлангийн мэргэжлийн багшид сонголыг шалгуулж тэнцсэн. Дараа өдрөөс нь хүүхэддээ өөрт нь зориулан хуур худалдан авч сургалт 10 сарын 1-нээс эхэлсэн. 12-р сараас эхлэн гарын хөдөлгөөн сайжирч, нот хурдан тогтоогоод өөрийн болгож тоглож сурсан. 6 сарын дараа сургуулийнхаа “Бид авьяаслаг амжилтын эзэд” тайлан тоглолтод оролцож “Шилдэг сурагч” –аар шалгарсан.

- ✓ Жилийн дараа богино аяыг тоглодог болж сургууль болон дүүргийн олон уралдаан тэмцээнд орж эхэлсэн. 2дахь жилээс урт ая тоглож сурсан. “Ая эгшгийн 6 жигүүр” 2 жилд 1 удаа болдог улсын уралдаанд 2 удаа амжилттай оролцсон.
- ✓ Судалгааны 3 дахь жилээс хүссэн аяыг тоглох чавдартай болсон
- ✓ Судалгааны 4 дэх жил тухайн суралцагч өөрөө эрэл хайгуул хийж бие даах чадвар сайжирч хөөмийлж сурсан.
- ✓ 2017-2018 оны хичээлийн жилд “Бид авьяаслаг амжилтын эзэд” тайлан тоглолтын морин хуурын тоглолтыг удирдан оролцсон.
- ✓ Судалгааны 5 дахь жил: 2018-2019 оны хичээлийн жилд Завхан аймагт зохион байгуулагдсан 3000 морин хуурчийн тоглолтонд амжилттай оролцсон
- ✓ Морин хуурыг сайн судлахын зэрэгцээ бяцхан дүү нар, үе тэнгийн найзууд, ах эгч нартаа зааж сургаж, зөвлөн, удирдан чиглүүлж сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд амжилттай хамрагдан суралцаж байна.



Судалгааны явцын бичлэгүүдийг тухайн цаг үед нь байршуулж архивлав

<https://www.facebook.com/enkhubayr.olziidelger/videos/1343772172416953/>

<https://www.facebook.com/enkhubayr.olziidelger/videos/1343747685752735/>

<https://www.facebook.com/baigalmaa.tsoodol/videos/1173354152718084/>

<https://www.facebook.com/baigalmaa.tsoodol/videos/1170903506296482/>

<https://www.facebook.com/enkhubayr.olziidelger/videos/864988883628620/>

<https://www.facebook.com/enkhubayr.olziidelger/videos/959549394172568/>

<https://www.facebook.com/bilguun.bilguun.1209/videos/463954967447551/>

<https://youtu.be/awUJfFQwM>

<https://www.facebook.com/100009471155416/videos/2171921339800217/>

<https://www.facebook.com/PresidentBtKh/videos/1916657348403950/>

<https://www.facebook.com/bayanzul.zagarjav/videos/1871802839562055/>

Дугуйлангийн багшийн арга зүйн туршлагаас: Бусдаас ялгаатай талыг харж үздэггүй, бусад хүүхдүүдийн адил үүрэг даалгавар өгдөг. Сурагчийн хувьд нээлттэй, тулгамдаж байгаа асуудлаа хэлдэг. Хуураар хичээллэж байгаа үед гар нь байнгын хөдөлгөөнтэй байдаг учир гарын булчин, шөрмөсний үйл ажиллагаанд маш сайн нөлөөлсөн. Өөрийгөө дутуу гэж үнэлж байсан нь асар өөрчлөгдөж, өөрөөрөө бахархах сэтгэл төрсөн. Бусад хүүхдүүдийн үнэлэх үнэлэмж нь сайжирсан. Сурагч өөрөө эрэл хайгуул хийж сурч байна. Багшгүйгээр бие даан сурч байна. Тууштай байж сурсан. Зүрх сэтгэлээ гаргаж ажилладаг болсон. Хуурандаа маш их хайртай. Цаашид хуураар хичээллээд явах мэргэжлийн чиг баримжаагаа олж авсан.

Бие биенээсээ суралцсан зүйл: Тэвчээртэй сууж сурсан. Нот тогтоох нь аливаа зүйлийг нүдэлж тогтооход дөхөм болгодог. Ая сонсоод сэтгэлдээ хоногшуулсан ая шууд тоглодог болсон. Хүүхдүүдийн сурч чадахгүй байгаа хүнд аяыг түргэн сурч, бусаддаа заадаг, тусалдаг болсон. Тайлан тоглолт болон бусад тоглолтыг удирдан зохион байгуулж бусаддаа зааж сургаж зөвлөдөг болсон.



Дугуйланд хамрагдаж байгаа 10 сурагчаас судалгаа авахад тууштай байж цаг баримталдаг болж чадсан, хөгжмийн болон гоо зүйн мэдрэмжтэй, авьяасаа нээн хөгжүүлж найз, нөхөд, хамт олны дунд нэр хүндтэй болсон нь харагдаж байна.



Хуурын дугуйлангийн сурагчид болон ангийн найзуудаас авсан судалгаанаас харахад аливаа зүйлд нээлттэй байж чаддаг, тусч энэрэнгүй, бичгийн хэв сайжирч, хурдан тогтоодог, цаг баримталдаг, нэр хүндтэй, түүнийг сургуулийн бүх хүмүүс таньдаг болсон нь дугуйлангаар хичээллэсний давуу тал болж байгаа нь харагдаж байна.

Тав. Судалгааны үр дүн

5.1 Зорилгодоо хүрсэн байдал

Тухайн хүүхэд өөрийгөө таних, би хэн бэ? Гэдгийг нээж илрүүлж өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж өгсөн. Цаашид өөрийн мэргэжлийн чиг баримжааг олж авсан. Олон уралдаан тэмцээнд амжилттай оролцсон. Урилгаар хуур тоглодог. Найз нөхдийн хүрээлэл тэлсэн. Сургуулийн бүхий л үйл ажиллагаанд оролцдог болсон.

5.2 Яагаад сайн болсон бэ?

Аав ээжийн дэмжлэг маш сайн. Дугуйлангийн багш ялгаатай байдлыг нь чухалчилдаггүй, бусад хүүхдийн адил үүрэг даалгавар өгч зааж сургасан. Хүүхэд өөрөө суралцах чин хүсэлтэй. Өөрийгөө дутуу гэж үнэлж байсан нь өөрчлөгдөж өөртөө итгэлтэй, өөрөөрөө бахархсан, маш их тэмүүлэлтэй, нээлттэй болсон.

5.3 Бусад хүргэх туршлага

Найз нөхдийн дунд яаж давуу талыг нь бий болгох вэ? Тухайн хүүхдийн сул талыг давуу тал болгон хөгжүүлэхэд сургуулийн хгүа –ны цаг буюу дугуйлан, секц чухал ач холбогдолтой учир тэдгээр хүүхдүүдээ тэгш хамруулан сургах шаардлагатай.

5.4 Цаашид хөгжүүлэх санал

1. ХБХх –ийг илүү олон дугуйлан, секцээр хичээллүүлж үр дүнг бусдад тайлагнан бүтээлийн үзэсгэлэн гаргах.
2. Олон уралдаан тэмцээнд оролцуулах

ТАВ. СУДЛАГДАХУУНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

БАГА БОЛОВСРОЛЫН САЛБАР

Хүн ба байгалийн хичээлд бодит ба дүрслэлт үзүүлэнг ашиглах нь

“Загас, мэлхийн үржил хөгжил” ээлжит хичээлийн арга зүйн жишээн дээр

¹М. Хоролмаа, ²Ш. Оюунбилэг, ³Б. Цэрэндэжид, ⁴Б. Наранчимэг,

⁵Я.Болормаа, ⁶Т.Сүрэнжав, ⁷Г.Ванчигмаа

¹Завхан, Улиастай, Жавхлант цогцолбор сургуулийн сургалтын менежер,

²Завхан, Улиастай, Жавхлант цогцолбор сургуулийн багш нар,

Удиртгал

Дэлхийн даяаршлын үед улс орон бүр тогтвортой хөгжлийн боловсролын гол үзэл санааг хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна. Манай улсын хувьд боловсролын шинэчлэлийн бодлогын үр өгөөжтэй зорилтын нэг болсон хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн арга зүйгээр цөм хөтөлбөрийг шат шатны боловсролын түвшиндээ хэрэгжүүлж байна. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын хүн бүрийн үүрэг оролцоо чухал төдийгүй тэр дундаа багш нарын бүтээлч сэтгэлгээ, хамтын хөдөлмөр, чанартай үйлчилгээ нэн чухал байр суурийг эзэлнэ. Чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд багш нарын сургалтын арга барил, мэргэжил, мэргэшлийн чадвар, хэрэгжүүлэх хичээлийн төлөвлөлт, хамтын ажиллагаа багагүй үүрэгтэй байдаг. Сайн хичээлийг менежмент сайтайгаар төлөвлөн хэрэгжүүлэх нь хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг ажлын байран дээр нь хөгжүүлэх оновчтой арга юм. Энэ удаад хэрэгжүүлсэн сайн хичээлийн хувьд сэдэлжүүлэлт, сэргээн санах, таамаглал дэвшүүлэх үйлийн үед ажлын хүснэгт өгч царцаа ба эрвээхийний үржлийн ялгаатай ба ижил талыг илрүүлэх нээлттэй асуултаар суралцагчдын дунд хэлэлцүүлэг хийж, хичээлийн өрнөл буюу мэдлэг бүтээх хэсэгт загас мэлхийний үржил хөгжлийг загварчлах аргаар илрүүлэн баталж, хичээлийн төгсгөл хэсэгт дүгнэлтийг харьцуулан гаргасан. Ингэснээр суралцагчийн сонирхон судлах, харьцуулан оюун дүгнэлт гаргах суралцахуйн бүтээлч үйлийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг авчирсан. 5-р ангийн Хүн ба байгалийн хичээлийн хөтөлбөрт тусгагдсан “Амьтдын үржил хөгжил” нэгж сэдвийн хүрээнд “Загас мэлхийн үржил хөгжил” ээлжит хичээлийг ажиглах болон загварчлах аргаар төлөвлөн хэрэгжүүлсэн сайн хичээлийн үр дүнг танилцууллаа.

Онол арга зүйн үндэс:

Үзүүлэн таниулахыг шинж чанараар нь :

1. Бодит үзүүлэн

2. Дүрслэлт үзүүлэн \зураг, кино\

3. Тэмдэгт үзүүлэн \график схем\ гэж ангилж болно.

Үзүүлэн таниулах нь хүүхдийн анхаарлыг төлөвшүүлэх, хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлдэг. Бодит ба дүрслэлт үзүүлэн нь **хүнд сэдэв заах** эсвэл сурагчдаар ажиглуулж, харьцуулж загварчлах мөн дүгнэлт гаргуулах, нэгтгэн дүгнэж бататган ойлгох үйл ажиллагаанд хэрэглэх нь илүү үр дүнтэй. Мөн сурагчид өөрсдийн үзсэн харсан зүйлээ бусдад тайлбарлан ярилцах нь хүүхдийн ярих чадварыг хөгжүүлэх, мэдээллийг бодит байдлаар төсөөлөн хүлээж авах, сургалтын үйл ажиллагааг дээшлүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой. Үзүүлэн таниулах арга нь онол практик хоёрыг зэрэгцүүлэн авч үзэж болдог учраас энэ зарчмыг хэрэгжүүлэхэд багш тодорхой шаардлагуудыг хангах ёстой.

Сэдвийг сонгосон чиг хандлагын үндэслэл:

Манай орны боловсролын хувьд хүүхэд нэг бүрийг болон багшлахуйн арга зүйг хөгжүүлэх гэсэн хүн төвтэй бодлогыг боловсролын чанарын шинэчлэлийн зорилт болгон хэрэгжүүлсэн. Иймээс багш нар цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн багаар хамтран, судалгаатай ханддаг болж эхэлсэн. Үүнд:

1.3-5- р ангид орж ирсэн Үржил хөгжил гэсэн нэгж сэдвийн хүрээнд мэргэжлийн бус багш заахад хүнд нүдэнд үзэгдэхгүй далд ертөнцийн учир шалтгааны үндэс суурийг нь зөв тавих,байгалийн ухааны хичээлд,дур сонирхолтой болгох.

2.Багш өөрөө хөгжих боломжтой болсон.

3.Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар “Загас мэлхийн үржил хөгжил”-ийг судлах хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг хамтран хөгжүүлэх

4. Хөтөлбөрийг оновчтой арга зүйгээр төлөвлөн хэрэгжүүлснээр гол мэдлэгийг ойлгуулах боломжтой төдийгүй хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлдэг эсэхийг судлах арга зүйн туршлагаа хуваалцах, бусдаас зөвлөгөө авч хөгжүүлэхээс үүдэн энэхүү илтгэлийг толилуулж байна.

Сэдвийг сонгосон практик үндэслэл:

Багш арга зүйгээ өөрчилснөөр хүүхэд хөгжинө. Хүүхэд хөгжинө гэдэг бол мэдлэг бүтээх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бусадтай хамтран ажиллаж ,харилцаж өөрийгөө хөгжүүлнэ гэсэн санаа. Иймээс суралцагчаа зөв чиглүүлэх сургалтын чанарыг дээшлүүлэхэд сургалтын бодит ба дүрслэлт хэрэглэгдэхүүнээр дэмжиж хүрсэн үр дүнг

- 2015-2016 оны хичээлийн жилд Завхан аймгийн Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 3-р ангийн 5 бүлэгт Хүн ба орчин хичээлийн “ Амьд биеийн өсөлт хөгжил ” судалгаат хичээл
- 2016-2017 оны хичээлийн жилд “ Цэцэгт ургамлын үржил хөгжил ” судалгаат хичээлийг мөн тус сургуулийн 5-р ангийн 4 бүлэгт заан сайжруулсан туршлагыг
- Цэцэг ургамлын үр тогтолт судалгаат хичээлийг Бага боловсролын сургууль дундын заах аргын нэгдлийн ажилд заан хэлэлцүүлэн дахин сайжруулсан
- Цэцэгт ургамлын тоос хүртэлт ээлжитийг аймгийн сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөнд оролцон түгээн дэлгэрүүлсэн .
- Улмаар бага ангийн хүн байгаль хичээлийн агуулагт байсан амьд биеийн үржил хөгжил бүлэг сэдвийн хүрээнд “ Багшийн сэтгэл хүүхдэд 2 ” төвийн бүсийн аймгийн сургалтанд түгээн дэлгэрүүлсэн нь амжилттай хэрэгжсэн зэрэг үндэслэл байна.


2017-2018 оны хичээлийн жил бага боловсролын цөм хөтөлбөрт “ Амьтны үржил хөгжил ” гэсэн нэгж хичээлийн Загас, мэлхийний үржил хөгжил сэдвийг 5-р ангийн сурагчдад хялбар **дөхөм аргаар ойлгуулах боломж юу байгааг хайх зорилгоор** мэргэжлийн багийн хэлэлцүүлгээр илрүүлж, хэрхэн хэрэгжүүлэх арга зүйг боловсруулж, туршин хэрэгжүүлэхээр уг сэдвийг сонгосон юм.

“Хичээлийн санаа”: “Загас, мэлхийний үржил хөгжил” гэсэн ээлжит хичээлийн эхлэл буюу сэдэлжүүлэх хэсэгт яагаад? асуултаар баг доторх хэлэлцүүлгийг өрнүүлж, нэгдсэн хэлэлцүүлгээр багуудын санал, таамаглалыг сонссон. Хичээлийн мэдээлэл боловсруулах буюу тайлбарлах хэсэгт загас мэлхийний үр тогтолт усан орчинд явагддаг ба гадаад үр тогтолттойгоороо ижил болохыг загварчлах аргаар , бүрэн ба бүрэн бус хувиралтайг ажиглах , харьцуулах замаар ялгааг гаргуулсан. Энэ нь суралцагчийн идэвхтэй, бүтээлч суралцахуйн үйлийн дэмжлэгтэйгээр хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх, сонирхолтой арга байснаараа онцлогтой.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Улиастай сумын ЖЦС-ийн бага боловсролын 12 багш, бага боловсролын сургалтын менежер М. Хоролмаа /Тэргүүлэх/ химийн багш Б. Цэрэндэжид \Тэргүүлэх\ нартай хичээлийн бэлтгэл судалгааг хамтран хийж, хөтөлбөрийг 2 удаа туршин хэрэгжүүлж, ажиглалт, хэлэлцүүлгээр илрүүлсэн саналдаа үндэслэн хөтөлбөрийг сайжруулж ажилласан. Хэрэглэгдэхүүний судалгааны хүрээнд байгалийн ухааны кабинетийн **загас, мэлхийн**

аквариум, загас мэлхий загасны үржил хөгжлийг дүрслэлт үзүүлэн\ кино, зураг\ , тарааж өгөх материал болон өмнөх мэдлэгийг илрүүлэх ажлын хүснэгт зэргийг бэлтгэсэн.

Сайн хичээл: 2018 оны 04-р сарын 15-2" нд “ Загас , мэлхийний үржил хөгжил ” сайн хичээлийн бэлтгэл судалгааг хийж , бага боловсролын багш нар ЕБЖЦ сургуулийн 5б ангийн 32 суралцагчдын дунд туршин хэрэгжүүлж, сургалтын менежер болон бусад багш нараас зөвлөгөө авч хамтран сайжруулсан. 2018 оны 04-р сарын 23-нд дээрх бүрэлдэхүүнтэйгээр 4 ажиглагчтайгаар, анхны хэлэлцүүлгээс сайжруулсан хөтөлбөрийг сургуулийн 5г ангийн 25 суралцагчдад хэрэгжүүлж, хэлэлцүүлгээс ажлын хуудас ашиглан хичээлийг явуулах гэсэн саналыг авч хөтөлбөрийг 3 дахь удаагаа сайжруулсан.



Загвар1а. Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх


Эндээс суралцагчдын харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлэхийн тулд ээлжит хичээлийн үе шат бүрд тодорхой ахисан түвшний үйлийг төлөвлөн хэрэгжүүлэх нь оновчтой шийдэл болж чадсан.

Судалгааны хамрах хүрээ, хугацаа, давтамж:


Судалгаанд хамрагдсан сургууль, анги, бүлэг (сурагчийн тоо)	Хичээлийн жил	Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн багш
Амьд бие хэрхэн өсдөг вэ? 3а, б, в,г, д ангиуд /148 сурагч /	2015-2016	Ш, Оюунбилэг, Р. Янжмаа Ч. Алтанцоож, Я. Болормаа, Т. Сүрэнжав
Жавхлант цогцолбор сургууль “ Цэцэгт ургамлын үржлийн эрхтэн ” 5а, б, в, ангиуд \ 82 сурагч \	2016-2017	Ш.Оюунбилэг, Б. Наранчимэг Я. Болормаа
Жавхлант цогцолбор сургууль “ Ургамлын үр тогтолт ” 5в, г, а, ангиуд \ 89 \		Ё. Хоролсүрэн, Т. Сүрэнжав Я. Болормаа
Жавхлант цогцолбор сургууль “ Цэцэгт ургамлын тоос хуртэлт ” 5в, 5а, 5г \ 89 сурагч \		Ч. Алтанцоож, Н. Уранбилэг Д. Баасанхүү
Ерөнхий боловсролын Жавхлант цогцолбор сургууль “ Загас, мэлхийний үржил хөгжил ” 5а, б, в, г, д \ 143\	2017- 2018	Ш. Оюунбилэг, Я. Болормаа Т. Сүрэнжав, Б. Наранчимэг



Ээлжит хичээл : Цэцэгт ургамлын үржлийн эрхтэн




Ээлжит хичээл : Ургамлын үр тогтолт



Ээлжит хичээл : Цэцэгт ургамлын тоос хүртэлт

Судалгааны үр дүн:



Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөнд хийсэн зарим сайжруулалтыг дараах алхмаар хийсэн.

А. Загас ба мэлхийний үржил хөгжлийн ижил болон ялгаатай байгааг ажиглах загварчлах аргаар илрүүлэн, нээлттэй асуултаар хэлэлцүүлэн гарган авсан үр дүнг эрдэмтдийн гаргасан үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Б. бодит ба дүрслэлт үзүүлэн ашиглан загас, мэлхийний амьдралын эргэлтийг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн



В. Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илрүүлсэн, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн

Хичээлийн үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг:		
Таамаглал дэвшүүлэх-сэргээн санах, сэдэлжүүлэх	-Суралцагчдад ажлын хуудас тараан өгч өмнөх мэдлэгийг сэргээн сануулах . - тараан өгч баг доторх хэлэлцүүлгээр эрвээхий ба царцааны, гэрийн ялаа, жоомны үржил хөгжлийн онцлогийг тайлбарлуулсан. - Загас ба мэлхийний тухай ярилцаж үржил хөгжлийн талаар хэлэлцүүлж таамаглалыг самбарт тэмдэглэсэн.	1. Асуултаар өмнөх мэдлэгийг сэргээн сануулах явцад цагийн алдагдалд оруулсан. Иймээс багийн дунд ажлын хүснэгт өгч хэлэлцүүлсэн. 2. Царцаа ба эрвээхийний амьдралын эргэлтийн ижил болон ялгаатай талыг хэлэлцүүлэн харьцуулж дүгнэсэн.

Хичээлийн өрнөл хэсэг:		
Туршилт ажиглалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх-мэдлэг бүтээх	-Анги нийтээрээ хэлэлцэн гаргасан үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу сурах бичгийн загасны үржил хөгжлийн тухай мэдээллийг уншиж судлан багаараа хэлэлцэж , загасны амьдралын эргэлтийг түлхүүр үг ашиглан загварчилж,мэлхийний хөгжлийн үе шатыг ажиглалт хийж харьцуулах аргаар, бүрэн ба бүрэн бус хувиралтайг тодорхойлсон. -Үржил хөгжлийн ялгаатай байдлыг багаараа болон анги нийтээрээ хэлэлцсэн. Хүүхдүүдийн ялгаатай байдлыг \сурах арга барил\ харгалзаж үзээгүй.	1. Загас ба мэлхийний үржил хөгжлийн ялгаатай байгааг ажиглалт ба загварчлалын үр дүнгээс хэлэлцүүлэн гаргасан. 2. Загас ба мэлхий нь гадаад үр тогтолтойгоороо царцаа ба эрвээхийнээс ялгаатай байгаа шалтгааныг багаар болон анги нийтээрээ хэлэлцэн гаргасан. 3. Хүүхэд нэг бүрийн оролцоог дэмжих зорилгоор даалгавар 3-ыг ажиллуулахдаа хүүхэд нэг бүрийн ялгаатай байдлыг харгалзаж үзсэн.
Хичээлийн төгсгөл хэсэг:		
Туршилтын үр дүнг нэгтгэх, боловсруулах, тайлбарлах	-Загас ба мэлхийний үржил хөгжлийн амьдралын эргэлтийг загварчилж дүгнэлт гаргасан . -Ярих, илтгэх чадвар сайтай суралцагч туршилтын үр дүнг боловсруулан, танилцуулж тайлбарладаг байсан.	1. Дүгнэлт гарган тайлбарлахад хугацаа их хэмжээгээр зарцуулж хүүхдүүд тайлбарлахад учир дутагдалтай байсан. 2. Багийн бүх гишүүдийг оролцуулснаар суралцагчдын тэгш оролцоог хангасан төдийгүй ярих, илтгэх чадвар буюу харьцуулан судалж, дүгнэлт гаргах чадварын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг болсон.

Ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнгээс:

- Эхлэл хэсгийн сэргээн сануулах үйлээс үүдэлтэйгээр гарсан цагийн алдагдлыг бууруулж, нягтаршуулах зорилгоор зөвхөн **ажлын хүснэгт** дээр ажиллуулж, судлах зүйлийг гаргах
- Загас ба мэлхийний үржил хөгжлийн тухай онолын мэдлэг ашиглан загварчлуулан, загвараас нэгдсэн хэлэлцүүлгээр дүгнэлтийг гаргах
- Мэлхийн амьдралын эргэлтийг ойлгохын тулд харгалзуулах даалгаврыг багаараа хамтарч хийж гүйцэтгэх явцад сурагчдын оролцоо бага байсныг хэлэлцээд , хүүхэд нэг бүрийг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор уг даалгаврыг хүүхэд нэг бүр ажиллуулахаар дараагийн төлөвлөлтөндөө тусгасан.

Б. Гол санааг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Багшийн асуулт, үндсэн үйл ажиллагаа	Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн явц, үр дүн	Тухайн хэсгийн дидактик шийдэл, сайжруулалт
<i>Хичээлийн эхлэл хэсэг:</i>		
Ажлын хүснэгтээр өмнөх мэдлэгийг сэргээн сануулахыг сонгосон. Өмнөх мэдлэгийг багаар болон анги нийтээр хэлэлцүүлэх	- Ажлын хүснэгтийг ажиллуулснаар цагийн алдагдлыг багасгасан.	-Царцаа болон эрвээхий зэрэг шавжийн амьдралын эргэлтийг онолоор тайлбарлан хөгжүүлэх боломжтой.
<i>Хичээлийн өрнөл хэсэг:</i>		

-Дотоод ба гадаад үр тогтолтой байна уу? Бүрэн ба бүрэн бус хувиралтай эсэх загас ба мэлхийний үржил хөгжлийн ялгаатай ба ижил талыг яагаад гэсэн асуулгаар хэлэлцүүлэг хийх	-Ялгаатай байгаа шалтгааныг видео бичлэгээр ажиглан даалгавар гүйцэтгэсэн. -Загас ба мэлхийний үржил хөгжлийг ойлгохын тулд загвараар илэрхийлсэн дадлага ажлаас тодорхойлуулсан. - Өөрөөр хэлбэл загас ба мэлхийний үржил хөгжлийн онцлог болон ялгаатай ба ижил талыг нь гаргуулж дүгнэлт хийсэн.	- Ялгаатай байгаа шалтгааныг видео бичлэгээр харуулах - Мэлхий бүрэн хувиралтай үржлийн үедээ усанд амьдардаг бусад үед хуурай газар амьдардаг хоёр нутагтан . Загас бүрэн бус хувиралтай гадаад үр тогтолтой гэсэн ялгааг баталсан. - Бодит ба дүрслэлт үзүүлэнгээс загварчлах санааг дэвшүүлсэн.
<i>Хичээлийн төгсгөл хэсэг:</i>		
Туршилтын үр дүнг нэгтгэн дүгнэх, тайлбарлах	Даалгавар 1 2 3 4-ийг ажиллаж дараах дүгнэлтийг гаргасан.	- Видео бичлэг болон бодит үзүүлэн ашиглан нүдэнд үзэгдэж ,гарт баригдахгүй зүйлийг загварчлан нэгтгэн дүгнэсэн.

В. Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илрүүлсэн суралцагчдын гаргасан алдаа, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн

Асуулт	Суралцагчдын гаргасан алдаа	Хөтөлбөрт алдаанаас сэргийлэх төлөвлөлтийг тусгасан байдал	Суралцагчдад илэрч байгаа эерэг хандлага, өөрчлөлт
Хөтөлбөр А	Таамаглал дэвшүүлэх үе шатанд олон хаалттай асуулт асуухад сурагчид өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олдоогүй .	Хоёр асуултыг нэгтгэж нэг болгосон .	Цагийн алдагдал багасч сурагчдад асуултанд хариулах боломж нээгдсэн.
	Багт нэг ширхэг харгалзуулах даалгаврыг өгсөн нь багийн сурагч бүр хичээлд ТӨМ-тай ажиллах боломж олгоогүй.	Хүүхэд бүр оролцохоор ТӨМ-ыг олшруулсан.	Хүүхэд нэг бүрийг тэгш оролцох бололцоог хангасан.
Хөтөлбөр Б	Ажлын хуудсыг нэмэлтээр өгснөөр сурагчдын хичээлийн алхам тодорхой болж цагийн алдагдал үүсээгүй.	Даалгавар нэгийг ажлын хүснэгттэй болгосноор олон асуулгаар төөрөгдөлд оруулаагүй.	Видео бичлэг болон бодит үзүүлэн ашигласнаар ажиглах харьцуулах нэгтгэн дүгнэх чадвар нэмэгдсэн.

Дүгнэлт:

Дээрх сайн хичээлийг хэрэгжүүлсэн үр дүнгээс багш нар нүдэнд үзэгдэхгүй , гарт баригдахгүй зүйлийг бодит ба дүрслэлт үзүүлэн ашиглан мэдээллийг орхигдуулахгүйгээр танин мэдэх нь хамгийн чухал гэдгийг ойлгосон. Өөрөөр хэлбэл хөтөлбөр “А”-д мэдээлэл боловсруулан мэлхий ба загасны амьдралын эргэлтийг харьцуулах , загварчлах аргаар хүүхдэд хүргэхийг чухалчилсан. Харин хөтөлбөр

“Б”-д суралцагчдын шинжлэн судлах чадвар, танин мэдэхүйн чадамжийн дэмжлэгтэйгээр аливаа нүдэнд үзэгдэхгүй ойлголтыг бодит ба дүрслэлт ашиглан харьцуулах, загварчлах аргаар хэрэгжүүлсэн.

Хүн ба байгалийн ухааны хичээлийг бодит байдлаар загварчлан тодорхойлсон нь нүдээр харж харьцуулан судалж, дүгнэлтийг үнэн бодитоор гаргадаг гэсэн эерэг үр дүнг тодорхой хэмжээгээр авчирдаг болохыг харуулсан. Суралцагчид хүн ба байгалийн ухааны хичээлийг бодитоор харж загварчилснаар дүгнэлт хийх чадвар нь сайжирсан төдийгүй, нүдэнд үзэгдэхгүй жижиг хэсгийг загварчлан хийлгэснээр хүүхдийн бодитоор мэдэрч, хөгжих хүслийг нэмэгдүүлэн оролцох, хийж бүтээх эрмэлзлийг бий болгосон.

Бодит ба дүрслэлт үзүүлэн хэрэглэснээр гарсан эерэг үр дүнгээс:

Суралцагчдад : Амьд харилцааг бий болгож, амьтдыг хайрлах, тэднийг хооллох, арчлах аргад суралцаж, тэдний тухай мэдээлэл цуглуулж хуваалцах, амьдралын эргэлтийг сонирхон судлах хүсэл сонирхлыг нэмэгдүүлсэн.

Багшид : Тухайн ухагдахууныг **хялбар аргаар ойлгомжтой**, сонирхолтой хэлбэрээр зохион байгуулсан. Цаг хугацаа ачааллыг багасгасан. Бусдад түгээн дэлгэрүүлсэн. Ээлжит хичээлд суралцагч бүрийг оролцуулан тэдний сонирхолыг татахуйц төм-ыг бэлтгэж хэрэглэсэн.

Багш хөгжиж байгалийн ухааны чиглэлээр судалгаа хийх үндэс болсон.

Цаашид багш бүр байгалийн ухааны хичээлүүдийн хүнд сэдвийг бодит ба дүрслэлт хэрэглэгдэхүүн ашиглан явуулах нь зүйтэй гэж үзлээ.

Ном зүй

1. Д. Алтанцэцэг, Е. Батчулуун, Г. Баярмаа, Б. Баярчимэг, М. Ганбат, С. Гэндэнжамц Ж. Дөлгөөн, У. Мягмаржав, Ц. Пагмасүрэн, М. Энхбаяр *Багшийн ном Хүн ба байгаль –V, УБ., 2014 он.*
2. Д. Алтанцэцэг, Е. Батчулуун, Г. Баярмаа, Б. Баярчимэг, М. Ганбат, С. Гэндэнжамц Ж. Дөлгөөн, У. Мягмаржав, Ц. Пагмасүрэн, М. Энхбаяр *Хүн ба байгаль –V, УБ. 2014 он.*
3. Н.Нэргүй, Ч.Нямгэрэл ба бусад, *Багшлахуйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент (Боловсролын бодлого боловсруулагч, судлаач, арга зүйч, ЕБС-ийн удирдах ажилтан нарт зориулав), УБ., 2013.*
4. Н.Оюунцэцэг, Ч.Нямгэрэл ба бусад *Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил-төслийн зөвлөмж-1,2,3 УБ., 2010.*
5. С.Батсүх *Хүүхдийн хөгжил- УБ., 2010.*
6. www.infovisual.infowww.youtube.comprezi.comwww.anna-b.jp
7. www.mwt.netwww.twinkle.co.ukwww.translate.com
8. www.frog life cycle
9. www.fish life cycle

У ангид “Хөшүүрэг, хялбар механизм” сэдвийн хүрээнд шинэ хэрэглэгдэхүүн зохион бүтээсэн нь

¹ Ц.Одгэрэл, ² Л.Энхчимэг, ³ Б.Амарцэцэг, ⁴ А. Норжинжимуна,

⁴ Б.Отгонхишиг, ⁵ Т.Үүрийнцолмон, ⁶ М.Батзаяа

¹ Улаанбаатар, Баянгол дүүрэг, 28-р сургуулийн сургалтын менежер,

² Улаанбаатар, Баянгол дүүрэг, 28-р сургуулийн багш нар,

Удиртгал

2014-2015 оны хичээлийн жилд Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэхтэй холбогдуулан Болосрол шинжлэх ухааны сайдын 2014 оны 06 дугаар сарын 03 өдрийн А\240 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Бага боловсролын сургалтын төлөвлөгөөг баталсан байна. Бага ангийн байгалийн ухааны хичээлийн зорилго нь суралцагчдын байгалийг танин

мэдэх, байгалийн үзэгдлийг ойлгох, судлах сонирхлыг төрүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмших, байгалийг хайрлах, зөв зохистой харилцах хандлага хөгжихөд чиглэгдэнэ.⁹

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлнэ. Үүнд:

- Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт тусгасан ерөнхий чадвар (сэтгэн бодох, асуудал шийдвэрлэх, бие даан болон хамтран суралцах)-ыг хөгжүүлэх
- Бага боловсролын “Хүн ба байгаль” хичээлийн тусгай чадвар (шинжлэн судлах арга

барил)-ыг эзэмшүүлэх

1-3 дугаар ангид эзэмшихүй, нийгэмшихүй, зөв дадал хэвшилд сургахад суралцахуйн зорилтуудыг түлхүү чиглүүлсэн бол 4-5 дугаар ангид байгалийн юмс үзэгдэл, түүний учрыг мэдэх сонирхол төрүүлэх, сорил туршилтын арга, шинжлэх ухаанч арга барилын тухай ойлголт олж авахад чиглэнэ. Мөн тухайн зорилтын хүрээнд хэрэглэгдэх шинжлэн судлах арга барилын үйлүүд ба түүнийг хэрэгжүүлэх агуулгын сургалтын цөм хөтөлбөрт тодорхойлсон болно.

Бага боловсролын сургалтын төлөвлөгөөнд Хүн ба орчин хичээл 1-3 ангид долоо хоногт 3 цаг, Хүн ба байгаль хичээл 4-5 ангид долоо хоногт 2 цаг орохоор тусгагдсан.

IV-V ангид байгалийн ухааны хичээлээр сурагчид дараах чадварыг эзэмшинэ гэсэн байна.

1. Таамаглал дэвшүүлэх

- Юу?, хэзээ?, хаана?, яаж?, яагаад өөрчлөгдсөн бэ?, ингэвэл яах байсан бэ? зэрэг асуух үгийг хэрэглэн сэргээн санах, хэрэглэх, ойлгох, задлан шинжлэх, үнэлэх түвшний асуултыг зохиож чаддаг болох
- Асуултыг бусдад ойлгомжтой, мэдээлэл, баримт нотолгоогоор баяжуулан асууж чаддаг болох
- Өөрийн туршлага, өдөр тутмын амьдралд тохиолдох үзэгдэлд баримжаалан таамаглал дэвшүүлдэг болох

2. Үйл ажиллагаагаа төлөвлөх

- Таамаглал батлах, асуултад хариулахад ямар баримт, мэдээлэл хэрэгцээтэй байгаа талаар хамтран ярилцаж, хэлэлцэж чаддаг болох
- Юуг?, яаж?, хэзээ?, хэнтэй? хийх ёстойг баримжаалж, ажиглалт, туршилтын алхмуудыг төлөвлөж чаддаг болох
- Ажиглалт, туршилт хийхэд шаардлагатай багаж хэрэгслийг нэрлэж, зөв сонгож чаддаг болох
- Багаж, хэрэгслийг хэрхэн зөв хэрэглэх талаарх зөвлөмж, удирдамж, техникийг уншиж, ойлгодог, хамгийн чухлыг ялгадаг байх
- Ажиглалт, туршилтын явц, хэмжилтийн үр дүнг тэмдэглэхэд шаардлагатай хүснэгт, ажлын хуудас зэргийг багшийн тусламжтай болон бие даан боловсруулж чаддаг болох
- Туршилтын явцад гарч болох аюул, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг тооцож, түүнээс хэрхэн хамгаалах талаар өөрийн саналаа дэвшүүлж чаддаг болох

3. Төлөвлөсний дагуу хийж гүйцэтгэх

- Бие даан болон хамтран боловсруулсан төлөвлөлтийн дагуу ажиглалт, туршилтыг гүйцэтгэж чаддаг, шаардлагатай нөхцөлд зарим өөрчлөлтийг хийж чаддаг болох
- Туршилтын багаж хэрэгслийг зөвлөмж, удирдамж, техникийн дагуу хэрэглэж, алдаа гаргавал засч чаддаг болох
- Үр дүнг тэмдэглэх, хэмжих, нягтлах үйлийг туршилтын явцад тогтмол хийж сурсан байх
- Аюулгүй байдлыг ханган ажиллахад нэг нэгэндээ зөвлөж, сануулж чаддаг болсон байх

4. Мэдээлэл боловсруулах

- Таамаглалаа батлах, асуултад хариулахад ажиглалт, туршилтаас цуглуулсан мэдээлэл нь хүрэлцээтэй эсэхийг нягталдаг болох
- Ажиглалт, туршилтын үр дүнг яаж, хэрхэн илэрхийлбэл оновчтой болох талаар саналаа хэлдэг байх
- Ажиглалт, туршилтын дүнг бусдад яаж, хэрхэн танилцуулах арга, хэлбэрээ сонгож чаддаг болох

⁹ БАГА БОЛОВСРОЛЫН “ХҮН БА БАЙГАЛЬ” ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ IV-V АНГИ

V ангид “Хөшүүрэг, хялбар механизм” сэдвийг судалснаар сурагчид хөшүргийн тулах цэг, тэнцвэр, мөрний талаар мэдэх, ялган таних, хөшүүргээр хүчийг хувиргах аргад суралцах, хөшүүргийн тэнцвэрийн дүрэм нөхцөлийг мэдэх, жишээгээр тайлбарлаж чаддаг болно.

Сэдвийг сонгох үндэслэл

Нийслэлийн Баянгол дүүрэгт ? сургууль бага ангийн байгалийн ухааны кабинеттай болсон байна. Эдгээр сургууль төслийн шугамаар сургалтын хэрэглэгдэхүүн болох хөшүүрэгтэй болсон ба бусад ? сургууль хөшүүрэггүй тул “Хөшүүрэг, хялбар механизм” хичээлийн цагийг сурагчидтай ярилцах, зурах, бичих асуултад хариулах зэргээр өнгөрөөдөг байна. Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн хувьд 2016 онд “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд сургалтын цөм хөтөлбөр ба “Авьяс” хөтөлбөрийг дэмжих сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт бичсэн төсөл шалгарч байгалийн ухааны кабинеттай болсон. Кабинетийн хөшүүрэг чанарын шаардлага хангахгүй, ачаа зүүхэд хүндрэлтэй, тогтвор муутай, дуу чимээ ихтэй зэрэг нь хичээл явуулахад хүндрэлтэй байлаа.

Хамрах хүрээ

Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн бага ангийн сургалтын 2 менежер, III ангийн 6 багш, II ангийн 1 багш гэсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй судалгаат хичээлийн үйл ажиллагааг явуулж байна. 2017-2018 оны хичээлийн жилд V ангийн 6 бүлэгт, 2018-2019 оны хичээлийн жилд нэг бүлэгт “Хөшүүрэг, хялбар механизм” бүлэг сэдвийн “Хөшүүргийн тэнцвэрийн дүрэм нөхцөлийг мэдэх” хичээлийг зааж, хэрэглэгдэхүүнээ засан сайжрууллаа. Хичээлд V ангийн 230 хүүхэд хамрагдсан.

Судалгаат хичээлийн явц

Хичээл заасан анги	Сар өдөр	Хичээлд суусан багшийн тоо	Гарсан үр дүн		
			Хөшүүрэг	Арга зүй	Сурагчдын оролцоо
5 Б	2017.10.27	7	Байгалийн ухааны кабинетийн хөшүүргийг ашигласан.	Багш өөртөө итгэлтэй, сандарч тэвдсэн зүйлгүй, хөшүүргийн тэнцвэрийн тооцоолол дээр зарим үед эргэлзэж байсан.	Баг бүрт нэг хэрэглэгдэхүүн байсан. Сурагч бүр идэвх сонирхолтой байсан боловч хөшүүрэг тэнцвэр муутай, ачаа зүүхэд унаж, дахин эхлэх шаардлага гарч бужигнаж байсан.
5 Д	2017.11.21	8	Модон хөшүүргийн тэнцвэрийн дүрэм нөхцөл алдагдсан. Хөшүүргийн өнгө үзэмжинд их анхаарч байсан.	Хөшүүрэг нарийн тэнцэхгүй үед асуудлыг шийдэхэд багшид хүндрэл үүсч байсан. Хичээлийн залгамж холбоо муу.	Багшийн асуулт оновчтой бус байснаас таамаглал буруу дэвшигдсэн, ангиуд харилцан адилгүй\ хөшүүргийг хүчээр тэнцүүлж байсан.
5 в	2017.12.21	12			
5 А	2018.02.23	12			
5 Е	2018.04.45	18			
4 а	2018.	7			
5 Г		7			
5 Д			Пластик хөшүүргийн дүрэм нөхцөл алдагдаагүй.	Хичээлийн явц нэг хэсгээс нөгөө хэсэг рүү уялдаа холбоотой урсан орж байсан. Багш сандрал байхгүй өөртөө итгэлтэй, ямар нэг онолын алдаа гаргаагүй.	Хөшүүрэгтэй ажиллахад ямар нэг хүндрэл гараагүй, сонирхол татсан, багийн гишүүн бүр хөшүүрэгт хүрч ажиллахыг эрмэлзэж байлаа.

1. Хэрэглэгдэхүүн хэрхэн сайжирсан бэ?

№1	<ul style="list-style-type: none"> • Хэмжигдэхүүнийг нарийвчлалтай гаргасан, угсрахад хялбар, авч явахад хялбар • Суурь муутай, ачаа зүүхэд хүндрэлтэй, дуу чимээ багатай, эрүүл аюулгүй байдал талаасаа хангалтгүй
№2	<ul style="list-style-type: none"> • Монгол ахуйдаа тохируулан ачааг гэрээр орлуулсан, тулгуурыг оньсолсон, эрүүл ахуйн болон аюулгүй байдлыг хангаж модыг сонгосон. • Ачаа буюу гэр олон өнгөтэй, хэмжээ нарийн тавигдаагүй, ачаа зүүх тодорхой цэггүй, модны чийгшилээс хамаарч тэнцвэрийн нөхцөл алдагдаж байсан
№3	<ul style="list-style-type: none"> • Нарийн хэмжээтэй, тэнцвэрийн нөхцөл алдагдаагүй. Гэрийг бодит байдалд нийцүүлж цагаан өнгөөр будсан.

1. Багш, сурагчдад гарсан ахиц, хөгжил

Судалгаат хичээлийн явцад :

- Багшийн арга зүй
- Сурагчдын оролцоо
- Хэрэглэгдэхүүн
- Багшийн асуултыг ажиглах хуудсуудыг тараан өгч, багш нарын саналыг тусган үйл ажиллагаагаа сайжруулсаар ирсэн.

Багшийн арга зүй: Энэ 2 хүүхэд яаж суувал дүүжин даажин тоглож чадах вэ? гэсэн таамаглал дэвшүүлэх асуултад сурагчид

- Хүнд хүүхэд нь урагшилж сууна
- Жижиг хүүхэд дээр хүүхэд нэмж сууна
- Жижиг хүүхэд хойшоо сууна.
- Том чулуу авчраад сууна
- Аль нэг хүүхдийг босгоод нөгөө хүүхдийн жинтэй адил жинтэй хүүхэд суулгана.
- Өндөр хүүхэд нь хөлөөрөө тулна гэх мэт олон янзын хариултуудыг хэлж байсан нь багшийн асуулт тодорхой биш байсныг харуулж байна. Судалгаат хичээлийн явцад асуултаа засан сайжруулж “ Яг энэ нөхцөлд зөвхөн энэ 2 хүүхдийн хувьд явал дүүжин даажин тоглож чадах вэ? гэсэн оночтой асуултыг сурагчдаас асуух гэх мэтээр асуултаа оновчтой төлөвлөж сурлаа.
- Туршилт хийх нь сурагчдад илүү сонирхолтой байдгийг олж харсан.
- Шинжлэх ухааны хичээл учир тэнцвэрийн зүй тогтол алдагдахгүй байх ёстойг мэдэж авсан.
- Хөшүүрэг тэнцээгүй тохиолдолд туршилт эхлэхгүй байх ёстойг мэдсэн.
- Дунд ангийн мэргэжлийн багш нартай хамтарч ажиллах нь чухал болохыг ойлгосон
- Физикийн багш Мөнх – Эрдэнэ “ Агуулга нь маш хүнд, 8 дугаар ангид яг энэ хичээлийг ордог ”, Тунгалаг “ Зорилго томдсон, хөшүүргийг танин мэдэх талаар л ярих байх гэсэн тооцоолол орж ирсэн.”, Баяржаргал “ Таамаглал дэвшүүлэх асуултаа буруу төлөвлөсөн учир хичээлийн зорилго хангагдаагүй” гэж хэлсэн бол Технологийн багш Чулуунбаатар “ Зорилго томдсон гэдэг нь бага ангийн болон дунд ангийн багш нарын залгамж холбоо муу, V ангид хөшүүргийн талаар ямар агуулга судлах ёстойг судлаагүй болохыг харуулж байна”

Сурах бичиг

- **5-р ангийн сурах бичиг**

Зүүн мөр	
Ачаа г	мөр

Баруун мөр	
Ачаа г	мөр

-8-р ангийн сурах бичиг

Зүүн тал	
Ачааны масс	зай

Баруун тал	
Ачааны масс	зай

5- р ангийн сурах бичиг

- Зүүн мөрний ачааны дарах хэмжээ н ьбаруун мөрний ачааны дарах хэмжээтэй тэнцүү тохиолдолд хөшүүрэг тэнцвэрт орно.

8-р анги

$$F_1=L_2 \quad F_1 \times L_1 = F_2 \times L_2$$

$$F_2=L_2$$

- Бага мөрөнд их хүч ,их мөрөнд нь бага хүч үйлчлэхэд хөшүүрэг тэнцэнэ.
- Туршилтын хэрэглэгдэхүүнийг сурагчдын сонирхлыг төрсөн үед гаргаж тавих нь чухал ач холбогдолтойг мэдсэн.
- Туршилтын зарчим биеллээ олохгүй байгаа нь хэрэглэгдэхүүнтэй хамааралтай болохыг мэдсэн.
- Хүүхэд өөрийн үгээр туршилтын үр дүнг тайлбарлаж байвал хичээл үр өгөөжтэй болсныг илтгэлэг болохыг мэдсэн.
- Багш туршилт явуулахын өмнө уншиж судалсан, туршиж үзсэн байх хэрэгтэй гэдгийг мэдсэн.
- Холбоотой мэдээллийг хайхад хэлний мэдлэг чухал мэдлэг болохыг мэдсэн. Жич : Хөшүүрэг – lever , - дүүжин даажин
- Ачаа зүүх цэг, ачааны хэмжээг багш зааж, хэлэх нь сурагчдад бодож, өөрөөр сэтгэх боломжийг олгоогүй байсныг олж харсан.
- Дүүжин даажин тоглож байгаа 2 бол бидний ачаа болох гэр байж болох юм. Том биетэй хүүхдийг 2 гэрээр, жижиг биетэй хүүхдийг нэг гэрээр орлуулж болно гэдгийг огт сурагчидтай ярилцаагүй, дүүжин даажин ярьж байснаа гэр ярих нь сурагчдад ойлгомжгүй байсныг олж харсан.

2. Сурагчдын оролцоо

Бүх хичээлийн явцад сурагчдын идэвх оролцоо сайн байсан гэдгийг хичээлд суусан багш нарын санал сэтгэгдлээс харж болохоор байна. Яагаад гэвэл туршилт хийх нь сурагчдад сонирхолтой.

- 5 б ангийн сурагч Тэмүүлэн гэр цагаан өнгөтэй байх ёстойг хэлж сануулсан.
- Ачааг нэмж зүүхэд өмнө зүүсэн ачаа унаж, сурагчдад хүндрэл учруулж байсныг хэлсэн.
- Хөшүүрэг ачаа зүүх үед хөшүүргийн суурь тогтвор муутай байгааг олж харсан.
- Дуу чимээ ихтэй байгааг мэдэрсэн.
- 5е ангийн багш Оюун – Эрдэнэ “ Хамгийн дуу султай хүүхэд хамгийн эхний асуултад хариуллаа” гэсэн нь хичээл сонирхолтой байсны нэг баримт мөн.
- Тооцооллыг маш богино хугацаанд хийж байсан.

Дүгнэлт

2017-2018 оны хичээлийн жилд хичээлийн судалгааны нийгэмлэгээс зохион байгуулсан онол практикийн V бага хуралд “Бага ангийн байгалийн ухааны хичээлийн багшийн асуултаар сурагчдыг хөгжүүлэх нь” сэдэвт илтгэлээс Хөшүүрэг сэдвээр судалгаат хичээл явуулж, шинэ хэрэглэгдэхүүн зохион бүтээх санаа төрсөн. 2017 - 2018, 2018 - 2019 оны хичээлийн жилд V ангид “ Хөшүүрэг, хялбар механизм ” бүлэг сэдвийн Хөшүүргийн тэнцвэрийн зүй тогтол сэдвээр 28 дугаар сургуулийн 3 дугаар ангийн 6 багш хамтарч явууллаа. Шинэ хэрэглэгдэхүүн зохион бүтээх зорилгыг Судалгаат хичээлийн үр дүнд багш багшаасаа, багш сурагчаасаа, сурагчид багшаасаа суралцсан, шинэ хэрэглэгдэхүүн зохион бүтээж, туршсан үр дүнтэй ажил боллоо.

Цаашид хөгжүүлэх санал

Багш нарын багшлах ур чадвар, арга зүйгээ системтэйгээр хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа болох судалгаат хичээлийг явуулах нь сайн багш болох, судлаач багш болох, өгөөжтэй багш болох замыг нээнэ. Ийм учраас хичээлийн хөтөлбөрт, сургуулийн дотоод журамд судалгаат хичээлийн цагийг төлөвлөж, багш нарыг онолын болон арга зүйн мэдлэг, мэдээллээр хангах ажлыг шат шатандаа хийх шаардлагатай байна.



Тогтвор муутай, дуу чимээ ихтэй, ачаа зүүхэд хүндрэлтэй, эрүүл аюулгүй байдал хангагдаагүй

Монгол ахуйтай холбогдуулан ачааг гэр хэлбэлт оруулж, сүүрийг оньсолсон боловч хөшүүргийн тэнцвэрийн нөхцөл алдагдаж байсан.



Хөшүүргийн мөрийг акрилик материалаар хийж, хөшүүргийн тэнцвэрийн нөхцөл алдагдахгүй болгосон.



Ном зүй

1. Боловсрол соёл, шинжлэх ухааны яам, Хүн байгаль, V УБ -2017
2. Боловсрол соёл, шинжлэх ухааны яам, Физик, VIII УБ 2015 он
3. Боловсрол соёл, шинжлэх ухааны яам багшийн ном Физик VIII УБ 2015 он
4. Бага боловсролын цөм хөтөлбөр
5. “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүд

Музейг сургалтад ашиглан сурагчдын ажиглах, тэмдэглэх чадварыг нэмэгдүүлэх нь

- ¹Ц.Нарантуяа, ²Д.Алтантуяа, ³Да.Мөнхцэцэг, ⁴Б.Мөнхцэцэг, ⁵Б.Сарангэрэл
¹Улаанбаатар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч,
²Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 115-р сургуулийн сургалтын менежер,
³Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 115-р сургуулийн сургалтын багш нар,
⁵Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 84-р сургуулийн сургуулийн багш,

Удиртгал:

Музейг хүмүүс яагаад үздэг вэ. Мэдээж янз бүрийн шалтгаантай байгаа. Миний хувьд зочлон очиж байгаа орон нутаг, улс орны соёл заншил, түүхийн талаар цэгцтэй, товч, сонирхолтой мэдлэг мэдээллийг би музейгээс нь олж авдаг. Мөн аялан явахгүйгээр амьдран байгаа хотынхоо музейгээсээ дэлхийн соёл түүх, шинжлэх ухааны нээлтийг мэдэж суралцдаг. Тэгэхээр музейг бас мэдлэг боловсрол олгодог боловсролын байгууллага гэж тодорхойлж болно. Боловсролыг хүн дан ганц сургуульд сууж диплом авснаар эзэмшихдээ биш бас өөрийгөө олон хэлбэрээр боловсруулж, олсон тэр мэдлэгээ мэргэжлийн ажлаас гадна амьдралдаа хэрэглэж чаддаг байх нь чухал. 2014 онд АНУ-ын Музей, Номын 82

сангийн институтээс гаргасан тоон мэдээллээр тус улсад одоогоор 35,144 идэвхтэй ажиллаж музей байгаа бөгөөд 1990-ээд оны тооноос 2 дахин нэмэгдсэн болохыг тус институт онцолсон байна. Энэ тоо нь Макдоналдс (14000) болон Старбакс кофег (11000) нийлүүлсэнтэй тэнцэх тооны музей энэ улсад байна гэж сонин сэтгүүл дээр хүртэл бичсэн байх юм. Тус институтийн захирал хэлэхдээ "...Америк дахь музейнүүд нь байгаа газрууддаа боловсрол, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, өсөлтийн хүчирхэг чиглүүлэгч байдаг..." гэж хэлсэн байна. Мөн тус улсад музейг албан бус боловсролд маш чухал үүрэг гүйцэтгэдэг олон нийтэд үйлчлэх байгууллага гэж үздэг.

Боловсрол музейн үйл ажиллагааны чухал хэсгийг эзэлдэг. Хүүхэд залуучууд, олон нийт музейд очиж танхимын бус хэлбэрээр олон сонирхолтой мэдлэг мэдээллийг өөрсдийн сонгосон арга замаар (үзэсгэлэнгийн танхимын тайлбартай аялалд оролцох, музейн боловсролын сургалтад оролцох, музейн судлаачдын лекц сонсох, сайн дурын ажил хийх г.м) мэдлэгийг олж суралцдаг. Музейн боловсролын онцлог нь бага наснаас тэтгэврийн насны бүх хүмүүсийг хамарсан байдаг ба олон улсад музейг насан туршийн боловсрол олгодог байгууллага гэж тодорхойлдог түүнээс гадна музейг албан ёсоор ерөнхий боловсролын сургалтын анги танхимаас гадуур мэдлэг олгох суурь бааз болгох нь олон улсад нийтлэг туршлага болоод байгаа. Анги танхимд дутагдалтай байдаг материаллаг бааз музейд байдаг ба танхимаас авсан мэдлэгийн хүрээг музейн үзэсгэлэн, үзмэр болон боловсролын сургалтаар тэлэх боломжтой. Манайд музей нь байгаль ба соёлын өвийг хадгалж хамгаалахаас гадна олон нийтэд үнэт өвүүдийг танин мэдүүлэх зорилготой гэдгийг хүн болгон гадарладаг. Гэхдээ боловсролын системд танхимаас гадуур сургалт, насан туршийн боловсрол олгох музейн эдгээр боломж бололцоог манайд тэр болгон ашиглахгүй байна. 2015 онд Японд "Бага боловсролын байгалийн ухааны хичээлийн сургалтын үр нөлөөг сайжруулах нь" сургалтад явж байхад ч музейг сургалтад олон хувилбараар ашиглаж буй аргад суралцаж ирээд мөн хэрэгжүүлэх боломжийг эрж хайсаар ирсэн билээ. Тиймээс ч нэг арга хувилбар нь сурагчдын ажигч чанарыг нэмэгдүүлэх боломж гэж үзлээ.

Монголчууд малч удамтай, алсыг харах арга ухаантай ард түмэн билээ. Тэр ч утгаараа хөдөөгийн малчид их ажигч гярхай байдаг. Гэтэл орчин үед техникийн дэвшил хөгжлийн давуу тал байгаа ч зөвхөн өмнөх дэлгэцээ ширтсээр их холыг хардаг, аливааг ажиглах чадвар багасаад байна гэлтэй. Тиймээс музей үзэх явцдаа ажигласан зүйлээ тэмдэглэх тодорхой ажиглалт, тэмдэглэлийн хуудас боловсруулсан ашиглахад энэхүү судалгааны гол арга оршино.

Ажиглалт гэдэг нь объектыг идэвхтэй, системтэй, чиглэсэн зорилготой, тодорхой төлөвлөгөөтэй ойлгоход чиглэгдсэн судалгааны арга бөгөөд судалж буй объектын гадаад дүр төрх, шинж тэмдэг, харилцааны талаар мэдээлэл олж авах зорилготой юм. Ажиглалт ажиглагч, ажиглалтын объект, ажиглалтын хэрэгсэл гэсэн элементүүдээс бүрддэг. Орчин үед ажиглалтын нэлээд хөгжингүй хэлбэр болгон хүмүүсийн мэдрэмж, идэвхийг сайжруулах, объектэд нөлөөлөхөд чиглэгдсэн багаж хэрэгслүүдийг ашигладаг. Энэ нь ажиглалтыг туршилтын үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болгон хувиргадаг давуу талтай юм. Ажиглалтад дараах арга зүйн шаардлагууд тавигддаг. Үүнд:

1. Идэвхтэй байх (объектыг зүгээр нэг өнгөцхөн ажиглах биш, идэвхтэй эрэл хайгуул хийж, сонирхсон зүйлийг цаг тухайд нь тусгаж авах).
2. Чиглэсэн зорилготой байх (анхаарлаа зөвхөн сонирхож буй үзэгдэлд төвлөрүүлэх).
3. Төлөвлөгөөтэй, зориуд хандсан байх (урьдчилж боловсруулсан төлөвлөгөөний дагуу ажиллах).
4. Системтэй байх (боловсруулсан зорилгын шаардлагад нийцсэн тодорхой бүдүүвчийн дагуу дүрэм журмын хүрээнд ажиллах) зэрэг юм.

Шинжлэх ухааны үйл ажиллагааг зохион байгуулах арга зүйн төвшинд ажиглалтын явц болон үр дүнд тавих хяналт, түүнтэй холбоотой ойлгох боломжийн асуудал чухал байр эзэлдэг. Ажиглалтын явцад ажиглагчийн идэвх санаачлага, ерөнхий байдал, тодорхой үр дүнд хүрэх гэсэн итгэл үнэмшил, урьдчилсан бэлтгэл зэрэг сэтгэл зүйн хүчин зүйлүүд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийм хүчин зүйлүүдээс бүрэн төгс ангижрах боломжгүй учир энэ нь ажиглалтын үр дүнг субъектив хандлагаас салгах асуудлыг хөнддөг. Ажиглалтыг тэмдэглэх (объектын хэсэг, элемент, зүйлүүдийг тус тусад нь ойлгох), бүхэлдээ тусгах (объектыг бүхэлд нь ойлгох) зорилготой гэж ангилдаг. Мөн ажиглалтын шууд (судлаач судалж буй объектын шинж тэмдгийг онцгойлон авч үздэг), шууд бус (тухайн объектэд бус,

түүний үр дагаварт анхаарлаа хандуулдаг), төвлөрсөн (нэмэлт хэрэгсэл хэрэглэхгүйгээр зөвхөн хүний мэдрэх эрхтнүүдийн тусламжтайгаар явуулдаг), төвлөрсөн бус (багаж хэрэгслийн тусламжтайгаар явуулдаг) төрлүүд байдаг. Ажиглалт танин мэдэхүйн олон талт арга, танин мэдэхүйн үйл ажиллагааны урьдач нөхцөл болохын хувьд объектын талаарх анхдагч мэдээллийг туршилтын баталгааны нийлбэрийн хэлбэрээр өгдөг онцлогтой. Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйд ажиглалтыг бие даасан, өргөн хүрээтэй, түгээмэл арга гэж үздэг. Тэр ч байтугай ажиглалт маш энгийн нөхцөлд ч оюун ухааны үйл явцтай холбоотой, нэлээд нарийн төвөгтэй нөхцөлд онцгой шаардлагатай албан ажлын аргын үүргийг гүйцэтгэдэг. Ялангуяа социологи, антропологи, нийгмийн сэтгэл зүй, сэтгүүл зүй зэрэг нийгмийн шинжлэх ухаанд чухал ач холбогдолтой юм. Энд ажиглагч - объект хэмээх харилцаа нь ажиглагч - ажиглуулагч гэсэн харилцаа болон хувирч, ажиглуулагч бас л тухайн ажиллагааны идэвхтэй төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, ажиглалтыг эсэргүүцэх, зан байдлаа зориуд өөрчлөх, ажиглагчид нөлөөлөхийг оролдох, хүсэн хүлээж буй зүйлийг санаатайгаар тодруулах үйлдэл хийж болно. Тэгэхлээр тухайн тохиолдолд ажиглагчийн оролцоо өөрөө шийдвэрлэхийг шаардсан асуудалтай тулгардаг. Тиймээс социологи анх удаа зарчмын хувьд өөр хувилбарыг буюу ажиглагчийг судалж буй бүлгийн ахуй амьдралд биечлэн оролцож, өөрөө судалгааны объект болон хувирах аргыг сонгосон бол антропологи тийм аргыг ажиглагч оролцож буй тэр орчноос өөр соёлыг судлахад ашиглах болсон.

Хичээлийн санаа: Бид хичээл сургалт явуулахдаа “Гадаа байдаг шүү, тэнд л байдаг гэнэ лээ” гэдэг байдлаар бус тэдэнд байгаль орчинд сургалт явуулах боломжийг бүрдүүлэх гэдэг л илүү чухал байна. Сурагчид номноос, видео бичлэгээс олж харсан мэдлэг, мэдээллээ бодитоор барьж, харж, үнэрлэж, ажиглаж, хийж гүйцэтгэх, туршилтаараа нотлох нөхцөл бололцоог тэдэнд олгох хэрэгтэй. Мэдээж төрөл бүрийн талбайд хичээл сургалтаа хөтлөн явуулдаг бол сурагчид маань илүү ихийг мэдэрч ойлгоно. Тийм нэг боломж нь музейг сургалтад ашиглах гэж үзлээ.

Музейн сан хөмрөгийг

- Цуглуулах, иж бүрдүүлэх
- Бүртгэх баримтжуулах
- Хадгалах хамгаалах
- Судалгаа хийх
- Сурталчлах, түгээх ёстой байдаг юм байна.

Тийм ч учраас сурагчдаар музей үзэх явцдаа ажиглах, тэмдэглэх чадварыг нэмэгдүүлж цаашдаа сан хөмрөгийг хайрлах хамгаалах үзлийг төлөвшүүлэх боломжтой гэж бодож хичээлийн санааг эхлээд ажиглуулах, тэмдэглүүлэх гэж тодорхойлсон болно.

Судалгаа 1. Эхлээд бага боловсролын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад ирсэн эхний жилийн 630 багшид музей үзүүлэхдээ ажиглалтын тодорхой чиглэл өгдөг үү. Чиглэл өгч ажиглалт, тэмдэглэл хөтлөх нь сурагчдын ямар чадварыг нэмэгдүүлэх боломжтойг тандаж БГД-ийн 20-р сургуулийн музейг ажиглалтын чиглэлийн дагуу ажиглалт хийлгэж тэмдэглэл хөтлөх, түүнд дүгнэлт хийлгэх хэлбэрээр судлууллаа.

Ажлын хуудас: Музей үзэж тэмдэглэл хөтлөх

Зорилго: Судалсан агуулгаа музейн үзмэр үзэж бататгах, ажиглангаа тэмдэглэл хөтлөх, музей үзэх аргад суралцах чадвартай болох.

Үйл ажиллагааны алхамчлал:

1. Музей үзэх ажлын зорилгоо тэмдэглэлийн хэсэгт бичээрэй.
2. Музейгээр аялах аяллын санамжийг сайтар уншин дагаж мөрдөх
3. Музейн тайлбарлагчийн тайлбарыг анхааралтай сонсон зарим гол зүйлүүдийг дэвтэртээ бичиж аваарай.
4. Музейн тэмдэглэл хөтлөхдөө дараах аргуудаас сонгон хэрэглээрэй.

Хэрэглэж болох аргуудаас:

- а. Сурагч бүхэн багш
- б. KWL арга
- в. Хамтран суралцах арга + Тэмдэглэл хөтлөх арга

г. INSERT арга

5. Тэмдэглэл бичихдээ дараах загварын дагуу бичихэд анхаараарай.

Бид энэ удаагийн аяллаар музейг үзэж сонирхлоо. Энэхүү музей онд байгуулагдсан юм байна.

Ямар зорилгоор энэ сэдвийг судлах болсон бэ? Яагаад? ----- ----- -----		
Сургуулийн анхны захирал хэн бэ?	Цахим түүх юуг өгүүлсэн бэ?	Багшийн тэмдэглэл юуг өгүүлсэн бэ?
Энэ сургуулиас төрсөн алдартнуудаас нэрлээрэй.	Техник хэрэгслэлийн хөгжлийн талаар таны бодол:	Сургуулийг онцлох зүйл:
Хамгийн их сонирхол татсан үзмэрийн талаар бичнэ үү. Яагаад? ----- ----- -----		

Өөрийн аймаг, сум сургууль дээр очоод ямар нэгэн зүйлийг түүхийн олдвор болгох талаар бодсон уу. Хэрэв аль нэгийг нь сонгон авах гэж байгаа бол түүнийг яагаад сонгох болсноо тайлбарлана уу.

--

Сургуулийн түүхийг бүтээхийн ач холбогдлыг та юу гэж дүгнэж байна вэ?

гэх мэт асуултад хариулж, өөрсдийн дүгнэлтийг гаргана.

1. Музейн аяллын дараа эсээ бичих, шүлэг зохиох, макет хийх, аймгийн газрын зураг дээр олдворуудыг тэмдэглэх, тайлбар хийх, дүгнэлт гаргах зэрэг даалгавруудаас сонгон хийлгэж болох бөгөөд бусад сургалтын хэрэглэгдэхүүнээс нэмэлт байдлаар ашиглаж болохыг анхаараарай.

Судалгааны дүгнэлт: Багш нар өөрсдөө музей үзэхдээ дээрх өгөгдсөн чиглэлийн дагуу ажиглалт хийгээд олон зүйлийг харж чадсан, эдгээрийг цаашид хэрхэн хэрэглэх боломжтой вэ гэдэг санаагаа нэгтгэж чадаж байсан. Тиймээс бид ямар нэгэн үйлийг тодорхой зорилго чиглэлтэй хийлгэх нь үр дүнтэй юм гэж дүгнэсэн. Чиглэл өгч ажиглалт хийлгэж тэмдэглэл хөтлөх чадварт сургах аргыг сурагчдадаа хэрэглэж үзье гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Судалгаа 2. Үүний дараа сургалтад суусан багш нартай хамтран 115-р сургууль, 84-р сургуулийн тодорхой анги бүлгийг сонгон авч сурагчдыг музей үзэхээр явуулахдаа тодорхой чиглэлийн дагуу ажиглалт хийж тэмдэглэл хөтлөх ажлын хуудсыг урьдчилан боловсруулж үр дүнд анализ хийлээ.

Ажлын хуудас: Музейг сургалтад ашиглах боломжийг илрүүлэх судалгаа

Таны нас: _____ Хүйс: _____
Сургууль: _____ Анги: _____

1. Музей үзэж байсан уу? Та эдгээрээс аль музейг үзсэн бэ.

- Богд хааны ордон музей УБ хотын музей
 Үлэг гүрвэлийн төв музей Оюун ухааны музей
 Чойжин ламын музей Монголын үндэсний музей
 Монгол цэргийн музей Дүрслэх урлагийн музей

Жич: Үзсэн музей бүрийн өмнөх дөрвөлжин нүдэнд тэмдэглээрэй.

2. Хэнтэй хамт үзсэн бэ?

- Гэр бүлийнхэнтэйгээ Найзуудтайгаа Ангиараа багштайгаа Бусад


3. Музей үзэхэд гол анхаарах зүйл юу вэ?

4. Хамгийн их анхаарал татсан үзмэрээсээ нэрлэнэ үү.

5. Ангиараа музей үзэхээр болбол ямар дүрэм бэ. -----

Судалгааны үр дүн: Сурагчид чиглэлийн дагуу ажиглалт хийгээд ажигласан зүйлээ тэмдэглэж ирснээр илүү нухацтай үзэх, үзсэн харсан зүйлийнхээ дагуу ярилцах, зохион найруулж бичих чадвар их нэмэгдсэн байлаа. Бид бага сургуулийн 4,5-р ангийн 6 бүлгийн сурагчдыг сонгон авч үлэг гүрвэл, байгалийн үзэсгэлэнт газруудын талаар зохион бичлэг хийлгээд, Богд хааны ордон музей, Улаанбаатар хотын музейг чиглэл өгч ажиглалт хийж ирсний дараа дахин ярилцлага хийх, зохион бичлэг хийх байдлаар ажиглалтын үр дүнд өөрчлөлт гарсан эсэхийг дүгнэн үзэхэд маш их өөрчлөлт дэвшил гарсан

МУЗЕЙ ҮЗЭЖ БАЙСАН УУ? ТА ТЭДГЭЭРИЙН АЛЬ МУЗЕЙГ ҮЗСЭН БЭ?



байсан тул тодорхой чиглэлийн дагуу тэмдэглэл хөтлөх ажлын хуудсан дээр ажиллуулснаар сурагчдын ажиглах чадварт эерэг өөрчлөлт гарч байлаа.

Үйл ажиллагааны алхамчлалыг тодорхой өгч хүүхдүүдийг ажиглалт хийх аргад сургахыг гол зорилго болгон ажиллалаа.

Алхам 1: Ажиглалт

Таван мэдрэхүйгээ мэдэрч олдворын талаар мэдэж авахыг хичээгээрэй. Хэмжээ, хэлбэр, өнгө, дуу чимээ, тэмдэглэгээ, чимэглэл, материал, үнэр, нөхцөл, бүтэц гээд энэхүү олдворыг талаар олон зүйлийг мэдэж авах боломжтой шүү.

Алхам 2: Дүн шинжилгээ

Та ажиглалтынхаа тэмдэглэл, мэдээллийг ашиглан дараах асуултуудад хариулна уу. Энэхүү олдворыг хэн хэзээ олсон хийгээд яаж энд ирсэн бэ? Үүнийг цаашид хэрхэн ашиглаж болох вэ? Энэ нь хаана хийгээд ашиглагдаж болох байсан бэ? гэх мэт үзмэрийг талаар дүн шинжилгээ хийх юм.

Алхам 3: Таамаглал


Өөрийн ажиглалт, тэмдэглэлийг хараарай. Өөрийнхөө бүртгэлд үндэслэн өөрийн олдворын талаар нэг таамаглал (сайн таамагласан таамаглал) гаргаж ирээрэй.

Таны бодлоор хамгийн сайн нотолгоо юу байсан бэ?

Цаашид дэвшүүлэх санаа: Эцэст нь энэхүү баримт нотолгоонд үндэслэн үзсэн, харсан зүйлийнхээ талаар илүү ихийг мэдэх хүсэл тэмүүлэл төрүүлэх, аливаа сайн харж тэмдэглэж сурах аргад сурагчид суралцаж чадсан шүү. Тиймээс

- ✓ Музейн сан хөмрөгийг баяжуулах
- ✓ Цуглуулах, иж бүрдүүлэх
- ✓ Бүртгэх баримтжуулах
- ✓ Хадгалах хамгаалах
- ✓ Судалгаа хийх
- ✓ Сурталчлах, түгээх ёстой байдаг юм байна гэдгийг л өөрсдөд нь мэдрүүлэхүйц байдлаар ажиглалт тэмдэглэл хөтлүүлж сурцгаая.

Дүгнэлт: Хүн ба нийгэм хичээлийн Эх орны түүх соёл бүлэг сэдвийн хүрээнд энэхүү судалгаат хичээлийг явуулснаар хүүхдүүдийн ажиглах чадвар нэмэгдэх бөгөөд багш гагцхүү ажиглах чиглэлийг тодорхой өгч байх хэрэгтэй юм. Сурагчид чиглэлийн дагуу ажиглалт хийгээд ажигласан зүйлээ тэмдэглэж ирснээр илүү хянамгай үзэж, үзсэн харсан зүйлийнхээ дагуу ярилцах, зохион найруулж бичих, цаашид судлаж мэдэх зүйлээ тодорхойлсон байсан нь судалгаанаас харагдаж байлаа. Мөн 4-5-р ангийн 6 бүлгийн сурагчдыг сонгон авч үзвэл үлэг гүрвэл байгалийн үзэсгэлэнт газруудын талаар зохион бичлэг хийгээд Богд хааны ордон музей, УБ хотын музейг чиглэл өгч ажиглалт хийсний дараа дахин ярилцлага хийх зохион бичлэг хийлгэхэд маш их өөрчлөлт дэвшил гарч сурагчдын ажиглах чадварт эерэг өөрчлөлтүүд гарсан байлаа.



Ном зүй

(2013). Багшлахуйн хөгжил хичээлийн судлагааны арга зүйн үндэс. Улаанбаатар: Содпресс.

(2014). Бага боловсролын цөм хөтөлбөр, БСШУЯ. Улаанбаатар

(2015). "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй", БСШУЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт. Улаанбаатар.

(2017). “Музейг сургалтад ашиглах нь” Улаанбаатар: БХАН.

Хүүхдийн сонирхолд түшиглэн хөгжүүлэх боломж

Ц. Одончимэг,

Говьсүмбэр аймаг, Шивээговь сумын ЕБС-ийн бага ангийн багш

Үндсэн хэсэг

Хичээлийн судалгааны аргад суралцах түвшний¹⁰ үйл ажиллагаа манай аймагт 2012-2015 оны хичээлийн жилд Японы Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагын сайн дурын мэргэжилтэн Yamanaka Ayaka багштай сургалтын менежер байх хугацаанд дүрслэх урлагийн хичээлээр 40 цагийн хичээлийн судалгаа зохион байгуулж, хамтран ажилласан. Туршлага судлан, хичээлийн судалгаа хийх явцад “Дүрслэх урлаг”-ийн судлагдахууны зорилго мөн чанар, арга зүйг илүү ойлгохыг зорьж, багш нартай баг болон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Ayaka багш бидэнд: “Урлаг хичээл нь хүүхдийн төлөвшилд хамгийн ойр судлагдахуун бөгөөд сэтгэлзүйн боловсролын хичээл”¹¹ юм гэдгийн ойлгуулсан.

Би 2015 онд нэгдүгээр анги хүлээн авч ажилласан. Шинэхэн сурагчдыг хэрхэн төлөвшүүлж, хөгжүүлэх вэ? гэсэн асуудалтай тулгарч, ангийн сурагчдын дунд судалгаа хийхэд 70-аас илүү хувь нь **зурах, дүрслэх үйлд** сонирхолтой болох нь ажиглагдсан. Ингээд:

1. Ayaka багшийн “Урлаг хичээл нь хүүхдийн төлөвшилд хамгийн ойр судлагдахуун бөгөөд сэтгэлзүйн боловсролын хичээл” гэсэн ойлголт.
2. Дүрслэх урлагийн хичээлийн судлагаа хийхэд суралцсан арга зүй, технологи
3. Япон улсад туршлага судлахдаа суралцсан сургалтыг дэмжих хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулах аргад түшиглэн, ангийнхаа нийт 35 сурагчид сургалтыг дэмжих, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар “Миний бүтээлийн утга” дүрслэх урлагийн дугуйланг нэгдүгээр ангиас одоог хүртэл хичээллүүлж байна.

Энэ дугуйлангаараа бүх сурагчдыг зураач болгохыг зориогүй. Зөвхөн хүүхдийн дуртай зүйлээр нь дамжуулан бусад чадварыг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорьсон.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

20-р зууны эхэн үеэс эхлэн прагматик сургалтын үзэл санаа АНУ болон европын орнуудад дэлгэрсэн. Өнгөрсөн зууны дунд үеэс эхлэн когнитив онол конструктив хандлага газар авч эхэлснийг бас тэмдэглэх нь зүйтэй. Германы дэвшилтэд сурган хүмүүжүүлэгч А. Дистервег хөгжүүлэх сургалтыг бие даасан онолын нэг урсгал болгон төлөвшүүлсэн. Оросын нэрт сэтгэл зүйч Л. С. Выготский хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх асуудлаар өөрийн үзэл онолоо дэвшүүлснээр хөгжүүлэх сургалтын сэтгэл зүйн үндэс тавигдсан.

Тэрээр оюун ухааны хөгжлийн ойрын бүсийн тухай онолдоо хүүхдийн оюун ухаанд хөгжлийн 2 бүс байдаг гэж үзжээ. Жишээ нь:

Өнөөгийн бүс: Хүүхдийн яг одоо ойлгож, мэдэж, хийж, чадаж буй бүх зүйлс багтна.

Ойрын бүс: Хүүхэд одоохондоо ойлгохгүй, мэдэхгүй хийж чадахгүй байгаа ч томчуудын бага зэргийн тусламж, дэмжлэгтэйгээр ойрын ирээдүйд хийж чаддаг болох зүйлс орно.

Бид сургалтаа зохион байгуулахдаа хүүхдийн хөгжлийн өнөөгийн бүст тулгуурлаж ойрын бүсрүү чиглүүлэн явуулах нь зүйтэй¹² гэсэн дүгнэлтийг энэ эрдэмтэд хийсэн байна.

Л. С. Выготскийн үзэснээр сайн зохион байгуулагдсан сургалт нь хүүхдийн оюун ухааны хөгжлийг араасаа дагуулдаг байна. Ийм сургалтын зохион байгуулах нэг боломж бол хичээлийн судалгаа юм.

1. Бэлтгэл - /preparation – kyozai kenkyu/ шийдэл

Багш нар мэргэжилтэн багштай хамтран, цөм хөтөлбөр, сурах бичгээ судлан, хичээлийн зорилго, бүтэц хэлбэрээ сурагчдын хэрэгцээ сонирхолд нийцүүлэн бэлтгэж хэрэглэгдэхүүнээр

¹⁰ [Багшлахуйн хөгжил хичээлийн судалгааны арга зүйн үндэс,2013]

¹¹ [Yamanaka Ayaka,2012]


¹² [Сэтгэл судлал,1990]

баяжуулах замаар төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулж байлаа. Бэлтгэсэн хөтөлбөрөөр мэргэжилтэн багш үзүүлэх хичээл зааж, энэ хичээлд бусад багш нар болон сургуулийн удирдлагууд сууж, ажиглалт хийнэ.

1. Асуудлаа тодорхойлох
2. Хичээлээ төлөвлөх
3. Хичээлээ бэлтгэх
4. Дахин сайжруулах
5. Сайжруулсан үр дүнгээр нөгөө бүлэгтэй дахин заах
6. Үнэлгээ хийж, дахин хэлэлцэх
7. Үр дүнг тайлагнах, хуваалцах /Бүтээлийн үзэсгэлэн/ гэсэн дарааллаар ажилласан.

Бодит хичээл буюу хичээл заах, ажиглах /actual class-koukai kenkyu jyugyo/ шийдэл

Мэргэжилтэн багшийн хичээлд сууж, суралцсан арга зүйгээ өөрийн хичээлд тусган мөн өөрийн арга технологийг боловсруулан, ээлжит хичээлээ төлөвлөн нөгөө бүлэгт заах замаар хичээлийн хөтөлбөрөө сайжруулан заасан.



2. Хэлэлцэх сайжруулах- / class review sessions – jyugyo kentoukai / шийдэл

Энэ хугацаанд бид: Хичээлийн дараа хэлэлцэх, сайжруулах шатанд хичээлийн талаар товч танилцуулах, хичээлийн зорилгыг тайлбарлан, үүний дараа бусад оролцогч өөрийн багшлахуйн туршлагад тулгуурлан, санаагаа илэрхийлэх ба хичээл дээр өгөгдсөн асуудал, багшийн үүрэг, суралцагчдын санаагаа тайлбарлан ярьж буй байдал, суралцахуйн үйл ажиллагааны талаар асуулт асууж, хэлэлцэх аргад суралцаж байлаа.



Энэхүү хамтын үйл ажиллагаагаар бид хичээлийн зорилго, бодит үйл явцын хоорондын ялгаанд ажиглалт хийж, хичээлийн төдлөвлөлтийг хөгжүүлэх, сайжруулахад суралцаж байсан бөгөөд хичээлийн явцад болон хичээлийн бэлтгэл судалгааны үед авч үзээгүй шинэ сэдэв, асуудлыг нээх, хөгжүүлэх зэрэг маш олон аргад суралцсан.

Бид мэргэжилтэн багштай хамтарч ажилласанаар хичээлийн судалгааны арга зүй сайжрахаас гадна, багш нарт дараах өөрчлөлт гарч байгаа нь ажиглагдаж байлаа.

1. Багшийн харилцаа, хандлагын өөрчлөлт
2. Хичээлийн хэлэлцүүлгийн явцад тавих асуулт
3. Зааварчилгаа өгөх, авах
4. Багаар болон бие даан ажиллах чадварт ахиц гарч ажилдаа илүү хариуцлагатай болж байгаа нь ажиглагдаж байсан юм.

Энэ удаагийн хамтын ажиллагаагаар 40 цагийн хичээлийн судалгаа хийж дараах сэдвүүдээр “Дүрслэх урлаг”-ийн хичээлийн жишиг хөтөлбөртэй болсон. Одоо ч уг хөтөлбөрийн арга зүйг сайжруулан туршсаар байна.

Анги	Зорилго	Сэдэв	Цаг
I	Нэг төрлийн дүрс бүтээлийг янз бүрийн аргаар чимэглэхэд суралцах	Нэг дүрсээр хувьлахуй	4
	Оюуны зураглал, цацаргах сэтгэлгээний аргаар мэндчилгээ хийх	Миний хайраас төрсөн хамгийн сайхан бүтээл	4
II	Будах, зурах, хуйлах аргаар дахин боловсруулах /хаягдал/ материал ашигалан чимэглэл хийх	Мөрөөдлийн сум	4
	Амьтан зурах аргад суралцах	Дэгдээхий зурцгаая	4
III	Байгаль дээрх зүйлийг ажиглан тэнгэр, уул, үүл, модлог, бутлаг ургамлыг зурж зурах	Ийм мод байвал гоё уу?	4
	Үндсэн өнгийг эх өнгөтэй холих аргад суралцах	Юу зурмаар байна вэ?	4
IV	Төрөл бүрийн материал ашиглан, нимгэн товгор наамал хийх	Миний унаагаар явъя	4
	Дагнааслах аргад суралцах	Чойрын богд уул	4
V	Цаасаар янз бүрийн нугалбар хийх аргаар бүтээл хийх	Баярлалаа 3-р сургууль	4
	Нэг цэгийн алслалтыг шугаман байгуулалтаар зурах аргад суралцах	Алхам, алхмаар	4
Нийт цаг			40

Туршилт судалгааны хэсэг

Зохиолч судлаач Бау Мари Солонгосын Кён вон их сургуулийг төгссөн бөгөөд хүүхдийн дүрслэх урлагийн талаарх боловсролыг судалж, заадаг багш юм. Энэ судлаач нь “Миний ээж аз жаргалтай зургийн багш” номондоо “Хүүхдийг үнэтэй зургийн сургалтанд явуулахгүйгээр багаас нь зураг зурах арга барилд сургаж болох чухал зүйлийг судалж, нийтэлсэн байдаг. Энэ судлаач хүүхдийн зураг зурах үйл явцыг 3-н үе шаттай хувааж болно гэж үзжээ.

1. Сараачих үе / 2 – 3 нас /

Энэ насандаа хүүхэд зурах биш ихэнхдээ цаасан дээр сараачиж байдаг. Хамгийн эхлээд хүүхэд эмх замбараагүй муруй шугам сараачдаг. Энэ зүйлсийг нь зүгээр л замбараагүй зүйл байна гэж анзааралгүй орхиж болохгүй. Сайн ажиглахад олзуурхууштай зүйлс байдаг байна.

2. Сэдэвчлэн зурах үе / 3 – 5 нас /

Хүүхдүүд өөрийн нүдээр харсан зүйлсийг сэдэвчлэн буулгаж эхлэдэг. Тэд мод, машин, орон сууц, цэцэг, хүн зэргээр бага багаар өөрийн харсан зүйлсийг дүрслэн буулгаж эхлэдэг байна.

3. Дүрслэн зохиомжлон зурах үе / 5+ нас /


Энэ үед хүүхэд аливааг системтэй зурахыг эрмэлзэнэ. Өөрөөр хэлвэл аливааг дүрслэн зохиомжлодог. Тухайлбал далай зурахдаа далайн од, бөмбөг, усны хувцастай хүмүүс зэргээр аливааг бүтэцтэй зурж эхлэнэ.

Дээрх судалгаанаас харахад нэгдүгээр ангид элсэн суралцаж байгаа хүүхдүүд дүрслэн зохиомжилж зурж чадах үедээ байдаг ба энэ үед дүрслэх, зурах үйлийн сургалтыг зорилготойгоор удирдан зохион байгуулвал хүүхдийн дараах чадварууд хөгжинө гэж үзжээ.

1. Мэдрэмжээ илэрхийлж бүтээлдээ тусгадаг
2. Сэтгэн боддог
3. Сонирхон судалдаг
4. Асуудал дэвшүүлэг

5. Зохиомжилдог
6. Шийдвэр гаргадаг
7. Мэдээлэл боловсруулдаг
8. Өөрийгөө илэрхийлдэг

Эдгээр нь бидний эзэмшүүлэхээр зорьж буй цөм хөтөлбөрийн агуулгад орсон чадваруудын нийлээдгүй хувийг эзэлж байгаа учраас хүүхдийн сонирхолтой зүйлд нь түшиглэн дээрх чадваруудыг хөгжүүлэх зорилго тавин дугуйлангаа хичээллүүлж эхэлсэн.



Сурагч, эцэг эхчүүдээс нэгдүгээр ангийн 2-р улиралд дээрх судалгааг авсан. Графикаас харахад зурах авьяастай хүүхдийн тоо олон байгааг дагаад дүрслэх урлагийн хичээлд дуртай сурагчид илүү хувийг эзэлж байна.

Ангийн сурагчдад дугуйлан хичээллүүлэх үйл ажиллагааг хичээлийн судалгааны явцаас суралцсан арга зүй, технологид түшиглэн хэрэгжүүлсэн.

- Бийр сонгох ашиглах
- Гуаш, усан будаг сонгох, ашиглах
- Сургалтын үйл явцыг зохион байгуулах
- Орчноо бэлтгэх
- Хэрэглэгдэхүүнээ ангилах зэрэг олон аргад суралцсан. Энэ аргуудыг ашиглан дугуйлангаа хичээллүүлсэн.

1. Хэрэглэгдэхүүний шийдэл



- Гуаш сурагчдын хэрэгцээ шаардлагад тохирсон, олон хүүхдэд хэрэглэхэд тохиромжтой, үнийн хувьд боломжийн. Нийт үндсэн 3 өнгө, хар, цагаан 5 өнгө авахад хангалттай. Нэг удаа авсан гуашаар хагас жил орчим хэрэглэх боломжтой зэргийг харгалзан гуашаа сонгосон. Энэ бүх сонголтыг мэргэжилтэн багшийн зөвлөсний дагуу зохион байгуулсан.
- Бийр зөөлөн үстэй, хүүхэд авч явахад тохиромжтой гээгдэхгүй байхаар савалгаатай, бүтээл хийхэд өргөн нарийн сонголттой байхаар тооцож, нэг сурагч 6 ширхэгтэй нэг багц бийртэй байна.
- Будаг найруулах савыг гарын доорх материал ашиглах байдлаар шийдвэрлэсэн.

2. Арга зүйн шийдэл



- Бийрийг зөв ашиглах, угаах
 - Усан будаг найруулах
 - Үйл ажиллагааны заавар зэргийг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан зургаар илэрхийлэх нь тохиромжтой юм гэдгийг хичээлийн судалгааны явцад сурсан. Мөн зургийн сайтуудаас өөрт хэрэгтэй хэрэглэгдэхүүнийг ашиглаж болно.
3. Сургалтын хөтөлбөрийн шийдэл

Дугуйлан хичээллүүлэх сургалтын хөтөлбөрөө боловсруулахад:

- “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” буцалтгүй тусламжийн “Дүрслэх урлаг” бага ангийн багшид зориулсан гарын авлага.
- Мэргэжилтэн багштай хамтран боловсруулсан “Дүрслэх урлагийн хичээлийн жишиг хөтөлбөр”
- Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр
- Зураг зурж сурахад зориулагдсан веб сайтууд зэргийг баримжаалан сургалтын хөтөлбөрөө боловсруулсан.

"МИНИЙ БҮТЭЭЛИЙН УТГА" ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ДУГУЙЛАНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ																			
№	Судлах анги																		
	I анги						II анги			III анги				IV анги			V анги		
Бүлэг сэдэв	Нэгдүгээр бүлэг																		
Ээлжит хичээл	Зураас	Үндэглэн	Дүрс	Үндэглэн	Өнгө	Үндэглэн	Өнгө	Үндэглэн	Тон	Үндэглэн	Гадаргуу	Үндэглэн	Биег	Далдлага	Үндэглэн	Орон зай	Далдлага	Үндэглэн	
	Цаг	3	2	3	2	4	2	20	4	21	2		2	10	21	4	8	21	6
Чидар	1. Зураасны төрөл, урвасны төрлөөр хэрхэн бүтэл хийхэд суралцах 2. Зураасуудыг өнгө, дүрс, тухай өнгөх, зураас ашиглан дүрс үүсгэн сурах, төлөрхөй ба төлөрхөй буюу дүрсийн талар өйгөх, дүрс ашиглан бүтэл хийх.						1. Өнгөний тухай мэдэх, үндэглэн өнгө, өнгөний хүрч, үүсэх өнгө, өнгөний үнэг тодруулах, өнгөний дүрсийг хийн сурах, хэргийн ба дуулан өнгө, хэргийн өнгө, таврал өнгө, гэрлийн долгион, цэвэр гэрлийн талар судлын бүтэл хийх.			1. Өнгөний тухай тухай өйгөх, цагаан өнгөний хэргийн үүсэх, хар ба цагаан өнгө, өнгөний тухай үүсгэн бүтэл хийх 2. Гадаргууг таларх өйгөх, гадаргуу хэргийн, дагалцаж гадаргуу бүтэл, гадаргуу гадаргуу бүтэл, гадаргуу хэргийн өйгөх, өнгөний таларх гадаргуу бүтэл хийх.				Биегтэй байх бодлогыг өгж мэдэх, 2 ба 3 хэмжээг бие бие тухай судлах, бүтэл хийх.			Орон зайг хэрхэн бий болгох туршигт хийх, агаарыг болон нэг өнгөний тухай өйгөх, өнгөх агууламт дагхан олон төрлийн бүтэл хийх.		
ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН: БАГШ Ц. ОДОНЧИМЭГ																			

4. Хэргэжилтийн шийдэл

Дүрслэх урлагийн сонгоныг анги нийтээр нь долоо хоногт 2 цагаар баасан гарагийн 5, 6-р цаг дээр ордог. Энэ нь сургалтын төлөвлөгөөний 2 цагтай нийт долоо хоногт 4 цагт зурах, дүрслэх хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Анхлан зурж сурч байгаа хүмүүст болон зурах сонирхолтой хүмүүст зориулсан олон сайтууд байдаг. Эдээр сайтаас дугуйлангийн үйл ажиллагаанд ашигладаг бөгөөд энэ нь сурагчдад илүү ойлгомжтой, хүртээмжтэй, сонирхолтой байдаг. Өөрийн зохион байгуулаж буй үйл ажиллагааны зорилгод нийцэхээр цахим хэрэглэгдэхүүнүүдийг ашиглах нь илүү үр дүнтэй. Сурагчид маш их дуртай, сонирхолтой, баяр хөөртэйгөөр суралцдаг нь ажиглагддаг.

Эдгээр веб сайтаас зарим нэгийг нь энд орууллаа: [Зурж сурахад тань түсэх 10 веб сайт / ub.life/](#)

- Drawspace - 500 гаруй мэргэжлийн болон, сохирхогчдын хичээлтэй
- Drawing Coach – Шог зургаар мэргэших, суралцах боломжтой
- Arty factory – Уран зургаас гадна дизайны нэмэлт хичээлтэй
- Academy of art university – Нэг удаагийн хичээл бүрэн мэдлэг олгохуйц чанартай бүтээгдсэн.
- Rate my drawings- Бусад зураачийн бүтээлтэй танилцах боломжтой
- Drawing now – Олон мянган зураг, дүрс, амьтан, хүний дүрсүүдээс сонголтоо хийн, зурж сурах нөхцлөөр хангагдсан.
- Daily sketch Challenge – Урлагийн талаарах хамгийн том сайт
- Ctrl+paint –Бусад сайтаас илүү орчин үеийн загвар, дизайн бүхий хичээлүүдтэй.
- Pinterest – Зөвхөн урлагийн төдийгүй бүх салбарын мэдлэг мэдээллийг олгох нийгмийн сүлжээ сайт
- You Tube – Видео бичлэгийн том сайтад зургийн талаарх мэдээллүүд их бий. Маш олон хичээлүүд байдаг тул өөрийн зорилгод тохируулан сонголтоо зөв хийх хэрэгтэй.

Үйл ажиллагааны явц:




- Дугуйлангийн цагаараа шинэ жилийн чимэглэл хийж, ангиа чимсэн.
- Гарын доорх материалаар бүтээлийн самбар хийж, бүтээлээ байрлуулсан.
- Дугуйлангийн үйл ажиллагаатаа сурталчлан бусдад түгээх боломжтой болсон

5. Үнэлгээний шийдэл



- Уншсан номын тэмдэглэл
- Миний бүтээлийн утга
- Хорт зуршлийн эсрэг гэсэн сэдвийн хүрээнд бүтээлийн үзэсгэлэн гаргаж, дугуйлангийн үйл ажиллагаагаа сурталчиллаа.

Эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах явцад сурагчид өөрийн бүтээлээр бахархаж, бүтээлийн утга санаагаа бусдад ярьж, бусад хүүхдийн бүтээлээс асуулт асуун ярилцаж байдаг нь хамтран суралцах, өөрийгөө илэрхийлэх аргад илүү суралцаж байгааг нь харагддаг.



Бага ангийн сурагчдад эзэмшүүлэх найман ерөнхий чадварын хүрээнд жил бүр судалгаа хийж үр дүнг тооцоход сурагчдын чадвар өсөлттэй байгаа нь бусад хичээлийн агуулга эзэмшилтээс шалтгаалж байгаа ч “Дүрслэх урлаг”-ийн сонгоны үйл ажиллагаа эдгээр чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна гэж дүгнэсэн.

Хүүхдийг зураг зурах явцад харааны ой илүү хөгжиж, аливаа зүйлийг хурдан тогтоодог мөн гарын жижиг булчингууд сайн хөгждөг байна. Энэ чадвар нь монгол хэлний хичээл дээр илүү ажиглагддаг бөгөөд бага ангийн сурагчдын дунд зохион байгуулагддаг монгол хэлний олимпиадад амжилттай оролцож **“Алдаагүй цэвэр бичигтэн”** ангиар шалгарсан нь нэг жишээ юм.

Мөн сургалтын үйл ажиллагаа илүү халуун дулаан уур амьсгалтай байдаг ба хүүхэд зурж байхдаа аз жаргалтай, баяр хөөртэй байдаг. Зурж чадахгүй, зурах дургүй хүүхэд нэгээхэн ч үгүй байлаа.

Дүрслэх урлагийн сургалт нь хүүхдийн чадварыг хөгжүүлэхээс гадна тэдний төлөвшилд сайнаар нөлөөлж байгаа нь дараах байдлаар харагддаг.

- Хичээлийн хэрэгслийг ариг гамтай, зөв ашиглах.
- Багаар хамтарч ажиллах
- Бусдын бүтээлээс сайн талыг олж харах
- Хувийн зохион байгуулалт сайжрах
- Өөртөө итгэлтэй болох зэрэг чадварууд хүүхэд бүрийн төлөвшилд гарч байгаа нь явцын үнэлгээгээр илэрдэг.

Дүгнэлт

Сайн зохион байгуулсан сургалт нь хүүхдийн хөгжлийг араасаа дагуулдаг байна. Сургалтын үйл ажиллагааг сайн зохион байгуулах аргын нэг хэлбэр нь хичээлийн судалгаа бөгөөд хамтын үйл ажиллагаанд түшиглэн хичээлийн судалгааг зохион байгуулахад өөр, өөр арга зүй туршлага бүхий багш нар хамтран ажиллаж, харилцан суралцах, туршлага солилцох боломжийг бүрдүүлж чаддаг үр дүнтэй үйл ажиллагаа юм. Сайтар бодож төлөвлөсөн, судалгаанд суурилсан хичээлийг улам сайжруулахын тулд судалгаат хичээл зохион байгуулах замаар багш нар хамтран туршилт судалгаа хийж хичээлийн судалгаа (Juygokenkyu) –нд оролцох явцдаа арга зүйн хувьд хөгждөг байна. Энэ үйл явцаас багш нар харилцан суралцахаас гадна, шинэ арга зүй, технологийг нээн илрүүлж, түүгээрээ хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх өөрийн арга туршлагатай болох зэрэг олон боломжийг хичээлийн судалгааны хамтын үйл ажиллагаа олгож байдаг.

Сургалтыг дэмжих хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар бусад хичээлийн чадварыг хөгжүүлэх боломжтой гэдэг нь дугуйланд хамрагдсан сурагчдын чадварт ахиц гарч байгаагаар дүгнэж болно. Мөн

хүүхдийн чадвараас гадна, тэдний төлөвшилд эерэг нөлөөтэй байгаа нь сургалтын үр дүнгээс харагддаг. Дугуйланг хүүхэд бүрийн хийх дуртай зурах үйлд түшиглэн хэрэгжүүлсэн нь ангийн бүх хүүхдийг хамруулах боломж олгосон. Ийнгэснээр тэгш сургах боломж бүрдэж байгаа нь уг үйл ажиллагааны давуу тал юм.

Хүүхдийг хөгжүүлэхэд сонирхолтой хийх дуртай зүйлээр дамжуулан сургалтыг зохион байгуулах нь илүү үр дүнтэй байна. Үүнтэй холбоотойгоор мэдээллийн технологийг ашиглаж байгаа нь олон төрлийн сурах арга барилд шинэчлэл хийхэд нэн тохиромжтой, сурагчдын идэвхийг нэмэгдүүлэх, давуу талтай, багшийн ажлыг хөнгөвчилж болохыг зохион байгуулсан үйл явц харуулж байна. Иймээс сургалтын арга зүйг хэрэгжүүлэхэд мэдээллийн технологийг оновчтой ашиглавал чухал хэрэглэгдэхүүн болох нь харагдаж байгаа юм.

Талархал

Биднийг хамтын ажиллагааны үйл явцаар хангаж, багш нар ажлын байрандаа хөгжих, хамтран мэргэжлээ дээшлүүлэх, боломжийг олгосон “Сурагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн бүх хүмүүст болон тухайн үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулах ажлыг маш үр дүнтэй удирдан зохион байгуулсан, аймгийн бага боловсрол хариуцсан мэргэжилтэн, С. Энх-Амгалан, бидэнтэй сэтгэл зүрхээрээ хамтран ажилласан, сайн дурын мэргэжилтэн багш Yamanaka Ayaka болон сургуулийн удирдлага, хамтран ажилласан багш нартаа талархал илэрхийлье.

Ном зүй

2. (2013). *Багшлахуйн хөгжил хичээлийн судлагааны арга зүйн үндэс*. Улаанбаатар: Содпресс.
3. *Жадамба, Б. Чимэдлхам, Ц. (2001). Судалгааны арга зүй*. Улаанбаатар: Тоонот принт.
4. (2014). *Бага боловсролын цөм хөтөлбөр, БСШУЯ*. Улаанбаатар
5. (2015). *“Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй”*, БСШУЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт. Улаанбаатар.
6. (2009). *“Дүрслэх урлаг” Бага ангийн багшид зориулсан гарын авлага*. Улаанбаатар: Улаанбаатар принт.
7. (2017). *Суралцагчдын ухаалаг хэрэглээ-Сургалтын үйл ажиллагаа*, БСШУЯ, Боловсролын хүрээлэн. Улаанбаатар: Соёмбо принтинг.
8. *Дагшхүү, Д. (1990). Сэтгэл судлал*. Улаанбаатар
9. (2016). *Хүүхэд бүрийн хөгжил-туришлага, амжилт, үр дүн*, БСШУЧ. Улаанбаатар.
10. www.activityvillage.co.uk

Математикийн хичээлд хөтлөн чиглүүлэх аргыг хэрэглэсэн үр дүн

¹М.Ариунзаяа, ²Ц.Оюунболор, ³О.Урангоо, ⁴О.Оюунтуяа

¹Дархан-Уул аймаг, Дархан сум, Шинэ Алхам сургуулийн багш нар,

³Дархан-Уул аймаг, Дархан сум, Од цогцолбор сургуулийн багш нар,

Удиртгал:

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт хоёрдугаар ангийн математикийн сургалтын хүрэх үр дүнг 6 чадварыг эзэмшүүлэхээр тодорхойлсон бөгөөд эдгээрийн нэг шинж болох юмсын байршил, хөдөлгөөнийг тодорхойлох чадварын хүрээнд мөр, баганыг нь тоо, үсгээр тэмдэглэсэн хүснэгт, дөрвөлжин шугамтай цаас хэрэглэн аль нэг нүдэнд байгаа юмсын байршилыг олох(1), заасан нүдэнд зурах(2), өгсөн зураг, мэдээллийг хэрэглэн юмсын байршил, түүнд хүрэх зам, чиглэлийг тодорхойлох(3), заасан зам чиглэлийн дагуу шилжүүлэх(4), холбогдох заавар өгөх(5), юмсын байршил, хөдөлгөөний агуулгатай асуудал шийдвэрлэх(6) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр (2014). х 42)- өөр тус тус заасныг хүүхдийн хэрэгцээ, сонирхол, туршлага, чадварт суурилж, бие даан суралцах арга барилыг хөгжүүлэх, хүүхэд бүр хамтаар дасгал, бодлого, сорил, даалгавар гүйцэтгэх зэргээр хамтран ажиллах болон оролцооны арга барилд суралцахад цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйг чиглүүлэх, тодорхойлсонтой холбогдуулан авч үзэж, хүүхэд өөрөө мэдлэг бүтээх, алдаанаасаа суралцахад нь анхаарах, асуултаар үйл ажиллагаа болон суралцагчийн хөгжлийг дэмжих, үйлийн явцад хөгжих, тоглох явцад хөгжих төлөвших (Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр (2014). х 18)гэсэн аргагүйн шаардлагад нийцүүлэн, хоёрдугаар ангийн математикийн хичээлийн нэг хэсэг юмсын байршил хөдөлгөөнийг тодорхойлох үйлийг хөтлөн чиглүүлэх аргыг сонгон үр дүнтэй явуулах боломжтой гэж үзэн, уг сэдвийг сонгон, онол, аргагүйн судалгааг тус тус хийлээ.

Нэг: Онолын хэсэг


А. Юмсын байршил хөдөлгөөнийг тодорхойлох арга, аргачлал

Бага боловсролын математик сургалтын цөм хөтөлбөрийн хүрээнд байршил, хөдөлгөөний тухай ойлголт өмнөх он жилүүдэд заагдаж байгаагүй бөгөөд заах аргагүйн хувьд хүнд сэдвийн тоонд ордог.

Байршил, хөдөлгөөнийг заах дарааллыг Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн багийн судлаачдын хувьд


1. Газрын зураг дээрх байрлалыг зүг чиг заах сумыг ашиглах (математик-II анги 2013)
2. Тодорхой нэг зүйлийг төв болгон авч зүг чигээр тэмдэглэн бичих (хүн ба орчин I анги 2015)
3. Орчин үеийн математик сургалтын онцлог нь аливаа хүүхэд сурах үйлээр дамжуулан өөртөө мэдлэг бүтээх явдал (Sigma2 Генри Шульц, Бенни Зиберг.. 2011 он)
4. Шатрын хөлөг, онгоц буудаж тоглох зэрэг тоглоом ашиглах

Дээрх байршил, хөдөлгөөнийг тодорхойлох арга барил тус бүрд задлан шинжилгээ хийсний үндсэн дээр бага боловсролын хоёрдугаар ангийн математикийн хичээлийн хүрээнд хичээлийн сэдвийг энгийн хүүхдийн сонирхлыг татахуйц өгснөөр ухагдахууныг ойлгуулахдаа хөтлөн чиглүүлэх аргыг ашиглан тоглонгоо мэдлэгээ чавдар болгож буй үйлийг санал болгож байна.



Сурах бичгийн хүрээнд авч үзвэл :

Зураг 1



Дээрх арга, аргачлалаас хоёрдугаар ангийн математикийн сургалтад хүснэгт дээрх юмсын байршлыг тогтоох, хэдэн янзаар шилжих үйлийг түлхүү хэрэглэгдэж байгаа нь сургалтын практикаас харж болно.

Б. Хөтлөн чиглүүлэх арга

Хүүхдийг хөгжүүлэхэд төгс тохирсон технологи гэж байхгүй, харин хүүхдийн цогц хөгжлийг дэмжих технологи тодорхой аргад үндэслэн хөгжүүлж болдог. Хүүхдийн хамгийн ойр хэрэглэгддэг үгсийг ашиглан тоглонгоо сургах аргын зориулалт бол сурган хүмүүжүүлэх үзэгдэлд ямар нөлөө үзүүлэхэд тэр хэрхэн өөрчлөгддөг, эдгээр нөлөөлийн үр дагавар, зүй тогтол зэргийг нарийн судалж тогтоох явдал юм. Хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон сонирхолтой, хөгжилтэй үгсийг ашиглан хичээлийн сэдвийн нэрийг өгснөөр тэндий хичээлд оролцох идэвх илүү хүүхэд өрнөсөөр тэдний хөгжиж буйг судалгаанаас харж болно.

Хоёр: Судалгааны хэсэг



Бага боловсролын математик сургалтын практикт тэр тусмаа хоёрдугаар ангийн “байршил, хөдөлгөөнийг тодорхойлох” сэдвийг ямар аргыг хэрэглэж буй өнөөгийн байдлыг илрүүлэх зорилгоор бага боловсролын багш мэргэжилтэй 73 багшаас асуулгын аргаар судалгаа авлаа. Судалгаанд “Од” цогцолбор сургуулийн 48, Шинэ Алхам сургуулийн 6, бусад сургуулийн 19 багшийг хамруулав. Санал асуулгын үр дүнг дараах диаграмм, тайлбараас харвал:

Диаграмм- 1

Хоёрдугаар ангийн сурах бичигт хүснэгт ашиглан юмсын байршил хөдөлгөөнийг тодорхойлох аргыг хэрэглэн таниулахаар орсон байдаг. Санал өгсөн багш нарын 73% нь хүснэгт ашиглан юмсын байршил хөдөлгөөнийг тодорхойлох гэсэн хариулт өгсөн нь сурах бичигт байгаа аргаар заадаг нь харагдаж байна.

Диаграмм- 2

Ялангуяа хоёрдугаар ангийн математикийн сургалтын хүрээнд хүүхдийн ойр мэддэг үг хэллэгээр заах аргачлал сурах бичигт тодорхой биш байдаг учир бэрхшээлтэй байдаг, мөн сурагчдын хүлээн авах чадвар өөр өөр учир багш өөрийн үгээр илэрхийлэх үйл ажиллагаа чухал байдгийг онцолсон.



Диаграмм-3

Ойлгоогүй сурагчид бусад найз нарынхаа тайлбарыг сонсохоос гадна тоглож буй үйлээс суралцаж байгаа нь илүү үр дүнтэй байсан. Заавал ялгавартай даалгавраар сайжруулах бус бусдын тоглох явцад өөрөө учрыг олж буй байдал тэдний тоглонгоо суралцах таатай, эерэг үйлийг бүрдүүлж өгдөг үзэл баримтлалд нийцэж байлаа.

Судалгаат хичээл, үр дүн:

Бага боловсролын хоёрдугаар ангийн математикийн хичээлийн хүрээнд юмсын байршил хөдөлгөөнийг тодорхойлох хичээлийг “Найздаа туслацгаая” сэдвээр хөтлөн чиглүүлэх аргаар хичээлийг зохион байгуулж, хичээлийн судалгааны үнсэн алхам (Хичээлийн төлөвлөлт /бэлтгэл судалгаа/- Хичээл заах, ажиглах- Хичээлийг хэлэлцэх)-ын дагуу хийсэн судалгаат хичээл (Судалгаат хичээл бол хичээлийн судалгааны үндсэн нэгж юм. Хичээлийн судалгааны 3 алхмыг нэг удаагийн ээлжит хичээлд буулгаж хэрэгжүүлсэн судалгааны нэгж) – ийн үр дүнг танилцуулбал:


Дархан-уул аймгийн Дархан сумын Шинэ алхам сургуулийн М.Ариунзаяа багштай 2а ангийн 25 сурагчийг хамруулан, 3 удаагийн судалгаат хичээлийг 2018.09.24- 10.05-ныг дуусталх хугацаанд зохион байгуулсан.

Хичээлийн төлөвлөлт

Хүснэгт 1


№	Үе шат	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа
1	Бэлтгэл үе	Юмсын байршил хөдөлгөөний тодорхойлох сэдэвт холбогдох онолын судлагдахууныг уншиж судлах, боловсруулалт хийх, багцлах, нэгтгэх	
		Хичээлийн бэлтгэл судалгаа хийх 1. Судлагдахууны агуулгын судалгаа хийх 2. Мэдлэг эзэмшилтийн судалгаа 3. Аргазүй (багшлах арга барил)-н судалгаа 4. Хэрэглэгдэхүүний судалгаа 5. Үнэлгээний судалгаа	2017-2018 2018-09-10 2 долоо хоног
2	Үндсэн үе	Ээлжит хичээлийн төлөвлөлтийн дагуу “ Судалгаат хичээл”-ийг заах	3 дахь долоо хоног
		Судалгаат хичээл 1	2018-09-24
		Хичээл 1-ийн хэлэлцүүлэг	
		Судалгаат хичээл 2	2018-09-26
		Хичээл 2-ын хэлэлцүүлэг	
		Судалгаат хичээл 3	2018-10-28
3	Төгсгөл үе	Судалгаат хичээлийн үр дүнг танилцуулсан өгүүлэл бичих	Судалгаат хичээлийн хэлэлцүүлгийн дараа
		Судалгаат хичээлийн үр дүнг танилцуулсан илтгэл хэлэлцүүлэх	
		Сайжруулсан хичээлийн агуулгаар Үзүүлэх хичээл заах, хэлэлцүүлэх	

“Хичээлийн бэлтгэл судалгаа”-г элемент тус бүрээр хэрхэн хийснийг харуулбал:



Судлагдахууны агуулгын судалгаа хийсэн чиглэл	Юмсын байршил хөдөлгөөнийг тодорхойлох сэдвийн хүрээнд агуулгын судалгаа хийсэн байдал
Юмсын байршил хөдөлгөөнийг тодорхойлох сэдвийн агуулга бага боловсролын математикийн цөм хөтөлбөрт хэрхэн туссан бэ?	Юмсын байршил, хөдөлгөөнийг тодорхойлох чадварын хүрээнд мөр, баганыг нь тоо, үсгээр тэмдэглэсэн хүснэгт, дөрвөлжин шугамтай цаас хэрэглэн аль нэг нүдэнд байгаа юмсын байршлыг олох(1), заасан нүдэнд зурах(2), өгсөн зураг, мэдээллийг хэрэглэн юмсын байршил, түүнд хүрэх зам, чиглэлийг тодорхойлох(3), заасан зам чиглэлийн дагуу шилжүүлэх(4), холбогдох заавар өгөх(5), юмсын байршил, хөдөлгөөний агуулгатай асуудал шийдвэрлэх(6) чадварыг эзэмшүүлэхээр тусгасныг үндэс болгосон.
Бусад хичээлүүдтэй ямар залгамж холбоотой вэ?	1дүгээр ангийн хөтөлбөрийн орон зайн, чиглэлтэй холбоотой үг хэллэг хэрэглэн юмсын байршил хөдөлгөөнийг тайлбарлах, заасан байрлалд зураг байрлуулахтай холбогдоно. 1дүгээр ангийн Хүн ба орчин судлагдахууны “Манай гэр ба сургууль” нэгж хичээл
Дараагийн ангид энэ сэдвээр юу юуг гүнзгийрүүлэн судлах вэ?	Танил орчин, юмсын байршлын хялбар зургийг тайлбарлах, юмсын байршлыг тодорхойлох агуулгатай асуудал шийдвэрлэх Өгсөн зураг мэдээллийг хэрэглэн юмсын байршил, түүнд хүрэх зам, чиглэлийг тодорхойлох Заасан зам чиглэлийн дагуу шилжүүлэх, холбогдох заавар өгөх Юмсын байршил, хөдөлгөөний агуулгатай асуудал шийдвэрлэх асуудлыг эзэмш тусгасан.
Агуулгын судалгааг ямар ямар эх сурвалжаас хийсэн бэ?	Бага боловсролын цөм хөтөлбөр, 2014 Математик 2, зурах бичиг, 2014 Математик 2, багшийн ном 2014 Хоёрдугаар ангийн математикийн хичээлийн зөвлөмж, 2014 Батболд, Г, Чимгээ, Б (2014) Бага боловсролын математикийн онол, аргазүйн асуудалд, Улаанбаатар
Сурагчдаа энэ агуулгыг яаж таниулах вэ?	Хялбар үг хэллэг хэрэглэн Тоглуулах /хүснэгт ашиглан / Шатрын хөлөг ашиглах

Хэрэглэгдэхүүний судалгаа:

Ямар, ямар хэрэглэгдэхүүн сонгож, хэрэглэхээр төлөвлөв? Тэдгээрийг бэлтгэхэд анхаарах зүйл юу вэ?	<ul style="list-style-type: none"> - “Нөхрийн хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтнэ” хэлц ашиглах - ТӨМ- хулгана-бяслаг, нохой-яс, туулай - лууван явах хүснэгтийг хүүхэд 1 бүрт өгөх - Тоглоом болгон ашиглах цагаан 5x5 самбар сурагчдын тоогоор өгөх - Зурагт болон хэрчмэл үзүүлэн өгөх <div style="text-align: right;"> <p>Найздаа туслацгаая Нөхрийн хэрэг бүтвэл Өөрийн хэрэг бүтнэ</p>  </div>
Хэрэглэгдэхүүн тус бүрийг хичээлийн ямар үе шатанд, хэрхэн хэрэглэхээр төлөвлөв? Яагаад	<p>Сэдэлжүүлэх үе- найзууддаа яаж туслах арга замыг олох</p> <ul style="list-style-type: none"> - Хоол хүнсэндээ яаж хүрэх замыг заалгах /зурагт хэрчмэл үзүүлэн/ - Гэрийн хаягийг нь хэлж өгцгөөе- цагаан самбар ашиглан тоглох <p>Мэдлэг бататгах- байршлыг тогтоохдоо мөр, багана ойлголтыг орц, давхар болгон тоглуулах</p> <p>Үнэлгээнд – дүрс, биет байршуулсан зурагт ажлын хуудас</p> <p>Дүгнэлт- амьтдын байршлыг тодорхойлох, бичих хуудас</p>
Цахим хэрэглэгдэхүүн хэрэглэх шаардлагатай юу? Ямар шаардлагыг хангасан гэж үзэж байна вэ?	<p>https://www.facebook.com/conmamiaprendo/videos/2185972845017300/бие</p> <p>Сурагчдын бие даан асуудлаа шийдвэрлэх чадварыг хангахад туслах</p>

Самбар төлөвлөлтийг хэрхэн төлөвлөх вэ?	Зураг оруулах
---	---------------

Мэдлэг эзэмшилтийн судалгаа хийсэн чиглэл:

Суралцагч сурахуйн ямар арга барил илүү эзэмшсэн байна вэ?	Мөр, баганыг мэдсэнээр байршлыг тогтоох, байршуулах, шилжүүлж чаддаг болсон байна. Дурын байршилд тэмдэглэх, явах зүгийг тодорхойлдог болсон. Юмсын байршлыг бичих, тайлбарлах чадвартай.
Энэхүү агуулгыг судлахад сурагчдын өмнөх төсөөлөл, мэдлэг, чадвар ямар байх вэ?	Байршил хөдөлгөөний үг хэллэгийг мэддэг байх Баруун, зүүн, урд, хойно, өмнө гэсэн зүг чигийг таньдаг байх
Суралцагч ямар үйл хийж, шинэ мэдлэг эзэмшихээр төлөвлөсөн бэ?	Амьтдын хоол хүнсийг олж идэх замыг зурах Очих газрын хаягийг ба байршлыг тогтоох Өгөгдсөн байршил болон байршлыг бичих, зурах, нүдийг тоолох
Суралцагч ямар алдаа гаргаж болох вэ?	Байршил, хөдөлгөөн гэдэг үгсээр заахад учрыг олохгүй байх Явах замыг диагналдаж зөөх гэх мэт алдаа гаргаж болно. А5 гэж бичихийг 5А гэх мэт

Багшлахуйн арга зүйн судалгаа хийсэн чиглэл:

Сургалтын ямар аргыг илүү сонгож авсан бэ?	Хичээлийн сэдвийг сонирхол татахуйц өгч түүгээрээ хөтлөн чиглүүлэх замаар тоглуулах аргыг сонгосон нь сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх, тухайн ухагдахууны мөн чанарыг ухаарч ойлгох асуудал шийдвэрлэх чадварт сургах сайн талтай гэж үзсэн.
Хичээлийн ямар үе шатад сургалтын аргад хэрхэн хэрэгжүүлсэн вэ?	Сэдэлжүүлэх хэсэгт – хөтлөн чиглүүлэх аргаар сурагчид мөр, баганын учрыг олох Мэдлэг бүтээх хэсэгт- юмсын байршлыг тогтоох, тогтсон байршилд шилжүүлэх Дүгнэлт хэсэгт- цагаан самбар дээр тоглох

Үнэлгээний судалгаа хийсэн чиглэл:

Үнэлгээний ямар хэлбэрийг, хэрхэн сонгож авсан бэ?	Сурагчид бэлтгэсэн цагаан самбарт дурын цэг байрлуулж түүнийгээ хэлж оноо өгч тоглох
Суралцагчдын ахиц, амжилтыг үнэлэх талаар багш хэрхэн төлөвлөсөн бэ?	Сурагчдын анхны явцын тандалт ба сурагчдын оролцог ажиглан тэмдэглэх тэдгээрийн ахицаар үнэлэх
Хичээлийн төгсгөлд хүүхэд юу мэддэг, чаддаг, хувирган хэрэглэдэг болсон байх вэ?	Юмсын байршлыг тодорхойлж бичих, тогтсон байршилд тэмдэглэх түүнийг тайлбарлан ярих чадвартай болсон байна.

“Судалгаат хичээл”-ийг зааж хэлэлцүүлгийн үр дүнд сайжруулсан зарим сайжруулалт

Хүснэгт 2

Хичээлийн бүтэц, үе шат	Хичээл 1	Хичээл 2	Хичээл 3
Анги зохион байгуулалт	Анги нийтээр зохион байгуулсан. Сурагчдыг бүрэн хамруулсан	Хүүхэд болгоныг оролцуулсан боловч сонгох байдал дээр сул	Хүүхэд бүрийг оролцуулсан бөгөөд тайлбарыг хэлэх

	боловч цагийн алдагдал гарсан.	байсан. Хичээлийн дэгийг төлөвлөсөн боловч дуу чимээ ихтэй байсан. Бусдыг сонсоход бэрхшээлтэй байсан.	сурагчдыг гар өргөж ярихаас илүү оролцох сурагчид босож зогсоод ижил санаа гарсан тохиолдолд сурагчид сууснаар хичээл их тааламжтай орчинд бусдыг сонсох байдал илүү давуу болсон.
Сэдэлжүүлэлт	Хөдөлгөөнт үзүүлэнг цахимаар үзүүлэнгээ заасан боловч шууд мөр, баган гэхэд сурагчдын ойлголт эрс буурсан. Тиймээс буцаж тайлбарлаж цаг алдсан.	Найздаа зам зааж туслах зорилгоор хөдөлгөөнийг хийж хаягийг нь олж өгсөнөөр байршлыг тодорхойлж байгаа боловч багшийн сурагчдаас асуух асуултыг оновчтой болгох ёстойг хүүхдийн үгнээс засан цааш үргэлжлүүлсэн.	Бид найздаа яаж туслах вэ? -зам заах -явах замыг зуруулах - хаягийг тодорхойлох гэсэн дараалал тогтоосноор цаг алдахгүйгээр заагдсан.
Мэдлэг бүтээлгэх	Байршлыг тодорхойлоход мөр баганаа мэдэхгүйгээс АЗ-ыг ЗА гэж хэлж түүнийг засах арга их хүндэвтэр болсон.	Мөрийг орц, баганыг давхар гэж ярилцсанаар амьтдын байршлыг маш сайн тогтоож бичиж байсан боловч математик хэллэгээр тусгах тал дээр дутмагшилтай байсан.	Багш тулгуур дохио ашигласнаар тайлбарлан ярихад асуудал гараагүй.
Мэдлэгээ бататгах	Сурах бичиг дээр дасгалуудыг ашигласан боловч даалгаврын ангилалд анхаараагүй улмаас маш их цаг авсан. № 133	Сурах бичгийн №130-ыг хийлгэсний дараа №129 рүү оруулах нь илүү давуу байсан.	Сурагчдын сонирхолд нийцүүлэн №133-ыг ажиллуулснаар маш сайн бататгал болсон.
Үнэлгээ	Сурагчдын хичээлд оролцож буй сурагчдын тоо бага ба бусад сурагчдыг үнэлэх аргыг тодорхойлоогүй.	Сурагчдын дэвтрийг хураан авч үнэлнэ гэсэн төлөвлөлт байсан боловч хүүхэд гэртээ хариад өмнөхөө бататгах байдлыг харгалзаагүй.	Сурагчдыг цагаан самбарт байршил болон хөдөлгөөнийг тодорхойлсон байдалд үнэлгээ хийх илүү хялбар байсан.
Дүгнэлт	Дүгнэлт хийх цаг гараагүй.	Самбарт төлөвлөлт анхаараагүй тул дүгнэлт гарч чадаагүй.	Сурагчид хичээлийн сэдвийн нэрэнд тулгуурлан самбар дээр зүйлийг ажиглан хичээлээ дүгнэсэн.

Дүгнэлт:

1. Юмсын байршил, хөдөлгөөнийг тодорхойлох сэдэвт холбогдох онолын судлагдахууны хүрээнд:
 - Мэргэжил нэгт багш нарын заахад хүндэтгэр сэдвийг сонгон авч 7 настай сурагчдад энгийн хэрэглэгдэхүүнээс гадна тэдний хамгийн ойр үгсээр энгийн хүүхдэд тохирсон хичээлийн гарчиг өгөх нь тэдгээрийг хөтлөн чиглүүлэхэд их нөлөө үзүүлсэн байдлыг жагсаалтаар харуулсан нь багш нарт энэ ухагдахууныг олон арга байдлыг нэг дороос харах, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжтой болох
 - Мөн хүснэгтийг ашиглан заах нь нийтлэг арга зүй мэт харагдаж байгаа боловч математик үг хэллэгт сургахын тулд заавал энгийн үгсийг тулгуур үгээр сольж буй байдлыг ажиглуулах нь илүү чухал гэдгийг онцлон авч үзлээ.
2. Хичээлийн судалгааны нэг хэсэг болох судалгаат хичээлийг зохион байгуулснаар багшлахуйн арга зүйд суралцсан сайн алхмын нэг болсон.
3. Судалгаат хичээлийнхүрээнд энгийн үгээр хөтлөн чиглүүлэх аргыг хоёрдугаар ангийн математикийн хичээлд ашиглаж болох аргазүйн хувилбарыг боловсруулж, хэрэгжүүлсэн нь үр дүнтэй болсон гэж дүгнэж байна.

Ном зүй:

1. Ариунтунгалаг. Б, Гантулга. Б, Хишигжаргал. Д, (2014). Математик 2, Улаанбаатар
2. Батболд. Г, Чимгээ. Б (2014) Бага боловсролын математикийн онол, аргазүйн асуудалд, Улаанбаатар
3. Бүндэн. Д, Шаравнямбуу. Ц, (1983) га боловсролын сургалтын цөм хөтөлбөр, Улаанбаатар

Хүүхэд нэг бүрийг өгүүлбэртэй бодлого бодуулж сургах нь

Л.Болортунгалаг, холбоо барих утас: 9118122, С.Отгонбаяр, Завхан аймгийн Цэцэн-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нар

Удиртгал

Хүн бүр математикч байх албагүй гэж ярьдаг. Гэхдээ амьдралд өдөр бүр л ямар нэгэн асуудлыг шийдвэрлэх ,тооцоолох , бодож үзэх шаардлага урган гарч байдаг. Иймээс аливаа асуудлыг зөв дараалалтай ,цэгцтэй, хурдан шаламгай сэтгэн бодож тооцоолох чадвар хүн бүхэнд хэрэгтэй байдаг. Эдгээр чадварыг хөгжүүлэх нэг арга зам нь өгүүлбэртэй бодлогыг бодуулж сургах юм.

Гэтэл хүүхдүүд өгүүлбэртэй бодлогыг бодохдоо тийм ч дуртай биш байдаг.Хүүхдэд олон бодлогоос сонгож бодох боломж өгөхөд ихэнх нь өгүүлбэртэй бодлого бодохоос зайлсхийж байгаа нь харагдсан.Энэ нь тэд өгүүлбэртэй бодлогыг бодох нь хэцүү гэдэг ойлголттой мөн өгүүлбэрийг гүйцэт уншиж ойлгодоггүйтэй холбоотой. Энэ асуудлыг багш эцэг, эх, суралцагч хамтран шийдэх арга зүйг харуулахыг зорилоо.

Сэдэв сонгосон үндэслэл

Бага боловсролын математикийн хичээлд өгүүлбэртэй бодлого бодуулж сургах нь чухал юм. Өгүүлбэртэй бодлого бодох явцад сурагчдын унших, ойлгох, ярих, тооцоолох зэрэг олон чадвар хөгжиж байдаг. Сурагчид бодлого бодох арга барилыг эзэмшснээр дүнд ахлах ангид математикийн хичээл болон хими, физик, биологи, газарзүй зэрэг олон хичээлд энэхүү чадвар нь хэрэглэгдэж байдаг. Гэвч хүүхэд бүр өгүүлбэртэй бодлогыг бодох чадвар сул байдаг нь багш бидний хувьд бэрхшээлтэй асуудал хэвээр байна. Иймд 1,2-р ангиас зөв арга барил эзэмшүүлэх зорилго нь энэхүү сэдвийг сонгох үндэслэл болсон.

Бага боловсролын сурагчдад математикийн хичээлд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх зорилгоор 2-5-р ангийн сурагчдаас 1-р улиралд авсан шалгалтын дүнд өгүүлбэртэй бодлого бодсон байдалд хийсэн анализ



Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

6-11 насны хүүхдийн дүрслэл идэвхтэй оролцохгүйгээр тэд ертөнцийг танин мэдэж чадахгүй. Судалгаанаас үзэхэд хүүхдүүд хичээлээр заалгасан зүйлээ тогтоож, тэдгээрийг ой ухаандаа хадгалж, сэргээн санахад тэдний дүрслэх үйл онцгой үүрэгтэй болох нь нотлогджээ. Хүүхдийн хувийн туршлага нэмэгдэж, мэдлэг төсөөллийн хүрээ ихсэх тусам тэдний дүрслэлийн агуулга өргөжин, баялаг олон талтай болж, хөгжин төлөвшинө. Зохион бодохуйн хөгжлийн хувьд хүүхдийн туршлага нэмэгдэхийн хирээр тэдний зохион бодох үйл идэвхтэй хөгжинө. Зохион бодох үйл нь хүүхдийн тоглох, сурах, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад хөгждөг.

Өгүүлбэртэй бодлого бодуулах арга зүй

Өгүүлбэртэй бодлогын нөхцөл нь бидний амьдралд өдөр бүр тохиолдож байдаг үйл явдал юм гэдгийг ойлгуулах нь чухал байдаг.

Өгүүлбэртэй бодлого бодуулж сургахад бид сурагчдаар дараах 5 алхамыг хийлгэдэг билээ.


1. Өгүүлбэрийг сайтар уншиж, ойлгох
2. Бодлогын нөхцөл өгөгдөл, олох зүйлийг загварчлан дүрслэх
3. Төлөвлөгөө зохиож, бодох аргаа сонгох
4. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх, бодох
5. Бодолтоо хянах, бусдад тайлбарлах

1,2-р ангийн сурагчдын хувьд бодлогын өгүүлбэрийг уншиж сайн ойлгосны үндсэн дээр бодлогын нөхцөлөө тодорхойлж зураглал, товч бичиглэл хийх. Үүний дараа зураглал болон товч бичиглэлээ харж бодлого бодох үйлдлээ хийж гарсан шийдээ бүтэн өгүүлбэрээр хариулдаг болох нь чухал юм.

3-р ангиас эхлэн бодлогын төрөл зүйл олшрох ба өмнөх ангиудад өгүүлбэрээр уншиж ойлгоод зураглал хийж сурсан сурагчдад хүндрэл бага гарна. Иймд 3-р ангиас нэг бодлогыг олон аргаар бодуулж сургах чадвар эзэмшүүлнэ.

2-р ангийн сурах бичигт өгүүлбэртэй бодлогын эзлэх хэмжээ

Нийт 677 дасгал даалгавар




■ Бусад дасгал даалгавар ■ Өгүүлбэртэй бодлого

Хичээлийн санаа: Заах аргын нэгдлийн багш нар болон сургалтын менежертэй хамтран сурах бичиг болон шалгалтын сэдэвт анализ хийсний дараа сурагчдын өгүүлбэртэй бодлого бодох чадварыг нэмэгдүүлэх, зөв арга барил эзэмшүүлэх зорилгоор хичээлийн хөтөлбөрөө хамтран бэлтгэж болвсруулсан.

Хичээлийн бэлтгэл судалгаа:

2-р ангийн сурагчдын бодлого бодох чадварыг тандсан.



Бэлтгэл судалгаагаа хийхдээ сурагчдын энгийн бодлого бодох чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах шаардлага гарч ирсэн.

Судалгаат хичээл:

Энэ хичээлийг заахын тулд хамтран бэлтгэл судалгааг хийж 3 цагийн хичээлийг бэлтгэж заахаас гадна сурагчдыг чадваржуулах зорилгоор 2 сарын хугацаанд хийх ажлаа төлөвлөн хийсэн. Энэхүү ажилд эцэг эхчүүдийг мөн идэвхтэй оролцуулсан.

№	Хийх ажил	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Гарааны үнэлгээ тогтоох	3-р сард	Энгийн ба нийлмэл бодлого бодох чадварыг сурагч бүрээр гаргах
2.	Бэлтгэл судалгаа	3-р сард	
3	Судалгаат хичээлийг заах	3-р сард	
4.	Бодлого төрөлжүүлэн бэлтгэж хувилах	3-р сард	Энгийн-10, нийлмэл-90 бодлого бэлтгэх.Нийлбэр,ялгавар, үржвэр, ногдвор олох зэрэг бодлогыг сурагчдаар бодуулж чадваржуулах
3.	Эцэг эхчүүдэд сургалт хийх	3-р сард	Бодлого бодох алхамууд болон бодлогын төрлүүдээр сургалт явуулснаар гэрийн даалгавар хийлгэхэд дөхөм болно.
5.	Эцсийн үнэлгээ хийх	4-р сард	2-р шатны 50 бодлогын хүрээнд анализ хийж дүгнэлт гаргах
6.	Тайлан	4-р сард	Сурагчид өгүүлбэртэй бодлого бодож чадваржсанаа эцэг эхчүүддээ тайлагнах

Хичээлийн эхлэл хэсгийн шийдэл:

Алхам-1 Энгийн бодлого бодуулах арга барил эзэмшүүлэх зорилготой. Сурагчид хосоор ажилласан. Багш сурагчдад бодлогын өгүүлбэрийг тараан өгч уншуулсан. Уншиж ойлгосны дараа бодлогын өгөгдөлд гарсан зүйлүүдийг зургаар өгч хосоор нь цаасан дээр наалгасан. Эндээс ажиглалт хийхэд хос болсон сурагчдын 6 хос буюу 66% нь зөв байрлуулан нааж 3 хос буюу 44% нь буруу байрлуулсан байсан.

Буруу байрлуулан наасан сурагчид нь бодлогын өгүүлбэрийг сайн ойлгоогүй байсан. Багш өгүүлбэрийг сайн уншиж ойлгоход нь чиглүүлсэн

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл:

Алхам-2 Сурагчдаар өөрсдийн хийсэн зураглалыг нь дэвтэрт бичиглэл болгон хийлгэж багшийн асуултаар чиглүүлсэн.

- Бодлогын нөхцөлд юуны тухай гарсан бэ?
- юу юу хэдэн ширхэг байна ?
- Юу мэдэгдэхгүй байна вэ?
- Яаж олох вэ?

Зарим сурагчид зураглалыг дэвтэртээ бичиглэл болгохдоо алдаатай хийсэн байгаа нь ажиглагдаж байсан. Үүнийг багш тухай бүрд нь чиглүүлж засаж байлаа.

Алхам-3 Зураглал, бичиглэлийг хийсний дараа сурагчид бодолтыг дэвтэртээ хийсэн. Нийт сурагчдын 14 буюу 77% нь бодож 4 сурагч бодолтыг буруу хийсэн байсныг багшийн тайлбар чиглүүлгээр зассан.

Хичээлийн төгсгөл хэсгийн шийдэл:

Сурагчдаар бодсон бодолтыг тайлбарлуулан ярилцсан.Ихэнх сурагчид бодолтоо бусдадаа тайлбарлаж байсан бол зарим сурагчид зөв бодсон боловч тайлбар хийсэнгүй. Дээрх арга зүйгээр энэ хичээл дээр 2 бодлогын бодсон.Сурагчдаас хичээлийн төгсгөлд хичээл хэр сонирхолтой байсан бэ?, дараагийн хичээлээр юу хийхийг хүсэж байгааг асуухад

- Зураг наах сонирхолтой байна
- Дараагийн хичээлээр нааж, зурж өгүүлбэртэй бодлого бодмоор байна гэж хариулж байсан.

Хэлэлцүүлэг:Хичээл заасан болон ажиглалт хийсэн багш нар хамтран хичээлийн дараа хэлэлцүүлэг хийж дахин сайжруулах саналаа нэгтгэсэн.

Багш нараас гарч байсан нийтлэг санал:

- Бодлогын өгүүлбэрийг сайн ойлгуулах 2 ангид багш дахин уншиж өгөх

- Өгүүлбэрийг төсөөлүүлэн бодуулах
- Зураглал бичиглэл хийх
- Бодолтыг гүйцэтгэх
- Бодолтыг тайлбарлуулах
- Дараагийн хичээлээр хос бүрд өөр өөр бодлого өгч бодуулах зэрэг саналууд гарсныг дараагийн хичээлийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлсэн.


Судалгаат хичээлээр хичээлийн хөтөлбөрт хийсэн сайжруулалт

Хичээлийн үе шат	Анх төлөвлөсөн үйл	Дахин сайжруулсан хувилбар	Гарсан үр дүн
Хичээлийн эхлэл хэсэг	-Сурагчид бодлогын өгүүлбэрийг уншиж ойлгох -Ойлгосон зүйлээ цаасан дээр наах зураглах -Хосоор ажиллуулах	-Сурагчдаар өгүүлбэрийг сайн уншуулж ойлгуулах . -2-р ангийн сурагчдын хувьд багш заавал уншиж тайлбарлах, үүний дараа сурагчдаар зураглал хийх -Хосоор ажиллуулахаар төлөвлөсөн нь нийлмэл бодлого бодуулахад хэрэглэгдэхүүн их шаардаж байсан учир багаар хувиарласан.1 баг 4 сурагчтай.	Сурагчид өгүүлбэрийг бүрэн гүйцэт ойлгосноор зураглал, бичиглэл, бодолтыг сайн гүйцэтгэж даалгавар бүтээлч болсон.
Хичээлийн өрнөл хэсэг	-Зураглалын дагуу товч бичиглэл хийх -Бодолт хийх	-Энэ алхамд багшийн чиглүүлэг чухал байсан учир багш дагуулан бичиглэл хийлгэх	Сурагчид бодолтыг гүйцэтгэх үед хэрхэн гүйцэтгэж байгаа талаар багш хянах боломжтой болсон.
Хичээлийн төгсгөл хэсэг	-Сурагчид бодолтоо бусдадаа тайлбарласан.	-Багаар ажилласан сурагчдын бодолтыг самбарт харагдахуйц байрлуулж тайлбарлуулсан. -Бодлогын нөхцөл өгөдөлтэй холбоотой алжаал тайлах дасгалуудыг хийлгэх	Сурагчдын хаана алдаж байгааг хянах боломжтой болсон. Ихэнх сурагчид хэмжих нэгж, нэрийг бичдэг болсон. Өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэх итгэл нэмэгдсэн.


1. 2 сарын хугацаанд бодох бодлогын төрөлжүүлэн бэлтгэж тарааж өгсөн.
2. Эцэг эхчүүдэд өгүүлбэртэй бодлого бодох алхам, хүүхдэдээ хэрхэн тусалж гэрийн даалгавар хийлгэх талаар сургалт явуулав.




3. Эцэг эхчүүдийг урьж хичээл заасан.
4. Дээрх ажлуудыг хийсний үр дүнг нэгтгэх зорилготой, сурагчид бодлого бодох арга барил хэрхэн эзэмшнийг хянах зорилгоор үнэлгээ хийсэн.



Эндээс харахад нийлмэл бодлого бодох чадвар нь 45%-иар нэмэгдсэн байна. Энгийн бодлогыг бодож чадаагүй сурагчдын хувьд унших чадвар нь бусдаасаа сул сурагчид байсан. Иймд багш миний хувьд эдгээр сурагчдын унших, ойлгох ,ярих, бодох чадварыг хөгжүүлэх шаардлага гарч ирсэн.



- 2 Сарын хугацаанд бодсон бодлого болон бусад бодлогын хувьд сурагчид эцэг эхчүүддээ тайлан тавьсан. Энэ үйл ажилгааны хүрээнд сурагчид бэлтгэсэн бодлогыг сугалан уншиж ойлгоод зураглал, бичиглэл хийж бодлогоо бодож түүнийгээ бусад тайлбарлаж байсан . Мөн ижил төстөй бодлогын өгүүлбэр зохиосон.
- Сурагчид өгүүлбэртэй бодлогын төрөлжсөн дэвтэртэй болж өдөр бүр 2-3 бодлого бодож байсан.



Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа:

Сурагчид өгүүлбэртэй бодлогын утгыг ойлгож ухаарах, нөхцөлийг ойлгох, түүнийгээ бодитоор зураглал хийх, ургуулан бодож бодолтыг хийснээр бодлого бодох бэрхшээлийг арилган тооцоолон бодох чадварт ахиц гарч байсан нь батлагдсан юм.

Дүгнэлт

Яагаад сайн хичээл болсон бэ? Сурагчид бодлого бодох арга барил сайн эзэмшээгүй нь тэдэнд тулгарч байсан гол бэрхшээл байсан юм. Иймд энэ бэрхшээлийг арилгаснаар хүүхэд бүрт болон ангийн сурлагын чанарт ахиц гарсан. Мөн багш бид өгүүлбэртэй бодлого бодох явцад сурагчдын олон чадварууд давхар хөгжиж байгааг олж харсан.

- Сурагчид бодлого бодох аргаа эзэмшсэн учраас сонирхолтой идэвхтэй болсон
- Ангидаа өдөр бүр өгүүлбэртэй бодлогын цагтай болсноор сурагчдын бодлого бодох чадвар нэмэгдсэн.
- Сурагч бүр бодлогын дэвтэртэй болсон.
- Өгүүлбэртэй бодлого бодох явцад сурагчдын унших, бичих,өөрийгөө илэрхийлэх чадвар ч бас хөгжиж байсан.
- Зарим ахицтай сурагчдыг өөр төрлийн бодлого гүнзгийрүүлэн бодуулж байна.

Бусдад хүргэх туршлага: Өгүүлбэртэй бодлогыг сурагчдаар уншуулж ойлгуулах алхам бол хамгийн чухал. Сурагчдаар бодлогыг бодуулах гэж яаралгүйгээр сайтар уншиж өгөх, өөрсдөөр нь уншуулах, ажиглуулах, төсөөлөн бодуулах нь чухал байдаг.

- Бодлогын өгүүлбэрийг сурагчдаар сайтар уншуулах
 - Ойлгоогүй тохиолдолд дахин уншуулах
 - Ойлгосноо эргэцүүлэн тунгаан бодох хугацаа өгөх.
 - Уншаад ойлгосны дараа багшийн асуултаар чиглүүлэн ярилцдаг./бодлогод юуны тухай гарсан ,юу юу хэдэн ширхэг байна гэх мэт/
 - Бодлогын нөхцөлийг төсөөлөн бодох
 - Бодлогын нөхцөл хэсэг, асуултыг ялгах
2. Зураг дүрслэл, загварчлах алхам
- Сурагчид бодлогыг ойлгосныхоо дараа өөрт ойлгомжтойгоор зураг, дүрслэл, товч бичиглэл хийх
 - Бодлогын нөхцөлд өгсөн зүйлийг ялган бичиж олох зүйлийн ард асуултын тэмдэг бичиж тодруулах
 - 1,2-р ангид энэхүү алхамыг хийхэд багш тусалж дагуулан хийж сургах хэрэгтэй байдаг.
 - 3,4,5-р ангийн сурагчид өөрсдөө болон бусдад ойлгомжтойгоор товч бичиглэл зураглал хийнэ.
- 3.Зураг, бичиглэлийн дагуу бодолт хийх
- Сурагчид өөрсдийн хийсэн товч бичиглэл, зураглалын дагуу бодолтоо хийнэ.Энэ үед сурагчдын дундуур явж ажиглана.
 - Хэн хэрхэн бодож байна, юун дээр алдаж байна гэдгийг анхаарч сурагч бүртэй ажиллах.
- 4.Бодолтыг шалгах тайлбарлах
- Бодолт хийх явцад үйлдэл бүр юуг олж байгааг тайлбарлуулах
 - Зорилгоо биелүүлж чадсан эсэхийг ярилцах
 - Бодолтыг сурагчдаар тайлбарлуулах нь хамгийн чухал ингэснээр сурагчдын өөрийгөө илэрхийлэх чадвар нэмэгддэг.
- 5.Бодлогоо өөр аргаар бодох
- 3-5-р ангид өөр аргаар бодсон эсэхийг асуух
 - Өөр бодолт байвал сурагчийг самбарт гарган тайлбарлуулж ярилцдаг.
 - Мөн сурагчдаар эрэлхийлүүлдэг.

Ном зүй

- С.Батболд “ Бага боловсролын математикийн онол арга зүй”
- С.Норов “ Математикийн бодлого бодох арга”
- Ц.Нямжав “Арифметикийн өгүүлбэртэй бодлого бодох аргууд” УБ.,2002 он
- Б.Балдулмаа “Бага сургуулийн математик боловсролын стандартыг хэрэгжүүлэх зөвлөмж” УБ.,2000 он
- Багшийн мэргэжил дээшлүүлэх институт “Багшийн хөгжил” сэтгүүл 2017он №6
- Цөм хөтөлбөр
- Б.Оюунцэцэг, Т.Энхмаа “Сургуулийн бага насны хүүхдийг судлах арга зүй”

Процент сэдвийг заах арга зүй

¹С.Болормаа, холбоо барих утас: 96646576, ²А.Бямбасүрэн,
¹Улаанбаатар, Лаборатори 20-р сургууль бага ангийн багш,
²Улаанбаатар, Лаборатори 20-р сургууль сургалтын менежер,

Судалгаат хичээлийг явуулсан үндэслэл:

5-р ангийн сурагчдыг тухайн ээлжит хичээл дээр эхний 40 минутад “Процентын тухай ойлголт” дараагийн 40 минутад “Процентын үндсэн бодлогууд” гэсэн сэдэвтэйгээр 80 минутад бүрэн ойлгуулах арга зүйг багш нар дундаа нэвтрүүлэх. Жил бүрийн 5-р ангид уламжлал болон заагдах

Сонгосон судлагдахуун: Математик

Хамрах хүрээ: 5-р ангийн нийт 700 гаруй сурагчид 4,5-р ангийн бага ангийн 25 багш Эерэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа: 3 жилийн давтамжтай

Судалгаат хичээлийг явуулах болсон санаа:

Анх 2010 онд 12 жилийн тогтолцоотой 5-р ангид заагдсан. Тухайн үед хэрэглэж байсан сурах бичигт “Процент” сэдэв нь олон хуудсыг хамарсан байсан учраас багш хичээлийг олон цагаар төлөвлөсөн. Мөн “Процентын үндсэн бодлого”-ууд нь тус тусдаа заагдахаар тусгагдсан байсан. Энэ дагуу 6 цагаар төлөвлөж заагдаж байсан. Тухайн үед багш нарт зөвлөсөн хэрэглэгдэхүүний санаа байгаагүй. Багш өөрийн боломжиндоо тулгуурлан хэрэглэгдэхүүн багатайгаар зааж байсан учраас суралцагч бүр жигд ойлгож чаддаггүй сурлагын хоцрогдол гарч байсан.

2015 оны 5-р анги Цөм хөтөлбөр туршиж байсан үе таарсан. Тэр үед математикийн хичээлийн арга зүйн зөвлөмж, багшийн ном, сурах бичигтэйгээ хамт гарсан. Мөн хэрэглэгдэхүүний санааг гаргаж өгсөн. Сурах бичигт тухайн сэдэв олон хуудсыг хамраагүй. Багш хэдэн цагаар төлөвлөх нь чөлөөтэй. Нэг дор харьцуулан заах боломжтойгоор тусгагдсан. Мөн хэрэглэгдэхүүнийг хүүхэд бүрийн гарт хүртээмжтэйгээр хийж өгсөн. Ингэж зааснаар 40 минутад ангийн бүх сурагчид бүрэн ойлгож гарах боломжтой нь мэдэгдсэн. Тухайн цаг дээрээ явцын болон эцсийн үнэлгээгээр сурагчдаа үнэлэх боломжийг бүрдүүлж өгсөн.

2010, 2015, 2017, 2018 онуудад жил бүрийн 5-р ангид “Процент” сэдвийг засан сайжруулж заасан.

Хичээлийн бэлтгэл судалгааг хэрхэн хийсэн талаар:

Хичээлийн бэлтгэлийг тухайн жилд 5-р ангид зааж байгаа багш нар хамтран бэлтгээд, бүх ангидаа нэг багш нь заадаг. Хичээл зааж байх үед дараа жил нь 5-р ангид заах багш нар сууж, хэрхэн засан сайжруулах саналыг өгдөг.

Хичээлийн хөтөлбөрийн засан сайжруулалтыг тухай бүрд нь хийж явсан.

Батлав: Сургалтын менежер.....\Х.Наранцэцэг/

2015 оны-р сарын

Хичээлийн сэдэв: Процент

Хамрах хүрээ: 5-р анги

Цаг: 40 мин

Хэрэгцээ:

Суралцагчийн хэрэгцээ: Юмсын зууны хэсгийг олох, барааны үнийн өсөлт бууралтын хувь, банкны хадгаламжийн хүү, зээлийн хүү, татварын хэмжээ зэрэг амьдрал ахуйд тохиолдох асуудлыг оновчтой шийдвэрлэх

Нийгмийн хэрэгцээ: Процентийн мэдлэгийг амьдрал ахуйдаа ашиглан зах зээлийн нийгэмд амьдрах иргэн төлөвшүүлэх

Ерөнхий чадвар: Процентийн тухай мэдлэгтэй болно.

1. Бутархайг процентоор илэрхийлэх чадварыг эзэмшинэ
2. Процентийг аравтын бутархайд шилжүүлэх чадварыг эзэмшинэ.

Анги зохион байгуулалт: 6 багаар

Хичээлийн хэлбэр: Шинэ мэдлэг олгох хичээл

Хэрэглэгдэхүүн:

- Диаграмм бш
- Слайд 41ш \100 хуваалтын тодорхой хэсгийг илэрхийлсэн\
- Цифр 0-ээс 9 хүртэл
- Энгийн бутархайгаар илэрхийлсэн тоо – 6 ш
- Тодорхойлолт тэмдэглэсэн бичмэл үзүүлэн
- Бутархайг илэрхийлсэн дугуй – 41 ш

Ээлжит хичээл 1

Хичээлийн явц:

Багш самбарт:

Сэдэв: Процент

Сурагчид дэвтэртээ хичээлийнхээ сэдвийг бичнэ.

Багш сурагчдаас өмнөх төсөөллийг нь асууна.

Зорилго болон эзэмшүүлэх чадвараа дэлгэцэн дээр харуулна.



Зорилго:
Процентийн тухай мэдлэгтэй болно.

Эзэмших чадвар:

1. Бутархайг процентод шилжүүлж сурах
2. Процентийг бутархайд шилжүүлж сурах

Бүгдээрээ хамтраад нэг бодлого бодъё гэсний дагуу, дараах үйл ажиллагаанд шилжинэ.

1-р үйл ажиллагаа: Хичээлийн эхлэл хэсэг

Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
<p>Багууд даалгаврын өгөгдлийг ажиглаад ярилцана.</p> <p>Ярилцсаныхаа дагуу нэг нь босож тайлбарлана.</p> <p>Бусад багууд сонсоод санал нэг байгаа эсэх, нэмэх зүйл байвал нэмэлт тайлбарыг өгнө.</p>  <p>5-ын "А" ангийн 40 сурагчдаас дугуйланд хамрагджээ.</p>	<p>Багш багуудад эхний даалгаврыг тараан өгнө.</p> <p>Дэлгэцэн дээр гаргана.</p>  <p>5-ын "А" ангийн 40 сурагчдаас дугуйланд хамрагджээ.</p> <p>Сурагчид диаграммыг тайлбарлах явцад багш самбарт дугуйлангийн нэрсийг хэдэн хүүхэд хамрагдаж байгаа тоотой нь байрлуулна.</p>

2-р үйл ажиллагаа: Хичээлийн өрнөл хэсэг

Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
<p>Сурагчид дараах хариултыг өгнө.</p> <p>Зураг - $\frac{6}{40}$</p> <p>Бүжиг - $\frac{8}{40}$</p> <p>Хөгжим - $\frac{2}{40}$</p> <p>Теннис - $\frac{4}{40}$</p> <p>Шатар - $\frac{10}{40}$</p> <p>Сурагчид самбар дахь бичилтийг ажиглан, хэд дахин ихэсгэвэл 100 хуваарьтай болж болох вэ? гэсэн эрэл хайлтыг хийнэ.</p> <p>2.5 дахин ихэсгэвэл 100 хуваарьтай болж болно гэсний дагуу сурагчид дэвтэртээ бодолтыг хийнэ.</p> <p>Нэг сурагч нэг хариуг хэлэхэд бусад сурагчид зөв эсэхийг хурууныхаа дүрмээр илэрхийлнэ.</p>	<p>Эдгээр сурагчдын дугуйланд хамрагдсан байдлыг энгийн бутархайгаар илэрхийлж болох болов уу? гэсэн асуултыг сурагчдаас асууна.</p> <p>Багш сурагчдыг хариулт өгөх явцад самбарт өмнөх бичилтийн ард бичнэ.</p> <p>Эдгээр энгийн бутархайг 100 хуваарьтай энгийн бутархайд шилжүүлнэ үү?</p> <p>Сурагчдын бодолтын хариуг мөн самбарт байрлуулна.</p> <p>Багш самбарт сурагчдын хэлсэн хариуг нэг бүрчлэн бичнэ.</p> <p>100 гэсэн хуваарь юуг илэрхийлж байна. Хүртвэрт байгаа тоо юуг илэрхийлж байна гэж асуугаад сурагчдаар тайлбарлуулан дүгнэлт гаргуулна.</p>

Зурагт –	$\frac{6 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{15}{100}$	Сурагчдын гаргасан дүгнэлтийн дагуу, дэлгэцэн дээр тодорхойлолтыг гаргаж ирнэ.
Бүжиг –	$\frac{8 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{20}{100}$	
Хөгжим –	$\frac{2 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{5}{100}$	
Теннис –	$\frac{4 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{10}{100}$	
Шагар –	$\frac{10 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{25}{100}$	

Ямар нэг тоо буюу аливаа юмсыг 100 тэнцүү хэсэг болгон хуваагаад түүний тодорхой хэсгийг илэрхийлэх тоог **процент** гэнэ.

Зууны нэг хэсгийг зууны 1 хувь буюу 1 процент гэнэ.

3-р үйл ажиллагаа: Хичээлийн төгсгөл хэсэг

Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
<p>Баг бүр өөрт оногдсон слайдынхаа өгөгдлийг уншаад процентоор илэрхийлэх</p> <p>Жишээ нь: $\frac{15}{100} = 15\%$ гэх мэтчилэн баг бүрээс хоёр хүүхэд тайлбарлана.</p> <p>Сурагчид жижиг самбар дээрээ багшийн үзүүлснийг процентоор илэрхийлж харуулна. Ийм дасгалыг 3 удаа хийж, өөрсдийн ойлголтыг бататгана.</p> <p>Сурагчид жижиг самбар дээрээ энгийн бутархайг аравтын бутархайгаар илэрхийлэн бичээд өргөж харуулна. Энгийн бутархайгаа 100 хуваарьтай болгож болно гэсэн хариултыг өгнө. Аравтын бутархай дээр ямар бодолт хийсэн тохиолдолд процент нь гарч байгааг харьцуулаад дүгнэлт гаргана. Мөн өмнөх бодолттойгоо харьцуулан процентийг аравтын бутархайгаар илэрхийлэхийг ярилцана.</p>	<p>Багш баг бүрт 100 хуваалтын тодорхой хэсгүүдийг илэрхийлсэн слайдууд тараан өгнө.</p> <p>Багш самбарт багуудын уншсанаас төлөөлөл болгон бичнэ. $\frac{24}{100} = 24\%$ Багш 100 хуваалтын тодорхой хэсгийг харуулсан слайд үзүүлнэ. Тэгвэл 100 биш хуваарьтай бутархайг процентоор хэрхэн илэрхийлэх вэ? гэж асуугаад дадлага ажил хийлгэхийн тулд бутархайг илэрхийлсэн дугуйг хүүхэд бүрт тараан өгнө. $\frac{1}{2}$ -ийг харуулаарай. Үүнийгээ аравтын бутархайгаар илэрхийлэн жижиг самбар дээрээ бичээрэй. Бичсэнээ хэдэн процент гэдгийг яаж мэдэх вэ?</p> <p>Тэгвэл процентийг аравтын бутархайгаар хэрхэн илэрхийлэх вэ? гэсэн асуултыг тавина.</p>

Энгийн бутархайн хуваарийг 100 хуваарьтай болгоно.

Энгийн бутархайгаа аравтын бутархайд шилжүүлээд, 100 дахин ихэсгэнэ.

Процентийг 100 дахин багасгаж, аравтын бутархайд шилжүүлнэ.

Дүгнэлт:

Сурагчид хэрхэн шинэ хичээлээ ойлгосныг шалгах зорилгоор, сурагчид өөрсдийгөө багшийн зааврын дагуу үнэлнэ.

Багш дэлгэцэн дээр тоо бүрийг нэг нэгээр нь гаргаад, хариуг нь сүүлд гаргана.

Сурагчид өөрсдийн бодолтын зөв бурууг тэмдэглэнэ.

4 тооны хэдийг нь зөв бодсоноор өөрсдийгөө үнэлнэ.

$$\frac{3}{5} = 0,6 = 60\%$$

$$\frac{55}{100} = 55\%$$

$$1.35 = 135\%$$

$$1.35 = 135\%$$


Хичээлийн төгсгөлд багш дэлгэцэн дээр бодлого гаргана. Энэ процентийн өгөгдөлтэй бодлогыг хэрхэн бодох вэ? гэж сурагчдаас асуугаад дараагийн хичээл дээр үзнэ гэсэн сэдлийг төрүүлээд орхино.

**43 метрийн
25% нь хэдэн
сантиметр вэ?**

Гэрийн даалгаварт:

Чадвар тус бүр дээрээ 5 бодлого зохион бодож ирээрэй.

Хичээлд ашигласан хэрэглэгдэхүүн:



Засан сайжруулсан хичээл:

Батлав: Сургалтын менежер.....\А.Бямбасүрэн/

2017 онд

Хичээлийн сэдэв: Процент

Хамрах хүрээ: 5-р ангийн “г”, “а”, “б”, “в”, “д”, “е” бүлэгт

Цаг: 40 мин

Хэрэгцээ:

Суралцагчийн хэрэгцээ: Юмсын зууны хэсгийг олох, барааны үнийн өсөлт бууралтын хувь, банкны хадгаламжийн хүү, зээлийн хүү, татварын хэмжээ зэрэг амьдрал ахуйд тохиолдох асуудлыг оновчтой шийдвэрлэх

Нийгмийн хэрэгцээ: Процентийн мэдлэгийг амьдрал ахуйдаа ашиглан зах зээлийн нийгэмд амьдрах иргэн төлөвшүүлэх

Ерөнхий чадвар: Процентийн тухай мэдлэгтэй болно.

Тусгай чадвар:

3. Бутархайг процентоор илэрхийлэх чадварыг эзэмшинэ
4. Процентийг аравтын бутархайд шилжүүлэх чадварыг эзэмшинэ.

Анги зохион байгуулалт: 6 багаар

Хичээлийн хэлбэр: Шинэ мэдлэг олгох хичээл

Хэрэглэгдэхүүн:

- Диаграмм бш
- Слайд 41ш \100 хуваалтын тодорхой хэсгийг илэрхийлсэн\
- Цифр 0-ээс 9 хүртэл
- Энгийн бутархайгаар илэрхийлсэн тоо – 6 ш
- Тодорхойлолт тэмдэглэсэн бичмэл үзүүлэн

- Бутархайг илэрхийлсэн дугуй – 43 ш

Ээлжит хичээл 1

Хичээлийн явц:

Багш самбарт:

Сэдэв: Процент

Сурагчид дэвтэртээ хичээлийнхээ сэдвийг бичнэ.



Багш сурагчдаас өмнөх төсөөллийг нь асууна. Процент гэдэг үгийг урьд нь сонсож байсан уу? Юу гэсэн утгыг илтгэдэг юм болоо?

Зорилго болон эзэмшүүлэх чадвараа дэлгэцэн дээр харуулна. Мөн самбарт давхар байрлуулна.

<p>Зорилго: Процентийн тухай мэдлэгтэй болно.</p>	<p>Эзэмших чадвар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бутархайг процентод шилжүүлж сурах 2. Процентийг бутархайд шилжүүлж сурах
---	---

Бүгдээрээ хамтраад нэг бодлого бодъё гэсний дагуу, дараах үйл ажиллагаанд шилжинэ.

1-р үйл ажиллагаа:

Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа												
<p>Багууд даалгаврын өгөгдлийг ажиглаад ярилцана. Ярилцсаныхаа дагуу нэг нь босож тайлбарлана. Бусад багууд сонсоод санал нэг байгаа эсэх, нэмэх зүйл байвал нэмэлт тайлбарыг өгнө.</p> <p>5-ын "А" ангийн 40 сурагчдаас дугуйланд хамрагджээ.</p>  <table border="1"> <caption>5-ын "А" ангийн 40 сурагчдаас дугуйланд хамрагджээ.</caption> <thead> <tr> <th>Хүрээ</th> <th>Тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>зураг</td> <td>6</td> </tr> <tr> <td>бүжиг</td> <td>8</td> </tr> <tr> <td>хөгжим</td> <td>2</td> </tr> <tr> <td>төнис</td> <td>4</td> </tr> <tr> <td>шатар</td> <td>10</td> </tr> </tbody> </table>	Хүрээ	Тоо	зураг	6	бүжиг	8	хөгжим	2	төнис	4	шатар	10	<p>Багш багуудад эхний даалгаврыг тараан өгнө. Дэлгэцэн дээр гаргана.</p> <p>5-ын "А" ангийн 40 сурагчдаас дугуйланд хамрагджээ.</p>  <p>Сурагчид диаграммыг тайлбарлах явцад багш самбарт дугуйлангийн нэрсийг хэдэн хүүхэд хамрагдаж байгаа тоотой нь байрлуулна.</p>
Хүрээ	Тоо												
зураг	6												
бүжиг	8												
хөгжим	2												
төнис	4												
шатар	10												

2-р үйл ажиллагаа:

Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
<p>Сурагчид дараах хариултыг өгнө.</p> <p>Зураг - $\frac{6}{40}$</p> <p>Бүжиг - $\frac{8}{40}$</p> <p>Хөгжим - $\frac{2}{40}$</p> <p>Төнис - $\frac{4}{40}$</p> <p>Шатар - $\frac{10}{40}$</p> <p>Сурагчид самбар дахь бичилтийг ажиглан, хэд дахин ихэсгэвэл 100 хуваарьтай болж болох вэ? гэсэн эрэл хайлтыг хийнэ.</p>	<p>Эдгээр сурагчдын дугуйланд хамрагдсан байдлыг энгийн бутархайгаар илэрхийлж болох болов уу? гэсэн асуултыг сурагчдаас асууна.</p> <p>Багш сурагчдыг хариулт өгөх явцад самбарт өмнөх бичилтийн ард бичнэ.</p> <p>Эдгээр энгийн бутархайг 100 хуваарьтай энгийн бутархайд шилжүүлнэ үү?</p> <p>Сурагчдын бодолтын хариуг мөн самбарт байрлуулна.</p>

<p>2.5 дахин ихэсгэвэл 100 хуваарьтай болж болно гэсний дагуу сурагчид дэвтэртээ бодолтыг хийнэ.</p> <p>Нэг сурагч нэг хариуг хэлэхэд бусад сурагчид зөв эсэхийг хурууныхаа дүрмээр илэрхийлнэ.</p> <p>Сурагч – $\frac{6 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{15}{100}$</p> <p>Бүжиг – $\frac{8 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{20}{100}$</p> <p>Хөгжим – $\frac{2 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{5}{100}$</p> <p>Теннис – $\frac{4 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{10}{100}$</p> <p>Шатар – $\frac{10 \times 2.5}{40 \times 2.5} = \frac{25}{100}$</p>	<p>Багш самбарт сурагчдын хэлсэн хариуг нэг бүрчлэн бичнэ.</p> <p>100 гэсэн хуваарь юуг илэрхийлж байна. Хүртвэрт байгаа тоо юуг илэрхийлж байна гэж асуугаад сурагчдаар тайлбарлуулан дүгнэлт гаргуулна.</p> <p>Сурагчдын гаргасан дүгнэлтийн дагуу, дэлгэцэн дээр тодорхойлолтыг гаргаж ирнэ.</p> <div style="background-color: #e0e0e0; padding: 10px; margin-top: 20px;"> <p>Ямар нэг тоо буюу аливаа юмсыг 100 тэнцүү хэсэг болгон хуваагаад түүний тодорхой хэсгийг илэрхийлэх тоог процент гэнэ.</p> <p>Зууны нэг хэсгийг зууны 1 хувь буюу 1 процент гэнэ.</p> </div>
--	--

3-р үйл ажиллагаа:

Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
<p>Баг бүр өөрт оногдсон слайдынхаа өгөгдлийг уншаад процентоор илэрхийлэх</p> <p>Жишээ нь: $\frac{15}{100} = 15\%$ гэх мэтчилэн баг бүрээс хоёр хүүхэд тайлбарлана.</p> <p>Сурагчид жижиг самбар дээрээ багшийн үзүүлснийг процентоор илэрхийлж харуулна. Ийм дасгалыг 3 удаа хийж, өөрсдийн ойлголтыг бататгана.</p> <p>Сурагчид жижиг самбар дээрээ энгийн бутархайг аравтын бутархайгаар илэрхийлэн бичээд өргөж харуулна. Энгийн бутархайгаа 100 хуваарьтай болгож болно гэсэн хариултыг өгнө. Аравтын бутархай дээр ямар бодолт хийсэн тохиолдолд процент нь гарч байгааг харьцуулаад дүгнэлт гаргана. Мөн өмнөх бодолттойгоо харьцуулан процентийг аравтын бутархайгаар илэрхийлэхийг ярилцана.</p>	<p>Багш баг бүрт 100 хуваалтын тодорхой хэсгүүдийг илэрхийлсэн слайдууд тараан өгнө.</p> <p>Багш самбарт багуудын уншсанаас төлөөлөл болгон бичнэ. $\frac{24}{100} = 24\%$</p> <p>Багш 100 хуваалтын тодорхой хэсгийг харуулсан слайд үзүүлнэ. Тэгвэл 100 биш хуваарьтай бутархайг процентоор хэрхэн илэрхийлэх вэ? гэж асуугаад дадлага ажил хийлгэхийн тулд бутархайг илэрхийлсэн дугуйг хүүхэд бүрт тараан өгнө. $\frac{1}{2}$ -ийг харуулаарай. Үүнийгээ аравтын бутархайгаар илэрхийлэн жижиг самбар дээрээ бичээрэй. Бичсэнээ хэдэн процент гэдгийг яаж мэдэх вэ?</p> <p>Тэгвэл процентийг аравтын бутархайгаар хэрхэн илэрхийлэх вэ? гэсэн асуултыг тавина.</p>

Энгийн бутархайн хуваарийг 100 хуваарьтай болгоно.

Энгийн бутархайгаа аравтын бутархайд шилжүүлээд, 100 дахин ихэсгэнэ.

Процентийг 100 дахин багасгаж, аравтын бутархайд шилжүүлнэ.

Дүгнэлт:

Сурагчид хэрхэн шинэ хичээлээ ойлгосныг шалгах зорилгоор, сурагчид өөрсдийгөө багшийн зааврын дагуу үнэлнэ.

Багш дэлгэцэн дээр тоо бүрийг нэг нэгээр нь гаргаад, хариуг нь сүүлд гаргана.

Сурагчид өөрсдийн бодолтын зөв бурууг тэмдэглэнэ.

4 тооны хэдийг нь зөв бодсоноор өөрсдийгөө үнэлнэ. Өөрсдийн үнэлгээг хувиар илэрхийлнэ. Анги нийтийн ойлголтыг мөн хувиар илэрхийлнэ.

$$\frac{3}{5} = 0,6 = 60\%$$

$$\frac{55}{100} = 55\%$$

$$1.35 = 135\%$$

$$1.35 = 135\%$$

Хичээлийн төгсгөлд багш дэлгэцэн дээр бодлого гаргана. Энэ процентийн өгөгдөлтэй бодлогыг хэрхэн бодох вэ? гэж сурагчдаас асуугаад дараагийн хичээл дээр үзнэ гэсэн сэдлийг төрүүлээд орхино.

43 метрийн 25% нь хэдэн сантиметр вэ?

Гэрийн даалгаварт:

Чадвар тус бүр дээрээ 5 бодлого зохион бодож ирээрэй.

Хэрэгжүүлсэн байдал:

1. 2010 оны 11 жилийн сургалттай 5-р ангийн “б” бүлэгт “Процент” сэдвээр заасан
2. 2015 онд 5-р ангийн “б” бүлэгт “Процент” сэдвээр үзүүлэх хичээл заасан
3. 2017 онд 5-р ангийн “а, б, в, г, д, е” бүлэгт Процент сэдвээр судалгаат хичээлийг 12 цаг заасан

Хичээлийг хэрхэн заасан тайлан: 2010, 2015, 2017 оны харьцуулалт

11 жилийн сургалттай 5-р ангид заасан байдал	12 жилийн сургалттай Цөм хөтөлбөрийн туршилтын 5-р анги	12 жилийн сургалттай Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн үеийн 5-р анги
-Чадвар дээр тулгуурлаагүй. - Шууд л процентын 3 төрлийн бодлогыг тус тусад нь орсон - Хэрэглэгдэхүүнийг хүүхэд бүрийн гарт өгөөгүй. - Багш төвтэй сургалт - багш дүгнэлтээ гаргасан.	Чадвар дээр суурилсан Хичээлээ маш сайн дүгнэсэн. Хэрэглэгдэхүүн дээр суурилсан. 1 ангид заасан. Хэрэглэгдэхүүнийг хүүхэд бүрийн гарт өгсөн.	Цахим хичээлтэй хавсарсан. Хэрэглэгдэхүүн дээр суурилсан. 6 ангид 12 цагийн хичээлийг заасан. Хүүхдээр дүгнэлтээ гаргасан. Хичээлээ хэр зэрэг ойлгосныг хувьчилж бодуулсан.

	<p>Дунд ангийн математикийн багшаас зөвлөгөө авч засан сайжруулалт хийсэн.</p> <p>Хүүхдээр дүгнэлтийг гаргуулсан.</p> <p>DVD дээр бичсэн.</p>	<p>Бүх анги 90% -иас дээш ойлгосон байсан.</p> <p>4, 5-р ангийн болон хөдөө орон нутгаас ирсэн багш нар сууж зөвлөгөө өгсөн.</p>
--	---	--

Судалгааны үр дүн:

Хичээлийг хэрэглэгдэхүүнтэй зааснаар ангийн сурагчид мэдлэгийг гүн бат ойлгож авдаг.

- Сурагчдын хичээлийн идэвх оролцоо нэмэгдсэн.
- Эцэг эхчүүдийн идэвх оролцоо нэмэгдэж ирсэн. Яагаад гэвэл “Эцэг эхийн нэг өдөр”-ийг зохион байгуулж, хэрэглэгдэхүүнтэй хичээл заасан. Ингэснээр эцэг эхчүүдийн сэтгэл зүйд маш том өөрчлөлт гарч, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд багшид материаллаг туслалцаа үзүүлэх чин сэтгэлтэй болж ирсэн.
 - Улсын хэмжээний бага ангийн багш нарт хэрэглэгдэхүүнээ хэрхэн хийх, яаж ашиглах талаар зааварчилгаа өгсөн.
- Багшийн олон цагийн хөдөлмөрийг хөнгөвчилсөн, агуулгын залгамж холбоотой болж ирсэн.
- Багийн эв найрамдал, хамтран ажиллах, ажлын үр дүн, туршлагаа түгээн дэлгэрүүлэх, заах арга зүй ур чадвар нь нэмэгдэх
- Сургалтын чанар үр дүн дээшлэх
- Тухайн хичээлийг заахад хэрэглэгдэх хэрэглэгдэхүүн бэлтгэх чин хүсэл эрмэлзлийг бий болгож, хичээл бүрийг хэрэглэгдэхүүн дээр суурилан заадаг болсон.

Ном зүй:

Ичинхорлоо Ш. Сургалтын онол. УБ. 2012.

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр

Бага ангийн багшийн гарын авлага \МУБИС

Бага боловсролын математикийн онол, дидактик

Чанартай боловсрол, хөгжлийн баталгаа \илтгэлүүдийн эмхэтгэл

БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР

“Гурвалжны талбай олцгооё” ээлжит хичээлийн арга зүйн туршлага

¹Б.Нямдаваа, ²Ц.Чимэдрэгзэн, ¹С.Сарангэрэл, ¹Р.Энхцолмон
1-Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн
математикийн баг, 2-БСУГ-ын мэргэжилтэн
У:99878117-d_altone@yahoo.com,99469004
cheemeeganzoo27@gmail.com

Хураангуй

Зорилго: Энэхүү судалгаат хичээлээр аливаа гурвалжны талбайг тооцоолох, мэдээллийг загварчлан боловсруулах аргаар илрүүлэн, хүүхэд нэг бүрийг харьцуулан судалж, дүгнэлт гаргах чадварын хөгжлийг дэмжсэн үр дүнг танилцуулж байна.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Суурь боловсролын 7-р ангийн “Геометр, Хэмжигдэхүүн” бүлгийн “Талбай Эзлэхүүн” нэгж хичээлийн “Гурвалжны талбай олох” ээлжит хичээлийн бэлтгэл судалгааны хүрээнд гурвалжны талбайг тэгш өнцөгт, хурц өнцөгт, мохоо өнцөгт гурвалжин байх тохиолдолд тооцоолох, тооцоолсон үр дүнгээс ерөнхий томьёо гаргаж, дүгнэлт гаргуулах аргаар хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Сурагчид гурвалжны талбай олоходоо өгөгдсөн гурвалжнуудын өндрийг ашиглах, талбайг нь хялбархан олох боломжтой дүрсүүдэд хуваах, гүйцээлт хийх, гурвалжны талуудыг тэмдэглэх, тооцооллын үр дүнгээ нэгтгэх дүгнэлт хийх зэргээр математик хэл сэтгэлгээгээ хөгжүүлэн, аливаа ухагдахууны зүй тогтол учир шалтгааныг илрүүлэн судалсан. Энэ нь суралцагчдын сонирхон судлах эрэлтийг нэмэгдүүлэн, суралцахуйн бүтээлч үйлийг хэрэгжүүлсэн нь суралцах, харьцуулан дүгнэлт гаргах, чадварын хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг тодорхой хэмжээгээр авчирсан.

Практик ач холбогдол: Дээрх арга зүйн санааг ерөнхий боловсролын сургуулийн математикийн болон байгалийн ухааны боловсролын багш нар хичээлдээ туршин хэрэгжүүлэх боломжтой. Хичээлийн судалгаагаар дамжуулан суралцагчдад гурвалжны талбайг тооцоолох болон томьёоны гаргалгаа хийж дүгнэлт хийх аргаар төлөвлөн хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжлийг дэмжсэн хичээлийн арга зүйг бүтээх боломжтойг харуулсан.

Шинэлэг тал /ашиг тус/: Гурвалжны талбай олох томьёог ойлгуулахад математик тооцооллын болон мэдээллийг загварчлах аргаар бодитоор мэдрүүлж, хооронд нь харьцуулж, сонирхон судлах хэрэгцээ, оролцоон дээр суурилан хүүхэд бүрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Түлхүүр үг: Гурвалжин, өндөр зурах, гурвалжны орой, тэгш өнцөгт гурвалжин, хурц өнцөгт гурвалжин, мохоо өнцөгт гурвалжин, гүйцээлт хийх, талбай, томьёо, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх, дүгнэлт гаргах чадвар

Товч агуулга:

Математикийн суурь боловсролоор суралцагчид өөрсдийн бүтээлч үйлээр дамжуулан ахуй амьдрал дээрх мэдлэгийг Шинжлэх ухааны туршилтын, мэдээлэл боловсруулах, тооцоолох, загварчлах аргаар танин мэдэж, аливаа зүйлсийн талаар мэдээлэлтэй болдог. Иймээс хичээлийн үе шат бүрд суралцагчийн оролцоог дэмжсэн тооцоолох, зурах, байгуулах, загварчлах аргаар гурвалжны талбай олох томьёог ойлгуулахаар хичээлийг төлөвлөн хэрэгжүүлэхээр хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйн бэлтгэл судалгааг хийсэн. Тэгш өнцөгт, хурц өнцөгт, мохоо өнцөгт гурвалжин тус бүр дэс дарааллан талбайг тооцоолон олох дасгал ажлыг гүйцэтгүүлж, гурвалжны талбайг олох томьёог тус бүр дээр нь алгебрийн илэрхийлэл ашиглан бичих даалгавар ажиллаж ерөнхий дүгнэлтийг сурагчдаар гаргуулсан. Математикийн боловсролын аливаа хөтөлбөрийг суралцагчдын оролцоо, идэвхи сонирхолыг дэмжсэн, суралцахуйн бүтээлч үйлийг дэмжсэн шинжлэх ухааны тооцоолох, загварчлах аргаар зохион байгуулж, багшийн нээлттэй асуултаар хүүхдээ сонсож, суралцагчийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх алхмыг нарийн төлөвлөснөөр хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж чадах юм гэж дүгнэсэн. Сурагчдад бэлэн томьёо тогтоолгож бодолт хийлгэхээс татгалзаж гурвалжны талбайг тооцоолох

бүтээлч үйлийн аргаар дамжуулан дүгнэлт хийлгэсэн нь аливаа ухагдахуунд бодитойгоор хандах хандлагыг бий болгож байгаа үр дүн харагдсан.

Удиртгал

Дэлхийн даяаршлын үед улс орон бүр тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна. Манай улсын хувьд боловсролын шинэчлэлийн бодлогыг үр өгөөжтэй зорилтын нэг болсон хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн арга зүйгээр цөм хөтөлбөрийг шат шатны боловсролын түвшиндээ хэрэгжүүлж байна. Чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд багш нарын сургалтын арга барил, мэргэжил, мэргэшлийн чадвар, хэрэгжүүлэх хичээлийн төлөвлөлт, хамтын ажиллагаа багагүй үүрэгтэй байдаг. Судалгаат хичээлийг менежмент сайтайгаар төлөвлөн хэрэгжүүлэх нь хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг ажлын байран дээр нь хөгжүүлэх оновчтой арга юм. Энэ удаагийн хэрэгжүүлсэн судалгаат хичээлийн хувьд сэдэлжүүлэх бодлого тавьж, сэргээн санах үйлийн үед тараах материал дээр ажиллуулан, дүрсийн талбайг тооцоолон олуулж хэрхэн олсон талаар суралцагчдын дунд нээлттэй хэлэлцүүлэг хийж, мэдлэг бүтээх хэсэгт гурвалжны талбайг тооцоолох, талууд болон хэмжээсүүдийг алгебрийн илэрхийлэлд шилжүүлэн томъёог гарган дүгнэлт хийсэн. Ингэснээр суралцагчийн сонирхон судлах, харьцуулан оюун дүгнэлт гаргах суралцахуйн бүтээлч үйлийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг авчирсан. 7-р ангийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан “Геометр, Хэмжигдэхүүн” бүлгийн “Талбай Эзлэхүүн” нэгж хичээлийн “Гурвалжны талбай олох” ээлжит хичээлийг тооцоолох болон загварчлах, дүгнэлт хийх аргаар төлөвлөн хэрэгжүүлсэн судалгаат хичээлийн үр дүнг танилцууллаа.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Сэдвийг сонгосон чиг хандлагын үндэслэл:

Улс орон бүрийн хөгжлийн гол түүчээ нь хүний хөгжил. Тэгвэл манай орны боловсролын хувьд хүүхэд нэг бүрийг болон багшлахуйн арга зүйг хөгжүүлэх гэсэн хүн төвтэй бодлогыг боловсролын чанарын шинэчлэлийн зорилт болгон хэрэгжүүлсэн. Орчин үед судлаачид хүүхэд аливаа зүйлийг бие дааж өөрийн бүтээлч үйлээр дамжуулан хийвэл мэдлэгийг өөртөө цогцлоон бүтээж чадна хэмээн үзэж байгаа. Иймээс багш нар цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн багаар хамтран, судалгаатай хаддаг болж эхэлсэн. Үүнд: 1. Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар “Гурвалжны талбай олох” –г судлах хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг хамтран хөгжүүлэх

2. Хөтөлбөрийг оновчтой арга зүйгээр төлөвлөн хэрэгжүүлснээр гол концепцийг ойлгуулах боломжтой төдийгүй хүүхэд нэг бүрийг харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлдэг эсэхийг судлах арга зүйн туршлагаа хуваалцах, бусдаас зөвлөгөө авч хөгжүүлэхээс үүдэн энэхүү илтгэлийг толилуулж байна.

Сэдэв сонгосон практик үндэслэл: Математикийн боловсролын багш нар геометрийн агуулгыг заахдаа ихэвчлэн хэрэглэгддэг томъёо, тодорхойлолтыг эхэлж өгөөд дараа нь дасгал даалгавараар бататгаж явдаг, энэ нь суралцагчдын бүтээлч үйлийг орхигдуулсан бэлэн хийсвэр мэдээллийг сурагчдад өгч, аливаа зүйлсийн учир шалтгааныг орхигдуулж байгааг мэргэжлийн багийн хэлэлцүүлгээр илрүүлж, хэрхэн хэрэгжүүлэх арга зүйг боловсруулж, туршин хэрэгжүүлэхээр уг сэдвийг сонгосон юм. **Хичээлийн санаа:** “Гурвалжны талбай олох” гэсэн ээлжит хичээлийн эхлэл буюу сэдэлжүүлэх хэсэгт сурагчдад слайдаар байшингийн зураг харуулах. Энэ байшингийн үүдэн хэсгийг шиллэх болжээ. (Үүдэн хэсэг нь гурвалжин хэлбэртэй) Хэдэн метр квадрат шил орох вэ? Та нар хэрхэн олно гэж бодож байна вэ? (Байшингийн өргөн 12м өндөр нь 5м болно.) гэсэн нээлттэй асуултуудыг тавьж ярилцлага өрнүүлэн сурагчдын хариултыг сонсож, хэрхэн олох, яаж тооцоолох талаарх хэлэлцүүлгийг өрнүүлж асуудалаа шийдэх гарцыг хайхаар болсон. Ингээд хичээлийн шинжлэн судлах буюу тайлбарлах хэсэгт сурагчдад тэгш өнцөгт, мохоо өнцөгт, хурц өнцөгт гурвалжин зурсан тараах материалыг дээр дэс дарааллуулан өгч ажиллуулж талбайг нь тооцоолуулан олуулж, дор бүрд нь хэрхэн олсон талаар хэлэлцүүлж, гурвалжны талууд болон өндрүүдийг үсгээр тэмдэглэж талбайг олох даалгавар ажиллуулж дүгнэлт гаргуулсан. Эндээс гурвалжны талбайг олох томъёог гаргаж чадсан нь суралцагчдын идэвхтэй,

бүтээлч суралцахуйн үйлийн дэмжлэгтэйгээр хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх сонирхолтой арга болж чадсан.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн математикийн боловсролын 6 багш, мэдээлэл зүйн багш Р.Энхцолмон, сургалтын менежер Д.Мөнхдэлгэр/МУ-ын зөвлөх багш/, химийн боловсролын багш Ц.Чимэдэрэгзэн /МУ-ын зөвлөх багш/ нартай хичээлийн бэлтгэл судалгааг хамтран хийж, хөтөлбөрийг 3 удаа туршин хэрэгжүүлж, ажиглалт, хэлэлцүүлгээр илрүүлсэн саналдаа үндэслэн хөтөлбөрийг сайжруулж ажилласан. Хэрэглэгдэхүүний судалгааны хүрээнд орон тортой цаасан дээр гурвалжнуудаа зурж бэлтгэсэн байх, слайд бэлтгэж сурагчдын гүйцэтгэсэн даалгавар болон дүгнэлтэнд хариу нотолгоог хийх, долоодой тоглоомын дүрсүүд ашиглан үнэлгээ хийх, агуулгын судалгааны хүрээнд аливаа гурвалжны талбай олох нэгдсэн нэг арга байгааг ойлгуулахад чиглэгдэж байна.

Судалгаат хичээл: 2018 оны 2-р сарын 01-03-нд “Гурвалжны талбай олох” судалгаат хичээлийн бэлтгэл судалгааг хийж ЧЭЛ сургуулийн математикийн багш нар 76 ангийн 32 суралцагчдын дунд туршин хэрэгжүүлж, сургалтын менежер болон математикийн мэргэжилтнээс зөвлөгөө авч хамтран сайжруулсан. Энэ үед сурагчдад бичгийн цаасан дээр гурвалжнуудаа зурсан нь өндөр буулгах, гүйцээлт хийж зурахад хүндрэлтэй байсныг орон тор ашиглан сайжруулалт хийсэн. 2018 оны 2 сарын 06 –нд дээрх бүрэлдэхүүнтэйгээр ЧЭЛ сургуулийн 7в ангийн 27 сурагчид сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлж, хэлэлцүүлгээс гурвалжныг тэгш өнцөгт, хурц өнцөгт, мохоо өнцөгт байх бүх тохиолдолд авч үзэн ерөнхий дүгнэлтийг гаргуулах саналыг авч хөтөлбөрөө 2 дахь удаагаа сайжруулсан. Сайжруулсан хөтөлбөрийг “Сайн хичээл” сургуулийн заах арга зүйн уралдаанд 2018 оны 2-р сарын 09 нд 7а ангийн 32 суралцагчдын дунд хэрэгжүүлэн 1-р байрт шалгарсан. Хичээлийн судалгаандаа “Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх” нь суралцагчдын бүтээлч сэтгэлгээ, тооцоолон бодох, харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлж, ээлжит хичээлийн үе шат бүрд тодорхой ахисан түвшин үйлийг төлөвлөн хэрэгжүүлэх оновчтой шийдэл болж чадсан.

Судалгааны хамрах хүрээ, хугацаа, давтамж

Судалгаанд хамрагдсан сургууль, анги, бүлэг, сурагчийн тоо/	Хичээлийн жил	Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн багш
ЧЭЛ сургууль-7б /32/	2017-2018	Б.Нямдаваа
ЧЭЛ сургууль-7в /27/	2017-2018	Б.Нямдаваа
ЧЭЛ сургууль-7а /32/	2017-2018	Б.Нямдаваа

Судалгааны үр дүн:

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөнд хийсэн зарим сайжруулалтыг дараах алхмаар хийсэн.

1. Тэгш өнцөгт, хурц өнцөгт, мохоо өнцөгт гурвалжин тус бүрийн талбайг тооцоолохдоо талбайг нь хялбархан олох боломжтой өөрсдийн мэддэг дүрсэд шилжүүлэн зурах, гурвалжны өндөр ашиглан нээлттэй асуулгаар хэлэлцүүлэн гарган авсан талбайн томъёог олсон үр дүнг эрдэмтдийн гаргасан үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн
2. Гол концепцийг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн
3. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илрүүлсэн суралцагчдын гаргасан алдаа, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн
 1. *Тэгш өнцөгт гурвалжин, хурц өнцөгт гурвалжин, мохоо өнцөгт гурвалжин тус бүрийн талбайг тооцоолохдоо талбайг нь хялбархан олох боломжтой өөрсдийн мэддэг дүрсэд шилжүүлэн зурах, гурвалжны өндөр ашиглан нээлттэй асуулгаар хэлэлцүүлэн гарган авсан талбайн томъёог олсон үр дүнг эрдэмтдийн гаргасан үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн*

Геометрийн ухагдахууны нэг чухал хэсэг нь теорем (томъёо) –г таниулах түүнийг батлах шаардлага гардаг. Өгөгдсөн теоремыг батлах, нотлон харуулах үүнийг суралцагчдаар бүтээлгэх нь их хийсвэр байдаг. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр баталгааны анхны ойлголтыг хөгжүүлэх боломжтой.

Хичээлийн үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг:		

Таамаглал дэвшүүлэх, сэргээн сэдэлжүүлэх санах,	-Сурагчдыг 5-6 хүүхэдтэй 6 багаар ажиллуулсан. -Суралцагчдад урд хэсэг нь гурвалжин хэлбэртэй байх байшингийн зураг харуулсан, дэвтэртээ урд хэсгийг нь загварчлан зурж өндөр татах даалгавар өгсөн. - Сэдэлжүүлэх бодлого Энэ байшингийн үүдэн хэсгийг шиллэх болжээ. Хэдэн метр квадрат шил орох вэ? Байшингийн өргөн 12м өндөр нь 5м болно. Өнөөдөр энэхүү асуудлыг шийдвэрлэнэ гээд дараагийн алхамд шилжсэн.	-Сурагч бүрийн дүгнэлтийг нэгтгэсэн. -Самбараас харж зурахад цагийн алдагдал гарсан тул байшингийн зургийг жижиг хэвлэж тараан өгч, дэвтэрт нь наалгаж өндрийг нь зуруулсан. - Та нар хэрхэн олно гэж бодож байна вэ? нээлттэй асуултаар хөтлөн хэлэлцүүлэг өрнүүлсэн. -Өндөр татсан зураг харуулж сурачдын санал сонссон.
Хичээлийн өрнөл хэсэг:		
Мэдлэг бүтээх, төлөвлөх, хэрэгжүүлэх	-Цаасан дээр зурсан тэгш өнцөгт, хурц өнцөгт, мохоо өнцөгт гурвалжнуудаас багуудаар сугалуулан уг гурвалжны талбайг тооцоолон олох ямар арга байгааг нь төлөвлөгөө гаргуулан олох үйл ажиллагааг хийлгэсэн. 6 баг хос хосоороо адилхан гурвалжин дээр ажиллаж тооцоо хийсэн. -Өгөгдсөн гурвалжны талуудыг үсгээр тэмдэглэн талбай олох томъёо гаргуулсан. Ижил гурвалжин авсан багуудаа хооронд нь яриулсан.	-Цаасыг орон тортой болгож өгсөн. -Бүх багуудад ижил төрлийн даалгавар өгч нэгдсэн дүгнэлтийг хийлгэсэн. -Эхлээд тэгш өнцөгт гурвалжны талбай олох, дараа нь хурц өнцөгт гурвалжны талбай олох, эцэст нь мохоо өнцөгт гурвалжны талбай олох тооцоолол хийлгэсэн. -Хэрхэн олсноо баг дотор нь яриулан багийн дүгнэлтийг гаргах
Хичээлийн төгсгөл хэсэг:		
Үр дүнг нэгтгэх, боловсруулах, тайлбарлах	-Гурвалжны талбай олох томъёо гаргаж үр дүнгээ анги хамт олондоо танилцуулах -Ярих илтгэх чадвар сайтай цөөн тооны суралцагч багийн үйл ажиллагаа үрдүнгээ нэгтгэн тайлбарладаг байсан.	-Гурвалжны талбай нь суурийн уртыг өндрөөр үржүүлсний хагастай тэнцүү гэсэн дүгнэлтэнд хүрсэн -Багийн гишүүдийг дугаарлан асуултын хариуг авахдаа болон үр дүнгээ танилцуулахад санамсаргүйгээр сонгогдсон сурагчаар тайлбарлуулдаг болсноор бүх сурагчийн оролцоог жигд хангасан төдийгүй илтгэх, ярих чадварт ахиц гарсан.

Ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнгээс:

- Эхлэл хэсгийн сэргээн сануулах үйлээс үүдэлтэй гарсан цагийн алдагдлыг багасгаж, нягтаршуулах зорилгоор хүүхэд бүрт зургийг хэвлэн өгч ажиллуулж, судлах зүйлийг гаргасан.
- Баг бүрт ижил төрлийн даалгавар ажиллуулж, түүн дээр өндөр татуулах, нэмэлт байгуулалт хийлгэхийн зэрэгцээ, өмнөх мэдлэг чадвараа ашиглан загварчлуулан, загвараас нэгдсэн хэлэлцүүлэг хийн дүгнэлт гаргах
- Суралцагч бүрийн оролцоог дэмжин ажиллах, хүүхэд бүрийг багт үүрэгтэй оролцуулах
- Гурвалжны талбай олох томъёоны гаргалгааг хийсэн үр дүнг эрдэмтдийн гаргасан томъёотой харьцуулан харуулах /Слайдаар харуулах/ сурагчдын хэлэлцүүлгээс дүгнэлтийг гаргах гэсэн сайжруулах саналуудаа дараагийн төлөвлөлтөндөө тусгасан.

2. Гол концепцийг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

2018 оны 2-р сарын 09 нд 7а ангийн 32 суралцагчдын дунд хэрэгжүүлсэн.Эндээс хөтөлбөрийг хэлэлцүүлэн сайжруулсан тул математикийн боловсролын багш нар сургалтандаа ашиглан хэрэгжүүлж, үр дүнг үндэслэн хөгжүүлэх бүрэн боломжтой.

Багшийн асуулт үндсэн үйл ажиллагаа	Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн явц, үр дүн	Тухайн хэсгийн дидактик шийдэл,сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг		
<p>Сэдэлжүүлэх бодлого Энэ байшингийн үүдэн хэсгийг шиллэх болжээ. Үүдэн хэсэг нь ямар дүрсээс бүтсэн байна вэ? Хэдэн метр квадрат шил орох вэ? Та нар хэрхэн олно гэж бодож байна вэ? (Байшингийн өргөн 12м өндөр нь 5м болно.) Хичээлийн өрнөл хэсэг:</p>	<p>-Үүдэн хэсэг нь гурвалжин дүрсээс бүтсэн ба гурвалжны талбай олж хэдий хэмжээний шил орох боломжтойг гаргаж болохыг тодорхойлуулсан.</p> <p>-Ярилцлага өрнүүлэн жижиг дүгнэлтүүдийг хэлэлцсэн</p>	<p>-Гурвалжны талбайг олохдоо өөрсдийн мэддэг дүрсэд шилжүүлэх нэмэлт байгуулалт хийх зэргээр хөгжүүлэх боломжтой.</p> <p>- Орон торон дээр ажиллаж байгаа тул нэгж квадратаар талбайг тооцоолох боломжтой.</p>
<p>-Тэгш өнцөгт гурвалжны талбайг тооцоолоорой та нарын мэддэг ямар дүрсээр гүйцээж болох вэ? -Тэгш өнцөгт гурвалжны өндрүүдийг нэрлээрэй - Хурц өнцөгт гурвалжны талбайг тооцоолон олох, талуудыг нь үсэгээр тэмдэглэн талбайг олох томьёо гаргах -Мохоо өнцөгт гурвалжны талбайг тооцоолон олох, мөн талуудыг нь үсэгээр илэрхийлэн бичиж талбай олох томьёог хэлэлцэн гаргах</p>	<p>-Гурвалжныг ихэнх сурагчид тэгш өнцөгт болгон гүйцээж зурж байсан. Талбайг нь тооцон олж талуудыг нь үсэгээр тэмдэглэн томьёо зохиосон.</p> <p>-Хурц өнцөгт болон мохоо өнцөгт гурвалжнуудынхаа талбайг орон тороо ашиглан тооцоолон олохоос гадна, тэгш өнцөгт гурвалжныхаа талбайг олох аргаар ижил тооцоолох боломжтой байгааг илэрүүлсэн.</p> <p>-Гурвалжинд өндөр татаж 2 тэгш өнцөгт гурвалжинг үүсгэж талбайг тооцоолсон</p> <p>-Зарим сурагчид тэгш өнцөгт болгон гүйцээж тооцоолол хийж байсан.</p>	<p>-Гурвалжны талбай олохдоо аль нэг оройгоос нь түүний эсрэг талд өндөр буулгах санааг гаргуулах</p> <p>-Хурц өнцөгт дурын гурвалжны аль ч оройгоос татсан өндөр нь гурвалжинг 2 тэгш өнцөгт гурвалжинд хувааж байгааг таниулах нь чухал</p> <p>-Мохоо өнцөгт гурвалжинд ч аль нэг оройгоос нь өндөр татаж тэгш өнцөгт гурвалжин үүсгэж талбайг тооцоолох боломжтойг таниулах</p> <p>-Гурвалжны талбай олох томьёог тал өндрөөр нь илэрхийлүүлэх</p>
Хичээлийн төгсгөл хэсэг:		
<p>Үр дүнг нэгтгэх, тайлбарлах - Өнөөдрийн хичээл дээр бид юу хийж гүйцэтгэсэн бэ? - Та өнөөдрийн хичээлээс юуг олж мэдсэн бэ?</p>	<p>-Сурагчдын санал дээр үндэслэн гурвалжны талбай нь суурийн уртыг өндрөөр үржүүлсний хагастай тэнцүү байна гэсэн дүгнэлт гаргуулах</p> <p>-Суралцагчид өөрсдийн бүтээлч үйлийн үр дүнг нэгтгэн тайлбарлаж өгөгдсөн асуудлаа шийдвэрлэх</p>	<p>-Ямар ч гурвалжин байсан гурвалжны талбай нь түүний суурийн уртыг, энэ суурьт буулгасан өндрөөр үржүүлсний хагастай тэнцүү байна гэсэн дүгнэлт гаргах</p>

3. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илэрүүлсэн суралцагчдын гаргасан алдаа, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн

Хэрэгжүүлсэн хөтөлбөр	Суралцагчдын гаргасан алдаа	Хөтөлбөрт алдаанаас сэргийлэх төлөвлөлтийг тусгасан байдал	Суралцагчдад илэрч байгаа эерэг хандлага, өөрчлөлт
Хөтөлбөр 1	Суралцагчид орон торон дээр дүрсийн талбай тооцоолоход алдаа гаргаж байсан 7в	Гурвалжнуудын талбай олохдоо нэг бүтэн нүдийг нэг нэгж квадратаар тооцох заавар өгсөн.	Бүх гурвалжны талбайг зөв тооцоолон олж байсан.
	Гурвалжнуудын өндөр татахдаа зарим суралцагч хэмжилтийн алдаа гаргаж байлаа 7б	Гурвалжны талбай олох томьёог гаргуулах зорилготой учраас гурвалжинаа зурахдаа анхаарсан, мөн тэгш	Суралцагч бүрийг эхний бодлого дээр гурвалжны өндөр татуулсан. дараагийн үйл ажиллагааны чиглүүлгийг оновчтой болгосноор сурагчдын хийж

		өнцөгт хэлбэрийн шугам бэлтгэсэн.	бүтээх, зурах, тэмдэглэх хүсэл эрмэлзлийг бий болгосон.
Хөтөлбөр 2	Зөвхөн орон торон дээр талбайг тооцох боломжтой гэсэн ойлголттой үлдэх сурагчид байсан. 7а	-Талуудыг нь үсэгээр илэрхийлэн бичээд талбайг тооцоолох даалгавар өгч тооцоолол хийлгэн дүгнэлт гаргуулсан.	Бэлэн томьёо ашиглан асуудлаа шийдвэрлэлгүйгээр талбай олох томьёог өөрсдөө гаргаж дүгнэлт хийж асуудлаа шийдвэрлэж байгаа нь суралцагчдад аливаад бүтээлчээр хандах хандлагыг бий болгосон.

Практик шийдэл:

Геометрийн хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ сурагчдыг багт хуваарилан тэгш өнцөгт, хурц өнцөгт, мохоо өнцөгт гурвалжны талбай тус бүрийн тооцоолон олж, тохирсон талуудыг үсэгт илэрхийлэл ашиглан тэмдэглэж, үзүүлэн загвар хийж дараа нь тооцоолол хийлгэж дүгнэлт гаргуулсан. Энэ нь сурагчдын төсөөлөн бодох чадвар болон хамтран ажиллах чадварт ахиц гарсан эерэг үр дүнг авчирсан. Сурагчид бодлого бодохоос өмнө төсөөлөн зурах, хэрэгтэй тооцоог хийж дүгнэлтэнд хүрэх боломжтойг ойлгодог болсон.

Дүгнэлт:

Дээрх судалгаат хичээлийг хэрэгжүүлсэн үр дүнгээс багш нар гол ухагдахууныг орхигдуулахгүйгээр танин барих нь маш чухал гэдгийг ойлгосон. Суралцагчийн шинжлэн судлах чадвар, танин мэдэхүйн чадамжийн дэмжлэгтэйгээр аливаа ухагдахууны талаарх ойлголтыг оролцоон дээр суурилсан мэдээллийг боловсруулах аргаар хэрэгжүүлсэн. Хүүхдийн танин мэдэх, өөртөө мэдлэгийг бүтээх бүтээлч үйлийн оролцоотойгоор ямар ч шинэ ойлголт, ухагдахууныг ойлгуулж болдгийг батлах боломжтойг харуулсан.

Суралцагчийн хийх үйлийг тодорхой болгож, зөв чиглүүлснээр хүүхдийн хийж бүтээх, зурах, тэмдэглэх хүсэл эрмэлзлийг бий болгож, бэлэн томьёо ашиглан асуудлаа шийдвэрлэлгүйгээр талбай олох томьёог өөрсдөө гаргаж дүгнэлт хийж асуудлаа шийдвэрлэж байгаа нь суралцагчдад аливаад бүтээлчээр хандах хандлагыг бий болгосон.

Ном зүй:

1. Н.Батбилэг, Д.Түвшинжаргал, Ж.Батболд, Д.Даваасүрэн, Т.Батчимэг, Э.Чойсүрэн, Н.Гэндэнсүрэн, Б.Равданжамц, Н.Цогзолмаа, Б.Энхболд, Б.Эрдэнэсүвд, Б.Ариунтунгалаг Математик-VII, УБ., 2015. 2016.

2. Математик-VII Багшийн ном




3. Н.Нэргүй, Ч.Нямгэрэл ба бусад, Багилахуйн хөгжил: Багилахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент (Боловсролын бодлого боловсруулагч, судлаач, арга зүйч, ЕБС-ийн удирдах ажилтан нарт зориулав), УБ., 2013.

4. С.Батхуяг Амжилттай суралцахуй.

5. Б.Батаа, М.Чойжилжав Суралцах чадвар. УБ..

6. С.Батсүх Хүүхдийн хөгжил-УБ., 2010

Хичээлийн үйл явц, үр дүнгийн зураг:



Квадрат функцийн график, тоон интервал ашиглан квадрат тэнцэтгэл биш бодож сургах

Б.Ариунзул, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, МУИС-ийн Байгаль-Эх лицей сургууль
Холбоо барих утас, имэйл хаяг: 96622959, ariun0430@gmail.com

Удиртгал, зорилго, зорилт

Миний бие 2006 онд МУИС-ийн онолын математикийн ангийг дүүргэж эзэмшсэн мэргэжлээрээ 12 жил ажиллаж байна. Энэ хугацаанд сурагчдаа элсэлтийн ерөнхий шалгалтад тасралтгүй бэлтгэж ирлээ. Математикийн багшаар ажиллах хугацаанд миний анхаарал татсан зүйлүүдийг нэг бол суралцагчдын санамсаргүй болон мэдлэг дутмагаас болж гардаг алдаа нь ахлах ангийн хичээлүүдэд муугаар нөлөөлж улмаар элсэлтийн шалгалтад хангалтгүй дүн авах үндэслэл болсоор байгааг олж мэдсэн юм. Энэ алдаа нь бага ба дунд ангиасаа буруу дадаж хэвшсэн байдаг. Анхнаасаа буруу дадаж хэвшсэн зүйлийг зөвөөр засаж хэвшүүлэхэд амаргүй бөгөөд их цаг хугацаа зарцуулдаг болно.

Судалгааны ажлаа математикийн хичээлд ихээхэн тохиолдолддог квадрат тэнцэтгэл бишийг буруу бодож дадсан тэр дадлыг засах, сайжруулах **зорилготой** бичлээ.

Зорилгодоо хүрэхийн тулд 5 зорилт дэвшүүллээ.

1. Тухайн буруу дадлыг хичнээн олон хүүхэд гаргаж байгааг олж мэдэх
2. Тухайн буруу дадал бусад ямар ямар хичээлийн сэдвүүдтэй холбоотой байгааг мэдэх
3. Судалгаат хичээлүүд хийж турших
4. Судалгаат хичээлээ сайжруулж турших
5. Үр дүнг тооцож, ирээдүйд ашиглах зөвлөмж гаргах.

Нэг. Сэдвийг сонгосон үндэслэл

Суралцагч квадрат тэгшитгэл боддог аргуудаа квадрат тэнцэтгэл биш дээр ашиглахдаа алдаа гаргаж улмаар түүнийгээ бусад сэдвүүд дээр ч ашиглаж боддог нь ажиглагдсан. Энэ алдаа нь цаашдын бүлэг сэдвийн хичээлүүд, ЭЕШ ба физик зэрэг хичээлүүдэд хортой нөлөөлдөг нь ч давхар харагдсан юм.

Манай сургууль зөвхөн ахлах ангиудад элсэлт авдаг бөгөөд энэхүү алдаа нь дунд ангиас нь улбаатай байсан учир ахлах ангид засаж залруулна гэдэг үнэхээр төвөгтэй байлаа. Би рационал тэгшитгэл гэсэн бүлэг сэдэв дээр тулгуурлан алдааг засах оролдлого хийдэг байв. Тухайн үед засч чаддаг ч хэсэг хугацааны дараа дахиад л алдаа давтагддаг байсан.

Харин 2016 оноос цөм хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 10 ба 11-р ангид “**Квадрат тэгшитгэл тэнцэтгэл биш**” гэсэн бүлэг сэдэв нэмэгдсэнээр дээрх алдааг засах боломж олдсон юм. Гэвч сурагчид энэхүү алдааг гаргасаар л байна. Иймд уг алдааг яаж засч залруулах арга боловсруулах, хичээлийн аль үе шатанд алдаа гаргаж байгааг олж мэдэх зорилгоор энэхүү сэдвээр илтгэл бичихээр шийдлээ.

Хоёр. Түлхүүр үг: Сурах нөхцөл, сургах арга, сурагчийн дадал

Гурав. Хамрах хүрээ: МУИС-ийн “Байгаль-Эх лицей” ахлах сургуулийн 10-12-р ангиуд

Дөрөв. Эерэг үр дүнд хүрэхэд зарцуулсан хугацаа: 2016-2018 он

Тав. Хичээлийн санаа:

Квадрат тэнцэтгэл бишийг алдаж бодож байгаа хэлбэрүүдийг сонгон авч тусад нь 1-2 цагийн хичээл орно. Энэ хичээлийг хэрхэн ойлгосныг 11 ба 12-р ангиудаас сорилго авч шалгах, мөн 12-р ангид **уламжлалын хэрэглээ, тригонометр, тэгшитгэл ба тэнцэтгэл биш** сэдвүүд үзэх үед дээрх алдааг гаргаж буй эсэхийг ажиглаж тийм алдаанаас урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Зургаа. Хичээлийн бэлтгэл судалгаа:

Энэхүү сэдвээр өнгөрсөн 2017 оны 9-р сард квадрат тэнцэтгэл биш сэдэв үзсэний дараа шалгалт авахад $ax^2 + bx + c > 0 (< 0)$ хэлбэрийн тэнцэтгэл бишийг бодож чадаж байсан ч $ax^2 > b$ хэлбэрийн тэнцэтгэл бишийг бодох явцад $x^2 = 4$; язгуур гаргаж $x = \pm 2$ гэх өмнөх ойлголтоос болж өгөгдсөн бодлогуудыг буруу бодож мөнөөх алдааг гаргаж байв.

Дээрх алдаа нь цөм хөтөлбөрийн 11-р ангийн **квадрат тэнцэтгэл биш, тригонометр, уламжлал** ба 12-р ангийн **уламжлал, тригонометр** гэсэн сэдвүүдэд мөн л давтагдаж байлаа. Энэ жилийн 12-р анги буюу өмнөх 2017 оны 11А ангийн 17 сурагчдад энэхүү сэдвээр товч сануулж байгаад дахин $\frac{2}{x} > 1$ ба $x^2 > 4$ гэсэн хоёр бодлогоор шалгахад 65.0 хувьтай гүйцэтгэж байв. Харин жилийн дараа буюу 2018 оны 09-р сард мөнхүү хоёр бодлогоор дахин шалгалт авахад 60.0 хувьтай гүйцэтгэж байв.

Шалгалтын дүнг харуулбал:

1-р сурагч	100	11-р сурагч	40
2-р сурагч	60	12-р сурагч	10
3-р сурагч	70	13-р сурагч	40
4-р сурагч	100	14-р сурагч	80
5-р сурагч	90	15-р сурагч	60
6-р сурагч	50	16-р сурагч	25
7-р сурагч	50	17-р сурагч	100
8-р сурагч	10	18-р сурагч	50
9-р сурагч	10	Гүйцэтгэлийн дундаж хувь	60
10-р сурагч	100		

11-р анги ба 12-р ангийн хүүхдүүдийн бодолтыг доор харуулав.



Иймд 2018 оны 11А-р ангийн **квадрат тэнцэтгэл биш** сэдвийг заахдаа дахин ийм алдаа гаргахгүй байхын тулд ээлжит хичээлийн бэлтгэлээ дахин шинэчилж, 2018.09.21-нд 11А-р ангид хичээл орсон хөтөлбөрөө дор үзүүлэв.

Нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулсан: БЭЛАС-ийн математикийн багш Б.Ариунзул

Хичээлийн нэр: Квадрат тэгшитгэл

Хугацаа: 80мин

Хамрах хүрээ: 11-р анги

Зорилт :

1. Квадрат тэнцэтгэл биш графикийн аргаар бодож сурах.
2. Квадрат тэнцэтгэл бишийн шийдийг тоон шулуун дээр бичиж дүрсэлж сурах.
3. 2 зэргийн рационал тэнцэтгэл бишийг бодож сурах.

Судлагдахуун: Квадрат тэгшитгэл, тэнцэтгэл биш

Арга зүй : Асуудлыг шийдвэрлэх, тайлбарлан ярих, ярилцах гэх мэт аргуудыг ашиглана.

Хэрэглэгдэхүүн : Ажлын хуудас 1 ба 2, сурагчийн дэвтэр, үзүүлэн тараах материал, самбар, анги танхим гэх мэт материаллаг хэрэглэгдэхүүнээс гадна сурагчийн өмнөх мэдлэг, багшийн заах арга, ур чадвар гэх мэт оюуны хэрэглэгдэхүүн орно.

Хичээлийн явц :

Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	хугацаа 80 минут
------------------------------	--------------------------------	-----------------------------

Мэндлэх	Мэндлэх	1 минут
Асуулт: <ul style="list-style-type: none"> $x^2 > 4$ тэнцэтгэл бишийг бодно уу? $\frac{1}{x} > 1$ тэнцэтгэл бишийг бодно уу? 	Бодоод багшид хураалгах	Сэдэлжүүлэх 8 мин
Багш хичээлийн танилцуулга хийнэ: <ul style="list-style-type: none"> Бүгдээрээ энэ хоёр тэнцэтгэл бишийг өнөөдрийн хичээл дээр бодож сурья. Иймд ажлын хуудас №1-ийг та бүхэнд тарааж өгнө. Энэхүү ажлын хуудас дээрх ажлуудыг алгасахгүйгээр дарааллаар нь хийнэ үү? (Хэрэглэгдэхүүн №1) 		
Ажлын хуудас тарааж өгөөд, хүүхдүүдийн хийж буй зүйлийг шууд зааж өгөхгүйг анхаарна.	Ажлын хуудас №1-ийн 1-7 ажлыг дэс дарааллаар нь хийнэ. /15 минут/	Мэдлэг бүтээх, бататгах 32 мин
Анхааруулга: Бүгд дууссан бол нар зөв тойргоор ажлын хуудсаа бие биедээ дамжуулж, бие биенийхээ хийснийг ажиглана уу? Ингэж ажиглахдаа хүүхдийн хийсэн цаасан дээр бичиж тэмдэглэхгүй өөрөө өөртөө дүгнэлт хийнэ үү?	Ажлын хуудаснуудыг дамжуулан ажиглана. /8минут/	
Анхааруулга: Бүгд дамжуулаад өөрийн чинь хийсэн хуудас чамд ирвэл өөрийн хийсэн зүйлээ засаж болно. Хэрэв миний зөв гэж бодвол засвар хийхгүй байж болно.	Өөрийн ажлын хуудсаа засна. /2 минут/	
Самбарт салаа болгоноос нэг нэг хүүхэд гаргаж ажлын хуудсан дээрх бодлогыг бодуулна.	Самбарт гарч бодно. Самбар дээрх бодолтоос дүгнэлт хийнэ. /7 минут/	
Ажлын хуудсыг хурааж авна.		
Багш хичээлийн танилцуулга хийнэ: Ажлын хуудас №2-ыг та бүхэнд тарааж өгнө. Энэхүү ажлын хуудас дээрх ажлуудыг алгасахгүйгээр дарааллаар нь хийнэ үү? (Хэрэглэгдэхүүн №2)		Сэдэлжүүлэх 2 мин
Ажлын хуудас тарааж өгөөд, хүүхдүүдийн хийж буй зүйлийг шууд зааж өгөхгүйг анхаарна.	Ажлын хуудас №1-ийн 1-7 ажлыг дэс дарааллаар нь хийнэ. /15 минут/	Мэдлэг бүтээх, бататгах 32 мин
Анхааруулга: Бүгд дууссан бол нар зөв тойргоор ажлын хуудсаа бие биедээ дамжуулж, бие биенийхээ хийснийг ажиглана уу? Ингэж ажиглахдаа хүүхдийн хийсэн цаасан дээр бичиж тэмдэглэхгүй өөрөө өөртөө дүгнэлт хийнэ үү?	Ажлын хуудаснуудыг дамжуулан ажиглана. /8минут/	
Анхааруулга: Бүгд дамжуулаад өөрийн чинь хийсэн хуудас чамд ирбэл өөрийн хийсэн зүйлээ засаж болно. Хэрэв миний зөв гэж тооцвол засвар хийхгүй байж болно.	Өөрийн ажлын хуудсаа засна. /2 минут/	
Самбарт салаа болгоноос нэг нэг хүүхэд гаргаж ажлын хуудсан дээрх бодлогыг бодуулна.	Самбарт гарч бодно. Самбар дээрх бодолтоос дүгнэлт хийнэ. /7 минут/	
Ажлын хуудсыг хурааж авна.		
Багш дахин нэг бодлого өгч бодуулаад хурааж авна. $\frac{2}{x} > 1$		5 мин

Ажлын хүүдас №1

1. Квадрат функцийн график гарна.
2. $y = x^2$ график зурна уу?
3. $y = x^2 - 1$ график зурна уу?
4. $y = x^2 - 1$ график ашиглан:
 - a) $x^2 - 1 = 0$ шийд шийдийг график дээр тэмдэглэнэ үү?
 - b) $x^2 - 1 = 0$ шийдийг графикаас бичнэ үү?
 $x_1 = \dots\dots\dots$ $x_2 = \dots\dots\dots$
 - c) $x^2 - 1 = 0$ үржигдэхүүн задалж бодно уу?
 - d) $x^2 - 1 = 0$ язгуур ашиглан бодно уу?
5. $y = x^2 - 1$ график ашиглан:
 - a) $x^2 - 1 > 0$ тэнцэтгэл бишийн шийдийг график дээр дүрсэлнэ үү?
 - b) $x^2 - 1 > 0$ график ашиглан шийдийг бичнэ үү?
 - c) $x^2 - 1 > 0$ үржигдэхүүн болгон задалж бодно уу?
6. $x^2 > 1$ тэнцэтгэл бишийг бодно уу?
7. $x^2 > 4$ тэнцэтгэл бишийг бодно уу?

Ажлын хүүдас №2



1. $\frac{x}{2} = 3$ тэгшитгэлийг бодно уу?
2. $\frac{2}{x} = 3$ тэгшитгэл хэдэн зэргийн тэгшитгэл бэ?
 зэргийн тэгшитгэл
3. $\frac{2}{x} = 3$ тэгшитгэлийн шийд 6 ба 0 мөн үү? Шалгаж үзнэ үү?
4. Тоог тоонд хувааж болохгүй.
5. $\frac{2-3x}{x} = 0$ тэгшитгэл хэдэн зэргийн тэгшитгэл бэ?
 зэргийн тэгшитгэл
6. $\frac{2-3x}{x} = 0$ тэгшитгэлийг бодно уу? Тодорхойлогдох мужийг олно уу?
7. $\frac{2}{x} = 3$ тэгшитгэлийг бодно уу?
8. $\frac{2-3x}{x} > 0$ тэнцэтгэл биш тоон шулууныг хэсэгт хуваана.
9. $\frac{2-3x}{x} > 0$ тэнцэтгэл бишийг бодно уу?
10. $\frac{2}{x} > 3$ тэнцэтгэл бишийг бодно уу?
11. $\frac{1}{x} > 1$ тэнцэтгэл бишийг бодно уу?

Долоо. Судалгаат хичээл



1. Өмнө нь квадрат тэнцэтгэл биш сэдвээр ерөнхийд хичээл заасан байсан. Үүнийгээ хир үр дүнтэй болсон эсэхийг шалгаж хичээлийн эхэнд 11А ангиас сорилго болгож $\frac{1}{x} > 1$ ба $x^2 > 4$ хоёр бодлогоор шалгалт авч дараах үр дүн гарав.

1-р сурагч	0	7-р сурагч	30	13-р сурагч	20	19-р сурагч	0
2-р сурагч	50	8-р сурагч	0	14-р сурагч	20	20-р сурагч	20
3-р сурагч	0	9-р сурагч	50	15-р сурагч	0	21-р сурагч	20
4-р сурагч	0	10-р сурагч	10	16-р сурагч	0	22-р сурагч	50
5-р сурагч	10	11-р сурагч	10	17-р сурагч	40	Гүйцэтгэлийн хувь	11.7
6-р сурагч	10	12-р сурагч	0	18-р сурагч	50		

Шалгалтын материалаас дор харуулав:



2. Багш ажлын хуудас №1-ийг тараан өгч, ажил бүрийг алгасалгүй хийхийг сануулав. Энэ нь алхам алхмаар дамжуулан $x^2 > 4$ тэнцэтгэл бишийг бодож сургах зорилготой байсан. Ингэж ажлын хуудсаар ажиллах нь хүүхэд өөрөө мэдлэгийг бүтээж чадах юм.
3. Бүх хүүхэд ажлын хуудас №1-ийг ажиллаж дууссаны дараа нар зөв тойруулан бүгд бусдынхаа бодолтыг харьцуулан үзэх боломж олгосон. Энэ нь сурагчдад бусдынхаа хийсэн ажлыг өөрийн болон бусад сурагчдын хийсэнтэй харьцуулж тэндээсээ дүгнэлт хийх чадвар суулгах зорилготой байв. Энэ үйл ажиллагааны дараа тухайн сурагч өөрийн хийсэн ажлын хуудсаа дахин засаж хянаж байлаа.



Дээр яригдсан ажлын хуудас №1-ийг 9 дугаартай хүүхэд хэрхэн гүйцэтгэснийг доор харуулав:

№9

Ажлын хуудас №1

1. Квадрат функцийн график $y = x^2$ байна. $y = x^2$ график зурна уу?

$x \quad -2 \quad -1 \quad 0 \quad 1 \quad 2$
 $y \quad 4 \quad 1 \quad 0 \quad 1 \quad 4$

3. $y = x^2 - 1$ график зурна уу?

$x \quad -2 \quad -1 \quad 0 \quad 1 \quad 2$
 $y \quad 3 \quad 0 \quad -1 \quad 0 \quad 3$

4. $y = x^2 - 1$ график ашиглан:

a) $x^2 - 1 = 0$ шийд шийдийг график дээр тэмдэглэнэ үү?
 b) $x^2 - 1 = 0$ шийдийг графикаас бичнэ үү?
 $x_1 = \dots$ $x_2 = \dots$

c) $x^2 - 1 = 0$ үржигдэхүүн задлаж бодно уу?
 $(x-1)(x+1) = 0$
 $x_1 = 1 \quad x_2 = -1$

d) $x^2 - 1 = 0$ язгуур ашиглан бодно уу?
 $x^2 - 1 = 0$
 $x^2 = 1$
 $x = \pm 1$

a) $x^2 - 1 > 0$ тэнцэтгэл бишийн шийдийг график дээр дүрслэнэ үү?
 $x \in]-\infty; -1[\cup]1; +\infty[$

b) $x^2 - 1 > 0$ график ашиглан шийдийг бичнэ үү?
 $x \in]-\infty; -1[\cup]1; +\infty[$

c) $x^2 - 1 > 0$ үржигдэхүүн болгон задлаж бодно уу?
 $x^2 - 1 > 0$
 $x^2 - 1 = 0 \quad (x-1)(x+1) = 0 \quad x_1 = 1 \quad x_2 = -1$

6. $x^2 > 1$ тэнцэтгэл бишийг бодно уу?
 $x^2 > 1 \quad x^2 = 1 \quad x = \pm 1$

7. $x^2 > 4$ тэнцэтгэл бишийг бодно уу?
 $x^2 > 4 \quad x^2 = 4$

$x^2 - 4 > 0$
 $x^2 - 4 = 0$
 $(x-2)(x+2) = 0$
 $x_1 = 2 \quad x_2 = -2$

4. Дараа нь самбарт салаа бүрээс нэг нэг хүүхэд гарч ажил тус бүрийг ээлжлэн хийж ярилцав. Энд багш давхар тусалж байлаа.

5. Ажлын хуудас №2-ыг тараан өгч №1-ийн адил ажиллав. Гэтэл сорилгод орсон 22 сурагчаас нэг сурагч буюу “17” дугаартай сурагч ингэж ажиллахаас татгалзав. Тэр сурагч хийсэн зүйлээ өөрийн зөв гэж үзсэн боловч нөгөөх л нийтлэг гаргадаг алдааг давтсан байлаа. Гэвч хичээлийг хөндлөнгөөс ажиглаж суугаад өөрийн алдааг олж харж байв.

Дээр яригдсан ажлын хуудас №2-ыг 9 дугаартай хүүхэд хэрхэн гүйцэтгэснийг доор харуулав:

Ажлын хуудас №2

1. $\frac{2}{3} = 3$ тэгшитгэлийг бодно уу?
 $x = 6$

2. $\frac{2}{3} = 3$ тэгшитгэл хэдэн зэргийн тэгшитгэл бэ?
 $\frac{2}{3}$ зэргийн тэгшитгэл

3. $\frac{2}{3} = 3$ тэгшитгэлийн шийд 6 ба 0 мөн үү? Шалгаж үзнэ үү?
 $\frac{2}{3} \neq 3 \quad x \neq 0$
 $\frac{2}{3} \neq 3 \quad x \neq 0$

4. Тоог $\frac{0}{x}$ тоонд хувааж болохгүй.

5. $\frac{2-3x}{x} = 0$ тэгшитгэл хэдэн зэргийн тэгшитгэл бэ?
 $\frac{2-3x}{x}$ зэргийн тэгшитгэл

6. $\frac{2-3x}{x} = 0$ тэгшитгэлийг бодно уу? Тодорхойлогдох мужыг олно үү?
 $x \neq 0 \quad D(-\infty; 0) \cup (0; +\infty)$
 $-3x = -2 \quad x = \frac{2}{3}$

7. $\frac{2}{x} = 3$ тэгшитгэлийг бодно уу?
 $x \neq 0$
 $3x = 2 \quad x = \frac{2}{3}$

8. $\frac{2-3x}{x} > 0$ тэнцэтгэл биш тоон шулууныг \dots хэсэгт хуваана.

9. $\frac{2-3x}{x} > 0$ тэнцэтгэл бишийг бодно уу?
 $\frac{2-3x}{x} > 0 \quad x \neq 0$
 $x = \frac{2}{3}$


10. $\frac{2}{x} > 3$ тэнцэтгэл бишийг бодно уу?
 $\frac{2-3x}{x} > 0 \quad \frac{2-3x}{x} = 0 \quad x \neq 0$
 $x = \frac{2}{3}$

11. $\frac{1}{x} > 1$ тэнцэтгэл бишийг бодно уу?
 $\frac{1-x}{x} > 0 \quad x \neq 0$
 $x = -1$


6. Ажлын хуудас №2-ыг хураан авсны дараа самбарт багш тайлбарлаж өгөв.



7. Хичээлийн төгсгөлд дахин $\frac{2}{x} < 1$ бодлогоор сорил авав. 2 дахь сорилыг харуулбал:



“17” дугаартай сурагчийн эхний ба 2 дахь сорилын гүйцэтгэлийг харуулбал:



8. 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдөр мөнхүү бодлогыг хэр зэрэг бодож байгааг тандах зорилгоор дахин нэг сорилго авав.

Найм. Судалгааны үр дүн:

Судалгаат хичээлийн төлөвлөлтөд хийсэн сайжруулалт:

- a) Сорил шалгалтын бодлогын тэмдгийг өөр өөр сонгож авах ёстой.
- b) Ажлын хуудас №1-ийн 5А асуултыг илүү ойлгомжтой асуух хэрэгтэй.
- c) Ажлын хуудас №1-ийн 5Б асуултыг өмнөх жилийн хичээл заах үед илүү анхаарч ойлгуулах шаардлага байгаа нь ажиглагдсан.
- d) Ажлын хуудас №2-ын 2-р асуултад хариулж чадахгүй байгаа нь 10-р ангийн олон гишүүнт сэдвийг дутмаг ойлгосонтой холбоотой байв. Иймд энэ хичээлийг өмнөх жилд илүү анхаарал төвлөрүүлж заах хэрэгтэй.
- e) Ажлын хуудас №2-ын 10 ба 11-р асуултад хариулж чадахгүй байгаа нь 11-р ангийн тэнцэгтэл биш сэдвийг олон хэлбэр тус бүр дээр харьцуулан заахыг багшид анхааруулж байна.

Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа:

Хичээлийн эхэнд ба төгсгөлд сорил авч байгаа нь сурагчийг идэвхжүүлэх ба өөртөө дүгнэлт хийх болж олгож байна.

Ийнхүү хичээлийн 87.0 хувийг ажлын хуудсаар шийдсэнээр багш өөрөө асуудлыг шийдэж өгөлгүй, ажлын хуудсаар дамжуулан сурагч өөрөө шийдэж байгаа шинэлэг арга барил юм. Багшийн оролцоо бага байгаа нь шавь төвтэй сургалт, сурагчдыг бусадтайгаа харьцуулан өөртөө дүгнэлт хийлгүүлсэнээр цаашид ийм алдаа гаргахгүй байх дадал хэвшил олгож байна.

Хичээлийн хэсэг тус бүрийн шийдлийг хэрэгжүүлсэн байдал:

- Ажлын хуудас №1 дээр ажилласан үр дүнг доор харуулбал:

Сурагчийн дугаар	эхний сорил	ажлын хуудас №1													Гүйцэтгэлийн
		1	2	3	4a	4b	4c	4d	5a	5b	5c	6	7		
1-р сурагч	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	1	91.7
2-р сурагч	50	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	100.0
3-р сурагч	0	1	1	1	1	1	1	1	1	0	0	1	1	1	83.3
4-р сурагч	0	1	0	1	1	1	1	1	1	0	1	0	0	0	58.3
5-р сурагч	10	1	0	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	50.0
6-р сурагч	10	1	1	1	1	1	1	1	1	0	0	1	1	1	83.3
7-р сурагч	30	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	1	83.3
8-р сурагч	0	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	58.3
9-р сурагч	50	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	100.0
10-р сурагч	10	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	58.3
11-р сурагч	10	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	58.3
12-р сурагч	0	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	58.3
13-р сурагч	20	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	75.0
14-р сурагч	20	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	75.0
15-р сурагч	0	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	16.7
16-р сурагч	0	1	1	1	1	1	1	1	1	0	1	0	0	0	66.7
17-р сурагч	40	1	0	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	58.3
18-р сурагч	50	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	58.3
19-р сурагч	0	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	0	0	75.0
20-р сурагч	20	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	1	1	91.7
21-р сурагч	20	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	1	83.3
22-р сурагч	50	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	100.0
Гүйцэтгэлийн хувь	17.7	100.0	81.8	95.5	95.5	95.5	100.0	95.5	40.9	54.5	36.4	27.3	40.9	72.0	

- Ажлын хуудас №2 дээр ажилласан үр дүнг доор харуулбал:

Сурагчийн дугаар	эхний сорил	ажлын хуудас №2											Гүйцэтгэлийн	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
1-р сурагч	0	1	0	1	1	1	1	0	1	1	1	1	1	81.8
2-р сурагч	50	1	0	0	1	0	0	1	1	1	1	1	0	54.5
3-р сурагч	0	1	1	1	1	1	1	0	1	1	1	0	0	72.7
4-р сурагч	0	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	90.9
5-р сурагч	10	1	0	1	1	1	1	1	1	1	1	0	1	81.8
6-р сурагч	10	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	90.9
7-р сурагч	30	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	0	81.8
8-р сурагч	0	1	0	0	1	1	1	1	1	1	0	1	1	72.7
9-р сурагч	50	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	100.0
10-р сурагч	10	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	0	81.8
11-р сурагч	10	1	0	1	1	1	1	1	1	1	1	0	0	72.7
12-р сурагч	0	1	0	1	1	1	1	1	1	1	0	0	0	63.6
13-р сурагч	20	1	0	1	1	1	1	1	1	1	0	0	0	63.6
14-р сурагч	20	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	72.7
15-р сурагч	0	1	0	1	1	1	1	1	0	1	1	1	0	72.7
16-р сурагч	0	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	90.9
18-р сурагч	40	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	90.9
19-р сурагч	50	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	90.9
20-р сурагч	0	1	0	1	1	1	1	1	0	0	0	0	1	63.6
21-р сурагч	20	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	90.9
22-р сурагч	20	1	0	1	1	1	1	1	0	1	1	1	0	72.7
Гүйцэтгэлийн хувь	50	100.0	19.0	90.5	100.0	95.2	95.2	90.5	85.7	76.2	66.7	47.6	78.8	

- 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдөр сорил №3 буюу а) $x^2 < 9$; б) $\frac{3}{x} > 1$ гэсэн хоёр бодлогоор сорилго авахад дараах үр дүн гарав:

Сурагчийн нэрс	сорил №1	сорил №2	сорил №3	Сорил 1 ба 3-ын зөрүү	Сорил 2 ба 3-ын зөрүү
1-р сурагч	0	90	60	60	-30
2-р сурагч	50	90	100	50	10
3-р сурагч	0	30	95	95	65
4-р сурагч	0	80	50	50	-30
5-р сурагч	10	50	10	0	-40
6-р сурагч	10	100	95	85	-5
7-р сурагч	30	40	40	10	0
8-р сурагч	0	90	20	20	-70
9-р сурагч	50	100	100	50	0
10-р сурагч	10	30	20	10	-10
11-р сурагч	10	50	90	80	40
12-р сурагч	0	80	20	20	-60
13-р сурагч	20	20	60	40	40
14-р сурагч	20	20	100	80	80
15-р сурагч	0	20	60	60	40
16-р сурагч	0	90	80	80	-10
17-р сурагч	40	100	70	30	-30
18-р сурагч	50	90	70	20	-20
19-р сурагч	0	90	80	80	-10
20-р сурагч	20	90	90	70	0
21-р сурагч	20	90	100	80	10
22-р сурагч	50	30	70	20	40
Гүйцэтгэлийн хувь	17.7	66.8	67.3	49.5	0.5

Ес. Дүгнэлт

Судалгааны ажлын шинэ санаа:

Би өөрийн ажиглаж мэдсэн математикийн хичээлд ихээхэн тохиолдолддог квадрат тэнцэтгэл бишийг буруу аргаар бодож алдаа гаргадаг дадлыг засах зорилго бүхий судалгаат хичээлийнхээ 87.0 хувийг ажлын хуудсаар шийдсэн. Ингэж шийдсэнээр багш өөрөө асуудлыг шийдэж өгөлгүй, ажлын хуудсаар дамжуулан сурагч өөрөө шийдэж мөн сурагчдыг бусадтайгаа харьцуулан өөртөө дүгнэлт хийлгүүлсэнээр цаашид ийм алдаа гаргахгүй байх дадал хэвшлийг баттай олгож байгаа болно.

Шийдвэрлэсэн асуудлууд:

1. Тухайн алдааг хичнээн хүүхэд гаргаж байсныг болон хичээлийн төгсгөлд хэдэн хүүхэд зөв бодож байгааг сорил 1 ба 2-ын үр дүнгээр үзүүлбэл:

Сурагчийн нэрс	сорил №1	сорил №2	өсөлтийн зөрүү	Сурагчийн нэрс	сорил №1	сорил №2	өсөлтийн зөрүү
1-р сурагч	0	90	90	13-р сурагч	20	20	0
2-р сурагч	50	90	40	14-р сурагч	20	20	0
3-р сурагч	0	30	30	15-р сурагч	0	20	20
4-р сурагч	0	80	80	16-р сурагч	0	90	90
5-р сурагч	10	50	40	17-р сурагч	40	100	60
6-р сурагч	10	100	90	18-р сурагч	50	90	40
7-р сурагч	30	40	10	19-р сурагч	0	90	90
8-р сурагч	0	90	90	20-р сурагч	20	90	70
9-р сурагч	50	100	50	21-р сурагч	20	90	70
10-р сурагч	10	30	20	22-р сурагч	50	30	-20
11-р сурагч	10	50	40	Гүйцэтгэлийн хувь	17.7	66.8	49.1
12-р сурагч	0	80	80				

- Тухайн буруу дадал бусад ямар ямар хичээлийн сэдвүүдтэй холбоотой байгааг мэдэв. Дээрх алдаа нь цөм хөтөлбөрийн 11-р ангийн **квадрат тэнцэтгэл биш, тригонометр, уламжлал** ба 12-р ангийн **уламжлал, тригонометр** гэсэн сэдвүүдэд дахин давтагдаж байгааг олж харж зассан.
- Дээрх хичээлийг 2017-2018 ба 2018-2019 оны хичээлийн жилүүдэд зааж туршив.
- Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд дараах 5 сайжруулалт хийхээр болов.
 - Сорил шалгалтын бодлогын тэмдгийг өөр өөр сонгож авах
 - Ажлын хуудас №1-ийн 5А асуултыг илүү ойлгомжтой асуух
 - Ажлын хуудас №1-ийн 5Б асуултыг өмнөх хичээл дээр илүү сайн зааж ойлгуулах
 - Ажлын хуудас №2-ын 2-р асуултад хариулж чадахгүй байгаа нь 10-р ангийн олон гишүүнт сэдвийг дутмаг ойлгосонтой холбоотой байна. Иймд энэ хичээлийг тухайн үед нь сайн заах
 - Ажлын хуудас №2-ын 10 ба 11-р асуултад хариулж чадахгүй байгаа нь 11-р ангийн тэнцэтгэл биш сэдвийг олон хэлбэр тус бүр дээр харьцуулан заах хэрэгтэйг багшид анхааруулж байна.
- 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдөр сорил №3 буюу а) $x^2 < 9$; б) $3/x > 1$ гэсэн хоёр бодлогоор сорилго авахад №1 сорилоос 49.5 хувиар, №2 сорилоос 0.5 хувиар тус тус өссөн үр дүн гарсан.

14 дүгээр сурагчийн сорилго №1, №2, №3-ыг харуулав:

Дараах тэнцэтгэл бишийг бодно уу?

1. $\frac{1}{x} > 1$
 $x \in]0; 1[$

2. $x^2 > 4 \Rightarrow x^2 - 4 > 0$
 $x > \pm 2$
 $x \in]2; +\infty[\cup]-\infty; -2[$

11А А.ТЭШ

1) $\frac{2}{x} < 1$
 $x \neq 0$
 $\frac{2}{x} = 1$
 $2 = x$

$x \in (-\infty; 0) \cup (2; +\infty)$

1) $x^2 < 9$
 $x = \pm 3$
 $x^2 - 9 < 0$
 $x \in]-3; 3[$

2) $\frac{3}{x} > 1$
 $x \neq 0$
 $\frac{3-x}{x} = 0$
 $3-x = 0$
 $x = 3$

$x \in]0; 3[$

Яагаад сайн хичээл болсон бэ:

Хичээлийн эхэнд 17.7 хувийн гүйцэтгэлтэй байсан бол хичээлийн төгсгөлд 66.8 хувийн гүйцэтгэлтэй, сорилго 3-аар 49.5 хувийн өсөлтийг үзүүлж чадсан дэвшилтэй харагдаж байна. Эндээс дүгнэхэд ойлгоогүй үлдсэн бусад сурагчид энэ алдааг дахиж гаргах нь эрс буурах улмаар алдаа гаргахгүй болох баттай магадлал бий болов.

Бусдад хүргэх түршлага:

1. $\frac{1}{x} > 2$ ба $x^2 > 4$ гэх мэт бодлогыг нэг ээлжит хичээл болгон заах
2. Сурагчийн алдааг тэмдэглэж авч, өөрөө дахин тайлбарлаж өгөх
3. Өөрийн мэдлэгээ байнга дээшлүүлж байх

Эцэст нь хэлэхэд сурагчдын мэдлэг чадварын дутмаг байдал нь сурагчийн сурах хүсэл эрмэлзэлтэй шууд холбоотой хэдий ч багшийн заах ур чадвар, сурагчидтайгаа тулж ажиллах арга барил зэрэг хүчин зүйл ихээхэн нөлөөтэйг санаж явах ёстой билээ.

Ном зүй

1. Боловсрол соёл шинжлэх ухааны яам. “Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын модуль” Улаанбаатар 2018 он.
2. Б.Баяржаргал нар. “Математик-10” 2016 он.
3. Б.Баяржаргал нар. “Математик-11” 2017 он.
4. “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол практикийн V бага хурлын хураангуй. 2018 он.
5. “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол практикийн V бага хурлын дэлгэрэнгүй. 2018 он.

Суралцахуйн алдаанаас хэрэглэгдэхүүнийг сайжруулсан үр дүн

Д.Урантогос¹, Б.Мөнхдөл², Б.Оюун³
физикийн багш¹, математикийн багш², физикийн багш³
Дорнод аймаг Хэрлэн сум¹ Шинэ хөгжил цогцолбор сургууль², 12-р сургууль³

Зорилго: Судалгаат хичээлийн зорилго сурагчдын сурах үйлийн явцад гаргасан алдааг шинжилж, хичээлийн хэрэглэгдэхүүнээ боловсронгуй болгоход оршино.

Судалгааны загвар/арга зүй/хандлага: Хичээлийн хэрэглэгдэхүүнийг боловсруулах судалгаа хийсэн. 6 –р ангийн физикийн хичээлээр толин ойлтын зүй тогтлыг туршилтаар судлахад зориулсан хэрэглэгдэхүүн бэлтгэхэд чиглэсэн. 7 удаагийн судалгаат хичээлээр дамжуулан сурагчид хэрэглэгдэхүүнтэй хэрхэн харьцаж байгааг, уг хэрэглэгдэхүүн үүргээ биелүүлж чадаж байгаа эсэхэд анхаарлаа төвлөрүүлж хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлэг, ажиглалтын үр дүндээ тулгуурлан хэрэглэгдэхүүнээ сайжруулж сурагчдын ажиглалт, мэдлэг бүтээх процессыг судалсан.

Судалгааны үр дүн: Гэрлийн ойх, хугарах үзэгдлийн зүй тогтлыг илрүүлэх гарын доорх материал ашигласан хэрэглэгдэхүүн боловсруулж чадсан. Үүнд цацрагийн мөр илрүүлэх тунгалаг хавтгай, хоёр талт өнцөг хэмжигч, хавтгай толины систем, хагас цилиндр ялтас, цацрагийн хайрцаг зэргийг гарын доорх материал ашиглан бэлтгэсэн. Сурагчдын шинжлэх ухаанч эрэл хайлт хийх чадвар, мэдлэгт мэдэгдэхүйц ахиц гарсан.

Практик ач холбогдол: Бүтээсэн хэрэглэгдэхүүнийг гэрлийн ойлт, хугарлын зүй тогтлыг бие даан илрүүлэхэд ашиглах бүрэн боломжтой.




Шинэлэг тал/ашиг тус: Сурагчдын суралцах явцад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг хэрэглэгдэхүүнтэй холбон ажиглах, улмаар хэрэглэгдэхүүнийг төгөлдөржүүлэх судалгаа, судалгааны үр дүнд боловсруулан бүтээсэн хэрэглэгдэхүүний онцлог давуу тал

Түлхүүр үг: Суралцахуйн алдаа, шийдвэрлэх арга зам, хэрэглэгдэхүүний судалгаа


Товч агуулга

Физикийн хөтөлбөр, сурах бичиг, гарын авлагад гэрлийн ойлгыг судлах хэрэглэгдэхүүний талаар тодорхой өгүүлсэн байдаг. Хичээлийн судалгааны нийгэмлэгийн 3 –р бага хуралд Завхан аймгийн Тосонцэнгэл сумын багш Г.Оюундэлгэр гэрлийн толин ойлтын тэгш хэмийг илрүүлэх тунгалаг хавтгай боловсруулсан талаар танилцуулсан. Бид уг хэрэглэгдэхүүнийг улам сайжруулж янз бүрийн хуваарьтай тунгалаг ба тунгалаг бус өнцөг хэмжигч, нэг ба хоёр толины систем, толийг тогтоогч, хугарлын үзэгдлийг судлах ялтас, цацрагийн хайрцаг зэргийг бүтээж иж бүрдэл болгох судалгаа хийсэн. Судлагдахууны багаараа хамтран хичээлийн судалгааг жилд 2-3 удаа, сүүлийн 2 жилийн хугацаанд 7 удаа зохион байгуулах явцад сурагчдын тулгарч буй хүндрэл бэрхшээл, сурагчдын шинжлэх ухаанч эрэл хайлтад гарч буй ахиц өөрчлөлтийг ажиглаж, хэлэлцэж судалсан.

А. Өнцөг хэмжигчийг сайжруулсан нь. 1-р хувилбар: Дэлгүүрээс худалдаж авсан хуванцар өнцөг хэмжигч (0° – 180° баруун, зүүн давхар хуваарьтай). Сурагчид өнцөг хэмжихдээ хуваарийг уншаад хоёр цацрагийн заалтын ялгаврыг авахгүй байх, хуваарийг буруу унших байдал ажиглагдаж байв. Багшийн гаргасан алдаа нь сурагчдыг зүүн баруун хуваарьтай өнцөг хэмжигч ашиглаж чадна гэж үзсэн. Мөн хуванцар өнцөг хэмжигчийн төв нь ирмэгээс тодорхой зайтай байрлах учир багажийн төвийг нь зохих газарт байрлуулах боломжгүйгээс хэмжилтийн алдаа нэмж гарч байсан. Нөгөө талаас өнцөг хэмжигч нь 1-2 мм зузаантай учир толины доор байрлуулах боломжгүй байсан.





2-р хувилбар: Иймд бид интернэтээс өнцөг хэмжигч цаасан дээр хуулбарлан буулгаж ашигласан. Энэ нь өнцөг хэмжигчийг дуртай газартаа байрлуулах боломжийг өгсөн. Гэхдээ принтерлэх үеийн босоо хэвтээ өсгөлтийн алдаанаас өнцгийг буруу хэмжих талтайг илрүүлсэн. Амархан бохирдож ирмэг нь нугарч байсан учир тунгалаг гадаргаар бүрсэн. Гэвч хуваарийг буруу унших байдал үргэлжилсээр байсан.




Хэмжилт	1	2	3	4	5
Тусгалын өнцөг α	50°	30°	45°	55°	60°
Ойлтын өнцөг β	130	150	135	125	120

Баруун, зүүн $0^\circ - 180^\circ$ хуваарьтай өнцөг хэмжигч

Сурагчид заалтыг шууд авч нормалтай үүсгэх өнцгийг авахгүй байв. Зүүн хуваарийн заалтыг нэгжийн орныг баруунаар уншиж байв.





3-р хувилбар: Энэ байдлыг засахын тулд дундаас баруун, зүүн тийш хуваарьтай өнцөг хэмжигчийг цаасан дээр буулган ашиглав. Нормалтай үүсгэх өнцөг олох бэрхшээл арилсан. Гэхдээ яагаад эндээс өнцөг хэмжих нь зөв болохыг ойлгохгүй, механикаар үйлдэл хийж байв.




Хэмжилт	1	2	3	4	5
Тусгалын өнцөг α	15°	25°	30°	35°	45°
Ойлтын өнцөг β	75	65	150	55	45

Төвөөс баруун, зүүн $0^\circ - 90^\circ$ хуваарьтай өнцөг хэмжигч

Сурагчид заалтыг зөв уншиж байв. Зүүн хуваарийн заалтын уншихад зарим бэрхшээл байв. Түүнийг хэлэлцэж засварласан.




4-р хувилбар: Цаасан өнцөг хэмжигчийн дээгүүр цацраг гулсах үед ашиглах боломжтой юм. Гэвэл савтай ус руу савны хана дагаж гэрэл тусгах тохиолдолд өнцөг хэмжигч тунгалаг байх нь тохиромжтой байсан. Иймд бид тунгалаг хатуу принтерийн хальсан дээр 10 см диаметртэй төвөөс баруун зүүн $0^\circ - 90^\circ$ хуваарьтай өнцөг хэмжигч хэвлэж гаргасан. Үүнээс бага диаметртэй үед хугалах хагас цилиндрийн хэмжээтэй тохирохгүй, үүнээс их үед лазерийн цацрагийн цацрагийн мөр олоход бэрхшээлтэй байв.

	
<p>Баруун зүүн $0^\circ - 90^\circ$ хуваарьтай, хоёр туйлт, тунгалаг өнцөг хэмжигч.</p> <p>Энэ нь ойлт хугарлын өнцгийг хэмжих боломжтой.</p>	<p>Баруун зүүн $0^\circ - 90^\circ$ хуваарьтай, хоёр туйлт, тунгалаг, дундаа эргэх суурьтай өнцөг хэмжигч.</p>

Өнцөг хэмжигч ба толь хөдөлгөөнгүй үед тусах цацрагийг шилжүүлэх шаардлагатай болж байв. Энэ үед тусгалын төв цэгээ мартаж, онохгүй байх, лазерин цацрагийг зөв тусгах нь амаргүй ажлын тоонд орж байв. Иймд бид толь өнцөг хэмжигчийн хамт эргэдэг харин гэрлийн цацраг нэг чигт тусдаг байхаар суурийг өөрчлөв. Энэ нь цацрагийн чигийг дахин дахин өөрчлөх, хэмжилтийн алдаа бага гарах, цаг хэмнэх гол санааг ойлгоход хялбар болох нөхцлийг бүрдүүлсэн болно.


Мөн өнцөг хэмжигч ашиглан өнцөг хэмжих дасгал оруулсан ажлын хуудас бэлтгэж сурагчдыг өнцөг хэмжиж сургасан. Энэ нь туршилтын үед өнцөг хэмжихэд алдаа гарахгүй байх урьдчилсан нөхцөл болов.

В. Толийг сайжруулсан нь. 1-р хувилбар: Эхлээд сурагчдын хэрэглэдэг дугуй, хавтгай, том жижиг янз бүрийн толийг гараар барьж байгаад лазерин цацраг тусгаж үзэв. Чөлөөний зэрэг (хувьсах параметр) хэт олон учир юу болж байгааг хянахад хэцүү байв. Толь тогтворгүй, гэрлээ зөв тусгаж чадахгүй, өнцөг хэмжиж чадахгүй гэх мэт олон бэрхшээл нэг дор цугларсан.



2-р хувилбар: Ижил тэгш өнцөгт толь хэрэглэх нь зүйтэй гэж үзэв. Толины газарт очоод том жижиг янз бүрийн толь зүсүүлж туршилтад хэрэглэв. Гэвч ийм том жижиг өргөн өндөр нь ялгаатай толийг хадгалахаас эхлээд, тогтоочийг бэхлэхээс эхлээд хүндрэл учрав.

3-р хувилбар: Ижил хэмжээтэй толь дахин зүсүүлэв. Толины хэмжээг урьдчилан туршиж тооцоолоогүй учир том толь эгц босоо тогтооход бэрхшээлтэй байв. Иймд толийг 80 x 40 мм хэмжээтэй байх нь хамгийн тохиромжтой гэсэн дүгнэлтэд хүрэв. Толийг эхлээд нарийн скочоор хүрээлсэн нь гоо сайхан, эрүүл ахуйн хувьд зохимжгүй байсан учир өтгөн будгаар будаж гар зүсэхгүй болгов. Толийг босоо болгохын тулд баримлын шавар, матар хавчаар, модон тулгуур зэргийг туршсан ба сүүлд нь толины ард жижиг соронзон хөдөлгөөнгүй нааж төмөр босоо түшлэгт наах арга хэрэглэх нь хамгийн тохиромжтой гэсэн дүгнэлтэд хүрэв.



Сурагчдын гаргаж буй алдааг засан сайжруулах зорилгын хүрээнд 2 жилийн хугацаанд 6-р ангийн 2 цагийн ээлжит хичээлийн засан сайжруулсан жишиг болохуйц хөтөлбөр хэрэглэгдэхүүнтэй болсон.

С. Гэрлийн цацраг үүсгэгчийг сайжруулсан нь:




1-р хувилбар: Лазерын заагуур ашиглаж гэрлийн цацраг үүсгэв. Энэ нь нүдэнд тусвал аюултайн дээр чигийг олж хөдөлгөөнгүй байрлуулах нь түвэгтэй байв.





2-р

хувилбар: Лазерын цацраг үүсгэгчийг хөдөлгөөнгүй бэхлэх арга сэдэв. Гэвч цацрагийн чигийг тохируулахад түвэгтэй хэвээр байв.

3-р хувилбар: Японы цацрагийн хайрцгийг дуурайж цацрагийн хайрцаг хийхээр шийдэв. Энэ нь зөөх боломжтойн дээр хэвтээ ба босоо хавтгайд соронзонгоор тогтоох өргөн боломжтой байв. LED гэрэл ашиглаж цацрагийн хайрцаг хийж туршив. Энэ нь тогтвортой, цацрагийн мөр сайн харагддаг, зөөх боломжтой зэрэг давуу талтай байсан боловч цацраг нь өргөн учир хэмжилтийн нарийвчлал муудаж байв.



		
<p>LED цацрагийн хайрцаг өргөн цацраг гаргаж хэмжилтийн алдаа ихсэж болж байв.</p>	<p>Лазерын цацрагийг зөв чиглүүлэхэд бэрхшээлтэй байв.</p>	<p>Цилиндр цацруулагчтай дан ба лазерын цацрагийн хайрцаг хамгийн сайн үзүүлэлттэй байв.</p>

4-р хувилбар: Лазерын заагуурын өмнө маш жижиг тунгалаг хоолойг (дуслын системийн тунгалаг гуурс) хөндлөн байрлуулж цилиндр линз үүсгэж цацрагийг босоо чигт өргөн өнцгөөр тусгадаг болгов.




Сурагчдын мэдлэг бүтээх үйлийг зөв удирдахын танин мэдэх процесст нөлөөлөх хөндлөнгийн саадыг багасгаж хэрэглэгдэхүүнийг байнга сайжруулж байх нь чухал гэдгийг ойлгов. Багажийг сайжруулах тутамд сурагчдын шинжлэх ухаанч эрэл хайлтын үр дүн сайжирч, мэдлэг чадварт нь мэдэгдэхүйц ахиц гарч байсан.





Өнцөг

Хэмжигч ашиглан өнцөг хэмжих дасгал оруулсан ажлын хуудас бэлтгэж сурагчдыг өнцөг хэмжиж сургасан. Энэ нь туршилтын үед өнцөг хэмжихэд алдаа гарахгүй байх урьдчилсан нөхцөл болов.



Хэмжилт	1	2	3	4	5
Тусгалын өнцөг α					
Ойлтын өнцөг β					

Дүгнэлт

Сурагчдын мэдлэг бүтээх үйлийг зөв удирдахын танин мэдэх үйл явцад нөлөөлөх хөндлөнгийн саадыг багасгаж хэрэглэгдэхүүнийг байнга сайжруулж байх нь чухал гэдгийг ойлгосон.

Гэрлийн ойлт ба хугарлын үзэгдлийг судлахад шаардлагатай, гарын доорх материал ашигласан хэрэглэгдэхүүний иж бүрдлийг бүтээсэн. Олон удаагийн туршилтаар хичээлд ашиглах нь үр ашигтай, боломжтой нь тогтоогдсон. Багажийг сайжруулах тутамд сурагчдын шинжлэх ухаанч эрэл хайлтын үр дүн сайжирч, мэдлэг чадварт нь мэдэгдэхүйц ахиц гарч байсан.

Ном зүй

1. Тайжси Н. Байгалийн ухааны туршилттай хичээл заах аргачлал. Дархан-Уул. 2009.
2. Нямгэрэл Ч, Оюунцэцэг Н, Урансайхан Ч, Баярмаа Г, Сайнбилэг Ш, Лхагвасүрэн П, Отгонбаяр Н, Батбилэг Ж. Сорил тооцоогоор мэдлэг бүтээлгэх арга зүй. УБ. 2007.
3. Нямгэрэл Ч нар. Мэдээлэл боловсруулах аргаар мэдлэг бүтээх арга зүй. УБ. 2008.
4. Оюунцэцэг Д. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй. УБ.2004.
5. Чулуунцэцэг О нар. Бодит юмсыг загварчлан тооцоолох арга зүй. УБ хот. 2008 он.
6. Лхагважав Ч. Хичээл хоорондын холбоо, багш нарын хамтын ажиллагаа. УБ. 1999.
7. БСШУЯ, Жайка. Сурагчдын суралцахуйд суурилсан арга зүй хөгжил. 2007.
8. “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” онол,практикийн VI бага хурал. УБ. 2015

“Бодит хөдөлгөөний ажиглалтаас хөдөлгөөнийг загварчлах” арга зүй


Илтгэл бичсэн: Физикийн багш
Ж.Эрдэнэбулган, Б.Эрдэнэтуяа
Email: g.erkaal207@yahoo.com
Утас: 99350988, 95025552

Удиртгал: Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Сэдэв сонгосон үндэслэл: Хүүхэд сонссон зүйлийнхээ 10%-ийг сурч үлддэг. Харин хийж, хэрэглэж, сурсанаа хуваалцсанаар 90%-ийг сурч үлддэг гэдгийг эрдэмтэд нотолсон бөгөөд 8-р ангид нийт 17 судлагдахуунаар хичээллэдэгээс 90 орчим хувь нь танхимын аргаар хичээл сургалтын үйл ажиллагаа явуулдаг. Гэвч 12-14 насны хүүхдийн нас сэтгэхүйн онцлог нь аливаа зүйлийг хүрч мэдэрч мэдлэг чадвараа өөрийн болгодог онцлогтой. Физикийн уламжлалт хичээлд бэлэн загвар, хэмжигдэхүүн, томъёо өгч тооцоот бодлого бодуулж томъёог чээжлүүлдэг. Жишээбэл зам, траектор, хурд, дундаж хурдны тухай ойлголтыг танхимд физикийн туршилтын биетийн хөдөлгөөнөөр үзүүлж бэлнээр өгдөг. Сургалтын шинэ хөтөлбөрт суурь боловсролын түвшинд хичээлийг Тогтвортой Хөгжлийн Боловсролтой холбох [1, 2], шинжлэх ухаанч эрэл хайлтын аргаар явуулж, эрэл хайлтын алхамд сургахыг сургалтын зорилт болгон дэвшүүлсэн [2, 3]. Орчин үеийн дидактикт бэлэн загварыг өгөх нь уламжлалт сургалтын аргад хамаарна, харин сурагчдаар загварыг өөрсдөөр нь бүтээлгэхийг чухалчилсан [6]. Загварчлалд сургахыг чухалчилж байгаа хэдий боловч, сурагчдаар хэрхэн загвар бүтээлгэх арга аргачлалын талаар хуримтлуулсан туршлага, судалгаа маш дутмаг байна [7]. Иймд ЭКО-аялал орон нутаг судлал интеграци хичээлийн судалгаанд тулгуурлан Физикийн агуулгыг хичээлийн судалгааны хэлбэрээр жилээс жилд сайжруулан агуулгыг өргөсгөснөөр загварчлах арга зүйг хөгжүүлж байна.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Онолын хэсэг

1.1 Тогтвортой хөгжлийн бодлого, ногоон хөгжил



ТХБ-ын зорилт-4-ийн хүрээнд сурагчдад чанартай боловсролыг хүртээх мөн ногоон хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг бага наснаас нь байгаль дэлхийг хайрладаг, бахархдаг иргэн төлөвшүүлэхийн тулд суурь боловсролын түвшинд “ЭКО аялал Орон нутаг судлал” интеграци хичээлийг зохион байгуулах нь шаардлагатай юм. Тогтвортой хөгжлийн бодлогод хувь нэмэрээ оруулах зорилгоор Орхон аймгийн ЗДТГ, БСУГ-аас 2013-2014 оны хичээлийн жилд санаачлан “Эко аялал-Орон нутаг судлал” интеграци хичээлийг зохион байгуулах эхэлсэн.

“Эко аялал-Орон нутаг судлал” интеграци хичээл: Монгол хэл, газар зүй, математик, хими, физик, биологи, газар зүй, түүх, дүрслэх урлаг, технологи, хөгжим, биеийн тамир, гадаад хэлний хичээлийн агуулгыг багтааж, орон нутгийн байгаль орчин, түүх, соёлын дурсгалт газартай танилцуулах, анги танхимд эзэмшсэн мэдлэгийг хэрэглээ болгох, багаар ажиллах чадварт суралцуулах, сурагчдын авьяас, сонирхлыг нээх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн ЕБС-ийн 8-р ангийн сурагчдад “Эко аялал-Орон нутаг судлал” интеграци хичээлийг тодорхой маршрутын дагуу зохион

байгуулдаг. Үүнд Орхон аймгийн ЕБ-ын сургуулиудын 8-р ангийн сурагчид болон багш, удирдах ажилтан хамрагддаг. Тус хичээлийг зохион байгуулахад Музей, ССАЖГ, ТАЗГ, УЦУОША, “Эрдэнэт” үйлдвэрийн Ил уурхай, Ус цэвэршүүлэх байгууламж зэрэг байгууллагууд хамтарч ажилладаг байна. Үр дүнд нь сурагч бүр ажиглах, турших, тэмдэглэх, тооцоолох, хэмжих, боловсруулах арга барил эзэмшиж, эх орныхоо байгаль, түүх, соёлын дурсгалаар бахархах, хайрлан хамгаалах, зөв зохистой ашиглах арга ухаанд суралцсаар байна. Харин багш нарт сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, хичээл зохион байгуулах шинэлэг арга хэлбэртэй танилцаж, сургалтыг танхимаас гаргах, хүүхэд бүрийн оролцоог хангах, бүтээл бий болгох, хамтран суралцах, хөгжихөд дэмжлэг болохоос гадна хичээлийн судалгааны шинэ хэлбэрийг бий болгож чадсан.

1.2 8-р ангийн сурагчдын Физикийн хичээлээр эзэмшвэл зохих мэдлэг чадвар

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг төлөвшсөн иргэн болж хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн зорилгыг тависан бөгөөд эдгээр чадваруудыг сурагчдад эзэмшүүлэхэд байгалийн ухааны хичээл чухал үүрэгтэй

Бидний судлах сэдвийн хүрээнд:

Агуулга: Жигд хөдөлгөөн-1цаг Дундаж хурд-1 цаг, Хөдөлгөөнийг графикаар илэрхийлэх- 1цаг
Мэдлэг: Хөдөлгөөний харьцангуй чанарыг таних хөдөлгөөнийг үгээр илэрхийлэх, диаграмм ба томъёогоор хөдөлгөөнийг илэрхийлэх, харилцан шилжүүлэх, хувьсах хөдөлгөөнийг жигд хөдөлгөөнтэй адилтгах мэдлэгээ хөдөлгөөний энгийн бодлого бодоход ашиглах

Чадвар: Жигд хөдөлгөөнийг таних, үгээр илэрхийлэх, тайлбарлах, жигд хөдөлгөөнийг томъёолох, графикаар илэрхийлэх, зам хурд хугацааны нэгжийн шилжүүлэг хийх, хурдны утгыг утгачилан уншиж ойлгох

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Бодит хөдөлгөөний ажиглалтаас хөдөлгөөнийг загварчлах” аргачлал

Загвар-1. Тодорхой маршрутын дагуу автобусаар аялахад дундаж хурдыг тооцох аргачлал

Амарын талбайд ⇒ **Найрамдлын өндөрлөг** → **Ус цаг уурын орчны шинжилгээний албанд**
(Эхлэл ба төгсгөл цэг)

Хангалын гол ← Ус цэвэршүүлэх байгууламж **Хүдрийн ил уурхай**

- Анхны цэгээс хөдлөнгүүт хугацаа хэмжигч сурагч эхлэсэн хугацааг харж бусдад мэдээлнэ.
- Зам хэмжигч сурагч машины миллийн заалтыг харж бусдад мэдээлнэ
- Дараагийн цэгт ирээд зогсох үед хугацаа хэмжигч сурагч зогссон хугацааг харж бусдад мэдээлнэ. Эндээс үргэлжилсэн хугацааг сурагчид тооцоолно.
- Зам хэмжигч сурагч машины миллийн заалтыг харж бусдад мэдээлэхэд бүх сурагчид дэвтэрт мэдээлэл тэмдэглэл хөтлөнө.
- Хоёр цэгийн хооронд машин явж байх агшинд спидометрын заалтыг зам хэмжигч сурагч 25км/ц, 15км/ц, 30км/ц, гэх мэт хэлж машины хурдан удааныг өөрөөр хэлбэл агшин зуурын хурдыг тодорхойлно. Энэ нь танхимд эзэмшсэн хурд, эгшин зуурын хурд гэсэн ойлголтуудыг амьдрал практиктай холбож байгаа аргачлал юм.
- Маршрутын дагуу дараагийн цэгт зогсосноос хойш хөдлөх хүртэл хичнээн хугацаа өнгөрснийг мөн хугацаа хэмжигч сурагч эхлэсэн хугацааг харж бусдад мэдээлнэ.
- Дараагийн цэгүүдэд дээрх аргачлалын дагуу тэмдэглэгээг хариуцсан сурагчид бусаддаа мэдээлэл тэмдэглэл хөтлөж явна.
- Аяллын турш дахь тэмдэглэл(өгөгдөл)-ээр хамгийн эцсийн зогсоолд ирж сурагчид аяллын турш дахь автобусны дундаж хурдыг танхимаар эзэмшсэн мэдлэгээ ашиглан олно.
- Сурагчдад зогссон үеийн хугацааг хэрхэн тооцох вэ? Гэдэг асуудал тулгарна. Үүнд багш чиглүүлэг хийж зөвөлгөө өгнө.

Хүрсэн үр дүн-1: Сурагчид автобусаар аяласнаар агшин зуурын хурд, дундаж хурдыг тооцоолж

- Нэгжийн шилжүүлгийг хийж сурсан.
- Танхимаар эзэмшсэн мэдлэгээ бодит нөхцөлд хэрэглэх чадвартай болсон
- Багаар хамтран ажиллаж үр дүнг математик аргачлалаар тооцоолж сурсан
- Математик тооцоолол хийсэн
- Нягт нямбай ажиллаж сурсан
- Маршрутын дагуу дундаж хурдыг тооцоолсон
- Байгаль орчноо хайрлаж хог хаягдлыг байгальд үлдээхгүй байсан

Загвар-2. Явган аялах үед алхамаар дундаж хурдыг тооцох аргачлал

- a) Анхны цэгээс хөдлөнгүүт хугацаа хэмжигч сурагч эхлэсэн хугацааг харж бусдад мэдээлнэ.
- b) Бүх сурагч дараагийн өртөө хүртлэх алхамаа тоолж явна. Дараагийн цэгт очих бүртээ алхамын тоог тэмдэглэж явна.
- c) Дараагийн цэгт ирээд зогсох үед хугацаа хэмжигч сурагч зогссон хугацааг харж бусдад мэдээлнэ. Эндээс үргэлжилсэн хугацааг сурагчид тооцоолно.
- d) Дараагийн цэгүүдэд дээрх аргачлалын дагуу тэмдэглэгээг бүх сурагчид тэмдэглэл хөтлөж явна.
- e) Аялалын турш дахь тэмдэглэл(өгөгдөл)-ээр хамгийн эцсийн зогсоолд ирж сурагчид алхамынхаа дундаж хурдыг танхимаар эзэмшсэн мэдлэгээ ашиглан олно.
- f) Сурагчдын алхамын тоо өөр өөр, хүн бүрийн алхамын хэмжээ харилцан адилгүй байгааг сурагчид ажиглана. Үүнээс шалтгаалан хүүхэд бүрийн дундаж хурд харилцан адилгүй байгаагаас дүгнэлт хийлгэнэ.

Хүрсэн үр дүн-2: Сурагчид явган аяласнаар агшин зуурын хурд, дундаж хурдыг тооцоолоход

- Алхамаар яаж хэмжилт хийх аргачлалд суралцсан
- Алхамаа уртын нэгжрүү шилжүүлж сурсан
- Явган хүний дундаж хурдыг мэдсэн
- Математик тооцоолол хийсэн
- Нягт нямбай ажиллаж сурсан
- Маршрутын дагуу дундаж хурдыг тооцоолсон
- Байгаль орчноо хайрлаж хог хаягдлыг байгальд үлдээхгүй зэрэг чадварт суралцсан

Загвар-3. Усны урсгалын хурд тооцоолох аргачлал

- a) Маршрутын дагуу явж Хангалын гол дээр усны урсгалын хурдыг тооцоходоо намуухан урсгалтай тэгш гадаргатай хэсгийг сонгон эхлэл төгсгөлийн 2 цэг тэмдэглэж олс баригч хүүхдүүдийг зогсооно.
- b) Усны мандалд хөвүүлэх завийг хийхдээ ус нэвчихгүй хөнгөхөн байх материал сонгоно.
- c) Завийг хөвүүлж эхлэхээс зогсох хүртлэх хугацааг хугацаа харагч хүүхэд харж тэмдэглэнэ. Бусад сурагчид ажиглалт хийнэ.
- d) Хэмжигч сурагч олсны уртаар замыг хэмжинэ.
- e) Эдгээр өгөгдлөөс голын урсгалын дундаж хурдыг тооцоолно.
- f) Голын ширүүн урсгалтай хэсгийн урсгалын хурдыг дээрх аргачлалаар тооцоолно.

Хүрсэн үр дүн-3: Сурагчид урсгалын хурдыг тооцоолоход

- Хэмжилт хийх аргачлалд суралцсан
- Секундометртэй ажиллаж сурсан
- Математик тооцоолол хийсэн.
- Нягт нямбай ажилласан.
- Дүгнэлт гаргасан.
- Илтгэх чадвар сайжирсан
- Голын бохирдуулж буй хог хаягдлыг түүж цэврэлсэн.
- Байгаль орчноо хайрлаж хог хаягдлыг байгальд үлдээхгүй зэрэг чадварт суралцсан

Загвар-4. Тодорхой маршрутын дагуу автобусаар аялахад бодит ажиглалтаас загвар бүтээх аргачлал

Амарын талбайд \Rightarrow **Найрамдлын өндөрлөг** \rightarrow **Ус цаг уурын орчны шинжилгээний албанд**
(Эхлэл ба төгсгөл цэг)

Хангалын гол \leftarrow Ус цэвэршүүлэх байгууламж **Хүдрийн ил уурхай**

- j) Эхлэл цэгээс хөдлөнгүүт сурагч бүр хугацаа хэмжигч сурагч speedmeter ашиглан хурдыг хэмжинэ.
- k) Зам хэмжигч сурагч машины миллийн заалтыг харж бусдад мэдээлнэ
- l) Дараагийн цэгт ирээд зогсох үед сурагч зогссон хугацааг харж тэмдэглэнэ. Эндээс үргэлжилсэн хугацааг сурагчид тооцно.
- m) Зам хэмжигч сурагч машины миллийн заалтыг харж бусдад мэдээлэхэд бүх сурагчид дэвтэрт мэдээлэл тэмдэглэл хөтлөнө.
- n) Хоёр цэгийн хооронд машин явж байх агшинд спидометрын заалтыг сурагч 25км/ц, 15км/ц, 30км/ц, гэх мэт машины хурдан удааныг өөрөөр хэлбэл агшин зуурын хурдыг тодорхойлно. Энэ нь танхимд эзэмшсэн хурд, эгшин зуурын хурд гэсэн ойлголтуудыг амьдрал практиктай холбож байгаа аргачлал юм.
- o) Маршрутын дагуу дараагийн цэгт зогсосноос хойш хөдлөх хүртэл хичнээн хугацаа өнгөрснийг мөн эхлэсэн хугацааг харж тэмдэглэнэ.
- p) Дараагийн цэгүүдэд дээрх аргачлалын дагуу сурагчид тэмдэглэл хөтлөж явна.
- q) Аяллын турш дахь тэмдэглэл(өгөгдөл) -ээр хамгийн эцсийн зогсоолд ирж сурагчид аяллын турш дахь автобусны дундаж хурдыг хэрхэн олох вэ? Гэсэн асуудлын дагуу хэлэлцэнэ. Үүнд багш чиглүүлэг хийж зөвөлгөө өгнө.



Хүрсэн үр дүн-1: Сурагчид автобусаар аяласнаар агшин зуурын хурд, дундаж хурдыг тооцоолж

- Нэгжийн шилжүүлгийг хийж сурсан.
- Танхимаар эзэмшсэн мэдлэгээ бодит нөхцөлд хэрэглэх чадвартай болсон
- Багаар хамтран ажиллаж үр дүнг математик аргачлалаар тооцоолж сурсан
- Математик тооцоолол хийсэн
- Нягт нямбай ажиллаж сурсан
- Маршрутын дагуу дундаж хурдыг тооцоолсон
- Хоромхон хурд дундаж хурдыг ялгаж, загварчлах аргад суралцсан.
- Байгаль орчноо хайрлаж хог хаягдлыг байгальд үлдээхгүй байсан.

ГУРАВДУГААР ХЭСЭГ: Сурагчдын мэдлэг чадварт гарч буй ахиц амжилтыг тооцох

Судалгааны зорилго: ЭКО-аялал орон нутаг судлал интеграци хичээлээр сурагчид бодит ажиглалтаас хөдөлгөөнийг загварчлахад гарч буй өөрчлөлтийг илрүүлэх

3.1 2014,2015 оны ЭКО-аялал - Мэдлэгийг батлаж, нотлох



2016, 2017 оны ЭКО аялал -ШУЭХ-ын бүтэцчилсэн эрэл хайлтын алхам

Ажлын хуудас

Ангн _____ Нэр _____

Ахлам-1: Хэмжээ

1-р шөвгөө 2-р шөвг хүрэхэд зайг хэмээн үү?

a) Хугацаа _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

b) Зайг _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

1-р шөвгөө 3-р шөвг хүрэхэд зайг хэмээн үү?

a) Хугацаа _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

b) Зайг _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

1-р шөвгөө 4-р шөвг хүрэхэд зайг хэмээн үү?

a) Хугацаа _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

b) Зайг _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

1-р шөвгөө 8-р шөвг хүрэхэд зайг хэмээн үү?

a) Хугацаа _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

b) Зайг _____ Эхлэл _____ Төгсгөл _____ Ургэлжлэх _____

Геошолол _____

Ахлам-2: Усны ургалын хураамт тооцоолох

№	Биег	Зай	Эхлэх аугаана	Дуусах аугаана	Ургэлжлэх аугаана	Ургалын хура
1						
2						
3						

Ахлам-3: Ахламын тухай тэмдэглэл

2018 оны ЭКО аялал-ШУЭХ-ын чиглүүлэгтэй эрэл хайлтын алхам

Ажлын хуудас

Ангн _____ Нэр _____

Ахлам-1: Хэмжээ


№	Ахламын шат	U	S	t	v
1					
2					
3					
4					
5					

Ахлам-2: Speedometr-ийг хэрхэн ажигласан бэ? Мөн түүнийг ажиглахад юу ажиглагдсан бэ?

Ахлам-3: Ахламын тухай тэмдэглэл

3.2 Сурагчдын мэдлэг эзэмшилтийг үнэлэхэд

График-1



Дүгнэлт-1: ЭКО-аялал орон нутаг судлал интеграци хичээлээр сурагчид дундаж хурд сэдвийн мэдлэг эзэмшилтийн түвшин 2018 онд ахисан нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

1. Эко -аялал орон нутаг судлал интеграци хичээлээр бодит үзэгдлийг загварчлах арга зүйгээр олон талаас нь судлан сурагчдаар өөрсдөөр нь үйлдүүдэх мэдлэг бүтээлгэх, хичээлүүдийг интеграцчилах боломжтойг илрүүлсэн. Иймд хичээлийг судалгаатай холбосноор хичээлийг явуулах, судлах арга туршлага хуримтлуулав.
2. Хичээлийн явцад хийсэн бодит хөдөлгөөний ажиглалтаас физик ойлголтын талаар шинэ мэдлэг бүтээх, шинжлэх ухаанч эрэл хайлтын алхамд сургах, физик ойлголтын талаар өөрсдөө мэдлэг бүтээх, загвар бүтээх боломжтой. Үүнийг сурагчдын эзэмшсэн мэдлэгийн ахиц, сонирхол идэвх эрс дээшилсэн.
3. Бодит ажиглалтыг лабораторийн туршилттай холбосноор хичээлийг прагматчилах боломж улам нээгдэж, бодит амьдралыг хичээлтэй холбох, тогтвортой хөгжил, шинжлэх ухаанч хандлага төлөвшүүлэхэд тус болно гэж үзэж байна.
4. Физикийн хичээлийг ингэж явуулснаар бидэнд бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээний чадварт өсч ШУАБ-д суурилсан сургалтын хэлбэртэй ойртож байна.

Дэвшүүлж буй шинэ санаа

1. Эко -аялал интеграци хичээл нь олон хичээлийн агуулгыг контекстэд суурилан хөгжүүлэх, уялдуулж интеграцчилах өргөн боломж байгааг бид олж харсан. Үүнд биеийн тамирын хичээлтэй-Спортын хурд тодорхойлох, Газарзүйн хичээлтэй-Аялалын маршрутыг газрын зурагт дүрслэх гэх мэт
2. Физикийн судлагдахууны хувьд ирээдүйд хурдсах удаашрах хөдөлгөөн, түүнийг илэрхийлэх хэмжигдэхүүн, кинетик потенциал энергийн тухай санаа гаргах суурь ажиглалт, хөрс болох юм.

Талархал

Хүүхдийг хөгжүүлэх, чадваржуулахад багш бүр өөр өөрийн гэсэн арга, аргачлалтай байдаг. Иймд багш бүр өөр өөрийн арга туршлагыг хуваалцаж байх нь хамгийн чухал бөгөөд бидэнд арга туршлагаа хуваалцах боломжийг олгож байгаа БМДИ-ийн хамт олонд талархал дэвшүүлье. Мөн

сурагчдад танхимаар олж авсан мэдлэг чадвараа хэрэглэж, туршиж боломжийг олгодог ЭКО аялал-интеграци хичээлийг санаачлан зохион байгуулагч Орхон аймгийн БСУГ-ын удирдлагууд мөн дэмжин ажилладаг ЗДТГ болон бусад байгууллагуудадаа талархал илэрхийлье.

Ном зүй

1. БСШУЯ. Тогтвортой хөгжлийн бодлого -2030. УБ. 2015.
2. БСШУЯ. “Суурь боловсролын цөм хөтөлбөр”. УБ., 2015.
3. БСШУЯ. Суурь боловсролын физикийн хичээлийн суралцахуйн удирдамж. УБ., 2015
4. БСШУЯ. Чанартай боловсрол хөгжлийн баталгаа. УБ., 2001. хх. 42-44, 251, 252.
5. БСШУЯ., Жайка. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй. УБ., 2016.
6. Бурмаа Б. Физик дидактик. 2012.
7. Бурмаа Б., Даваасамбуу Ж., Ганбат М., Дулмаа А., Дөлгөөн Ж. Физик дидактик УБ., 2016.
8. Бурмаа Б., Ганбат М. Физик 1, 2002. х. 13.
9. Ганбат М., Амартайван Ц., Амаржаргал Э., Батболд Х., Дөлгөөн Ж., Мөнхсайхан Я., Пүрэвжсал Б. Багшийн ном. Физик 9, УБ. 2015. х. 7
10. Ганбат М., Бурмаа Б., Дөлгөөн Ж. Багшийн ном. Физик 7, УБ. 2015. хх. 17-24. хх. 24-28.
11. БМДИ. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага, УБ., 2018. х. 57
12. БСШУЯ., Жайка. Контекст төвтэй сургалтаар мэдээлэл харилцааны цогц чадамж төлөвшүүлэх арга зүй. Зөвлөмж III. “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” Жайка. УБ., 2009. х. 31.
13. “Боловсрол судлал”. УБ., 2013 /01/02/
14. МУИС. Орхон сургууль “Эрдэм шинжилгээний бичиг”. УБ., 2014.
15. Мягмар О. Судлаач багшийн гарын авлага. УБ., 2009.

Хавсралт-1

Орхон аймгийн “Эрдэнэт” цогцолбор сургуулийн “ЭКО”- хичээлд ашиглах хэрэглэгдэхүүнүүд

\	Мэргэжил	Мэргэжлийн багш нар нэр	“ЭКО”- хичээлд бэлтгэх зүйл
1	Монгол хэл, уран зохиол	Батзул, Н.Тунгалаг	Тэмдэглэл хөтлөх үзэг, дэвтэр
2	Математик	Б. Цэнд, Бадамцэцэг	10 м олс А метр
3	Англи хэл	Энхмаа, Ш.Хүрэлбаатар, Хандсүрэн, Б. Туяа	Аяллын тухай орос, англи үгийн цуглуулга
4	Физик	Ж.Эрдэнэбулган, Ж.Шинэчимэг	Цаасан завь баг бүр 2ш, модон метр 1 ш, 10 м олс, цаг хэмжигч
5	Хими	Э.Гантуяа	Усны дээж хийх вакусны шил 2ш баг бүр
6	Технологи, зураг зүй	Ө.Ганзориг, Ч.Оюунбаатар, Хандхүү	Ус цэвэрлэх байгууламжийн мэдээлэл, Зургийн дэвтэр харандаа, усан будаг
7	Биологи	Г.Уранцэцэг	Хөрсний дээж хийх гялгар үдээстэй уут 4ш, орчны экологийн тэмдэглэл хийх дэвтэр
8	Газар зүй	Б.Ёндонсамбуу	Хүрз 4ш, хүүхэд бүр трансфортертэй шугам план зураг зурах зургийн дэвтэр, шугам, баллуур, харандаа
9	Эрүүл мэнд	Д.Уртнасан	Цаг агаараас шалгаалж өмсөх дулаан хувцас, маск
10	Түүх, нийгэм	Б. Амартүвшин	Өндөрлөг ба Бөхөнгийн өврийн хэрэгсүүрийн тухай мэдээлэл
11	Биеийн тамир	Х.Эрдэнэбилэг	Чанга яригч, секундмер, шүгэл. Хүүхэд бүр 1ш сонин, гялгар уут 1ш
12	Дуу хөгжим	Нинжбадгар	Анги бүрд 1ш CD, Дууны бичлэг 2ш, дууны үгийг хүүхэд бүрд

Баг ба сурагчдын бэлтгэх зүйл

Хүүхэд бүр:Баг бүр:

- | | |
|--|--------------------|
| 1. Маск | 1. Цаасан завь 2ш |
| 2. Цагаан футболк | 2.вакусны шил 2ш |
| 3. Ногоон галстук | 3.хогийн уут 2ш |
| 4. 40 жил тэмдэг | 4. Үдээстэй уут 4ш |
| 5. 24 хуудастай дэвтэр | |
| 6. Үзэг, бал | |
| 7. Харандаа | |
| 8. Бүтэн сонин, гялгар уут | |
| 9. трансфортертэй шугам, хүндрүүлэгчтэй | |
| 10. зургийн дэвтэр, харандаа, усан будаг | |

“Эко” аялалд оролцох анги хамт олон, багш нарын үйл ажиллагааны төлөвлөлт

Аялалын эхэнд:

Бүх ангиуд: Ногоон галстук, цагаан подволкоор жигдэрнэ. Ангиуд хаягаа барьж жагссан байна.

Аялалын явцад:

- /Монгол хэл/ аян замын тэмдэглэл хөтөлнө.
- /Биений тамир/ аялалын үйл ажиллагаанд баримтлах дэгд суралцана.
- /Англи, орос хэл/ Аялалд хэрэглэх түгээмэл үг хэллэгт суралцана.
- /Хөгжим/ Эрдэнэтийн тухай 1-2 дуу дуулж сурна. Орон нутгийн дууны сан бүрдүүлнэ.
- Бүх ангиуд: Зогсоол хоорондын хугацаа, зайг тогтмол хэмжиж явна. Дундаж хурд олно.

1. Найрамдлын талбайд:

- Анги бүлгээр жагсаж, аяллын дэг танилцуулна.
- Хуваарийн дагуу автобусанд сууж, танилцуулж холбогдох материал тарааж өгнө.

2. Ус цаг уурын орчны шинжилгээний албанд:

- Бүх ангиуд: Цаг уурын багаж хэрэгслэлтэй танилцана. Тэмдэглэл хийнэ.
- Хөрсний лабораторийн үйл ажиллагаатай танилцана.

3. Эрдэнэтийн овоонд:

Бүх ангиуд:

- Овоог босгосон чулуулагтай танилцаж, хүдэр, эрдэс, чулуулгийн ялгааны талаар мэдээлэл авна.
- Агаарын урсгал, Эрдэнэт хот орчмын гадаргын ерөнхий төрх ажиглаж, тэмдэглэл хөтөлнө.
- Газарзүйн план зургийн дүрслэл үйлдэнэ. /Эрдэнэт орчмын/

1, 3 дугаар баг:

- Ургамлын бүрдлийг ажиглаж, хатаадас хийнэ.

2, 4 дүгээр баг:

- Хөрсний дээж авах, орчин тодорхойлох

4. Хүдрийн ил уурхайд:

Бүх ангиуд:

- Уулын үйлдвэрийн нөхөн сэргээлттэй танилцана.
- Хүдрийн ил уурхайн дамжлагыг ажиглаж, тэмдэглэл хөтөлнө.

1, 3 дугаар баг:

- Сүүдрийн урт хэмжиж, тэмдэглэл хийнэ.

2, 4 дүгээр баг:

- Трансфортироор нарны тусгалын өнцөг хэмжиж, тэмдэглэж авна.

5. Хиймэл нуур буюу хаягдлын аж ахуйд:

1, 3 дугаар баг:

- Усны төлөв, нуур орчмын хүн, амьтан, ургамлын орчин ажиглаж тэмдэглэл хөтөлнө.

2, 4 дүгээр баг:

- Хөрсний бүтэц, өнгө, орчин тодорхойлно.

Бүх ангиуд:

- Хаягдлын аж ахуй, түүний хамгаалалтын талаар мэдээлэл авна.

6. Бөхөнгийн нурууны өвөрт:

2, 4 дүгээр баг:

- Ойн ургамал, амьтдын бүрдэл, нас, дасан зохилдлогоог ажиглаж тэмдэглэл хөтөлнө.

1, 3 дугаар баг:

- Хөрсний бүтэц, өнгө, орчин тодорхойлно.

Бүх ангиуд:

- Гол, горхины эх, хөндийн бүтэцтэй танилцана.
- Урсгалын хурд тодорхойлно.

7. Бөхөнгийн өврийн түрэг булшинд:

Бүх ангиуд:

- Булш, хиргисүүрийг ажиглан ялгаатай ба төсөөтэй шинжийг гаргаж, дүгнэнэ.
- Булш хиргисүүрийн хүрээний уртыг хэмжиж талбайг тооцоолон гаргах
- Булш хиргисүүрийг хамгаалах зорилгоор хашаа хайс барихад шаардагдах материалн тооцоо гаргах
- Ургамлын хатаадас, шавжийн цуглуулга хийнэ.
- Байгалийн судалбар зураг зурна.

8. Хиймэл нуурын зүүн хэсэгт:

1, 3 дугаар баг:

- Усны төлөв, нуур орчмын хүн, амьтан, ургамлын орчин ажиглаж тэмдэглэл хөтөлнө.

2, 4 дүгээр баг:

- Хөрсний бүтэц, өнгө, орчин тодорхойлно.

Бүх ангиуд:

- Бодис шүүх аргатай танилцаж, холимог, дан бодисын аль нь болохыг тодорхойлно.

9. Ус цэвэрлэх байгууламжид:

Бүх ангиуд:

- Ус нийлүүлэх болон цэвэршүүлэх үйл ажиллагаатай танилцаж, ус цэвэрлэх байгууламж, байгаль орчны нөлөөллийн талаар дүгнэлт бичнэ.
- Ус цэвэршүүлэх технологитой танилцаж, үйлдвэрлэлийн дараалал бичнэ.

10. Дулааны цахилгаан станцад:

Бүх ангиуд:

- Автобус дотроос ажиглалт хийж, хөтөч багш мэдээлэл өгнө. Үйлдвэрлэлийн онцлог, нүүрсний хэрэглээ, утаа шүүх арга хэлбэрийн талаар.

11. Хивсний үйлдвэр:

Бүх ангиуд:

- Автобус дотроос ажиглалт хийнэ. Хөтөч багш жилд хэрэглэх усны хэрэглээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл өгнө.

12. Найрамдал өндөрлөг дээр:

Бүх ангиуд:

- Өндөрлөгийн булш, хиргисүүртэй танилцан Бөхөнгийн өврийн булш, хиргисүүртэй харьцуулж тэмдэглэл хөтөлнө.

1, 3 дугаар баг:

- Сүүдрийн урт хэмжиж, тэмдэглэл хийнэ.

2, 4 дүгээр баг:

Трансфортироор нарны тусгалын өнцөг хэмжиж, тэмдэглэж авна.

Туршилт ажлын дэвтэр ашиглан суралцагчдад шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэх нь

Б.Тунгалаг

Өмнөговь аймаг Цогтцэций сумын 6-р сургууль

Утас: 89111711, e-mail: tungalag.b@dreamschool.edu.mn

УДИРТГАЛ

Сэдвийг сонгосон үндэслэл

Монгол улсын боловсролын шинэчлэл болон дэлхий нийтээр бодит чадвар бүхий суралцагчийг бэлтгэх чиг хандлагатай болсон юм. Физикийн хичээлээр суралцагчдад шинжлэх ухаанч арга барилыг эзэмшүүлэхийн тулд багш өөрийн гэсэн арга зүйг боловсруулсанаар суралцахуйг илүү үр дүнтэй болно.

Иймээс боловсролын салбарт хэрэгжүүлж буй чанарын шинэчлэлийг одоо дээрээс нь биш, харин доороос нь хийж эхлэх хэрэгтэй болжээ. Өөрөөр хэлбэл багш нар орчин үеийн онол, үзэл баримтлалуудад баримжаалан өөрсдөө хөтөлбөр, арга зүй боловсруулан турших замаар эрэл хайгуул хийж, улмаар хуримтлуулсан туршлага дээрээ тулгуурлан багшлах арга зүйгээ өөрөө шинэчлэн бүтээх хэрэгтэй байгаа юм.

Хичээлийн санаа


Суралцагчдын сурахуйн хэв шинжийг тодорхойлж, тэдгээрт тохируулан туршилт ажлаар шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэх нь суралцахуйн үр дүнд эерэг өөрчлөлт гарах боломжийг бүрдүүлнэ.

Хичээлийн бэлтгэл судалгаа


1. Суралцагчдын оюуны чадвар, мэдээллийг хүлээн авах болон мэдээлэлд боловсруулалт хийх хэв шинжийг урьдчилан тодорхойлох шат.

Нейл Флеминг-ийн боловсруулсан асуулга (VAK)-ыг хэрэглэн нийт суралцагчдын хараа-сонсгол-мэдэрхүйн хэв шинжийг судлахад /нийт 306 хүүхэд хамрагдсан/


Мэдээлэл хүлээн авах хэв шинжийн судалгаа



✍ Швейцарийн сэтгэл зүйч К.Юнгийн боловсруулсан асуулгаар бие хүний темпераментыг тодорхойлоход /нийт 306 хүүхэд хамрагдсан/



✍ Хоней Мамфорд нарын боловсруулсан асуулгыг хэрэглэн суралцагчдын сурахуйн хэв шинжийг тодорхойлоход /нийт 306 хүүхэд хамрагдсан/



Дүгнэлт: Судалгаанаас харахад сурагчдын 42% нь биеэр үйлдэж мэдээллийг хүлээн авдаг, 32% нь прагматикч буюу үйлийн мэдлэг, хэрэглээтэй холбоотойгоор мэдээлэлд боловсруулалт хийх

сонирхолтой болохыг харуулж байна. Иймээс судалгаан дээр үндэслэн туршилт судалгааны ажил буюу биеэр үйлдэн мэдлэг олгох арга зүйг сонгосон болно.

2. Туршилт ажлын дэвтэр боловсруулах шат:

Туршилт ажлын дэвтрийн бүтэц

Туршилт ажлын дэвтэр нь суралцагчдад шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэхүйц алхамуудтай, логик дараалалтай байна. Үүнд:

1. **Туршилтын сэдэв** – туршилтын агуулгатай нийцэхүйц, суралцагчдын сонирхлыг татахаар үг хэллэгийг сонгон сэдвийг тогтооно
2. **Туршилт ажлын зорилго** – суралцагч уг туршилтыг хийж гүйцэтгэсэнээр агуулгын хүрээнд юуг сурч, мэдэхийг тоймлон тодорхойлно
3. **Хэрэглэгдэх зүйлсийн жагсаалт** – туршилтанд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, гарын доорх материалиудыг хэлбэр хэмжээ, өнгө, тоо ширхэгээр нь ялган бичнэ
4. **Таамаглал дэвшүүлээрэй** – тухайн туршилт ажлын талаарх өмнөх төсөөлөл, асуудлыг тодорхойлох зорилготой асуулт даалгавар байна.
5. **Туршилт ажлыг гүйцэтгэх дараалал** – туршилтыг гүйцэтгэх алхам бүрийг тоочин бичнэ. Зарим тохиолдолд суралцагч бие даан туршилт ажлыг төлөвлөх боломжтой байдлаар бэлтгэнэ.
6. **Боловсруулалт, үр дүн** – туршилт ажлын ажиглалт, хэмжилтийн үр дүн, дүгнэлтийг тэмдэглэх хэсэг юм. Ажиглалт, хэмжилтийн үед өөрчлөгдөх ба өөрчлөгдөхгүй хэмжигдэхүүнийг ялган тэмдэглэж, үр дүнгээ зураг, график, диаграм, бичгээр илэрхийлэх зэрэг олон хэлбэртэй байна.
7. **Санамж** – туршилт ажлын үед гарч болзошгүй эрсдлийг тооцсон аюулгүй ажиллагааны дүрэм байна.

Физикийн хичээлээр 7-9 ангийн сурагчдад эзэмшүүлэх мэдлэг, чадварын хүрээнд боловсруулсан туршилт ажлын дэвтэр ашиглалтыг дараах диаграммаар харууллаа





Туршилт ажлын дэвтэрийн зураг

Суурь боловсролын цөм хөтөлбөрийг судалан үнэлгээний шалгуур гаргах шат
Байгалийн ухааны хичээлийн суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн гол үзэл санаа

“Сурагч нь байгалийн юмс үзэгдлийг танин мэдэх арга барилаа хөгжүүлж, тасралтгүй суралцдаг, хүрээлэн буй орчиндоо ээлтэй, түүнийг хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулдаг иргэн болж төлөвшинө” гэсэн зорилгын хүрээнд суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжих юм.

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт байгалийн ухаан хичээлээр суралцагчид шинжлэх ухаанч арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшихээр тусгасан байна.

Чадвар	VI-VII анги	VIII-IX анги
Асуудал таамаглал дэвшүүлэх	Өмнөх төсөөлөл болон ажиглалтанд суурилан байгалийн юмс, үзэгдэл, түүний өөрчлөлтийн талаар асуулт асуух; Таамаглах; Тулгарч буй асуудлын талаар санал бодлоо илэрхийлэх;	Баримт нотолгоо, шинжлэх ухааны мэдлэгт суурилан байгалийн юмс, үзэгдлийн учир шалтгаан, зүй тогтлыг эрэлхийлсэн асуулт асуух; Таамаглал дэвшүүлэх; Зайлшгүй шийдвэрлэх асуудлыг томъёолон хэрэгцээг тодорхойлох;
Шинжлэн судлах ажлыг төлөвлөх	Асуудлаа шийдвэрлэх, таамаглалаа батлах ажлын дарааллыг багштайгаа хамтран төлөвлөх; Ажиглалт, туршилтын үед өөрчлөгдөх хэмжигдэхүүнийг ялган таних; Хэрэглэх багаж хэрэгслийг нэрлэж сонгох; Аюулгүй ажиллагааны талаар эргэцүүлэн бодох;	Асуудлыг шийдэх, таамаглалаа шалгах ажлын төлөвлөгөө гаргах; Сорил туршилтын үед тогмол болон хувьсах хэмжигдэхүүнийг сонгох; Ашиглах тохиромжтой багаж төхөөрөмжийг сонгож үндэслэлээ тайлбарлах; Туршилтын явцад тохиолдож болох эрсдлийг тооцох, үнэлэх;
Баримт нотолгоо гаргах, тайлагнах	Ажиглалт, туршилт, хэмжилтийг нягт нямбай хийх; Ажиглалт, тэмдэглэл, хэмжилтийн үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, багана диаграм, шугаман графикаар илэрхийлэх;	Ажиглалт, туршилт, хэмжилтийг зөв хийж хянах, шаардлагатай тохиолдолд давтан хийх; Ажиглалт, тэмдэглэл, хэмжилтийн үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, математик статистик диаграмаар илэрхийлэх;
Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, үнэлэх	Ажиглалт, туршилт, мэдээлэл боловсруулах явцыг таамаглалтай тохирч буй эсэхийг нягтлах; Өөрийн алдааг олж түүнийг засах санааг дэвшүүлэх; Үр дүнгээс дүгнэлт гаргах; Ажиглалт, туршилтыг сайжруулах санаа дэвшүүлэх;	Ажиглалт, туршилт, мэдээлэл боловсруулах явцыг байгалийн ухааны хэл ашиглан танилцуулж, таамаглалтай тохирч буй эсэхийг тодорхойлж үнэлэх; Өөрийн болон бусдын алдааг олж засах; Ажиглалт, туршилтыг сайжруулах шинэ санаа, хувилбарыг дэвшүүлэх;




Үнэлгээний шалгуур

Эзэмших чадвар	Үнэлгээний шалгуур үзүүлэлт				
	5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо
Асуудаг, таамаглал дэвшүүлэх	<ul style="list-style-type: none"> Баримт нотолгоонд тулгуурлан учир шалтгаан, зүй тогтлыг эрэлхийлсэн асуулт асууж байвал Асуултыг бүтэн өгүүлбэрээр нээлттэй асуулт асууж байвал Тулгарч буй асуудлын талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байвал 	5 онооны шалгуурт хүрэхгүй 3 онооны шалгуур үзүүлэлтээс дээгүүр байвал	<ul style="list-style-type: none"> Өмнөх төсөөлөл болон ажиглалтандаа тулгуурлан асуулт асууж байвал Асуултыг бүтэн өгүүлбэрээр асууж байвал Үзэл бодлоо бусдын дэмжлэгтэйгээр илэрхийлж байвал 	3 онооны шалгуурт хүрэхгүй 1 онооны шалгуур үзүүлэлтээс дээгүүр байвал	<ul style="list-style-type: none"> Ажиглалтанд тулгуурлан асуулт асууж байвал Хаалттай асуулт асууж байвал Үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байвал
Шинжлэн судлах ажлыг төлөвлөх	<ul style="list-style-type: none"> Ажлын дарааллыг бие дан төлөвлөж чадаж байвал Туршилтанд хэрэглэгдэх багаж хэрэгсэлээ нэрлэж, зөв сонгож байвал Аюулгүй ажиллагааны дүрмийг оновчтой боловсруулж байвал 		<ul style="list-style-type: none"> Ажлын дарааллыг бусдын тусламжтайгаар төлөвлөж чадаж байвал Туршилтанд хэрэглэгдэх багаж хэрэгсэлээ зөв сонгож байвал Аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж байвал 		<ul style="list-style-type: none"> Ажлын дарааллыг оролдож байвал Туршилтанд хэрэглэгдэх багаж хэрэгсэлээ бусдын тусламжтай нэрлэж байвал Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах чадвар сул байвал
Баримт нотолгоо гаргах, тайлагнах	<ul style="list-style-type: none"> Ажиглалт, туршилт, хэмжилтийг нягт нямбай хийж байвал Үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, диаграмм, графикаар илэрхийлж байвал Бусдад бүтэн өгүүлбэрээр оновчтой илэрхийлж байвал 		<ul style="list-style-type: none"> Ажиглалт, туршилт, хэмжилтийг зааврын дагуу хийж байвал Үр дүнг бичвэр, зураг, хүснэгтээр илэрхийлж байвал Үр дүнг бусдын дэмжлэгтэйгээр илэрхийлж байвал 		<ul style="list-style-type: none"> Ажиглалт, хэмжилт, туршилтыг бусдын тусламжтай хийж байвал Үр дүнг зөвхөн бичвэрээр илэрхийлж байвал Үр дүнгээ бусдад илэрхийлэх чадвар сул байвал
Баримт нотолгоо ба үр дүнг нягтлан үнэлэх	<ul style="list-style-type: none"> Туршилтын үр дүн таамаглалд тохирч байгаа эсэхийг нягтлаж байвал Өөрийн болон бусдын алдааг олж түүнийг засах туршилтыг сайжруулах санаа дэвшүүлж байвал 		<ul style="list-style-type: none"> Туршилтын үр дүнг нягтлаж байвал Өөрийн алдааг олж түүнийг засах санаа дэвшүүлж байвал 		<ul style="list-style-type: none"> Туршилтын үр дүнг хянах оролдлого хийж байвал Алдааг илрүүлэх чадвар сул байвал

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл

1. Туршилт ажлыг явуулах

Ээлжит хичээл тус бүр дээр суралцагчдад “Туршилт ажлын дэвтэр”-ийг ажиллуулах, ажиглалт тэмдэглэл хөтлөх, сайжруулах



2. Туршилт ажлын технологийн картыг бэлтгэх

Энэхүү технологийн картыг бэлтгэсэнээр бусдад арга зүйгээ танилцуулах, заавар зөвлөгөө өгөхөд дөхөм болох үүднээс багш дараах бүтцийн дагуу бэлтгэсэн. Үүнд:

- Таамаглал дэвшүүлэх асуулт
- Зорилго
- Санамж
- Хэрэглэгдэх зүйлс
- Үйл ажиллагаа
- Дүгнэлт
- Багшид өгөх зөвлөгөө
- Ажлын хуудас

<p>Байгалийн ухааны туршилт</p> <p>Сэдэв: Зэрэгцээ холболтын үеийн гүйдлийн үүс</p>	<p>Ангийн гэрэл цуваа холболттой болов уу? Зэрэгцээ холболттой болов уу?</p> 	<p>Зорилго: Зэрэгцээ холболт, түүгээр гүйдлийн хүчийг тодорхойлох</p> <p>Санамж: Халхэвнэ түлхүүрийг заавал угсраарай ✓ Түлхүүрийг залгахын өмнө халхэвэ шалгуулаарай</p>	<p>Хэрэглэгдэх зүйлс:</p> 	<p>Үйл ажиллагаа 1: Хоёр чийдэнг зурагт үзүүлсэнээр зэрэгцээ холбоно</p> 
<p>Үйл ажиллагаа 2: Хараар тэмдэглэсэн I цэгт амперметрийг холбон гүйдлийн хүчийг тэмдэглэж авна</p> 	<p>Үйл ажиллагаа 3: Хараар тэмдэглэсэн II цэгт амперметрийг холбон гүйдлийн хүчийг тэмдэглэж авна</p> 	<p>Үйл ажиллагаа 4: Хараар тэмдэглэсэн III цэгт амперметрийг холбон гүйдлийн хүчийг тэмдэглэж авна</p> 	<p>Үйл ажиллагаа 5: Хараар тэмдэглэсэн IV цэгт амперметрийг холбон гүйдлийн хүчийг тэмдэглэж авна</p> 	<p>Дүгнэлт: Зэрэгцээ холболтын үед гүйдлийн хүч хэрэглэгч бүр дээр салаална</p> 


Технологийн картын загвар

Судалгааны үр дүн


Туршилт ажлын дэвтрийг ашиглан хичээлийг туршилттайгаар зохион байгуулсанаар сурагчдын чадвар ба мэдлэгт гарсан ахиц, амжилтыг харууллаа

2015 – 2016 оны хичээлийн жил

- 7-8-р ангийн нийт 114 сурагчийн чадварын үнэлгээний дундаж үзүүлэлт **5,3%** -аар ахисан байна.




ангийн нийт 114 сурагчийн мэдлэг эзэмшилтийн үнэлгээний дундаж үзүүлэлт **12.3%** -аар ахисан байна.




2016 – 2017 оны хичээлийн жил

- 8 – 9-р ангийн нийт 99 сурагчийн чадварын үнэлгээний дундаж үзүүлэлт **8.7%** -аар ахисан байна.




- 8 – 9-р ангийн нийт 99 сурагчийн мэдлэгийн үнэлгээний дундаж үзүүлэлт **14.8%** -аар ахисан байна.




2017 – 2018 оны хичээлийн жил


- 8 – 9-р ангийн нийт 93 сурагчийн чадварын үнэлгээний дундаж үзүүлэлт **9.5%** -аар ахисан байна.



- 8 – 9-р ангийн нийт 93 сурагчийн мэдлэгийн үнэлгээний дундаж үзүүлэлт **17.8%** -аар ахисан байна.



- 2015–2016 он, 2016–2017 он, 2017–2018 оны хичээлийн жилүүдийн сурагчдын чадварын үнэлгээг графикаар харууллаа /нийт 7-9-р ангийн 306 сурагч/



- 2015–2016 он, 2016–2017 он, 2017–2018 оны хичээлийн жилүүдийн сурагчдын мэдлэгийн үнэлгээг графикаар харууллаа /нийт 7-9-р ангийн 306 сурагч/



Дүгнэлт: Чадварыг шалгуурын дагуу үнэлж дүгнэхэд суралцагчдын асуудал таамаглал дэвшүүлэх чадвар 3%, шинжлэн судлах ажлыг төлөвлөх чадвар 4%, баримт нотолгоо гаргах, тайлагнах чадвар 3%, баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, үнэлэх чадвар 6%-аар ахисан үзүүлэлт ажиглагдаж байна. Иймээс

“Туршилт ажлын дэвтрийг ашиглан суралцагчдад судалгаа хийх арга барил эзэмшүүлэх арга зүй”-г хэрэгжүүлсэнээр суралцагчдын чадварт дундажаар 3 жилийн хугацаанд **4%**-иар ахиц гарсан байна.

Суралцагчдын мэдлэгийг үнэлж дүгнээд оношилгооны шалгалттай харьцуулахад **5%**-иар ахисан байна. Энэ нь суралцагчдад шинжлэх ухаанч арга барилыг тодорхой хэмжээнд эзэмшүүлж чадсантай холбоотой гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Тодорхой туршилтын ажлын агуулга, түүгээр эзэмших мэдлэгээс гадна шинжлэх ухаанч эрэл хайлтын алхмаар ажлыг төлөвлөж чадвал физикийн мэдлэг төдийгүй физикийн тухай мэдлэг, чадвар олгох боломжтойг харуулав. Энд туршилтын ажлын дэвтэр онцгой үүрэг гүйцэтгэнэ. Энэ талаар цаашид нарийвчлан судлах шаардлагатай.

Судалгааны ажлын шинэ санаа

Туршилт ажлын дэвтэр ашиглан суралцагчдад шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэх арга зүй нь суралцагчдаа судлан, оюуны циклын загварыг шинжлэх ухаанч арга барил эзэмших явцтай холбож хичээлийг зохион байгуулсанд оршино.

Яагаад сайн хичээл болсон бэ?

- Даалгаврын түвшин, тавил ба түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төрөл зэргийг суралцагчдад давамгайлж буй мэдээллийг хүлээн авах болон мэдээлэлд боловсруулалт хийх хэв шинжэд нийцүүлсэн нь суралцагчдын оролцоог нэмэгдүүлсэн
- Туршилт ажлаар судалгаа хийх арга барил эзэмшүүлэх үйл явцад суралцагчдын оюун ухааныг “Сельф-систем – Метакогнитив систем – Когнитив систем – Метакогнитив систем – Сельф-систем” гэсэн циклээр ажиллуулж суралцах үйлийг дэмжсэн учраас суралцахуй бүхэлдээ суралцагчийн үйлийн төвтэй өрнөсөн.
- Суралцахуйн үр дүнг суралцагчийн мэдлэг, чадварыг нэгтгэн үнэлсэн учраас суралцахуйн эргэх холбоо сайжирсан.

Ном зүй

1. Суурь боловсролын цөм хөтөлбөрийн гарын авлага. (2015). УБ.
2. Батболд,Д, Алимаа,Б, Уугантуяа,Г. (2013). Боловсролын зорилгын таксаномийн хөгжил. Боловсрол судлал сэтгүүл №7.
3. Бурмаа,Б, Батболд,Д, Гэндэнжамц,С. (2013). Байгалийн ухааны хичээлийн даалгаварт гарч буй шинэчлэл. УБ.
4. Бурмаа,Б, Н. Д. (1998). Сургалтын сэтгэл судлалын үндэс. УБ.
5. Д.Батболд. (2016). Даалгавраар суралцагчдын оролцоог хангаж, сурах үйлийг дэмжих арга зүй. УБ.

“Дуу авианы өнгө” ээлжит хичээлийн арга зүйг сайжруулсан туршлага

*А.Дэмбэрэлнямбуу¹, П.Пүрэвдорж¹, М.Тувшинзаяа¹, Н.Баярсайхан¹
/ Сүхбаатар дүүргийн Шинэ-Үе бүрэн дунд сургуулийн сургалтын менежер,
Физикийн багш, Химийн багш, Химийн багш /*

Хураангуй

Зорилго: Энэхүү судалгаат хичээлээр бүдүүн, нарийн, чанга ба сул дууг энгийн туршилт хийж ялган ангилах, дууны эдгээр шинж чанарын тухай шинжлэх ухааны үг хэллэг эзэмшүүлүүлэхэд энэ хичээлийг зорилго оршино. Уг хичээлийн хүүхэд нэг бүрийн харьцуулан судалж, дүгнэлт гаргах чадварын хөгжлийг дэмжсэн үр дүнг танилцуулж байна.

Судалгааны загвар/арга зүй/ хандлага: Суурь боловсролын 7-р ангийн “Дуу авиа” бүлгийн, “Дууны шинж чанар” нэгж хичээлийн, “Дуу авианы өнгө” ээлжит хичээлийн бэлтгэл судалгааны хүрээнд дууны өнгөний ялгааг тооцоолох болон туршилт хийх аргаар харуулах хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн- Дуу юунаас үүсдэг, нарийн ба бүдүүн дуугаралт нь юунаас хамаарах вэ? зэрэг төвөгтэй асуудлуудыг сурагчидаар гитар ашигласан маш энгийн туршилт хийлгэн дууны үүсэл болон бүдүүн ба нарийн дуугаралтын учир шалтгааныг ойлгуулсан.

Энэ нь суралцагчдын сонирхон судлах эрэлтийг нэмэгдүүлэн, суралцахуйн бүтээлч үйлийг хэрэгжүүлсэн нь суралцах, харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг тодорхой хэмжээгээр авчирсан.

Практик ач холбогдол- 7-р ангид дуу юунаас үүсдэг вэ? Бүдүүн нарийн болон чанга сул дууны тухай мэдлэгийг ойлгуулахад гитар хамгийн тохиромжтой хэрэглэгдэхүүн болсон.

Хичээлийн судалгаагаар дамжуулан хичээлийг туршилт хийн нэгтгэн дүгнэх аргаар төлөвлөн хэрэгжүүлснээр суралцагчдын хөгжлийг дэмжсэн хичээлийн арга зүйг бүтээх боломжтойг харуулсан.

Шинэлэг тал/ашиг тус-Бүдүүн, нарийн, чанга, сул дуугаралтыг ойлгуулахад туршилт хийж ажиглан турших аргаар бодитоор мэдрүүлж, хооронд нь харьцуулж, сонирхон судлах хэрэгцээ, оролцоон дээр суурилан хүүхэд нэг бүрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Түлхүүр үг- Дуу авиа, нарийн, бүдүүн, чанга, сул дуу, дууны давтамж, дууны далайц, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл, харьцуулан судлах, дүгнэлт гаргах чадвар

Товч агуулга:

Физикийн суурь боловсролоор суралцагчид өөрсдийн бүтээлч үйлээр дамжуулан ахуйн мэдлэгийг ШУ-ы сорил туршилтын, мэдээлэл боловсруулах, тооцоолох, загварчлах аргаар танин мэддэг. Иймээс хичээлийн үе шат бүрд, суралцагчийн оролцоог дэмжсэн туршилт хийх аргаар дууны чанга болон бүдүүн дуугаралтын ялгааг ойлгуулахаар төлөвлөн хэрэгжүүлэхээр хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйн бэлтгэл судалгааг хийсэн. Гитарыг туршилтанд ашигласан ба гитарын утсыг эхлээд ажиглуулж ягаад бүдүүн ба нарийн утастай байгааг асуудалд дэвшүүлэн хэлэлцүүлж гитараар дууны дуугаралтын туршилт хийн сурагчидын ажигласан зүйлсийг нэгтгэн дүгнэж асуудлыг шийдвэрлэсэн.

Дууны дуугаралтын ялгаатай байгааг утасны нарийн бүдүүн буюу чичирхийлэх хөдөлгөөн болон утасны анхны таталттай холбоотой болохыг тодорхойлуулсан.

Утасны бүдүүн ба нарийн дуугаралт нь утасны хэлбэр болон чичирхийлэх хурдаас хэрхэн хамаарах туршилт хийлгэж, бүдүүн утас удаан чичирхийлэн хөдөлсөн ба бүдүүн дуу гаргасан харин нарийн утас хурдан чичирхийлэн хөдөлсөн ба нарийн дуу гаргасан гэсэн чухал дүгнэлт гаргуулсан.

Мөн гитарын утсыг чанга татвал чанга дуу, зөөлөн татвал сул дуу гардаг буюу дууны далайц гэсэн шинжлэх ухааны шинэ үг хэллэгийг ойлгуулах туршилт хийлгэсэн.

Физикийн боловсролын аливаа хөтөлбөрийг суралцагчдын оролцоо, идэвх сонирхлыг дэмжсэн суралцахуйн бүтээлч үйлийг дэмжсэн ШУ-ы туршилт хийх аргаар зохион байгуулж, багшлахуйн нээлттэй асуултаар хүүхдээ сонсож суралцагчийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх алхмыг нарийн төлөвлөснөөр хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж чадна гэсэн эерэг үр дүнг ямар нэг хэмжээгээр авчирдаг юм байна гэдгийг дүгнэсэн. Дууны үүсгүүрийн хэлбэлзлийн хөдөлгөөний хурдыг хэмжих боломжгүй байдаг ба хэлбэлзэгч биетийн хурдан удааныг нүдэн баримжаагаар үүнийг хамгийн сайн ялгаж чадах хэрэглэгдэхүүн бол гитар юм.

Иймээс дууны үүсгүүрээс гарах дууны өнгийг судлахад гитар хамгийн оновчтой хэрэглэгдэхүүн болоод зогсохгүй цаашид ч дууны өөр шинж чанаруудыг судлахад үндэс суурь болохыг туршилтын үр дүн баталсан.

Удиртгал

Дэлхийн даяаршлын үед улс орон бүр тогтвортой хөгжлийн боловсролын гол үзэл санааг хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна. Манай улсын хувьд боловсролын шинэчлэлийн бодлогын үр өгөөжтэй зорилтын нэг болсон хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн арга зүйгээр цөм хөтөлбөрийг шат шатны боловсролын түвшиндээ хэрэгжүүлж байна. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын хүн бүрийн үүрэг оролцоо чухал төдийгүй тэр дундаа багш нарын бүтээлч сэтгэлгээ, хамтын хөдөлмөр, чанартай үйлчилгээ нэн чухал байр суурийг эзэлнэ. Чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд багш нарын сургалтын арга барил, мэргэжил, мэргэшлийн чадвар, хэрэгжүүлэх хичээлийн төлөвлөлт, хамтын ажиллагаа багагүй үүрэгтэй байдаг. Судалгаат хичээлийг менежмент сайтайгаар төлөвлөн хэрэгжүүлэх нь хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг ажлын байран дээр нь хөгжүүлэх оновчтой арга юм. Энэ удаад хэрэгжүүлсэн судалгаат хичээлийн хувьд сэдэлжүүлэлт, сэргээн санах үйлийн үед гитарын утаснуудаас гарах өөр өөр өнгө аястай дуутай бичлэг үзүүлж дууны ялгаатай шинж нь юутай холбоотой болохыг илрүүлэх нээлттэй асуултаар суралцагчдын дунд хэлэлцүүлэг хийж, мэдлэг бүтээх хэсэгт гитарын бүдүүн ба нарийн утаснуудын дуугаралтын ялгааг илрүүлэх туршилт хийн илрүүлэн баталж, үр дүнг харьцуулан гаргасан. Ингэснээр суралцагчийн сонирхон судлах, харьцуулан оюун дүгнэлт гаргах суралцахуйн бүтээлч үйлийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг авчирсан. 7-р ангийн сургуулийн хөтөлбөрт тусгагдсан “Дуу авиа” бүлгийн “Дууны шинж чанар” нэгж сэдвийн хүрээнд “Дуу авианы өнгө” ээлжит хичээлийг туршилт хийх аргаар төлөвлөн хэрэгжүүлсэн судалгаат хичээлийн үр дүнг танилцууллаа.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Сэдвийг сонгосон чиг хандлагын үндэслэл:

АНУ 1983 онд боловсролын тогтолцоондоо судалгаа хийж, аюул нөмөрлөө гэсэн дүгнэлтээсээ үүдэн бүх корпорациуд нь боловсролдоо санхүүгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Ингэснээр 1\$ тутмаасаа 29\$-ын ашиг олсон. Ингэхээр улс орон бүрийн хөгжлийн гол түүчээ нь хүний хөгжил. Тэгвэл манай орны боловсролын хувьд хүүхэд нэг бүрийг болон багшлахуйн арга зүйг хөгжүүлэх гэсэн хүн төвтэй бодлогыг боловсролын чанарын шинэчлэлийн зорилт болгон хэрэгжүүлсэн. Иймээс багш нар цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн багаар хамтран, судалгаатай ханддаг болж эхэлсэн. Үүнд:

1. Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар “Дуу авианы өнгө”-г судлах хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг хамтран хөгжүүлэх
2. Хөтөлбөрийг оновчтой арга зүйгээр төлөвлөн хэрэгжүүлснээр гол концепцийг ойлгуулах боломжтой төдийгүй хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлдэг эсэхийг судлах арга зүйн туршлагаа хуваалцах, бусдаас зөвлөгөө авч хөгжүүлэхээс үүдэн энэхүү илтгэлийг толилуулж байна.

Сэдвийг сонгосон практик үндэслэл:

Байгалийн ухааны багш нар “Бүдүүн ба нарийн дуу” гэсэн ээлжит хичээлийг хэрэгжүүлэхдээ гарын доорх материал ашиглан дууны нарийн бүдүүнийг тодорхойлох туршилт хийлгэдэг байсан ба хамгийн чухал зүйл болох үүсгэгчийн хэлбэлзэх хөдөлгөөний давтамжтай холбож чадахгүй байсан нь дууны өнгийг тодорхойлох гол утга санаа дутуу дулимаг байгаа учир шалтгааныг орхигдуулж байгааг мэргэжлийн багийн хэлэлцүүлгээр илрүүлж, хэрхэн хэрэгжүүлэх арга зүйг боловсруулж, туршин хэрэгжүүлэхээр уг сэдвийг сонгосон юм.

“Хичээлийн санаа”: “Дуу авианы өнгө” гэсэн ээлжит хичээлийн эхлэл буюу сэдэлжүүлэх хэсэгт өмнөх мэдлэгийг сэргээх, оношлох зорилгоор 6-н утастай гитар үзүүлнэ.

Гитараар ая тоглохгүйгээр утаснуудын ялгааг ажиглуулж хэлэлцэнэ.

Гитар яагаад олон утастай байдаг вэ? Гитарын утаснууд яагаад ижилхэн урттай байна вэ? гэж асуудал дэвшүүлсэн. Асуултаар баг доторх хэлэлцүүлгийг өрнүүлж, нэгдсэн хэлэлцүүлгээр багуудын санал, таамаглалыг сонссон.

Хичээлийн шинжлэн судлах буюу тайлбарлах хэсэгт дээрх 2 асуулттай холбоотой 2 туршилт хийлгэсэн. Туршилт1-д хоёр гитарын утаснуудыг ижилхэн далайцтай татаж дуугаралт (дууны өнгө)-ын ялгаа болон утасны чичирхийлэх хурдыг ажиглуулсан.

Туршилт2-д гитарын утаснуудыг чанга ба зөөлөн татаж ямар дуу гарч буйг сонсгон ялгуулсан.

Гитарын бүдүүн ба нарийн утаснуудын үүсгэх дуу ялгаатай байгаагийн шалтгаан юу вэ?

гэсэн хэлэлцүүлгээс хэлбэлзэх утасны хэлбэлзэх хурд буюу давтамжаараа ялгаатай гэсэн санаа гаргасан. Тэр үед утаснууд хэлбэлзэх давтамжаараа ялгаатай байгаа шалтгааныг хэлэлцүүлэн дууны бүдүүн буюу нарийн өнгө аяс нь давтамжаас хамаарна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Мөн чанга ба сул дуу нь гитарын утсыг татах хүч буюу далайцаас хамаарна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Энэ нь суралцагчийн идэвхтэй, бүтээлч суралцахуйн үйлийн дэжлэгтэйгээр хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх, сонирхолтой арга байснаараа онцлогтой.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Завхан аймгийн Улиастай сумын физикийн боловсролын багш нар, ЧЭЛ сургуулийн сургалтын менежер А.Дэмбэрэлнямбуу/МУ-ын гавьяат багш / нартай хичээлийн бэлтгэл судалгааг хамтран Завхан аймагт хичээлийн судалгаа анх эхлүүлсэн бөгөөд 2018 онд Сүхбаатар дүүргийн “Шинэ-Үе” дунд сургуульд ажиллах үедээ энэ нэгж хичээлийн хэрэглэгдэхүүнийг шинэчлэн туршиж, ажиглалт, хэлэлцүүлгээр илрүүлсэн саналдаа үндэслэн хөтөлбөрийг сайжруулж ажилласан.


Хэрэглэгдэхүүний судалгааны хүрээнд “Шинэ-Үе” дунд сургуулийн дуу хөгжмийн кабинетын мандалин хөгжимийг багийн тоогоор хичээлийн хэрэглэгдэхүүн болгон ашигласан.

Судалгаат хичээл: 2016 оны 10-р сарын 01-07-нд “Дуу авиа” судалгаат хичээлийн бэлтгэл судалгааг хийж, Улиастай сумын физикийн мэргэжлийн багш нар ЧЭЛ сургуулийн 7а ангийн 20 суралцагчдын дунд туршин хэрэгжүүлж, сургалтын менежер, мэргэжилтнээс зөвлөгөө авч хамтран сайжруулсан.

Энэ үед гарын доорх материал ашиглан туршилт хийсэн нь хичээлийн цагийн алдагдал их, практик ач холбогдол муу, бүдүүн нарийн дуу нь давтамжаас хамааруулан судлахад бэрхшээл тулгарч байсан.

2018 оны 3-р сарын 15-нд энэ хичээлийн хэрэглэгдэхүүнийг сайжруулан “Шинэ-Үе” дунд сургуулийн 7аб ангиудын нийт 30 суралцагчдад хэрэгжүүлж, хэлэлцүүлгээс гитараас үүсэх дуу авианы бүдүүн ба нарийн дуугаралт нь утасны хэлбэр болоод утасны чичирхийлэн хөдлөх хурд буюу давтамжаас хамаардаг гэдгийг харуулах туршилтын аргыг хэрэгжүүлэх оновчтой саналыг авч хөтөлбөрийг 2, 3 дахь удаагаа сайжруулсан.

Сайжруулсан хөтөлбөрийг Сүхбаатар дүүргийн “Шинэ-Үе” дунд сургуулийн 7аб ангийн 30 суралцагчдын дунд хэрэгжүүлж, хэлэлцүүлгээр хөтөлбөрийг сайжруулсан бөгөөд хичээлийн судалгаандаа “Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх” загварын менежмент [1]-ийг хэрэгжүүлэхийг зорьсон.



Загвар1а. Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх

Эндээс суралцагчдын харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлэхийн тулд ээлжит хичээлийн үе шат бүрд тодорхой ахисан түвшний үйлийг төлөвлөн хэрэгжүүлж, гол концепцийг зөв сонгон хэрэгжүүлэх нь оновчтой шийдэл болж чадсан.

Судалгааны хамрах хүрээ, хугацаа, давтамж:

Судалгаанд хамрагдсан сургууль, анги, бүлэг (сурагчийн тоо)	Хичээлийн жил	Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн багш
--	---------------	----------------------------------

Чандмань-Эрдэнэ лаборатори- 7a /25/	2016-2017	П. Пүрэвдорж
Чандмань-Эрдэнэ лаборатори -7б /22/	2016-2017	П. Пүрэвдорж
Шинэ-Үе-7a /14/	2017-2018	П. Пүрэвдорж
Шинэ-Үе-7a /16/	2017-2018	П. Пүрэвдорж

Судалгааны үр дүн:

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөнд хийсэн зарим сайжруулалтыг дараах алхмаар хийсэн.

А. Гарын доорх материал ашиглан дууны өнгийг сонсголын эрхтэнээр дамжуулан ялгааг ажиглуулан багаар хэлэлцүүлэн дүгнүүлэх мөн дээр туршилтыг хийж утасны чичирхийлэх хурдыг нүдээрээ ажиглан багаар хэлэлцүүлэн дүгнүүлж заасан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн.

Б1. Гол концепцийг тусгасан туршилтын хэрэглэгдэхүүнийг сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн.

Б2. Гол концепцийг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

В. Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илрүүлсэн суралцагчдын гаргасан алдаа, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн

Дуу авианы шинж чанарыг тодорхойлдог нэг чухал хэмжигдэхүүн бол давтамж.

Дууны давтамжийг сайн ойлгосоноор сурагчид ахлах ангидаа орохдоо дууны бусад шинж чанарыг судлахад хялбар болдог. Давтамж бол хэлбэлзэл үүсгэгчийн чичирхийлэх хурдаас буюу 1секундэд хэлбэлзэх тоогоор тодорхойлогддог физик хэмжигдэхүүн.

Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ үндэсний лаборатори сургуульд “Дууны өнгө” ээлжит хичээлийг анх заасан.

Хичээлийн үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг:		
Таамаглал дэвшүүлэх-сэргээн санах, сэдэлжүүлэх	Өмнөх хичээлтэй холбоотой дууны үүслийн тухай асуулт асууж хичээлийг эхлүүлсэн. Чичирхийллээс үүссэн гэсэн хариулт авсан. Янз бүрийн өнгө бүхий дуунууд сонсож дуунуудын ялгаатай шинжүүдийг хэлэлцүүлж таамаглалыг самбарт тэмдэглэсэн.	1. Дуу авиа чичирхийллээс үүсдэг гэдгийг сайн мэдсэн байсан. 2. Туршилтаар нарийн, бүдүүн дуу болон чанга сул гэсэн ялгаатай дуунуудыг зөв нэрлэсэн. 3. Эдгээр дууны шинж чанарыг туршилтаар судлахаар болж хичээлийг гарчиг бичиж өнөөдрийн хичээлийг гол цөмүү орсон.
Хичээлийн өрнөл хэсэг:		
Туршилтыг төлөвлөх, хэрэгжүүлэх-мэдлэг бүтээх	1. Гарын доорх материал ашиглан хийсэн хэрэглэгдэхүүн харуулж, бүдүүн ба нарийн дууг хэрхэн үүсгэх талаар асуулт асууж туршилтыг төлөвлөсөн. 2. Багш туршилтаа хийхдээ сурагчидтай хамтран гарын доорх материалын тэвхний байрлалыг холдуулж ойртуулана гэсэн санааг гаргаж баг бүрт заавар тарааж өгч туршилт хийлгэсэн. 3. Багууд зааврын дагуу туршилтыг хийж гүйцэтгэн дүгнэлт гаргасан.	3. Гарын доорх материалаар хийсэн хэрэглэгдэхүүн ашиглан бүдүүн ба нарийн дууг хэрхэн үүсгэх талаар сурагчид оновчтой санаа гаргаагүй. 4. Багшийн зааврын дагуу багууд туршилтыг хийж гүйцэтгэсэн. 5. Нарийн ба бүдүүн дуу нь тэвхний байрлалыг өөрчилсөнөөс болж утасны уртаас хамаарч байгаа гэсэн буруу дүгнэлтэнд хүрсэн. Туршилтаар утасны хэлбэлзэх хөдөлгөөний хурдыг ялгах боломжгүй байсан. Туршилтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах шаардлага гарсан.
Хичээлийн төгсгөл хэсэг:		

Туршилтын үр дүнг нэгтгэх, боловсруулах, тайлбарлах	<p>1. Багш бүдүүн ба нарийн дуу нь утасны хурдан ба удаан хэлбэлзэх хөдөлгөөнтэй холбоотой болохыг нэмэлтээр хэлж сурагчидаас гаргасан дутуу дүгнэлтийг залруулж хэлж өгсөн.</p> <p>2. Тарааж өгөх дасгал ажиллуулсан.</p>	<p>3. Туршилтаар утасны чичирхийлэх хөдөлгөөний хурдыг нарийн ялгахын тулд гитар ашиглахаар болсон.</p> <p>4. Шинжлэх ухааны үг хэллэг ашигласан даалгавар өгөхөөр өөрчилсөн.</p>
---	--	---

Ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнгээс:

- Сэдэлжүүлэх туршилтыг өөрчлөх.
- Туршилтын багажны буруу сонголтоос цагийн алдагдалд орсон ба туршилтын хэрэглэгдэхүүнийг өөрчлөхөөр шийдвэрлэсэн.
- Туршилтыг төлөвлөхдөө хичээлийг гол зорилготой холбосон асуултаар чиглүүлэх.
- Шинжлэх ухааны нэр томъёогоор дууны чанга ба сулыг утасны чичирхийлэх хөдөлгөөний хурдаар тайлбарлаж, шинжлэх ухааны нэр томъёотой холбон мэдлэг олгох.

Давтамж ихтэй дуу нарийн харин давтамж багатай дуу бүдүүн дуу гаргадаг гэсэн онолын мэдээллийн талаарх анхны ойлголтыг дараах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөгжүүлэх боломжтой. Шинэ-Үе дунд сургуулийн 7б ангид 2018 оны 3-р улиралд энэ хичээлээ заасан.

Хичээлийн үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг:		
Таамаглал дэвшүүлэх-сэргээн санах, сэдэлжүүлэх	<p>Суралцагчдад нарийн бүдүүн чанга сул дуунууд сонгож дуунуудыг ялгаатай шинжийг ажиглуулсан.</p> <p>Дуу юунаас үүссэн тухай асуулт асууж чичирхийллээс үүсэн хариулт авсан.</p> <p>Дуунуудын ялгаатай шинжүүдийг хэлэлцүүлж таамаглалыг самбарт тэмдэглэсэн.</p>	<p>4. Дуу авиа юунаас үүссэн болохыг сурагчид буруу хариулт өгч цагийн алдагдал гарсан.</p> <p>5. Сэдэлжүүлэх туршилтаар дууны шинж чанарыг ялгахад тохиромжтой байсан ба яагаад ялгаатай дуу гарч байгаа шалтгааныг сурагчид ойлгоход хаалттай байсан.</p> <p>6. Сэдэлжүүлэх туршилтаас дууны үүсгэгчийг ил байхаар сайжруулах шаардлага гарсан тул гитарыг сэдэлжүүлэлтэнд ашиглах.</p> <p>7. Дуунууд сул, чанга, бүдүүн нарийн өнгө аястай байдлаараа ялгаатай болохыг дүгнүүлэх.</p>
Хичээлийн өрнөл хэсэг:		
Туршилтыг төлөвлөх, хэрэгжүүлэх-мэдлэг бүтээх	<p>Гитар ашиглан бүдүүн ба нарийн дууг хэрхэн үүсгэх талаар асуулт асууж туршилтыг төлөвлөсөн.</p> <p>Багууд хэлэлцэн гаргасан төлөвлөлтийн дагуу туршилтыг хийж гүйцэтгэж, ялгаатай дууг судлахын тулд утаснуудын чичирхийлэх хөдөлгөөний хурдыг ажиглах туршилт хийсэн.</p> <p>Багууд нарийн утас хурдан, бүдүүн утас удаан чичирхийлдэг болохыг илрүүлж дүгнэсэн.</p> <p>Багш гитарын утасны чичирхийлэх хурдыг давтамж гэдэг физик</p>	<p>6. Гитараас гарах дуунууд өөр өөр байгаагийн шалтгааныг хэлэлцэн гитарын утасны хөдөлгөөний хурдыг ажиглахаар багууд төлөвлөх.</p> <p>7. Гитарын утаснууд нарийн ба бүдүүн байгаагийн гол шалтгаан нь утаснуудын чичирхийлэх хурд өөр өөр байгаатай холбоотой гэсэн дүгнэлтэд хүрэх.</p> <p>8. Гитарын нарийн утас хурдан чичирхийлдэг буюу давтамж ихтэй харин бүдүүн утас удаан чичирхийлдэг буюу давтамж багатай болохыг дүгнэх.</p>

	хэмжигдэхүүнээр тодорхойлдог болохыг нэгтгэн дүгнэсэн.	
Хичээлийн төгсгөл хэсэг:		
Туршилтын үр дүнг нэгтгэх, боловсруулах, тайлбарлах	<p>1. Гитарын дээр багш ая тоглож давтамжаар нь ялгах, эрэмбэлэх дадлага ажил хийлгэсэн.</p> <p>Үүнд: Гитарын утаснуудыг давтамжаар нь эрэмбэлэхэд бэрхшээл үүсэх учир утаснуудыг дугаарлах юмуу дуу хөгжмийн хичээлээр үзсэн До, Ре, Ми, Па, Соль, Ля, Си гэсэн нотыг ашигласан.</p> <p>Багууд гитар дээр ая тоглож бусад багуудаар таалгасан.</p>	<p>5. Гитар дээр ганцхан дууны давтамжийн талаар ая тоглож таалгах нь учир дутагдалтай байсан.</p> <p>Дараагийн хичээл дээр дууны чанга сулыг нэмж оруулах.</p> <p>6. Багууд гитарын 1 утсаар ая тоглосон ба гитараа нууж нөгөө багуудад таалгасан нь сурагчидын идэвхи оролцоог дэмжиж, сонирхолыг төрүүлсэн туршилт хийх.</p> <p>7. Дүгнэлт гарган тайлбарлахад хугацаа их хэмжээгээр зарцуулсан ба багийн бүх гишүүдийг дугаарлан асуултын хариултыг авахдаа болон туршилтын үр дүнг танилцуулахдаа аль нэг дугаар бүхий суралцагчаар тайлбарлуулдаг болсноор суралцагчдын тэгш оролцоог хангасан төдийгүй ярих, илтгэх чадвар буюу харьцуулан судалж, дүгнэлт гаргах чадварын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг болсон.</p>

Ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнгээс:

- Эхлэл хэсгийн сэргээн сануулах үйлээс үүдэлтэйгээр гарсан цагийн алдагдлыг бууруулж, нягтаршуулах зорилгоор гитарын ая тоглосон дүрст бичлэгийг үзүүлэхээр болсон.
 - Туршилтаас буруу төсөөлөл авахаас сэргийлж гитарын утасыг жигд чангалж, туршилт хийхэд анхаарах гол зүйлийг туршилтын төлөвлөлтөнд оруулахаар болсон.
 - Мөн гитарын чанга сулыг нэмж судлахаар төлөвлөсөн.
 - Гитарын чанга ба сул дуу нь утасны тэнцвэрийн байрлалаасаа хазайх хазайлт буюу далайцаас хамаарахыг туршилтаар тодорхойлж дүгнүүлэхээр төлөвлөв.
- Хичээлийн төгсгөл хэсэгт багш гитарын 1 утсаар ая тоглохдоо чанга сул, бүдүүн нарийн нэгэт төрлийн дуу гарган таалгасан ба багууд мөн адил туршилтыг хийж бусад багуудад таалгахаар төлөвлөв. Тоглосон дууны шинж чанарыг таалгахдаа давтамж, далайц, их, бага гэсэн шинжлэх ухааны үг хэллэг ашиглан таалгаж цээжлүүлэх зорилгоор сайжруулав.

Б1. Гол концепцийг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Сайжруулсан хөтөлбөрийг би 2017-2018 оны хичээлийн жилийн III улиралд Шинэ-Үе дунд сургуулийн 7а бүлгийн 15 суралцагчдад хэрэгжүүлсэн. Эндээс хөтөлбөрийг Шинэ-Үе дунд сургуулийн байгалийн ухааны багш нар хэлэлцүүлэн сайжруулж 2017-2018 оны III улиралд би Шинэ-Үе дунд сургуулийн 7б бүлгийн 16 суралцагчдад сайжруулан дахин заасан.

Багшийн асуулт, үндсэн үйл ажиллагаа	Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн явц, үр дүн	Тухайн хэсгийн дидактик шийдэл, сайжруулалт
<i>Хичээлийн эхлэл хэсэг:</i>		

<p>1. Дуу юунаас үүсдэг вэ? гэсэн сэргээн сануулах асуултаар хичээл эхлэнэ.</p> <p>2. Гитарын зураг үзүүлж гитар яагаад олон утастай байдаг вэ?</p> <p>3. Дараа нь гитараар ая тоглосон бичлэг (гитарын ая нь чанга, сул, бүдүүн нарийн гэсэн холимог өнгөтэй) үзүүлж гитараас ямар ямар дуу гарч байгааг асуусан.</p> <p>4. Яагаад өөр өөр өнгөтэй дуу гарч байгаа талаар асууж үүнийг энэ хичээлээр судлахаар шийдсэн.</p>	<p>1. Гитар олон утастай байгаа шалтгаан бол өөр өөр өнгө аястай дуу гаргах гэж сурагчид хариулсан.</p> <p>2. Багууд дууны өнгөний ялгааг бүгд хэлсэн.</p> <p>3. Чичирхийлэх хурд өөр гэж цөөхөн хариулж туршилтаар батлахаар болсон</p>	<p>1. Багууд гитарын утас бүдүүн нарийнаараа ялгаатай болохыг хэлэх.</p> <p>Утаснууд уртыг нэмж асууж сайжруулах.</p> <p>Багуудын хариулт гитараас өөр өөр аятай дуу гарч байгааг хэлэх.</p>
--	--	--


Хичээлийн өрнөл хэсэг:

<p>1. Гитарын бүдүүн ба нарийн дууг судлахын тулд ямар туршилт хийх вэ?</p> <p>2. Баг бүрт гитар тараан өгч туршилт хийлгэсэн.</p> <p>3. Гитарын чанга ба сул дууг судлахын тулд ямар туршилт хийх вэ?</p> <p>4. Туршилт хийлгэх.</p> <p>5. Нэгдсэн дүгнэлт хамтран гаргах.</p>	<p>1. Сурагчид гитарын бүдүүн ба нарийн дуу юунаас болж үүссэн шалтгааныг олох туршилт хийлгэхээр төлөвлөсөн.</p> <p>2. Багууд төлөвлөгөөний дагуу туршилт хийж нэгдсэн оновчтой дүгнэлтэнд хүрсэн.</p> <p>3. Сурагчид гитарын чанга ба сул дуу юунаас болж үүссэн шалтгааныг олох туршилт хийлгэхээр төлөвлөсөн.</p> <p>4. Багууд төлөвлөгөөний дагуу туршилт хийж оновчтой дүгнэлтэнд хүрсэн.</p> <p>5. Нэгдсэн дүгнэлт хамтран гаргах.</p>	<p>1. Гитарын бүдүүн нарийн дууг судлах туршилтыг төлөвлөх.</p> <p>2. Багууд туршилтаа зааврын дагуу хийх.</p> <p>Сурагчидыг оролцоог жигд хангах.</p> <p>3. Гитарын дууны чанга сулыг судлах туршилтыг төлөвлөх.</p> <p>4. Туршилтыг зааврын дагуу хийж нэгдсэн дүгнэлт гаргах.</p> <p>5. Сурагчид дууны шинж чанрын шинжлэх ухааны үг хэллэгийн мэдлэг эзэмших.</p>
---	---	---

Хичээлийн төгсгөл хэсэг:

<p>Багш гитараар чанга, сул, бүдүүн, нарийн дуу бүхий ая тоглож багуудаар таалгаж багуудыг үнэлэх.</p> <p>Багуудаар гитарын ая тоглуулж таалгах дадлага ажил хийлгэнэ.</p>	<p>Багшийн тоглосон аяг дууны шинж чанрын тухай шинжлэх ухааны үг хэллэг ашиглан таах.</p> <p>Багууд нэг нэг ая тоглож бусад багуудаар таалгана. Зөвхөн шинжлэх ухааны үг хэллэг ашиглан таана.</p>	<p>Сурагчид гитарын дууны аяг ангилах нэрлэх дадлага туршилт хийх.</p> <p>Шинжлэх ухааны үг хэллэгийг цээжлэх дадал хийх.</p> <p>Ая таасан багуудыг үнэлэх.</p>
--	---	---

Дууны өнгө гэдгийг дуу хөгжим, физикийн хичээл хоорондын холбоогоор тодорхойлон авч үзвэл:



В. Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илрүүлсэн суралцагчдын гаргасан алдаа, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн

Асуулт	Суралцагчдын гаргасан алдаа	Хөтөлбөрт алдаанаас сэргийлэх төлөвлөлтийг тусгасан байдал	Суралцагчдад илэрч байгаа эерэг хандлага, өөрчлөлт
Хөтөлбөр А	Нарийн ба бүдүүн дуу нь утасны уртаас (туршилтын багажны тэвхний байрлалаас) хамаарна.	Ижил урттай бүдүүн ба нарийн утас ашиглах. Чавхдасны утасны хэлбэлзэх хурдыг ажиглах.	Туршилтын хэрэглэгдэхүүнийг гараа бариж мэдэрсэн. Чичирхийллээс дуу үүсдэгийг баталсан.
Хөтөлбөр Б1	Бүдүүн утас чанга дуу гаргадаг, нарийн утас сул дуу гаргадаг. Чанга утаснаас чанга дуу, сул утаснаас сул дуу гардаг.	Дууны чанга сулыг судлуулахгүйгээр зөвхөн бүдүүн ба нарийн дууг судлуулахаар төлөвлөсөн. Гитарын утаснуудыг ижилхэн хазайлттай татах.	Гитарын утаснуудын чичирхийлэх хөдөлгөөний хурдыг нүдээр ялгаж чадсан ба нарийн утас хурдан чичирхийлсэн. Харин бүдүүн утас удаан чичирхийлсэн хөдлөж байсан. Дуу чичирхийллээс үүсдэг, дууны өнгө аяс чичирхийлэх хурдаас хамаардаг болохыг мэдсэн.
Хөтөлбөр Б2		Гитарын утаснуудыг дуу хөгжмийн багшаар сайн хөглүүлж утаснуудыг жигд чангалуулсан. Гитарын утаснуудыг ижилхэн хазайлттай татах.	Гитарын утаснуудын чичирхийлэх хөдөлгөөний хурд нь гитарын утасны чичирхийлэх давтамж болохыг ойлгож утас бүр өөр өөр давтамжтай дуу гаргадаг болохыг мэдсэн. Мөн дууны чанга сул нь гитарын утсыг хэр чанга ба сул татахаас хамаардаг буюу үүнийг дууны далайц болохыг мэдэж өөр хөгжмийн зэвсэгүүдийн давтамжийг эрэмбэлэх чадвартай болсон.

Дүгнэлт:

Дээрх судалгаат хичээлийг хэрэгжүүлсэн үр дүнгээс багш нар гол концепц агуулгыг цогцоор нь орхигдуулахгүйгээр танин барих нь хамгийн чухал гэдгийг ойлгосон.

Хөтөлбөр “А”-д зөвхөн дууны нарийн ба бүдүүн гэсэн физик ухагдахууныг гарын доорх материал ашигласан туршилтын багажаар туршилт хийлгэсэн нь агуулгын хувьд бага хамгийн гол сурагчид нарийн ба бүдүүн дууны үүслийн мөн чанрын тухай буруу ойлголт дүгнэлтэд хүрсэн.

Хөтөлбөр “Б-1”-д хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнийг өөрчилж гитар ашиглан хөтөлбөр “А”-гийн хүүхдэд буруу ойлгуулсан мэдлэгийг залруулсан.

Харин хөтөлбөр “Б-2”-д өмнөх хөтөлбөр дээр нэмээд дууны чанга ба сул гэдэг физик ухагдахууныг “дуу үүсгэгчийн далайц” гээд гитар дээр туршилт хийсэн нь бага хугацаанд их мэдлэгийг цогцоор олгох төдийгүй физикийн шинжлэх ухааны үг хэллэгийг ашиглан бататгаж чадсанаараа энэ хичээлийг давуу тал оршино.

Суралцагчдын шинжлэн судлах чадвар, танин мэдэхүйн чадамжийн дэмжлэгтэйгээр аливаа физикийн ухагдахуун, хэмжигдэхүүний талаарх ойлголтыг оролцоон дээр суурилсан мэдээллийг нэгтгэн дүгнэх аргаар хэрэгжүүлсэн.

Гитарын утаснуудын чичирхийлэх хөдөлгөөний хурд буюу давтамжийг хэмжиж тодорхойлох боломжгүй учраас гитарын утаснуудын чичирхийлэх хурдыг нүдээрээ ажиглаж хооронд нь ялгаж эрэмбэлэх туршилт ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Мөн гитарын дууны чанга ба сулыг тодорхойлохоор гитарын нэг утсыг 3 өөр таталтаар (чанга, дунд, сул) татах туршилт хийж гүйцэтгүүлсэн.

Дуу чичирхийллээс үүсдэг, дууны давтамж нь дуу үүсгэгчийн чичирхийлэх хөдөлгөөний хурдаас хамаардаг, дууны далайц буюу чанга сул нь хэлбэлзэгчийн тэнцвэрийн байрлалаас хазайх хазайлтаас хамаарна гэсэн сурах бичигт байдаг тодорхойлолтуудыг туршилтаар судлаж хүүхдэд

ойлгуулахад төвөгтэй байдаг ба маш олон туршилтын хэрэглэгдэхүүн шаардагддаг. Харин гитарыг хичээлийг хэрэглэгдэхүүн болгон авсанаар эдгээр агуулга мэдлэгийг сурагчидад зөв ойлгуулахад маш тохиромжтой хэрэглэгдэхүүн болж чадсан. Сурагчид дуу үүсгэгчийн чичирхийлэх хөдөлгөөнийг бодитоор нүдээр харж мэдрэн харьцуулан судалж, дүгнэлтийг үнэн бодитоор гаргадаг гэсэн эерэг үр дүнг тодорхой нэгэн хэмжээгээр авчирдаг болохыг харуулсан.

Сурагчидын туршилтыг төлөвлөх, хийх, ажиглах, нэгтгэн дүгнэх, багаар ажиллах, дүгнэлт гаргах зэрэг чадамжийг хөгжүүлж цаашид хөгжих хүслийг нэмэгдүүлэн оролцох, оролдох, хийж бүтээх хүсэл эрмэлзлийг бий болгосон.

Гитар дээр хийсэн энэ туршилтууд нь дээр дурьдсан дуу авианы шинж чанарыг тодорхойлдог чухал параметруудийг тодорхойлох боломжтойг харуулсан “мэдлэг бүтээх” арга зүйн нэгэн загварыг бий болгож, туршин хэрэгжүүлж байна.

Ном зүй

10. Бурмаа Б., Ганбат М., *Физик дидактик хичээлийн практикт.* УБ. 2006.
11. БСШУЯ. *Суурь боловсролын физикийн хичээлийн суралцахуйн удирдамж.* УБ., 2015
12. Ганбат М., Бурмаа Б., Дөлгөөн Ж. *Багшийн ном. Физик 7, УБ.* 2015.
13. Ганбат М., Амартайван Ц., Алтангэрэл Н., Бадам Б., Батболд Д., Батболд Х., Бурмаа Б., Дөлгөөн Ж., Мөнхсайхан Я., Энхбаяр М. *Физик 1 VII ангийн сурах бичиг.* 2014.

“Диффузийн хурдад гадаргуугын талбай нөлөөлөх нь” ээлжит хичээлийн арга зүйн туршлага

Г.Дэмбэрэлмаа¹, Ц.Чимэдрэгзэн² Э.Сайнжаргал¹, Б.Нямдаваа¹ Б.Норжмаа¹, Ч.Эрдэнэчимэг¹
Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн, химийн багш нар, БСГ-ын
мэрэгжилтэн², математикийн багш, физикийн багш, газарзүйн багш/ У:88033549-
g.demberel88@gmail.com, [99469004; cheemeeganzoo27@gmail.com](mailto:99469004@cheemeeganzoo27@gmail.com)

Хураангуй

Зорилго: Энэхүү судалгаат хичээлээр диффузын хурдад гадаргуугын талбай хэрхэн нөлөөлж байгааг тооцоолох, мэдээллийг загварчлан боловсруулах аргаар илрүүлэн, хүүхэд нэг бүрийн харьцуулан судалж, дүгнэлт гаргах, молекул кинетикийн онолын үүднээс учирлан тайлбарлах чадварын хөгжлийг дэмжсэн үр дүнг танилцуулж байна.

Судалгааны загвар/арга зүй/ хандлага: Суурь боловсролын 9-р ангийн “Бодисын төлөв, шинж чанар” бүлгийн, “Диффузи, диффузын хурд ” нэгж хичээлийн, “Диффузын хурдад гадаргуугын талбай хэрхэн нөлөөлөх нь” ээлжит хичээлийн бэлтгэл судалгааны диффузийн хурдад гадаргуугийн талбай яаж нөлөөлж байгааг тооцоолох болон загварчлах аргаар харуулах хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно. Мөн 7-р ангид диффузийг жижиг хэсгийн онолоор тайлбарлаж байсан бол 9-р ангид молекул кинетик онолын үүднээс учирлан тайлбарлах, шалтгааныг дүгнэх.

Судалгааны үр дүн- Диффузийн хурд жижиг хэсгийн гадаргуугын хэмжээнээс хамаардаг болохыг үл харагддаг жижиг хэсгийг загварчлах аргаар төлөөлөн мэдэрч, тооцооллын үр дүн, эрдэмтдийн судалгааны үр дүнтэй харьцуулан судалсан. Энэ нь суралцагчдын сонирхон судлах эрэлтийг нэмэгдүүлэн, суралцахуйн бүтээлч үйлийг хэрэгжүүлсэн нь суралцах, харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлсэн, тооцооллын үр дүнг туршилтын үр дүнтэй харьцуулан хэд хэдэн хэмжилтийн үр дүнгийн дунджаар тооцон гаргаж байгаа нь алдаатай дүгнэлт гаргахаас сэргийлж байлаа.

Практик ач холбогдол-Дээрх арга зүйн санааг ерөнхий боловсролын сургуулийн химийн болон байгалийн ухааны боловсролын багш нар хичээлдээ туршин хэрэгжүүлэх боломжтой. Хичээлийн судалгаагаар дамжуулан хичээлийг тооцоолох болон загварчлах аргаар төлөвлөн хэрэгжүүлснээр суралцагчдын хөгжлийг дэмжсэн хичээлийн арга зүйг бүтээх боломжтойг харуулсан. Загварчлан тооцолсон үр дүн нь энгийн туршилтын үр дүнгээр батлагдаж байгаа нь сурагчдад шинжлэн судлах, эрэл хайгуул хийх боломжийг олгож байна.

Шинэлэг тал/ашиг тус-Химийн гол концепцийг ойлгуулахад математик тооцооллын болон мэдээллийг загварчлах аргаар бодитоор мэдрүүлж, харьцуулуулж, сонирхон судлах хэрэгцээ, оролцоон дээр суурилан хүүхэд нэг бүрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Түлхүүр үг- Диффузи, диффузын хурд, жижиг хэсэг, жижиг хэсгийн хэмжээ, жижиг хэсгийн гадаргуугын талбай, Броуны хөдөлгөөн, молекул кинетикийн онол, туршилт, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл, загварчлах арга, харьцуулан судлах, дүгнэлт гаргах чадвар

Товч агуулга:

Химийн суурь боловсролоор суралцагчид өөрсдийн бүтээлч үйлээр дамжуулан ахуйн мэдлэгийг ШУ-ы сорил туршилтын, мэдээлэл боловсруулах, тооцоолох, загварчлах аргаар танин мэдэж, материалын шинж чанарын талаар мэдээлэлтэй болдог. Иймээс хичээлийн үе шат бүрд, суралцагчийн оролцоог дэмжсэн тооцоолох болон загварчлах аргаар диффузын хурд жижиг хэсгийн гадаргуугын хэмжээнээс хэрхэн хамаарч байгааг, жижиг хэсгийн гадаргуун талбай ихэснэ гэдэг нь молекулын тоо ихсэнтэй холбоотой гэдгийг ойлгуулахаар төлөвлөн хэрэгжүүлэхээр хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйн бэлтгэл судалгааг хийсэн. Суралцагчдын танил хэрэглэгдэхүүн болох баримлын шавраар бодисыг төлөөлүүлж авсан нь сонирхолыг татаж байсан. Нэг том баримлын шаврын гадаргуугын талбайг хэмжүүлсэн. Мөн гадаргуугийн талбайг нь яаж ихэсгэж болох талаар хэлэлцүүлэг хийлгэж, баримлын шаврыг хувааж жижигрүүлэн тус гадаргуугын талбайг математик аргаар тооцоолоход жижиг

хэсгүүдийн тоо нэмэгдэхийн хирээр гадаргуугын талбай ихсэж байгааг тодорхойлсон. Бодисыг бүрдүүлэгч жижиг хэсэг нь том байх тусам гадаргуугын талбай бага, жижиглэгдэх тусмаа олон жижиг хэсгийн гадаргуугийн талбайн нийлбэр ихэсдэг гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Химийн боловсролын аливаа хөтөлбөрийг суралцагчдын оролцоо, идэвх сонирхлыг дэмжсэн суралцахуйн бүтээлч үйлийг дэмжсэн ШУ-ы тооцоолох болон загварчлах аргаар зохион байгуулж, багшлахуйн нээлттэй асуултаар хүүхдээ сонсож суралцагчийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх алхмыг нарийн төлөвлөснөөр хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж чадна гэсэн эерэг үр дүнг ямар нэг хэмжээгээр авчирдаг юм байна гэдгийг дүгнэсэн. Бодисыг бүрдүүлэгч жижиг хэсгүүдийг бодитоор харж, шинжийг нь тодорхойлох боломжгүй байдаг. Иймээс материал, бодисыг бүрдүүлэгч жижиг хэсгийг загвараар дүрслэн мэдэрч, шинж чанарын ялгааг тодорхойлох нь илүү үнэнд нийцэж байгааг тооцооллын үр дүнтэй харьцуулан гаргасан. Мөн суралцагчидад илүү ойр үйлийн алхамаар хөтлөн молекул кинетикийн онолын үндэслэлийг тайлбарлан таниулахад хялбар байсан.

Удиртгал

Дэлхийн даяаршлын үед улс орон бүр тогтвортой хөгжлийн боловсролын гол үзэл санааг хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна. Манай улсын хувьд боловсролын шинэчлэлийн бодлогын үр өгөөжтэй зорилтын нэг болсон хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн арга зүйгээр цөм хөтөлбөрийг шат шатны боловсролын түвшиндээ хэрэгжүүлж байна. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын хүн бүрийн үүрэг оролцоо чухал төдийгүй тэр дундаа багш нарын бүтээлч сэтгэлгээ, хамтын хөдөлмөр, чанартай үйлчилгээ нэн чухал байр суурийг эзэлнэ. Чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд багш нарын сургалтын арга барил, мэргэжил, мэргэшлийн чадвар, хэрэгжүүлэх хичээлийн төлөвлөлт, хамтын ажиллагаа багагүй үүрэгтэй байдаг. Ингэснээр суралцагчийн сонирхон судлах, харьцуулан оюун дүгнэлт гаргах суралцахуйн бүтээлч үйлийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг авчирсан. 9-р ангийн сургуулийн хөтөлбөрт тусгагдсан 9-р ангийн “Бодисын төлөв, шинж чанар” бүлгийн, “Диффузи, диффузын хурд” нэгж хичээлийн, “Диффузын хурдад гадаргуугын талбай нөлөөлөх нь” ээлжит хичээлийн бэлтгэл ээлжит хичээлийг тооцоолох болон загварчлах аргаар төлөвлөн хэрэгжүүлсэн судалгаат хичээлийн үр дүнг танилцууллаа.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Сэдвийг сонгосон чиг хандлагын үндэслэл:

Улс орон бүрийн хөгжлийн гол түүчээ нь хүний хөгжил. Тэгвэл манай орны боловсролын хувьд хүүхэд нэг бүрийг болон багшлахуйн арга зүйг хөгжүүлэх гэсэн хүн төвтэй бодлогыг боловсролын чанарын шинэчлэлийн зорилт болгон хэрэгжүүлсэн. Иймээс багш нар цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн багаар хамтран, судалгаатай ханддаг болж эхэлсэн. Үүнд:

1. Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар “Диффузын хурдад гадаргуугын талбай нөлөөлөх нь” ээлжит хичээлийн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг хамтран хөгжүүлэх
2. Хөтөлбөрийг оновчтой арга зүйгээр төлөвлөн хэрэгжүүлснээр гол концепцийг ойлгуулах боломжтой төдийгүй хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлдэг эсэхийг судлах арга зүйн туршлагаа хуваалцах, бусдаас зөвлөгөө авч хөгжүүлэхээс үүдэн энэхүү илтгэлийг толилуульж байна.
3. Молекул кинетикийн онолын үүднээс тайлбарлахдаа гадаргуугийн талбай ихсэнэ гэдэг нь жижиг хэсгийн тоо ихсэх буюу молекулын тоо ихсэнтэй холбоотой гэдгийг сурагчдаар гаргуулж шинжлэх ухаанч хандлагаар хандах боломжийг бүрдүүлэх.

“Хичээлийн санаа”: “Диффузын хурдад гадаргуугын талбайхэрхэн нөлөөлөх нь” гэсэн ээлжит хичээлийн эхлэл буюу сэдэлжүүлэх хэсэгт өмнөх мэдлэгийг сэргээх, оношлох зорилгоор “Диффузын хурдад температур хэрхэн нөлөөлөх” бэ? Гэсэн асуултаар сурагчдаас өмнөх төсөөллийн судалгаах авч нэгтгэхэд. Диффузын хурд температур шууд хамааралтай, температур ихсэхэд диффузын хурд ихэснэ, температур ихсэхэд кинетик энерги ихсэн диффузын хурд нэмэгдэнэ гэсэн тулгуур санаанууд гарч байлаа. Хичээлийн үндсэн хэсэг рүү шилжихдээ эрэл хайгуул хийх асуудал дэвшүүлэх асуулт асуун хэлэлцүүлэг хийсэн. Диффузын хурдыг ихэсгэх өөр өөр ямар боломж байна вэ? Гадаргуугын

талбайг багасгах бодисыг жижиглэх, нунтаглах, хутгах гэсэн таамаглал санаанууд сурачдаас гарч байлаа. Тэгвэл бүгдээрээ энэ баримлын шаврын гадаргуугын талбайг яаж өөрчилж болох вэ? Багийн бүх сурагчдын жигд оролцоог хангах зорилгоор багийн 1-6 хүртэл дугаарлаж хэлэлцүүлэг туршилтын үр дүнг сурагчдын дугаар давхардуулалгүй тайлбарлуулсан. Багийн тооцоолол, туршилтын үр дүнд баримлын шаврыг олон жижиг хуваахад тэдгээрийн гадаргуугын талбай ихсэж байна дүгнэлт гарч ирсэн. Жижиг хэсгийн гадаргуугын талбай ихсэх нь диффузын хурдад хэрхэн нөлөөлж байгааг туршилт хийн илрүүлцгээе гээд шинжлэн судлах хэсэг рүү шилжсэн. Диффузын хурдад зэсийн сульфатын гадаргуугын талбай хэрхэн нөлөөлөх вэ? Зэсийн сульфатын гадаргуугийн талбайг ихэсгэхэд диффузийн хурд нэмэгдэнэ. Учир нь жижиг хэсгийн тоо ихэссэнээр кинетик энерги ихэсч диффузи хурдан явагдсан. Талбайг багасгахад диффузийн хурд ихэснэ. Багасгах тусам жижиг хэсгийн хөдөлгөөн нь хурдасч диффузи хурдан явагдана. Сурагчид диффузын хурдад зэсийн сульфатын гадаргуугийн талбай хэрхэн нөлөөлөхийг илрүүлэх туршилтын төлөвлөгөө боловсруулж, дараа нь сурах бичгийн 21-р хуудсан дахь туршилтын төлөвлөгөөтэй харьцуулан өөрсдийн төлөвлөгөө алхмыг сайжруулсан. Төлөвлөгөөний дагуу туршилтаа хийн бодисын гадаргуугын талбай ихсэх диффузын хурдыг нэмэгдүүлж байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Энэ нь суралцагчийн идэвхтэй, бүтээлч суралцахуйн үйлийн дэжлэгтэйгээр хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх, сонирхолтой арга байснаараа онцлогтой.

Хичээлийн бэлтгэл судалгаа: БСУГ-ын мэргэжилтэн Ц. Чимэдрэгзэн, химийн Г.Дэмбэрэлмаа, Э.Сайнжаргал, математикийн багш Б.Нямдаваа, физикийн багш Б. Норжмаа, газар зүйн багш Ч.Эрдэнэчимэг хөтөлбөрийг 3 удаа туршин хэрэгжүүлж, ажиглалт, хэлэлцүүлгээр илрүүлсэн саналдаа үндэслэн хөтөлбөрийг сайжруулж ажилласан.

Судалгаат хичээл: 2018 оны 10-р сарын 12-18 нд дээрх бүрэлдэхүүнтэйгээр 8 ажиглагчтайгаар, анхны хэлэлцүүлгээс сайжруулсан хөтөлбөрийг ЧЭЛ сургуулийн 9а ангийн 24 суралцагчдад хэрэгжүүлж, хэлэлцүүлгээс материал, диффузын хурдад жижиг хэсгийн гадаргуугын талбай ихсэх нь шууд нөлөөлж байгаа баримлын шаврын жижиг хэсгийн гадаргуугийн талбайг тооцоолж олохоос гадна химийн туршилтаар хамаарлыг илрүүлэх нь зүйтэй гэсэн саналыг авч хөтөлбөрийг 2 дахь удаагаа сайжруулсан. Сайжруулсан хөтөлбөрийг 9в ангийн 28 суралцагчдын дунд хэрэгжүүлж, хэлэлцүүлгээр хөтөлбөрийг дахин сайжруулсан.

Эндээс суралцагчдын харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлэхийн тулд ээлжит хичээлийн үе шат бүрд тодорхой ахисан түвшний үйлийг төлөвлөн хэрэгжүүлж, гол концепцийг зөв сонгон хэрэгжүүлэх нь оновчтой шийдэл болж чадсан.

Судалгааны хамрах хүрээ, хугацаа, давтамж:

Судалгаанд хамрагдсан сургууль, анги, бүлэг (сурагчийн тоо)	Хичээлийн жил	Хичээл заасан багш
Чандмань-Эрдэнэ лаборатори- 9а /24/	2018	Ц.Чимэдрэгзэн
Чандмань-Эрдэнэ лаборатори -9в/28/	2018	Г.Дэмбэрэлмаа
Чандмань-Эрдэнэ лаборатори 9б/24/	2018	Ц.Чимэдрэгзэн Г.Дэмбэрэлмаа

Судалгааны үр дүн:

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөнд хийсэн зарим сайжруулалтыг дараах алхмаар хийсэн.

А. Диффузын хурдад гадаргуугын талбай хэрхэн нөлөөлөхийг баримлын шаврыг хувааж гадаргуугийн талбайг математик аргаар тооцоолж, нээлттэй асуултаар хэлэлцүүлэн гарган авсан үр дүнг туршилтаар илрүүлсэн гаргасан үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Б. Гол концепцийг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

А. Диффузийн хурдад гадаргуугын талбай хэрхэн нөлөөлөхийг баримлын шаврыг хувааж гадаргуугийн талбайг математик аргаар тооцоолж, нээлттэй асуултаар хэлэлцүүлэн гарган авсан үр дүнг туршилтаар илрүүлсэн гаргасан үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Диффузын хурдыг шууд нөлөөлдөг чухал хүчин зүйл бол гадаргуугийн талбай.

Бодисын жижиглэн олон хэсэгт хуваахад гадаргуугын талбай нэмэгдэж диффузын хурд ихсэнэ.

Гадаргуугын талбай багасахад диффузын хурд буурдаг. Диффузын хурд гадаргуу

н талбайгаас шууд хамаардаг гэсэн онолын мэдээллийн талаарх анхны ойлголтыг дараах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөгжүүлэх боломжтой.

Хичээлийн үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг:		
Таамаглал дэвшүүлэх-сэргээн санах, сэдэлжүүлэх	Диффузын хурдад температур хэрхэн нөлөөлөхийг тодорхойлсон.	Диффузын хурд температур 2 шууд хамааралтай . Температур ихсэхэд диффузийн хурд ихсэнэ. Температур ихсэхэд кинетик энерги ихсэн диффузын хурд нэмэгдэнэ
Хичээлийн өрнөл хэсэг:		
Туршилтыг төлөвлөх, хэрэгжүүлэх-мэдлэг бүтээх	1 баг нь хуваалгүйгээр гадаргуугийн талбайг олно. II-V баг баримлын шаврыг тэнцүү 2,4,6,8 хэсэгт хувааж баримлын шаврын нийт гадаргуугийн талбайг тооцоолж олно.	Кубын талайг олохдоо дараах томъёог ашиглана. $S=6*a$ $S_{нийт} = S_1 + S_2 + S_3$
Хичээлийн төгсгөл хэсэг:		
Туршилтын үр дүнг нэгтгэх, боловсруулах, тайлбарлах	Ялгаатай нунтаглалт бүхий 0,5гр зэсийн сульфатыг урьдчилан жинлэсэн байна. Туршилт хийх сайжруулсан төлөвлөгөөг нэгтгэн бичнэ. Туршилтын өөрчлөлтийг ажиглан, үр дүнг хэлэлцэн дэвтэртээ тэмдэглэнэ.	Усанд уусган өөрчлөлтийг ажиглана. Хугацааг тэмдэглэн хурдыг харьцуулах . Туршилт хийх сайжруулсан төлөвлөгөөг нэгтгэн бичнэ. Туршилтын өөрчлөлтийг ажиглан, үр дүнг хэлэлцэн дэвтэртээ тэмдэглэнэ.

Төлөвлөлтийн үр дүнгээс:

- Температур нэмэгдэхэд диффузын хурд нэмэгдэж байгаа шалтгааныг жижиг хэсгийн хөдөлгөөн, онол болон молекул кинетикийн үүднээс тайлбарлах
- Жижиг хэсгийн тоо нэмэгдэхэд гадаргуугийн талбай ихсэж, байгааг жижиг хэсэг тус бүр өөр өөрийн гадаргуутай байдаг гэсэн дүгнэлт гаргах.
- Гадаргуугийн талбай ихсэж жижиг хэсгийн тоо ихсэх тусам **ашигтай мөргөлдөлтийн тоо** ихсэж диффузын хурд нэмэгдэнэ. **Броуны хөдөлгөөнөөс** хамаарна гэсэн оюун дүгнэлтийг хэлэлцүүлгээс гаргах гэсэн сайжруулалтыг дараагийн төлөвлөлтөндөө тусгасан.

Б. Гол концепцийг тусгасан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Дахин сайжруулсан хөтөлбөрийг 9в бүлгийн 28 суралцагчдад хэрэгжүүлсэн. Эндээс хөтөлбөрийг хэлэлцүүлэн сайжруулсан тул 2018 оны 1-р улиралд Улиастай сумын химийн боловсролын 7 багш сургалтандаа ашиглан, хэрэгжүүлсэн үр дүнгийн саналыг нэгтгэн хөгжүүлэх боломжтой.

Багшийн асуулт, үндсэн үйл ажиллагаа	Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн явц, үр дүн	Тухайн хэсгийн дидактик шийдэл, сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг:		
Диффузын хурдад температурын хамаарлыг багаар болон анги нийтээр хэлэлцүүлэх	1. Диффузын хурд температур хоёр шууд хамааралтай. 2. Температур ихсэхэд диффузын хурд ихсэнэ. Температур ихсэхэд	1. Бодисыг бүрдүүлэгч жижиг хэсэгтэй холбон, жижиг хэсгийн онолоор тайлбарлан хөгжүүлэх боломжтой. 2. Жижиг хэсгийн хөдөлгөөн температур нэмэгдэхэд ихэсж,

	кинетик энерги ихсэн диффузын хурд нэмэгдэнэ.	кинетик энерги нь нэмэгддэг учраас диффузын хурд нэмэгдэж байгаа тайлбарлах.
<i>Хичээлийн өрнөл хэсэг:</i>		
Тэгвэл бүгдээрээ энэ баримлын шаврын гадаргуугын талбайг яаж өөрчилж болох вэ? Баримлын шаврыг хувааж жижигрүүлэн гадаргуугын талбайг математик тооцооллоор олох.	<p>1.Эхний баг нь хуваалгүйгээр гадаргуугийн талбайг олно. II-V баг баримлын шаврыг тэнцүү 2,4,6,8 хэсэгт хувааж баримлын шаврын нийт гадаргуугийн талбайг тооцоолж олно. Талбайг ихэсгэхэд диффузийн хурд нэмэгдэнэ.</p> <p>2. Учир нь жижиг хэсгийн тоо ихэссэнээр кинетик энерги ихэсч диффузи хурдан явагдсан.</p> <p>3. Гадаргуугын талбайгаараа ялгаатай зэсийн сульфатын усанд диффузлэдэх хурдын нунтаглалтаас хамаарах хамаарлаар нь илэрхийлэх.</p>	<p>1. Гадаргуугын талбайг ихэсгэхэд диффузын хурд нэмэгдэнэ. Учир нь жижиг хэсгийн тоо ихэссэнээр кинетик энерги ихэсч диффузи хурдан явагдсан.</p> <p>2. Жижиг хэсэг тус бүр өөрийн гэсэн гадаргуутай олон жижигрэн хуваагдах тусам төдий чинээ гадаргуугын талбай нэмэгдсэн гэдгийг таниулах. Хэлэлцүүлгийн үр дүнгээс зэсийн сульфатын гадаргуугын талбай хэрхэн ихэсгэх вэ? Гэсэн асуудлыг дэвшүүлж, туршилыг төлөвлөн хэрэгжүүлэх.</p> <p>3. Гадаргуугын талбай ихэсэж жижиг хэсгийн тоо ихсэх тусам ашигтай мөргөлдөлтийн тоо ихэсэж диффузын хурд нэмэгдэнэ. Броуны хөдөлгөөнийг тайлбарлах</p>
<i>Хичээлийн төгсгөл хэсэг:</i>		
Туршилтын үр дүнг нэгтгэн дүгнэх, тайлбарлах	Диффузын хурдад гадаргуугын талбай шууд нөлөөлж байгаа нь гадаргуугын талбай ихэсхэд жижиг хэсгийн тоо олширч байгаатай холбоотой.	-Математик тооцоолол ба туршилтын харьцуулсан туршилтын дараа усанд зэсийн сульфат диффузлэгдэх үзэгдлийг жижиг хэсгийн загвараар илэрхийлүүлэх.

Дүгнэлт: Дээрх судалгаат хичээлийг хэрэгжүүлсэн үр дүнгээс багш нар гол концепцийг орхигдуулахгүйгээр танин барих нь хамгийн чухал байсан. Иймээс энэ судалгаат хичээлээр суралцагчдын шинжлэн судлах чадвар, танин мэдэхүйн чадамжийн дэмжлэгтэйгээр аливаа химийн ухагдахуун, хэмжигдэхүүний талаарх ойлголтыг оролцоон дээр суурилсан мэдээллийг загварчлах аргаар хэрэгжүүлэх боломжтойг харуулахыг зорьсон. Мөн гадаргуугын талбайг нь яаж ихэсгэж болох талаар хэлэлцүүлэг хийлгэж, баримлын шаврыг хувааж жижигрүүлэн тус гадаргуугын талбайг математик аргаар тооцоолоход жижиг хэсгүүдийн тоо нэмэгдэхийн хирээр гадаргуугын талбай ихэсэж байгааг тодорхойлсон. Бодисыг бүрдүүлэгч жижиг хэсэг нь том байх тусам гадаргуугын талбай бага, жижиглэгдэх тусмаа олон жижиг хэсгийн гадаргуугын талбайн нийлбэр ихэсдэг гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Химийн боловсролын аливаа хөтөлбөрийг суралцагчдын оролцоо, идэвх сонирхлыг дэмжсэн суралцахуйн бүтээлч үйлийг дэмжсэн ШУ-ы тооцоолох болон загварчлах аргаар зохион байгуулж, багшлахуйн нээлттэй асуултаар хүүхдээ сонсож суралцагчийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх алхмыг нарийн төлөвлөснөөр хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж чадна гэсэн эерэг үр дүнг ямар нэг хэмжээгээр авчирдаг юм байна гэдгийг дүгнэсэн. Мөн суралцагчид илүү ойр үйлийн алхамаар хөтлөн молекул кинетикийн онолын үндэслэлийг тайлбарлан таниулахад хялбар байсан. Жижиг хэсэг тус бүр өөрийн гэсэн гадаргуутай олон жижигрэн хуваагдах тусам төдий чинээ гадаргуугийн талбай нэмэгдэж ашигтай мөргөлдөлтийн тоо ихэсэж диффузын хурд нэмэгдэнэ гэж дүгнэж хэлж болно.

Ном зүй

Н.Нэргүй, Ч.Нямгэрэл ба бусад, Багшлахуйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент (Боловсролын бодлого боловсруулагч, судлаач, арга зүйч, ЕБС-ийн удирдах ажилтан нарт зориулав), УБ., 2013.

14. С.Батсүх Хүүхдийн хөгжил УБ., 2010.

15. Н.Оюунцэцэг, Н.Нэргүй, Ч.Нямгэрэл ба бусад Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил-төслийн зөвлөмж-1,2,3 УБ., 2010.

16. Н.Оюунцэцэг, Д.Сарангэрэл, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, Б.Наранцогт Багшийн ном Хими-VII, УБ., 2015.

17. Н.Оюунцэцэг, Д.Сарангэрэл, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, Б.Наранцогт, З.Урансайхан Хими-VII, УБ., 2015.

18. Н.Оюунцэцэг, Д.Сарангэрэл, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, Б.Наранцогт, З.Урансайхан Хими-IX, УБ., 2016.

19. Н.Оюунцэцэг, Д.Сарангэрэл, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, Б.Наранцогт Багшийн ном Хими-IX, УБ., 2015.

Химийн бодлого бодоход гарч буй хүндрэлийг ажиглалт болон рубрик арга ашиглан судласан туршлагаас

А.Ариунзаяа¹, Б.Уранбилэг², Ч.Нарантуяа³

1-Өвөрхангай аймаг Арвайхээр сум Алтангадас одонт ЕБ-ын 1 дүгээр сургуулийн химийн багш, 99701129

adiyaariunzaya@gmail.com

2-Өвөрхангай аймаг Арвайхээр сум Алтангадас одонт ЕБ-ын 1 дүгээр сургуулийн химийн багш, 99908095

uuk.urnaa@gmail.com

3-Өвөрхангай аймаг Арвайхээр сум Алтангадас одонт ЕБ-ын 1 дүгээр сургуулийн химийн багш, 99327878

Удиртгал

Ахлах ангийн химийн цөм хөтөлбөрийн зорилгод “Сурагч нь ахуй амьдралын болон шинжлэх ухаан, технологийн мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад химийн хэл, сэтгэлгээгээр хандах, бие даан, бүтээлчээр суралцах мэдлэг, чадвар эзэмшихэд оршино” гэсэн. (Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр "ХИМИ", 2016) Химийн бодлого бодож, тооцоо хийж сурах нь химийн хэлд тайлагдах зайлшгүй чухал чадвар юм. Аравдугаар ангидаа стехиометрийн тооцоот бодлогыг эхлэн бодож, моль гэдэг ойлголттой танилцаж байгаа. Сурагчдыг химийн тооцоот бодлого сайн бодож сургахад анхны тавил зөв байх хэрэгтэй гэж үзэж байна.

Химийн сургалтын цөм хөтөлбөрийн шинэчлэл нь сургалтын арга зүй, технологийн шинэчлэлийг зүй ёсоор шаардана. (Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр "ХИМИ", 2016) Химийн тооцоот бодлогыг шилжүүлэгч факторын аргаар бодох шинэ арга сургалтанд нэвтрээд удаагүй байна. Энэ шинэ аргаар бодлого бодож сургахад багш нар адилхан л хариу гарахаас гэж үзэн ихэвчлэн хуучин аргаар зааж байгаа ажиглагдсан.

Онол арга зүйн үндэс, судалгаа

Сэдвийг сонгосон үндэслэл:

1990 оноос дэлхий нийтээр нийгмийг төдийгүй боловсролыг цоо шинээр харах болж, боловсролыг шинэчлэх шинэ концепциудыг дэвшүүлж эхэллээ. Монгол оронд ардчилсан хувьсгал өрнөж, хөгжлийн шинэ замыг сонгож замнах боллоо. Бид энэхүү түүхэн бодит нөхцөлд химийн боловсролын шинэчлэлийг хийж байна. (Ч.Нямгэрэл, 2013) Боловсролын шинэчлэлийн нэг хэсэг болох “Цөм хөтөлбөр” хэрэгжээд удаагүй байна. Химийн цөм хөтөлбөрт химийн тооцоот бодлого бодох нь ахлах ангиас эхлэн үзэхээр тусгагдсан байгаа.

Бүрэн дунд боловсролын 10-р ангийн хими сургалтын цөм хөтөлбөрт анх удаа бодлого, тооцоо орж байгаагаараа онцлог. (Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр "ХИМИ", 2016) Химийн тооцоот бодлогыг эхэлж бодохоос гадна арга зүй нь “Шилжүүлэгч фактор” ашиглан бодох арга зүйгээр шинэчлэгдсэн.

Сурагчдад химийн бодлого бодоход нь бэрхшээл хүндрэл гараад байна. Химитэй холбоотой сургалтын бэрхшээл нь маш өргөн хүрээтэй бөгөөд ангилахад хялбар биш юм. Сургалтын бэрхшээлийн хамрах хүрээнээс нь хамааруулан хамгийн чухал 5 үндсэн хэсэгт хуваасан байна (Ghassan, 2007).

- Хөтөлбөрийн агуулга: Орчин үед химийг макро, субмикро, тэмдгийн түвшинд зэрэгцүүлэн заах нь сурагчдад хүндрэл бэрхшээл үүсгэж байна.
- Сурагчдын санах ойн хэт ачаалал: Санах ойн ажиллах багтаамж нь хязгаарлагдмал байдаг. Энэ хязгаарлагдмал багтаамж нь гаднаас ирсэн мэдээллийг ухамсарт санах ойд—барьж авах, түүнийг боловсруулах, улмаар зохицуулан урт хугацааны санах ойд хадгалахад бэлэн болгох гол холбоос юм. Санах ойн энэхүү хязгаарлагдмал багтаамжаас сургалтын үед сурагчид өгч буй мэдээллийн ачаалал хэт их байх суралцах нөхцөл байдал сурагчдад тулгарсан үед ач холбогдол багатай мэдээлэл, чухал мэдээллийг сонгоход хэцүү байдаг.
- Хэл болон харилцаа: Хэл нь мэдээллийн хэт ачаалал үүсэхэд хувь нэмэр болдог байна. Хэлний хувьд суралцахуйн бэрхшээл үүсгэдэг асуудалд танил биш үг хэллэг, эсвэл оновчгүй үг сонголт, химид хэрэглэгдэхдээ ердийн хэрэглээнийхээс утга нь өөрчлөгдсөн танил үг хэллэг, хэлэхэд хэцүү хүнд дуудлагатай үг, давхар үггүйсгэл зэргийг хамааруулдаг.
- Ухагдахууны төлөвшил: Хими нь хийсвэр ойлголт ихтэй учир химид суралцах нь сэтгэж бодох, гярхай байхыг шаарддаг. Бодисын жижиг хэсэг, уусмал, химийн холбоо нь химийн суурь үндсэн ойлголтууд юм. Хэрэв эдгээр ухагдахууныг ойлгоогүй бол урвалын хурд, хүчил суурь, электрохими, химийн тэнцвэр гэх мэт сэдвүүд нь химийн хүнд сэдвүүд болдог. Бодит ойлголт нь зөвхөн тухайн ойлголтын үндсэн зарчмыг мэдэхийг биш бүхий л ойлголтуудын хооронд нь логик дэс дараа, утга учиртай холбохыг шаарддаг.
- Сэдэл: Сурагчдад бүгдэд нь тухайн зүйлийг ойлгох гэж хичээх сэдэл байхгүй бол багш нар асуудалтай тулгардаг. Сурагчдын сэдлийг суралцахуйн талаас гадаад (шалгалтыг амжилттай давахын төлөө мэдэхийг хүссэн), дотоод (өөрийн тусын тулд мэдэхийг хүссэн) гэж ангилж болно. Сэдлийн гурав дахь ангилал нь сэдэлгүй байх (amotivation) гэж нэрлэдэг бөгөөд ямар нэг зүйлийг сурах нь тэдэнд тустай гэдэгт итгэл үнэмшилгүй байхыг илэрхийлдэг. (Ж.Энэбиш, 2018)

Конструктивизмын онол

Конструктивизмын онол нь сүүлийн 20 жилд дотроо олон урсгал чиглэлтэйгээр эрчимтэй хөгжиж байна. Энэ бүх урсгал чиглэлд байдаг ерөнхий зүйл бол “**Мэдлэг зүгээр нэг дамждаггүй, мэдлэгийг хүн бүр өөрөө зохиомжлон бүтээдэг**” гэсэн үзэл санаа юм. Конструктивизмын онолын гол санаа нь сэтгэл судлалын нэрт эрдэмтэд болох Швейцарын эрдэмтэн Ж.Пиаже, Оросын эрдэмтэн Л.Выготский нарын бүтээлд тусгагдсан байдаг тул тэднийг конструктивизмын онолыг үндэслэгчид гэж үздэг.

Танин мэдэх, мэдлэг эзэмших үйл ажиллагаанд зохиомжлон бүтээх гэсэн тулгуур ухагдахуун гол үүрэг гүйцэтгэдэг. Хүний оюун ухааны хөгжилд зохицон дасгах бүтэцчилсэн зохион байгуулалтын гэсэн хоёр гол зарчим үйлчилж байдаг. Хүний орчиндоо дасан зохицох үйл явц 2 хэлбэрээр явагддаг.

- 1- Хүн орчныхоо нөлөөллийг өөртөө байгаа боломжийн хэрээр хувирган зохицохыг ассимиляц гэнэ.
- 2- Хүн өөрөө өөрчлөгдөж орчиндоо дасан зохицохыг аккомодац гэнэ. (Б.Бурмаа, 2002)

Өнөөгийн асар хурдацтай хөгжиж буй нийгэмд биологийн хуулиараа хүчтэй нь биш харин орчин нөхцөлтэйгөө хэр хурдан зохицож чадсан нь илүү хөгждөг. Иймээс нийгмийн хөгжлийг дагаад багшийн хөгжил нь шинэчлэгдэн өөрчлөгдөх тасралтгүй үйл явц юм.

Хүний хөгжлийн гол хүчин зүйл нь насан туршдаа тасралтгүй суралцаж, нийгэм соёлын шинэ хандлагыг эзэмшихэд орших нөхцөл бүрдүүлнэ.

Рубрик аргын тухай

Рубрикийн арга нь хичээлээр сурагчийн хийж гүйцэтгэсэн даалгаврын гүйцэтгэл, чадварын түвшинг тодорхой шалгуур үзүүлэлт ашиглан үнэлснээр сурагчдын мэдлэг, чадварын түвшинг илрүүлж, улмаар сурагчдад ялгаатай хандах байдлыг хэрхэн хэрэгжүүлэх боломжийг олгодог үнэлгээний нэг арга юм. (Н.Оюунцэцэг, 2015)



Оношлох үнэлгээ

Сурагчдын сурах үйл ажиллагаанд гарч буй бэрхшээлүүдийн шалтгааныг олоход зориулагддаг. Оношлох үнэлгээг суралцагч хичээлийн зорилтын алиныг нь зохих түвшинд эзэмшээгүй байгааг тодорхойлох, мөн яагаад тухайн хичээлийн зорилтыг сайн эзэмшээгүй байгаа шалтгаан нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох гэсэн хоёр зорилготой явуулдаг. Ингэснээр суралцах үйл явц нь сул талыг тодорхойлж сурагчын гаргаж алдаа дутагдалыг засах арга замыг багш мэддэг. Явцын үнэлгээ ихэвчлэн ахиц, амжилтыг харуулдаг боловч ахиц гаргахгүй байх нь бэрхшээл байгааг харуулж ингэснээр цаашид илүү нарийн оншлох үнэлгээг хийх шаардлагатайг нотолдог. Явцын үнэлгээ нь өдөр тутмын ерөнхий арга барил болдог бол оношлох үнэлгээ нь илүү нарийн нэмэлт арга барил хэрэглэхийг шаарддаг. Оношлох үнэлгээ нь багшийн урьдчилан бэлтгэсэн даалгавар болон ажиглах аргуудад суурилдаг. (Н.Оюунцэцэг, 2015)



Явцын үнэлгээ ихэвчлэн ахиц, амжилтыг харуулдаг боловч ахиц гаргахгүй байх нь бэрхшээл байгааг харуулж ингэснээр цаашид илүү нарийн оншлох үнэлгээг хийх шаардлагатайг нотолдог. Явцын үнэлгээ нь өдөр тутмын ерөнхий арга барил болдог бол оношлох үнэлгээ нь илүү нарийн нэмэлт арга барил хэрэглэхийг шаарддаг. Оношлох үнэлгээ нь багшийн урьдчилан бэлтгэсэн даалгавар болон ажиглах аргуудад суурилдаг. (Н.Оюунцэцэг, 2015)

Өөрийн үнэлгээний тухай

Өөрийн үнэлгээ гэдэг нь тухайн хүн өөрийнхөө мэдлэг чадвар, хийж гүйцэтгэсэн ажил, өөрийн бүтээлч үйл ажиллагаандаа үнэлгээ өгөх үйл явц юм. Өөрийн үнэлгээ нь тодорхой тогтсон шалгуурын дагуу

хийгдэж байх ёстой. Багш сурагчид хамтран энэхүү шалгуураа тодорхойлно. Өөрийн үнэлгээний тайлан нь сурагчдын хэрэгцээ, асуудал, сонирхол, хандлагыг гүйцэт ойлгоход багшид тусалдаг арга юм. Сурагчид амжилт болон тохирохгүй байгаа шалгуурыг олох, багш сайжруулах аргыг санал болгох бөгөөд Сурагчид амжилтаа тодорхойлоод сайжруулах зүйлээ олоод бие даан сайжруулалтаа хийнэ.

Өөрийн үнэлгээ нь:

- Хичээл болон сургуульдаа хэрэгжүүлж байгаа өөрийн болон хамтын үнэлгээг эргэн харах, сайжруулахад хэрэглэж болно.
- Багш нар өөртөө хэрэглэж болох өөрийн үнэлгээний аргыг мэдэж авах боломжтой байна.
- Өөрийн үнэлгээг хөгжүүлэх чадвартай Сурагч суралцах арга барилаа нэмэгдүүлснээр чанарын үнэлгээний мэдээллийг хэрэглэх, тайлбарлах, дүгнэх мөн хувирган өөрчлөх боломжтой болно.
- Сурагчдын өөрийн үнэлгээний чадвар нь ямар хэмжээнд хөгжиж байгааг судлах боломжтой болно.
- Сурагч сэдэлжсэн, илүү биеэ даасан болох бөгөөд суралцах үйл явцад идэвхтэй оролцох болно.
- Сурагчийн хувийн хөгжилд маш их дэвшилт гарч ирнэ зэрэг олон ач холбогдолтой. (М.Тунгалаг, 2011)

Хичээлийн санаа: Химийн бодлогийг бодоход гарч байгаа хүндрэлийг судлах, цаашид шийдвэрлэх арга замыг сонгоход чиглэсэн.

Хичээлийн бэлтгэл судалгаа:

Химийн тооцоот бодлого бодох агуулгыг “Бодисын тоо хэмжээ ба стехиометр” нэгж хичээлийн агуулгын хүрээнд “Бодисын тоо хэмжээ”, “Массын концентраци”, “Молийн концентраци”, “Химийн урвалаас тооцоо хийх” гэсэн сэдвүүдээр бодлого бэлтгэж боловсруулсан. “Бодисын тоо хэмжээ ба стехиометр” сэдвийн хувьд өмнөх мэдлэг залгамж холбоо судалсан. /Хавсралт №1 Химийн бодлогууд/

Судалгаа, туршилтын хэсэг:

Судалгаа №1 “Бодисын тоо хэмжээ ба стехиометр” нэгж хичээлийн хувьд өмнөх мэдлэг, залгамж холбоог судалсан. Мэдлэг чадварын жагсаалт гаргасан. Өмнөх мэдлэгийн хувьд 7-р ангид атом, молекулын ялгааг 9-р ангид бодисын харьцангуй атом массыг тодорхойлдог.

Мэдлэг	Чадвар
<ul style="list-style-type: none"> • Моль • Молийн масс • Хийн молийн эзэлхүүн • Химийн урвалын стехиометр 	<ul style="list-style-type: none"> ➤ Авогадрогийн тогтмол болон жижиг хэсгийн тооны хамаарлыг ашиглан бодисын тоо хэмжээ олох ➤ Молийн масс болон массыг ашиглан бодисын тоо хэмжээг олох ➤ Жижиг хэсгийн тоог ашиглан массыг олох ➤ Масс ашиглан жижиг хэсгийн тоог олох ➤ Стандарт нөхцөлд хэмжигдэхүүнийг зөв өгөгдөлд шилжүүлэх ➤ Нэгжийн шилжүүлэг хийж томьёонд орлуулах ➤ Өгүүлбэрийн өгөгдөл ашиглан тохирох томьёог зөв сонгох



Судалгаа №1-ын үр дүн: Бодисын тоо хэмжээ ба стехиометр нэгж хичээлийн өмнөх мэдлэг болон эзэмшсэн мэдлэгийн жагсаалтыг гаргасан. Авогадрийн тогтмол болон жижиг хэсгийн тооны хамаарал болон масс, молийн массыг хамааралтай томъёогоор бодисын тоо хэмжээ, молийг олж чадаж байгаа сурагчид нийт сурагчдын 52.5% нь байна. Жижиг хэсгийн тоог ашиглан масс олох мөн масс ашиглан жижиг хэсгийн тоог олох бодлогийг нийт сурагчдын 62.1% нь чадахгүй байна.

Судалгаа №2 Химийг бодлогыг бодоход сурагчдад гарч байгаа алдаа болон хүндрэлийг ажиглалт болон рубрик, дэвтэрийн бичиглэлд анализ хийж судалсан.

Химийн бодлого бодох рубрик үнэлгээ


Бодлогын төрөл	Маш сайн /3 оноо/	Хангалттай /2 оноо/	Анхаарах хэрэгтэй /1 оноо/	Хангалтгүй /0 оноо/
Бодисын тоо хэмжээ тооцох	Молийн тоо, молийн масс, хийн эзэлхүүнийг олоод, нэгж, бичиглэл бүрэн бол	Молийн тоо, молийн масс, хийн эзэлхүүн олж чаддаг бол	Молийн масс олдог, молийн тоо, хийн эзэлхүүн олж чадахгүй бол	Бодисын томъёо бичихгүй, молийн масс олж чадахгүй бол
Массын концентраци	Массын концентраци, бодисын хэмжээ олох бодлогыг нэгж, бичиглэл зөв хийвэл	Массын концентрацийг аль нэг аргаар тооцож чаддаг бол	Өгөгдсөн хэмжигдэхүүнийг зөв тэмдэглэж чаддаг бол	Уусмал болон ууссан бодисын хэмжээг
Молийн концентраци	Моль, массын концентрацийг шилжүүлж чаддаг бол	Молийн концентрацийг олж чаддаг бол	Бодисын томъёо бичиж, молийн масс тооцож чаддаг бол	Бодисын томъёог алдаатай бичиж, молийн масс олж чадахгүй бол
Химийн урвалаар тооцоо хийх	Химийн урвалын тэгшитгэл зөв тэнцүүлж, бодолт хийхдээ бичиглэл, нэгж, нэр, хариу зөв бичсэн бол	Химийн урвалын тэгшитгэл зөв тэнцүүлж, бодолт хийж, хариуг зөв гаргасан бол	Химийн урвалын тэгшитгэл зөв тэнцүүлж, өгөгдсөн зүйлийг бичсэн бол	Химийн урвалын тэгшитгэлийг бичихдээ бодисын томъёо зөв бичээд тэнцүүлж чадахгүй бол
Бүх төрлийн бодлого	Аль нэг аргаар бодож, хариуг зөв гаргасан. Бичиглэл зөв, нэгжийн гаргалгаа зөв хийсэн.	Аль нэг аргаар бодож хариуг гаргасан	Аль нэг үйлдэл дутуу хийгдсэн.	Огт үйлдэл хийж чадахгүй

Бодлогын төрөл	Маш сайн /3 оноо/	Хангалттай /2 оноо/	Анхаарах хэрэгтэй /1 оноо/	Хангалтгүй /0 оноо/
<i>Бодисын тоо хэмжээ тооцох</i>	23.9%	28.1%	26.7%	21.3%
<i>Массын концентраци</i>	14.1%	22.5%	38.7%	24.6%


Сурагчид химийн бодлогыг бодохдоо нийт сурагчдын 23.9 хувь нь маш сайн ойлгосон буюу сайн боддог, 28.1 хувь нь хангалттай харин 26.7 хувь нь анхаарах хэрэгтэй, 21.3 хувь нь хангалтгүй гэж дүгнэгдсэн бөгөөд сурагч 52 хувь нь бодож харин 48 хувь нь бодисын тоо хэмжээ тооцох бодлогыг бодож чадахгүй байна. Массын концентрацийн бодлогыг нийт сурагчдын 14.1 хувь нь маш сайн ойлгосон, 22.5 хувь нь хангалттай харин 38.7 хувь нь анхаарах болон 24.6 хувь нь хангалтгүй гүйцэтгэсэн байна.




Судалгаа №3: Сурагчид бодлого бодохдоо дараах алдаа болон хүндрэлийг ажиглалт болон рубрикийн арга ашиглан илрүүлсэн үр дүнгээс . /Багш жишээ бодлого өгсний дараа бодолт гүйцэтгэж байгааг нь ажиглах мөн бодолтыг шалгаж дүн тавьж байхдаа ажигласан алдаа, хүндрэлийг доор жагсаав. 10-р ангийн нийт 4 бүлэгт 3 удаагийн судалгаат хичээлийг зохион байгуулсан бөгөөд ажиглалт хийсэн багш нар сурагчдад бодлого бодоход ямар алдаа болон хүндрэл гарч байгааг тодорхойлсон. Хавсралт хэсэгт сурагчдын гаргасан алдаа болон хүндрэлийг харуулав.

№	10-р ангийн нийт 4 бүлгийн сурагчдын хувьд дараах нийтлэг алдаа байна.
1	Бодлогийн өгүүлбэрийг буруу ойлгох
2	Химийн бодлогийг бодохдоо бодлогийн өгөгдлийг буруу өгөх. Жишээ нь бг масстай гэхэд жижиг хэсгийн тоо N-ээр тэмдэглэх
3	Томьёоны гаргалгаа буруу хийх
4	Хариу, тооцоолол алдах
5	Химийг эхнээсээ ойлгоогүй учир чадахгүй нь гэсэн бодолтой. Химид сонирхолгүй
6	Бодлогыг бодсон сурагчдаас хуулах
7	Багшийн тайлбарыг анзаарахгүй өнгөрөх



Судалгаа №4: Сурагчдаас химийн бодлого бодоход нь гарч байгаа хүндрэлийг судалсан үр дүнгээс 10-р ангийн нийт 136 сурагчдаас химийн бодлого бодоход нь гарч байгаа хүндрэлийг илрүүлэх зорилгоор 5 асуулга бүхий судалгаа авч үр дүнг боловсруулсан.





Судалгаа №5: Асуудлыг багасгах арга зүй хайж судалсан нь:

Багш нараас асуултаар болон фээсбүүк грүүпээр багш нараас судалгаа авч үр дүнг тэмдэглэсэн.

№	Цаашид анхаарах зүйлсээ багш тэмдэглэсэн нь.
1	Нэгж хичээлийн хувьд залгамж холбоо, өмнөх мэдлэгийн жагсаалт гаргах
2	Багш өөрөө бодлогыг бодох
3	Сурагчийг оношлох үнэлгээ хийх
4	Номны жишээ бодлоготой өгөгдөл өөр бодлого өгч бодуулах
5	Химийн нэгдлийн нэршил бичүүлж харьцангуй атом масс олуулах
6	Аргачлал, нэгжийн шилжүүлэг болон хураалт дээр нь анхаарах
7	Математик болон физикийн багш нартай нь хамтран ажиллах

Дүгнэлт

- Өмнөх мэдлэгийн жагсаалт гаргаснаар хичээлийн төлөвлөлтөд ашиглан холбон тайлбарлах мөн мэдлэг чадварын жагсаалтаар сурагчдын чадварыг үнэлж, ангилан тайлбарласан. Авогадрийн тогтмол болон жижиг хэсгийн тооны хамаарал болон масс, молийн массыг хамааралтай томъёогоор бодисын тоо хэмжээ, молийг олж чадаж байгаа сурагчид нийт сурагчдын 52.5% нь байна. Жижиг хэсгийн тоог ашиглан молийн масс олох мөн масс ашиглан жижиг хэсгийн тоог олох бодлогыг нийт сурагчдын 62.1% нь чадахгүй байна.
- Сурагчид химийн бодлогыг бодоходоо нийт сурагчдын 23.9 хувь нь маш сайн ойлгосон буюу сайн боддог, 28.1 хувь нь хангалттай харин 26.7 хувь нь анхаарах хэрэгтэй, 21.3 хувь нь хангалтгүй гэж дүгнэгдсэн бөгөөд сурагчид 52 хувь нь бодож харин 48 хувь нь бодисын тоо хэмжээ тооцох бодлогыг бодож чадахгүй байна. Массын концентрацийн бодлогийг нийт сурагчдын 14.1 хувь нь маш сайн ойлгосон, 22.5 хувь нь хангалттай харин 38.7 хувь нь анхаарах болон 24.6 хувь нь хангалтгүй гүйцэтгэсэн байна.
- Судалгаат хичээлийг зохион байгуулж сурагчдад гарч байгаа алдаа дутагдалыг бусад багш нар ажиглан хичээлийн төгсгөлд дэвтэр хураан авч ямар алдаа болон хүндрэл байгааг илрүүлсэн бөгөөд сурагчдын ихэнх хэсэг нь Өгөгдлөө буруу өгөх, бодлогийн хариуг буруу гаргах алдаа харин бодлого бодоходоо өгөгдлөө өгч чадахгүй, нэгжийн шилжүүлэг, томъёоны гаргалгаа гаргах мөн тухайн өгөгдлөө ашиглан томъёогоо зөв сонгож чадахгүй, алгоритмээ зохиох, хариуг буруу гаргах математик тооцоолол алдах ойлгоогүй мөртлөө хүүхдээс хуулах зэрэг хүндрэлүүд гарч байна. Химийн бодлого бодоход сурагчдад хамгийн түрүүнд гарч байгаа хүндрэл бол математик арга бичиглэл тооцоолол бөгөөд химийн хичээлийн онолын мэдлэг дутуу байгаа учраас бодлого бодоход нь хүндрэл гарч байна.
- Нийт 136 сурагчаас 5 асуулгаар судалгаа авч үр дүнг боловсруулсан. Та химийн хичээлд сонирхолтой юу гэсэн асуултанд нийт сурагчдын хувьд тийм-60.2%, үгүй-38.8%, химийн бодлого бодоход танд ямар хүндрэл гарч байгаа тухай хичээлээ ойлгоогүй гэж 16.7%, ямар томъёо хэрэглэхээ мэдэхгүй гэж 40.5%, өгөгдлөө зөв өгч чадахгүй гэж 30.2%, нэгжийн шилжүүлэг гэж 12.6% мөн химийн бодлогийг бодоход хүндрэл гарч байгаа шалтгааны хувьд математик суурь муу гэж нийт сурагчийн 70 сурагч, химийн өмнөх мэдлэг дутмаг гэж 61 сурагч, химийн хичээлд сонирхолгүй гэж 45 сурагч. Химийн бодлогийн өгөгдлийг хараад тохирох томъёог ашиглаж чадаж байгаа эсэхэд тийм гэж 61.2%, үгүй гэж 38.8%, химийн бодлого бодоходоо юуг анхаарах нь чухал вэ? Гэсэн асуултанд өгөгдлөө зөв өгөх гэж 40 сурагч, тохирох томъёог зөв тодорхойлох гэж 35 сурагч, өгүүлбэрээ сайн уншиж ойлгох гэж 61 сурагч мэдэхгүй гэж 70 сурагч, хичээлээ ойлгодоггүй гэж 63 сурагч тус тус хариулсан.
- Химийн бодлогыг сайн ойлгуулахын тулд оношлох үнэлгээ хийх, номны жишээ бодлоготой адилхан жишээг багш өөрөө зохиож, нэгжийн шилжүүлэг, нэгжийн болон хүртвэр хувиарын тоон утгыг зөв адил нэгжийг болон хүртвэр, хуваарь дахь тоог хураахдаа, хичээлийн бэлтгэл судалгаанд үндэслэн багш өөрөө хичээлийн бэлтгэл хийж байх үедээ эхлээд бодлогоо бодож сурагчдад яаж хялбар аргаар ойлгуулах алхамаа тодорхойлох мөн нэгж хичээлийн хувьд залгамж холбоо, өмнөх мэдлэгийн жагсаалт гаргах, химийн нэгдлийн нэршил бичүүлж харьцангуй атом масс олуулах, математик болон физикийн багш нартай нь хамтран ажиллах нь чухал юм.

Ном зүй

1. "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" сэдэвт онол практикийн III бага хурлын хураангуй. (2015). Улаанбаатар.
2. "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй-2014". (2014). Улаанбаатар.
3. Chassan.s. (2007). *Learning diffcultes in chemistry Turkish science education . Turkish.*

4. Б.Бурмаа. (2002). Сургууль соёлын шинэ чиг хандлага. Улаанбаатар.
5. Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр "ХИМИ". (2016). Улаанбаатар.
6. Д.Сарангэрэл, Н. Ш. (2017). Хими Х анги. Улаанбаатар.
7. Д.Сарангэрэл, Н. Ш. (2017). Хими XI. Улаанбаатар.
8. Ж.Энэбиш, Ч. Б. (2018). Химийн урвал ухагдахууны хүрээнд сурагчдад илэрч буй өмнөх төсөөлөл, алдаатай ойлголт, алтернатив ойлголтыг судалсан үр дүн. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй V бага хурал, 11.
9. М.Тунгалаг. (2011). Суралцагчийн өөрийн үнэлгээ. Улаанбаатар.
10. Н.Оюунцэцэг. (2015). Багшийн ном: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 9 дүгээр анги. Улаанбаатар.
11. Н.Оюунцэцэг, Н. Ч. (2013). Багшийн ном Хими IV. Улаанбаатар.
12. Н.Оюунцэцэг, Ч. Н. (2014). Багшийн ном Хими V. Улаанбаатар.
13. Н.Оюунцэцэг. (2016). Бүрэн дунд боловсролын X-XII ангийн химийн сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын модуль I. Улаанбаатар.
14. Ч.Нямгэрэл. (2013). БАГШЛАХУЙН ХӨГЖИЛ: Химийн хичээлийн модуль. Улаанбаатар.

“Кейс-судалгаа”-нд суурилсан асуудал шийдвэрлэх арга зүйгээр шинжлэх ухаанч арга барилыг хөгжүүлэх нь

Б.Нарантуяа,
Улаанбаатар хот Шинэ Монгол Харумафүжи сургууль, 95984029,
barsanarka@gmail.com

Удиртгал

Сэдвийг сонгосон үндэслэл:

Асуудал шийдвэрлэх суралцахуй яагаад чухал вэ? “21-р зуунд бичиг үсэгт тайлагдаагүй гэдэгт уншиж эсвэл бичиж чадахгүй байхыг биш, харин сурах чадваргүй, сурахыг хүсдэггүй, тасралтгүй суралцаагүй байхыг ойлгоно.” Future Shock номын зохиогч Алвин Тоффлер гэж хэлсэн байжээ.

Энэхүү санаагаа Японы Васэда Их Сургуулийн профессор Мизүхара [сургалт, 2018]-ын судалгааны илтгэлээс улам дэлгэрүүлбэл, “21-р зуунд улс орон амжилттай хөгжихөд ямар иргэн бэлтгэх ёстой вэ? гэсэн асуултад гурван зүйлийг дурьдвал: 1-рт. Бие дааж үйл ажиллагаа явуулах чадвар буюу өөрөө өөрийгөө удирдах чадвар бүхий иргэн. 2-рт. Олж авсан мэдлэг чадвараа олон дахин ашиглах чадвар буюу олж авсан мэдлэгээ уялдуулан аливаа асуудлыг шийдвэрлэх зэвсэг болгон ашиглах чадвар. Эдгээр чадварыг төлөвшүүлэх нь Японы боловсролын зорилго оршино. Учир нь хүүхдүүд сургууль дээрээ зөвхөн шалгалтад бэлтгэгдэн, түүнд зориулагдсан цээжилсэн мэдлэгээр сайн байхаас гадна сургуулийн гадна бас сайн байх ёстой. Өөрөөр хэлбэл хичнээн мундаг олон дипломтой оюутан амьдралд ажлын байран дээрээ гараад юу ч хийж чадахгүй, мэдлэгээ хэрэглэж чадахгүй, хөрвөх чадваргүй нэгэн байдаг. Энэ бүх байдлыг сайжруулах зорилгоор Японы боловсролд “Төсөлт ажил” хичээлээр дамжуулан сурагчид судалгаа шинжилгээний ажил багаар хамтарч, асуудлыг шийдвэрлэх суралцахуйг хөгжүүлэх шаардлага тавигдах болсон.” гэж хэлсэн байна.

2017-2018 оны хичээлийн жилд Дорнод аймгийн 16 сургуулийн 12-р ангийн 155 сурагчдаас химийн хичээлийн ЭЕШ-д бэлтгэх сунгаа болон явцын үнэлгээний дүнд анализ хийж үзэв. БҮТ-с шинээр боловсруулсан материал болон өмнөх онуудын ЭЕШ-ийн материалаар авсан шалгалтын үнэлгээг харьцуулж үзэхэд амжилт- 50 %, чанар нь 40 %-иар бага байгаагаас үзэхэд **сурагчид мэдлэгээ шинэ нөхцөлд хэрэглэх, тодорхой асуудлыг шийдвэрлэхэд ашиглах чадварууд дутмаг байгаа нь ажиглагдав.** Дэвшүүлсэн асуудал: Хүүхдүүд өмнө олж авсан мэдлэг, чадвараа хэрэглэн аливаа асуудлыг шийдвэрлэх арга барилд суралцаж чадаж байна уу?

ХИМИ

Бүсийн дүн

2017 оны 12 сарын 1

№	Бүсийн нэр	Бүсийн төв сургуулийн захирал	Анги бүлгийн тоо	Сурагчдын тоо	Гүйцэтгэл /хувиргал/																	Ерөнхий дүн												
					Шалтгадсан Цэвэр ба хосломог бодис	Байр	Бодисын ангилал томъёо	Байр	Исэлдлийн зэрэг	Байр	Уусмал уусгах чанар	Байр	Органик урвал нэгдэл тооцоо	Байр	Урвалын дулаан	Байр	Химийн тэнцвэр зурв	Байр	Үелэх систем атомын бүтэц	Байр	Томъёо тэргийгээр тооцоо жийк	Байр	Чанарын урвал	Байр	Гүйцэтгэлийн хувь	Байр	A	B	C	D	F	Анжилт	Байр	
1	3-р бүс	М.Наранжаргал	7	157	30	83.9	1	94.2	1	85.3	1	81.0	1	77.1	1	84.2	1	79.9	1	75.9	1	76.3	1	76.4	1	79.6	1	13	8	3	1	3	89.3	1
2	1-р бүс	Б.Батсух	9	216	38	77.6	2	87.4	2	66.9	3	74.3	2	62.5	4	75.9	2	54.6	3	70.0	3	71.8	2	62.2	2	68.9	2	14	5	4	5	10	73.7	2
3	2-р бүс	Ж.Болормаа	8	197	32	72.2	4	66.3	4	64.3	4	67.7	3	67.9	2	66.2	4	54.8	2	71.7	2	60.0	4	45.0	4	64.1	3	7	6	3	4	12	62.5	3
4	4-р бүс	М.Аюушхорлоо	7	141	22	72.2	3	73.5	3	71.4	2	60.8	4	64.7	3	41.7	5	46.0	4	53.1	4	62.3	3	51.3	3	61.0	4	2	4	0	4	12	45.5	5
5	5-р бүс	Г.Будуяа	8	193	33	69.0	5	65.3	5	61.5	5	60.7	5	45.0	5	70.9	3	43.8	5	53.0	5	54.4	5	44.4	5	51.7	5	6	5	4	3	16	51.5	4
	БНД			904	155	22.8		23.5		21.8		20.9		19.8		21.2		17.4		20.2		20.3		17.5		20.3		41	28	14	17	53	65.4	

0	0	100	0.0	F
Амжилт	33.78			
Чанар	18.92			
А	17			
В	11			
С	11			
Д	11			
Е	98			
А	16			
В	11			
С	11			
Д	11			
Е	98			
А	42			
В	31			
С	14			
Д	17			
Е	54			

Тухайлбал: “Индикатор” сэдэв ухагдахууны талаарх ойлголт , мэдлэг чадвараа өөр нөхцөлд, өөр асуудлыг шийдвэрлэхэд, мөн өмнөх мэдлэгээ сэргээн санах, түүнийгээ дахин хэрэглэх чадвар нь учир дутагдалтай байгаа нь сургалтын явцад сурагчдад гарч байсан тулгамдсан асуудлын нэг байсан.

“Индикатор” сэдвийн агуулгын залгамж холбоо

6-р анги	7-р анги	8-р анги	9-р анги
Индикатор ашиглан хүчил, суурийг таних, саармагжих үзэгдэл, түүний зарим хэрэглээг тайлбарлах	Химийн урвал явагдсаныг индикатор ашиглан илрүүлэх (хүчил+суурь= давс+ ус)	Химийн урвал явагдсаныг индикатор ашиглан илрүүлэх (үелэх хандлага, шүлтийн металл+ус= шүлт + устөрөгч)	Хүчлийн, суурийн оксид, давсыг таних pH универсаль цаасан индикаторыг хэрэглэх

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Олон улсын суралцагчдын үнэлгээний хөтөлбөр /PISA/ нь Олон улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага OECD-гийн гишүүн орнуудын сурагчдын суурь боловсрол эзэмших чадварыг гурван жилд нэг удаа үнэлдэг систем юм.

PISA юу юуг шалгадаг вэ?

- Хүүхдүүдэд олгож буй мэдлэг, чадвар орчин үеийн нийгмийн оролцоонд зайлшгүй чухал хэрэгцээт чадварыг бий болгож буй эсэх
- Тухайн орны түүх, соёл, уламжлалын залгамж байдлыг хангаж байгаа эсэх
- Хүүхдүүд мэдлэгийг эргэн санахдаа гол биш, амьдралын янз бүрийн нөхцөл байдалд асуудлыг хэрхэн шийдвэрлэхэд мэдлэг чадвараа шилжүүлэн ашиглах

Эдийн засагт мэдлэгийг эргэлтэд оруулах өөрөөр хэлбэл хүн сурч мэдсэнээ мэдэх биш, хийх, амьдралд хэрэглэх чадварыг шалгадаг байна. [PISA шалгалтын үр дүнгийн тайлан OECD, 2015 он]

Төрөөс дэвшүүлсэн боловсролын шинэчлэлийн бодлогод 21 дүгээр зууны боловсролын үндсэн зорилго болсон шинжлэх ухаанч арга барилыг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Энэ зорилтыг химийн боловсролд буулган авч үзвэл химийн сургалтын зорилго нь нэг талаас суралцагчдын химийн тухай мэдлэг буюу шинжлэх ухаанч арга барилын хөгжлийг дэмжих, нөгөө талаас химийн мэдлэг эзэмших, мэдлэгээ хэрэглэхэд чиглэгдэх юм.

Зорилго: Сургалтын хөтөлбөрийн зорилгын хэрэгжилтыг үнэлэхэд оршино.

Үнэлгээний зорилтууд:

1. Шинжлэн судлах арга барилын хөгжил
2. Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт
3. Аливаа зүйлийг судлах сонирхол, идэвх зүтгэл, эрмэлзэл зэрэгт гарч буй ахиц өөрчлөлт, хөгжлийг илрүүлэхэд оршино.

Дээрх цөм хөтөлбөрийн үнэлгээний зөвлөмжид химийн сургалтын үнэлгээний арга зүйг дараах үнэлгээний зорилгоор буулган тодорхойлсон байна. Үүнд:


1. Химийн мэдлэг, ойлголт (химийн шинжлэх ухааны болон суралцагчдын эзэмшсэн концепцийн мэдлэгийг үнэлнэ)
2. Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх (химийн мэдлэгийн хэрэглээ, мэдээлэл боловсруулан хэрэглэх, тэдгээрт суурилан асуудал шийдвэрлэх чадвар)
3. Дадлага ажлын чадвар (химийн сорил туршилтын болон шинжлэх ухаанч арга барилын чадвар)
4. Аффектив чадвар (хандлага, төлөвшлийг үнэлнэ) [Н.Оюунцэцэг...нар, 2015]

Бидний сурагчид шинэ арга барилаар суралцаж, шинэ ертөнцөд бэлтгэгдэхэд ямар чадваруудыг эзэмшүүлсэн байх ёстой вэ? Шинэ зууны мастер чадваруудыг багаас нь төлөвшүүлэхэд асуудал шийдвэрлэх сургалт чухал үүрэгтэй. [Карл Поппер, 1999] [Н.Оюунцэцэг...нар, 2015]

Асуудлыг шийдвэрлэхэд танин мэдэхүйн ямар үе шат ордог вэ?

Зураг 1. Асуудлыг шийдвэрлэх арга зам

1. Асуудлыг илрүүлэх
2. Мэдээлэл цуглуулж, санаа дэвшүүлэх
3. Хамгийн оновчтой шийдлийг сонгох
4. Санаагаа хэрэгжүүлж, туршиж үзэх
5. Үр дүнг үнэлэх



Олон төрлийн кейс нь асуудал шийдвэрлэх сургалтын гол орчин юм. Кейс нь амьдралд тохиолддог юм. [Shon, 1983]. Асуудал шийдвэрлэх сургалтын хувьд кейс бол хичээлийн агуулгын жишээ юм. Сургалтад кейс олон үүргийг гүйцэтгэнэ.

- Кейс- судалгаа (жишээлбэл бодит контекст, тулгарч буй асуудлын талаар тодорхой мэдээлэл уншаад асуултын дагуу нөхцөл байдал, шийдлийн хувилбарыг задлан шинжлэх, үнэлэх)
- Кейс- симуляц (загварчлал) (бодлого дасгал, лабораторийн ажлын дадлагатай болох гэх мэт) [Н.Оюунцэцэг...нар, 2015]

Хичээлийн санаа:

Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүй нь нэг талаасаа асуудлыг ухаалгаар шийдвэрлэх чадварт буюу “Бүтээлч сэтгэлгээ”-г хөгжүүлэх нь чухал гэж үзсэн. Ингээд саармагжих үзэгдэл агуулгын хүрээнд, сурагчдаар хийлгэх сорил, туршилтад суурилсан хичээлийг асуудал шийдвэрлэх, ШУАБ-ыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байдлаар хэрхэн багшлахуйн арга зүйг сайжруулах талаар шинэ санаа эрэл хийсэн болно.

Химийн багш нараас “Саармагжих үзэгдлийн хэрэглээ болон хөрсний рН –ийн утгыг тодорхойлох туршилтыг сургалтдаа ашиглаж байсан уу?” гэсэн асуултад туршилтын багаж, индикатор, дадлага ажлын ном, хөрсний дээж байхгүй учраас энэ хичээлийг сорил, туршилтаар үзүүлэх боломж хомс байдаг гэж хариулж байв.

Иймд багш нарт сорил туршилтын дидактик нь гарын доорх материал ашиглан явуулах арга зүйг хөгжүүлэх нь чухал болохыг ойлгуулах хэрэгтэй байлаа.

“Кейс-судалгаа”-нд суурилсан асуудал шийдвэрлэх арга зүйгээр ШУАБ-ыг хөгжүүлснээр сурагчид аливаа асуудлыг шийдвэрлэхдээ шинжлэх ухааны мэдлэг, чадвараа хэрэглэхэд хэрхэн дэмжлэг үзүүлж чадаж буйг судалгаат хичээлээр судлах, үр дүнг тооцоход оршино.

Хичээлийн бэлтгэл судалгаа: Хэрлэн сумын 8-р сургуулийн химийн багш Б.Нарантуяа миний бие, сургалтын менежер Г.Анхжаргалтай хамтран хичээлийн бэлтгэл судалгааг хийсэн. Бүх хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэгт Япон багш Х.Ноако БСУГ-ын мэргэжилтэн Э.Эрхэмтөгс, сургалтын менежер Г.Анхжаргал нар болон зарим хичээлд байгалийн ухааны багш нар оролцсон.


1. Хүүхдийн өмнөх мэдлэг, чадварыг судлах
2. Туршилтын дээж, багажийг гарын доорх материалаар бэлтгэх
\\Үүнд: Хөрсний дээжийг бэлтгэх. Учир нь гурван тариалангийн талбайгаас авсан хөрсний дээжний орчинг багш бодит нөхцөл байдал үүсгэх зорилгоор урдчилан бэлтгэж өгсөн\\

3. Асуудал шийдвэрлэх чадварыг үнэлэх үнэлгээний шалгуур бэлтгэх
4. Кейс- судалгааны өгөгдлийг боловсруулах шийдвэрлэх асуудлыг тодорхойлох

Асуудал шийдвэрлэх арга зүй ба ерөнхий чадваруудыг үнэлэх шалгуур:

Алхам	Асуудал шийдвэрлэх үйл явц ба ерөнхий чадварууд	Үнэлгээ	Жишээ: “Саармагжих үзэгдэл, түүний хэрэглээ” асуудал шийдвэрлэх үйл явц
1.	Шийдвэрлэх буюу шийдэх асуудлыг зөв тодорхойлох. \Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг олж, түүнийг шийдвэрлэх асуудлыг гаргаж ирэх.\	Шийдвэрлэх асуудлыг оновчтой олох, тодорхойлох \Асуудлыг илрүүлэх\	Өгөгдсөн кейсээс тариачинд туслахын тулд түүнд тулгарч байгаа 2 асуудлыг сурагчид олж тогтоох.
2.	Түүнийг шийдвэрлэх аргыг томъёолох \таамаглал, шинэ санаа, шийдэл дэвшүүлэх\	Мэдээлэл цуглуулж, шинэ санаа дэвшүүлэх \Хамгийн оновчтой шийдлийг сонгох\	Тэрхүү асуудлыг шийдвэрлэх арга замыг олох туршилтын төлөвлөгөө, шинэ санааг гаргах. Үүнд: -Гурван талбайн хөрсний дээжийн орчинг универсаль индикатороор таних -Ургац муу авсан хөрсийг сайжруулахын тулд түүнийг саармагжуулах
3.	Асуудлыг шийдвэрлэх санаагаа хэрэгжүүлэх, туршиж үзэх, гүйцэтгэх.	Туршилт явуулах арга барил, туршилтыг бэлтгэх, аюулгүй ажиллагааг мөрдөх	Туршилт явуулах аюулгүй ажиллагааг хангах, химийн багаж сав сонгох, бэлтгэх, гүйцэтгэх.
4.	Үр дүнг нягтлах, үнэлэх Шийдэл буюу таамаглалаа ажиглалт ба туршилтаар шалгах	Үр дүнг боловсруулах, өгөгдлөөс дүгнэлт гаргах. Өөр асуудал, шинэ санаа гаргах.	Туршилтын явцаас шинэ асуудлыг олж харах. Саармагжих үзэгдлийн дараа дахин индикатороор шалгах.

Судалгаат хичээл: 2017 онд Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р сургуулийн 6 а,б,в,г ангид, 2018 онд Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р сургуулийн 6 а,б ангиудад зааж туршиж хичээлийн хөтөлбөрөө хэд хэдэн удаа дахин засаж сайжруулсан бөгөөд хичээлийн судалгаандаа “Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх” загварын менежмент [Ч.Нямгэрэл, Н.Оюунцэцэг, З.Урансайхан, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, П.Лхагвасүрэн, Ц.Отгонбаяр, Ц.Лхагвасүрэн, 2008]-ийг хэрэгжүүлэхийг зорьсон. Судалгаат хичээлд ажиглагч болон зөвлөхөөр Хэрлэн сумын 8-р сургуулийн сургалтын менежер Г.Анхжаргал, 8-р сургуулийн химийн багш Б.Уранчимэг, БСУГ-ын БУ-ны мэргэжилтэн Э.Эрхэмтөгс, мөн аймгийн



химийн багш нар судалгаат хичээлд оролцсон болно.

Загвар 1а.Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх

Судалгааны ерөнхий үр дүн

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд хийсэн зарим сайжруулалт: 2018 оны 3-р сард 6-р ангиудад заагдсан судалгаат хичээлийн арга зүй, төлөвлөлтөд гол сайжруулалт хийгдсэн бөгөөд заримыг дор танилцуулав.

Асуудал шийдвэрлэх арга зүйн төлөвлөлт

Хичээл 1	Шийдвэрлэх асуудлаа тодорхойлох, түүнийг	Дэвшүүлсэн асуудал ба таамаглал	Туршилт	Дүгнэлт ба хүрэх үр дүн
		- Ямар шинж чанартай хөрсөнд ургамал сайн ургах вэ?	Туршилт 1. Хөрсний шинж чанарыг судлах	Суурилаг хөрс нь ургамлын өсөлтөд сайн нөлөөлдөг.
		- Хүчиллэг хөрсийг сайжруулахын тулд юу хийх вэ?	Туршилт 2 Хөрсийг сайжруулах	Хүчиллэг хөрсийг суурилаг бодисоор саармагжуулна.

6-р анги: “Саармагжих үзэгдэл, түүний хэрэглээ” сэдэвт хичээл:

1. Эхний хичээлийн төлөвлөлтөд багшийн зүгээс хүчиллэг, суурилаг, саармаг шинжтэй уусмалуудыг урьдчилан бэлтгэн универсаль индикаторын өнгөний өөрчлөлтөөр уусмалын орчин тодорхойлон судлах туршилтын зорилго, аргачлалыг урьдчилан бэлтгэн өгч байсан билээ.

Энэ нь “Бататгасан ШУАБ”-ын түвшин [Н.Оюунцэцэг, Ч.Нямгэрэл, З.Урансайхан, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, П.Лхагвасүрэн, Ц.Отгонбаяр, Ц.Лхагвасүрэн, 2008] (Зураг 3)-г сургалтын явцад хэрэгжүүлж байсан боловч сурагчдын зүгээс шийдвэрлэх асуудлыг өөрсдөө тодорхойлох, туршилтыг төлөвлөх, гүйцэтгэх, ямар өгөгдөл цуглуулах, гарган авсан өгөгдлийг хэрхэн буулган тайлбарлахаа шийдвэрлэх боломжтой байсан тул “Чиглүүлсэн ШУАБ”-ын түвшинг хэрэгжүүлэхийг зорив.

Зураг 3. Шинжлэх ухаанч арга барилын түвшин:



2. Анхны хичээлийн төлөвлөлтөд “Хүчиллэг орчинтой хөрсөнд ургамал муу ургана. Түүнийг суурилаг бодисоор саармагжуулснаар хөрсний чанарыг сайжруулж болдог юм” гэсэн мэдээллийг багш шууд дамжуулж байсан бол, харин дараа нь “Тариачинд тулгарсан хоёр асуудлыг олж харах, түүнийг шийдвэрлэх сорил туршилтыг төлөвлөх, турших, батлах, үр дүнг нягтлах гэх мэт ШУАБ-д суралцуулах” замаар сурагчид бие дааж шинэ мэдлэг, чадварт суралцаж чадаж байхаар арга зүйн төлөвлөлтийг өөрчилсөн.
3. Анхны судалгаат хичээлийн төлөвлөлтөөр саармагжих үзэгдлийн хэрэглээг хөрс, шүдний оо, ходоодны эмийн жишээгээр тайлбарлан багш мэдээллийг өгч байсан. Гэвч сурагчид нэгэнт өмнөх хичээлээр лакмус, фенолфталеин индикаторын тухай мэдлэг ойлголттой байсан учраас универсаль индикаторын тусламжтай хөрсний орчинг тодорхойлохын тулд кейс өгөгдлөөс асуудлыг олж харах, түүнийг шийдвэрлэхийн тулд, урьдчилан таамаглал дэвшүүлж, туршин судалж, эрэл хийх, үр дүнг нягтлах зэрэг асуудал шийдвэрлэх арга зүйгээр хичээлийн төлөвлөлтийг өөрчлөх хэрэгтэй болсон.
4. Өмнө нь “Туршилтын заавар”, “Үр дүн” тэмдэглэх хүснэгт, “Дүгнэлт” гаргах асуулт зэргийг ажлын хуудсанд багш урьдчилан бэлтгэж өгч байсан бол үүнийг сурагчид бие даан төлөвлөх, турших, үр дүнг нягтлах, дүгнэлт гаргах үйл ажиллагаанд чиглүүлэхэд, багшийн зүгээс зөвхөн шийдвэрлэх асуудал болох “кейс-судалгаа”-г бэлтгэн боловсруулах арга замаар шийдэлд хүрсэн.

5. Эрэл хайлтын асуудлаар сэдэлжүүлдэггүй, шийдвэрлэх таамаглалын “АСУУЛТ” - аа оновчтой томьёолж чадахгүй байв. Тухайлбал, “Хүчиллэг орчинд рН-ын утга хэд байх вэ?” гэсэн хаалттай баримтын мэдлэг шалгасан асуултыг “Яагаад гурван талбайд харилцан адилгүй ургац хурааж авсан бэ? Ургамлын өсөлтөд яагаад хөрсний рН нөлөөлж байна. Муу хөрсийг хэрхэн сайжруулах вэ?” гэсэн нээлттэй шинжлэх ухааны туршилт хийх боломжтой, нотолгоонд суурилсан асуултаар өөрчилсөн билээ.

Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа:

Багшийн асуулт, үндсэн үйл ажиллагаа	Тухайн хэсгийн шийдэл, гол санаа
<u>Хичээлийн эхлэл хэсэг:</u>	
“Кейс-судалгаа”-нд дурдагдсан асуудлыг шийдвэрлэхэд хичээлийн бүхий л үйл явцыг чиглүүлнэ. Ургамлын өсөлтөд хөрсний рН хэрхэн нөлөөлдөг болох талаар асуудлыг шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> Амьдралын энгийн мэдлэгээ сэргээн санах, түүнийг химийн мөн чанарын үүднээс эрэгцүүлэн бодох, тайлбарлах. Ямар хөрсөнд ургамал сайн ургах вэ? Хөрсний чанарыг хэрхэн сайжруулах вэ? гэсэн <u>таамаглал дэвшүүлэх</u>
<u>Хичээлийн өрнөл хэсэг:</u>	
Асуудлыг шийдвэрлэхийн тулд сурагчид туршилтыг төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг нягтлах, боловсруулах гэх мэт үйлийн мэдлэгт суралцана.	<ul style="list-style-type: none"> Химийн сорил туршилт гүйцэтгэх, ажиглах, ажиглалтын тэмдэглэл хөтлөх чадварт хувь нэмэр оруулах Гурван талбайн хөрсний шинж чанарыг универсаль индикатороор тодорхойлох төдийгүй хөрсний шинж чанарыг сайжруулахын тулд саармагжих урвалыг явуулах
<u>Хичээлийн төгсгөл хэсэг:</u>	
Сорил туршилтын үед ажиглагдсан үр дүнг ашиглан ямар хөрсөнд ургамал сайн ба муу ургадаг болох талаар дүгнэлт гаргах. Ургац муу хураасан талбайн хөрсийг хэрхэн сайжруулсан талаар дүгнэлт гарган, саармагжих үзэгдлийн ач холбогдлийн талаар сурагчдаас хариулт авах замаар ярилцах	<ul style="list-style-type: none"> Ажиглалт, химийн урвалын үеийн илрэл зэрэгт үндэслэн химийн урвалын тэгшитгэлийг бичиж тэнцүүлэх Сорил туршилтын үр дүнг химийн мэдлэгтээ тулгуурлан логик сэтгэхүйн аргаар дүгнэж таамаглалаа батлах

Хичээлийн хэсэг тус бүрийн шийдлийг хэрэгжүүлсэн байдал

Кейс-судалгаа \Тариачинд хэрхэн туслах вэ?\

Нэгэн тариачин гурван өөр талбайд лууван тарьжээ. Намар луувангаа хураахад талбай бүрийн ургац харилцан адилгүй байжээ. Нэг талбайн лууван харлаж муудсан байдалтай бол нөгөө талбайн лууван маш сайхан ургасан байжээ. Энэ шалтгааныг олохын тулд тариачин химичдэд ханджээ. Тариачинд хэрхэн туслах вэ? Тариачин химичдээр ямар 2 асуудлыг шийдвэрлүүлэх хэрэгтэй болсон бэ?

Хичээлийн үеийн протоколын зарим хэсгээс ишлэл хийж, тайлбарлах байдлаар хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдлыг дор үзүүлэв.

Ишлэл 1. Хичээлийн эхлэл хэсэг

Хичээлийн энэ хэсэгт багшийн зүгээс асуудал шийдвэрлүүлэх зорилгоор кейс өгч сурагчдад тухайн асуудлыг шийдвэрлэх явц нь хичээлийн зорилго болох ёстой.

Сурагчид өгөгдсөн кейстэй танилцаж, тариачинд тулгарсан асуудлыг олж тогтоох, түүнийг хэрхэн шийдвэрлэх арга замыг эрэл хайх болно. Сурагчид шийдвэрлэх асуудлаа тодорхойлж, таамаглал дэвшүүлнэ.

Ишлэл 1. Хичээлийн эхлэл хэсэг

Багш: Тариачинд ямар асуудал үүссэн бэ?

Хариулт 1: Яагаад гурван талбайд харилцан адилгүй ургац хураасан болоо

Хариулт 2: Яаж 3-р талбай шиг ургацыг нөгөө талбайгаасаа авах вэ?

Хариулт 3: Ирэх жил бүх талбайдаа яаж ижил сайн ургац авах вэ?

Багш: Тариачин химичдээр ямар хоёр асуудлыг шийдвэрлүүлэх хэрэгтэй болсон бэ?

Хариулт 1: Яагаад 1-р талбайд ургасан лууван харлаж муудсан бэ?

Хариулт 2: Яаж хөрсний чанараа сайжруулах вэ?

Ишлэл 2. Хичээлийн өрнөл хэсэг

Багш гурван талбайд ургасан ургацын зургийг харуулснаар сурагчдад тулгуур мэдээлэл болж өгсөн. Ингээд дээрх хоёр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцав.

Багш: Бид юу хийх вэ? (Дээрх хоёр асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар туршилт явуулах вэ?)

Хариулт 1: Хөрсний шинжийг судлах.

Хариулт 2: Индикаторын тусламжтайгаар хөрсний шинж чанарыг судална.

Хариулт 3: Хөрс нь хүчиллэг, суурилаг, саармаг ямар орчинтой болохыг шалгана.

Багш: Ямар шинж чанартай хөрсөнд ургамал сайн ургах вэ?

Хариулт 1: Суурилаг

Хариулт 2: Саармаг

Хариулт 3: Хүчиллэг

Сорил туршилтыг эхлэхийн өмнө баримтлах ёстой аюулгүй ажиллагааны дүрмийг сануулсан бөгөөд багажаа зөв сонгон, туршилтын төлөвлөгөөг боловсруулан багшид шалгуулан зөвшөөрөл авсан багууд сорил туршилтаа гүйцэтгэсэн.

Ишлэл 3. Хичээлийн төгсгөл хэсэг

Багш: Ямар шинжтэй хөрсөнд ургамал сайн ургасан бэ?

Хариулт 1: Сул суурилаг

Багш: Ургац муу хураасан хөрсний шинж чанарыг хэрхэн сайжруулах вэ?

Хариулт 1: Хүчиллэг шинжтэй хөрсийг саармагжуулахын тулд суурилаг шинжтэй уусмалтай холино.

1. Эцэст нь сурагчид “Саармагжих үзэгдэл, түүний хэрэглээ” судалгаат хичээлээр мэдлэгийг асуудал шийдвэрлэх, туршилт судалгаан дээр үндэслэн нээж чадаж байсан. Үүнд, хөрсний шинж чанарыг рН индикаторын тусламжтайгаар судалж, хөрсний шинж чанарыг сайжруулахад саармагжих үзэгдлийг хэрэглээ болгох чадварт суралцаж байв. Ингээд хичээлийн бүхий л үйл явцыг багш самбарт тэмдэглэл хөтөлж байсан учраас сурагчид тэмдэглэл хийх, үр дүнг ажиглах, харьцуулах, дүгнэлт гаргахад маш их дэмжлэг үзүүлсэн. Хичээлийн явцад сурагчдын зүгээс учир шалтгааныг нээх, олох, сонирхсон асуултаа дэвшүүлж байсан. Ургамлын өсөлтөд хөрсний рН нөлөөлөх нь юунаас шалтгаалдаг болох хөрс яагаад янз бүрийн рН орчинг үүсгэдэг талаар асууж сонирхож байсан.

Асуудал шийдвэрлэх арга зүйн кейс өгөгдлийг боловсруулахад дараах зүйлийг анхаарах нь чухал болох нь харагдаж байна.

1. Химийн шинжлэх ухааны агуулгыг контексжүүлэх /амьдралын бодит жишээ/
2. Тухайн асуудлыг шийдвэрлэхийн тулд сорил, туршилтад суурилсан
3. Кейс нь тухайн сурагчдын өмнөх мэдлэг, чадварт тулгуурлан, түүнийг хэрэглэх боломжтой асуудал дэвшүүлсэн байх
4. Шийдвэрлэх асуудлаа бие даан олж харах боломжтой, асуудлаа ялгахад чиглэгдсэн байх
5. Багшийн зүгээс асуудал шийдвэрлэх арга зүйгээр сурагчдын ШУАБ-ыг хөгжүүлэхийн тулд “зохион байгуулсан эсвэл чиглүүлсэн ШУАБ” –ын түвшинг ахиулах нь чухал болох нь харагдаж байна.

Иймд нийт ангийн сурагчдын хувьд 90% - 97% нь онолын хувьд харьцангуй зөв дүгнэлт гаргаж байсан учраас хичээлийн энэ хэсэгт бэрхшээл гараагүй.

Дүгнэлт

Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүйгээр хичээллэснээр хүүхдүүд бие дааж судалж, бодож, ажиглалт хийлгэхийн тулд туршилт, судалгаагаар дамжуулан аливаа асуудлыг шийдвэрлэхэд мэдлэгээ хэрэглэх чадварт суралцаж байсан. Асуудал шийдвэрлэх сургалтын үед:

- Хүүхэд асуудлыг олох
- Өөрөө эргэцүүлэн бодох
- Өмнөх мэдлэгээ хэрэглэх
- Урьдчилан бодох төсөөлөх, төлөвлөх зэрэг олон чадварыг хөгжүүлж чадаж байсан.

Сурагчид хичээл бүрээр ШУАБ-ын түвшинг ахиулах тутам дараах чадваруудад суралцаар байсан. Үүнд:

- Таамаглал дэвшүүлэх буюу тайлбарлах, урьдчилан тааварлах,
- Туршилтыг төлөвлөх ба гүйцэтгэх
- Туршилтын үр дүнг ашиглан, нотолгоог буулган дүгнэлт гаргах;
- Бусдадаа дамжуулах, тайлбарлах чадварт ахиц өөрчлөлт гарч чадсан билээ.

Асуудал шийдвэрлэх арга зүйн мөн чанар нь: Сурагчдад судалгааны арга зүйг эзэмшүүлэх, асуудлыг олж харан томъёолох, гүн бат мэдлэг чадвартай болгох, хамтран ажиллах чадварыг хөгжүүлсэн.

Асуудал шийдвэрлэх арга зүйг хэрэгжүүлэхэд хоёр зүйлийг хамтад нь нэгдмэл байдлаар зайлшгүй авч үзэх нь чухал болохыг ойлгов.

Үүнд, нэг талаас шинжлэх ухааны онолын суурь мэдлэг нөгөө талаас түүнийг хэрэглэх аливаа асуудлыг шийдвэрлэхэд ашиглах арга ухаанд зэрэгт суралцуулах чухал хэрэгтэй.

Энэ хоёр сургалт хоёулаа чухал бөгөөд аль нэг нь байхгүй бол сурагчдын ШУАБ-ыг бүрэн хөгжүүлэхэд учир дутагдал үүсэж байв.

Эцэст нь дүгнэхэд асуудал шийдвэрлэх арга зүйг хэрэгжүүлэх явцад дараах сул талууд байсан.

Үүнд:

- Хүүхдэд ШУАБ-ын түвшинг ахиулахад цаг их шаарддаг, туршилтын ур чадвар, дадалд суралцсан байдал нөлөөлөхөөс гадна өмнөх шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар сайн байж түүнийг хэрэглэх нь чухал бол,
- Багшийн хувьд илүү нарийн төлөвлөлт, кейс даалгаврыг бэлтгэх, асуудлаа оновчтой тодорхойлох, химийн бодис, багаж хэрэгсэл зэргийг судалж арга зүйгээ сонгох хэрэгтэй байсан тул багшийн боловсруулсан зарим дасгал ажил, кейс бүтэлгүй болох тохиолдол үүсэж байсан.

Ном зүй

1. *Н.Нэргүй, Ч.Нямгэрэл, Ш.Оюунцэцэг, Ө.Цэндсүрэн, Л.Сувдаа, Я.Нарангэрэл, Х.Баясгалан, Ц.Намжилдорж, Д.Энхтуяа. (2013). Багшлахуйн хөгжил: Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент. Улаанбаатар.*
2. *Ч.Нямгэрэл, Н.Оюунцэцэг, З.Урансайхан, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, П.Лхагвасүрэн, Н.Отгонбаяр, Ж.Батбилэг. (2007). Сорил тооцоогоор мэдлэг бүтээлгэх арга зүй. Улаанбаатар.*
3. *Ч.Нямгэрэл, Н.Оюунцэцэг, З.Урансайхан, Г.Баярмаа, Ш.Сайнбилэг, П.Лхагвасүрэн, Ц.Отгонбаяр, Ц.Лхагвасүрэн. (2009). Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй. 10-15 хуудас. Улаанбаатар.*
4. *Н.Оюунцэцэг, Д.Сарангэрэл, Ш.Сайнбилэг, Н.Наранцогт, Г.Баярмаа. (2015). Багшийн ном Хими VIII. 7-14 хуудас. Улаанбаатар.*
5. *Н.Оюунцэцэг, Д.Сарангэрэл, Ш.Сайнбилэг, Н.Наранцогт, Г.Баярмаа, Ж.Энэбиш, Ц.Отгонбаяр. (2015). Багшийн ном. Хими IX. Улаанбаатар.*
6. <http://www.itpd.mn/teacher-development/research/1115> *OECD 2015 оны PISA шалгалтын үр дүнгийн тайлан*
7. <http://bataabaatar.blogspot.com/2015/01/21.html> *Б.Батаа (2015). Шинэ цагийн боловсрол буюу 21-р зууны чадварууд.*

“Молекул кинетикийн онол” ээлжит хичээлийн арга зүйн туршлага

¹Наранбаатар Баярсайхан, m.bayaraa0616@gmail.com

¹Мягмар Түвшинзаяа, tuvshe_1144@yahoo.com

²Ардхүү Дэмбэрэлнямбуу, deemee0325@yahoo.com

³Пүрэвсүрэн Пүрэвдорж, ppurewdorj2016@yahoo.com


Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Шинэ-Үе сургуулийн ¹химийн багш, ²сургалтын менежер, ³физикийн багш
Дэлгэрэнгүй

Удиртгал

Зорилго: Сурагчдын молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр ухагдахууны (алдаатай) ойлголтыг илрүүлэх, хөдөлгөөнт дүрс ашиглан үнэн зөв төсөөлөл бий болгох

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Суурь боловсролын 9-р ангийн “Бодисын төлөв шинж чанар” бүлгийн, “Бодисын төлөв, төлөвийн шилжилт” нэгж хичээлийн, “Молекул кинетикийн онол” ээлжит хичээлийн бэлтгэл судалгааны хүрээнд агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Онол арга зүй

 Хичээлийн судалгаа

Орчин үед хичээлийн судалгааг багш ажлын байран дээрээ мэргэжил дээшлүүлэх албан бус тогтолцоо, арга зүйн шинэчлэлийг хөгжүүлэх тогтолцоо, боловсролын шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо болтлоо хөгжсөн гэж үздэг. Хичээлийн судалгаанд оролцож хичээл зааж байгаа багшид ч, хичээлд ч оноо дүн тавьдаггүй бөгөөд оролцогчид бүгд шинийг эрэлхийлж, суралцаж судалдаг, хүүхэд судлал, хичээл судлалын чухал эх сурвалж болдог зэрэг олон давуу талтай багш нарын сайн дурын үйл ажиллагаа юм.

Хичээлийн судалгааг зориулалтаас нь хамааруулж дараах байдлаар ангилна (1-р хүснэгт).

Хүснэгт 1. Хичээлийн судалгааны ангилал /зориулалтаас хамааран/

№	Зориулалт	Зорилтот бүлэг	Зохион байгуулах түвшин	Практик хэрэглээ
1	Сайн хичээлийн туршлага судлахад	Залуу багш	Сургуулийн хэмжээнд	Багш ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэхэд
2	Хичээлийн арга зүйг сайжруулахад	Багшийн ангийн оюутан	Дүүрэг, аймаг/нийслэлийн хэмжээнд	Мэргэжил дээшлүүлэх сургалтад
3	Хичээлийн судалгаа хийх аргад сургахад	Судлаач	Улсын хэмжээнд	Ур чадварын тэмцээнд
		Мэргэжлээ дээшлүүлж буй багш		Сургуулийн хөгжилд
				Шинэ арга зүйг олж судлан түгээн дэлгэрүүлэхэд
4	Хэрэглэгдэхүүний судалгаа хийх, туршихад	ЕБС-ийн судлаач багш	Их дээд болон ЕБС-ийн хэмжээнд	Судлаачийн түвшинд судалгааны ажил хийхэд
		Их дээд сургуулийн судлаач багш	Дүүрэг, аймаг/нийслэлийн хэмжээнд	Сургалтын болон судалгааны материал боловсруулахад
		Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэдэг байгууллага	Улсын хэмжээнд	

Аналитик рубрик

Рубрик нь субъектив үнэлгээг хэмжээсжүүлэх хэрэгсэл бөгөөд бичгийн ажил, төсөлт ажил, эссэ болон бусад даалгавар дахь сурагчийн гүйцэтгэлийг үнэлэхэд хэрэглэгдэх суралцахуйн зорилттой холбоотой стандарт ба шалгуурын багц юм. Тухайн даалгаврын сурагчдын гүйцэтгэл өөр, өөр байх учир ямар гүйцэтгэлд ямар дүн өгөх вэ гэдэг нь тодорхойгүй байдаг тул багш сэтгэлийн хөдөлгөөн, үзэмжээр дүн тавих байдал гарах боломжоос сэргийлдэг хэрэгсэл юм. Хүсэж буй үр дүнд хүрэхийн тулд тухайн сурагчийн мэдэх ёстой тэрхүү шалгууруудыг тодорхойлон жагсаадаг зэрэглэл тогтоох хэмжүүр учраас шалгуурт тулгуурладаг.

Бүтцийн хувьд аналитик рубрик нь хэд хэдэн мөр багана бүхий хүснэгтэн хэлбэрийн хөлгөн мэдээллийг агуулдаг бөгөөд тухайн бүтээгдэхүүн, процессын бие даасан хэсгүүд буюу тусгайлсан зүйлсийг дүрслэн үзүүлдэг. Аналитик рубрик нь суралцагчийг гүйцэтгэлийн хэд, хэдэн чиглэл тус бүрээр үнэлдэг.

Сэдвийг сонгосон чиг хандлагын үндэслэл:

Техник, технологийн асар хурдацтай хөгжлийн явцад багш бид нар сурагчдын хэрэгцээ, сонирхлын үндэслэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах нь сургалтын үр дүн, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд зохистой хэрэглээг дэмжиж, бодитоор нүдэнд харагдахгүй хийсвэр ухагдахууны талаар үнэн зөв төсөөлөл бий болгох, мөн боловсролын хувьд хүүхэд нэг бүрийг болон багшлахуйн арга зүйг хөгжүүлэх гэсэн хүн төвтэй бодлогыг боловсролын чанарын шинэчлэлийн зорилт болгон хэрэгжүүлсэн. Иймээс багш нар цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн багаар хамтран, судалгаатай ханддаг болж эхэлсэн. Үүнд:

4. Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар “Молекул кинетикийн онол”-г судлах, хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг хамтран хөгжүүлэх
5. Хөтөлбөрийг оновчтой арга зүйгээр төлөвлөн хэрэгжүүлснээр гол концепцийг ойлгуулах боломжтой төдийгүй хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлдэг эсэхийг судлах арга зүйн туршлагаа хуваалцах, бусдаас зөвлөгөө авч хөгжүүлэхээс үүдэн энэхүү илтгэлийг толилуулж байна.

Хичээлийн санаа:

“Молекул кинетикийн онол” гэсэн ээлжит хичээлийн эхлэл буюу ¹сэдэлжүүлэх хэсэгт өмнөх мэдлэгийг сэргээх, оношлох зорилгоор “Монголчууд яагаад зуны халуун өдрүүдэд гэрийн хаяавчаа сөхөж сэрүүцдэг вэ? Хэрэв гэрийн хаяавчийн ойролцоо унтвал даарч хонох уу? Халууцаж хонох уу? Яагаад? асуултаар баг доторх хэлэлцүүлгийг өрнүүлж, нэгдсэн хэлэлцүүлгээр багуудын санал, таамаглалыг сонсон өмнөх ямар төсөөлөлтэй байгаа тухай мэдээлэл авна. Хичээлийн ²шинжлэн судлах буюу тайлбарлах хэсэгт халуун болон хүйтэн усны нягтыг харьцуулсан туршилтыг гүйцэтгүүлж, усыг халаахад усны молекулуудын хөдөлгөөний хурд улмаар кинетик энерги өсөх тул хүйтэн усны молекулуудтай харьцуулбал хөдөлгөөн нь хурдан, молекул хоорондын зай ихэссэн байна. Иймд нягт багассан байна. Халуун устай колбо дээр хүйтэн устай колбыг хөмрүүлж тавих нь нягт багатай шингэн дээр нягт ихтэй шингэнийг хөмрүүлж тавина.

Хичээлийн ³тайлбарлах үе шатанд гүйцэтгэсэн туршилтын үр дүнд асуултын дагуу задлан шинжлэх үйл хийгдсэнээр бодисын төлөв, төлөвийн шилжилтийг тайлбарлаж буй молекул кинетикийн онолын гол санааг тайлбарлана.

Хичээлийн ⁴нарийвчлах шатанд phet.colorado.edu.com болон хөдөлгөөнт дүрсийг ашиглан туршилтын үйл явцыг жижиг хэсгийн загвараар дүрслэх, хичээлийн эхэнд болон төгсгөл дэх сурагчдын ойлголтыг харьцуулан дүгнэлт гаргана.

Хичээлийн бэлтгэл судалгаа:

Шинэ Үе сургуулийн сургалтын менежер А.Дэмбэрэлнямбуу (МУ-ын гавьяат багш), химийн багш М.Түвшинзаяа, Н.Баярсайхан нар хамтран хичээлийн бэлтгэл судалгааг хийж, хөтөлбөрийг 3 удаа туршин хэрэгжүүлж, ажиглалт, хэлэлцүүлгээр илрүүлсэн саналдаа үндэслэн хөтөлбөрийг сайжруулж ажилласан. Хэрэглэгдэхүүний судалгааны хүрээнд хөдөлгөөнт дүрс болон *simulation, interactive* хичээлүүдийг ашигласан болно.

Судалгаат хичээл



Ажиглалтын судалгааг суралцахуйн сэтгэл судлалын конструктивизмын “мэдлэг бүтээгддэг” зарчимд тулгуурлан суралцагчдын болон багшийн алдаа оноо, сурах арга барилд дүгнэлт хийх замаар хичээлийн арга зүйг хөгжүүлэх байдлыг илрүүлэхүйц шалгуураар хичээлийг үнэлдэг. Улмаар заасан багш болон хичээлийн судалгаанд оролцогчид энэхүү үйл ажиллагааны явцад багшлах арга зүй, ур чадварын хувьд хөгжинө.

Бүдүүвч 1. Судалгаат хичээлийн бүтэц

[Ш.Сайнбилэг, Н.Оюунцэцэг “Хичээлийн судалгаа нь багшлах арга зүйд нөлөөлж буй эсэхийг судалсан үр дүнгээс” 2014 он]

Судалгаат хичээл 1. 2016 оны 09-р сарын 05-09-нд “Молекул кинетикийн онол” судалгаат хичээлийн бэлтгэл судалгааг хийж, 9а ангийн 25, 9б ангийн 24 сурагчдын дунд туршин зааж, хэлэлцүүлэг зохион байгуулж хамтран сайжруулсан. Хичээлийн хэлэлцүүлгээр: Сурагчдын молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр (алдаатай) ойлголт /*хатуу бодис хөдөлдөггүй, тогтвортой байдаг учир жижиг хэсгүүд ч мөн хөдөлдөггүй, хатуу төлөвийг бодисын жижиг хэсгийн загвараар зураглах/-*ыг илрүүлж ажлын хуудасны боловсруулалт болон сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулсан. Мөн хичээлийг химийн лабораторид бус компьютерийн лабораторид орох шийдлийг гаргасан.

Судалгаат хичээл 2. 2017 оны 09-р сарын 04-08-нд “Молекул кинетикийн онол” судалгаат хичээлийн бэлтгэл судалгааг хийж, 9а ангийн 20, 9б ангийн 22 сурагчдын дунд туршин зааж, хэлэлцүүлэг зохион байгуулж хамтран сайжруулсан. Хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэгт сургалтын менежер А.Дэмбэрэлнямбуу, химийн багш М.Түвшинзаяа, Н.Баярсайхан нар хамтран ажилласан. Хичээлийн хэлэлцүүлгээр: ¹Компьютерийн лабораторид хичээлийг зохион байгуулах, ²бодисын төлөв, жижиг хэсгийг шинжийг харуулсан видео бичлэг үзүүлэх, хичээлийн төлөвлөлт, ажлын хуудасны боловсруулалтыг сайжруулах, ³Молекул кинетикийн онолын физикийн хичээлтэй интеграцлах зэрэг арга зүйн болон хэрэглэгдэхүүний сайжруулалтыг хийсэн.

Судалгаат хичээл 3. 2018 оны 09-р сарын 03-07-нд “Молекул кинетикийн онол” судалгаат хичээлийн бэлтгэл судалгааг хийж, 9а ангийн 28, 9б ангийн 25 сурагчдын дунд туршин зааж, хэлэлцүүлэг зохион байгуулж хамтран сайжруулсан. Хичээлийн хэлэлцүүлгээр: ¹Компьютерийн лабораторид хичээлийг зохион байгуулах нь шинэлэг тал боловч сурагчдын цаг ашиглалт, идэвх оролцоо зэрэг (компьютерийг өөр зорилгоор ашиглах)-т хүндрэл гарч байсан тул толгой компьютерээс бүх компьютерийг удирдах, ²бодисын нягтын талаарх видео үзүүлэх (<https://www.youtube.com/watch?v=1dx-Tx5dPKk>), ³видео үзүүлэхээс гадна сурагчдын молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр (алдаатай) ойлголтыг хөдөлгөөнт дүрс (<Phet.colaroda.edu.com>) ашиглан үнэн зөв төсөөлөл бий болгох, хичээлийн төлөвлөлтийн зарим үе шатуудад чиглүүлэх асуулт асуух зэрэг арга зүйн болон хэрэглэгдэхүүний сайжруулалтыг хийсэн.

³Температурын өөрчлөлтөөс хамааран хийн жижиг хэсгүүдийн кинетик болон потенциал энергийн өөрчлөлтийг ажиглуулах

²Химийн хийсвэр ухагдахууныг ойлгуулахад хөдөлгөөнт дүрсийг ашиглан сурагчдад бодитоор мэдрүүлж, хооронд нь харьцуулж, сонирхон судлах нөхцлийг бүрдүүлэх

¹Хичээлийн арга зүйг сайжруулах, Бодисын нягтын зөрүүг үндэслэн молекул кинетикийн онолыг тайлбарлах

²Сурагчдын молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр (алдаатай) ойлголтыг молекулын бүтэц, загварчлалыг харуулсан видео үзүүлэх

¹Хичээлийн арга зүйг сайжруулах, "Молекул кинетикийн онол"-ын талаар сурагчдад үнэн, зөв төсөөлөл бий болгох

Судалгаат хичээл – 3

(Ажлын хуудас-3)
(Видео)
(Хөдөлгөөнт дүрс)

2018

(Компьютерийн лаборатори)

Судалгаат хичээл – 2

(Ажлын хуудас-2)
(Видео)
(Хөдөлгөөнт дүрс)

2017

(Компьютерийн лаборатори)

²Сурагчдад алдаатай ойлголт үлдээж буйн шалтгааныг тогтоох, хичээлийн арга зүйг сайжруулах

¹"Молекул кинетикийн онол" сэдвийн хүрээнд сурагчдын шинжлэх ухааны хийсвэр (алдаатай) ойлголтыг илрүүлэх

Судалгаат хичээл – 1

(Ажлын хуудас-1)
(Видео)

2016

(Химийн лаборатори)

Бүдүүвч 2. "Молекул кинетикийн онол" судалгаат хичээлийн ерөнхий бүдүүвч

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл

Үе шаг	Хөтөлбөр 1	Хөтөлбөр 2	Хөтөлбөр 3
	Анхны төлөвлөлт	Сайжруулалт	
Шинжлэн судлах	Д1: Бодисыг төлөвөөр нь хэд ангилдаг вэ ? Төлвийн шинж чанарыг тодорхойлно уу. Д2: Бодисын хатуу, шингэн, хийн төлөвийг загварчлах	Д. Phet.colorado.edu.com сайт руу нэвтрэн төлөвийг харьцуулан судалж, хичээлийн төгсгөл гэсэн хэсэгт хатуу, шингэн, хийг загварчлах, ялгааг харьцуулан ярилцах	Д. Халуун усанд улаан өнгийн будагч бодис, хүйтэн усанд цэнхэр өнгийн будагч бодис хийсэн бол холилдохгүй байгаа шалтгааныг тайлбарлуулах https://www.youtube.com/watch?v=Idx-Tx5dPKk Д. Phet.colorado.edu.com сайт руу нэвтрэн төлөвийг харьцуулан судалж, 130°C болон 180°C температурт хийн хөдөлгөөнийг ажиглах, ялгааг харьцуулан ярилцах
Нарийвчл	А. Монголчууд зуны халуунд гэрийн хаягаа сөхөж сэрүүцдэг шалтгаан юу вэ? <i>/Бодисын нягттай холбон дүгнэлт гаргуулах/</i>	А. Монголчууд зуны халуунд гэрийн хаягаа сөхөж сэрүүцдэг шалтгаан юу вэ? <i>/Бодисын нягттай холбон дүгнэлт гаргуулах/</i>	
Үнэлэх	Халуун усанд улаан өнгийн будагч бодис, хүйтэн усанд цэнхэр өнгийн будагч бодис хийсэн бол холилдохгүй байгаа шалтгааныг тайлбарлуулах https://www.youtube.com/watch?v=Idx-Tx5dPKk	Халуун усанд улаан өнгийн будагч бодис, хүйтэн усанд цэнхэр өнгийн будагч бодис хийсэн бол холилдохгүй байгаа шалтгааныг тайлбарлуулах https://www.youtube.com/watch?v=Idx-Tx5dPKk	Д. Молекул кинетикийн гол санааг тайлбарлах, дүгнэлт бичих

Судалгааны үр дүн


1. Сурагчдын молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр ухагдахууны (алдаатай) ойлголтыг илрүүлсэн.
2. Бодисыг халаах эсвэл хөргөхөд жижиг хэсгийн хөдөлгөөний хурд улмаар кинетик энерги өөрчлөгддөг учир жижиг хэсгүүд хоорондын таталцлын хүч улмаар хоорондын зай өөрчлөгдөнө иймд бодисын нягт өөрчлөгддөг гэсэн санааг нүдэнд үл харагддаг жижиг хэсгүүдийг хөдөлгөөнт дүрсээр орлуулан үзүүлсэнээр молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр ойлголтын талаар зөв төсөөллийг бий болгосон.
3. Хичээл хоорондын интеграцийг гаргасан
4. Сургалтанд мэдээлэл харилцааны технологийг ашигласнаар сурагчдын сурах сэдэл, тэмүүлэл, оролцоо нэмэгдсэн.
5. “Молекул кинетикийн онол” хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулж өгсөн.

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлт, сургалтын хэрэглэгдэхүүнд хийсэн сайжруулалтыг дараах алхмаар харуулав:

А. Сурагчдын молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр (алдаатай) ойлголтыг илрүүлсэн байдал

- Сурагчдын ажлын хуудас 1-ийн “Бодисын төлөвийн шинжийг тодорхойлох” болон “Бодисын төлөвийг жижиг хэсгийн загвараар илэрхийлэх” даалгаваруудын гүйцэтгэлд үндэслэн хатуу бодис маш бага хэлбэлзэх хөдөлгөөнд оршдог гэж тайлбарласан боловч жижиг хэсгийн загвараар илэрхийлэхдээ хэлбэлзэх хөдөлгөөнийг тусгаагүй байсан.
- Сурагчдын ажлын хуудас 2-ийн “Бодисын төлөвийг жижиг хэсгийн загвараар илэрхийлэх”¹ хичээлийн эхэнд, болон ² хичээлийн төгсгөлд даалгаваруудын гүйцэтгэлд үндэслэн хатуу бодис маш бага хэлбэлзэх хөдөлгөөнд оршдог гэж тайлбарласан боловч жижиг хэсгийн загвараар илэрхийлэхдээ хэлбэлзэх хөдөлгөөнийг бүрэн зураглаагүй байсан.

В. Сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулалт

 Ажлын хуудас:

Ажлын хуудсаар дамжуулан сурагчдын сурах үйл, ажиллах алхамыг чиглүүлэн ажилласан.

АЖЛЫН ХУУДАС 1		
Үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Таамаглал дэвшүүлэх-сэргээн санах, сэдэлжүүлэх	Асуулт 1. Монголчууд зуны халуунд гэрийн хаяагаа сөхөж сэрүүцдгийн шалтгаан юу вэ?	Асуулт 1. Монголчууд зуны халуунд гэрийн хаяагаа сөхөж сэрүүцдгийн шалтгаан юу вэ? <i>/Зурган мэдээлэл оруулсан/</i>
АЖЛЫН ХУУДАС 2		
Үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Нарийвчлах	Ярилцлагын дүнд дүгнэлт гаргуулах <i>Дулааны нөлөөгөөр жижиг хэсгийн хөдөлгөөн хэрхэн өөрчлөгдөж байгаа эсэхийг тодорхойлж халуун агаар сийрэг учраас хүйтэн агаартай харьцуулахад нягт багатай болдог гэсэн дүгнэлт гаргуулах</i>	Сэдэлжүүлэх хэсгийн асуултыг дахин тавьж шалтгааныг тайлбарлуулах Асуулт 3. Монголчууд зуны халуунд гэрийн хаяагаа сөхөж сэрүүцдгийн шалтгаан юу вэ?
АЖЛЫН ХУУДАС 3		
Үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Шинжлэн судлах		Нарийвчлах хэсгийн асуултыг эрэл хайлтын асуулт болгон оруулсан. Асуулт 2. Халуун усанд улаан өнгийн будагч бодис, хүйтэн усанд цэнхэр өнгийн будагч бодис хийсэн бол холилдохгүй байгаа шалтгааныг тайлбарлана уу? <i>/Зурган мэдээлэл оруулсан/</i>

Шинжлэн судлах	Даалгавар 3. Бодисын төлөвийг жижиг хэсгийн загвараар илэрхийлэн ажлын хуудсанд /Хичээлийн эхэнд болон төгсгөл хэсэгт/ зураглана уу.	ДААЛГАВАР 1. Бодисын төлөв, шинж чанарыг тодорхойлж, бодисын жижиг хэсгийн загвараар илэрхийлэх /Хүснэгтэн мэдээллийг тодорхой өгч ажлуулсан/
----------------	---	--

Ажлын хуудсыг илүү чанартай боловсруулж, хичээлдээ ашиглах нь суралцагчдын суралцах үйлд хэрхэн нөлөөлж буйг илрүүлэхийн тулд давтан заасан судалгаат хичээл тус бүрээр сурагчдын ажлын хуудасны гүйцэтгэлийн ялгааг аналитик рубрикийн арга ашиглан тодорхойлсон. Нийт 144 ажлын хуудсанд дүн шинжилгээ хийсэн.

 Видео:

Бодисын төлөвийн шилжилтийг бодисын нягтын өөрчлөлттэй холбон тайлбарласан агуулга бүхий видеог сонгон авснаар *бодисыг халаах, эсвэл хөргөхөд жижиг хэсгүүдийн хөдөлгөөний хурд улмаар кинетик энерги өөрчлөгддөг учир жижиг хэсгүүд хоорондын таталцлын хүч улмаар хоорондын зай өөрчлөгдөнө. Иймд бодисын нягт мөн өөрчлөгддөг* гэсэн дүгнэлтэд хүрсэн.

 Цахим хэрэглэгдэхүүн

Бодисын төлөв, жижиг хэсгийн шинж, төлөвийн шилжилтийг харуулсан агуулга бүхий видео үзүүлэхийн оронд химийн хийсвэр ухагдахууныг ойлгуулахад хөдөлгөөнт дүрс ([Phet.coloroda.edu.com](http://Phet.colorado.edu.com))-ийг ашиглан жижиг хэсгийн хөдөлгөөн, таталцлын хүч, хоорондын зай хэрхэн өөрчлөгдөж буйг сурагчдад бодитоор мэдрүүлж, хооронд нь харьцуулж, сонирхон судлах нөхцлийг бүрдүүлснээр *бодисыг халаах, эсвэл хөргөхөд жижиг хэсгүүдийн хөдөлгөөний хурд (кинетик энерги) өөрчлөгддөг учир жижиг хэсгүүд хоорондын таталцлын хүч улмаар хоорондын зай (потенциал энерги) мөн өөрчлөгддөг, улмаар төлөвийн шилжилт явагддаг болохыг тодорхойлсон.*

С. Хичээл хоорондын интеграци

Молекул кинетикийн онолыг бодисыг бүрдүүлэгч жижиг хэсгийн хөдөлгөөний хурд, жижиг хэсгүүд хоорондын таталцлын хүч болон хоорондын зай өөрчлөлтөд үндэслэн тайлбарлахын тулд тухайн бодисын нягттай холбон тайлбарлах чухал юм. Тиймээс ч сурагчид нягтын тухай физикийн хичээл дээрээ илүү дэлгэрэнгүй үздэг тул физик болон математикийн хичээлүүдтэй интеграцчилах нь илүү үр дүнтэй. Хичээлийн сэдэлжүүлэх хэсгийн асуулт болох “*Монголчууд зуны халуунд гэрийн хаяагаа сөхөж сэрүүцдгийн шалтгаан*”-ыг бодисын нягттай холбон тайлбарласнаар молекул кинетикийн онолыг тайлбарлахад дөхөм болж буй юм.

ДҮГНЭЛТ

- Судалгаат хичээлээр сурагчдын хийсвэр ухагдахууны тухай үнэн зөв ойлголттой болох арга зүйн шинэлэг санааг 9 дүгээр ангийн “Молекул кинетикийн онол” гэсэн ээлжит хичээл дээр хэрэгжүүлэн үр дүнг туршсан болно.
- Молекул кинетикийн онолын талаарх шинжлэх ухааны хийсвэр ухагдахууны (алдаатай) ойлголтыг илрүүлж, сурагчдад үнэн зөв мэдлэг бүтээлгэх, шавь төвтэй хичээлийг зохион байгуулсан.
- “Молекул кинетикийн онол” хичээлийн агуулга харьцангуй физикийн хичээлийн агуулгатай холбогдож буй учир хичээл хоорондын интеграци хийж (нягтын зөрүүг илэрхийлсэн бичлэг үзүүлэх, <https://www.youtube.com/watch?v=1dx-Tx5dPKk>) бодисын жижиг хэсгийн кинетик энерги өөрчлөгдсөнөөр жижиг хэсгүүд хоорондын таталцлын хүч өөрчлөгддөг. Таталцлын хүчний өөрчлөлтөөс хамааран нягт өөрчлөгдөж бодисын төлөв шилждэг гэсэн ойлголтыг сурагчдаар гаргуулахын тулд молекулын бүтцийг, загварчилан хөдөлгөөнт үзүүлэн бэлтгэсэн phet.colorado.com сайтыг ашигласан.
- Хичээлийг компьютерийн лабораторид ажлын хуудсаар чиглүүлэн зохион байгуулж жижиг хэсгийн шинжүүд, төлөвийн шилжилтийг хөдөлгөөнт дүрс ашиглан температурын өөрчлөлтөөр хэмжээсжүүлсэнээр жижиг хэсгийн хөдөлгөөний хурд, таталцлын хүч, хоорондын зай хэрхэн өөрчлөгдөж буйг сурагчдад бодитоор мэдрүүлж, хооронд нь харьцуулж, сонирхон судлах нөхцлийг бүрдүүлсэн.

1. Д.Сарангэрэл, Н.Оюунцэцэг, Ш.Сайнбилэг, Г.Баярмаа, Ж.Энэбиш, Н.Наранцогт, Ц.Отгонбаяр, З.Урансайхан. (2016). Хими IX. УБ.
2. Н.Нэргүй, Ч. б. (УБ). Багишлахуйн хөгжил: Багишлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент (Боловсролын бодлого боловсруулагч, судлаач, арга зүйч, ЕБС-ийн удирдах ажилтан нарт зориулав). 2013.
3. Н.Оюунцэцэг, Д.Сарангэрэл, Ш.Сайнбилэг, Г.Баярмаа, Ж.Энэбиш, Н.Наранцогт, Ц.Отгонбаяр. (2015). Багийн ном. УБ.

Сурагчдын бүтээлч сэтгэлгээг нэмэгдүүлэх нь

“Өргөн хэрэглэгддэг бодис, материалын орчинг судлах” ээлжит хичээлийн жишээн дээр

Завхан аймаг, Жавхлант цогцолбор сургууль, Б.Цэрэндэжид, Ө.Алтанцэцэг, С.Баярцэцэг, Н.Наранжаргал, физикийн багш Б.Батжаргал, Д.Пүрэвжанцан, Д.Пүрэвдорж, Б.Батболд, Ё.Дэлгэрмаа

Хураангуй:

Зорилго: Энэхүү судалгаат хичээлээр өргөн хэрэглэгддэг бодис, материалын орчинг туршилтын аргаар илрүүлэн, хүүхэд нэг бүрийн харьцуулан судалж, дүгнэлт гаргах, бие даан суралцах чадварыг дэмжсэн үр дүнг танилцуулж байна.

Судалгааны загвар/арга зүй/ хандлага: Суурь боловсролын 6-р ангийн “Бодис, Материалын өөрчлөлт” бүлгийн, “Хүчиллэг ба суурилаг шинж” нэгж хичээлийн, “Бодис, материалын орчинг судлах” ээлжит хичээлийн бэлтгэл судалгааны хүрээнд өргөн хэрэглэгддэг гарын саван, бок, хүнсний сода, кола ундаа зэргийн орчинг судлахаар харуулах хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн-Өргөн хэрэглэгддэг бодис, материалын орчинг харьцуулан судалж, ялгаатай ба төсөөтэй шинжийг илрүүлсэн. Цаашид аль бодис, материалыг амьдрал ахуйдаа хэрэглэвэл зохистой болохыг гэртээ туршин бусдад тайлагнах арга зүйг судалснаар суралцагчдын сонирхон судлах эрэлтийг нэмэгдүүлэн, суралцахуйн бүтээлч үйлийг хэрэгжүүлсэн нь суралцах, харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг тодорхой хэмжээгээр авчирдаг.

Практик ач холбогдол-Дээрх арга зүйн санааг ерөнхий боловсролын сургуулийн химийн болон байгалийн ухааны боловсролын багш нар хичээлдээ туршин хэрэгжүүлэх боломжтой. Мөн хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар суралцагчдын бие даан хөгжих чадварыг үнэлсэн.

Шинэлэг тал/ашиг тус-Химийн болон байгалийн ухааны хичээлийг судалснаар түүнийгээ амьдрал ахуйдаа зүй зохистой хэрэглэх боломж олгох, мэдлэгээ бүтээлчээр ашиглах аргад суралцана.

Түлхүүр үг- Бодис материал, өргөн хэрэглэгддэг бодис, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл, загварчлах арга, харьцуулан судлах, дүгнэлт гаргах чадвар

Товч агуулга:

Шинжлэх ухааны мэдлэг ойлголтыг эзэмшин, амьдрал үйлдээ хэрэглэх чадвартай иргэн болох, багаасаа өөрийн хэрэглэж буй бодис материалаа зөв сонгон хэрэглэх, бусдад зөв үлгэр дуурайлал үзүүлдэг ирээдүйд өөртөө итгэлтэй, хүсэл тэмүүлэлтэй, насан туршдаа суралцаж чаддаг, өөрийн удирдлагатай иргэн болж төлөвшихөд чухал үүрэгтэй билээ. Ийм иргэн болон төлөвшүүлэхийн тулд ээлжит хичээл бүрийг суурь боловсролын цөм хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байхын тулд энэхүү ээлжит хичээлийг хэрэгжүүлсэн билээ. Эхний судалгаат хичээлээр өргөн хэрэглэгддэг гарын саван, бок, хүнсний сода, кола ундаа, сүүний орчинг универсаль индикатор ашиглан тодорхойлж, хүчиллэг, суурилагаар нь ангилж ерөнхий шинж чанарыг гаргасан. Энэ нь хэдий амьдрал ахуй д хэрэглэгддэг бодисын шинжийг судалж буй хэдий ч цаашид амьдрал ахуйдаа хэрэглэгдэх ач тус нь харагдахгүй байна. Тиймээс 1 орчинтой бодисын орчинг судлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл зөвхөн гарын савангийн орчинг судлаад яагаад ялгаатай байгааг илрүүлэх нь цаашид хүүхэд илүү нарийн судалгаа хийх арга аргачлалыг зааж өгөх түлхүүр нь болно санааг дэвшүүлж хичээлийн үйл ажиллагааг зөвхөн гарын савангийн орчинг судалсан. Химийн боловсролын аливаа хөтөлбөрийг суралцахуйн бүтээлч үйлийг

дэмжсэн ШУ-ы аргаар зохион байгуулж, хүүхдийн өөрийн хэрэглэдэг зүйлийн талаар нарийвчлан судалснаар суралцагчийн бие даан суралцах чадварыг хөгжүүлэн дэмжиж чадна гэсэн эерэг үр дүнг ямар нэг хэмжээгээр авчирдаг юм байна гэдгийг дүгнэсэн. Гарын савангийн орчин нь РН=8-10 байна энэ нь тухайн савангийн найрлагаас хамаарч өөр өөр байна, үүнийг шошгийг нь ашиглан мэдэж болно, РН=9-10 ихтэй саван нь хирийг сайн арилгадаг, РН багатай гарыг хуурайшуулдаггүй гэсэн ахуй амьдралтайгаа холбосон дүгнэлт гарч байсан нь энэ хичээл нь суурь боловсролын цөм хөтөлбөрийн зорилтот нийцэж байна. Мөн хүүхдийг цаашид судалгаа хийх үндэс, бие даан бүтээлчээр суралцах арга замыг нээж өгсөн.

Удиртгал

Дэлхийн даяаршлын үед улс орон бүр тогтвортой хөгжлийн боловсролын гол үзэл санааг хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна. Манай улсын хувьд боловсролын шинэчлэлийн бодлогын үр өгөөжтэй зорилтын нэг болсон хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн арга зүйгээр цөм хөтөлбөрийг шат шатны боловсролын түвшиндээ хэрэгжүүлж байна. Шинэчлэлийг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын хүн бүрийн үүрэг оролцоо чухал төдийгүй тэр дундаа багш нарын бүтээлч сэтгэлгээ, хамтын хөдөлмөр, чанартай үйлчилгээ нэн чухал байр суурийг эзэлнэ. Чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд багш нарын сургалтын арга барил, мэргэжил, мэргэшлийн чадвар, хэрэгжүүлэх хичээлийн төлөвлөлт, хамтын ажиллагаа багагүй үүрэгтэй байдаг. Судалгаат хичээлийг менежмент сайтайгаар төлөвлөн хэрэгжүүлэх нь хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг ажлын байран дээр нь хөгжүүлэх оновчтой арга юм. Энэ удаад хэрэгжүүлсэн судалгаат хичээлийн хувьд сэдэлжүүлэлт, сэргээн санах үйлийн үед өөрийн хэрэглэдэг угаалгын бодис материалын ялгаатай шинжийг илрүүлэх нээлттэй асуултаар суралцагчдын дунд хэлэлцүүлэг хийж, мэдлэг бүтээх хэсэгт материал, бодисын орчинг универсаль индикатор ашиглан илрүүлэн, үр дүнг харьцуулан гаргасан. Ингэснээр суралцагчийн сонирхон судлах, харьцуулан оюун дүгнэлт гаргах суралцахуйн бүтээлч үйлийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг авчирсан. 6-р ангийн сургуулийн хөтөлбөрт тусгагдсан “Материалын өөрчлөлт” бүлгийн “Хүчиллэг ба суурилаг” нэгж сэдвийн хүрээнд “Бодис, материалын орчинг судлах” ээлжит хичээлийг тооцоолох болон загварчлах аргаар төлөвлөн хэрэгжүүлсэн судалгаат хичээлийн үр дүнг танилцууллаа.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Сэдвийг сонгосон чиг хандлагын үндэслэл:

Хүүхэд бүрийг сурах эрмэлзлэлтэй цаашид өөрийн сонирхсон зүйлийг судлах боломж олгох нь багш бидний үүрэг юм. Ингэхийн тулд:

6. Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар “Бодис, материалын орчин”-г судлах хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг хамтран хөгжүүлэх
7. Хөтөлбөрийг оновчтой арга зүйгээр төлөвлөн хэрэгжүүлснээр хүүхэд бүрийг туршин төлөвлөх аргад суралцуулах боломжтой төдийгүй хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлдэг эсэхийг судлах арга зүйн туршлагаа хуваалцах, бусдаас зөвлөгөө авч хөгжүүлэхээс үүдэн энэхүү илтгэлийг толилуулж байна.

Сэдвийг сонгосон практик үндэслэл:


Байгалийн ухааны багш нар “Бодис, материалын өөрчлөлт” гэсэн ээлжит хичээлийг хэрэгжүүлэхдээ зөвхөн орчинг нь судлаад орхидог. Яагаад орчин нь өөр өөр байдаг. Нэг орчинтой хэдий ч шинж чанар нь яагаад ялгаатай байдаг талаар цухас дурьдаж өнгөрдөг. Иймээс хичээлийг судлах явцдаа өөртөө болон бусдын зөв зохистой хэрэглэнд үнэлэлт дүгнэлт өгөх, мэдлэгээ бүтээлчээр хэрэглэж буйг судалж хүүхдэд гарч буй ахиц өөрчлөлтийг тооцох зорилгоор тухайн хичээлийг туршин хэрэгжүүлсэн.

“Хичээлийн санаа”: “Өргөн хэрэглэгддэг бодис материалын орчинг судлах” гэсэн ээлжит хичээлийн эхлэл буюу сэдэлжүүлэх хэсэгт бидний өдөр тутмын хэрэглэдэг саван ямар орчинтой байх вэ? яагаад? асуултаар баг доторх хэлэлцүүлгийг өрнүүлж, нэгдсэн хэлэлцүүлгээр багуудын санал, таамаглалыг сонссон. Хичээлийн шинжлэн судлах буюу тайлбарлах хэсэгт гарын савангийн

орчинг судалж төстэй шинж ба ялгааг гаргуулсан. Нэгэн ижил савангийн орчин ялгаатай байдгийн шалтгаан юу вэ? гэсэн хэлэлцүүлгээс найрлага ялгаатай байгаа гэсэн санаа гаргасан. Тэр үед найрлагаараа ялгаатай байгаа шалтгааныг хэлэлцүүлэн бодис, материалыг бүрдүүлэгч химийн бодис нь шошгон дээрээ байдаг гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Энэ нь суралцагчийн ахуйн болон хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авахдаа шошго найрлагыг нь харах түүнийг судлах эх үндэс болж идэвхтэй, бүтээлч суралцахуйн үйлийн дэжлэгтэйгээр хүүхэд нэг бүрийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх, сонирхолтой арга байснаараа онцлогтой.

Хичээлийн бэлтгэл судалгаа: ЖЦС сургуулийн сургалтын менежер Б.Буяннэмэх, Химийн боловсролын багш Ө.Алтанцэцэг, байгалийн ухааны секцийн багш нартай хичээлийн бэлтгэл судалгааг хамтран хийж, хөтөлбөрийг 3 удаа туршин хэрэгжүүлж, ажиглалт, хэлэлцүүлгээр илрүүлсэн саналдаа үндэслэн хөтөлбөрийг сайжруулж ажилласан. Хэрэглэгдэхүүний судалгааны хүрээнд сурагчдын өөрсдийнх нь хэрэглэдэг саванг сонгосон.

Судалгаат хичээл: 2016 оны 2-р сарын 01-07-нд “Өргөн хэрэглэгддэг бодис, материалын орчинг судлах” судалгаат хичээлийн бэлтгэл судалгааг хийж, ЖЦС-ийн байгалийн ухааны секц суралцагчдын дунд туршин хэрэгжүүлж, сургалтын менежер, мэргэжилтнээс зөвлөгөө авч хамтран сайжруулсан. Энэ үед олон янзын бодис материалын орчинг судлах төлөвлөлтөөр сайжруулсан байсан. 2016 оны 2-р сарын 08-нд дээрх бүрэлдэхүүнтэйгээр 9 ажиглагчтайгаар, анхны хэлэлцүүлгээс сайжруулсан хөтөлбөрийг ЖЦС сургуулийн 6б ангийн 20 суралцагчдад хэрэгжүүлж, хэлэлцүүлгээс зөвхөн өөрсдийн хэрэглэдэг савангийн орчинг судлах нь цаашид тухайн суралцагчийн бүтээлчээр хандах хандлагыг нэмэгдүүлж байна гэсэн саналыг авч хөтөлбөрийг 2 дахь удаагаа сайжруулсан. Сайжруулсан хөтөлбөрийг 2017-2018 оны хичээлийн жилд ЖЦС сургуулийн 6в ангийн 24 суралцагчдын дунд хэрэгжүүлж, хэлэлцүүлгээр хөтөлбөрийг сайжруулсан бөгөөд хичээлийн судалгаандаа “Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх” загварын менежмент[1]-ийг хэрэгжүүлэхийг зорьсон.



Загвар 1а. Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх
Эндээс суралцагчдын харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлэхийн тулд ээлжит хичээлийн үе шат бүрд тодорхой ахисан түвшний үйлийг төлөвлөн хэрэгжүүлж, гол концепцийг зөв сонгон хэрэгжүүлэх нь оновчтой шийдэл болж чадсан.

Судалгааны хамрах хүрээ, хугацаа, давтамж:

Судалгаанд хамрагдсан сургууль, анги, бүлэг (сурагчийн тоо)	Хичээлийн жил	Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн багш
ЖЦС- 6а /25/	2016-2017	Б.Цэрэндэжид
ЖЦС -6б /20/	2016-2017	Б.Цэрэндэжид
ЖЦС-6в /28/	2017-2018	Ө.Алтанцэцэг
ЖЦС-6а /24/	2017-2018	Б.Цэрэндэжид

Судалгааны үр дүн:

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөнд хийсэн зарим сайжруулалтыг дараах алхмаар хийсэн.

А. Өргөн хэрэглэгддэг бодис материалын орчинг харьцуулан судалсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Б. Зөвхөн гарын савангийн орчинг судлах сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

В. Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илрүүлсэн суралцагчдын гаргасан алдаа, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн

Химийн бодис материалын өөрчлөлийг тодорхойлдог нэг чухал хэмжигдэхүүн бол орчин. Бодис материалын орчинг универсаль индикаторо болон бусад илрүүлэгч ашиглан хялбар тодорхойлж болдог.

А. Өргөн хэрэглэгддэг бодис материалын орчинг харьцуулан судалсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Хичээлийн үе шат	Тухайн хэсгийн анхны боловсруулалт	Тухайн хэсгийн шийдэл, сайжруулалт
Хичээлийн эхлэл хэсэг:		
Таамаглал дэвшүүлэх-сэргээн санах, сэдэлжүүлэх	- гарын саван, бок, хүнсний сода, кола ундаа, сүү зэргийг хүчиллэг, суурилагаар нь ангилах	-Сурагчид амьдрал ахуйгаас олж авсан мэдлэгтэй тулгуурлан таамаглал дэвшүүлсэн.
Хичээлийн өрнөл хэсэг:		
Туршилтыг төлөвлөх, хэрэгжүүлэх-мэдлэг бүтээх	-өргөн хэрэглэгддэг бодис материалын орчинг универсаль индикатор ашиглан тодорхойлох ажлын төлөвлөгөөг багаараа хэлэлцэн боловсруулж туршин үр дүнгийн хүснэгтэд нэгтгэсэн. . үүгээр бодис материал нь хүчиллэг эсвэл суурилаг гэж гарсан.	-Бодис материал нь хүчиллэг, суурилаг шинж чанартай байна гэсэн гол санааг гаргасан.
Хичээлийн төгсгөл хэсэг:		
Туршилтын үр дүнг нэгтгэх, боловсруулах, тайлбарлах	-сурах бичиг болон туршилтын үр дүнгээ харьцуулан дүгнэлт гаргасан. -Ярих, илтгэх чадвар сайтай суралцагч туршилтын үр дүнг боловсруулан, танилцуулж тайлбарладаг байсан.	-Хэдий хүчиллэг чанартай бодис материал нь индикаторын хөх цаасыг улаан болгодог исгэлэн амттай, суурилаг шинж чанартай бодис материал нь индикаторын улаан цаасын хөх болгодог гулгамттай шинж чанартай гэсэн дүгнэлт хийж байгаа хэдий ч яагаад ялгаатай байгааг цааш нь судлах боломжийг олгоогүй. Өөр бодисын шинжийг судлах боломж хомс олгосон. -Багийн бүх гишүүдийг дугаарлан асуултын хариултыг авахдаа болон туршилтын үр дүнг танилцуулахдаа аль нэг дугаар бүхий суралцагчаар тайлбарлуулдаг болсноор суралцагчдын тэгш оролцоог хангасан төдийгүй ярих, илтгэх чадвар буюу харьцуулан судалж, дүгнэлт гаргах

		чадварын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг болсон.
--	--	---

Ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнгээс:

- Эхлэл хэсгийн таамаглал дэвшүүлэх үйл нь өргөн хэрэглэгддэг бодис, материалын орчноор нь ялгах нь сурагчдад бэрхшээлтэй байна. Учир шалтгаангүй таамаглал болсон. Тиймээс зөвхөн өөрсдийн өдөр тутамдаа хэрэглэдэг саван ямар орчинтой вэ? Яагаад? гэсэн асуултаар эхлэх нь зүйтэй гэсэн сайжруулах санал гарсан.
- Өөрсдийн хэрэглэдэг савангийн орчинг судалснаар цаашид хүүхэд загас барих арга олсон мэт бусад бодис, материалын орчинг судалж бүтээлчээр хандах хандлага үүснэ гэсэн оюун дүгнэлтийг хэлэлцүүлгээс гаргах гэсэн сайжруулалтыг дараагийн төлөвлөлтөндөө тусгасан.

Сайжруулсан хөтөлбөрийг ЖЦС сургуулийн химийн багш Б.Цэрэндэжид 7а бүлгийн 24 суралцагчдад хэрэгжүүлсэн. Эндээс хөтөлбөрийг хэлэлцүүлэн сайжруулсан тул 2017-2018 онд Улиастай сумын химийн боловсролын 7 багш сургалтандаа ашиглан, хэрэгжүүлж, үр дүнг үндэслэн хөгжүүлэх боломжтой.

Б. Зөвхөн гарын савангийн орчинг судлах сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүн

Багшийн асуулт, үндсэн үйл ажиллагаа	Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн явц, үр дүн	Тухайн хэсгийн дидактик шийдэл, сайжруулалт
<i>Хичээлийн эхлэл хэсэг:</i>		
Бидний өдөр тутмын амьдрал ахуйдаа хэрэглэдэг саван орчин ямар байх вэ? Яагаад гэсэн таамаглалын асуултаар эхэлнэ.	-хирийг арилгадаг, гулгамтгай учраас суурилаг шинж чанартай, эсвэл хүчиллэг шинжтэй байна, амьдрал ахуйд хэрэглэгддэг бодис материал учир саармаг байна гэсэн таамаглалууд дэвшигдсэн.	-амьдрал ахуйд хэрэглэгддэг (өөрийн хэрэглэдэг) савангийнхаа шинж чанарыг судлах нь сонирхолтой сэдэлжүүлэлт болсон. Мөн хэзээ ч хаана ч ямар ч бодисын шинжийг судлах эрэл хайлт хийх боломж нээгдсэн.
<i>Хичээлийн өрнөл хэсэг:</i>		
-бидний хэрэглэж буй савангийн орчинг хэрхэн тодорхойлох вэ? Гэсэн асуудлыг дэвшүүлсэн.	-Ямар орчинтой байгаа шалтгааныг батлах туршилтыг төлөвлөн гүйцэтгэсэн. -өөр өөрийн хэрэглэдэг савангийн уусмал бэлтгэсэн. -бэлтгэсэн савангийнхаа уусмалд универсаль индикатор дүрж РН-ийг	-хатуу төлөвт оршиж буй бодисуудын орчинг тодорхойлохдоо уусмал бэлтгэнэ гэсэн санааг гаргуулах -савангийн орчин нь ижил байгаа шалтгааныг хэлэлцүүлсэн үр дүнгээс гулгамтгай шинж чанартай бодис материал суурилаг гэсэн гол концепцийг ойлгуулах нь чухал.

	тэмдэглэж харгалзах орчин тэмдэглэсэн. Гарын саван бүрийн орчин суурилаг байна гэж дүгнэсэн.	-саван бүрийн орчин ижил байх уу? гэсэн асуудлыг дэвшүүлж, туршилтыг төлөвлөн хэрэгжүүлэх -Дээрх туршилтын дараа өөр өөрийн савангийн нэрний ард РН-ийг тэмдэглэх
<i>Хичээлийн төгсгөл хэсэг:</i>		
Туршилтын үр дүнг нэгтгэн дүгнэх, тайлбарлах	Саван бүрийн орчин ижил боловч РН нь ялгаатай байгаагийн учрыг тайлбарлах	-Гарын савангийн орчин нь РН=8-10 байна энэ нь тухайн савангийн найрлагаас хамаарч өөр өөр байна, үүнийг шошгийг нь ашиглан мэдэж болно, РН=9-10 ихтэй саван нь хирийг сайн арилгадаг, РН багатай гарыг хуурайшуулдаггүй гэсэн ахуй амьдралтайгаа холбосон дүгнэлт гарч байсан

В. Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний дараах ажиглалт хэлэлцүүлгээр илрүүлсэн суралцагчдын гаргасан алдаа, сурагчдад гарч байгаа эерэг хандлага, өөрчлөлтийн үр дүн

Асуулт	Суралцагчдын гаргасан алдаа	Хөтөлбөрт алдаанаас сэргийлэх төлөвлөлтийг тусгасан байдал	Суралцагчдад илэрч байгаа эерэг хандлага, өөрчлөлт
Хөтөлбөр А	Олон янзын бодис материалын орчинг таамаглахдаа учир шалтгааныг ойлгохгүй байсан.	Өргөн хэрэглэгддэг бодис	Таамаглал тодорхой болоход ажлын төлөвлөгөө боловсруулах дүгнэлт хийх чадвар нь сайжирсан.
	Хэрэглээний бодисуудын зөвхөн орчинг л тодорхойлсноор бодис материал зөвхөн орчингоороо л өөр байдаг гэсэн ойлголттой болсон.	Бодис бүр зөвхөн орчингоороо өөр хүчиллэг, суурилаг, саармаг байна.	Өргөн хэрэглээний бодисыг хүчиллэг, суурилагаар нь ангилах чадварт суралцсан.
Хөтөлбөр Б		Зөвхөн гарын савангийн орчинг нарийвчлан судалснаар хоорондын ялгааны учрыг химийн мэдлэгээ болон практикт үндэслэн тайлбарлах	Орчин нь ижил боловч РН хоорондоо ялгаатай байгааг хэрэглээтэйгээ холбон тайлбарлах боломж нээгдсэн.

2016-2017 онд бодис Цаашид суралцагчид ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж буйг ХГҮА цагаараа тулгамдаж буй асуудлаа гарган ярилцахад гэр бүлийн болон өөрийнхөө гарын саванг зөв сонгоход нь тусалъя гэсэн саналын дагуу дараах үйл ажиллагааг явуулсан.

1. Өөрийн болон бусдын савангийн орчинг судлах
2. Яагаад энэ саванг хэрэглэж байгаад нь үнэлэлт өгөх
3. Гарын савангаа сонгоход нь дэмжлэг үзүүлэх

Хүүхдүүдийн эзэмшсэн мэдлэг чадварын ахицыг үнэлэх шалгуур, үнэлэх аргачлалаа боловсруулсан.

Дүгнэх аргачлал	№1: Өөрийн амьдралдаа нөлөөлсөн нөлөөлөл:	№2: Гэрийнхэндээ нөлөөлсөн нөлөөлөл:	№3: Бусдад нөлөөлсөн нөлөөлөл:
Хангалттай бол 3 оноо	Өөрийн хэрэглэж буй савангийн орчинг судалж дүгнэлт хийж буй байдал	Савангийн орчингийн ялгааг зөв тайлбарлан ойлгуулж буй байдал	
Дунд зэрэг бол 2 оноо	Өөрийн арьсанд тохируулж савангаа хэрэглэж буй байдал	Ахуйн хэрэглээний бодисын найрлагыг шошго ашиглан мэдэж болдгийг ойлгуулж буй байдал	
Дэмжлэг хэрэгтэй бол 1 оноо	Савангийн шошго ашиглан орц найрлагыг судалж, хэрэглээндээ дүгнэлт хийж буй байдал	Ахуйн бодисыг зүй зохистой хэрэглэхэд нь тусалж буй байдал	
Үнэлэх боломжгүй бол 0 оноо			

Хүснэгт1

Үйл ажиллагааны тайлан хамгаалах үе шат

Хүний хийсэн үйл ажиллагаа нь үр дүн сайтай цаашид юу хийхээ төлөвлөдөг. “Гарын савангаа зөв сонгоё” гэсэн үйл ажиллагааны тайланг явцын болон эцсийн хэлэлжүүлэг байдлаар 2 үе шаттайгаар хамгаалахад хүүхдүүд багшаас зөвлөгөө авах, бусадтай харилцан санал бодлоо солилцож байсан.

Явцын үйл ажиллагааны хэлэлцүүлэг хийхэд	Эцсийн үйл ажиллагааны хэлэлцүүлэг хийхэд	Нэмэлт тайлбар:
-Зөвхөн өөрийн хэрэглэдэг савангийн орчинг судалсан. -Гэрийнхэнийхээ арьсны орчинг судалж, түүнд тохирох гарын савангийн эрэлт хайлт хийж эхэлсэн. -Савангийн орчин, шошгон дээрх найрлагын онцлогийг судалж эхэлсэн. -гарын савангийн орчин суурилаг байна.	-РН=9-10 саван нь тослог арьсанд тохиромжтой байна. Найрлаганд нь бактер устгагч их агуулагддаг байна. -РН=7-8 саван нь хуурай арьсанд тохиромжтой байна. -Шингэн гарын саван нь элдэв харшил өгөхгүй хэрэглэхэд хялбар байна. -Тослог арьсанд суурилаг ихтэй саван хэрэглэх нь зүйтэй -Гэр бүлийн гишүүн бүрт тохирсон саванг хэрэглэдэг болсон.	Би хуурай арьстай надад гарын шингэн саван болох Safeguard тохирч байхад манай аав тослог арьстай учир “Anita” –ийн ногоон өнгөтэй саван тохирч байна гэсэн тайлбаруудыг өгч байна. Ингэснээр гэр бүлийн гишүүн бүр өөрийн тохирох савангаа хэрэглэх болсон. Гарын савангийн РН=7-10 байна. Савангийн хадгалах горимыг өөрчилвөл орчин нь өөрчлөгдөж болно. Жишээ нь чийгтэй

	<p>-Хүүхдийн савангийн орчин саармаг байна. Энэ нь арьсанд ямар ч харшил өгдөггүй байна.</p> <p>-Нэг төрлийн саван өөр өөр өнгөтэй бол ногоон өнгөтэй нь хуурай арьсанд, цэнхэр өнгөтэй нь тослог арьсанд тохирч байна.</p>	орчинд удаан ил байлгавал хүчиллэг шинжтэй болдог.
--	---	--

Хүснэгт2

Энэ үе шатанд хүүхэд бүр гар угаадаг савангийнхаа орчин, шошгийг нь ашиглан орц найрлагыг судлах үр дүнд яаж өөрчлөгдөж байгааг хэлэлцүүлгийн аргаар дүгнэн нэгтгэвэл:




График1

Эцсийн хэлэлцүүлгийн дараа суралцагчид өөрийн амьдралдаа болон бусдад мэдлэгээ зүй зохистой хэрэглэх чадвар нэмэгдсэн нь харагдсан.

-Суралцагчдад гарсан өөрчлөлтийг үнэлж дүгнэхдээ боловсруулсан шалгуурын дагуу хэр зэрэг үр дүнтэй байгааг хүүхэд бүрийн чадвар, ахиц амжилтыг явцын ба эцсийн хэлэлцүүлгийн үеэр 0-3 оноогоор дүгнэн тэмдэглэл хөтлөв.

Хавсралт-1

Хүснэгтэнд буулгасан мэдээллийг боловсруулж, үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийх

Багш боловсруулсан шалгуур, дүгнэх аргачлалын дагуу явцын ба эцсийн хэлэлцүүлэг хийх үед хүүхэд бүрийн төлөвшил хандлагын ахиц өөрчлөлтийг тооцсон тэмдэглэлдээ тулгуурлан чадвар тус бүр дээр математик боловсруулалт хийснээр хүүхэд мэдлэгээ бүтээлчээр ашиглаж буйг үнэлж дүгнэхэд оновчтой болж байна.





График2

График3



Багш бэлтгэл судалгаа хийж байхдаа хүүхдүүд хичээл судлагдахуунаар эзэмшсэн ямар чадвараа яаж хөгжүүлж, тэдэнд ямар хандлага төлөвшихийг төсөөлж байсан. Үүнийг явцын ба эцсийн хэлэлцүүлэг, чанарын судалгааны аргаар боловсруулалт хийж үзлээ.

Сурагчдад төлөвших хандлага	Нэмэлт тайлбар
-туршилт төлөвлөж төлөвлөгөөний дагуу туршилт гүйцэтгэх чадвар нэмэгдсэн -Өөрийн арьсны онцлогийг мэдэх -Өөрийн арьсанд тохирсон гарын савангаа сонгож сурсан. - Шошго найрлага ашиглаж сонголт хийх - Гэр бүлийн гишүүдэд сонголт хийхэд нь шинжлэх ухааны үүднээс нь тайлбарлан туслах -Гэр бүлийн санхүүгийн тооцоололт хэмнэлт гарах	-Янц бүрийн савангийн орчинг судлах -Хуурай,тослог,эмзэг, холимог зэрэг арьсны онцлогийг судлах -Ахуй хэрэглээний англи хэлний үгийн баялаг нэмэгдэх -Бусдын арьсанд тохирол савангийн хэрэглээг нь тайлбарлан өгч сурсан. -Гэр бүлийн гишүүн бүрт тохирсон саванг хэрэглэж хэвшсэн.

Дүгнэлт:

Дээрх судалгаат хичээлийг хэрэгжүүлсэн үр дүнгээс багш нар цаашид бүтээлчээр хандах хандлагыг орхигдуулахгүйгээр танин барих нь хамгийн чухал гэдгийг ойлгосон. Өөрөөр хэлбэл хөтөлбөр “А”-д өргөн хэрэглэгддэг бодис материалын орчинг судалж хүчиллэг ба суурилагаар нь ангилахыг чухалчилсан. Харин хөтөлбөр “Б”-д суралцагчдын өөрсдийн хэрэглэдэг савангийн орчинг судалж ялгааг нь харьцуулснаар шинжлэн судлах чадвар, танин мэдэхүйн чадамж нэмэгдэхээр хэрэгжүүлсэн.¹³ Шинжлэх ухааны мэдлэг ойлголтыг эзэмшин, амьдрал үйлдээ хэрэглэх чадвартай иргэн болох. Энэхүү суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд байгалийн ухааны хичээлүүдийн хувьд сурагч нь байгалийн юмс үзэгдлийн танин мэдэх арга барилаа хөгжүүлж, тасралтгүй суралцдаг хүрээлэн буй орчинд ээлтэй, түүнийг хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулдаг иргэн болон төлөвшинө. Ингэхийн тулд багаасаа өөрийн хэрэглэж буй бодис материалаа зөв сонгон хэрэглэх, бусдад зөв үлгэр дуурайлал үзүүлдэг ирээдүйд өөртөө итгэлтэй, хүсэл тэмүүлэлтэй, насан туршдаа суралцаж чаддаг, өөрийн удирдлагатай иргэн болж төлөвшихөд чухал үүрэгтэй билээ. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд ээлжит хичээл бүрийг байгалийн ухааны цөм хөтөлбөр, суурь боловсролын цөм хөтөлбөрийн зорилтыг биелүүлэхэд хэр үүрэг гүйцэтгэж буйг харж байх нь чухал гэдгийг тухайн хичээл үйл ажиллагаагаар олж авлаа.

Өөрийн хэрэглэдэг савангийн орчны ялгааг судалснаар өөрийн хэрэглээндээ дүгнэлт өгөх, яагаад ялгаатай байгаа шалтгааныг судлах боломжийг нээж өгсөн “бүтээлчээр сэтгэх” нэгэн загварыг бий болгож, туршин хэрэгжүүлж байна.

Ном зүй

20. С.Гэндэнжамц, Д.Батболд, Ц.Амартайван, Ж.Дөлгөөн, Э.Энхтогтох, С.Цогбадрах, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, Г.Баярмаа, Д.Сарангэрэл, Н.Оюунцэцэг, Н.Наранцогт “Байгалийн ухаан-VI”.
21. Н.Нэргүй, Ч.Нямгэрэл ба бусад, Багилахуйн хөгжил: Багилахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент (Боловсролын бодлого боловсруулагч, судлаач, арга зүйч, ЕБС-ийн удирдах ажилтан нарт зориулав), УБ., 2013.
22. Н.Оюунцэцэг, Ч.Нямгэрэл ба бусад Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил-төслийн зөвлөмж-1,2,3 УБ., 2010.
23. С.Батсүх Хүүхдийн хөгжил- УБ., 2010.
24. Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр

¹³ Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр
210

Газарзүйн зургийг ашиглаж сурахад суралцагчдад тулгарсан зарим бэрхшээл

¹М.Баасанхүү, ²Э.Энхцоож, ³Б.Жанчив, ⁴Ж.Цэцэгмаа, ⁵Б.Мөнхзаяа, ⁶Л.Гэрэлмаа

¹Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 1-р сургууль, багш

²Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 1-р сургууль, багш

³Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 4-р сургууль, багш

⁴Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 3-р сургууль, багш

⁵Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 2-р сургууль, багш

⁶Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 6-р сургууль, багш

Зорилго

Энэхүү илтгэлээрээ 7-р ангийн Гео-орон зайн дүрслэл агуулгын хүрээнд төлөвлөсөн газарзүйн зургийг ойлгох, хэрэглэх чадварт суралцах зорилготой хичээлд орон нутгийн сансрын зураг хэрэглэх боломжийг туршсан үр дүн, суралцагчдад илэрсэн бэрхшээл, эргэлзээг тодорхойлсноо хуваалцаж байна.

Удиртгал

Хүний амьдралдаа суралцах эзэмших шаардлагатай чадваруудын нэг нь орон зайн баримжаатай байх явдал юм. Орон зайн баримжаа хөгжсөнөөр амьдарч буй орчноо, мөн алс холын газрыг ч төсөөлөн тархиндаа зураглаж өөрийн дэлхийг бүтээж байдаг билээ.

Мэдээлэл харилцааны технологи хөгжсөн өнөө үед дижитал газарзүйн зургийг хэрэглэх боломж улам бүр нэмэгдэж, бидний ахуй амьдралын олон салбарт нэвтэрч салшгүй хэсэг болон хэрэглэгдэж байна. Бид сургуульд бага ангиас нь хүүхдүүдэд газарзүйн зургийн тухай зааж байна. Дижитал газарзүйн зургийг ахлах ангийн хөтөлбөрт тусгасан байдаг ч суралцагчдын ойлголт, хэрэглээ түрүүлэх хандлагатай байна. Түүнийг гар утасны аппликэйшн, компьютерийн програм хангамжаар суралцаж, ашиглахын зэрэгцээ үндэс суурь болсон хэвлэмэл газарзүйн зургийг ойлгож хэрэглэн, өөрөө хэмжиж тооцоолж чаддаг болох зайлшгүй шаардлагатай билээ.

Тиймээс суралцагчид өөрийн амьдарч буй орчин, аялаж очсон газрынхаа мэдээлэл, байршлыг баримжаалан зураглах тэмдэглэхээс орон зайн баримжаа төлөвшиж, газарзүйн зургийг ойлгох хэрэглэх чадвар эхэлнэ.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

Сэдэв сонгосон үндэслэл

Газарзүйн зургаас уудам орон зайг нэг дор “харж”, ... бодит юмсаас гадна хийсвэр юмс, үзэгдлийн талаар мэдээлэл авч, тэдгээрийн тоон болон чанарын ялгааг судалж болдог¹⁴. Газарзүйн сургалтын нэг зорилго нь сурагчдад картографийн буюу газарзүйн зургийн бичиг үсгийн чадвар (Cartography Literacy) олгох явдал юм.¹⁵

Газарзүйн хичээлийн суралцахуйн удирдамжийн 7-р ангийн “Гео-орон зайн дүрслэл” агуулгын хүрээнд “*таних тэмдэг ашиглан газарзүйн зураг унших, масштаб ашиглан хэмжилт хийх, том, жижиг масштабын зураг харьцуулах, жиших, байрлал (уртраг, өргөрөг, солбицол) тодорхойлох, газар дээр болон газар дээр зүг чиг тодорхойлох, зай хэмжих чадвараа хөгжүүлж энгийн зураглал хийж сурна*”¹⁶ гэсэн чадваруудыг эзэмшүүлэх зорилт тавигдсан байдаг. Энэ зорилтын хүрээнд газарзүйн зургийн

¹⁴ [Батчулуун, 2017]

¹⁵ [Батчулуун, 2017]

¹⁶ Суурь боловсролын цөм хөтөлбөр, 2015

элементүүд болох таних тэмдэг, масштаб, зүг чиг, солбицол зэргийг ойлгох, ашиглаж сурах үйл ажиллагааг ээлжит хичээлүүдэд тусган буулгалаа.

Хичээлийн санаа

Сургалтын том масштабын газарзүйн зураг хомс байдаг билээ. Тиймээс газарзүйн зургийн үндсэн элементүүдийг ойлгох, хэрэглэхэд орон нутгийн сансрын зургийг ашиглахаар шийдсэн. Сурагчдын мэдэх орон нутгийн танил объектуудыг сансрын зургийг ажиглан таних, тогтоох, таних тэмдгээр илэрхийлэх, харилцан байршлыг тодорхойлох, зүг чигийг тодорхойлох дасгал ажлуудыг 4 ээлжит хичээлээр гүйцэтгэхээр төлөвлөсөн болно.

Хичээлийн бэлтгэл судалгаа

Хичээлийн бэлтгэл судалгааг Сүхбаатар сумын төвийн 6 багш хамтран зөвлөлдөж бэлтгэж хийсэн. Үндсэн хэрэглэгдэхүүн болох газарзүйн зураг олноц багатай учраас эх сурвалжуудыг судалж, GoogleEarth программын сансрын зургийг ашиглаж болно гэж үзсэн. Ингээд сурагчдын дасгал ажилд хэрэглэх зургуудыг Photoshop программ дээр засварлан зарим нэмэлт тэмдэг хийж, тохируулан бэлтгэсэн болно. Хичээлүүдийн дасгал ажлын даалгавар асуултыг орон нутгийн онцлогт тохируулан зохиосон. Жишээлбэл орон нутагт орших сурагчдын сайн мэдэх байгууллагуудын лого, тэмдэглэгээг таних тэмдэг хичээлд хэрэглэсэн. Харин масштабын хэмжилт хийхэд ноосон, даавуун, торгон гэх мэт олон төрлийн утас, зүйлсийг туршсаны эцэст сунахгүй бас уян хатан байх, нугалж тэнийлгэж болох бүрээстэй зэс утас (интернэтийн саарал утасны доторх нарийн утас)-ыг ашигласан. Мөн зүг чиг олох хичээлд сурагчдын мэддэг үйлчилгээний газар, байгууллагуудын харьцангуй байршил, чиглэлийг тодорхойлох даалгавар боловсруулсан. Ингэхдээ зүг чигийн таних тэмдгийг орчуулан засаж сурагч бүрийн ажлын хуудаст болон самбарт байрлуулахад зориулан томоор бэлтгэв. Хичээл бүрт сурагч болон баг бүрт сансрын зураг болон дасгал ажлын хуудсуудыг бэлдсэн болно. Мөн сансрын зураг болон хэвлэмэл газрын зургийг ажлын хуудастай хослуулан газарзүйн байршил солбицол тодорхойлох хичээлд хэрэглэхээр бэлдэв.

Судалгаат хичээл

Судалгаат хичээлийг 2017 оны 10 сар, дараах байдлаар сайжруулан заасан болно. Дараах 4 сэдэв бүхий ээлжит хичээлийн хөтөлбөрүүдийг 1-4 удаа туршигдан заасан ба хөтөлбөр болон ажлын хуудасны өөрчлөлтийг дараагийн хичээлүүд дээрээ тусган сайжруулсан. Цаашид эдгээр сайжруулсан хөтөлбөрүүдээр 2018 оны 10 сард дахин заан туршиж, сайжруулахаар төлөвлөж байна.

Ээлжит хичээлийн сэдэв	Хөтөлбөр 1	Хөтөлбөр 2	Хөтөлбөр 3	Хөтөлбөр 4
Газарзүйн таних тэмдэг зургийн	М.Баасанхүү 1-р сургууль, 7в 2017.10.16			
Газарзүйн масштаб зургийн	Э.Энхцоож 1-р сургууль, 7б 2017.10.17	Б.Жанчив 4-р сургууль, 7а 2017.10.17	М.Баасанхүү 3-р сургууль, 7а 2017.10.17	
Газарзүйн зургийн зүг чиг	М.Баасанхүү 1-р сургууль, 7г 2017.10.18	Б.Мөнхзаяа 2-р сургууль, 7а 2017.10.18	Л.Гэрэлмаа 6-р сургууль, 7а 2017.10.19	М.Баасанхүү 1-р сургууль, 7в 2017.10.25
Газарзүйн солбицол, байршил олох	Ж.Цэцэгмаа 1-р сургууль, 7а 2017.10.19			

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл (мэдлэг бүтээлгэх)

“Газарзүйн зурагт таних тэмдэг” хичээл: Орон нутагт орших байгууллагуудын лого, зорилго үйлчилгээг илэрхийлсэн зурагт таних тэмдгийг ажиглан сансрын зураг дээрээ байгууллагуудын лого, зургийг

“таних тэмдэг” болгон ашиглаж, байрлал дээр нь тэмдэгжүүлэн наах даалгаврыг ихэнх баг сурагчид ойлгож амжилттай хэрэгжүүлж байсан. Дараагийн алхам болох уг сансрын зураг дээр өөрийн мэдэх объект газруудыг мэдэх таних тэмдгээ ашиглан мөн шинээр таних тэмдэг зохиож тэмдэглэх даалгавар өгөгдсөн.

Багууд зураг дээрээ объектуудаа бичих, эсвэл таних тэмдгээр давхарлан зурж илэрхийлж байсан ч таних тэмдгүүдийг жагсаасан “тусгай булан”-даа мөн нэмж зурах тэмдэглэхээ мартаж орхигдуулж байсан. Харин дараа нь багшийн “Зураг дээрх энэ дүрс, тэмдгийг хэрхэн ойлгож тайлж унших вэ? Юу гэж ойлгох вэ?” гэсэн чиглүүлэх асуултаар өөрсдийн зохиосон дүрс тэмдгийг таних тэмдгийн буланд нэмж зурах ёстой байсныг ойлгосон. Ингээд нэмж зурснаар сурагчид энэхүү баяжуулан сайжруулсан зураг нь ойлгомжтой хэрэглэж болохуйц газарзүйн зураг болсныг ойлгосон. Өөрөөр хэлбэл өөрсдөө таних тэмдэг шинээр нэмж зохиож, зургийг баяжуулан сайжруулах явцдаа таних тэмдгийг хэрхэн хэрэглэхийг ойлгож мэдсэн. Багууд хаана байдаг юуг нэмж зураг дээр тэмдэглэсэнээ бусаддаа тайлбарлан танилцуулсан.

Таамаглал дэвшүүлэх	Таамаглалаа шалгах, турших	Хэлэлцэх
<p>Өгөгдсөн зураг нь ямар зураг вэ? Мэддэг газар байгууллага объект байна уу? Ямар байгууллага ямар хаяг логотой байдаг вэ? Жишээлбэл эмнэлэг? Цагдаагийн газар?</p>	 <p>Өөрсдийн мэдэх байгууллага, газруудыг өгөгдсөн таних тэмдгийг ашиглан зургийг “таних тэмдэг”-ээр илэрхийлэн наав. Дараа нь шинээр таних тэмдэг зохион нэмж өөр зүйлсийг зурагт тэмдэглэв.</p>	<p>Баг бүр ямар таних тэмдгээр юуг илэрхийлж зурснаа тайлбарлав. Газарзүйн зургийг уншиж ойлгоход таних тэмдгийг ашигладгийг ярилцав.</p> <p>Шинээр таних тэмдэг зохиох (Газарзүйн зураг болгон бүтээх)</p> 




Хөтөлбөр 1-д дасгал ажилд хэрэглэсэн таних тэмдгийн хэмжээ том байснаас зөвхөн тухайн объектоо бус ойр орчмын зарим объект нь наасан таних тэмдэгт дарагдаж байсан тул жижигрүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Энэ хичээлээр сурагчдын орон зайн баримжаа төлөвшүүлэхэд *сургууль-сургуулийн ойр орчим-багийн нутаг дэвсгэр-сумын нутаг дэвсгэр* гэсэн ойроос хол руу зарчмаар хөгжүүлэхийг зорив.

“Газарзүйн зураг зүг чиг” хичээл:

Хичээлийн эхэнд фото зураг үзүүлэн “Сурагч хаашаа харж байна вэ?” гэсэн асуултаар сурагчдын төсөөллийг илрүүлэхийг оролдсон. Сурагчид “ийшээ”, “тийшээ” гэх мэт ахуйн үг хэллэг ашиглан гараараа чиглүүлж заахаас гадна хойд, өмнө, баруун, зүүн зүг зэрэг шинжлэх ухааны хэллэгээр хариулж байсан. Яагаад ингэж бодсоноо “нар зүүн зүгээс мандаж байгаа болохоор эсрэг зүг нь баруун зүг, хүүхэд хойшоо харж байна, бамбарууш теди нь урагшаа харж байна. Хүүхдийн баруун гар тал нь зүүн зүг рүү, зүүн гар нь баруун зүг рүү хандсан байна” гэх мэтээр тодорхойлов.

Дараагийн асуулт болох “тэгвэл сурагчид та нар яг одоо аль зүг рүү харж байна вэ?(самбар руу харж байх үедээ) гэсэн асуулт нь өөрсдөө бодитоор тодорхойлж чадаж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой байв. Тухайн сургуулийн байршил, орох хаалга аль зүг рүү харсан байдаг, мөн тухайн ангид сурагчид самбар руу харахад аль зүг рүү харж байгаа зэрэг нь сурагчид эргэлзэх эсэхэд нөлөөлдөг нь ажиглагдсан. Тухайлбал 1-р сургуулийн хаалга, үүдний хэсэг нь урд талдаа байдаг буюу барилга нь хойноос-урагш чиглэсэн байрлалтай тул ихэнх сурагчид зүг чигээ зөв тодорхойлж баримжаалж байв. Харин 2-р сургууль нь баруун урагш харсан хаалгатай тул зарим сурагчид эргэлзэж байлаа.





Таамаглал дэвшүүлэх	Таамаглалаа шалгах, турших	Хэлэлцэх
 <p>“Сурагч хаашаа харж байна вэ?” гэсэн асуулт нь зүг чигийн төсөөллийг илрүүлэх зорилготой юм.</p> <p>Дараа нь өгөгдсөн орон нутгийн сансрын зургаас мэдэх газар, объектыг олж тэдгээрийн харилцан орших чиглэлийг олно.</p>	 <p>Сурагчид тухайн байрлалаас бусад объектууд аль зүгт, азимутын ямар өнцгийн чиглэлд оршиж байгааг олохдоо зүг чигийн таних тэмдэг, азимут өнцгийн хуваарь бүхий ТӨМ-ийг ашиглана.</p>	 <p>Багууд объектуудын орших байрлал чиглэлийг хэрхэн тодорхойлсноо танилцуулна.</p> <p>Мөн 2 объектын хоорондох харилцан бие бие рүүгээ чиглэсэн чиглэл нь эсрэг чиглэл (зүүн өмнө-баруун хойд гэх мэт) болохыг тодорхойлсон.</p>

Чиглэлийг тодорхойлох объектууд нь Хөтөлбөр 1-д бусдаас ялгарч харагдахгүй байсан тул дараа нь заахдаа тодруулж давхарлаж зурах, эсвэл дээр нь тод өнгийн стикер нааснаар даалгавраа гүйцэтгэхэд дөхөм болсон.

Мөн Хөтөлбөр 2-ийг хэрэгжүүлэхэд гол, уул гэх мэт объектыг сонгосон нь сурагчдад эргэлзээ үүсгэж байсан. Учир нь гол бол шугаман (line), харин уул нь талбайн (polygon) шинжтэй. Гэтэл чиглэл тодорхойлох объект нь тодорхой нэг цэгээр (point) илэрхийлэгдэх зүйл байх ёстой учир сурагчдад эргэлзээ төрүүлж, өнцгийг тодорхойлоход бэрхшээл тулгарсан.

Түүнчлэн сансрын зураг болон ажлын хуудасны буланд зүг чигийн таних тэмдгийг оруулж өгсөн боловч сурагчид зүгээ тодорхойлох болон азимут өнцөг олоход яг тухайн объектоос харьцуулж харахад төвөгтэй байсан. Иймд “зөөврийн” зүг чигийн таних тэмдгүүдийг тусгайлан бэлдэж тухайн объект дээрээ давхцуулан тавьж байрлуулан өнцөг, чиглэлээ тодорхойлсноор даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн.

“Газарзүйн зургийн масштаб” хичээл:

Таамаглал дэвшүүлэх	Таамаглалаа шалгах, турших	Хэлэлцэх																				
<p>Кэйс: Ээж нь чамд захиа бичиж үлдээжээ. Захианд орой ээж нь ажилтай учраас давтлагаа тараад дүүгээ цэцэрлэгээс нь аваарай гэсэн байв.</p> <p>Сурагчид цэцэрлэг хүрэх боломжит замуудыг хэлэлцэж аюулгүй, дөт нэг замыг сонгож зурсан.</p> <p>“Сургуулиас цэцэрлэг хүртэлх зай ямар хэмжээтэй байгаа бол?”, “ Үүнийг хэрхэн яаж мэдэх вэ?” гэсэн асуулт нь масштабын тухай өмнөх төсөөлөл, ойлголтыг тандах зорилготой байв.</p> 	<p>Масштабын таних тэмдгийг олох, ойлгох, зурагт хэмжилт хийх, тооцоолох</p>  <p>Дасгал 1-д сурагчид масштаб нь мэдэгдэж буй эхний зураг дээр хэмжилт хийж бодит зайг олсон бол Дасгал 2-т масштаб тодорхойгүй 2 дахь зурагт дээрх тооцоолж олсон бодит зай ямар хэмжээтэй зурагдсаныг хэмжиж тооцоолох замаар 2 дахь зургийн масштаб ямар байгааг тооцоолж гаргасан.</p> <table border="1" data-bbox="657 1102 1040 1346"> <thead> <tr> <th></th> <th>Дасгал 1</th> <th>Дасгал 2</th> <th>Дүгнэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хэмжсэн зай (см)</td> <td>20</td> <td>19</td> <td></td> </tr> <tr> <td>Масштаб</td> <td>1 см = 42.1</td> <td>1 см = 64.7</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>85 400</td> <td>82 530,54</td> <td></td> </tr> <tr> <td>Газар дээрх бодит зай (м)</td> <td>842 м</td> <td>842 м</td> <td></td> </tr> </tbody> </table>		Дасгал 1	Дасгал 2	Дүгнэлт	Хэмжсэн зай (см)	20	19		Масштаб	1 см = 42.1	1 см = 64.7			85 400	82 530,54		Газар дээрх бодит зай (м)	842 м	842 м		<p>Багууд хэмжилт, тооцоолсон үр дүнгээ самбарт бичиж, түүнийгээ тайлбарлав.</p>  <p>Өмнөх таамаглаж байсантай хэмжиж тооцоолсон нь ойролцоо байгаа эсэхийг хэлэлцсэн. Мөн 2 өөр зурагт ижил зай хэрхэн зурагдсаныг ярилцаж масштабын тухай ойлголтоо бататгав.</p>  <p>“см”-ээр илэрхийлэгдэх зураг дээрх зай юу?</p> <p>“км”-ээр илэрхийлэгдэх бодит газар дээрх зай юу?</p>
	Дасгал 1	Дасгал 2	Дүгнэлт																			
Хэмжсэн зай (см)	20	19																				
Масштаб	1 см = 42.1	1 см = 64.7																				
	85 400	82 530,54																				
Газар дээрх бодит зай (м)	842 м	842 м																				

“Сургуулиас цэцэрлэг хүртэлх хоорондох зай ямар хэмжээтэй байгаа бол?”, “ Үүнийг хэрхэн яаж мэдэх вэ?” гэсэн асуулт нь сурагчдын масштабыг ашиглаж олно гэдгийг таамаглаж байгаа эсэхийг илрүүлэх зорилготой байв. Бэлтгэсэн зургийн тэмдэглэгээ, таних тэмдгүүдээс масштабын таних тэмдгийг олж, түүнийг шугаман хэлбэрээр илэрхийлэгдсэн байгааг ойлгох нь эхний алхам байв. Дараа нь хэмжилт хийж, зайг тооцоолох дасгал ажиллах бөгөөд тооцоолохдоо цаг их зарцуулж байсан. Иймд математикийн багштай хамтран тооцоолох бодох арга жишээг зааж бататгасан байвал үр дүнтэй байна гэж үзлээ.

Сурагчид хэмжилт хийж, тооцож олох явцдаа тоогоор илэрхийлж үржүүлж, хувааж олоод байгаа боловч түүнийхээ “нэгж” болох см, эсвэл км-ийн алинаар нь илэрхийлэгдэх билээ? гэдэг дээр эргэлзэж байсан. Газарзүйн зураг дээрээ хэмжсэн бол бага нэгж болох “см”-ээр илэрхийлэгдэнэ, тооцоолж гаргасан бодит газрын хэмжээ нь их нэгж болох “км” эсвэл “м”-ээр илэрхийлэгдэх байв. Тооцоолох бичиглэлдээ нэгжийг хамт бичихгүй орхиж зөвхөн тоог бичиж байсан нь эцсийн хариуны нэгжээ тодорхойлоход эргэлзээнд хүргэсэн.

“Газарзүйн зурагт байршил олох (солбицол)” хичээл:

Таамаглал дэвшүүлэх	Таамаглалаа шалгах, турших	Хэлэлцэх
		

Дасгал 1-д солбицлуудыг нэргүй дасгалын зурагт тэмдэглэх даалгаврыг ихэнх сурагчид амжилттай гүйцэтгэсэн. Дасгал 2-д том нутаг дэвсгэртэй улсуудын нутаг дээр орших солбицлыг өгөөд хаана ямар улсад оршиж байгааг олуулах даалгавар байв.

Сурагчид хойд өргөрөг, өмнөд өргөрөг, зүүн уртраг, баруун уртраг гэдгийг хольж солих буюу өргөрөгийн “хойд”, “өмнөд” гэсэн ялгааг уртрагт хэрэглэх, эсрэгээрээ уртрагийг “баруун”, “зүүн” гэж хуваадаг ялгааг өргөрөгт хэрэглэж андуурч байсан. Тиймээс цаашид үүнийг заахдаа хойд, өмнөд туйл, анхны голдочоос баруун зүүн тийш гэдгийг тодотгон тайлбарлаж хэлэх шаардлагатай гэж үзлээ.


Мөн өргөрөг, уртраг хэмээх шинэ ойлголтыг буруугаар “өртрөг” гэж хэлж байсан. Иймд сурагчдын өмнөх мэддэг ойлголт болох урт ба өргөний тухай мэдлэгт тулгуурлан, “урт”-уртраг, “өргөн”-өргөрөг гэж дүйцүүлэн тайлбарлаж болох юм.

Гарын доорх хэрэглэгдэхүүн болох шаарыг ашиглан туйл, уртраг өргөрөгийг дээр нь маркераар зуруулж (сурагчид өөрсдийн глобусыг бүтээж суралцах), торын шугамууд хэрхэн яаж харагдаж байгааг ажиглуулж зааснаар сурагчдын алдаа багасдаг болох нь ажиглагдсан. Энэ хэрэглэгдэхүүн нь дараагийн хичээл болох тусгагийн тухай ойлголтыг эзэмшүүлэхэд ашиглахуйц хэрэглэгдэхүүн болж чадна гэж үзлээ.



Дасгал-3-т Монгол орны нууруудын нэр эсвэл тэдгээрийн орших солбицлын аль нэг нь өгөгдсөн. Газарзүйн зургаас мэдэгдэхгүй байгаа утгыг олох байв. Газарзүйн дасгалын зургууд нь өөр өөр сэдэвчилсэн, масштаб, зураглалын хэлбэрээрээ ялгаатай байв. Мөн эдгээр зургууд нь жижиг масштабтай тул том масштабтай зурагтай харьцуулан солбицолыг шалгахад тухайн солбицол дээр объект нь оршихгүй байх зэрэг зөрүү гарч байсан. Цаашид ийм зөрүү гарвал газарзүйн зургийн “гажилт”-аас хамаарч болохыг сурагчдад тайлбарлах хэрэгтэй гэж үзлээ. Хичээлийн бэлтгэл судалгаа хийх явцдаа хэд хэдэн зургийг харьцуулан дахин дахин шалгах шаардлагатайг ойлгосон.

Хэвлэмэл газарзүйн зураг дээрх газрыг “бодит”-оор харах (Google Earth програм дээр батлан шалгах)



Хэвлэмэл газарзүйн зураг дээрх газрыг “бодит”-оор (Google Earth програм дээр батлан шалгах) харж, уул, тариалангийн талбай замтай газар байна гэх мэтчилэн бататган шалгасан нь сурагчдын сонирхлыг улам нэмэгдүүлж, солбицлыг ингэж хэрэглэдэг юм байна гэсэн ойлголтыг өгснөөр амьдралдаа хэрэглэх, гүнзгийрүүлэн сурах хүсэл эрмэлзлийг өдөөсөн.

Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага

- Сансрын зургийг сургалтад ашигласнаар дижитал газарзүйн зургийг хичээл болон амьдралдаа хэрэглэхэд дөхөм болно.
- Орон нутгийн онцлогт тохирсон дадлага ажил, кейсийг зохиосон нь сурагчдад нутаг орноо улам сайн мэдэх, судлах ажиглах хүсэл эрмэлзэл төрөхийн зэрэгцээ өөрт тулгарсан зарим асуудлаа шийдэх арга замыг олж болохыг мэднэ.
- ЕБС-ийн багш нар хичээлдээ хөгжүүлэн хэрэглэх боломжтой ээлжит хичээлийн хөтөлбөрүүд, дагалдах ажлын хуудсуудыг боловсруулсан.
- Сурагчдын дасгал даалгаврын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг боловсруулж дүгнэх явцдаа хөтөлбөрийн сайжруулах хэсгийг тодорхойлсон.

Хичээлийн сэдэв	Үнэлэх шалгуурууд
Газарзүйн зургийн таних тэмдэг	<ul style="list-style-type: none"> ✓ Зурагт объектыг таних тэмдгээр илэрхийлсэн эсэх ✓ Таних тэмдгийн буланд шинээр зохиосноо нэмж зурсан эсэх ✓ Шинэ зохиосон таних тэмдгээ ашиглан нэмж объект тэмдэглэж зургаа баяжуулсан эсэх
Газарзүйн зургийн масштаб	<ul style="list-style-type: none"> ✓ Зураг дээр зайг хэмжиж чадсан эсэх ✓ Масштабыг зөв тооцоолсон эсэх ✓ Бодит газар дээрх зайг зөв олсон эсэх
Газарзүйн зургийн зүг чиг	<ul style="list-style-type: none"> ✓ Чиглэсэн сумыг чиглүүлж зурсан эсэх ✓ Чиглэл болон өнцгийг тодорхойлж чадсан эсэх ✓ Эсрэг чиглэлийг тодорхойлсон эсэх
Газарзүйн зургийн солбицол	<ul style="list-style-type: none"> ✓ Солбицлыг зурагт тэмдэглэх, олж чадсан эсэх ✓ Солбицлоор газар орныг олсон эсэх ✓ Газар орны нэрээр хайж, солбицол тодорхойлсон эсэх

- Хичээлийн дараах дүгнэлтийг нээлттэй асуултаар бичүүлж авснаар хичээлийн үр дүнг тодорхойлоход дөхөм болсон.

Судалгааны үр дүн

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд хийсэн зарим сайжруулалт, өөрчлөлтүүд:

Газарзүйн зургийн таних тэмдэг хичээлийн хөтөлбөрийн сайжруулалт (хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа)

Хичээлийн үе шат	Хөтөлбөрийн анхны боловсруулалт (Хөтөлбөр 1)	Хөтөлбөрт орсон өөрчлөлт
Хичээлийн эхлэл	1. Сэргээн санах-ахуй амьдралын таних тэмдгүүдийг ярилцах (фото зургаар)	

	2. орон нутагт орших байгууллагуудын лого таних тэмдгийн ажиглан таних, хаана оршдогийг ярилцах (фото зургаар)	
Хичээлийн өрнөл	3. Орон нутгийн сансрын зургийг багууд ажиглах, эхлээд өөрсдийн сургуулиа олох, мөн орон нутгийн байгууллагууд хаана байгааг олох 4. Таних тэмдгийн булан"-д байгаа зургуудыг ашиглан сансрын зургаа газарзүйн зураг болгон таних тэмдэгжүүлэн наах 5. Өөрийн мэдэх объект юмс хаана байгаа юу байгааг ярилцах, олох 6. Эдгээрийг нэмж таних тэмдгээр илэрхийлэх-сурагчид таних тэмдэг зохиож зурагтаа илэрхийлэх	6-р дасгал: Сурагч бүр дор хаяж нэг шинэ объект юмсыг таних тэмдгээр илэрхийлж нэмж зурах (сурагч бүрийг оролцуулах) Сурагчид 6-р ажлыг гүйцэтгэсний дараа багш дараах чиглүүлэх асуултыг асууна: Таних тэмдгийн буланд зураг дээрх бүх таних тэмдгүүд мөн зурагдсан байгаа эсэхийг шалгаарай.
Хичээлийн төгсгөл	7. Баг бүр өөрсдийн шинээр зохиосон таних тэмдэг болон тэмдэглэсэн объектоо бусад багуудад танилцуулах, илтгэх	Гэрийн даалгавар: гэрийнхээ ойр орчмын объектуудыг зураглах (таних тэмдэг ашиглах)


Газарзүйн зургийн масштаб хичээлийн хөтөлбөрийн сайжруулалт (хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа)

Хичээлийн үе шат	Хөтөлбөрийн анхны боловсруулалт (Хөтөлбөр 1)	Хөтөлбөрт орсон өөрчлөлт
Хичээлийн эхлэл	Кэйс унших-Дүүгээ цэцэрлэгээс авах тухай	
Хичээлийн өрнөл	Сургуулиас цэцэрлэг хүрэх зайг яаж мэдэж болохыг ярилцах Сансрын зургийг ажиглах Сургуулиа тэмдэглэх Очих цэцэрлэгийг тэмдэглэх Сургуулиас цэцэрлэг хүртэлх замыг зурах Дасгал 1 — Зурсан замаа дагуулан хэмжилтийн утсаа давхарлан барьж хэмжих — Хэмжиж авсан утсаа шугаман дээр тавьж уртыг ол \ см –ээр \ — Зургийн шугаман масштабыг тооцоолж олох — Сургуулиас цэцэрлэг хүртэлх зайг олох Дасгал № 2 — Сургуулиас цэцэрлэг хүртэлх зам өөр зурагт хэдэн см болж зурагдсан байгааг олох — Энэ зургийн мэдэгдэхгүй байгаа масштабыг олох	<ul style="list-style-type: none"> ➤ Дасгал 1, Дасгал 2-ыг багуудад хувааж зэрэг хийлгэх ➤ Дараа нь гарсан үр дүнг харьцуулан хэлэлцэх (2 өөр зурагт нэг ижил зай ялгаатай зурагдсан байгаа шалтгаан) ➤ Масштабыг ойлгох хэрэглэх талаар ярилцах-(1 см-т багтаасан зай) ➤ Бататгал гэрээс сургууль хүртэлх зайг хэмжиж тооцоолж олох
Хичээлийн төгсгөл	Ижил зай өөр зурагт ялгаатай зурагдсан байгаа шалтгааныг ярилцах	

Газарзүйн зургийн зүг чиг хичээлийн хөтөлбөрийн сайжруулалт (хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа)

Хичээлийн үе шат	Хөтөлбөрийн анхны боловсруулалт (Хөтөлбөр 1)	Хөтөлбөрт орсон өөрчлөлт
Хичээлийн эхлэл	Зургийг ажиглан зүг чигийг тодорхойлох (Энэ охин аль зүг рүү харж байна вэ?) Бид одоо аль зүг рүү харж байна вэ?(Сурагчид самбар руу харж суух үедээ)	
Хичээлийн өрнөл	— Сансрын зургийг ажиглах, сургуулиа олох — Зургийн зүг чигийн таних тэмдгийг ажиглаж, ярилцах, ойлгох — Дасгал ажиллах-объектоо олох, чиглэл тодорхойлох, азимут өнцөг тодорхойлох	Дасгал ажил гүйцэтгэх алхмыг нарийвчлан алхамд хуваасан 1. Объектуудаа олох 2. Тодруулан зурах, 3. Сургуулиас объект руу чиглүүлэн шулуунаар шугамаар холбон зурах Шулууныг объект руу чиглэсэн сум болгон үзүүрийг тэмдэглэх 4. Сургууль дээрээ жижиг зүг чигийн таних тэмдгээ байршуулах (ажлын хуудасныхтай ижил чиглэлд тохируулах) 5. Объектуудын зүг чиглэлийг тодорхойлох 6. Объектуудын орших чиглэлийн азимут өнцгийг тодорхойлох
Хичээлийн төгсгөл	Багууд дасгал ажлынхаа үр дүнг танилцуулах	Багийн гишүүдийг 1-6 хүртэл дугаарлаж, дараа нь ижил дугаартай гишүүд дахин нэг баг болж өөрийн багийн ажлаа танилцуулсан. Ингэснээр сурагч бүр оролцож чадсан.

Судалгаат хичээлийн үр дүнд хөтөлбөрүүдийг хэлэлцүүлгийн явцад гарсан дараах саналуудаар сайжруулж байв (Жишээ нь : “Газарзүйн зургийн зүг чиг” хичээлийн хөтөлбөрийг сайжруулах саналууд)



Газарзүйн зургийн зүг чиг хичээлийн ажлын хуудасны сайжруулсан байдал

Дараах объектууд Цагдаагийн газраас аль зүгт оршиж байна вэ?		Эмнэлэг	МСҮТ
Объектууд	Орших зүг		
0101-р анги		0101-р анги	
Эмнэлэг			Цагдаа
МСҮТ			
Эмнэлгээс-ээс цагдаа аль зүгт оршиж байна?		Цагдаагаас эмнэлэг аль зүгт оршиж байна?	
Хичээлийн дүгнэлт:			
Эргэлзээтэй ойлгоход хэцүү байсан нь:		Миний сайн ойлгосон зүйл:	

Хөтөлбөр 1, 2

Ажлын хуудас-2 (Сурагчийн)			Шонхор дэлгүүр	6-р сургууль
Дараах объектууд Бөмбөөлэй дэлгүүрээс аль зүгт оршиж байна вэ?			Бөмбөөлэй дэлгүүр	
Объектууд	Орших зүг	Чөлөөтийн өнцөг (азимут-вадуу)		
6-р сургууль				
Цэцэрлэг				Цэцэрлэг
Шонхор дэлгүүр				
Бөмбөөлэй дэлгүүрээс цэцэрлэг аль зүгт оршиж байна?			Цэцэрлэгээс Бөмбөөлэй дэлгүүр аль зүгт оршиж байна?	
Хичээлийн дүгнэлт:				
Эргэлзээтэй ойлгоход хэцүү байсан нь:			Миний сайн ойлгосон зүйл:	

Хөтөлбөр 3

Дүгнэлт

7-р ангийн Гео-оронзайн дүрслэл айн хүрээнд газарзүйн зургийн таних тэмдэг, масштаб, зүг чиг, солбицол зэрэг үндсэн ойлголтуудыг мэдэх, тэдгээрийг хэрэглэж сурах зорилго бүхий 4 ээлжит хичээлийн хөтөлбөрийг боловсруулж туршин сайжруулав. Хичээлийг заах явцад газарзүйн зургийн үндсэн ойлголтуудыг мэдэх, хэрэглэхэд сурагчдад илэрсэн эргэлзээ, алдаа, бэрхшээлийг тодорхойлов. Сансрын зургийг ашиглах нь сургалтын хөтөлбөрийг орон нутгийн онцлогтойгоор хэрэгжүүлэхэд дөхөм болж байна. Сургалтын том масштабын газарзүйн зураг ховор байдаг бэрхшээлийг шийдэх нэгэн гарц шийдэл нь сансрын зураг байх боломжтой гэж үзлээ

Номзүй

1. Батчулуун, Е. (2017). Газарзүйн боловсролын үндэс. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
2. Суурь боловсролын цөм хөтөлбөр (2015).
3. Батчулуун, Е. (2014). Газарзүй-1. Улаанбаатар: Сэлэнгэпресс ХХК.
4. Батчулуу, Е. (2015). Багшийн ном. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
5. Бурмаа, Б ба бусад. (2008). Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй.
6. Юмчмаа, Г ба бусад. (2013). Багшлахуйн хөгжил. Хүн байгаль хичээлийн модуль. Улаанбаатар: Содпресс ХХК

Бие даалтын бүтээлээр дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь

Хөвсгөл аймгийн ДМЦС-ийн газарзүйн багш Р.Хишигбуян¹

Газарзүйн клубын нэр: Саран дээр ч сүлжээ барина

Зорилго: Байгалийн юмс үзэгдлийн учир шалтгааныг илэрхийлсэн бүтээлч даалгавараар шинжлэх ухааны үг хэллэг, шинжлэн судлах арга барилд суралцуулсанаар бүтээлч чадвар, суралцах хүсэл эрмэлзлэлийг сайжруулах арга зүйг судлах.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Сурагчдын багаар гүйцэтгэсэн бүтээлийг хичээлийн агуулга, сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан, бусад шинжлэх ухааны интеграцилан хийх, бие даан суралцах суралцахуйн үйл ажиллагааг эзэмшихэд нөлөөлөхүйц бүтээлч даалгавар хийх арга зүйг сонгон сайжруулаж судалгаа хийсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү судалгаагаар суралцагчид өөрийн сонирхлын дагуу байгалийн юмс, үзэгдэл, учир шалтгаан, зүй тогтол зэргийг харуулсан бүтээлч даалгавар хийх явцдаа шинжлэх ухаанч эрэл хайлт хийх, бусад хичээлээр эзэмшсэн мэдлэг чадвараа хэрэглээ болгох, тогтолцоонд оруулах, улмаар бие даан суралцах арга барил хөгжиж байгаа нь батлагдсан.

Практик ач холбогдол: Хүүхэд нэг бүрт шинжлэн судлах арга барилыг эзэмшүүлэхдээ бүтээлч даалгавар хийлгэх арга зүйг бүхий л судлагдахуунд ашиглан бүтээлч сэтгэлгээ, оролцоо хандлагыг өөрчлөн зорилготой сургах боломжтой.

Шинэлэг тал/ач тус: Бүтээлч даалгавар хийх арга аргачлал, бүтээлийг үнэлэх шалгуурыг сурагчдад нээлттэй арга зүйг боловсруулан газарзүйн хичээлээр нь бүтээлч даалгавар хийлгэх замаар хүүхэд нэг бүрийн сонирхолыг өрнүүлж, хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлж зорилготой суралцуулах, хөгжүүлэх санааг дэвшүүлж байна.

Түлхүүр үг: Бүтээлч даалгавар, арга зүй, бүтээл, хамтран суралцах

Удиртгал

2006-2013 оны хооронд БСШУЯ, Японы Жайка олон улсын байгууллагаас хамтран “Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүйн хөгжил”, “Багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Эдгээр төслийн зорилго нь багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих, сурагчдын суралцахуйг дэмжсэн арга зүйг нээн хөгжүүлэх явдал байлаа. Иймд судалгаат хичээлээр багш нар хамтран хүүхдэд өгөөжтэй арга зүйг боловсруулан туршиж, үр дүнг хамтран хэлэлцэж, сайжруулан арга зүйгээ хөгжүүлэхийн зэрэгцээ харилцан бие биеэс суралцах, сурч мэдсэнээ түгээн дэлгэрүүлэх ач холбогдолтой. Дэлгэрмөрөн цогцолбор сургууль МХСН-тэй хамтран ажиллаж хичээлийн судалгааны түшиц сургууль болох зорилго тавин 2018 онд Газарзүйн баг, Биологийн багийн хичээлүүдийг технологийн санд бүртгүүлээ.

Нэгдүгээр бүлэг. Онол аргазүйн үндэс, судалгааны загвар

1.1Сэдвийг сонгосон үндэслэл: Оросын алдарт сурган хүмүүжүүлэгч К.Д.Ушинскийн хэлсэнчлэн “Хэрвээ сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг бүхий л талаар нь төлөвшүүлэхийг хүсвэл юуны өмнө түүнийг бүхий л талаар нь судлах хэрэгтэй” хэмээн хэлсэн байдаг. Суурь боловсролын цөм хөтөлбөр, шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хүүхэд нэг бүрийг шинжлэх ухааны суурь мэдлэг, амьдрах ухаан, сурах арга барил, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмшихэд сурагчдын сурах сонирхлоос хамааран хичээлд оролцох оролцоо хангалтгүй, биет үзүүлэн, хэрэглэгдэхүүн дутмаг, туршилтын тоног төхөөрөмж байдаггүй учир хичээлд оролцох оролцоо сул, багш хийсвэр байдлаар онолыг тайлбарлан ярьдаг. Энэ арга нь сурагчдад шинжлэн судлах арга барилыг хөгжүүлж чаддаггүй.

Хичээлийн санаа: Бүтээлч даалгавар хийх арга аргачлал, бүтээлийг үнэлэх шалгуурыг сурагчдад нээлттэй арга зүйг боловсруулан газарзүйн хичээлээр нь бүтээлч даалгавар хийлгэх замаар хүүхэд нэг бүрийн сонирхолыг өрнүүлж, хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлж зорилготой суралцуулах, хөгжүүлэх санааг дэвшүүлж байна.

Бэлтгэл судалгаа

Хичээлийн судалгааны зорилго: Сурагчдын сонирхол ур чадварыг судлан илрүүлж, сонирхсон зүйлд нь тулгуурлан бүтээлч даалгавар хийлгэж хүүхэд нэг бүрийн ээлжит хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлэн хөгжүүлэх боломж ач холбогдлыг судлах.

Бид сурах сурагчдын сонирхол, хийх дуртай зүйл, ур чадвар судлагдахууны агуулгын залгамж холбоо, заах арга барил, хэрэглэгдэхүүний судалгаа, суралцагчдын мэдлэг эзэмшилт, шинжлэх ухаанч арга барил, чадварын ахиц амжилтанд шинжилгээ хийн арга зүй боловсруулан туршсан. Үүнд:

Судалгаат хичээлийн давтамж:





Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 7а,в, 8д,е, 9а,б,г,е,10в,д ангид 2014-2018 онд туршин хэрэгжүүлэхдээ бүтээлч даалгавар хийх арга аргачлал, үнэлгээний шалгуур, арга зүйн судлагааг хийсэн. Судалгаат хичээлд зөвлөхөөр сургалтын менежер Б.Гантулга, сургалтын менежер Б.Тунгалагцэцэг, МХСН-ийн зөвлөх багш Д.Энхтуяа, газарзүйн багш Р.Хишигбуян, З.Баясгалан, Б.Энхтүвшин бусад мэргэжлийн багш нар оролцов.

Технологийн үндсэн үе шат, арга аргачлал

№	Үе шат	Аргачлал
1	Бэлтгэл үе шат	Сурагчдын сонирхолыг судлан илрүүлэх
		Бүтээлийн төрлөө сонгож өөрийн сонирхлоороо бүтээл хийх
2	Бүтээлийн туршилтын үе	Чадварыг тодорхойлох үнэлгээний шалгуурын дагуу бүтээлийн гүйцэтгэлээс сурагчдын ур чадварыг нээн илрүүлэх
		Бүтээлийн төрлөө сонгож бүтээл хийхэд шаардлагатай ШУ-ны агуулга, бусад хичээлтэй хэрхэн холбогдож буй талаарх бүхий л мэдээллийг цуглуулах
3	Үр дүнг боловсруулах үе	Алдааг нь тооцон үр дүнг боловсруулах, тайлагнах

Бүтээлийн үнэлэхдээ:

№	Үе шат	Аргачлал
1	Бэлтгэл үе шат	Сурагчдын сонирхолыг судлан илрүүлэх
		Бүтээлийн төрлөө сонгож өөрийн сонирхлоороо бүтээл хийх
2	Бүтээлийн туршилтын үе	Чадварыг тодорхойлох үнэлгээний шалгуурын дагуу бүтээлийн гүйцэтгэлээс сурагчдын ур чадварыг нээн илрүүлэх
		Бүтээлийн төрлөө сонгож бүтээл хийхэд шаардлагатай ШУ-ны агуулга, бусад хичээлтэй хэрхэн холбогдож буй талаарх бүхий л мэдээллийг цуглуулах
3	Үр дүнг боловсруулах үе	Алдааг нь тооцон үр дүнг боловсруулах, тайлагнах

- ✓ Шалгуур 1-Тухайн агуулгыг илэрхийлж буй эсэх
- ✓ Шалгуур 2- Бүх нийтийн хүртээл болохуйц
- ✓ Шалгуур 3- Бүтээлээ тайлбарлах чадвар Шалгуурыг дэлгэрэнгүй болгох

Дээрх шалгуураар шилдэг бүтээлтэй багийг шалгаруулав.

№	Багийн нэр	Анги	Бүтээлийн нэр	Агуулгын хүрээ
1	Газарзүйн баг	9	Дэлхийн дотоод бүтэц	Чулуун мандал
2	Бид туслая	9	Байгаль дахь усны эргэлт	Усан мандал

3	Саран дээр ч сүлжээ барина	10	Монгол орны хөлөгт тоглоом	Монгол орны газарзүйн онцлог
---	----------------------------	----	----------------------------	------------------------------

Шинэлэг санаа арга туршлага

Багийн бүтээлийн онцлог:

- Багаар хийсэн бүтээл нийт бүтээлийн 92% эзлэж байна.
- Өнгөрсөн хичээлийн жилд нэг сурагч нэг бүтээл хийж байсан бол энэ жил багаар оролцож байгаа нь давуу боллоо.
- Төрөлжсөн бүтээл хийн анги дотроо шалгаруулсан. /10д анги 4 төрлийн бүтээлийг сонгон шилдэг бүтээл хийж багаа тодруулсан/
- 10г ангийн хамт олон физик-газарзүйн хичээлийн интеграци илэрхийлсэн бүтээл хийсэн.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүүхдийн бүтээлээр дамжин хөгжиж ирсэн ахиц өөрчлөлтийг дараах хүснэгтээр харууллаа.

	
Анх хийсэн бүтээлч даалгавар	Бүтээлч даалгавар хийх арга аргачлал, бүтээлийг үнэлэх шалгуур, зөвлөгөө өгсний дараа

Аймгийн “Хөгжлийг бүтээгч хүүхэд” бүтээлийн үзэсгэлэнгийн үеэр манай сурагчдын бүтээлээс шилдэг бүтээл шалгаруулах шалгуурыг хангахуйц бүтээл цөөн байсан. Иймд сурагчдын бүтээлийг сайжруулахдаа сонирхлоор нь баг болгон шинжлэх ухааныг хамтад нь судлуулж хамтран ажиллах, харилцан суралцах нөхцлийг бүрдүүлснээр “Монгол орны газар зүйн онцлог” агуулгын хүрээнд дээрх бүтээлийг хийж чадсан.

ДҮГНЭЛТ

Газарзүйн шинжлэх ухаан нь байгаль, нийгмийн өргөн хүрээтэй салбарыг хамардаг учир судалгааны аргууд, бүтээлийн агуулгын хүрээ нь өргөн байдаг.

Бүтээл хийх агуулгыг сурагчдад нээлттэй өгсөнөөр тухайн хүүхдийн бүтээл хийх арга зүй, бүтээлийн бүтээцийн материалын сонголт зэргийг өөрийн нөхцөлд нийцүүлэн сонгох бүрэн боломжтой.

Газарзүйн хичээл нь байгалийн болоод нийгмийн хичээлүүдийн цогц тул үзэгдэл зүй тогтолуудыг тоолохын аргагүй юм.

Иймд нийгмийн тухай мэдлэг болон биологи, хими, физик зэрэг байгалийн ухааны суурь хичээлүүдийн чадваруудаас гадна математик, англи хэл, зураг зүйн хичээл, техник технологийн хичээлүүдийн чадварууд цогцоор гарч байна.

Сурагчид маань бүтээлээ хийхдээ дан ганц мэргэжлийн багшаас зөвлөгөө авахаас гадна бусад мэргэжлийн хичээлүүдийн багш нараас зөвлөгөө авч байлаа. Мэргэжлийн багш нарч танай хүүхдүүд ийм зүйл асуугаад явсан энийг нь ингэж хийвэл зүгээр юм байна гэсэн зөвлөгөөг өгч байлаа.

Арга зүйд суурилсан хичээлийн судалгаа буюу судалгаат хичээл нь багш ажлын байран дээрээ хөгжих, багш нар хамтран арга зүйгээ өөрчлөх өргөн боломжийг бидэнд нээж өгч байна. Судалгаат хичээлийг 2014-2018 оны хооронд зохион байгуулан ажилласнаар дараах дүгнэлтэд хүрлээ.

- Судалгаат хичээл зохион байгуулах явцдаа бид сонирхсон зүйлд тулгуурлан мэдлэг бүтээлгэх арга зүйгээ хөгжүүлэхийн зэрэгцээ сурагчдын хийсэн бүтээлийг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулан сургалтад бүтээлчээр ашиглаж сурлаа.
- Бүтээлээр дамжуулан хүүхэд нэг бүрийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн бүтээлч идэвхийг дэмжихэд чухал үүрэгтэй болохыг олж тогтоолоо.
- Байгалийн ухааны хичээлийн бүтээлээр дамжуулан бүх суралцагчдын шинжлэн судлах арга барил, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх бүх хичээлийг судлах сонирхол хүсэл эрмэлзэлтэй болгох ач холбогдолтой болох нь нотлогдлоо.

Үр дүн 3. Судалгаат хичээл зохион байгуулснаар багшийн арга зүй болон суралцагчдын сурах арга барилд дараах ахиц өөрчлөлтүүд гарсан. Үүнд:

Багшлах арга зүйд гарсан өөрчлөлт:

3. Сурагчдын шинжлэх ухаанч арга барил эзэмшилт, чадварын ахиц өөрчлөлтийг тооцох арга зүйг харилцан бие биенээсээ суралцсан.
4. Сурагчдын сонирхол ур чадварт тулгуурлан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүйгээ хөгжүүлсэн
5. Сургалтанд ашиглах бүрэн боломжтой бодитой, шаардлага хангахуйц багц хэрэглэгдүүнтэй болсон
6. Сурагчдын бүтээлийн чанарт үнэлгээ хийж гүйцэтгэсэн даалгаваруудыг нэгтгэн цахим 500 тестийн сан бүрдүүлээ.

Б. Суралцагчдын сурах арга барилын хөгжил:

3. Өөрийнхөөрөө бүтээлчээр сэтгэх, таамаглах, мэдээлэл цуглуулах, ажиглах, зурах, харьцуулах, оюуны зураглал хийх, бүтээл хийх зэрэг шинжлэх ухаанч арга барилд суралцаж эхэлсэн.
4. Шатлал бүрийн дараа багшийн дээрх арга зүйгээр сурагчдын гарааны үед үнэлсэн чадвараас /өөрийгөө илэрхийлэх, юмс үзэгдлийн зүй тогтлыг олж тайлбарлах, зөв төлөвшилтэй, харилцаа хандлага/ барианы үеийн чадвар хүртэл сурагчдын бүхий л чадварт 25,5%-ийн ахиц гарсан.
5. Шинжлэх ухаанч арга барил эзэмшиж өфбүтээл хийх сэдэв, шаардлагатай материалаа зөв сонгон төлөвлөн гүйцэтгэх, багаж хэрэгслээ зөв сонгох, таамаглалаа нотлох, үр дүнг нь тооцоолох, тайлбарлах, нэгтгэн дүгнэх чадвартай болсон.
6. Сурагчид өөрсдийн бүтээсэн бүтээлээрээ дамжуулан бусад шинжлэх ухааны хичээлийг сонирхон суралцах хүсэл эрмэлзлэлтэй болж харилцан бие биенээсээ суралцаж, мэдлэг бүтээх суралцахуйн хандлага төлөвшсөн.

Судалгааны ажлын шинэ санаа

Бүтээлч даалгавар хийх арга аргачлал, бүтээлийг үнэлэх шалгуурыг сурагчдад нээлттэй арга зүйг боловсруулан газарзүйн хичээлээр нь бүтээлч даалгавар хийлгэх замаар хүүхэд нэг бүрийн сонирхолыг өрнүүлж, хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлж зорилготой суралцуулах, хөгжүүлэх санааг дэвшүүлж байна.

Шийдвэрлэсэн асуудал

Сураглагч юуг яаж хийхээ мэддэг болсон хичээлийн явцад өөрт дутагдаж байгаа зүйлийг ойлгож тэдгээрийг засаж сайжруулахад анхаарч суралцах боломжтой болсон гэсэн эерэг хандлага илэрсэн.

Яагаад сайн хичээл болсон

Сурагчид байгалийн ухааны хичээлийн мэдлэг чадварын ахиц амжилт, мэдлэг бүтээх орчноо шийдэх цогц даалгавар боловсруулахаар жил гаруй янз бүрийн түвшинд өөрсдийн санаачлагаар хийж ном сурах бичиг, багшийн дэмжлэгтэйгээр дахин сайжруулж ажиллаж байгаа нь сурах арга барилын чадваржилт, хамтдаа асуудлыг шийдэх, зорилготой суралцах нийгэмшил, төлөвшилд эерэгээр нөлөөлж байна.

Бусдад хүргэх туршлага


Сурагчид өөрсдийн санаачлагаар бие даан цогц олон төрлийн даалгавар боловсруулж хичээлдээ хэрэглэж болдог гэдгийг баталлаа. Хийсэн ажлаа эхнээс нь дуустал дахин дахин шалгаж явцад нь сайжруулж туршин баталж байгаа нь ололттой тал байлаа.

Ном зүй

- ✓ Газарзүй- II,III сурах бичиг
- ✓ Зөвлөмж боловсруулах гарын авлага/2015он/
- ✓ Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй-I,II,III /МУЛсын БСШУЯ, Япон Улсын Жайка хамтран гаргасан зөвлөмж/
- ✓ Хичээлд мониторинг хийх арга зүйн зөвлөмж / МУЛсын БСШУЯ, Япон Улсын Жайка хамтран гаргасан зөвлөмж/
- ✓ Хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын онол, үзэл баримтлалаас Проф. Б.Бурмаа багшийн лекц /Хөвсгөл аймаг мөрөн сум 2014он/
- ✓ Сургалтын технологи, хичээлийн технологи-сурган хүмүүжүүлэх техник МХСН-ийн тэргүүн Н.Оюунцэцэг багшийн лекц/Хөвсгөл аймаг мөрөн сум 2014он/
- ✓ Сурагчдын ажлын хуудас
- ✓ Сорил тооцоогоор мэдлэг бүтээх арга зүй-I,II,III / МУЛсын БСШУЯ, Япон Улсын Жайка хамтран гаргасан зөвлөмж/
- ✓ Ээлжит хичээлийн төлөвлөлт

Хавсралт

2018 оны 1 сарын 12-ны өдөр анги ангидаа хийж, сургалтын менежер Б.Гантулга, байгалийн ухааны багш нар танилцаж зөвлөгөө өгч ажиллалаа. Энэ нь хүүхдүүд бусад багуудын хийсэн бүтээлтэй танилцаж, хичээлээр олж авсан мэдлэгээ бататгаж сэргээн санаж, мөн шинэ санаа олж авч, бүтээлийн эздэд нэмэлт санаа зөвлөгөө өгсөн бүтээлч ажил боллоо.



2018 оны 03 сарын 12-ний өдөр нийт 12-р ангийн сурагчдын “Хөгжлийг бүтээгч хүүхэд” аяны үр дүнгийн тайланчлалыг сургуулийн урлаг зааланд зохион байгуулж баг бүр сайжруулсан бүтээлээ танилцууллаа.



Туршилт, сургалт боллоо



Боловсрол соёл урлагийн газрын даргын 2018 оны 04-р сарын 09-ний өдрийн А/119 дугаар тушаалаар батлагдсан ЕБС-иудад “Шинжлэх ухаан сонирхогч сурагчдын клуб” байгуулах журмын дагуу Дэлгэрмөрөн цогцолбор сургууль дээр “Эврика” шинжлэх ухаан сонирхогч сурагчдын клуб 3 багтайгаар байгуулагдаад үйл ажиллагаагаа явуулж үр дүнд хүрч ажиллаа.

Мөнхзаяа	В	0	0	1	1	4.5	1	14	7.5	53.57	1
Мягмарсүрэн	В	0	0.5	0	0	0.5	0	14	1	7.143	3
Төгөлдөр	А	1	0.33	0	2	2	1	14	6.33	45.21	3
Хонгорзул Бат	А	0	0.33	1.5	1.5	5	1	14	9.33	66.64	1
Хонгорзул Бж	В	1	1	2	1	5	1	14	11	78.57	2
Хэнмэдэх	А	1	0.33	1.5	1	5	1	14	9.83	70.21	2
Уранзаяа	А	1	0.33	0.5	2	0	1	14	4.83	34.5	3
Сумьяабазар	А	1	0.33	1	2	3	1	14	8.33	59.5	2
Ганэрдэнэ	А	0	0.33	0.5	1	3	0	14	4.83	34.5	3
Мөнхочир	А	1	0.33	0	1	3	1	14	6.33	45.21	3

Сургуулийн хөндлөнгийн шалгалтын анализ

Анги: 7в Хичээл: Газарзүй Багш: Р.Хишигбуян 2017.3.23

№	Нэр	Хувилбар	Даалгавар						Авах	Авсан	Гүйц	чадварын үнэлгээ
			Газрын гадрага	Цэг агаар ба уур амьсгал	Агаарын даралтын зураглал	Бодлого	Газрын зурагт объект тэмдэглэх	Дэлхийн далай, гол мөрөн				
			1	1	3	3	5	1				
1	Б.Бямбадолгор	А	1	0.3	1	0	3	1	14	6.3	45	2
2	Ө.Үүрцайх	В	1	1	0.5	1	1	1	14	5.5	39.29	3
3	М.Нандинцэцэг	В	0	0.5	3	2	3	0.5	14	9	64.29	1
4	Б.Сайнзаяа	А	1	0.5	3	3	3	1	14	11.5	82.14	1
5	Н.Мөнхэрдэнэ	А	1	1	3	3	3	1	14	12	85.71	1
6	Б.Сэргэлэн	А	1	1	2	1	3	1	14	9	64.29	1
7	Д.Мөнхочир	В	1	1	1.5	3	1	1	14	8.5	60.71	2
8	М.Энхмарал	А	1	0.3	2.5	1.5	3	1	14	9.3	66.43	1
9	Л.Дэлгэрмаа	В	0	0.5	2	1.5	5	1	14	10	71.43	1
10	Э.Энхжин	А	1	0.33	1.5	1.5	5	1	14	10.33	73.79	2
11	М. Жавжансүрэн	В	1	0.5	3	1.5	3	1	14	10	71.43	1
12	А.Номинэрдэнэ	В	1	0.5	2	1	2	0.5	14	7	50	3
13	Ц.Батбилэгт	А	1	0	0	1	3	0.5	14	5.5	39.29	3
14	Б.Хосцэцэг	А	1	0.3	0.5	0	3	1	14	5.8	41.43	2
15	Б.Отгонжаргал	В	1	0.5	3	2	5	1	14	12.5	89.29	1
16	Г.Лхагвадорж	В	1	0.5	1	0	3	0.5	14	6	42.86	2
17	Э.Ариунболор	А	0	0.5	1.5	1	3	1	14	7	50	3
18	А.Анударь	В	1	1	3	1.5	3	1	14	10.5	75	1
19	Н.Эрдэнэтуул	А	1	0.5	1	0	5	1	14	8.5	60.71	2
20	Б.Нямдалай	В	1	0.5	0	0	2.5	1	14	5	35.71	3
21	А.Пүрэвочир	А	1	0	0	0	3	1	14	5	35.71	2
22	Д.Дэлгэрмаа	В	0	0.5	2	1	5	1	14	9.5	67.86	1
23	Д.Оюундарь	В	1	0	0.5	1	5	1	14	8.5	60.71	1
24	Ц.Эмүжин	В	1	0	2	3	3	0	14	9	64.29	2
25	Т.Итгэл	В	1	0.5	2	0	2.5	1	14	7	50	3
26	Л.Сумьяабазар	А	1	0.3	1	3	0.5	1	14	6.8	48.57	3
27	Д.Буянхишиг	В	1	0.5	3	1.5	5	1	14	12	85.71	1
28	С.Янжинлхам	А	1	0.33	3	1.5	3	1	14	9.83	70.21	1
29	Г.Номинчулуун	А	1	0.5	0.5	0	5	1	14	8	57.14	2
30	О.Тэмүүгэ	А	1	0	0	0	3	1	14	5	35.71	2
Авах			30	30	90	90	150	30	420			
Авсан			26	13.9	49	36.5	97.5	27		249.9	Өмнөх	60
Гүйцэтгэл			86.7	46.2	54.4	40.6	65.0	90.0	С-н хөндлөн		59.49	
									ЗАН бариа		51.18	
									Багшийн гараа		51.4	76

Сургуулийн хөндлөнгийн шалгалтын анализ												
Анги: 8д			Хичээл: Газарзүй				Багш: Б.Энхтүвшин					
№	Нэр	хувилбар	Даалгавар					Авах	Авсан	Гүйц	чадварын үнэлгээ	
			Цаг агаар Уур амьсгал	Дэлхийн даралтын бүсийн зураг	Бодлого	Гол мөрөн	Нуур					Газарзүйн объект тэмдэглэх
			1	1	3	3	5	1				
1	Амарзаяа	А	1	1	0	0	3	1	14	6	42.86	2
2	Ариун Эрдэнэ	В	1	0.5	1	1.5	5	1	14	10	71.43	1
3	Батхишиг	В	1	0	1	1.5	3	1	14	7.5	53.57	1
4	Батдэлгэр	В	1	0	0	0	3	1	14	5	35.71	2
5	Баасанжаргал	А	1	1	0	1.5	3	1	14	7.5	53.57	1
6	Бямбасүрэн	А	1	1	0	1.5	3	1	14	7.5	53.57	2
7	Бямба Очир	А	1	0.5	0	1.5	3	1	14	7	50	1
8	Бадрах	А	1	0.5	0	1.5	3	1	14	7	50	1
9	Гантулга	А	1	1	0	1.5	3	1	14	7.5	53.57	1
10	Даваачулуун	В	1	0	3	1.5	3	1	14	9.5	67.86	1
11	Дэнсмаа	В	1	0.5	0	1	5	1	14	8.5	60.71	2
12	Жавхлантагс	В	1	0.5	1	1.5	3	1	14	8	57.14	3
13	Лувсаншарав	А	1	1	0	1.5	3	1	14	7.5	53.57	1
14	Лхагва Очир	В	1	0	0.5	1.5	3	1	14	7	50	2
15	Лхагважаргал	А	1	0.5	0	1	3	1	14	6.5	46.43	3
16	Мөнхдорж	В	1	0.5	0	1.5	3	1	14	7	50	1
17	Нарантуяа	А	1	0.5	0	1.5	3	1	14	7	50	2
18	Норлха	В	1	0.5	1	1.5	3	1	14	8	57.14	3
19	Оюундаваа	А	1	1	0.5	1.5	3	1	14	8	57.14	3
20	Өсөхбаяр	В	1	0.5	0	0	0.5	1	14	3	21.43	3
21	Сүндэрьяа	А	1	0.5	0	1.5	1.5	1	14	5.5	39.29	2
22	Сэдэд	А	1	1	2.5	1.5	3	1	14	10	71.43	1
23	Түмэн Очир	А	1	1	3	1.5	3	1	14	10.5	75	1
24	Төрбат	В	1	0	3	1.5	3	1	14	9.5	67.86	2
25	Хасбагана	В	1	0.5	0	1.5	3	1	14	7	50	2
Авах			27	27	81	81	135	27	350			
Авсан			25	14	16.5	32	75	25		187.5	өмнөх	68
Гүйцэтгэл			92.6	51.9	20.4	39.5	55.6	92.6	С-н хөндлөн		53.57	
									ЗАН бариа		53.88	80
									Багшийн гараа		52.3	

Сургуулийн хөндлөнгийн шалгалтын анализ												
Анги: 9г		Хичээл: Газарзүй				Багш: Б.Энхтүвшин						
№	Нэр	Хувилбар	Даалгавар					Авах	Авсан	Гүйц	чадварын үнэлгээ	
			ХАА	Зам тээвэр	Бодлого	Зам тээвэр	Оюуны зураглал					Газарзүйн объект тэмдэглэх
			1	1	3	3	5	1				
1	Амаржаргал	В	1	1	3	1.5	5	1	14	12.5	89.3	2
2	Ариунзаяа	А	1	0.66	1.5	1.5	5	1	14	10.66	76.1	1
3	Батчимэг	В	1	0.5	1	1.5	5	1	14	10	71.4	1
4	Баярбаатар	А	1	0.66	3	1.5	5	1	14	12.16	86.9	1
5	Бөхбат	В	1	0	1.5	1	5	1	14	9.5	67.9	2
6	Буянчуулган	А	1	0.66	3	1.5	5	1	14	12.16	86.9	1
7	Ганбаяр	В	0	0.5	0	1.5	3	1	14	6	42.9	2
8	Дашням	А	1	0.33	1	1.5	2	1	14	6.83	48.8	3
9	Дашням	А	1	0.66	0	1.5	5	1	14	9.16	65.4	1
10	Идэртулга	В	1	0.5	0.5	1	5	0.5	14	8.5	60.7	2
11	Ичинхорлоо	А	1	0	3	1.5	3	1	14	9.5	67.9	1
12	Мичидмаа	А	1	0.5	3	1.5	5	1	14	12	85.7	1
13	Лхагвабаяр	А	1	0.33	2.5	1.5	5	1	14	11.33	80.9	1
14	Б.Отгонжаргал	А	1	0.5	0	1.5	3	1	14	7	50	2
15	Н.Отгонжаргал	А	1	0	0	1	1.5	1	14	4.5	32.1	3
16	Оюунчулуун	А	1	0	0.5	1	3	1	14	6.5	46.4	2
17	Өсөхбаяр	А	1	1	1	0	5	1	14	9	64.3	3
18	Пүрэвнамжил	А	1	0.66	0	1.5	4	1	14	8.16	58.3	1
19	Санчир	В	1	0.5	2.5	1.5	5	1	14	11.5	82.1	1
20	Сугармаа	В	1	0.5	3	1.5	5	1	14	12	85.7	1
21	Түвшинтөгс	А	1	0.66	3	1.5	5	1	14	12.16	86.9	1
22	Уянсанаа	В	1	0.5	1	1.5	3	0.5	14	7.5	53.6	2
23	Халиунаа	В	1	1	2	1.5	5	1	14	11.5	82.1	1
24	Хатантуул	А	1	0.66	3	1.5	5	1	14	12.16	86.9	1
25	Хишигбат	В	0	0	1	1.5	0.5	1	14	4	28.6	3
26	Хандалай	А	1	0	1	1.5	3	1	14	7.5	53.6	3
27	Шаравдорж	В	1	1	1.5	1.5	5	1	14	11	78.6	1
28	Шинэбаяр	А	1	0.5	3	1.5	5	1	14	12	85.7	1
Авах			31	31	93	93	155	31	392			
Авсан			26	13.8	45.5	38.5	116	27		266.8	өмнөх	75
Гүйцэтгэл			83.9	44.5	48.9	41.4	74.8	87.1	С-н хөндлөн	68.1		
									ЗАН бариа	58.9	82	
									Багшийн гараа	54.9		

НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

Өөрийн үнэлгээгээр оюутны ахиц хөгжлийг дэмжих арга зүй, боломж

Б.Алтанмандах

Улаанбаатар, БЗД, Шинэ Монгол Технологийн Коллежийн багш

Сургалтын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болсон үнэлгээ нь оюутны мэдлэг, чадварыг үнэлэхээс гадна сургалтын явцыг удирдахад чухал үүрэгтэй юм. Аливаа үнэлгээг бодитой болгоход багшийн төдийгүй, сурагчдын оролцоо чухал нөлөөтэй байдаг. (Alvyda Regina 2014) Зарим судлаач өөрийн үнэлгээ нь оюутны сурах үйл явцад чухал ач холболтойг онцолсон. Үүнд: Сурах сэдлийг нэмэгдүүлэх, сурах чиглэлээ тодорхойлох, хариуцлага нэмэгдэх, эргэцүүлэн бодох чадвараа хөгжүүлэх зэрэгт чухал нөлөөтэй гэжээ. Иймээс сурлагын ахиц, амжилтыг үнэлэхэд сурагчийн өөрийн үнэлгээ чухал байр суурь эзэлдэг бөгөөд, тэд ч үнэлгээнд биечлэн оролцох сонирхолтой байдгийг энэхүү судалгааны явцад хэрэгжүүлсэн сургалтаас ажигласан юм. Өөрийн үнэлгээг хэрэгжүүлснээр оюутнуудын сурах арга барил, хандлагад сурах үүрэг хариуцлагаа улам ухамсарлаж, суралцах эрмэлзэл хандлага нь нэмэгдэж, өөрийгөө бодитоор үнэлэх чадварт илэрхий ахиц гарч, багш оюутны үнэлгээний зөрүү багасан, улмаар өөрийн суралцахууд шүүмжлэлтэй хандах, өөрийн удирдлагатай суралцахууд суралцаж эхэлсэн. Энэ удаагийн судалгаагаар оюутны өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг урьдчилан боловсруулж, уг шалгуурыг оюутнуудад эхнээс нь нээлттэй, тодорхой байлгаснаар үнэлгээ илүү үнэн бодит болох үндэс болсныг нотолсноороо ач холбогдолтой болсон.

Түлхүүр үгс: Сургалт, сурах сургах үйл, хандлага, өөрийн удирдлагатай суралцахуй, суралцах чадвар

Оршил

Хүүхдийг оролцуулсан хичээл амжилттай болдгоос гадна хүүхдийг сайн сургая гээд хэтэрхий мэдлэгт анхаарлаа хандуулбал хүүхэд шалгалтын машин болж хувираад хүн чанараа мартана. Хичээл сургалтыг амжилттай зохион байгуулж, бие даан үйл ажиллагаа явуулах чадвар, өөрийгөө удирдах чадвар, харилцааны чадвар, олж авсан мэдлэг чадвараа олон талаас ашиглах чадвар, сургуулиас өөр орчинд хэрэглэх чадварыг нь үнэлэхээс гадна хичээлийн үр дүнг тодорхойлох, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бодитой үнэлэхүйц үнэлгээний арга хэрэгсэл дутмаг байна. Тиймээс ээлжит хичээлийг зохион байгуулахад суралцагч өөрийгөө хэрхэн үнэлдэг болох, багшийн үнэлгээтэй хэрхэн нийцдэгийг судалж, илрүүлэх зорилгоор нийгмийн ухааны хичээлээр суралцагчийн өөрийн үнэлгээг туршин, суралцахууд хэрхэн нөлөөлж буйг илрүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг бичлээ.

Судалгааны зорилго: Оюутны өөрийн үнэлгээний бодит байдал, сургалтанд хэрэгжүүлэх боломж, арга замыг тодруулж, суралцахууд хэрхэн нөлөөлж буйг илрүүлнэ.

Судалгааны зорилтууд:

- Өөрийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт боловсруулан, оюутнаар үнэлгээ хийлгэх
- Оюутнуудын өөрийн үнэлгээг багшийн үнэлгээтэй харьцуулан, зөрүүнд анализ хийх
- Судалгааны үр дүнг боловсруулж, дүгнэлт гаргах

Судалгааны арга зүй: Оюутны өөрийн үнэлгээг сургалтанд үр дүнтэй хэрэгжүүлэх, боломж, арга замыг тодруулах зорилгоор 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн 4 жилийн хугацаанд өөрийн үнэлгээний хувилбарууд боловсруулан ШМК-ийн 1-3-р курсын 400 оюутны хүрээнд туршиж үзлээ. Туршилтын үр дүнд өөрийн үнэлгээгээр оюутны суралцахууд гарсан өөрчлөлтийг тоон болон чанарын үнэлгээгээр харьцуулан үзэж, дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны шинэлэг тал: Өөрийн үнэлгээгээр мэдлэг, чадвар биш суралцахууд хандах хандлагыг тооцож үнэлэх, түүнийг хэрхэн дүгнэх аргачлалыг боловсронгуй болгох практик арга замыг эрэлхийлж, дэвшүүлснээрээ шинэлэг болсон гэж үзэж байна.

Судалгааны үр дүн

Өөрийн үнэлгээ гэдэг нь тухайн хүн өөрийнхөө мэдлэг, чадвар, хийж гүйцэтгэсэн ажил, өөрийн бүтээлч үйл ажиллагааг үнэлэх үйл явц юм. Аливаа хүний өөрийгөө үнэлэх үнэлгээ нь өөртөө тавьж буй шаардлага, нийгэм цаг үеийн байдлыг мэдрэх мэдрэмжээс хамаардаг. /М.Тунгалаг, 2007/ байна. Тухайлбал: хүн нийгмийн хэрэгцээ бодит байдлыг мэдрэхийн хэрээр өөртөө түүнд илүү ойр зохицсон шаардлагыг тавьж, өөрийнхөө үйл ажиллагааг түүнд хэр зохицож байгаагаар нь үнэлэх болно. /С. Батхуяг, 2006/


Өөрийгөө үнэлэх нь хүнд дахин хэрэгцээ бий болгож сонирхлыг төрүүлдэг. Хэрэгцээ сонирхлын дүнд хүн хөгжих боломж нээгддэг. Өөрийн үнэлгээ бодитой, үр дүнтэй байх эсэх нь үнэлгээний зорилго, ач холбогдлыг оюутнууд хэрхэн ойлгож байгаагаас хамаардаг болохыг нийгмийн танин мэдэхүйн онолоор тайлбарласан байдаг. Тодруулбал, тус онолыг үндэслэгчдийн нэг А.Бандура /1986/-гийн үзсэнээр өөрийн үнэлгээний ашиг тус, үр дагаврыг хэрхэн ойлгож төсөөлөх, энэ талаарх итгэл үнэмшил ямар байна вэ гэдгээс шалтгаалан суралцагч өөрийн сурах үйл ажиллагааны амжилт, үр дүнг янз бүрээр /хэт өндөр, бодитой, эсвэл доогуур/ үнэлдэг байна. Нөгөөтэйгүүр эл асуудлыг тухайн суралцагч бие хүн, түүний зан үйл, үнэлгээ хийж буй орчин гэсэн гурвалсан хүчин зүйлсийн харилцан үйлчлэлд нь авч үздэг.

С.Батхуяг /2012/ “Боловсрол нь хүний бие дааж суралцах, ажиллах, амьдрах чадамж, хүмүүншил, ухааны төлөвшлийн түвшин” гэж тодорхойлжээ. Эндээс үзвэл бие хүн хөгжин төлөвших, боловсрох үйл явц, түүний үр дүн нь тухайн хүний өөрийнх нь идэвхтэй үйл ажиллагаа, өөртөө тавих шаардлага, үнэлгээ зэргээс ихээхэн хамааралтайг харуулж байна. Тиймээс сургалтын үнэлгээнд хувиргалт хийх, цаашлаад оюутан төвт сургалтын арга зүйг үр дүнтэй нэвтрүүлэхэд оюутны өөрийн үнэлгээ ихээхэн чухал ач холбогдолтой.

Туршилт 1. Явцын онооны бүрдэлт, гүйцэтгэлийг оюутнуудаар үнэлүүлэх

Өөрийгөө үнэлэх үнэлгээний зааварчилгаа, шалгуур үзүүлэлтийн дагуу оюутнууд өөрийгөө тоон болон чанарын үнэлгээгээр үнэлсэн.

График 1. Оюутнуудын өөрийн болон багшийн үнэлгээний харьцуулалт




Туршилтанд 1-р курсын 41 оюутан хамрагдаж, өөрсдийгөө 0-60 оноогоор, үүнээс ихэнх нь буюу 73% нь 80-аас дээш оноогоор тус тус үнэлжээ. Энэ нь оюутан явцын оноо бүрдүүлэх, өөрийгөө үнэлэх талаар багшийн зааврыг эхнээс нь маш сайн ойлгож, үүрэг хариуцлагаа ихээхэн ухамсарлаж, өөрийн

удирдлагатай суралцахуйд суралцан эхэлж байгаа нь ажиглагдсан. Оюутнуудын тоон үнэлгээг чанарын үнэлгээтэй нь харьцуулан үзвэл, өөрийгөө багшийн үнэлгээнээс доогуур үнэлсэн оюутнуудын хувьд өөртөө итгэх итгэл сулавтар, нөгөөтэйгүүр даалгаврын гүйцэтгэлийн алдаа, шалтгаан зэргээ сайн мэдэж байсан учраас, шударгаар доогуур үнэлэх байдал ажиглагдлаа. Багшийн үнэлгээг оюутнуудын өөрийн үнэлгээтэй харьцуулахад багш оюутнуудаа дээгүүр үнэллээ. Учир нь оюутнууд өөрийн үнэлгээгээр алдаа, сул талаа ойлгож, шударгаар үнэлсэн байдлыг нь үнэлж, үнэлгээг ахиулах боломж олгосон нь дүнд нөлөөлсөн. Үүнээс харахад өөрийгөө шударгаар үнэлж, сурах нь оюутан суралцахуйд суралцах үйлээ өөрөө хөтлөн жолоодох өөрийн удирдлагатай суралцахуйд суралцах, хариуцлагаа ухамсарлаж эхэлж байгаа нь харагдлаа.

Туршилт 2. Бүтээлч даалгавраар өөрийг нь үнэлүүлэх

Оюутнуудын сурахуйд суралцах чадварыг нэмэгдүүлэх, өөрийн удирдлагатай суралцахуйд суралцуулах зорилгоор сонирхол хэрэгцээнд нь тулгуурлан өөрийнх нь сонирхсон сэдвийн хүрээнд бичил судалгаа хийж гүйцэтгэх даалгаврыг 5 долоо хоногийн хугацаатай өгсөн.

Даалгаврын гүйцэтгэлийг багш 7 хоног тутам хянаж, заавар зөвлөмжөөр чиглүүлж явсан. Долоо хоног бүрээр гүйцэтгэлийг хянаснаар оюутнуудыг төлөвлөлтөнд сургах, аливаа ажлыг төлөвлөсөн хугацаандаа чанартай хийж, гүйцэтгэх дадал чадварт сургах зорилготой байсан. Аливаа ажлыг төлөвлөх, цагийн ажлыг цаг хугацаанд нь хийж хэвшээгүй оюутнуудын хувьд хугацаанд нь тулгаж, чанаргүй хийх зэрэг бэрхшээлтэй зүйл ажиглагдсан. Бүтээлч даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээг тоон болон чанарын үнэлгээгээр үнэлж, багшийн болон оюутны өөрийн үнэлгээг харьцуулан үнэлж, дүгнэж үзлээ.



Судалгааны дүгнэлтээс харахад оюутнуудын ихэнх нь буюу 79% нь өөрийгөө 80-аас дээш оноогоор, 21% нь 79-өөс доош оноогоор үнэлсэн нь өөрсдийн сонирхсон сэдэв тулгамдсан асуудлаа судалж, байгаа учраас бүхий л нөөц бололцоог дайчилсан. Нөгөөтэйгүүр 7 хоног бүр багш гүйцэтгэлийг хянаж явснаар, дор бүр нь сайжруулж, үр дүнгээ тооцож байсан нь даалгаврын гүйцэтгэлийн дүнд нөлөөлсөн болов уу. 79-өөс доош үнэлгээгээр өөрийгөө үнэлсэн оюутнуудын хувьд яагаад ингэж үнэлэх болсон тайлбараа чанарын үнэлгээндээ тусгасныг ард хавсаргав.

Багшийн үнэлгээг оюутнуудын өөрийн үнэлгээтэй харьцуулахад оюутан өөрийгөө өндрөөр үнэлэх нийтлэг тал ажиглагдсан. Өөрт өгсөн оноог баталгаажуулахаар нэмэлт тайлбар үндэслэлд дүн шинжилгээ хийж үзэхэд, үнэлгээний шалгуурыг бүрэн гүйцэд ойлгоогүй, өөрийгөө үнэлэх дадлага

туршлага дутмаг байна. Иймээс өөрийн үнэлгээ хийх шалгуурыг тодорхой ойлгомжтой өгөх, дадлага туршлагатай болгох үүднээс явцыг үнэлэхдээ өөрийн үнэлгээг хэрэглэх шаардлагатай байна.

Хүснэгт 1. Оюутны өөрийн болон багшийн үнэлгээ, харьцуулалт

№	Шалгуур	Оюутны өөрийн үнэлгээ	Багшийн үнэлгээ	Үнэлгээний зөрүү
1.	Судалгааны сэдэв сонголт	4,5	4,3	0,2
2.	Төлөвлөлт гаргах	3,8	3,0	0,8
3.	Судалгааны арга сонголт	4,0	3,8	0,2
4.	Судалгааны асуулга боловсруулах чадвар	3,5	3,0	0,5
5.	Мэдээллийн боловсруулалт	4,8	4,5	0,3
6.	Дүгнэлт зөвлөмж бичих чадвар	4,0	3,7	0,3
7.	Ярих,илтгэх чадвар	4,8	5,0	0,2
8.	Цаг хугацаандаа гүйцэтгэх чадвар	3,8	2,3	0,5

Үнэлгээний маягтад тусгасан 8 шалгуурын дагуу 1-5 оноогоор үнэлэхэд оюутнуудын өөрийн үнэлгээний дундаж 3,5-4,8 хооронд хэлбэлзэж байна. Өөрийн үнэлгээг шалгуур тус бүрээр харьцуулж үзвэл мэдээллийн боловсруулалт хийх чадвар /4,8/, ярих илтгэх чадвар /4,8/, судалгааны сэдэв сонголт /4,5/ зэрэгт өндөр оноо өгсөн бол харин судалгааны асуулга боловсруулах чадварыг хамгийн доогуур буюу 3,5 оноогоор үнэлсэн. Судалгааны анкетын арга сонгосон оюутнуудын хувьд асуулга боловсруулах нилээн хэцүү байсан учир бэрхшээлтэй байсан учраас доогуур үнэлгээгээр үнэлсэн байж болох талтай.

Оюутнуудын өөрийн тоон үнэлгээг хэр бодитойг тодруулах зорилгоор чанарын үнэлгээг дараах асуулгаар үнэлж үзлээ.

Хүснэгт 2. Судалгааны даалгавар гүйцэтгэсэнээр та юу сурсан бэ?

Оюутнуудын сурсан зүйл	Хувь	Дүгнэлт тайлбар
Судалгааны аргуудыг хэрэглэж, боловсруулалтын аргад суралцсан	90%	1. Сурсан зүйлээ маш сайн тодорхой гаргаж бичсэн байсан нь илтгэх чадварт суралцаж, мэдээллээ цэгцлэх, аналитик чадварт суралцаж байгааг давхар харж болох юм. 2. Оюутнуудын сурсан зүйлийг хувиар нь харвал /давхардсан тоогоор/ судалгааны аргуудаас суралцаж, эзэмшсэн мэдээллийн боловсруулалт хийх, асуудалд бүтээлчээр хандах багаар хамтран ажиллах чадварт илүү суралцсаныг харж болох юм. 3. Зарим нэг оюутнуудын хувьд сул талаа олж харсан, муу дадал зуршлаа орхисон зэрэг сайн талтай үзүүлэлт харагдаж байна.
Асуулга боловсруулж сурсан	75%	
Хүмүүстэй харилцаа холбоо тогтоож сурсан	93%	
Программууд дээр ажиллаж сурсан	75%	
Гадаад хэл дээр мэдээлэл хайж сурсан	35%	
Чухал бусаас чухлыг ялгаж сурлаа	25%	
Төлөвлөлт хийж, цагийн менежментээс суралцлаа	83%	
Мэдээллийг оновчтой сонгох	78%	
Дүгнэлтийг товч тодорхой гаргах	58%	
Сэдвээ оновчтой жижиглэж сонгох	56%	
PP сонирхолтой байдлаар бэлтгэх	87%	
Багштай ойр дотно байсан	88%	
ЗОРИЛГОТОЙ болсон	35%	
Багаар ажиллах чадвар	96%	
Өөртөө итгэх итгэл нэмэгдсэн	27%	
Мэдээллийн эх сурвалжтай ажиллаж сурлаа	76%	
Бие даан ажиллах чадварт сурлаа	80%	
Хичээл таслахаа больсон, санаагаа чөлөөтэй илэрхийлж сурлаа.	12%	
Аливаа зүйлд бүтээлчээр хандаж сурлаа	87%	
Сул талаа олж харах	15%	

Хүснэгт 3. Судалгаа хийхэд таны давуу болон сул тал юу байсан бэ?

Оюутны давуу тал	Хувь	Сул тал	Хувь
Бүтээлч байдал	73%	Залхуу	37%

Гадаад хэл	26%	Цагийн юмыг цагт нь хийдэггүй	43%
Багштайгаа ойр ажилладаг	58%	Хайнга,шантрамтгай	27%
Сэдвээ зөв сонгосон	75%	Хэнэггүй,удаан	32%
Танил тал,холбоо	35%	Монголоор муу шивдэг	37%
Хурдан шивдэг	53%	Хэлний түвшин дутмаг	72%
Асуулт боловсруулах,найруулах	42%	Тууштай биш,ичимхий	17%
Цаг хугацаа сайн барьдаг	37%	Сэдвээ буруу сонгосон	23%
Хурдан сэргэлэн зан	25%	Олон санаа дундаас оновчтой шийдвэр гаргахдаа муу	38%
Үзэл бодлоо илэрхийлэх	47%		
Дүгнэлт сайн хийж чаддаг	43%		
Эхэлсэн бол дуусгадаг	25%		
Олон мэдээллийг зэрэгцүүлэн боловсруулдаг	37%		

Оюутнууд судалгааны ажил гүйцэтгэхэд, өөрийнхөө давуу талыг олж харж чадаж байгаа нь боломж нөөцөө ашиглахад болон сурах арга барилд суралцаж байгаагийн илрэл юм. Сул талаа харж чадаж байгаа нь аливаад бүтээлчээр хандах,чанартай хийж гүйцэтгэх, сурах арга барил хандлагаа өөрчлөх зэргийг ухаарч ойлгон, сурах үйлээ удирдах, төлөвлөх хянах чадварт суралцаж байгаа илрэл ажиглагдлаа.

Хүснэгт 4.Судалгаа хийхэд таньд ямар бэрхшээл тулгарсан бэ?

Судалгаа хийхэд гарсан бэрхшээл	Хувь	Дүгнэлт,тайлбар
Төлөвлөгөө гаргахад хэцүү байсан	75%	Судалгааны аргыг үзэж судлангаа практикт туршин эхэлж байсан тул судалгааны аргыг оновчтой сонгох,боловсруулах,дүгнэлт зөвлөмж гаргахад нилээн бэршээлтэй байсан нь асуулгын хариултын үр дүнгээс харагдаж байна.
Судалгаа нэгтгэх,ерөнхий дүгнэлт гаргах	78%	
Хүмүүс ярилцлага өгөх дургүй байсан	17%	
Мэдээллээ хураангуйлахад хэцүү байсан	43%	
Монгол хэл дээр мэдээлэл хомс	23%	
Статистик тоо баримт хуучин байсан	27%	

Бэрхшээлийг олж харан, дор бүр нь шийдвэрлэсэнээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, бие даан суралцах чадварт суралцахад нь түлхэц болсон. Өөрийн чанарын үнэлгээ хийснээр оюутан өөрийн сурах үйлийг тольдон харж, өөртөө дүгнэлт хийн дараа хийвэл ингэж сайжруулна хэмээн саналаа бичсэн байсан нь өөрийн удирдлагатай суралцахууд суралцуулах эхлэл болж байна.


Судалгааны ажлын үр өгөөжийг оюутнуудын 87% нь маш сайн гэж үнэлсэн нь нилээн чадваржуулж, өөрийн удирдлагатай суралцахууд чиглүүлсэн үр дүнтэй ажил болсон болов уу.

Оюутнуудын 58% судалгааны ажлын үр өгөөжийг маш сайн гэж үнэлсэн нь бүтээлч даалгавар сурах сонирхол хэрэгцээнд тулгуурласан учир сурах үйлээ идэвхтэй хөтлөн жолоодож, суралцахууд гарч байгаа амжилтын үр дүнг өөрсдийн сурсан зүйл гэсэн санал асуулгад тусгаснаас харж болох юм.

Өөрийн үнэлгээгээр давуу болон сул талаа тодорхойлж, цаашид энэ судалгаагаа сайжруулах саналаа бичсэн нь судалгааны үр өгөөжийн үнэлгээ дүнгээс харагдлаа.

Туршилт 3. Суралцах чадварын судалгаа

График 3. Судалгаа хийх бүтээлч даалгаврын үр өгөөжийг та хэрхэн үнэлж байна вэ?



Бүтээлч даалгавраар оюутнуудыг үнэлэхэд сурах үйлийг төлөвлөх чадвар, түүн дотроо хийх ажлынхаа цар хүрээг нарийвчлан тогтоох, суралцах зорилгод тулгуурлан үйл ажиллагааны ба цаг хугацааны төлөвлөлт хийх чадвар дутагдаж байсан нь оюутны өөрийн үнэлгээ болон багшийн үнэлгээнээс харагдсан. Судалгааны үр дүнд тулгуурлан суралцах чадварын түвшинг илрүүлж, дэмжлэг үзүүлэх

зорилгоор доорх судалгааг авч дүн шинжилгээ хийж үзлээ. Судалгаанд 2-р курсын 100 гаруй оюутан хамрагдсан.

Хүснэгт 5. Нийт ангиудын суралцах чадвар эзэмшилтийн түвшинг нэгтгэсэн нь

Анги	Суралцах үйлийг санаачлах чадвар	Суралцах үйлийг төлөвлөх чадвар	Хэрэгжүүлэх чадвар	Бэрхшэлийг даван туулах чадвар	Хамтран ажиллах чадвар	Дундаж	Чадвар эзэмшилтийн түвшин
2-1	3,7	3,5	3,7	3,6	3,7	3,6	Дундаас дээш
2-2	3,3	3,0	3,2	3,2	3,7	3,2	Дунд
2-3	3,9	3,6	3,7	3,8	4,0	3,8	Дундаас дээш
2-4	3,6	3,6	3,8	3,6	4,8	3,8	Дундаас дээш
Нийт	2,9	2,7	2,8	2,8	3,3	2,8	Дунд

Судалгааны нэгдсэн дүнгээс харвал: 2-3, 2-4 ангийн суралцах чадвар эзэмшилтийн түвшин харьцангуй дундаас дээш түвшин буюу сурах үйлээ өөрөө гүйцэтгэх, өөрийн удирдлагатай суралцах чадвар илэрч байна. 2-2 ангийн хувьд суралцах чадварын төлөвлөлийн түвшин дундаж түвшин илэрсэн нь сурах үйлээ өөрөө удирдан чиглүүлэх чадвар дутмаг, үйлдлийг гүйцэтгэхдээ бусдын дэмжлэг авдаг, багшийн туслалцаа чухал байгааг харж болно.

Ерөнхийд нь дүгнэвэл: суралцах чадвар эзэмшилтийн хамтран ажиллах түвшин харьцангуй өндөр байгаа нь хичээл зохион байгуулалтын хэлбэр багт суурилдаг хамтын суралцахуйг чухалчилж, сургаж байгаатай холбоотой байж болох юм. Дээрх судалгааны үр дүнгээс суралцах үйлийг төлөвлөх чадвар харьцангуй доогуур үнэлгээний дундажтай байгаа нь туршилт 3 буюу бүтээлч даалгаврын гүйцэтгэхдээ судалгааны төлөвлөлт хийх чадвар гэсэн шалгуур нь оюутан болон багшийн үнэлгээний зөрүү ихтэй шалгуурын нэг байсан нь эл чадвар оюутнуудад дутагдаж байгааг харуулж байна. Тиймээс сургалтын үйл ажиллагаанд суралцах үйлийг төлөвлөх чадварыг хөгжүүлэх дасгал даалгарын хувилбарууд боловсруулан үр дүнг тооцон ажиллах, чадвар төлөвлөлийн ахицын түвшинд дүгнэлт хийн суралцахуйг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллана.

Дүгнэлт

Оюутны өөрийн үнэлгээний бодит байдлыг тодруулах зорилгоор багш оюутны үнэлгээг харьцуулсан байдлаар судалж үзэхэд хоорондын зөрүү хол зөрүүгүй гарсан /0,2-0,8 оноо/нь оюутан өөрийн суралцахуйн үйлээ үнэлж дүгнэх чадварт суралцаж байгаа нь туршилтаас харагдаж байна. Оюутан өөрийгөө үнэлэх чадварт суралцсанаар өөрийгөө танин мэдэх, сурах үйлээ удирдан жолоодох, зөв бодитой үнэлж сурах, сурах сэдэл хариуцлагыг нэмэгдүүлэх, сурах үйлээ төлөвлөх зэрэг суралцахуйд гарч буй эерэг өөрчлөлтүүд нь сурлагын амжилтанд нөлөөлж байгааг судалгаа харуулж байна.

Суралцагчдын өөрийн үнэлгээ сурах үйлийг дэмждэг нэг арга тул хооронд нь уралдуулах, өрсөлдүүлэх үнэлгээний аргаас аль болох татгалзах, харин өөрийн суралцахуйн үйлдээ оюун дүгнэлт хийх хэрэгсэл болгон ашиглах нь үр дүнтэй. Суралцагч юуг яаж хийхээ төлөвлөдөг, өөрийн сул тал, алдаагаа засан сайжруулахад анхаарч суралцах боломжтой эерэг хандлагууд илэрч байгаа тул өөрийн үнэлгээ оюутны зөв хандлагыг төлөвшүүлэх ач холбогдолтой.

Суралцагчдын хувийн онцлогоос хамаарч, өөрийгөө хэт өндөр, эсвэл доогуур үнэлэх, өөрийн ахиц дэвшлийг бодитоор үнэлж чадахгүй байх, өөртөө шүүмжлэлтэй хандах хандлага илэрч байлаа. Суралцагчийн өөрийн үнэлгээг нэвтрүүлэх нь багшийн арга зүй шинэчлэгдэх суралцагч төвт, сургалтын арга зүйгээр сургалтаа төлөвлөн зохион байгуулах шаардлага тулгарч байгаа нь багш ажлын байран дээрээ хөгжих үндэс болж байна.

Багш суралцагчийг үнэлдэг нэг талын үнэлгээ байсан бол өөрийн үнэлгээг сургалтад хэрэгжүүлснээр, суралцагч багшийн даалгаврыг хийж багшаас дүн авдаг биш, сурахуйдаа нухацтай хандан, цаашид өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болж, хүүхэд өөрөө ёс суртахууныг эзэмшиж байгаа учир сургалтад өөрийн үнэлгээний арга зүйг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзээд дараах саналыг дэвшүүлж байна.

Үүнд:

1. Сургалтанд суралцагчийн өөрийн үнэлгээг хэрэгжүүлэхдээ өөрийн үнэлгээний шалгуурыг SMART байдлаар боловсруулж, өөрийн үнэлгээний хуудсыг ойлгомжтой боловсруулан өөрийгөө үнэлэх арга зүйд сургах боломжтой.
2. Өөрийн үнэлгээг явцад болон бүлэг сэдвийн дүгнэлт хичээл, бүтээлч даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглавал илүү үр дүнтэй бөгөөд суралцагч сурах үйлээ зөв хөтлөн жолоодох, суралцахуйд нь эерэгээр нөлөөлөх үр дүнтэй.

Ном зүй

Батхуяг.С, Ичинхорлоо.Ш, Энхжаргал.Б, (2006) "Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс" УБ.

Дамдинсүрэн.Б, ба бусад (2001) "ЕБС-ийн менежментийн зарим асуудал." УБ.

Жадамба.Б, Батсуурь.Ц, (2001) "Чанартай боловсрол-Багшийн хөгжил." Сургалт семинарын материал. УБ.

Загдаа А./1987/.Сурагчдад сурах арга эзэмшүүлэх нь. Сурган хүмүүжүүлэгч №5, хуу: 50-54

Загдаа А./1987/.Сурагчдад сурах арга эзэмшүүлэх нь. Сурган хүмүүжүүлэгч №5, хуу:50-54

Ичинхорлоо.Ш. (2003) "Сурах арга" УБ.,

Нитко, Ж.,Брүүкхарт, М (2011). Суралцагчдын эзэмшсэн боловсролыг үнэлэх арга зүй. (орч.) USA.Pearson, УБ.,

Намжилдагва, Р. (2015) Суралцахуй хийгээд сургахуйн онол, загварчлал. УБ.,

Т.Тунгалаг М. (2007) Суралцагчийн өөрийн үнэлгээ. УБ.,

МУБИС (2015) "Боловсролын үнэлгээ олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ.,

“Чухлыг сонгон тайлбарлах” аргаар сурагчдын бүтээлээр унших, бичих, ярих чадварыг хөгжүүлэх нь

СУДЛАГДАХУУН: ТҮҮХ, НИЙГМИЙН УХААН

Г.Бадамханд, Д.Бүжин, Д.Анхбилэг

Дорнод, Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн багш нар

Удиртгал

У В.А.Сухомлинский “Уншлага бол жирийн нэг үндсэн чадвар биш бөгөөд оюуны нарийн төвөгтэй процесс юм. Иймээс хүүхдийг бүтээлчээр сэтгэж, бие даан сурах чадвартай хүн болгохын тулд эхнээс нь зөв аргаар уншуулж сургах нь зүйтэй” гэжээ.

Уншина гэдэг ухаарна гэсэн үг. Тариачин хүн тариа хураахын тулд жилийн өмнөөс үрээ нөөцөлж, газраа бэлтгэж, цаг нь ирэхээр бэлдсэн хөрсөнд суулган арчилж, тордож байж л ургацаа хураан авдагтай адилаар уншаад дуусахдаа биш олон зүйл уншихдаа ч биш гагцхүү өөрт хэрэгтэй чухлыг сонгон тархиндаа суулгаж, ургуулж чаддаг л байх хэрэгтэй.¹⁷

Мэдээлэл нь ой санамжид хэрхэн үлдэж, тогтдогийг “Суралцахуйн пирамид” онол дараах байдлаар тодорхойлсон байдаг.



Хүний нөөц бололцоо, мэдлэг, чадамжийн гуравны нэг нь ил, гуравны хоёр нь далд байдаг юм байна. Далд байгаа тэр чадварыг яаж ил гаргах вэ? Блумын таксономийн сэргээн санах түвшний үйлийг хийлгээд байх нь суралцагчдад гүехэн хэмжээний мэдлэг олгоно гэсэн үг юм. Харин танин мэдэхүйн бүтээх түвшин рүү дөхөх тусмаа гүнзгий мэдлэг олгоно гэсэн үг юм.¹⁸

Уншиж чаддаг байна гэдэг бага хэрэг. Чухамхүү юуг яаж унших, унхсанаа хэрхэн ойлгох вэ гэдэг нь чухал юм.

К.Д.Ушинский

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

Сэдвийг сонгосон үндэслэл

2018-2019 оны хичээлийн жилд БСШУСЯ-аас дэвшүүлсэн зорилго нь “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын талаар дэвшүүлсэн зорилт болон багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөний зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, “*Суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц*” гаргахад оршино гэжээ.¹⁹

“Түүх, нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлснээр VI-XII ангид шинжлэн судлах арга барил буюу асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх, үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, үр дүнг хэлэлцэх, шинэ санаа гаргах чадваруудыг эзэмшинэ” гэж заажээ.²⁰

Хичээлийн санаа:

2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн ээлжит хичээлийн чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгын хүрээнд судлагдахууны багаар хамтран түүхийн хичээлээр хичээлийн судалгааг тасралтгүй зохион байгуулах явцад сурагчдын идэвхтэй оролцоо төдийлөн хангалттай бус, дэмжлэг шаардлагатай байсан. Бид дээрх хугацаанд 80 минутын ээлжит хичээлийн үе шат бүрт оюуны довтолгоо, тулгуур дохио, түүхэн асуулт, асуудал дэвшүүлэн ярилцах, зэрэгцэн тэмдэглэл хөтлөх, мэтгэлцэх аргуудыг хослуулан хэрэглэж судлагдахууны багаар ажиглалт судалгаа, анализ хийн, сурагчдын идэвх, оролцоог үнэлж дүгнэн, үр дүнг тооцон ажилласан.

2017-2018 оны хичээлийн жилд туршин хэрэгжүүлсэн арга зүйдээ хувиргалт хийн түүхэн мэдээллийг уншаад сурагчид өөрсдөө бие даан чухлыг сонгон бичиж, түүнийгээ өөрийн ойлголтоор дэлгэрүүлэн ярих, асуудал дэвшүүлэн ярилцах аргыг судалгаат хичээлээс өдөр тутмын хичээлд туршин хэрэгжүүлснээр сурагчдын бүтээлчээр унших, бичих, ярих чадварыг дэмжиж, сурагчдын идэвх оролцоо нэмэгдэж буйг ажиглалт судалгаагаар илрүүлсэн.

Хичээлийн бэлтгэл судалгаа

Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн Түүх нийгмийн багш Г.Бадамханд, Д.Бүжин, Д.Анхбилэг нар 2015-2016 оны хичээлийн жилээс 2018-2019 оны хичээлийн жил хүртэлх 4 жилийн хугацаанд 7 дугаар ангийн түүхийн “Өгэдэй хаан Монголын их гүрнийг байгуулсан нь”, “Монголын их Юань улсын төр, засаг захиргаа, хүн ам, нийгэм”, 8 дугаар ангийн түүхийн “ Ойрад монголын зэвсэгт бослого”, “Бурхны шашин Монголд өргөн дэлгэрсэн нь”, “Наполеон Бонапарт ба Францын эзэнт гүрэн” 9 дүгээр ангийн түүхийн “Лам нарын эсэргүү бослого”, Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжсэн нь, Монгол улсад ардчилсан хувьсгал эхэлсэн нь сэдвээр 22 удаагийн судалгаат хичээлийг зохион байгуулан ажиллалаа.

Бид судалгаат хичээлийг зохион байгуулах явцад хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн явц, ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнд хөтөлбөр тус бүрийг 3-5 удаа засан сайжруулж ажилласан. Хичээлийн бэлтгэл судалгаанаас хичээлийн үр дүн ихээхэн хамааралтай байдаг. Түүхийн хичээлийн гол цөм нь тухайн хичээл дээр танин мэдэх хичээлийн агуулга буюу түүхэн эх сурвалж, мэдээлэл юм.

¹⁸ Нийгмийн ухааны багшийн хөгжил: Онол практикийн тулгамдсан асуудал. УБ,2012 он.

¹⁹ <http://www.edub.edu.mn/>

²⁰ БСШУЯ.Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Гарын авлага. УБ.,2015 он.

Иймээс бид сурах бичиг, бусад эх сурвалжийг судлан сурагчдын уншиж судлах түүхэн мэдээлэл, эх сурвалжийг боловсруулах үйл ажиллагаагаар хичээлийн бэлтгэл судалгааг эхэлдэг. Хичээлийг заах явцдаа хичээлийн төлөвлөлт, дидактик хэрэглэгдэхүүн болох, үзүүлэн, дүрс бичлэг, газрын зураг, самбар төлөвлөлтийг засан сайжруулж байв.

Судалгаат хичээл

Судалгаат хичээлд ажиглагч болон зөвлөхөөр сургалтын менежер Д.Байгалмаа, С.Цэрэнтогтох, Я.Наранбаяр, Дунд ангийн 28 багш, БСУГ-ийн мэргэжилтэн А.Байгальмаа, аймгийн түүх нийгмийн ухааны 42 багш оролцсон.

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл (мэдлэг бүтээлгэх)

2017 оны 12 дугаар сарын 11 нд заасан судалгаат хичээлийг 9-р ангийн түүхийн “Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжсэн нь” хичээлийн өрнөл буюу мэдлэг бүтээх хэсгийг жишээ болгон авч үзвэл:

Багшийн дэмжлэг	Сурагчийн үйл ажиллагаа	Чадварт суралцаж буй байдал
<p>Алхам 1. Мэдээллийг уншаад чухлыг сонгоорой. 1921 оны 7 сард Монгол улс тусгаар тогтнолоо дахин сэргээж Хэмжээт эрхт хаант засаглалаа тунхагласныг зөвлөлт Орос улс хүлээн зөвшөөрөхгүй байлаа. Энэ нь Бүгд найрамдах засаглалт Монгол улсыг байгуулахыг зорьж төлөвлөж байсантай холбоотой. Богд хаан 1924 оны 5 сард таалал төгсмөгц мөн оны 6 сарын 3, 7 нд МАН-ын төв хороо хоёр удаа хуралдаж Бүгд найрамдах засаглалд шилжихээр шийдвэрлэсэн. Ийнхүү Монгол улс Хэмжээт эрхт хаант засаглалаас Бүгд найрамдах засаглалд шилжих шийдвэр гаргаж большевикуудын даалгаварыг биелүүлэв. Монголын тусгаар тогтнолыг ЗЗОУ, ДИУ хоёр хуйвалдан, цуцлахаар хэлэлцэж буйг Монголын эрх баригчид сайн мэдэж эсэргүүцэж байлаа. Урьд нь 1913 оны 11 сарын 5-нд Хятад, Орос хоёр хуйвалдаж гадаад монголын газар нутаг Хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг мөн хэмээн тохиролцсон нь 10 жил 2 сар 26 хоногийн дараа дахин давтагдсан юм. Монгол улс дэлхийн жишгийг дагаж үндсэн хуульт улс болгох бэлтгэл ажлыг 1921 оны зунаас эхлэж, ерөнхий сайд Д. Бодоо, эрдэмтэн Ж.Цэвээн нар тус бүр төсөл боловсруулсан байна. Гэвч 1922 онд Д.Бодоог улс төрийн хэрэгт буруутгасан тул түүний төсөл хэрэггүй болсон юм. Үүний дараа 1922 оны 5 сарын 19нд шүүх яамны сайд Н. Магсаржав, эрдэмтэн Ж.Цэвээн, түшмэл Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэй комисс байгуулж, “Англи мэт улсын хуулиас товчлон” Үндсэн хуулийн төсөл боловсруулахыг даалгав. Тус комисс Англи, АНУ, Япон, Норвегийн үндсэн хуулиас орчуулж төсөл бэлтгэж байв. Гэтэл большевикууд 1924 оны хавар хуульч Всесвятскийг Монголд ирүүлж комиссийг</p>	<p>Алхам 1 1921 оны 7 сард хаант засаглалаа тунхаглав. БНЗасаглалт Монгол улсыг байгуулах Богд хаан 1924 оны 5 сард таалал төгсөв МАН-ын Төв Хороо БНЗ-д шилжив. ЗЗОУ, ДИУ хоёр хуйвалдав. 1913 оны 11 сарын 5-нд Хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг мөн. Д. Бодоо, эрдэмтэн Ж.Цэвээн нар төсөл боловсруулсан 1922 онд Д.Бодоог буруутгасан.. 1922 оны 5 сарын 19нд шүүх яамны сайд Н.Магсаржав, эрдэмтэн Ж.Цэвээн, түшмэл Бат-Очир комисс Англи, АНУ, Япон, Норвегийн үндсэн хуулиас 1924 оны Всесвятскийг Монголд ЗЗОУ-ын 1918 оны Үндсэн хуулийг хуулбарлав 1924 оны 11 сарын 24-26 нд Үндсэн хууль” батлав. БНМАУ хэмээн шинэчлэв. Улаанбаатар гэж нэрлэв . “Жинхэнэ ард”, жинхэнэ бус ард Хувийн өмчийг хязгаарласан. Дээд эрхийг УИХ барина П.Гэндэнг, ерөнхий сайд Б.Цэрэндоржийг 30 хүн сонгосон, ЗХУ-ын хоёр Гайхамшигт хэрэг боллоо” Анх удаа Үндсэн хуультай болсон.</p>	<p>Чухлыг сонгон тулгуур үгээр илэрхий лэн бичих</p>

<p>шинэчлэж ЗОУ-ын 1918 оны Үндсэн хуулийг орчуулж, хуулбарлаж, шинэ төсөл боловсруулжээ. Уг төслийг 1924 оны 11 сарын 24-26 нд улсын анхдугаар их хурлаар хэлэлцээд “БНМАУ-ын Үндсэн хууль” хэмээн батлав.</p> <p>Монгол улс гэдэг нэрийг БНМАУ хэмээн шинэчлэв. Улсын нийслэлийг Улаанбаатар гэж нэрлэжээ. Үндсэн хуулиар ард түмэн өөрсдөө төрийн эрх барих тогтолцоог бий болгов. Угсаа сурвалжгүй хөрөнгө чинээгүй эгэл хүнийг “жинхэнэ ард” хэмээн нэрлэж тэдний эрх чөлөө үйл ажиллагааг дээдлэх ёстой хэмээв. Харин бусдыг Жинхэнэ бус ард хэмээн ялгаварлаж, аж ахуй эрхлэгчид, урьдын хаад ноёд хутагт хувилгаад, хүрээ хийдийн лам нарын улс төрийн эрхийг хассан юм. Мөн иргэдийн хувийн өмчийг хязгаарлаж, хөрөнгөжиж баяжихыг хориглов.</p> <p>Үндсэн хуулиар улсын дээд эрхийг УИХ барина, УИХ-ын чөлөөт цагт УБХ барина, УБХ нь засгийн газрыг томилно. УБХ-ын тэргүүлэгчдийн даргаар П.Гэндэнг, ерөнхий сайдаар Б.Цэрэндоржийг томилжээ. УБХ-ын гишүүнээр 30 хүн сонгосны дотор ЗХУ-ын харьяат Э.Ринчино, Р.Амагаев хоёр багтав. Анхдугаар их хурлаар Үндсэн хууль баталсаны ач холбогдлыг “бидний Монголд хэдэн зуун оноос үзэгдсэнгүй гайхамшигт хэрэг боллоо” хэмээн дүгнэжээ. Үндсэн хуулиар хаант засаглалыг халж Бүгд найрамдах засаглалд шилжиж анх удаа Үндсэн хуультай болсон нь тэмдэглүүштэй боловч тус хуулиар ард түмнээ жинхэнэ ба жинхэнэ бус, итгэж болох үл болох хэмээн хоёр хуваав.</p>		
<p>Алхам 2</p> <p>Тулгуур үгийг ашиглан түүхэн үйл явдлыг өөрийн ойлголтоор дэлгэрүүлэн яриарай.</p> <ul style="list-style-type: none"> • БНЗ-д шилжив. • Бодоо, Цэвээн нарын төсөл • Жинхэнэ ард, жинхэнэ бус ард 	<p>Алхам 2 /Сурагчдын хариулыг бичлэгээс түүвэрлэв/</p> <ul style="list-style-type: none"> • МАН-ын Төв Хорооны шийдвэрээр БНЗ-д шилжиж Оросын даалгаврыг биелүүлэв. • Анх дэлхийн жишгийн дагаж Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссоор Бодоо, Цэвээн нарын томилсон. • Ядуу, хоосон иргэдэл итгэж болно, тэд бол жинхэнэ ард, лам хуврага, хаад, ноёд, худалдаачин гэрэг хөрөнгө чинээтэй хүмүүсийг жинхэнэ бус хэмээн улс төрийг эрхийг хасаж байсан. 	<p>Тулгуур үгийг ашиглан мэдээллийг өөрийн ойлголтоор тайлбарлах</p>
<p>Алхам 3.</p> <p>Яагаад? асуулт тавьж үзэл бодлыг сонсов.хуаангуй</p> <ol style="list-style-type: none"> 1. МАН-ын Төв Хороо БНЗ-д шилжив. 2. ЗЗУ, ДИУ хоёр хувилдав. 3. 1922 онд Д.Бодоог буруутгасан.. 4. Англи, АНУ, Япон, Норвегийн Үндсэн хуулиас 5. 1924 оны Всесвятский, Монголд . 6. Жинхэнэ ард”, жинхэнэ бус ард 7. Хувийн өмчийг хязгаарласан. 	<p>Алхам 3.</p> <ol style="list-style-type: none"> 1. Богд таалал төгссөн, Орос улс шахсан. 2. Хувааж авах гэж, Хятадын бүрэлдэхүүн гэж, Тусгаар тогнолыг үгүйсгэж 3. Улс төрийн хэрэгт буруутгасан 4. Хөгжингүй улс орон учир, Эрх чөлөөний их хартаг дууриасан 	<p>Үзэл бодлоо илэрхийлэх</p>

8. 30 хүн сонгосон, ЗХУ-ын хоёр 9. Гайхамшигт хэрэг боллоо”	5. Оросууд нөлөөллөө тогтоох, Үндсэн хуулийн комиссын шинэчлэх гэж 6. Хөрөнгө чинээтэ хүмүүсийг хавчсан, Оросыг дууриасан. 7. Баяжихаас, эрх мэдэлтэй болохоос болгоомжилсон. 8. Нөлөөллөө тогтоох, БНЗ-ыг бий болгоход туслах, Өөрсдийн хараа хяналтад байлгах 9. Анх удаа Үндсэн хуультай улс болсон гэх зэргээр хариулж байв.	
--	--	--

Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага

Багш:

- Бүх сурагчийн үзэл бодлыг сонсох боломжтой “Чухлыг сонгон тайлбарлах, асуудал дэвшүүлэн ярилцах” аргыг ашигласан.
- Сурах бичигт буй эх сурвалж, мэдээлэлд боловсруулалт хийж тараах материал хэлбэрээр ашигласан.
- Сурагчдын мэдлэг бүтээх үйл ажиллагааг самбар төлөвлөлтөөр удирдсан.
- Самбарт, дэвтэрт бичих үйлийг зэрэг хийсэн.
- Дэвтрийн хөтлөлт нь мэдлэгийг богино хугацаанд сэргээн санах боломжтой.

Сурагч:

- Мэдээлэл, эх сурвалжийг унших явцдаа өгүүлбэр бүрээс чухлыг сонгон тулгуур үгээр илэрхийлсэн.
- Тулгуур үгийг ашиглан өөрийн ойлголтоор нэмэн дэлгэрүүлж ярьсан.
- “Яагаад “түүхэн асуултад өөрийн үзэл бодлоор хариулсан.
- Сурагчдын дэвтэр хөтлөлт тогтмолжиж, эмх цэгцтэй болсон.

Судалгааны үр дүн:

Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд хийсэн арга зүйн сайжруулалт:

Хичээлийн жил	Сэдэв	Арга зүй	Давуу тал	Сул тал
2015-2016	Өгэдэй хаан Монголын их гүрнийг байгуулсан нь	Багаар ажиллах,	<ul style="list-style-type: none"> • Самбар төлөвлөлтөөр хичээлийг удирдсан • Ажлын хуудсыг хичээлд ашигласан. • Газрын зураг дээр ажилласан. 	<ul style="list-style-type: none"> • Багаас идэвхтэй 2-3 сурагчид оролцож байв. 27.9 хувь нь үзэл бодлоо илэрхийлж идэвхтэй оролцсон.
	Юань улсын засаг захиргаа	Он цагийн хүснэгт Түүхэн асуулт арга	<ul style="list-style-type: none"> • Бүх сурагчид хосоор хамтарч асуулт боловсруулсан. 	<ul style="list-style-type: none"> • Он цагын хүснэгт арга нь түүхэн зарим үйл явдлыг орхигдуулж байв. 29 хувь нь үзэл бодлоо илэрхийлж оролцсон.
2016-2017	Бурхны шашин Монгол өргөн дэлгэрсэн нь	Оюуны зураглал Мэтгэлцэх	<ul style="list-style-type: none"> • Түүхэн үйл явдлыг уншин чухлыг сонгон тулгуур үгээр илэрхийлсэн. • Самбар төлөвлөлтөөр хичээлийг дүгнэсэн 	<ul style="list-style-type: none"> • 39-48 хувь нь үзэл бодлоо илэрхийлж оролцсон.
	Наполеон Бонапарт ба Францын эзэнт гүрэн	Он цагийн хүснэгт Түүхэн асуулт арга Мэтгэлцэх	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл, эх сурвалжид бичлэг ашигласан. • Самбар төлөвлөлтөөр хичээлийг удирдсан. • Газрын зураг дээр ажилласан. 	<ul style="list-style-type: none"> • Он цагын хүснэгт арга нь түүхэн зарим үйл явдлыг орхигдуулж байв. • Мэтгэлцэх шатанд сурагчдын оролцоо 46-52 хувьтай байв.


	Ойрад Монголын бослого тэмцэл	Тулгуур дохио Түүхэн асуулт арга	<ul style="list-style-type: none"> • Алхамт уншлага арга ашигласан. • Яагаад түүхэн асуултаар мэдлэгийг бататгасан. • Самбар, дэвтрийн бичиглэлийг хамт хийсэн. • Хүүхэд бүрийн оролцоог хангасан. 	<ul style="list-style-type: none"> • Сурагчдыг ярих явцад багш мэдээллээс чухлыг өөрөө сонгож, хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэж тулгуур үгээр самбарт байрлуулсан.
2017-2018	Лам нарын эсэргүү бослого	Тулгуур дохио Түүхэн асуулт арга Мэтгэлцэх	<ul style="list-style-type: none"> • Түүхэн мэдээллээс чухлыг сонгон тулгуур үгээр илэрхийлсэн. • Тулгуур үгийг ашиглан өөрийн ойлголтоор дэлгэрүүлэн ярьсан. • Яагаад түүхэн асуултад өөрийн үзэл бодлоор тайлбарласан. • Бүх сурагчдын оролцоог хангасан 	<ul style="list-style-type: none"> • Сэдэлжүүлэх, дүгнэлт шатанд бүтээлч сэтгэлгээний сонирхолтой аргуудыг ашиглах
	Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжсэн нь 2017.12.11			
2018-2019	1990 оны ардчилсан хувьсгал	<ul style="list-style-type: none"> • Чухлыг сонгох • Тайлбарлан ярих 		

Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа:

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Ямар чадварт суралцаж байна вэ?
Эхэнд	<p>-Өмнөх хичээлийг сэргээн сануулах асуулт</p> <p>-Тухайн сэдвийн талаар та нар юу мэдэх вэ?</p> <p>-Юу мэдэхийг хүсч байна вэ?</p> <p>Алхам 1</p> <p>-Түүхэн мэдээллийг уншуулж өгүүлбэр бүрээс чухлыг сонгон тулгуур үгээр илэрхийлэхийг хүснэ.</p>	<p>Асуултад хариулах</p> <p>Сэдвийг хүрээнд мэддэг зүйлээ, мэдэхийг хүсч буй зүйлээ хэлнэ</p>	<p>Асуултад хариулах</p>
Өрнөл хэсэг	<p>-Сурагчдын санааг багш самбарт бичнэ.</p>	<p>-Түүхэн үйл явдлыг уншин өгүүлбэр бүрээс чухлыг сонгон тулгуур үгээр илэрхийлнэ.</p> <p>-Самбарын тэмдэглэлтэй зэрэгцэн дэвтэрт тэмдэглэнэ.</p>	<p>-Мэдээллээс чухлыг сонгох</p> <p>-Тулгуур үгээр илэрхийлэх</p> <p>-Бусдыг сонсох</p> <p>- Зэрэгцэн тэмдэглэл хөтлөх</p>
Бататгал	<p>Алхам 2.</p> <p>Сонгосон чухал санааг өөрийн ойлголтоор дэлгэрүүлэн тайлбарлахыг хүснэ.</p> <p>Алхам 3</p> <p>-Яагаад асуулт тавьж түүхэн үйл явдлыг дүгнэн ярилцана.</p>	<p>- Сонгосон чухал санааг өөрийн ойлголтоор дэлгэрүүлэн ярина.</p> <p>Түүхэн үйл явдлыг учир шалтгааныг дүгнэн ярина</p>	<p>Өөрийн ойлголтоор тайлбарлах</p> <p>Үйл явдалд үнэлэлт дүгнэлт хийх, үзэл бодлоо илэрхийлэх</p>
Дүгнэлт	<p>Алхам 4.</p> <p>- Самбарын тэмдэглэлд тулгуурлаж:</p> <p>-Бид түүхэн үйл явдлаас ямар сургамжийг авсан бэ? гэсэн асуултын дагуу ярилцана..</p> <p>Түүхэн үйл явлыг нотлох болон няцаах хариулт руу шилжих замаар мэтгэлцэх</p>	<p>Өөрийн үзэл бодлоо хариулна.</p> <p>Эх сурвалж, мэдээлэлд тулгуурлан өөрсдийн үзэл болдоо илэрхийлнэ.</p>	<p>Өөрийгөө илэрхийлэх</p>

Хичээлийн хэсэг тус бүрийн шийдлийг хэрэгжүүлсэн байдал:

9-р ангийн түүхийн “Монголд ардчилсан хувьсгал эхэлсэн нь” судалгаат хичээлийг тэмдэглэлд суурилсан судалгаагаар сурагчдын бүтээлч оролцоог дүгнэвэл: /3 удаа засан сайжруулсан хичээл 2018.04.23, 04.26/

Үе шат	Үйл ажиллагаа	Сурагчийн оролцоо						
<p>1-р алхам</p>	<p>Мэдээллийг унших явцдаа чухлыг сонгон тулгуур үгээр илэрхийлээрэй.</p>  <p>1988-1989 онд залуучуудын дунд “Шинэ Үе”, “Орчлон” зэрэг улс төрийн нууц бичлэм клубүүд байгуулагдан нам, тэрний тогтолцоог шүүмжлэн хэлэгдэж хэрэгжүүлж явц нь удаан болжээ. 1989 оны эхээр нийгмийн гэрээг талбайг наашин зуураах хуралд тэрэн үеийн нам төрийн бодлогыг хуралар шүүмжилж, эргэцүүлэн олон ургалын үзэл, хүний эрхийг шаардсан нь улс төрийн “Шинэ Үе” бүлгэмийг үйл ажиллагаа байв. Энэ шаардлагыг харуулж 2 сард нам, засгийн “Угсаа сонинд Хүний эрхийн тэтгэмэл тунхаглалыг нийтэлснээр монголын олон нийт энэ удаагаа хүний эрхийн талаар ойлголцсан юм. 1989 оны 11 сард МХЗ-ийн Төв хорооноос зохион байгуулсан Залуу уран бүтээгчдийн улсын II зөвлөгөөнд болжээ. 1989 оны 12 сарын 9-нд шөнө цаана улс төр-олон нийтийн байгууллага болох Монголын ардчилсан клубоо (МАХК) байгуулав. МАХК-ны анхны Ерөнхий зохицуулагч ахлагч (ЕЗЗ)-ийн гишүүнээр С.Амарсайхан, С.Бат-Уул, Б.Батбаяр, Д.Базаран, С.Зориг, Л.Нямсүрэн, Д.Нанжид, Д.Сосорбаран, Дарь, Сүхбаатар, Ц.Элбэгдорж, В.Энхболд, Б.Энхтүвшин, Д.Энхбаатар, Г.Бадмаев, Ч.Энхээ нарны 15 хүнийг сонгосон байна. 12 сарын 17-ны цуглааны дараа болсон ЕЗЗ-ийн хуралар С.Зоригийг ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагчаар сонгов. Тухайн үеийн нам төрийн удирдлагууд МАХК-г БНМАУ-ын Ичдсан хуулиар эвчээрхсэн олон нийтийн байгууллага бий гэж болж. Базарын “Бүү мэт маргаал авчирч гэдэг гэр бичиг болон зарим хуульчийн нийгмийн тухай шүүмж гаргас гэр дамжин тарх байв. 1988 оны 12 сард МАХК-ын Төв хорооны V бүгд хурал хуралдаж нийгмээ шинэчлэх, нийгэм байгуулахыг энэ аргын ажилд шууд хуралдан оролцоогийг багасгах, ил тоо байдлыг хэргүүлэх зэрэг шүүмжлэлт өргүүлсэн боловч амьдралд</p> <p>Зориг А.Т. С.Зориг (1962-1998 он) “Би мөнхөт ирэх саяагт унахайр амьдрах”</p> <p>-Самбарын тэмдэглэлтэй зэрэгцэн дэвтэрт бичихийг сануулна.</p>	<p>4 сарын 2д Монголд ардчилсан хувьсгал эхэлсэн нь.</p> <ul style="list-style-type: none"> - 1988-1989 - Шинэ үе, Орчлон клуб байгуулагдсан - Базарын гэр бичиг тархсан - 1988-12 сард МАХК-г 8 хурал нийгмийн шүүмж - нийгэм - 1989 онд уулуурч наал болов - Шинэ үе хүний эрхийн шаардлага - “Монгол ХЭТГ-г эхэллээ” - Мөнхүүд ХЭТГ-г мэдсэн - 1989-11 сард зохиогдсон - 1989-12-9 - МАХК - МАХК - 15 гишүүнтэй. - 12-17 нд С.Зориг дарга болов. - Төрийн удирдлагагч зөвлөсгөөрөө - Уулуурч болов - МАХК зөвлөл өрн дараа байгуулагдсан - АСХ, МАХК байгуулагдсан - Д.Базаран, С.Зориг, Д.Нанжид 						
<p>2-р алхам</p>	<p>Тулгуур үгийг ашиглан өөрийн ойлголтоор тайлбарлан ярина уу. Тухайлбал: -1988-1989 онд Шинэ үе, Орчлон клуб байгуулагдав.</p>	<p>Хувилбар 1 -1988-1989 онд Монголын залуучууд оройлон нийгмийг өөрчлөх зорилгоор Орчлон, Шинэ үе зэрэг улс төрийн нууц бүлгэмүүд байгуулагдсан. Хувилбар 2 -1988-1989 онд Орчлон, Шинэ үе гэх мэт нууц клубүүд байгуулагдсан тэдний зорилго нь Орос улсын дуурайж нийгмийн өөрчлөх гэсэн. гэх мэтээр өөрийн ойлголтоор тайлбарлаж байв.</p>						
<p>Өөрийн ойлгосноор сурах бичиг ашиглахгүйгээр дэлгэрүүлэн яриу. Энэ үе шатанд 19-24 сурагч өөрийн ойлголтоор баяжуулан ярьсан.</p>								
<p>3-р алхам</p>	<p>Тулгуур үгэнд Яагаад? Түүхэн асуулт тавьж сурагчдын үзэл бодлыг сонсох</p>	<p>МАХК-ын ТХ-ны 5 дугаар хурлаар нийгмийг яагаад шүүмжилсэн бэ? Нийгмээ шинэчлэх Намын дээд эрх мэдлийг багасгах Төрийн ил тод байдлыг бий болгох Үнэн сонинд ХЭТГ-ыг яагаад хэвлэв? Хүмүүст хүний эрхийн талаар ойлголт өгөх Бусад улс орнуудын адил эрх чөлөөг эдлэх Үг хэлэх эрхтэй байх гэх мэт</p>						
<p>Энэ үе шатанд 94 хувь нь оролцсон.</p>								
<p>4-р алхам</p>	<p>Ардчилсан хувьсгал яагаад гарах болов? Дотоод, гадаад хүчин зүйл юу вэ?</p>	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="797 1694 1128 1726">Дотоод</th> <th data-bbox="1133 1694 1476 1726">Гадаад</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="797 1732 1128 1837"> Нийгмээ шинэчлэх Ил тод байдлыг бий болгох Нам, төрийг эрх мэдлийг хязгаарлах Дотроо хагаралдсан Ард иргэд бухимдсан </td> <td data-bbox="1133 1732 1476 1837"> Оросын нөлөө Социализм мухардсан Эдийн засаг хүндэрсэн </td> </tr> <tr> <td data-bbox="797 1843 1128 1894"> Дотроо хагаралдсан Ард иргэд бухимдсан </td> <td data-bbox="1133 1843 1476 1894"> Эрх чөлөөг хүссэн Бусад улс орныг дууриасан </td> </tr> </tbody> </table>	Дотоод	Гадаад	Нийгмээ шинэчлэх Ил тод байдлыг бий болгох Нам, төрийг эрх мэдлийг хязгаарлах Дотроо хагаралдсан Ард иргэд бухимдсан	Оросын нөлөө Социализм мухардсан Эдийн засаг хүндэрсэн	Дотроо хагаралдсан Ард иргэд бухимдсан	Эрх чөлөөг хүссэн Бусад улс орныг дууриасан
Дотоод	Гадаад							
Нийгмээ шинэчлэх Ил тод байдлыг бий болгох Нам, төрийг эрх мэдлийг хязгаарлах Дотроо хагаралдсан Ард иргэд бухимдсан	Оросын нөлөө Социализм мухардсан Эдийн засаг хүндэрсэн							
Дотроо хагаралдсан Ард иргэд бухимдсан	Эрх чөлөөг хүссэн Бусад улс орныг дууриасан							

Дүгнэлт:

Яагаад сайн хичээл болсон бэ?

- Хичээлд ажиглалт хийсэн багш нарын тэмдэглэл, хэлэлцүүлгийн явц, хичээл заасан багшийн ажиглалтын тэмдэглэлээс харахад сурагчдын идэвх, оролцоонд тоон болон чанарын ахиц гарсан. /Хавсралт3/
- Шинэ мэдлэг олгох шатанд чухлыг сонгон тайлбарлах аргыг хичээлд ашигласнаар сурагчдын бүтээлчээр унших, бичих, ярих чадварт ахиц гарсан.
- Бататгал шатанд ашиглаж буй “Асуудал дэвшүүлэн ярилцах” арга нь сурагчдын эргэцүүлэн бодох, үзэл бодлоо илэрхийлэх чадварыг дэмжсэн.
- Бататгал, дүгнэлт хэсэгт бүх сурагч үзэл бодлоо илэрхийлсэн.
- Хичээлийг самбар төлөвлөлтөөр удирдсан.
- Дэвтэрт тулгуур үгээр эмх цэгцтэй тэмдэглэсэн нь мэдээллийг эргэн санах ач холбогдолтой болсон.

Бусдад хүргэх туршлага

- Ээлжит хичээлд “Чухлыг сонгон тайлбарлах”, “Асуудал дэвшүүлэн тайлбарлах” аргыг ашгласан нь бүтээлчээр унших, бичих, ярих чадварыг хөгжүүлэх давуу талтай.
- Түүхэн эх сурвалж, мэдээллийг сурагчдаар хэсэгчлэн уншуулж, даалгавар гүйцэтгүүлэх нь сонирхлыг бууруулахгүй, идэвхтэй оролцуулах үр дүнтэй.
- Хичээлийн судалгааны явцад сурагчдад гарах өөрчлөлт, үр дүнг тооцон дараагийн хичээлийн төлөвлөлтөд тусган ажиллах
- Хичээлийн явцад сурагчдын эзэмшсэн мэдлэгийг самбарт тусган хичээлийн төгсгөлд сурагчдын мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх
- Ээлжит хичээлд тогтмол ашигласан арга зүй, туршлагаа гарын авлага, зөвлөмж болгон түгээн дэлгэрүүлэх /Хавсралт4/
- Түүхийн хичээлийн загвар болохуйц хөтөлбөрөөр өдөр тутмын хичээлээ төлөвлөх





Бусад

Хавсралт материалыг хавсаргав.

Ном зүй:

1. БСШУЯ. Багшийн ном түүх VII . УБ., 2015 он. Хуудас 7.[1]
2. БСШУЯ.Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Гарын авлага. УБ.,2015 он.
3. Нийгмийн ухааны багшийн хөгжил: Онол практикийн тулгамдсан асуудал. УБ,2012 он.
4. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын материал. УБ.2017 он
5. БШУ-ны сайдын 2013 оны 155 дугаар тушаал., “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого”
6. “Эх түүхийн сургалт, боловсролын уламжлал, шинэчлэлийн асуудлууд”УБ.,2012 он.
7. “Хүүхэд хөгжил хичээлийн судалгаа”эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын өгүүллүүд УБ., 2014 он.
8. Math SlidShare <https://www.slideshare.net/batkhuu/math>

Самбарын бичилт, сурагчдын дэвтэр хөтлөлт:



Сургууль, бүс, аймаг, улсад түгээн дэлгэрүүлсэн хичээлийн самбар төлөвлөлтөөс.




Монголын их Юань улсын төр,
засаг захиргаа, хүн ам, нийгэм



Бурхны шашин монголд өргөн дэлгэрсэн нь




- Наполеон Бонапарт ба Францын эзэнт гүрэн





- Ойрад Монголын бослого тэмцэл

**2015-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН ТҮҮХИЙН
СУДАЛГААТ ХИЧЭЭЛД СУРАГЧДЫН БҮТЭЭЛЧЭЭР ЯРИХ ЧАДВАРЫГ ХУВИАР
ИЛЭРХИЙЛВЭЛ**



2017-2018 оны хичээлийн жилд Дорнод аймгийн түүх нийгмийн ухааны 48 багшид өөрсдийн арга зүйгээ боршруу хэлбэрээр бэлтгэн түгээн дэлгэрүүлсэн.

<p>Чухлыг сонгон тайлбарлах аргаар "Түүх"-ийн хичээлийг зохион байгуулахад:</p> <ul style="list-style-type: none"> Сурагчид Эх сурвалж, мэдээллийг бүтээлчээр уншдаг. Дэс дараалалтай тэмдэглэж, дэвтэрийн тэмдэглэлээ ашигладаг. Мэдлэг ойлголтоо богино хугацаанд сэргээн санадаг. Сурагч бүр үзэл бодлоо амаар болон бичгээр оновчтой илэрхийлж сурсан. Мэдээлэл задлан шинжлэх, сэтгэн бодох чадварыг хөгжүүлж байна. Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандан сонсож сурсан. 	<p>Зөвлөмж:</p> <p>Багш түүхэн мэдээлэл, эх сурвалжийг сурагчдад уншуулахаас өмнө сайтар бэлтгэх шаардлагатай.</p> <p>Чухлыг сонгон тайлбарлах аргыг мэдээлэл цуглуулах, задлан шинжлэх, үр дүнг хэлэлцэх үе шатуудад хэрэглэх нь илүү тохиромжтой.</p> <p align="center">Утас: 95188086</p>	<p align="center">ТҮҮХ, НИЙГМИЙН УХААНЫ СУДЛАГДАХУУНЫ БАГ</p> <p align="center">ЧУХЛЫГ СОНГОН ТАЙЛБАРЛАХ АРГА</p>  <p align="right">2018 ОН</p>
---	---	---

ЧУХЛЫГ СОНГОН ТАЙЛБАРЛАХ АРГА

<p>Чухлыг сонгон тайлбарлах арга нь сурагчид мэдээлэл, эх сурвалжийг бүтээлчээр унших, мэдээллээс чухлыг сонгон авч, түүнийгээ дэлгэрүүлэн ярих зэргээр бодож, сэтгэх хэрэгцээ үүсгэж, хүүхэд бүрийг татан оролцуулдаг. Мөн үзэл бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх боломж олгодог ороо хичээлийн үр дүнг, өгөөжийг нэмэгдүүлдэг давуу талтай.</p>	<p>Алхамчлал</p> <p>I. Мэдээлэл цуглуулах, задлан шинжлэх үе шат:</p> <p>Сурагчид мэдээлэл, эх сурвалжийг бүтээлчээр уншин өгүүлбэр бүрээс чухлыг сонгож тулгуур үгээр дэвтэрт тэмдэглэнэ.</p> <p>Тэмдэглэсэн хариултаа анги нийтэд танилцуулахад багш сурагчдын хариулыг самбарт, сурагчид дэвтэрт зэрэгцэн тэмдэглэнэ.</p>	<p>II. Мэдээлэл боловсруулах үе шат:</p> <p>Сурагчид самбарын бичиглэл ашиглан сонгосон чухал санааг өөрийн ойлголтоор дэлгэрүүлэн ярина.</p> <p>III. Үр дүнг хэлэлцэх, шинэ санаа гаргах үе шат:</p> <p>Тулгуур үгэнд "Яагаад?" асуулт тавьж асуудал дэвшүүлэн ярилцан</p>
---	--	---

Ээлжит хичээлийн төлөвлөгөө

Ээлжит хичээлийн сэдэв: Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжсэн нь

Зорилго: Монгол улс Бүгд найрамдах засаглалд хэрхэн шилжсэн талаар танин мэдэж, чухлыг сонгон тайлбарлан ярих, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадварт суралцана.

Арга зүй: Чухлыг сонгон тайлбарлах арга, Асуудал дэвшүүлэн ярилцах арга

Хугацаа: 80 минут

Үе шат	Чадвар	Багшийн дэмжлэг	Суралцах үйл	Хэрэглэг -дэхүүн
Асуулт тавих / 6 минут /	Асуултад хариулах	-Бичлэг үзүүлж бичлэгт юуны талаар гарч байгааг асууна. - Бид өнөөдөр” Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжсэн нт” талаар судална хэмээн сэдвийг самбарт бичнэ.	- Бичлэгийг анхааралтай үзнэ. - Асуултын дагуу харилцан ярилцана.	Бичлэг
Мэдээлэл цуглуулж, задлан шинжлэх /28 минут/	Мэдээллийг бүтээлчээр унших	Алхам 1. Мэдээллийг уншаад өгүүлбэр бүрээс чухлыг сонгон тулгуур үгээр дэвтэртэй тэмдэглээрэй. 1921 оны 7 сард Монгол улс тусгаар тогтнолоо дахин сэргээж Хэмжээт эрхт хаант засаглалаа тунхагласныг зөвлөлт Орос улс хүлээн зөвшөөрөхгүй байлаа. Энэ нь Бүгд найрамдах засаглалт Монгол улсыг байгуулахыг зорьж төлөвлөж байсантай холбоотой. Богд хаан 1924 оны 5 сард таалал төгсгөмгц мөн оны 6 сарын 3, 7 нд МАН-ын төв хороо хоёр удаа хуралдаж Бүгд найрамдах засаглалд шилжихээр шийдвэрлэсэн. Ийнхүү Монгол улс Хэмжээт эрхт хаант засаглалаас Бүгд найрамдах засаглалд шилжих шийдвэр гаргаж большевикуудын даалгаварыг биелүүлэв. Монголын тусгаар тогтнолыг ЗЗОУ, ДИУ хоёр хуйвалдан, цуцлахаар хэлэлцэж буйг Монголын эрх баригчид сайн мэдэж эсэргүүцэж байлаа. Урьд нь 1913 оны 11 сарын 5-нд Хятад, Орос хоёр хуйвалдаж гадаад монголын газар нутаг Хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг мөн хэмээн тохиролцсон нь 10 жил 2 сар 26 хоногийн дараа дахин давтагдсан юм. Монгол улс дэлхийн жишгийг дагаж үндсэн хуульт улс болгох бэлтгэл ажлыг 1921 оны зунаас эхлэж, ерөнхий сайд Д. Бодоо, эрдэмтэн Ж.Цэвээн нар тус бүр төсөл боловсруулсан байна. Гэвч 1922 онд Д.Бодоог улс төрийн хэрэгт буруутгасан тул түүний төсөл хэрэггүй болсон юм. Үүний дараа 1922 оны 5 сарын 19нд шүүх яамны сайд Н. Магсаржав, эрдэмтэн Ж.Цэвээн, түшмэл Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэй комисс байгуулж, “Англи мэт улсын хуулиас товчлон” Үндсэн хуулийн төсөл боловсруулахыг даалгав. Тус комисс Англи, АНУ, Япон, Норвегийн үндсэн хуулиас орчуулж төсөл бэлтгэж байв. Гэтэл большевикууд 1924 оны хавар хуульч Всесвятскийг Монголд ирүүлж комиссийг шинэчлэж ЗОУ-ын 1918 оны Үндсэн хуулийг орчуулж, хуулбарлаж, шинэ төсөл боловсруулжээ. Уг төслийг 1924 оны 11	Алхам 1 Сурагчдын боломжит хариултууд: 1921.7 сар.Хаант засаглалаа тунхаглав. БНЗасаглалт Монгол улс Богд хаан таалал төгсөв МАН-ын Төв Хороо БНЗ-д шилжив. ЗЗОУ, ДИУ хоёр хуйвалдав. 1913.11.5. Хятадын нэг хэсэг Д.Бодоо, Ж.Цэвээн төсөл боловсруулсан 1922 он.Д.Бодоог буруутгасан.. 1922 оны 5 сарын 19нд шинээр комисс Англи, АНУ, Япон, Норвегийн Үндсэн хуулиас 1924 оны Всесвятскийг Монголд ЗОУ-ын Үндсэн хуулийг хуулбарлав 1924.11. 24-26 нд Үндсэн хууль” батлав. БНМАУ хэмээн шинэчлэв. Улаанбаатар гэж нэрлэв . “Жинхэнэ ард”, жинхэнэ бус ард Хувийн өмчийг хязгаарласан. Дээд эрхийг УИХ барина П.Гэндэнг, ерөнхий сайд Б.Цэрэндорж 30 хүн сонгосон, ЗХУ-ын хоёр Гайхамшигт хэрэг боллоо” Анх удаа Үндсэн хуультай болсон.	Мэдээлэл

<p>Мэдээлэл цуглуулж, задлан шинжлэх</p>	<p>Чухлыг сонгон тулгуур үгээр илэрхийлэн бичих</p>	<p>сарын 24-26 нд улсын анхдугаар их хурлаар хэлэлцээд “БНМАУ-ын Үндсэн хууль” хэмээн батлав.</p> <p>Монгол улс гэдэг нэрийг БНМАУ хэмээн шинэчлэв. Улсын нийслэлийг Улаанбаатар гэж нэрлэжээ. Үндсэн хуулиар ард түмэн өөрсдөө төрийн эрх барих тогтолцоог бий болгов. Угсаа сурвалжгүй хөрөнгө чинээгүй эгэл хүнийг “жинхэнэ ард” хэмээн нэрлэж тэдний эрх чөлөө үйл ажиллагааг дээдлэх ёстой хэмээв. Харин бусдыг Жинхэнэ бус ард хэмээн ялгаварлаж, аж ахуй эрхлэгчид, урьдын хаад ноёд хутагт хувилгаад, хүрээ хийдийн лам нарын улс төрийн эрхийг хассан юм. Мөн иргэдийн хувийн өмчийг хязгаарлаж, хөрөнгөжиж баяжихыг хориглов.</p> <p>Үндсэн хуулиар улсын дээд эрхийг УИХ барина, УИХ-ын чөлөөт цагт УБХ барина, УБХ нь засгийн газрыг томилно. УБХ-ын тэргүүлэгчдийн даргаар П.Гэндэнг, ерөнхий сайдаар Б.Цэрэндоржийг томилжээ. УБХ-ын гишүүнээр 30 хүн сонгосны дотор ЗХУ-ын харьяат Э.Ринчино, Р.Амагаев хоёр багтав. Анхдугаар их хурлаар Үндсэн хууль баталсаны ач холбогдлыг “бидний Монголд хэдэн зуун оноос үзэгдсэнгүй гайхамшигт хэрэг боллоо” хэмээн дүгнэжээ. Үндсэн хуулиар хаант засаглалыг халж Бүгд найрамдах засаглалд шилжиж анх удаа Үндсэн хуультай болсон нь тэмдэглүүштэй боловч тус хуулиар ард түмнээ жинхэнэ ба жинхэнэ бус, итгэж болох үл болох хэмээн хоёр хуваав.</p> <ul style="list-style-type: none"> - Сонгосон тулгуур үгээ анги нийтэд танилцуулахыг хүсэж сурагчдын санааг тулгуур үгээр самбарт тэмдэглэнэ. - Танилцуулж байгаа сурагчдын санаатай санал нэг бол дэвтэрт тэмдэглэл хөглөхийг сануулна. 	<p>Сурагчид өөрсдын сонгосон санаагаа бусад сурагчдад танилцуулан дэвтэрт тэмдэглэнэ.</p>	<p>Самбар, шохой</p>
<p>Мэдээлэл боловсруулах - лах /25минут/</p>	<p>Тулгуур үгийг ашиглан мэдээллийг өөрийн ойлголтоор тайлбарлан ярих</p>	<p>Алхам 2 Тулгуур үгийг ашиглан түүхэн үйл явдлыг өөрийн ойлголтоор дэлгэрүүлэн яриарай.</p> <ul style="list-style-type: none"> ✚ БНЗ-д шилжив. ✚ Бодоо, Цэвээн нарын төсөл ✚ Жинхэнэ ард, жинхэнэ бус ард 	<p>Алхам 2. Сурагчдын боломжит хариултууд:</p> <ul style="list-style-type: none"> ✚ МАН-ын Төв Хорооны шийдвэрээр БНЗ-д шилжиж Оосын даалгаврыг бичлүүлэв. ✚ Анх дэлхийн жишгийн дагаж ҮХ”ийн төсөл боловсруулах комиссоор Бодоо, Цэвээн нарын томилсон. ✚ Ядуу, хоосон иргэдэл итгэж болно, тэд бол жинхэнэ ард, лам хуврага, хаад, ноёд, худалдаачин гэрэг хөрөнгө чинээтэй хүмүүсийг жинхэнэ бус хэмээн улс төрийг эрхийг хасаж байсан. 	


<p>Үр дүнг хэлэлцэх /20 минут/</p>	<p>Үзэл бодлоо илэрхийлэх</p>	<p>Алхам 3. Самбарт буй тулгуур үгэнд Яагаад? асуулт тавьж асуудал дэвшүүлэн ярилцана. 1. МАН-ын Төв Хороо БНЗ-д шилжив. 2. ЗЗОУ, ДИУ хоёр хуйвалдав. 3. 1922 онд Д.Бодоог буруутгасан.. 4. Англи, АНУ, Япон, Норвегийн Үндсэн хуулиас 5. 1924 оны Всесвятский, Монголд . 6. “Жинхэнэ ард”, жинхэнэ бус ард 7. Хувийн өмчийг хязгаарласан. 8. 30 хүн сонгосон, ЗХУ-ын хоёр 9. “Гайхамшигт хэрэг боллоо”</p>	<p>Алхам 3. Сурагчдын боломжит хариултууд: 1. Богд таалал төгссөн, Орос улс шахсан. 2. Хувааж авах гэж, Хятадын бүрэлдэхүүн гэж, тусгаар тогнолыг үгүйсгэж 3. Улс төрийн хэрэгт буруутгасан 4. Хөгжингүй улс орон учир, Эрх чөлөөний их хартаг дууриасан 5. Оросууд нөлөөллөө тогтоох, Үндсэн хуулийн комиссын шинэчлэх гэж 6. Хөрөнгө чинээтэ хүмүүсийг хавчсан, Оросыг дууриасан 7. Баяжихаас сэргийлсэн, эрх мэдэлтэй болохоос болгоомжилсон. 8. Нөлөөллөө тогтоох, БНЗ-ыг бий болгоход туслах, өөрсдийн хараа хяналтад байлгах 9. Анх удаа ҮХуультай улс болсон.</p>	
<p>Гэрийн даалгавар</p>		<p>Дэвтэрт бичсэн тулгуур үгийг ашиглан эсээ бичээрэй.</p>		



“Хичээл төлөвлөлт хүүхдийн хөгжилд үйлийн судалгаа нөлөөлөх нь

Судлагдахуун: Түүх, нийгмийн ухаан

*Л.Эрдэнэчимэг
Ховд аймаг, Дуут сумын ЕБС-ийн багш*



[Document title]

[Document subtitle]

Abstract

[Draw your reader in with an engaging abstract. It is typically a short summary of the document.]


When you're ready to add your content, just click here and start typing.]

Иймээс үйлийн судалгаа хүүхдийн хөгжилтэй ямар их хамааралтай болох талаар Данийн Профессор Ж.Балтзерсен “Судалгаа гэдэг нь үндсэндээ шинэ мэдлэг бүтээх үйл явц юм.” гэж хэлсэн бол манай улсын судлаачид “Судалгаа гэдэг нь мэдлэг бүтээх үйл явцыг хэлэх бөгөөд мэдлэгийг бусадтай хуваалцан түгээн дэлгэрүүлдэг” гэж хэлсэн нь судалгааны ач холбогдлыг тодорхойлсон тодорхойлолт юм. Мөн үүний зэрэгцээ судалгаа нь багшийн хөгжлийн нэг үндэс сургалтын чанарыг сайжруулах нэг арга хүүхдэд хөгжүүлэх хөгжлийн нэг чиглэл болохыг ч судлаачид харуулсан. Тэгвэл үйл гэдэг юу ямар болох талаар тодруулья.

Ж.Балтзерсен:

“Үйл гэдэг нь танхимын сургалтын маш тодорхой төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэлж байгаа юм.” Үйлийн явцад системтэй судалсан үйлээс тодорхой үр дүн гардаг. Үйлийн судалгаа нь асуудлыг тодруулах, үйлийг төлөвлөх, үйлд ажиглалт хийх, эргэцүүлэн хянах буюу үйлийг шинээр төлөвлөх гэсэн үе шатаар өөрийгөө хөгжүүлэх үйл явцаас бүрддэг.

Асуудлыг тодруулах “Асуудлаа маш оновчтой тодорхойлох нь судалгааны цаашдын үр дүнд маш их ач холбогдолтой”



• Үйлийн төлөвлөлт /тодорхой асуудлаар шийдвэрлэх үйлээ төлөвлөн жагсаах/

• Үйл /шинэ арга зам, чиг, хандлага, сонгосон асуудлаа турших/

• Үйлийг ажиглах /үйлийн явцад тэмдэглэл хөтлөж, ажиглах/

• Эргэцүүлэх /ажиглалтандаа шинжилгээ хийж эргэцүүлэх/

• Үзэл баримтжуулах / шинэ санаагаа онолжуулах, үзэл баримтжуулах/

• Шинэ үйл / сайжруулсан шинэ үйл/

Үйлийн судалгааны зорилго нь:

1. Өдөр тутмын үйл ажиллагаа амьдралд тус болох практик мэдлэг бүтээх

2. Практик мэдлэгийн үндсэн дээр хүүхдийн хүчин зүйлийн хөгжлийг сайжруулж, багш хөгжих

3. Мэдлэг бүтээх шинэ чадвар, шинэ аргад сурах. Үүнээс үзвэл практик амьдралаас мэдлэг бүтээж, өөрийгөө хөгжүүлэх, шинэ чадвар эзэмших гэвэл үйлийн судалгаанд багш бүр суралцах хэрэгтэй. Энэ нь тулгамдсан асуудал болж байна. Үйлийн судалгаа нь багшийн ажил үйл дээр түшиглэдэгийн хувьд багшийн эрэл хайлт, бүтээлч эргэцүүллийг хөгжүүлдэг онцлогтой. Үйлийн судалгаа нь ажиглалт хийж, сурган хүмүүжүүлэх, тэмдэглэл, өдрийн тэмдэглэл, бүтээлийн сан, ярилцлага гэх мэт баримт мэдээллийг цуглуулан шинэ санааг гаргадагаараа багшийг хөгжүүлэх болон сурагчдыг хөгжүүлэх нэг үндэс болж өгдөг. Үйлийн судалгаа нь хичээл дээрх үйлийг судалдаг болохоор хичээлийн судалгаатай адилган үзэж болох талтай учир нь үйлээ зөв төлөвлөөд сурсан багш хичээлийн судалгааг маш сайн хийдэг. Эцэст нь хэлэхэд хичээл төлөвлөлт гэдэг нь үндсэндээ үйлийг төлөвлөнө гэсэн үг. Өнөө үед хүүхдийг хөгжүүлэх багш үйлээ зөв оновчтой төлөвлөх нь практик хэрэгцээнд сургахад хүүхэд нэг бүрийг судлахад үйлийн судалгаа чухал ач холбогдолтой гэдгийг өөрсдийн хийсэн судалгаандаа түшиглэн дүгнэлт өгөхийг зорилоо.

Судалгаа 1

Хичээл төлөвлөлтөнд анхаарах асуудлуудыг үйлийн судалгааг ашиглан ээлжит хичээлийн төлөвлөлтөнд дээр задлан авч үзвэл

Зорилго: Хичээл төлөвлөлтөнд Сэдэлжүүлэх ба хосоор ажиллах үйлийг хэрхэн явагддаг болохыг ажиглахыг зэрэгцээ дараагийн хичээлд ямар үйлийг нэмж судлах боломжтойг илрүүлэх

-Хичээл төлөвлөлтөнд багш хүний анхаарах нэн тэргүүний асуудлын нэг бол хүүхэд нэг бүрийг сайн судлах явдал юм.

Мөн ээлжит хичээлийн зорилго, зорилт нь үнэлж болохуйц үйлийн алхмаар хийгдвэл илүү үр дүнтэй байдаг. Хичээлийг төлөвлөхдөө ээлжит хичээлийн тодорхой үйл ажиллагааг нарийн төлөвлөн эхний

шат болох сэдэлжүүлэх үйлийг ажигласан ба хичээлийн явцад хосоороо ажиллах үйлийн сонгон ажиглалаа

-Ээлжит хичээлд үйлийн төлөвлөлтийг хэрхэн хийх талаар авч үзье

Сэдэв: ” Ажилгүйдэл” 11-р анги

Зорилго: Ажилгүйдэл,ажилгүйдлийн хэлбэр,шалтгаан, ажилгүйдлийг бууруулах арга замын тухай мэдлэг бүтээх

Зорилт:- Ажилгүйдэл, түүний хэлбэр, шалтгааныг хамтын шийдлээр гарган тодорхойлж ажилгүйдлийг бууруулах талаар санал дэвшүүлэх

-Бүлгээрээ ажиллаж хэлэлцүүлэгт оролцох явцдаа бусдын саналыг сонсож өөрийн үзэл бодлоо бусадтай хуваалцах

-Хүн сайн сайхан амьдрахын тулд хөдөлмөрлөх ёстой гэдгийг ухамсарлуулах

-Ажилгүйдлээс гарах арга замыг судлах ,өөртөө тохиолдсон үед түүнээс гарах арга замаа зөв сонгох,юу хийж болохыг эрэгцүүлэн дүгнэх чадвартай болох

Арга зүй: Бүлгээрээ судалгаа хийх,мэтгэлцэх,хосоороо ажиллах,марофон бичлэг,мэдээлэл цуглуулах ,таамаглал дэвшүүлэх, өртөөлөн бичих,чухалыг сонгох

Хичээлийн явц:

Үйл ажиллагаа 1” Сэдэлжүүлэх үйл” богино ярилцлага зохиох

Асуулт:-Чиний амьдралын зорилго юу вэ?

-Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд чи юу хийх хэрэгтэй гэж боддог вэ?

-Сүүлийн жилүүдэд ядуус олширсоны шалтгаан юу вэ? гэх мэтээр нээлттэй асуулт тавьж ярилцсаны дараа хичээлийн зорилтыг танилцуулна.

Үйл ажиллагаа 2 -Сурагчид эрхэлсэн ажилгүй хүмүүсээс судалгаа авч ирсэн байна.

-Судалгаа хийсэн сурагчид бүлгээрээ судалгаагаа нэгтгэж бусад бүлгүүдэд танилцуулна

Энэ үед хөдөлмөрийн зах зээл,ажил эрхлэлтийг сэргээн сануулах асуулт тавьж ярилцана.

Үйл ажиллагаа 3 -Өмнө нь судалсан ажил эрхлэлтийн эсрэг үзэгдэл болох , ажилгүйдлийг хэрхэн хамтарч судлах талаар санал цуглуулах ярилцлага өрнүүлэн асуудал дэвшүүлэх

-Ажилгүйдэл гэж юу вэ?

-Ямар хэлбэрээр илэрч байна вэ?

-Ямар сөрөг үр дагавартай вэ? -Яагаад ажилгүйдэл гарч байна вэ?

-Ажилгүйдэл нийгэмд заавал байх ёстой үзэгдэл үү? Ажилгүйдлийн бууруулж болох уу?

Сурагчдыг хосоор нь зохион байгуулалт оруулж бие биетэйгээ санал бодлоо солилцоно Хичээлийн арга зүйг боловсруулахдаа хүүхэд нэг бүрийн оролцоог хангах зорилгоор “хосоор ажиллаж сурцгааа” үйлийг сонгон судалгаа хийсний үндсэн дээр боловсруулсан . Энэ үйлийг сонгох үндэслэл нь сурагчдыг багаар ажиллуулахад сурагч бүр хичээлд жигд оролцдоггүй нь сургалтын чанар, үр дүнд сөрөг нөлөөтэй байсан. Энэ үйлийн судалгааны үр дүнд багш сурагч 2- т дараах ахиц дэвшил гарч байна.

Багш

Сурагч

-Сурагч бүрт хяналт тавих

-Даалгаврыг хосоороо гүйцэтгэх нь илүү үр дүнтэй

-Хүүхэд бүртэй ажиллах боломж нэмэгдсэн

-Бусдад өөрийгөө илэрхийлэх

чадвар сайжирна

Үйл ажиллагаа 4 Дээрхи асуултын хариуг олохын тулд таамаглал дэвшүүлж ярилцана

Ажилгүйдэл гэж юу болох талаар сурагчид тус бүртгээ амьдралаас ажигласан мэдсэн туршлагаараа тодорхойлолт өгнө . тодорхойлтыг марофон бичлэгийн аргаар хийх бүлэг дотроо нэгтгэнэ

Бүлгийн баруун гар талын нэг дэх сурагчаас эхлэн өртөөлөн бичнэ. Тодорхойлтыг бүлэг дотроо нэгтгэж саналаа солилцон ангийн сурагчдын хэлэлцүүлэгт оруулахад бэлтгэнэ.

Бүлгүүдийн саналыг сонсоны эцэст багш тодоройлтыг хэлнэ. Сурагчид өөрсдийн тодорхойлт тохирсон эсэхэд анализ хийнэ.

Үйл ажиллагаа 5 .Ажил эрхлээгүй хүмүүсийн талаар судалсан материал дээр хамтран дараах даалгаврыг гүйцэтгэнэ.

Даалгавар 1 Судалгаанд оролцсон ажилгүй хүмүүс ямар хэлбэрийн ажилгүйдэлд хамрагдаж байгааг тодорхойлж яагаад уг хэлбэрт хамрагдах болсоныг үндэслэлээр гаргах /Багш ажилгүйдлийн хэлбэрийг сурагчийн үзүүлэн хэлбэрээр баг тус бүрт өгнө/улиралын,бүтцийн , мөчлөгийн ,шилжилтийн/

Даалгавар 2 Судалгаанд хамрагдсан хүмүүсийн анхдагч ба хоёрдогч шалтгааныг тодорхойлох

Алхам 1 Судалгаанд хамрагдсан бүх хүмүүсийн шалтгааныг тодруулах Яагаад? Гэсэн асуултанд хариулах Яагаад ажилгүй байна вэ? ,Яагаад мэргэжилгүй байна вэ? гэх зэрэг шалтгаанын тогтоох

Алхам 2 Багаараа хийсэн зүйлээ чухлаас чухал бус руу ялган хэлэлцүүлэгт оруулах

Даалгавар 3 Ажилгүйдлийг бууруулах арга зам

Алхам 1хүүхэд бүрт өнгийн цаас өгч ажилгүйдлийг бууруулахад тус болох саналаа бичнэ. /заавал өөрийн санал биш бусдын дэмжиж буй саналыг бичиж болно/

Алхам 2 Гаргасан саналын хэрэгжих боломжтойг нь бүлэглэнэ

Үйл ажиллагаа 6 Бүлгийн хэлэцүүлэгт оруулах хэлэлцүүлэгийн дараа бусдыг болон өөрийгөө үнэлэх

Үйл ажиллагаа 7 Бүтээсэн мэдлэгээ өдөр тутмын амьдралдаа хэрэглэх Тохиолдлын шинжлэх бусадтай чөлөөтэй ярилцах /хосоороо даалгаварыг гүйцэтгэнэ/

Үйл ажиллагаа 8 Хичээлээр үзсэн зүйлээ батлах нотлохын тулд мэтгэлцээний кейс бичих нэг баг 3 гишүүнтэй сонирхолоороо баг болохыг зөвлөнө

Багш Сурагчидад чиглүүлээд үйл хийх бүхий л явцад сурагчдаа судалж , хичээлийн төгсгөл дараагийн хичээлийг яаж эхлэж болохыг судалж тогтоолоо. энэ хичээлийн явцад сурагчид өөртөө итгэлгүй ярьж байсанаас үүдэн “өөртөө итгэлтэй ярьж сурах” үйлийг нэмж сонгож судаллаа..

Судалгаа 2

.Дээрхи ээлжит хичээл дээр судалгаа хийхдээ дараах үйлийг судалахаар илэрүүлсэн юм.

Үйлийн сэдэв: Өөртөө итгэлтэй ярих чадварын судалгаа

Үйлийг сонгосон үндэслэл:


- Сурагчид өөртөө итгэл итгэлгүйгээс болж амжилттай суралцах боломжоо алддаг.
- Бусдад санал бодлоо илэрхийлж чаддаггүй.
- VSургалтын үед айх сандрах, ичих, биеэ барих явдал гардаг

Судалгаа2.1: Энэхүү үйлээ туршихын өмнө сэтгэл ханамжийн судалгаа авах юм.

- Хэрэглэхийн өмнө Бусдад найдаж зүгээр суухыг эрмэлздэг




Хэрэгжсэний дараа



Ээлжит хичээлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх явцад сурагчдын ярих чадвар харилцан адилгүй байснаас энэ үйлийг сонгон судалсан


Судалгаа 2.2 Хүүхдийн хэрэгцээг тодорхойлох судалгаа

Багш тань хичээл заахаасаа өмнө тухайн хичээлийн талаар саналыг тань сонсдог уу?



Энэхүү судалгаанаас үзэхэд багш сурагч хоёр сурах үйл хамтран оролцдог мөртлөө багшийн ажлын гол цөм болсон сурагчдаас хол хөндий ажлаа төлөвлөдөг төдийгүй сурагчдын түвшинг бүрэн судлаагүй байдаг дутагдал нь харагдаж байна. Иймээс үйлийг сонгохдоо хамгийн энгийнээс эхлэн сонговол илүү үр дүнтэй байх юм шиг санагдана.


Судалгаа 2.3 Та нар хичээлдээ хэр идэвхитэй оролцсон бэ?



Энэ нь сурагчдын идэвхи санаачлага хүсэл сонирхолд хир нийцсэнийг харуулахын зэрэгцээ сурагчдын түвшин өөр өөр байгаа нь харагдаж байлаа.

Судалгаа 2.4: Хичээлийн аргазүйн талаар хүүхдээс авсан судалгаа

Багшийн тань хичээл явуулж байгаа арга хэрхэн таалагдсан бэ?



Үйлийн судалгааны явцад ганц багш хөгжих төдийгүй сурагч бас хөгждөг. Багшийн хичээл төлөвлөлтөнд ахиц гарсан гэж үзэж болох юм.

Судалгаа 2.5 Та нар багштайгаа хэр чөлөөтэй ярилцсан бэ?



Энэ багш сурагчийн харилцаанд өөрчлөлт орж халуун дулаан итгэлцэл бий болсон.

Үйлийн судалгааг хэрэгжүүлснээр дараах хүндрэл бэрхшээлийг даван туулж үр дүнд хүрсэн
/практик хэрэглээ/

Д/д	Ямар асуудал гарсан	Шийдсэн арга зам	Хүрсэн үр дүн
1	Сурагчдыг бүрэн судлах шаардлага гарсан	Үйлийн судалгааг бусад судалгааны аргуудтай хослуулан, хүүхэд нэг бүрийн чадварыг судалсан	Суралцагчдыг судалсанаар хичээл төлөвлөхөд тодорхой ахиц гарсан
2	Төлөвлөлт хийхэд зарим арга барил дутмаг байсан	Асуудал дэвшүүлэх арга, сэдэлжүүлэх үйлийг судалсанаар хичээл төлөвлөлтийг боловсруулах арга зүйг эзэмшсэн -Багш бүр нээлттэй асуулт тавих чадвартай болсон -Сурагчид чөлөөтэй ярьж сэтгэх, санаа бодлоо илэрхийлэх боломжтой	Суралцахуйн үйлийг хэрхэн хийж гүйцэтгэхийг урьдчилан сайн тооцож, төлөвлөсөний үр дүнд хичээлийн зорилгод нөлөөлж хүүхдийг хөгжүүлэх нь төлөвлөлтийн чухал хэсэг гэдгийг багш нар ойлгосноор суралцагчид чадваржсан
3	Багаар ажиллуулах нь зарим сурагчдыг орхигдуулж байсан	Хосоороо ажиллах үйлийг судлан хичээлийн төлөвлөлтөнд тусгасан	Хосоороо ажиллах нь багш хичээл бүхэнд сурагчдын ахиц амжилтыг тэмдэглэх боломж олгон үйлийн явцад нь судалгаа хийж сурсан
4	Сурагчдын ярих чадвар сул байсан	Өөртөө итгэлтэй ярих үйлийг судлан төлөвлөлтөнд тусгасан хэрэглэсэн	Хичээлд оролцож буй оролцогчид бүгд өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэн ярих чадвар нь нэмэгдсэн
5	Сурагчдын чадвар өөр өөр байсан нь үнэлгээнд нөлөөлсөн	Идэвхитэй хийсвэр сэтгэлгээтэй туршилт хийх илүү чадвартай сурагчдыг нэг багт хувиарласан	Чадварт тохирсон даалгаврыг гүйцэтгүүлснээр суралцагчдын оролцоо сонирхол идэвхижиж хамтын ажиллагаа сэргэж эхэлсэн

Дүгнэлт

Сургалтанд үйлийн судалгааг ашиглаж туршиж үзсэнээр үйл явцын хариуцагч субъект нь суралцагч өөрөө байна гэдэг нь тодорхой байна.

Үйлийн явцад нь сурагчдыг судалсанаар нийт сурагч багш нар хамтран хөгжих боломжтой гэдэг нь харагдаж байна. Нэгж ,ээлжит хичээлүүдийг амжилттай төлөвлөж олон арга технологи боловсруулан зохион байгуулснаар сургалтын үр дүнд эерэг өөрчлөлт гарч байгааг судалгаа туршиж харуулж байна. Сурагчдын бие даасан бүтээлч ажлыг тэдний мэдлэг чадварын түвшин хэрэгцээ сонирхолд нийцүүлэн гүйцэтгэх хугацаа,арга зүйг нь оновчтой тогтоож сурагчдыг түвшингээр нь үнэлсэн нь сурлагын амжилтанд эерэг нөлөө үзүүлснээр батлагдлаа

- Суралцагчдын мэдлэгээ эрэмблэх чадвар, мэдлэгийн цар хүрээ, мэдлэг бүтээх, бие даан сурах үйлийн чадвар нь мэдлэгээ амьдралд хэрэглэх хэрэгцээгээ хангах боломжийг бүрдүүлэхэд нөлөөлж байна.

Өнөөдрийн боловсролын шинэчлэлийн өөрчлөлт нь хүүхэд нэг бүрийн хөгжил, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн тулд багш нар багаараа хамтран хөгжих хэрэгцээ шаардлага гарч байна. Хичээл төлөвлөлт нь үйлийг төлөвлөнө гэсэн үг. Энэ үйл нь угтаа үйл ажиллагаа юм үйл ажиллагааг амжилттай төлөвлөж үйлийг нь багш судалсанаар үргэлж шинэ үйл, шинэ санаа төрж байдаг. Энэ нь үндэсний хэмжээнд яригдаж бүх багш нар хэрэгжүүлэхээр зорьж буй судалгаат хичээл гэж хэлж болно. Үйлийн судалгаа нь туршлага хуримтлуулан туршлагаар баяжин хөгжиж, шинэлэг санаа төрүүлж байдгаараа бусад судалгаанаас илүү ач холбогдолтой. Өнөөдөр багш нар хичээлээ төлөвлөхөд тодорхой ахиц гарсан.Үйлийн судалгаа нь багш,сурагч хоёр зэрэгцэн хөгжих арга барилын тогтолцоог бий болгож байна. Нэгжийн төлөвлөлт сайн болсноор нэг ээлжит хичээлийн төгсгөл нь дараагийн хичээлийн эхлэл болж сурагчдын сурах идэвхийг өрнүүлж чадсан.Ер нь үйлийн судалгаанд сөрөг тал гэхээсээ эерэг авууштай зүйл их гэдгийг гаргасан .

Эерэг тал:

- Үйлийн судалгааг хийснээр зөвхөн багш биш багш нарын хамт сурагчид, сургууль ч хөгжих үндэс суурь болсон.

- Багш нарын дийлэнх нь үйлийн явцад хөгждөг,хүүхэд нь ч хөгжих боломжтой гэдэг нь судалгаагаар харагдсан
- Үйлийн судалгаа нь багшид ямар нэгэн нэмэлт ачаалал өгдөггүй багш ажлаа хийх явцдаа хөгждөг
- Үйлийн судалгааг ашигласанаараа судалгаат хичээлийн зорилгыг тодорхойлоход чухал ач холбогдолтой
- Сурагчдын сурлаганд тодорхой ахиц гарсан
- Сурагчдыгхоцроохгүй хөгжүүлэх бүх боломж нээлттэй
- Багш сурагчдын харилцаа илүү нээлттэй болсон
- Сурагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн сургалтын хэрэглэгдхүүнийг багш төдийгүй сурагчид идэвхитэй цуглуулах чадварыг улам нэмэгдүүлэн мэдээлэлийг олон талаас нь цуглуулах боломжтой
- Сурагчдын оюуны чадамжийг тодорхойлж, түвшинд тохирсон материалаар шалгаж, үнэлгээ өгөх боломжтой болсон
- Сурагчдыг үргэлж шинэ соргог мэдээлэлд хүргэх эрмэлзэлтэй болгосон
- Сурагч бүрийн үйлийн явцад тэдний чадварыг судлах боломж олгодог

Сөрөг тал

- Үйлийн судалгааг түгээн дэлгэрүүлэх багш бүрт хүргэх ажил хангалтгүй байна.
- Үйлийн судалгааны талаар багш бүр адил ойлголттой болоогүй.
- Судалгаа хийж буй багш нарт дэмжлэг үзүүлдэггүй, зарим ажлыг нь үнэлдэггүйгээс орхигддог.
- Үйлийн судалгаа хийсэнээр хүүхэд хөгжих боломжтой гэдгийг тэр бүр багш нар ойлгодоггүй
- Багш нарын идэвхи оролцоо ,хандлага харилцан адилгүй

Үйл үйлээ дагадаг

Үнээ тугалаа дагадаг гэгчээр хамтдаа хөгжье

Ном зүй

1. Акад. Жадамба Б /МУБС/
Проф. Жонни Балтзерсен /ДБИС/ Мэдээлэл 2006 он. УБ.
2. Акад. Жадамба Б /МУБС/
Проф. Жонни Балтзерсен /ДБИС/ Мэдээлэл 2007 он. УБ.
3. Акад. Жадамба Б /МУБС/
Проф. Жонни Балтзерсен /ДБИС/ Мэдээлэл 2008 он. УБ.
4. Акад. Жадамба Б /МУБС/
Проф. Жонни Балтзерсен /ДБИС/ Мэдээлэл 2009 он. УБ.
5. Акад. Жадамба Б /МУБС/
Проф. Жонни Балтзерсен /ДБИС/ Мэдээлэл 2010 он. УБ.
6. Акад. Жадамба Б /МУБС/
Проф. Жонни Балтзерсен /ДБИС/ Мэдээлэл 2011 он. УБ
7. Акад. Жадамба Б /МУБС/ Танхим дахь мэдлэг бүтээх үйл явц. 2005 он.УБ
8. Мэдээлэл.2007 он.сэтгүүл. У.Б.хот
9. Мэдээлэл.2008 он.сэтгүүл. У.Б.хот
10. Жадамба.Б.Танхим дахь сургалт 2004 он. У.Б.хот
11. Мягмар .О. Судлаач багшийн гарын авлага . У.Б.хот
12. Ванчин сүрэн,Д.Судалгаа шинжилгээний арга зүй. У.Б.хот

Тулгуур дохионы аргаар суралцагчдын англиар ярих чадварыг нэмэгдүүлэх нь

Судлагдахуун: Гадаад хэл

Б. Сувдаа

Өмнөговь аймаг, Цогтцэций сумын ЕБ-ын 6 дугаар сургуулийн багш

Онол арга зүйн үндэс : Суралцагчдын ярих чадварыг хичээлийн судалгаагаар дамжуулан сайжруулах боломжтой. Хичээлийн судалгаа гэдгийг Японы судлаач Makoto Yoshida ийнхүү тодорхойлсон байдаг: Хичээлийн судалгаа гэдэг нь багш нарын багшлах ур чадвар,арга зүйгээ

системтэйгээр хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа юм. Хичээлийн судалгааны онцлог нь нэг ижил хичээлийн агуулгаар олон удаа давтаж хийснээр тэр болгонд заах аргаа улам сайжруулах боломж бүрддэгт оршино. Хичээлийн бэлтгэл-хөтөлбөрийн судалгаа бол зорилгодоо хүрэхийн тулд хийдэг үйл ажиллагаа юм. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ямар үйл хийвэл зохих вэ? Ямар хэрэглэгдэхүүн ашиглах, ямар асуултууд асуувал түүндээ хүрэх вэ? гэдгийг багш нар үргэлж бодож, хичээлийн бэлтгэлээ хийхдээ тооцож үздэг байх нь чухал²¹. Тулгуур дохио нь ямар нэгэн утга санааг илэрхийлсэн таних тэмдэг дүрс, томъёолол, тэмдэгт, зураглал, схем, товч бичиглэл, эсвэл сурагчдад өмнө нь мэдээжийн болсон ухагдхуун буюу мэдээллийг ашиглан богино хугацаанд тухайн ойлголт төсөөллийг ой ухаандаа сэргээн санаж түүнийгээ үгээр ба бичгээр илэрхийлэн гаргах арга гэж үзэж болно.

Үндэслэл:

*Дэлхийн интернет мэдээллийн 70 орчим хувь болон дэлхийн шилдэг 500 гаруй их, дээд сургууль англи хэлээр үйл ажиллагаа явуулж, гэрээ, хэлэлцээрийн дийлэнх нь англи хэл дээр хийгдэн улс хоорондын болон олон улсын түвшинд англи хэлний гүйцэтгэх үүрэг, хэрэглээ эрс өсч байна.*²² гэж англи хэлний үндэснийн хөтөлбөрийн оршил хэсэгт өгүүлжээ.

Дэлхий нийтээр англи хэлний хэрэглээ өсөн нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд, англи хэлээр өөрийн бодол санааг аман болон бичгийн хэлбэрээр илэрхийлж сурах хэрэгцээ маш их байна. Ажиглалтаас харахад, англи хэлний хичээлээр дүрмийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд голлон анхаарч ирснээс суралцагчдын ярих чадвар нэлээд сул доогуур түвшинд байна. Тулгуур дохионы арга-аар суралцагчдын англиар ярих чадварыг хөгжүүлсэн нь нэлээд үр дүнд хүрч суралцагчид маань олон уралдаан тэмцээн олон улсын төсөл хөтөлбөрт амжилттай хамрагдсаны жишээ нь шавь нараас маань 2015, 2016 оны 2 төгсөгч АНУ-д, 2017 оны 1 төгсөгч IELTS-ийн 7,5 оноо авч улмаар Унгар улсад, 2017 оны 1 төгсөгч БНХАУ-д тэтгэлгээр суралцаж байгаа нь надад урам өгч энэхүү аргыг улам боловсронгуй болгож, аль болох олон багш, суралцагчдад түгээх сэдлийг бий болгосон билээ.

Хичээлийн санаа:

Олон хувилбарт даалгавраар тулгуур дохионы аргыг хэрэглэн суралцагчдын англиар ярих чадварыг нэмэгдүүлэхийн тулд судалгаат хичээлийг зохион байгуулах, гарсан үр дүнг улам бататган ажиллахад оршино. Хэрэглэгдэхүүнийг зөв оновчтой сонгон аргадаа нийцүүлэн хэрэглэснээр үр дүн гарна.

График: 1 “My favorite food” сэдвээр бэлтгэл судалгааны үед суралцагчдын ярих чадварын үзүүлэлт /10а-2014 он /

Шалгуур	Бэлтгэл судалгааны үед	Одоогийн үнэлгээгээр
Агуулга	19%	1
Логик дараалал	16%	1
Үгийн сан	30%	3
Дүрмийн мэдлэг	35%	3

²¹ http://www.slideshare.net/orgilsaihan_tungalag/ss-11578388

²² 1Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 293 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт АНГЛИ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-оршил хэсэг

Бэлтгэл судалгааны үед



2014 оноос эхлэн 4 жилийн туршид нийт 26 цагийн судалгаат хичээлийг 10,11,12-р ангиудад зохион байгуулсан. Үүнд: 10-р ангид тулгуур дохионы аргыг ашиглан “Around the world” бүлэг сэдвийн хүрээнд “My favorite food”, 11-р ангид “My favorite pet”, 12-р ангид “Why English is important” сэдвээр ярих чадварыг сайжруулах зорилготой судалгаат хичээлийн арга зүйг сайжруулан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно. Судалгаат хичээлийг явуулахдаа хэрэглэгдэхүүнийг багт болон хүүхэд бүрийн тоогоор бэлтгэн мэргэжил нэгт багш нараар туслуулан хяналт тавьж ажиллалаа. Хичээлд маань хүүхэд нэг бүр оролцож тухайн цагийн хичээлээс тодорхой мэдлэг эзэмшин чадвар дадал төлөвшсөнөөр багшийн хичээлийн зорилго биелнэ.

Хичээлийн өрнөл хэсэгт хэрэглэсэн тулгуур дохионы аргуудаас:

1. Дотоод болон гадаад тойрог / Inside and outside circle/

Сурагчид хоёр тойрог болж зогсоод гаднах тойргийн хүүхдүүд асуултыг асууж доторх тойргийн хүүхдүүд хариулна. Цагийн зүүний дагуу эргэж бүгд асуултад хариулснаар нэг сурагч 10-13 асуултанд хариулна. Сурагчид тойргоо сольж дахин энэ үйлийг давтана. Хэд хэдэн удаагийн давталтын дараа өгөгдсөн асуултад өөрийн бодлоор хариулж чаддаг болох дадалтай болно.

2. Taboo: Сурагчид багаар ажиллах бөгөөд баг бүрт нэг бүлэг үгс өгөөд тэр үгийг таана.

Энэ нь сэтгэн бодох, хамтран ажиллах, богино хугацаанд түргэн сэтгэх чадварыг хөгжүүлэх, давуу талтай.

Liquid Blue Drink Refreshing Swim ? /water/	Liquid Brand names Drink Refreshing Alcohol ? /beer/	Colors Sky Water Sad Cold ? /blue/
Air Breeze Gust Blow Move ? /wind/	Cocoa Milk Bitter Sweet Creamy ? /chocolate/	Star Burning Sky Yellow Hot ? /sun/
Hot Burning Red Lighter Elements ? //fire/	Fruit Bitter Green Monkey ? /banana/	Ponytail Head Curly Cut Brush ? /hair/

3. Tea kettle

Ярих чадварыг хөгжүүлэхэд авиа үсгийн зөв дуудах явдал чухал байдаг. Үгийн хэлээд зургийг олох, түүндээ тохирсон өгүүлбэрийг дүрмийн дагуу зөв хэлэх, багаараа ажиллах зэрэг давуу талтай.

see	Sea	
saw	Sore	
flower	Flour	
aunt	Ant	
buy	by	Bye
bare	Bear	
cheap	Cheep	
two	to	too
sew	So	
meat	Meet	
you	Ewe	
I	Eye	
sail	Sale	
but	butt	

4. The A to Z banquet: Сурагчид багаар ажиллан өмнөх сурагчийн хэлсэн өгүүлбэрийг анхааралтай сонсоод, давтаж хэлээд өөрт таарсан үсгэнд тохирох өгүүлбэрийг хэлнэ. Хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

“Food” сэдвийг заахад дараах тулгуур дохиог ашиглаж болно.

Student 1: At the banquet I ate apple pie.

Student 2: At the banquet I ate apple pie and bacon.

Student 3: At the bank I ate apple pie, bacon and carrots.....

5. Lucas Graham “7 years old.” дуу

Дууг сонсоод дараах асуултанд хариулна. Ахлах ангид хэрэглэхэд тохиромжтой ба суралцагчдын сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэн хувь хүний өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, орон орны соёл зан заншилтай танилцах зэрэг олон давуу талтай.

What is this song about?

What are the best parts of his life?

What does he worry about?

B/ Talk about his emotion.

B/ Make a timeline about his life.


What does this song say about American culture?

How is it different from Mongolian culture?

Are there any ways it is similar?

How do you feel about it?

Г/ Өөрийн амьдралын цаг хугацааны хүснэгтийг зур.



6. Drama/ Дүрийн тоглолт /Багаар/

You are stuck in an elevator. 10 seconds, then 5 minutes, and finally two hours.

You're stuck in the elevator and you have asthma. Астматай хүн

You fellow you're with is a chain smoker. Архаг тамхичин

You are a pregnant woman. Бие давхар эмэгтэй ... гэх мэтээр дүрүүд олон байж болно.


7. Activate book үзүүлэнгүүд

8. Асуулт бүхий зурагтай картууд /slide ,зургаар оруулсан./

Судалгааны үр дүн: Судалгааны үр дүнд суралцагчид англиар ярих энгийн дадал эзэмшин улмаар хэн ч захиран хянах боломжгүй хувь хүн бүрийн сэтгэлгээ, үзэл бодлыг англи хэлээр илэрхийлэхэд ахиц өөрчлөлт гарч байгааг дараах графикаас харж болно.

График 2. Судалгаат хичээлүүдийн дараа ахлах ангийн суралцагчдын англиар ярих чадварыг 1-5 оноогоор үнэлэхэд гарсан ахиц, өөрчлөлт /2016/:

Шалгуур	Бэлтгэл судалгааны үед	Судалгаат хичээлүүдийн дараа	Ахисан хувь буюу ахицын зөрүү
Агуулга	19%	35%	16%
Логик дараалал	16%	42%	27%
Үгийн сан	30%	41%	11%
Дүрмийн мэдлэг	35%	51%	16%




Дээрх судалганд хамрагдсан 133 суралцагчдын дунд судалгаат хичээлүүдийн дараа ажиглалт хийж ахицыг дүгнэлээ.

Дүгнэлт

Мэдлэгийг бүтээх, сурсан мэдсэнээ амьдралд хэрэглэж сурах чадвар, дадалтай болох нь сургалтын эцсийн зорилго билээ. Мэдлэгээ хэрхэн хэрэглэж буй нь бодит үйлээр илэрдэг. Суралцагчдаа үйлд татан оролцуулж, массыг нэмэгдүүлэх нь багшийн үүрэг юм. Энэ үүргээ биелүүлэхийн тулд багш судалгаат хичээл зохион байгуулж, хичээлээ судалж, хүүхдийг хөгжүүлэх зөв, оновчтой арга барил эзэмших асуудал зүй ёсоор урган гарч байна. Судалгаат хичээлээр багш арга зүйгээ байнга өөрчлөн, шинэ шийдлийг эрэлхийлсний үр дүнд суралцагчдад тохирох энгийн, ойлгомжтой арга хичээлдээ хэрэглэх болсон. Энэ арга нь англиар ярина гэдэг нь миний хийж чадах ажил юм байна заавал “мундаг” гэсэн хүүхдүүд хийдэг зүйл биш юм гэсэн итгэлийг суралцагчдад өгснөөрөө хамгийн гол ач холбогдол нь оршиж байсан.

Интернэт зэрэг бэлэн эх сурвалж нь хувь хүний санааг миний бодож байгаа шиг бүрэн гаргах боломжгүй тул давтагдашгүй бодьгал би өөрийн санааг өөрийн үгээр илэрхийлж чаддаг болсон гэсэн итгэлийг төрүүлж, хүүхдийг мэдлэг бүтээх үйлд дуудсанаараа тулгуур дохионы арга нь миний хувьд одоогоор хэрэглэж байгаа шилдэг аргын нэг боллоо. Багш хүн цаг үеэ мэдэрч, өөрчлөлт шинэчлэлтээс хоцрохгүй явах нь хувь хүний болон нийгмийн зайлшгүй хэрэгцээ учраас судалгаат хичээлийг олон удаагийн давтамжтай хийж, өөрийн арга барилаа байнга сайжруулан, шавь нараа хөгжүүлж байх учиртай. Энэ үйл ажиллагааг сайн зохион байгуулж хэвшсэнээр шавь нар маань англиар сонсох, унших, бичих чадвараас гадна хамгийн их хоцрогдоод байсан ярих чадвар нь эрс нэмэгдсэнд давуу тал ач холбогдол нь оршино.

График 3: Тулгуур дохионы арга хэрэглэх үед суралцагчдын хувьд дараах чадварууд өсөн нэмэгдсэнийг харуулсан график.



Англиар бичих чадвар нэмэгдсэний үр дүнд суралцагчдын сурлагын үзүүлэлт тогтмол өсөлттэй байлаа.

Англиар ярих чадвар сайжирснаар бусад чадварууд нэгэн адил дээшилснийг харуулах өөр нэг үзүүлэлт нь олимпиад уралдаан тэмцээнд амжилттай оролцсон явдал байлаа.

Судалгаанд хамрагдсан суралцагчдаас олимпиад, илтгэлийн уралдаанд гаргасан амжилтаас дурдвал

№	Он	Төрөл мэргэжлийн олимпиад, нэрэмжит болон бусад олимпиад, ЭЕШ-ын амжилт	Оролцогчид	Гаргасан амжилт	Шагнал
1	2018	Өмнөговь аймгийн орос хэлний төрөл мэргэжлийн олимпиад	12- а анги Д. Хувьтөгөлдөр	Аймагт тэргүүн байр, улсад 13-р байр	Алтан медаль, үнэмлэх
2	2018	“Англи хэлтэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд УИХ-н гишүүн Амарзаяагийн нэрэмжит илтгэлийн уралдаан	10- 6 ангийн сурагч Э.Сувд-Эрдэнэ	3-р байр	Хүрэл медаль, сертификат, мөнгөн шагнал
3	2017	“Англи хэлтэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд Ханбогд суманд зохиогдсон англи хэлний олимпиад	10- 6 ангийн сурагч Э.Сувд-Эрдэнэ	2-р байр /анги дэвшин оролцож /	Мөнгөн медаль, сертификат
4	2017	“Англи хэлтэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд Ханбогд суманд зохиогдсон англи хэлний олимпиад	10- 6 ангийн сурагч Г.Тэмүүлэн	3-р байр /анги дэвшин оролцож /	Хүрэл медаль, сертификат
5	2016	ЭЕШ ын дундажаар аймагтаа тэргүүлсэн	44 сурагч	Дээд оноо нь 720 Сурагч О. Сарангуа	Дундаж оноо 525

Тулгуур дохионы аргыг анги танхимдаа хэрэгжүүлэхээс гадна суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор олон ажлуудыг 2016-2018 онд сургуульдаа болон сумын хэмжээнд зохион байгууллаа.

2017 онд Англи хэлтэй Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд сургуулийнхаа 9-12 дугаар ангийн 118 сурагчдын дунд англи хэлээр илтгэлийн уралдааныг хоёр үе шаттайгаар зохион байгуулж 2-р шатанд 42 сурагч шалгаран оролцсоноос 9-р ангийн төрөлд Анхцэрэн, Энэрэл, Хүслэн, Мянган-Эрдэнэ нар, 11-р ангийн төрөлд М.Баярмөнх, Банзрагч, Бямбабаяр нар, 12-р ангийн төрөлд Энх-Үйлс, Уянга, Түвшинсанаа нар эхний байруудад шалгарлаа.

Сургуулийн хэмжээний эссэ бичлэг илтгэлийн уралдааны явцыг харуулсан зургуудаас:





2017 онд Т.Борын нэрэмжит Цогтцэций сумын сургууль болон ЕБС-ын 6-р сургуулийн 11-р ангийн 128 сурагчдын дунд англи хэлээр илтгэлийн уралдааныг зохион байгуулсан нь суралцагчдын англи хэл сурах идэвхийг өрнүүлэхэд чиглэсэн ажлын нэг боллоо. Тэрчлэн эдгээр сурагчдад англиар тулгуур дохионы аргыг хэрэглэн ярих чадвараа хөгжүүлэх талаар сургалт семинарыг зохион байгуулсан нь сурагчдын эрэлт хэрэгцээг хангасан арга хэмжээ болсныг тэдний өгсөн сэтгэл ханамжийн судалгаанаас харж болно. Оролцогчид семинарын үеэр:



Арга зүйгээ түгээн дэлгэрүүлсэн талаар Өмнөговь аймгийн Даланзадгад суманд аймгийн 19 сургуулийн англи хэлний 42 багшид сургалт зохион байгуулсан нь цаг үеэ олсон үр дүнтэй ажил боллоо.

Багш нар сургалтын явцад олон зүйлийг сурч мэдэж хичээл сургалтандаа хэрэглэх талаар сэтгэл ханамжийн судалгаандаа дурдсан байсан. Сургалтгуудын талаарх сэтгэл ханамж 100% эерэг байсныг хэлэхэд таатай байна.

Сургалтын үед хэрэглэсэн тулгуур дохионы хэрэглэгдэхүүнүүдийг багш нар ашиглан дадлага ажил хийлээ.



Миний бие Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй сэдэвт онол практикийн бага хуралд Өмнөговь аймгаас хоёр дахь удаагаа оролцож байна. Энэ бага хурлаас маш их зүйлийг сурч мэддэг бөгөөд энэ удаа зарим багш нараа ятган “урвуулан” хамт ирсэн билээ. Мянга сонсохоор нэг үз.

Монгол орны ирээдүй болсон хүүхэд бүрийг хөгжүүлэх их үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, багш бидэнд шинэ санаа шинэлэг арга, урам зориг, эрч хүч, чиглэл өгч байдаг Багшийн Мэргэжил дээшлүүлэх Институт, МХСН-ийн хамт олонд талархал дэвшүүлж ажлын өндөр амжилт хүсье.

Дэм дэмэндээ- Хамтдаа хөгжицгөөе!

Ном зүй:

1. Makoto Yoshida. 2004. *Ideas for Establishing Lesson-Study Communities*. NCTM's journal
2. Үндэсний хөтөлбөр. 2008. Англи хэл. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 293 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. УБ
3. Гадаад хэл. 2016. Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ
4. Barbara William Scoff. 2015. *How to improve speaking skills*.
5. *English Teaching Forum*. 2009. Volume 47, number 1
6. Хичээлийн судалгаа. 2015. <http://www.slideshare.net/>

Сурагчдад үр дүнтэй бичих арга техникийг эзэмшүүлэх нь

Судлагдахуун: Гадаад хэл

Г.Бямба

Орхон аймаг, Баян-Өндөр сумын ЕБ-ын 3-р сургуулийн багш
Удиртгал

Нийгмийн шаардлагатай хөл нийлүүлэн амьдрах арга ухаан, оюуны хэвшил байнга өөрчлөгдөж байгаатай холбогдон өөрчлөлтүүдийн нэг хэсэг бол хэл, хэл бичиг үгийн сангийн өөрчлөлт юм.

Саяхан бодит амьдралаас тасархай дасгалаар бичиж сургахыг шаардаж байсан бол одоо сурагчдыг зохион бичих, найруулах, хувиргах хураах, дэлгэрүүлэх ажилд сургахыг чухалчилж байна. Бичих гэдэг нь хүн ямар нэг зүйлийн тухай хэн нэгэнтэй ярьж байгаатай адил гэсэн мэргэн үг бий. Тиймээс ч аливаа нэг юм, үзэгдлийг ойлгомжтой, дэс дараалал сайтай, өөрийн санаагаар зохион бичиж илэрхийлэхийг эх зохион бичих гэдэг.

Ажлын байран дээрээ хичээлийн судалгаанд оролцох нь багш хөгжих нэг хэлбэр юм. Арга зүй, ур чадвар сайтай Хөгжсөн багшаас Хөгжсөн хүүхэд

Багш хичээлээ хүүхдийн танин мэдэхүйн түвшин, нас сэтгэхүйн онцлогт тохируулан оновчтой арга зүйгээр явуулах нь хүүхэд бүр хөгжих нэг үндэс. Багшийн хэлсэн үг, өгүүлбэрийг цээжээр бичих, өөрөө бодож тунгааж бичих гэдэг бол их өөр зүйл.

Хүүхэд зохион бичих явцад санаа өгөх зорилгоор ижил төстэй эх уншиж өгч болох юм. Хамгийн гол нь хүүхдээр өөрөөр нь санаа гаргуулж сайтар бодуулж байж бичүүлэх шаардлагатай учраас алдаатай бичихэд багш эмзэглэх хэрэггүй. Мөн багш анхааралтай уншиж, тусгайлан цаг гаргаж харилцан ярилцаж дахин засварлаж улам чанаржуулна. Эцэст нь сурагчид бичсэн зохион бичгүүдээ өөрийн болгож амаар ярин, бусадтайгаа хуваалцана.

Бичих гэдэг нь хүн ямар нэг зүйлийн тухай хэн нэгэнтэй ярьж байгаатай адил гэсэн мэргэн үг бий. Тиймээс ч аливаа нэг юм, үзэгдлийг ойлгомжтой, дэс дараалал сайтай, өөрийн санаагаар зохион бичиж илэрхийлэхийг эх зохион бичих гэдэг.

Бичихийн өмнө, бичих явцад, бичсэний дараа гэсэн үе шат бүхий арга техникийг сурагчдад эзэмшүүлснээр дүрмийн алдаагүй, ижил болон эсрэг утгатай үгсээр нэг үгийг давталгүйгээр баяжуулан 5 цогцолбороор агуулгаа бүрэн гүйцэт илэрхийлэх арга барилд суралцаж, сурагчдын танин мэдэх идэвх өрнөн бүтээлчээр сэтгэх, сурах бичгийн агуулгын хүрээнд өгөгдсөн сэдвээр олон талаас харж сэтгэж, илэрхийлэн бичих бие даасан бүтээлч үйл ажиллагаа нь хөгжиж, хүүхэд нэг бүрийн жигд оролцоог хангаад зогсохгүй суралцагчид өөрсдийн санаа бодлоо бусадтайгаа хуваалцсанаар хэлний 4 үндсэн чадварыг бие даан бүтээлчээр хөгжүүлэх арга барилтай болж, мөн хэлзүйн болоод үгийн сангийн хувьд суралцагчид бусдыгаа сонсонгоо бусдаас суралцах, алдаагаа засах, өөрийгөө илэрхийлэх чадварт суралцаж байна.

Мөн багшийн хувьд энэхүү аргыг хичээлдээ ашиглах нь суралцагчдын оролцоо давамгайлсан богино хугацаанд хүүхэд нэг бүрт өөрийн бичсэн мэдээллээ бусадтайгаа хуваалцах боломж олгож мөн бусдыг сонсож сурах арга барилыг эзэмшүүлэхийг зорьж байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн багш хичээлийн судалгааны бэлтгэл үеэс эхлэн багаар хамтран ажиллаж, хичээлийн хэлэлцүүлэгт тогтмол оролцож байгаа нь арга зүйгээ сайжруулах, ажлын байрандаа үнэ өртөг багатайгаар тасралтгүй хөгжих, бие биенээсээ суралцан туршлага солилцох боломжийг олгож өгснөөрөө сайн хичээл болсон гэж дүгнэж байна.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар

Сэдвийг сонгосон үндэслэл:

Ажиллах хугацаандаа англи хэлний 5 чадварыг /ярих, бичих, унших, сонсох, хэлний хэрэглээ/ сурагчид хэрхэн өөрийн болгож, ойлгож хэрэглээ болгон хичээл, амьдрал үйл ажиллагаандаа хэрэглэж байгаад ажиглалт хийх явц, мөн хөндлөнгийн ТТШ, аймгийн бага олимпиадад оролцсон сурагчдын дасгал даалгаварт анализ хийхэд сурагчдын бичих чадвар сул, сайжруулах шаардлагатай байгаа нь ажиглагдсан. Иймээс бичих чадвар цаашлаад хосолсон чадварыг хөгжүүлэхүйц арга аргачлалыг боловсруулах зайлшгүй шаардлага тулгарсан бөгөөд судлаач бид VI-IX ангийн сурах бичгийн бичих даалгавар анализ судалгаа хийлээ / хавсралтаар /

№	Types of writing	VI анги	VII анги	VIII анги	IX анги	Даалгаварын Тоо
1	description	2	2		2	6
2	paragraph	4	7	13	7	31
3	composition		3	1		4
4	e-mail		1	4	4	9
5	Invitation	1				1
6	Summary		1	3		4
7	Post card		1	2		3
8	Diary				1	1
9	Plan				2	2
10	animation				1	1
11	advertisement				2	2
	Нийт	7	15	23	19	64

Энэхүү судалгаа нь сурах бичгийн бичих даалгаварын сэдэв агуулга нь анги өгсөх тутам өргөсөн нэмэгдэж байгааг харуулахаас гадна сурагч нэг бүр бичих арга барил эзэмшүүлэх үр дүнтэй, бүтэц, агуулга сайтай бичих арга техникт сургах хэрэгцээ тулгарсан.

Хичээлийн санаа:

6-9 р ангийн сурах бичгийн бичих чадварыг хөгжүүлэх агуулгын хүрээнд анализ дүгнэлт хийж үзэхэд нийт дасгал даалгаврын 20-30 хувийг бичих даалгавар эзэлж байна. Аливаа зүйлийн талаар дүрслэл, цогцолбор, э-мэйл, захидал бичихээс мэндчилгээ, зар сурталчилгаа, зарын болон анхааруулах самбар, төлөвлөгөө зохиох, төсөөлөл, дүгнэлт, зохион бичлэг бичих зэргээр агуулга өргөсөж байна. Иймээс сурагчдын бичих чадварыг хөгжүүлэх шаардлага бий болж байна. 6-9 р ангид ижил сэдвээр /My day/ хичээлийн судалгааг зохион байгууллаа.

Зохион бичих явцад сурагчид бүтээлчээр сэтгэж, хэрхэн үр дүнтэйгээр зөв бүтэцтэй бичих арга барилд суралцаж, улмаар тэдний үгийн баялаг нэмэгдэж хэлзүйн алдаагүй бичиж хэвшээд байна.

Хичээлийн бэлтгэл судалгаа:


Хичээлийн бэлтгэл судалгааг 3-р сургуулийн англи хэлний багш нартай хамтран “*My day*” сэдвийн хүрээнд 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн дараах чиглэлийн дагуу хийсэн.

1. Агуулгын судалгаа

7-р ангид тус агуулга нь 10-р бүлэгт “My daily routine” сэдвээр, 8-р ангид 2-р бүлэгт “My daily routine” сэдвээр өгөгдсөн бөгөөд агуулгын хувьд school activities, after school activities, weekend activities, 9-р ангид тус агуулга нь 2-р бүлэгт “One day” сэдвээр өгөгдсөн бөгөөд агуулгын хувьд give more details about places, objects, people and events expressing by feelings болж өргөссөн байна. Хэл зүйн дүрмийн хувьд зөвхөн PRESENT SIMPLE цагаар “*My day*” сэдвээр бичиж байгаа нь суралцагчдад хялбар, үгийн нөөц арвинтай байгаа нь цаашид өөр сэдвүүдээр зохион бичүүлж болно гэж тодорхойлсон.

2. Арга зүйн судалгаа

Бичихийн өмнө, бичих явцад, бичсэний дараа гэсэн үе шат бүхий арга техникийг хэрэглэж тодорхой сэдвүүдийн хүрээнд сурагчдын бүтээлчээр бичих чадварыг хөгжүүлж эзэмшүүлж хэлний үндсэн 5 чадвараа хөгжүүлэх боломжтой юм байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Энэхүү арга нь өгөгдөн сэдвээр сурагчид дээрхи 3 үе шатаар зөв бүтэц, зохион байгуулалттай 5 цогцолбор бүхий зохион бичлэг бичиж үйл явц юм.



Ээлжит хичээлийг дараах үе шатуудад хуваан авч үзсэн.

Анги зохион байгуулалт:

Өмнөх мэдлэгийг сэргээж сэдэлжүүлэх

Гэрийн даалгавар – Хичээл дээр бичсэн зохион бичлэгээ сайжруулах

Хичээлийн явц:– Гурван үе шат бүхий арга техникийг ашиглан өгөгдсөн сэдвээр зохион бичлэг бичиж, бэлэн болсон сурагч ангийнхандаа уншиж өгнө.

3. Хэрэглэгдэхүүний судалгаа

Цахим хэрэглэгдэхүүн бэлтгэж, дасгал даалгаврыг сурагчдын нас сэтгэхүйн онцлогт нь тохируулан хэвлэмэл байдлаар сурагчдын тоогоор бэлтгэсэн. /worksheet for outline, description for method technology, vocabulary, the structure for present simple/. Сурагчдын бичих чадвараас хамааран дэмжлэг /бэлэн эх өгөн дууриан бичих, гол санаанд тулгуурлан эхийг гүйцээж бичих /үзүүлэхээр тооцоолсон. word wall

4. Суралцагчдын өмнөх төсөөллийн судалгаа

6-р ангиасаа суралцагчид өөрсдийн эзэмшсэн мэдлэг чадварын хүрээнд зохион бичээд дадсан учраас тухайн өгөгдсөн сэдвээр зохион бичихэд дөхөмтэй байсан гэж үзсэн. Үг хэллэгийнхээ 70 орчим хувийг, Present simple цагын хэрэглээг сайн ойлгож эзэмшсэн байсан. Өмнөх төсөөллийн судалгаанд оролцсон сурагчдын 65% нь үг хэллэгийн 70 орчим хувийг эзэмшсэн ба дүрмийн хэрэглээг 60% ойлголттой байсан зэрэг нь зохион бичихэд амархан байсан.

5. Хөгөлбөр боловсруулах

Хичээлийн үе шатууд	Багшийн үйл ажиллагаа	Суралцагчийн үйл ажиллагаа
Бэлтгэл, зохион байгуулалтын үе шат /2’/	<ul style="list-style-type: none"> ➢ Бие даасан бүтээлч үйл ажиллагааг дэмжих үүднээс уламжлалт маягаар анги нийтээр хичээллэнэ. ➢ Үнэлгээг/rubric/ сурагчдад тайлбарлана. <p>Сурагчдын бичсэн зохион бичлэгийг /content, organization, vocabulary, grammar/ шалгуур тус бүрийг оноожуулж /5оноо-нийт 20/ дүгнэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ➢ Сурагчид үнэлгээний журамтай танилцана.
Өмнөх мэдлэгийг бататгах үе шат /10’/	<ul style="list-style-type: none"> ➢ My day сэдвийн хүрээнд урьдчилан бэлтгэсэн word wall үүсгэх ажлын хуудсыг хүүхэд нэг бүрт тарааж өгнө. Сурагчид бичсэн үг хэллэгээ ашиглан present simple цагаар өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 1-2 өгүүлбэр зохионо. ➢ Багш бэлэн болсон сурагчдыг “my day ” –тэй холбоотой үг хэллэгээр үүсгэсэн word wall –оо, мөн бичсэн өгүүлбэрээ авч гарч ирэхийг урин, бусаддаа уншиж танилцуулах заавар өгнө. ➢ Багш амаар ,сурагчдыг thumbs up / down –р тухайн сурагчийг үнэлэх гэдгийн сануулна . 	<ul style="list-style-type: none"> ➢ Багшийн өгсөн цаасан дээр хүүхэд нэг бүр “my day”–тэй холбоотой үг хэллэгийг бичиж word wall үүсгэнэ., мөн бичсэн үг хэллэгээ ашиглан present simple цагаар өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 1-2 өгүүлбэр зохионо. ➢ Сурагчид өөрсдийн бүтээсэн word wall ,бичсэн өгүүлбэрээ уншина. ➢ Багш амаар сурагчид thumbs up / down –р тухайн сурагчийг үнэлж урамшуулна.
Сэдэлжүүлэх үе шат /5’/	<ul style="list-style-type: none"> ➢ Урьдчилан бэлтгэсэн graphic organizer –н бэлэн загварыг /making outline / дэлгэц дээр үзүүлж санаа өгнө. <p>what do you like to do everyday? What do you think today’s lesson topic is? Хичээлийн сэдэв болон сар, өдрийг самбарт бичнэ. Хичээлийн зорилго, зорилтыг танилцуулна.</p>	<p>Сурагчид анхааран сонсоноор, graphic organizer –г ашиглан outline хийх ойлголттой болж улмаар багшийн асуултанд хариулснаар хичээлийн сэдэв гарч ирнэ. “my day ”</p>
Шинэ мэдлэг олгох үе шат /20’/	<p>Алхам 1.pre writing Хүүхэд нэг бүрт graphic organizer –г ашиглан outline хийх ажлын хуудсыг тарааж өгнө. Бэлэн болсон эхний 3 сурагчаар хийснээ бусаддаа тайлагнах, ангиараа ярилцах цаг өгнө. Дэмжлэг хэрэгтэй сурагчдад бэлэн outline-г дууриан бичих боломжоор хангана. Багш тайлбар , дүгнэлтийг өгнө. Багш амаар ,сурагчдыг clapping hands –р тухайн сурагчийг үнэлэх гэдгийн сануулна</p>	<p>1.Хүүхэд нэг бүр ажлын хуудсан дээр ажиллана. Бэлэн болсон эхний 3 сурагчаар хийснээ бусаддаа тайлагнаж, ангиараа ярилцана. Дэмжлэг хэрэгтэй сурагчдад бэлэн outline-г дууриан бичнэ. Багшийн тайлбар , дүгнэлтийг анхааран сонсон өөртөө дүгнэлт хийн, сайжруулна. Багш амаар ,сурагчдыг clapping hands –р тухайн сурагчийг үнэлж урамшуулна.</p>
Бататгах үе шат /25’/	<p>Алхам 2. During writing Хүүхэд нэг бүрийг хийсэн outline- даа тулгуулран олон талаас нь бүтээлчээр сэтгэж бичиж эхлэхийг багш уриална. Ижил төстэй санаануудаа нэгтгэн нэг цогцолбор болгох,гол санаагаа нэмэлт мэдээллүүдээр агуулгаасаа гажихгүйгээр нэмэн дэлгэрүүлж, нэг үгийг ижил эсрэг утгатай үгээр орлуулан, холбоос ашиглан нийлмэл өгүүлбэрээр зөв цэвэр,гаргацтай алдаагүй бичих шаардлагатайг сурагчдад тайлбарлан сануулна. Дэмжлэг хэрэгтэй сурагчдад ижил төстэй эх өгөн тухай бүрд нь тайлбар өгч ажиллана.</p>	<p>Хүүхэд нэг бүр өөрийн хийсэн outline- даа тулгуулран олон талаас нь бүтээлчээр сэтгэж бичиж эхэлнэ.. Ижил төстэй санаануудаа нэгтгэн нэг цогцолбор болгоно. Гол санаагаа нэмэлт мэдээллүүдээр агуулгаасаа гажихгүйгээр нэмэн дэлгэрүүлж, нэг үгийг ижил эсрэг утгатай үгээр орлуулан, холбоос ашиглан нийлмэл өгүүлбэрээр зөв цэвэр,гаргацтай алдаагүй бичихийг хичээнэ. Багшийн дэмжлэгтэйгээр өөрийн санааг нэмэн дуурайн бичнэ.</p>

Дүгнэх үе шаг /15'/	Алхам 3.post writing Багш эхний 5 сурагчийг самбарын өмнө урьж “ <i>my day</i> ”сэдвээр бичсэн эхээ уншиж өгөх чиглэлийг өгнө. Хичээлийн дараа бүх сурагчид багшид дэвтрээ хураалгах, багш бичвэрт анализ хийн сурагчдыг дараагийн хичээлийн гэрийн даалгаварт сайжруулж ирэхийг сануулна.	Бэлэн болсон эхний 5 сурагч самбарын өмнө гарч “ <i>my day</i> ”сэдвээр бичсэн эхээ уншина. Хичээлийн дараа бүх сурагчид багшид дэвтрээ хураалгана, багшийн өгсөн зөвлөгөөг тусган дараагийн хичээлийн гэрийн даалгаварт сайжруулан бичнэ.
Төгсгөл хэсэг /3'/	Хичээлд идэвхитэй оролцсон сурагчдыг амаар болон дэвтэрт нь үнэлгээ тавьснаар урамшуулана. Багш сурагдад гэртээ “ <i>my day</i> ” сэдвээр бичсэнээ сайжруулах даалгавар өгнө.	Сурагчид гэртээ “ <i>my day</i> ” сэдвээр сайжруулан бичнэ.

Судалгаат хичээл

“*my day*”сэдэвт хичээлийг 6-9 ангийн 8 бүлэгт 2 удаа зааж туршсан бөгөөд 2018 оны 2сараас 9 сарыг дуустал нийт 8 цагийн хичээлийг 3-р сургуулийн ГХЗАН-н 4 багш доорхи хуваарийн дагуу судалгаат хичээлийг зохион байгуулсан.

№	Анги	Багшийн нэр	Туршилт хичээлийн Хугацаа	Сайжруулсан хичээлийн хугацаа
1	6а	Б.Ариунгэрэл	02.12	
2	6в	Б.Ариунгэрэл		02.15
3	7б	Л.Наранбаатар	05.07	
4	7а	Л.Наранбаатар		05.10
5	8б	П.Уранчимэг	04.16	
6	8в	П.Уранчимэг		04.19
7	9б	Г.Бямбаа	09.10	
8	9в	Г.Бямбаа		09.13

Хичээлийн судалгаанд тус сургуулийн Гадаад хэлний Заах аргын нэгдлийн 11 багш, Сургалтын менежер Б.Түвшинбаяр нар ажиглагчаар оролцсон. Ажиглагчид өөр өөр чиглэлийн дагуу ажиглалт хийж, хичээлийн дараа багшийн заах арга зүй, суралцагчдын суралцахуйг дэмжсэн тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр гарсан санаануудыг дараагийн хөтөлбөрт тусган сайжруулж хичээлээ заасан ба үүний үр дүнд багшийн заах арга зүйд болон суралцагчдын оролцоонд ихээхэн өөрчлөлт гарч байсан нь нэгдсэн хэлэлцүүлгийн үед харагдаж байлаа.

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл

Хүүхдээр юуг, яаж нээлгэсэн бэ?

Өмнөх хичээлийн бататгал үе шатанд: Өмнөх хичээл дээр үзсэн үг хэллэгүүд болоод суралцагчид өөрсдийн үгийн баялагтаа тулгуурлаад “*my day*”-тэй холбоотой үг хэллэгээр word wall бүтээж, үг хэллэгээ ашиглан present simple цаг дээр өгүүлбэр зохиосон.

Сэдэлжүүлэх үе шатанд: Сурагчид анхааран сонсоноор, graphic organizer –г ашиглан outline хийх ойлголттой болж улмаар багшийн асуултанд хариулснаар хичээлийн сэдэв гарч ирнэ. “*my day*”.

Шинэ мэдлэг олгох үе шатанд:

Алхам 1.pre writing

Хүүхэд нэг бүр graphic organizer –г ашиглан outline- аа ажлын хуудсан дээрээ хийнэ.

Бэлэн болсон эхний 3 сурагчаар хийснээ бусаддаа тайлагнах, ангиараа ярилцах цаг өгөхөд бэлтгэнэ.

Дэмжлэг хэрэгтэй сурагчдад бэлэн outline-г дууриан бичих боломжоор хангагдсан.

Багшийн тайлбар, дүгнэлтийг анхааран сонсон өөртөө дүгнэлт хийн, сайжруулна

үг хэллэг эзэмшилтийн хувьд: word wall бүтээсэн үг хэллэгийн утгыг бусдын жишээ өгүүлбэр, багшийн чиглүүлгийн тусламжтайгаар өөрсдийн өмнөх мэдлэгт тулгуурлан ойлгосон.

PRESENT SIMPLE –цагийн хэрэглээг багшийн тайлбар, өмнөх суурь мэдлэгтэй тулгуурлан бататгаж авсан.

Бататгал үе шатанд:

Алхам 2. During writing

Хүүхэд нэг бүр өөрсдийн хийсэн outline- даа тулгуурлан олон талаас нь бүтээлчээр сэтгэж бичиж эхэлсэн.

Ижил төстэй санаануудаа нэгтгэн нэг цогцолбор болгож, гол санаагаа нэмэлт мэдээллүүдээр агуулгаасаа гажихгүйгээр нэмэн дэлгэрүүлж, нэг үгийг ижил эсрэг утгатай үгээр орлуулан, холбоос ашиглан нийлмэл өгүүлбэрээр зөв цэвэр, гаргацтай алдаагүй бичихийг ойлгосон.

Дэмжлэг хэрэгтэй сурагчдад ижил төстэй эхийг өөрийн санаагаар баяжуулан бичсэн.

Дүгнэх үе шатанд:

Алхам 3. post writing

Багш эхний 5 сурагчийг самбарын өмнө урьж **“my day”** сэдвээр бичсэн эхээ ангийнхандаа уншиж өгсөн.

Хичээлийн дараа бүх сурагчид багшид дэвтрээ хураалгаж, багшийн өгсөн зөвлөгөөний дагуу дараагийн хичээлийн гэрийн даалгаварт сайжруулж ирнэ.

Төгсгөл хэсэгт:

Хичээлд идэвхитэй оролцсон сурагчдыг амаар болон дэвтэрт нь үнэлгээ тавьснаар урамшуулсан. Багш сурагчдад гэртээ **“my day”** сэдвээр бичсэнээ сайжруулах даалгавар өгнө.

Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага

Зохион бичих дасгал даалгавар бүхий ээлжит хичээлийг суралцагчид бичихийн өмнөх, бичих явцад, бичсний дараах гэсэн алхамууд дах даалгаварыг гүйцэтгэснээр өөрийн санааг илэрхийлэх, онцлох санаагаа багцлахад *хялбар* байсан. Гол санаагаа жишээ баримтаар баяжуулан, агуулгаас гажихгүй үр дүнтэйгээр алхам бүрийг зөв гүйцэтгэж сурагчдыг бичих чадвар хөгжүүлснээрээ үр дүнтэй, оновчтой арга зүй гэж үзлээ.

Судалгааны үр дүн

Судалгаат хичээлийн төлөвлөлтөнд хийсэн сайжруулалт:

✓ Бэлтгэл зохион байгуулалтын үе шатанд

Өмнө нь: сурагчдыг анги нийтээр нь зохион байгуулж байсан. Дэмжлэг хэрэгтэй сурагчдад ижил төстэй эх болон outline өгснөөр бие биенээсээ хуулах хандлага ажиглагдсан.

Дараа нь: сурагчдын бичих чадварт дүгнэлт хийн 2 багт хуваасан. Ингэснээр сурагчдын санаа давхцах, хуулах байдал багасч илүү бүтээлчээр хандаж байгаа нь ажиглагдсан.

✓ Өмнөх мэдлэгийг бататгах үе шатанд

✓ *Өмнө нь:* хүүхэд нэг бүр үзсэн үг хэллэгүүд болоод сурагчид өөрсдийн үгийн баялагтаа тулгуурлаад **“my day”**-тэй холбоотой үг хэллэгээр word wall бүтээж, үг хэллэгээ ашиглан present simple цаг дээр өгүүлбэр зохиосон.

✓ *Дараа нь:* багаараа үзсэн үг хэллэгүүд болоод сурагчид өөрсдийн үгийн баялагтаа тулгуурлаад **“my day”**-тэй холбоотой үг хэллэгээр word wall бүтээж, бүтээснээ баг тус бүрийн нэг гишүүн чангаар уншихад багш самбарт бичнэ. Бичихдээ school activities, after school activities, free time activities, house work гэж ангилан төрөлжүүлэн бичээд эдгээр үгийг ашиглан сайн дураараа сурагчид present simple цаг дээр өгүүлбэр зохиох бөгөөд багш нэмэлт тайлбар өгнө.

Сэдэлжүүлэх үе шатанд:

Өмнө нь:

➤ Урьдчилан бэлтгэсэн graphic organizer –н бэлэн загварыг /making outline / дэлгэцээр үзэж ойлгож, улмаар багшийн асуултанд хариулснаар хичээлийн сэдэв гарч ирнэ. **“my day**
what do you like to do everyday? What do you think today’s lesson topic is?

Дараа нь:

➤ Урьдчилан бэлтгэсэн graphic organizer –н бэлэн загварыг /making outline / дэлгэцээр үзэж ойлгосны үндсэн дээр баг тус бүр outline хийж нөгөө багдаа тайлагнана. Ингэснээр сурагчид багшийн чиглүүлэгийн тусламжтайгаар өөрсдөө хичээлийн сэдвийг таамаглал дэвшүүлсэн гаргаж ирнэ. **“my day**
what do you like to do everyday? What do you think today’s lesson topic is?

Шинэ мэдлэг олгох үе шатанд:

Өмнө нь: Алхам 1. pre writing

Хүүхэд нэг бүр graphic organizer –г ашиглан outline- аа ажлын хуудсан дээрээ хийнэ.

Бэлэн болсон эхний 3 сурагчаар хийснээ бусаддаа тайлагнах, ангиараа ярилцах цаг өгөхөд бэлтгэнэ. Дэмжлэг хэрэгтэй сурагчдад бэлэн outline-г дууриан бичих боломжоор хангагдсан.

Дараа нь: Алхам 1.pre writing

Хүүхэд нэг бүр graphic organizer –г ашиглан outline- аа ажлын хуудсан дээрээ хийсний дараа санаагаа багаараа нэгтгэн төрөлжүүлэн / school activities , after school activities, free time activities, house work / бичиж багийн outline-аа гаргана. Багууд өөрсдийн хийснээ харилцан тайлагнаж багууд нэг нэгнээ үнэлнэ.

Бататгал үе шатанд:

Өмнө нь: Алхам 2. During writing

Хүүхэд нэг бүр өөрсдийн хийсэн outline- даа тулгуурлан олон талаас нь бүтээлчээр сэтгэж бичиж эхэлсэн.

Ижил төстэй санаануудаа нэгтгэн нэг цогцолбор болгож, гол санаагаа нэмэлт мэдээллүүдээр агуулгаасаа гажихгүйгээр нэмэн дэлгэрүүлж, нэг үгийг ижил эсрэг утгатай үгээр орлуулан, холбоос ашиглан нийлмэл өгүүлбэрээр зөв цэвэр, гаргацтай алдаагүй бичнэ.

Дэмжлэг хэрэгтэй сурагчдад ижил төстэй эхийг өөрийн санаагаар баяжуулан бичсэн.

Дараа нь: Хүүхэд нэг бүр багаараа сайжруулан хийсэн outline- даа тулгуурлан олон талаас нь who, what, where, when, why , how гэсэн асуултуудаар чиглүүлэн өөрсдийн санаагаа баяжуулан бичиж улмаар бичсэнээ багаараа нэгтгэн нэг сайн эх зохион бичсэн..Ижил төстэй санаануудаа нэгтгэн нэг цогцолбор болгож, гол санаагаа нэмэлт мэдээллүүдээр агуулгаасаа гажихгүйгээр нэмэн дэлгэрүүлж, нэг үгийг ижил эсрэг утгатай үгээр орлуулан, холбоос ашиглан нийлмэл өгүүлбэрээр зөв цэвэр, гаргацтай алдаагүй бичихийг ойлгосон.

Дүгнэх үе шатанд:

Өмнө нь Алхам 3.post writing

Багш эхний 5 сурагчийг самбарын өмнө урьж **“my day”** сэдвээр бичсэн эхээ ангийнхандаа уншиж өгсөн. Хичээлийн дараа бүх сурагчид багшид дэвтрээ хураалгаж, багшийн өгсөн зөвлөгөөний дагуу дараагийн хичээлийн гэрийн даалгаварт сайжруулж ирнэ.

Дараа нь:

Баг тус бүр өөрсдийн сайжруулсан бичсэн эхээ бусаддаа уншиж өгсөн. Гэрийн даалгаварт хүүхэд нэг бүр өөрсдийн зохион бичлэгийг сайжруулан бичиж ирсэн.

Төгсгөл хэсэгт:

Хичээлд идэвхитэй оролцсон сурагчдыг амаар болон дэвтэрт нь үнэлгээ тавьснаар урамшуулсан. Багш сурагчдад гэртээ **“my day”** сэдвээр бичсэнээ сайжруулах даалгавар өгнө.

Сайжруулсан хичээлийн хөтөлбөр

Хичээлийн үе шатууд	Багшийн үйл ажиллагаа	Суралцагчийн үйл ажиллагаа
Бэлтгэл, зохион байгуулалтын үе шат /2’/	<ul style="list-style-type: none"> ➢ Сурагчдын бичих чадварт дүгнэлт хийн 2 багт хуваасан. ➢ Үнэлгээг/ rubric/ сурагчдад тайлбарлана. Сурагчдын бичсэн зохион бичлэгийг /content, organization, vocabulary, grammar/ шалгуур тус бүрийг оноожуулж /5оноо-нийт 20/ дүгнэнэ. 	<ul style="list-style-type: none"> ➢ Сурагчид үнэлгээний журамтай танилцана.
Өмнөх мэдлэгийг бататгах үе шат /10’/	<ul style="list-style-type: none"> ➢ Сурагчид багаар My day тэй холбоотой үг хэллэгийг өмнөх мэдлэгтэй тулгуурлан word wall бүтээнэ. Бүтээсэн үг хэллэгээ баг тус бүрийн нэг гишүүн чангаар уншихад багш самбарт бичнэ. Бичихдээ school activities, homework, freetime activities гэж ангилан төрөлжүүлэн бичнэ. ➢ Баг тус бүрийн 1 сурагч сайн дураара гарч ирж эдгээр үгийг ашиглан present simple цаг дээр өгүүлбэр зохионо. Багш нэмэлт тайлбар өгнө. ➢ Багш амаар ,сурагчдыг thumbs up / down –р тухайн сурагчийг үнэлэх гэдгийн сануулна . 	<ul style="list-style-type: none"> ➢ Баг бүр өөрийн wordwall үүсгэнэ. Баг бүрийн 1 гишүүн бүтээсэн үг хэллэгээ чангаар уншина. ➢ Сурагчид сайн дураараа эдгээр үгийг ашиглан present simple цаг дээр өгүүлбэр зохион ➢ Багш амаар сурагчид thumbs up / down –р тухайн сурагчийг үнэлж урамшуулна. ➢
Сэдэлжүүлэх үе шат /5’/	<ul style="list-style-type: none"> ➢ Урьдчилан бэлтгэсэн graphic organizer –н бэлэн загварыг /making outline / дэлгэцээр үзэж ойлгосны үндсэн дээр баг тус бүр outline хийж нөгөө багдаа 	<ul style="list-style-type: none"> Урьдчилан бэлтгэсэн graphic organizer –н бэлэн загварыг /making outline / дэлгэцээр үзэж ойлгосны

	тайлагнах, хичээлийн сэдвийг таамаглал дэвшүүлсэн гаргаж ирэх зэрэг чиглүүлэг өгнө. What do you like to do everyday? What do you think today's lesson topic is?	үндсэн дээр баг тус бүр outline хийж нөгөө багдаа тайлагнана. Багшийн чиглүүлэгийн тусламжтайгаар өөрсдөө хичээлийн сэдвийг таамаглал дэвшүүлсэн гаргаж ирнэ. "my day" what do you like to do everyday? What do you think today's lesson topic is?
Шинэ мэдлэг олгох үе шат /20'/	<i>Алхам 1 prewriting</i> Хүүхэд нэг бүр graphic organizer –г ашиглан outline-аа ажлын хуудсан дээрээ хийсний дараа санаагаа багаараа нэгтгэн төрөлжүүлэн / school activities , after school activities, free time activities, house work / бичиж багийн outline-аа гаргах. Багууд өөрсдийн хийснээ харилцан тайлагнах багууд нэг нэгнээ үнэлэх заавар өгнө.	Хүүхэд нэг бүр graphic organizer –г ашиглан outline-аа ажлын хуудсан дээрээ хийсний дараа санаагаа багаараа нэгтгэн төрөлжүүлэн / school activities , after school activities, free time activities, house work / бичиж багийн outline-аа гаргана. Багууд өөрсдийн хийснээ харилцан тайлагнаж багууд нэг нэгнээ үнэлнэ.
Бататгах үе шат /25'/	Алхам 2. During writing Хүүхэд нэг бүр багаараа сайжруулан хийсэн outline- даа тулгуурлан олон талаас нь who, what, where, when, why , how гэсэн асуултуудаар чиглүүлэн өөрсдийн санаагаа баяжуулах, бичсэнээ багаараа нэгтгэн нэг сайн эх зохион бичих зааварчиллага ..Ижил төстэй санаануудаа нэгтгэн нэг цогцолбор болгож, гол санаагаа нэмэлт мэдээллүүдээр агуулгаасаа гажихгүйгээр нэмэн дэлгэрүүлж, нэг үгийг ижил эсрэг утгатай үгээр орлуулан, холбоос ашиглан нийлмэл өгүүлбэрээр зөв цэвэр, гаргацтай алдаагүй бичүүлэхийг зорих.	Хүүхэд нэг бүр багаараа сайжруулан хийсэн outline- даа тулгуурлан олон талаас нь who, what, where, when, why , how гэсэн асуултуудаар чиглүүлэн өөрсдийн санаагаа баяжуулан бичиж улмаар бичсэнээ багаараа нэгтгэн нэг сайн эх зохион бичсэн.. Ижил төстэй санаануудаа нэгтгэн нэг цогцолбор болгож, гол санаагаа нэмэлт мэдээллүүдээр агуулгаасаа гажихгүйгээр нэмэн дэлгэрүүлж, нэг үгийг ижил эсрэг утгатай үгээр орлуулан, холбоос ашиглан нийлмэл өгүүлбэрээр зөв цэвэр, гаргацтай алдаагүй бичихийг ойлгосон.
Дүгнэх үе шат /15'/	Алхам 3. post writing Баг тус бүр өөрсдийн сайжруулсан бичсэн эхээ бусаддаа уншиж өгөхийг сануулан хэлнэ. Гэрийн даалгаварт хүүхэд нэг бүр өөрсдийн зохион бичлэгийг сайжруулан бичих даалгавар өгнө.	Баг тус бүр өөрсдийн сайжруулсан бичсэн эхээ бусаддаа уншиж өгсөн. Гэрийн даалгаварт хүүхэд нэг бүр өөрсдийн зохион бичлэгийг сайжруулан бичиж ирсэн. дараагийн хичээлийн гэрийн даалгаварт сайжруулан бичнэ.
Төгсгөл хэсэг /3'/	Хичээлд идэвхитэй оролцсон сурагчдыг амаар болон дэвтэрт нь үнэлгээ тавьснаар урамшуулна. Багш сурагчдад гэртээ "my day" сэдвээр бичсэнээ сайжруулах даалгавар өгнө.	Сурагчид гэртээ "my day" сэдвээр бичсэнээ сайжруулах даалгавар өгнө.

Дүгнэлт

Энэхүү судалгаат хичээлд бичихийн өмнө, бичих явцад, бичсэний дараа гэсэн үе шат бүхий арга техникийг сурагчдад эзэмшүүлснээр дүрмийн алдаагүй , үгийн олон сонголттойгоор баяжуулан 5 цогцолбороор агуулгаа бүрэн гүйцэт илэрхийлэн бичих ,сурагчдын танин мэдэх идэвх өрнөн бүтээлчээр сэтгэх, сурах бичгийн агуулгын хүрээнд өгөгдсөн сэдвээр олон талаас харж сэтгэж,илэрхийлэн бичих бие даасан бүтээлч үйл ажиллагаа нь хөгжиж , хүүхэд нэг бүрийн жигд оролцоог хангаад зогсохгүй суралцагчид өөрсдийн санаа бодлоо бусадтайгаа хуваалцсанаар хэлний 4 үндсэн чадварыг бие даан бүтээлчээр хөгжүүлэх арга барилтай болж, мөн хэлзүйн болоод үгийн сангийн хувьд суралцагчид бусдыгаа сонсонгоо бусдаас суралцах, алдаагаа засах , өөрийгөө илэрхийлэх чадварт суралаж байгаагаараа үр дүнтэй хичээл болсон гэж үзэж байна. Мөн багшийн хувьд уг арга технологийг хичээлдээ ашигласнаар нь сурагчдын идэвх оролцоо давамгайлсан сурагч төвтэй хичээл болж , богино хугацаанд хүүхэд нэг бүрт өөрийн санаагаа илэрхийлэн бичих, боломж

олгож мөн бусдыг сонсож сурах арга барилыг үзэмшүүлэхийг зорьж байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн багш хичээлийн судалгааны бэлтгэл үеэс эхлэн багаар хамтран ажиллаж, хичээлийн хэлэлцүүлэгт тогтмол оролцож байгаа нь арга зүйгээ сайжруулах, ажлын байрандаа үнэ өртөг багатайгаар тасралтгүй хөгжих, бие биенээсээ суралцан туршлага солилцох боломжийг олгож өгснөөрөө сайн хичээл болсон гэж дүгнэж байна.

Номзүй

Хэрэглээнд суурилсан сургалт зохион байгуулах арга зүй. УБ., 2009

Б.Жадамба “Танхим дахь мэдлэг бүтээх үйл явц”. УБ., 2003

Багшлахуйн хөгжил модулууд УБ., 2011

www.Google.mn “ Хичээлийн судалгаа”

“Гадаад хэл заах арга зүйн асуудлууд” .УБ., 2010

www.dawalga.mn

“Writing strategies” mentor teaching program. 2016

www.google.com Writing techniques and tips

VI ангийн сурах бичигт хийсэн анализ

				about zoo			mongolian food and write the recipe		
	write about Takashi using prompts		family members' jobs			My favourite person/ weekdays and weekends			
									English party

VII ангийн сурах бичигт хийсэн анализ

	Unit 1	Unit 2	Unit 3	Unit 4	Unit 5	Unit 6	Unit 7	Unit 8	Unit 9	Unit 10
description					1	1				
paragraphs	1	2		1		1			1	1
email			1							
compostion	1		1					1		
summary					1					

					partner's clothes	the..... In the world				
	country	trip /birthday		my favourite place		the tallest building in your town			the life in your life	daily routine
			a place to go together							
	Family		family members' hobbies					my favourite animal		
					to summarize both texts					

VIII ангийн сурах бичигт хийсэн анализ



	Unit 1	Unit 2	Unit 3	Unit 4	Unit 5	Unit 6	Unit 7	Unit 8	Unit 9	Unit 10
post cards	1					1				
paragraphs	1	1	2	1	3	1		3	1	1
email	1	1			1		1			
compostion								1		
summary			1	1	1					

cards with message										
Introduce one of friend	daily routine	well-known TV programme /weekly activities	winter and summer days	city/future transport / traffic in the street	first school journey			Khentii aimag / Egyptian arts/Recycling	Mongolian traditional clothing	write a recipe
new friend	school routine			weekend activities		Mongolian national landmarks				
							Natural History Museum of UB			
		Food/nutrition	story using plot	traffic	to penfriend					

IX ангийн сурах бичигт хийсэн анализ

	unit 1	unit 2	unit 3	unit4	unit 5	unit6	unit7	unit8	unit9	unit 10
a short description	1					1				
a short paragraph	1		1	2	1		1	1		
e-mail		1						1	1	1
a diary		1								
a plan			1							1
